

ГРАХАМ БРУУКС

Авлигын криминологи

Онолын чиг хандлага

Палгрэйв
Макмиллиан

ДАА 364
ННА 67.51
Б-685

Criminology of Corruption: Theoretical Approaches

By Graham Brooks

Авлигын криминологи: Онолын чиг хандлага

Зохиогч Грахам Брүүкс

Орчуулсан: А.Амармэнд

Редактор: Б.Батзориг, О.Мөнхбат, Д.Отгонжаргал

Эх бэлтгэсэн: Б.Тамир

First published in English under the title
Criminology of Corruption; Theoretical Approaches
by Graham Brooks, edition: 1

Copyright © The Editor(s) (if applicable) and The Author(s), 2016 *

This edition has been translated and published under licence from
Springer Nature Limited.

Springer Nature Limited takes no responsibility and shall not be made
liable for the accuracy of the translation.

Монгол орчуулгын эрх © Авлигатай тэмцэх газар

*Энэхүү бүтээл нь зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан болно.
Бүтээлийг зохиогчийн эрх, орчуулгын эрх эзэмшигчийн зөвшөөрөл-
гүйгээр хэсэгчлэн болон бүтнээр дахин хэвлэх, хайлтын системд
байршуулах, цахим, механик, фото хуулбар зэрэг ямар ч хэлбэрээр
хувиан олируулах, түгээн тараахыг хатуу хориглоно.*

Анхны хэвлэл 2021 оны наймдугаар сар

‘Урангар Пресс’ ХХК-д хэвлэв.

ISBN 978-9919-25-260-1

Утас: (976)-70110251

Цахим хуудас: www.iaac.mn

Агуулга

Өмнөх үг	v
Номын талаар товч өмнөтгөл	vii
Орчуулагчийн үг	ix
I бүлэг Оршил	1
Удиртгал	1
Асуудлын тодорхойлолт	6
Номын товч агуулга	13
Ашигласан материал	18
II бүлэг Авлигыг судлах нь: Салбар дамнасан асуудал	27
Удиртгал	27
Авлига гэж юу вэ?	28
Авлигыг тайлбарлах нь: Рационал эдийн засаг, улс төрийн шинжлэх ухаан ба хууль зүйн аргачлал	32
Авлигын социологи ба криминологийн хэрэгцээ шаардлага	39
Дүгнэлт	54
Ашигласан материал	55
III бүлэг Авлигын цар хүрээ	65
Удиртгал	65
Геркулесийн даалгавар буюу боломжгүй даалгавар: Авлигыг хэмжих	66
Бүх авлига муу юу: Үр ашиг муутай улс дахь авлигын үр нөлөөг хэмжих нь	84
“Арааг тослох нь”	85
“Арааг элсээр бөглөх”	87
Дүгнэлт	89
Ашигласан материал	91

IV бүлэг Авлигыг тайлбарлах нь: Ялгаатай нөхөрлөлийн онол	99
Удиртгал	99
Ялгаатай нөхөрлөл	100
Ялгаатай нөхөрлөлийн онолын хязгаарлагдмал тал	109
Ялгаатай нөхөрлөл: Автомашин үйлдвэрлэлийн салбар дахь авлига	112
Дайны бүс дэх ялгаатай нөхөрлөл: Хувийн цэргийн гэрээлэгчид ба хууль зөрчихийг дэмжих нь	115
Дүгнэлт	121
Ашигласан материал	122
V бүлэг Авлигыг тайлбарлах нь: Орчин үеийн дэлхий ертөнцөд дарамтыг мэдрэх нь	131
Удиртгал	131
Орчин үеийн дэлхий ертөнцөд дарамтыг мэдрэх нь	132
Дарамтын онолын хязгаарлагдмал тал	143
Олон зориулалтат, дахин ашиглах хөлөг:	
Зорилтын дарамт ба төсөв таналт	146
Дунд Стаффордшайрын Үндэсний эрүүл мэндийн албаны сангийн трест: Зорилгын ба төсвийн таналтын дарамт	150
Дүгнэлт	153
Ашигласан материал	153
VI бүлэг Авлигыг тайлбарлах нь: Авлигын ертөнц рүү гулсан орж гарах ба саармагжуулах арга хэрэгсэл	161
Удиртгал	161
Гулсах ба саармагжуулах арга хэрэгсэл	162
Саармагжуулах арга хэрэгслийн хязгаарлагдмал талууд	171
Авлигын агуулгад: Гулсах ба саармагжуулах үйлдлийг тайлбарлах нь	172
Дүгнэлт	181
Ашигласан материал	182

VII бүлэг Авлигыг тайлбарлах нь: Яагаад бид бүгдээрээ авлигын үйлдэл гаргадаггүй вэ?	187
Удиртгал	187
Хяналтын онол	188
Хяналтын хязгаарлагдмал тал	198
Хүлээн зөвшөөрөгдөх байдал дутагдах нь:	
Хуулийн сул хэрэгжилт ба нийгмийн гадаад хяналт	200
Дүгнэлт	209
Ашигласан материал	211
VIII бүлэг Авлигыг тайлбарлах нь: Зөрчилдөөний тогтолцоонд авлига гарцаагүй юу?	217
Удиртгал	217
Капитализм ба гэмт хэрэг	218
Зөрчилдөөний онолын хязгаарлагдмал тал	230
Ашгийн төлөө: Шилжилтийн капитализм ба авлига	232
Ашгийн төлөө: Улс орныг эзлэн түрэмгийлэх	236
Дүгнэлт	240
Ашигласан материал	241
IX бүлэг Авлигыг тайлбарлах нь: Байгууллага, институц, хувь хүмүүст авлигажсан гэх нэр шошго зүүх эрх мэдэл	247
Удиртгал	247
Гэмт хэргийн нийгмийн байгуулал	248
Нэр шошго зүүх онолын хязгаарлагдмал тал	253
Нэр шошго зүүх эрх мэдэл: Цагдаа ба Хилсбороу	254
Нэр шошго зүүх эрх мэдэл: Төрийн албыг авлигад буруутгах нь	259
Дүгнэлт	265
Ашигласан материал	267

Х бүлэг Авлигыг тайлбарлах нь: Рационал, тооцоолсон сонголт уу?	271
Удиртгал	271
Баруун реализм ба Хувь хүний хариуцлага	272
Рационал сонголтын хязгаарлагдмал тал	277
Рационал сонголт: Сүйтгэх дур сонирхол ба байгаль орчны авлига	279
Дүгнэлт	289
Ашигласан материал	290
ХI бүлэг Авлигыг тайлбарлах нь: Бизнесийн хэвшсэн үйл ажиллагаа юу?	295
Удиртгал	295
Гэмт хэрэг хэвшмэл зүйл болох нь:	
Байдаг л нэг зүйл үү?	296
Хэвшмэл үйлдлийн онолын хязгаарлагдмал тал	302
Ашгийн төлөө: Авлига, бизнес, санхүүгийн гэмт хэрэг	304
Дүгнэлт	313
Ашигласан материал	314
ХII бүлэг Эргэцүүлэл ба дүгнэлт	321
Төгсгөлийн эргэцүүлэл	321
Чиний алдсаныг би хожно: Авлигыг өөгшүүлэх нь	324
Ашигласан материал	326
Дэлгэрүүлж унших бүтээлүүд	328
Индекс	332

ӨМНӨХ ҮГ



Монгол улсын Авлигатай тэмцэх газар нь 2007 онд анх байгуулагдсанаар нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулан эдүгээ 15 дахь жилдээ ажиллаж байна.

Монгол Улсад авлигатай тэмцэж ирсэн ололт амжилт, алдаа дутагдал, хуримтлуулсан туршлагаас харахад авлигын цар хүрээ, түүний нийгмийн хөгжил дэвшилд саад учруулах сөрөг нөлөөний уг үндсийг бодитоор тогтоох, түүнтэй хэрхэн үр дүнтэй тэмцэх, үүний тулд бид цаашид яах ёстой вэ гэдэгт зөв хариулт олохын тулд асуудлын шалтгаан нөхцөл, зүй тогтлыг шинжлэх ухааны үндэстэйгээр тогтоож, түүнд тохирсон хариу арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх нь нэн чухал байна. Дэлхийн олон орнуудын хувьд ч ийнхүү хандах болсныг та бүхэн бэлхэнээ харж байна.

Авлигын гэмт хэрэг гарах шалтгаан нөхцлийг зөв тогтоож, цаашид гарахаас урьдчилан сэргийлэх, зөв арга барил, стратегиар үр дүнтэй тэмцэх, авлига гэж юу вэ, авлигыг хэрхэн хэмжих вэ,

Авлигын криминологи

энэ талаар иргэд олон нийтийг зөв ойлголттой болгох, манай улсад авлигын нөхцөл байдал бодитоор ямар байна вэ гэдгийг тогтооход энэхүү бүтээл чухал ач холбогдолтой гарын авлага болох нь дамжиггүй юм.

Авлига нь зөвхөн төрийн албаны асуудал биш болох тухай, авлигыг хэмжих нь тийм ч амар хялбар хэрэг биш тухай, авлига байгууллагын бүтэц дотор шингэж хэвшмэл зүйл болж болдог тухай зэрэг бидний хувьд олон шинэлэг ойлголт, сэдэв судлагдахуун энэхүү номд туссан байна. Түүнчлэн Авлигын асуудлыг криминологи, социологийн онолоор тайлбарласнаараа дэлхийн шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмэр оруулсан уг бүтээлийг орчуулан, үнэ төлбөргүйгээр олны хүртээл болгоход дэмжиж хамтран ажилласан Азийн Хөгжлийн Банк болон “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн багийн хамт олонд талархал илэрхийлье.

Авлигатай тэмцэх газрын дарга,
тэргүүн комиссар  З.Дашдаваа

Номын талаар товч өмнөтгөл

Монгол Улсад авлигын эсрэг хандлага, авлигатай тэмцэх эрх зүйн үндэс бүрдсээр байгааг бид хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Гэвч авлига хэмээх нийгмийн хорт хавдартай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хамгийн чухал хэсэг нь шалтгаан нөхцөлийг олон талаас харж, цогц, үр дүнтэй хэрэгжихүйц бодлого боловсруулах явдал юм. Эндээс асуудлыг голчлон хууль зүй, улс төрийн талаас нь бус шинжлэх ухааны олон ургалч үзэл хандлагад тулгуурлан авч үзэх шаардлага зүйл ёсоор гарч ирнэ.

Бид авлигыг олон талаас судалсан, тэмцэх гэж оролддог. Харин Баруун Лондоны их сургуулийн профессор бөгөөд криминологи, авлига болон бусад гэмт хэргийн талаар судалгаа хийдэг, тэр талаар олон бүтээл туурвисан, БНСУ, Тайван, Кипр, Арабын Нэгдсэн Эмират зэрэг улсын эрдэмтэдтэй авлигын талаар хамтран ажилласан туршлагатай судлаач Грахам Брүүксийн бүтээл шиг цогц байдлаар нэгтгэн судалсан нь үгүй.

Бидний хувьд харьцангуй “шинэ” онол, арга барил ойлголтоор авлигыг тайлбарлан бичжээ. Хэдий тийм ч энгийн ойлгомжтой байдлаар, жишээ баримт дурдан дэлгэрэнгүй авч үзсэн нь дан ганц авлигатай тэмцэх асуудлаар бус гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, гэмт явдалтай тэмцэх бодлого боловсруулагчид, хууль сахиулагчдын хувьд шинэлэг судлагдахуун, гарын авлага болох ач холбогдолтой байна.

Цаашид эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх, олон улсын туршлагаас судалж нэвтрүүлэх, бодлогын шийдвэрийг үндэслэл, судалгаатай гаргах, Монгол Улс дахь Авлигын төсөөллийн индексийг сайжруулах, олон улсад эзлэх байрыг дээшлүүлэхэд тустай талууд харагдаж байна.

Авлигын криминологи

Монгол Улсын Засгийн газраас хүний эрхийг дээдлэх, авлигатай тэмцэхэд онцгой анхаарч, мөн Үндсэн хуулийн өөрчлөлттэй уялдуулан холбогдох хууль, тогтоомжуудад өөрчлөлт оруулах ажил бидний өмнө тулгараад буй энэ цаг үед хууль, тогтоомжийг хэрэгжүүлэгчдээр тогтохгүй, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, түүнтэй үр дүнтэй тэмцэх, ард иргэдийн амгалан тайван байдлыг хамгаалах бодлого боловсруулагчдын хувьд үнэтэй хувь нэмэр оруулах бүтээлийг Азийн Хөгжлийн Банкнаас орчуулан олны хүртээл болгож байгаад хувийн зүгээс болон хууль сахиулагчдын зүгээс талархал илэрхийлье.

Монгол Улсын Их Хурлын гишүүн,
Монгол Улсын Засгийн газрын гишүүн,
Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар

Орчуулагчийн үг

Энэхүү номыг Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Авлигатай тэмцэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий Прокурорын газарт хэрэгжиж буй “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн санхүүжилтээр уншигч Танд орчуулан хүргэж байна.

Зохиогч Грахам Брүүкс нь авлига, криминологи, залилангийн гэмт хэрэг зэрэг сэдвээр цөөнгүй бүтээл туурвиж, шинжлэх ухааны сэтгүүлд ч олон арван нийтлэлээ хэвлүүлсэн нэгэн юм. Авлигын талаар БНСУ, Тайвань, Кипр, Арабын Нэгдсэн Эмират зэрэг улсын эрдэмтэдтэй хамтран ажилласан туршлагатай эрдэмтэн, профессор Грахам Брүүкс нь 2017 оноос эхлэн БНСУ-ын Цагдаагийн байгууллагыг шинэчлэх тусгай зөвлөхөөр ажиллаж байна. Харин та бүхний гар дээр хүрч буй энэхүү бүтээлийг хэвлэн гаргасан ‘Palgrave Macmillan’ компани нь академик буюу судалгаа шинжилгээний чиглэлийн чанартай бүтээлийг голчлон хэвлэдэг нэр хүндтэй компани юм.

Уг бүтээл нь шинжлэх ухааны бүтээл бөгөөд орчуулагч миний бие өөрийн өчүүхэн мэдлэгийн цар хүрээ, үгийн баялагт тохируулан утгачлан монголчлох бус аль болох эх текстийн үг хэллэгийг орхигдуулалгүй, нэгэн жигд орчуулахыг хичээлээ. Гэвч орчуулга хийх явцад зарим үг хэллэг монгол хэлнээ буугдаагүй, ялгаж оноогоогүй, тогтсон нэр томъёо байхгүй байх, зарим нь монгол хэлээр оновчгүй хөрвүүлэгдсэн байх гэх мэт бэрхшээл учирсан нь орчуулгыг төвөгтэй болох, өгүүлбэрийн өнгө аяс нь монголжоогүй үлдэх зэрэг алдаа дутагдал гарсан байх талтай тул уншигч та бүхнээс хүлцэл эрье.

Авлигын криминологи

Гэсэн хэдий ч юмсыг ялган нэрлэж, дэлгэрүүлэн оновчтой болгон хэвшүүлэх нь хүмүүсийн сэтгэлгээний цар хүрээг тодорхойлж, энэ нь цаашид асуудлыг илүү нарийвчлан харах, хэлэлцэхэд тус дэмтэй байх болов уу хэмээн санаж, эх номын агуулгыг орчуулгын явцад хөндөхгүй байх зарчмыг чадах чинээгээрээ баримталсан болохыг редактор авгай нар хүлээн зөвшиж, дэмжсэнд мөн талархууштай.

Мөн уг номд социологи, криминологийн онолын зарим нэр томъёог орчуулалгүй гадаад үгийг тэр хэвээр ашиглаж хэвшсэн байгааг дагалгүй, монгол хэл дээр хөрвүүлэхийг хичээсэн болно. Түүний зэрэгцээ зарим нэр томъёог өмнө орчуулснаас өөрөөр орчуулсан байх талтай тул тодруулж харах боломжтой байх үүднээс хаалтан дотор англи нэр томъёотой хамт оруулж өгөв. Түүнчлэн номын агуулгыг ойлгоход шаардлагатай гэж үзсэн зарим зүйлд нэмэлт тайлбар орууллаа.

Зохиогч нь их сургуулийн багш, судлаач хүн бөгөөд энэхүү бүтээлээ уншигчдад хүргэхдээ юуны өмнө номын нэрнээс харагдаж буйчлан уншигчдад дүгнэж цэгнэх боломж олгохын тулд эхлээд онолын олон янзын чиг хандлага, арга аргачлалыг товч дурдаад, дараа нь авлигын асуудал руу шилжин оржээ.

Ингэхдээ маш олон газарт эх бүтээлээс эш татсан, заримдаа зөвхөн эх судалгааны дүгнэлтийг багцлан бичсэн нь олонтаа таарах бөгөөд зарим хэсгийг эх судалгааны материалыг харалгүйгээр ойлгож орчуулахад хүндрэлтэй байсныг дурдах нь зөв болов уу. Тиймээс орчуулагч миний бие нэр дурдагдсан эх судалгааны өгүүлэл, бүтээлийг боломжийн хэрээр олж үзэн, дэлгэрүүлэхийг хичээсэн болохыг тэмдэглэе. Эх судалгааны материал олдоогүй болон дутуу дулимаг ойлгосны улмаас гарсан алдааг цаашид энэхүү сэдвээр гарах бүтээлүүд шүүн тунгааж, засаж залруулах болов уу гэж найдаж байна.

Энэхүү номд олон янзын онол түүний сул ба давуу тал, тэдгээрийн тухай тайлбарууд олон давталттай тэмдэглэгдсэн

байгаа. Энэ нь зарим хүнд толгой эргэм санагдаж болох ч аливаа юмс үзэгдлийг тайлбарлах онол нь тухайн цаг үеийн хүмүүсийн юмс үзэгдлийг ойлгон, тайлбарлах оролдлогоос үүддэг. Нийгэм дэх юмс үзэгдэл, хүмүүсийн үйл хөдлөл нь олон талтай, нарийн төвөгтэй учраас ямар ч зүйлийг 100 хувь тайлбарласан онол гаргах боломжгүй. Аливаа онол заавал хязгаарлагдмал талтай байж дараагийн шинэ онолууд төрөн гарах үед шүүмжлэлд өртдөг ч өмнөх онолууд юмс үзэгдлийн тодорхой талыг тайлбарласан байдгаараа ач холбогдлоо алдахгүй хэвээр байдаг зүйл гэж ойлгох нь зүйтэй болов уу.

Онол нь ямар нэг яршиг, төвөгтэй зүйл бус амьдралаас урган гардаг зүйл агаад үүсэн гарсан орчин нөхцөл дунд нь авч үзвэл ихэвчлэн мэдээж гэмээр зүйлс байдаг бөгөөд олон янз харагдах асуудлыг системтэй, өргөн цар хүрээтэй харахад тусалж, бидний сэтгэлгээг цэгцэлж өгдөг билээ. Уг бүтээлийг энэ талаас нь харвал хялбархан ойлгож хүлээн авах болов уу.

Эцэст нь төслийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ч уг бүтээлийг орчуулах ажлыг дэмжин, төсөв хуваарилах зөвшөөрөл олгосон Төслийн багийн ахлагч, Азийн Хөгжлийн Банкны дэд суурин төлөөлөгч Дэклан Магий болон дэмжин ажилласан Төслийн багийн гишүүн Э.Батцэрэн нарт талархал илэрхийлье. Мөн уг номыг орчуулах санааг анх өгч, санал болгосон АТГ-ын Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Б.Баярсайхан, санааг дэмжсэн Судалгаа шинжилгээний албаны дарга Ц.Шинэбаяр нарт гүн талархал илэрхийлье.

Түүнчлэн орчуулгыг хянаж үнэтэй санал, зөвлөгөө өгсөн Монголын Криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга Б.Батзориг, МУИС-ийн Социологи судалгааны хүрээлэнгийн захирал О.Мөнхбат нарт талархаж буйгаа тэмдэглэе. Мөн ном орчуулах ажилд дэмжлэг үзүүлсэн АТГ-ын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, ажилтан Ж.Болорчимэг, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан

Авлигын криминологи

Т.Мөнхтунгалаг, Монголын Криминологичдын холбооны ерөнхийлөгч Г.Эрдэнэбат нарт талархал илэрхийлж байна.

*“Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь”
төслийн зохицуулагч А.Амармэнд*

2021 оны 08 дугаар сар

I

Оршил

Удиртгал

Энэхүү номыг бичих санааг Хьюсман, Ванде Валле нарын 2010 онд гаргасан ижил нэртэй бүтээлээс авсан бөгөөд социологийн болон криминологийн холбогдох онолын чиглэл буюу аргачлалуудыг авлигын үйлдэлд хэрэглэсэн байгаад энэ номын мөн чанар оршино. Социологийн эсвэл криминологийн мэдлэгтэй ч авлигын талаар тийм ч сайн мэдэхгүй хүнд, эсхүл авлигын талаар мэдлэгтэй ч социологи, криминологийн мэдлэггүй хүмүүст зориулан энэхүү номыг бичихийг зорьсон болно.

Авлигын талаар тайлбарласан ихэнх онолын урсгал нь социологи болон криминологитой зарим талаар холбогдох ч улс төр, эдийн засгийн шинжлэх ухааны салбарт багтсаар ирсэн юм. Энэхүү номоор энэ дутагдалтай талыг нөхөхийг оролдсон бөгөөд үүгээрээ авлигын талаарх бүтээлүүдийг шүүмжилсэн биш эсрэгээрээ авлигын тухай олон улсын хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулж байгаа хэрэг юм. Энэхүү ном авлигын талаарх бүтээлд хэрэглэгдэж буй онол, арга зүйг өргөтгөн, хувь хүн, байгууллага, улс орнууд яагаад, хэрхэн, авлигажсан үйлдэл хийдэг вэ гэдэг асуудлыг өргөн хүрээгээр харахад туслах

болно. Улс төрийн шинжлэх ухаан болон эдийн засгийн онол нь авлигыг хэмжих, түүнээс урьдчилан сэргийлэхэд төвлөрдөг бөгөөд гэмт хэрэгтнүүдийг ихэвчлэн рационал тоглогч гэж үздэг. Энэ нь рационал сонголт (*Wilson, Herrnstein 1985*)¹ ба хэвшмэл үйлдлийн (*Cohen, Felson 1979*) талаарх криминологийн аргачлалтай төстэй харагддаг. Гэвч тэдгээр салбарт хамаарах авлигын болон криминологийн талаарх бүтээлийн аль алинд нь оролцогчдын үйл хөдлөлийг рационал бөгөөд өөрийн эрх ашгаа харсан гэж үздэг болохоос биш хувь хүн, байгууллага яагаад авлигын үйлдэл гаргалгүй, өөрийгөө зогсоож чаддаг вэ гэдэгт төдийлөн анхаарал хандуулдаггүй. Рационал криминологийн болон авлигын талаарх бүтээлд процесс болон бүтцийг өөрчлөх замаар авлига авах боломж, бололцооноос сэргийлж, авлигын үйлдлийг хязгаарлах тал дээр анхаарч байна.

Харин социологи, криминологид авлигаас урьдчилан сэргийлэхэд ‘шийтгэл’² илүү чухал үүрэг гүйцэтгэх талаар тодорхой тайлбарладаг. Мөн хүмүүс бусадтай харилцаа үүсгэх явцдаа ‘юуг хууль зөрчсөн үйлдэл гэх вэ’ гэсэн тодорхойлолт зэргийг ажиглах замаар гэмт хэрэгт суралцдаг хэмээн үзэж (*Sutherland 1939*) ирсэн. Нөгөө талаар ‘амжилт’ гэдэг нь баялаг хуримтлуулах явдал хэмээн тодорхойлогдож байгаа үед хууль ёсоор амжилтад хүрч чадаагүй хүн хууль бус үйлдэл гаргаснаа (*Merton 1938*) саармагжуулах арга хэрэгслээр өөрийгөө зөвтгөн (*Sykes, Matza 1957*), гэмт хэргийн ертөнц рүү нэг орж, нэг гарсаар (*Matza 1964*) байдаг. ‘Бусдад’ авлигач гэсэн нэр, шошго зүүх эрх мэдэлтнүүд (*Becker 1963; Erickson 1966*) өөрсдөө авлигажсан байдаг капитализмд авлига бол зайлшгүй гэх

1 Тухайн асуудлаар цааш дэлгэрүүлж унших боломжтой бүтээлийн нэрийг зохиогч өгүүлбэр дунд хаалтан дотор бичсэнийг хэвээр үлдээв. Энэ нэрээр ашигласан материал хэсгээс бүтээлийн нэрийг харах боломжтой. Ном, бүтээлийн нэрийг хайхад хялбар байх үүднээс орчуулаагүй үлдээсэн болно. (Орч.)

2 Англи эх дээр тухайн үгийг тодотгох үед ‘’ хаалтан дотор бичсэн байгааг тэр хэвээр оруулав. Цаашид ижил. (Орч.)

үзлийн (*Dahrendorf 1958; Turk 1969; Quinney 1969; Chambliss 1975*) зэрэгцээ хүмүүс яагаад авлигаас ангид байж, авлигын үйлдлийг гаргах шунал хүслээ тэвчдэг талаарх тайлбар ч гарсан байна. Энэ номд зохиогч миний бие ‘анхдагч’ онолын тайлбарыг ихэвчлэн хэрэглэх боловч шаардлагатай тохиолдолд холбогдох орчин үеийн бүтээлээс эш татсан болно. Ингэж оруулсан шалтгаан нь социологи болон криминологийг шинээр судалж буй хүмүүс онолын ‘анхдагч’ эх үүсвэр нь үр өгөөжтэй эсэх талаарх бусдын тайлбарт найдалгүйгээр өөрөө танилцаж, үнэлэх боломжтой байлгахыг зорьсон болно.

Онол боловсруулахыг ихэвчлэн ‘хоосон бодож бясалгах’ хэрэг хэмээн үл тоодог боловч онол нь биднийг гэмт хэрэгтнүүдтэй хэрхэн харилцах, хэрхэн шийтгэх, гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ гэдэгт нөлөөлж (*Lilly нар 1989*) байдаг. Эрүүгийн шүүн таслах бодлогыг товчхон нягтлаад, хуулийн ямар заалтыг хэрэглэхэд онолын чиг хандлага хэрхэн нөлөөлж байна вэ, ямар заалт нь гэмт явдлаас урьдчилан сэргийлэх тогтолцооны гол бүтцийг бүрдүүлж байна гэдгийг харж болно.

Авлига гэдэг ойлголт нь ёс зүйгүй, гэхдээ хууль ёсны үйлдлээс эхлээд ноцтой хууль бус үйлдэл хүртэл өргөн хүрээг хамардаг учир түүнийг нийтлэг хэм хэмжээнээс гажсан эсхүл гэмт үйлдэл гэж үзэж болно. Энэ тохиолдолд ялангуяа социологи болон криминологи хэрэг болдог бөгөөд эдгээрийн талаар хязгаарлагдмал мэдлэгтэй хүмүүс энэ номын цар хүрээнээс хэтэрсэн онолын дүн шинжилгээ бүхий олон бүтээлтэй танилцаж болно (*Tierney, O’Neill 2009; Hagan 2012; Siegal 2012; Treadwell 2012; Hopkins-Burke 2013; McLaughlin, Newburn 2013; Vito, Maahs 2015*). Социологи болон криминологийн аль аль нь нийтлэг хэм хэмжээнээс гажих үйлдэл, дүрэм зөрчих, ёс зүйг зөрчих үйлдэл, гэмт хэргийн үйлдлийг тайлбарлаж ирсэн түүхтэй. Энэ номд хүмүүс яагаад авлигажсан байдаг, түүнээс хэрхэн сэргийлэх вэ гэдэг асуудлыг ихэвчлэн өнөөгийн улс төр,

Авлигын криминологи

эдийн засгийн ухааны талаас хийж буй тайлбараас илүү өргөн хүрээнд авч үзэх болно.

Хүмүүс яагаад авлигын үйлдэл гаргаж, гэмт хэрэг үйлддэг болохыг судлан мэдэх эрэл хайгуул нь нийгмээс ангид, тусгаарлагдсан орчинд явагддаггүй. Харин ч өөрчлөгдөн буй нийгмийн нэг хэсэг болж байдаг. Авлига яагаад гарч байгааг ойлгох нь түүнийг хянаж, түүнээс урьдчилан сэргийлэх урьдач нөхцөл болно. Өдгөө онолын аргачлалууд нь бодлогын өөрчлөлтийг санал болгох, эсхүл бодлогын өөрчлөлт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлж, түүнийг бууруулах хамгийн сайн арга юм гэж зөвтгөж чадах хэмжээнд хүртэл хөгжөөд (*Lilly nap 1989*) байна. Онолын аргачлал нь ихэвчлэн хувь хүний хариуцлага, сайн сайхан байдалтай холбогддог хяналтын (*Garland 2001*) болон урьдчилан сэргийлэх (*Clarke 1980; O'Malley 1992; Clarke 1997; Farrington nap 2003; Crawford 2009*) арга хэрэгслийг зөвтгөж эсхүл зөвтгөх процессыг туулдаг. Гэвч тэдгээр нь цаг хугацааны эрхээр нийгэм, улс төрийн нөхцөл байдалд илүү тохирсон 'шинэ' аргачлалын нөлөөнд дарагддаг. Бодлогыг өөрчилж, эсхүл хэвээр хадгалж буй онолын тайлбар дахь өөрчлөлт нь улс төр, нийгмийн өөрчлөлт, түүнээс үүдэн гэмт хэрэгтнийг харах өнцөг өөрчлөгдсөнөөс үүсэн гардаг байна. Гэхдээ өмнөх аргачлал зүгээр алга болчихгүй. Түүний элемент нь боловсруулагдсан шинэ аргачлалын хэсэг болж үлдэнэ. Энэ номд авлигын үйлдлийг тайлбарлахад дөхөм болох хамгийн их хамаарал бүхий онолын аргачлалын хөгжлийг зураглан харуулна.

Цагаан захтны гэмт хэрэг болон эрх мэдэлтнүүдийн гэмт хэрэг дээр төвлөрсөн Ялгаатай нөхөрлөлийн онолоос (*Sutherland 1939*) гадна зөрчилдөөний талаарх бүтээлүүдийг (*Dahrendorf 1958; Turk 1969; Quinney 1969*) эс тооцвол эдгээр анхдагч социологи, криминологийн онолын аргачлалд авлигын талаар дурдах нь ховор, ихэвчлэн гудамжны гэмт хэрэг дээр төвлөрч байв. Харин эдгээр анхдагч тайлбарын сайжруулсан

хувилбарууд нь гудамжны гэмт хэргийн хүрээнээс халин гарч, авлигын талаарх хэлэлцүүлэгт социологи, криминологи хувь нэмэр оруулж болохыг (*Agnew 1992; Agnew, White 1992*) харуулжээ. Авлигыг онолын тогтолцоонд авч үзэх юм бол түүнийг салбар дамнасан, эсхүл хил дамнасан хүрээнд, олон улсын түвшинд ойлгох хэрэгтэй болно.

Номоо эхлэхээс өмнө тодруулах хэдэн зүйл бичье. Үргэлж биш ч ихэнх тохиолдолд энэ номд корпорацаас илүү байгууллагыг заан бичлээ. Яагаад гэвэл авлига нь корпорацад хамаарах зүйл бус улс орон, төрийн бус байгууллага болон бүхий л төрлийн байгууллагад тохиолддог зүйл юм. Корпорац нь хамгийн жигшмээр авлигын үйлдлийг авлигажсан төртэй хамтран үйлдэх нь бий. Бүх байгууллага том, жижиг байхаас үл хамааран авлигын үйлдэл гаргадаг. Мөн энэ номд ‘авлига’ гэсэн нэр томьёонд хамаатан садандаа туслах зэрэг хууль ёсных боловч ёс зүйгүй үйлдэл болон залилан мэхлэх зэрэг илтэд гэмт үйлдлийн аль алиныг багтаав. Эдгээр ойлголтууд нь авлига³ гэсэн цогц ойлголтын дотор багтана (*Brooks nap 2013*). Гэхдээ зарим тохиолдолд ‘авлигын гэмт хэрэг’ гэдэг нэр томьёонд ёс зүйтэй холбоотой үйлдэл бус тодорхой гэмт үйлдэл гаргасан жишээг багтаав.

Авлигын үйлдлийг зарим тохиолдолд цагаан захтны гэмт хэрэг гэж нэрлэдэг бөгөөд энэхүү нэр томьёо Америкийн зохиолчдын бүтээлүүдэд голлон (*Wheeler nap 1982; Weisburd nap 1991; Weisbur, Waring 2001*) дурдагддаг. Эдгээр бүтээлд цагаан захтны гэмт хэрэгт ихэвчлэн залилан мэхлэх, луйвардах болон хуйвалдах үйлдэл холилдсон эдийн засгийн гэмт хэргүүдийг багтаан бичигдсэн байдаг (*Weisburd nap 1991; Weisburd, Waring 2001; Shover, Hochstetler 2006; Ferguson*

3 Англи хэлний corruption буюу авлига гэдэг үгийн үндэс нь эвдрэх гэдэг утгатай учир энэхүү нэр томьёо нь маш өргөн утгаар хэрэглэгдэж ирсэн нь энэ номд тусгалаа олсон байгааг цаашид анхаарна уу. (Орч.)

2010; Gottschalk 2010; Payne 2013). Энэ нэр томъёо дараа нь Европт тархан дэлгэрсэн (*van Erp нар 2015*) ажээ.

Ийм өргөн хүрээтэй тодорхойлолт нь цагаан захтны гэмт хэргийн төрөл, гэмт хэргийн нарийн төвөгтэй байдал, холбогдсон хүмүүсийн тоо, хохирлын зэргийн үүднээс аваад үзвэл асуудалтай байдаг. Энэ номд залилан мэхлэх гэмт хэрэг болон цагаан захтны гэмт хэргийг хооронд нь ялгасан болно. Бусад бүтээлүүдэд эдгээр гэмт хэргийг төдийлөн ялгаагүй бөгөөд үүний шалтгаан нь цагаан захтны гэмт хэрэгт зөвхөн гэмт хэрэгтний албан тушаалыг заадаг. Жишээ нь, хэрвээ албан тушаалтан ашиг хүртэх зорилгоор залилан мэхлэх хэрэг үйлдвэл үүнийг цагаан захтны гэмт хэрэг (түүний зэрэгцээ залилан) хэмээн тодорхойлдог. Харин ажил эрхлээгүй хэн нэгэн хүн энэ төрлийн гэмт хэргийг үйлдвэл түүнийг залилан гэж үзэж ирсэнтэй холбоотой юм. Эндээс хоёр этгээд ижил төрлийн гэмт хэрэг үйлдсэн боловч гэмт хэрэгтнүүдийн албан тушаал, нийгмийн статус нь гэмт хэргийн төрлөө тодорхойлоод байгаа нь харагдаж буй. Тиймд будилахаас сэргийлж боломжтой тохиолдолд гэмт хэргийг мөнгө угаах, залилах, хахуульдах гэсэн нэр томъёогоор ангилав.

Асуудлын тодорхойлолт

Мэдлэгийн салбар болохын хувьд криминологи нь гэмт хэргийн статистикийн сул болон ашигтай тал, мөн гэмт хэргийн бүртгэлийн асуудалтай тал, түүнээс үүдсэн гэмт хэргийн хэмжилтийн асуудлыг судалж ирсэн түүхтэй. Коулман, Мойнихан нар (*Coleman and Moynihan 1996*) гэмт хэргийг хэрхэн бүртгэдэг, гэмт хэргийн статистик нь гэмт хэргийг яагаад нэлээд дутуу бүртгэдэг болохыг тайлбарласан. Эрүүгийн тогтолцоо нь мэтгэлцээний (*adversarial*) болон мөрдөн шүүх (*prosecutorial*) тогтолцооны аль нь байхаас үл хамааран, цагдаагийн ажилтан өөртөө итгэлгүй байх, цагдаад үл итгэх, өөрөө гэмт хэргийн хохирогч хэрнээ гэмт хэрэг

үйлдээд байдаг, эсхүл үнэ цэн багатай эд зүйл хулгайд алдагдах зэрэг ижил төрлийн асуудлуудтай тулгарч (*Bottomley, Coleman 1981; Bottomley, Pease 1986*) байдаг. Гэмт хэргийн статистик асуудалтай байсан ч гэмт хэргийн үзүүлэлтийн баримжаа болдог гэдэг талаас хүлээн авч, хязгаарлагдмал талуудыг нь мэдэж байвал тэдгээр нь зорилгоо гүйцэтгэж, үр дүнтэй байх болно. Бүртгэгдсэн гэмт хэргийн статистик нь дээр дурдсан хязгаарлалтууд байдаг ч гэмт хэргийг хэтэрхий савалгаатай, оновчтой бусаар сэтгэл хөдлөлд автаж харахгүй байхад тусалдаг бөгөөд энэ нь цагдаагийн байгууллага хэрхэн ажиллаж байгааг харуулж (*Jones 2006*) байдаг. Жишээлбэл, хэн, аль байршилд, ямар гэмт хэрэг үйлдэж байгаад анхаарал хандуулаад үзвэл баривчилгаа болон яллах ажиллагааны талаарх статистикийг илүү гүнзгий ойлгох боломжтой. Үүнээс гадна залилан мэхлэх зэрэг ‘нуугдмал гэмт хэргийг’ бүртгэхэд тулгарах асуудлын талаар авч үзсэн бүтээлүүд бий (*Levi, Burrows 2008; Button 2011*). Авлига нь байнга үйлдэгдээд байхгүй, хүчирхийллийн шинжгүй ч бусад гэмт хэрэгтэй адил ‘нуугдмал’ байдаг учраас үйлдэгдэж буй тоо хэмжээг үнэлэхэд (*Heywood 2015*) хүндрэлтэй байдаг. Мөн хохирогчдын тоог тодорхойлоход хүндрэл учирдаг.

Хэрэглэж буй онолын аргачлалаас шалтгаалан гэмт хэргийг янз бүрээр тодорхойлсон байдаг. Диттон (*Ditton 1979*) үзэхдээ шүүхээс яллагдагчийн гэм бурууг эсхүл гэм буруугийг тогтоох хүртэл түүнийг ямар ч гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй гэжээ. Гэхдээ хууль зөрчсөн хүн бүрт ял тулгаж чаддаггүй. Тухайлбал, зарим хэрэгтэнд анхааруулга өгөөд орхидог бол зарим гэмт хэрэгтнийг нас барсны дараа хэрэг нь илэрч, зарим хэргүүд үүрд нууц хэвээр үлддэг.

Гэхдээ эдгээр тодорхойлолт нь олон салаа утгыг агуулж байдаг. Тухайлбал, эрүүгийн хууль нь гэмт хэрэгт үзүүлэх хариу үйлдэл болохын зэрэгцээ түүний албан ёсны тодорхойлолт болдог. Энэ нь яагаад зарим төрлийн гэмт хэргийг гэмт хэрэгт тооцох болсныг, нөхцөл байдлаас шалтгаалан

Авлигын криминологи

төсөөтэй үйлдлүүд яагаад хүлээн зөвшөөрөгдөх, эсхүл хүлээн зөвшөөрөгдөхгүй байхыг, яагаад зарим гэмт үйлдлийг хүчингүй болгогчийг тайлбарлаж чаддаггүй. 1919-1933 оны АНУ-ын архины хоригийн Волстийдийн хууль бол нэг жишээ юм. Мөн дайны үед энгийн иргэнийг алах, эсхүл дайсны цэргийг алах, үр хөндөлтийг аль өнцгөөс хэрхэн харж буйгаас хамааран АНУ-ын мужуудын хууль ялгаатай байдаг нь үүний тод жишээ болно. Тиймээс гэмт хэргийг тодорхойлох нь ярвигтай ажил бөгөөд дараах бүлгүүдээр дэлгэрэнгүй авч үзэх онолын үндэслэлээс ихэвчлэн хамаардаг байна.

Бүхий л гэмт хэргийн статистик нь гэмт үйлдлийг хэмжих нь зүйтэй эсэх талаар маргааныг дагуулдаг. Зохиогчийн хувьд энэ нь зүйтэйгээр барахгүй зайлшгүй зүйл гэж үзэж байна. Гэмт хэргийн статистикт дутагдал байдаг гэх үндэслэл нь статистик мэдээлэл гаргахаа болих шалтгаан болохгүй. Зарим статистик, бүртгэл одоог хүртэл хэрэгцээтэй байна. Аливаа бодлого, стратегиар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгохын тулд тухайн хэргийн талаар ямар нэгэн чиг баримжаа хэрэгтэй байдаг. Тиймээс гэмт хэргийг хэмжих болон онолын илүү нарийн аргачлал боловсруулах нь тухайн асуудлын талаарх бидний мэдлэг, зарим үед, хохирлын түвшний талаарх мэдлэгийг нэмэгдүүлж байдаг.

Авлига гэдэг ойлголт, түүний шалтгаан, хэмжилт, байршил, үр дагавар, түүнээс хэрхэн сэргийлэх талаар бичигдсэн бүтээлүүд олон бий (*Philip 1997; Gardiner 2002; Johnston 2005; Golden, Picci 2005; Doig 2011; Brooks нар 2013; Heywood 2015; Hough 2015*). Гэхдээ авлигыг хэмжихээс өмнө зөв тодорхойлолттой байх шаардлагатай ч тэр нь байнга маргаантай байдагт асуудал оршдог. Энд 1990-ээд оны авлигатай тэмцсэн хамгийн хүчтэй оролдлого нь бодлогын том бүтэлгүйтэл болсон явдлыг дурдаж болно (*McCusker 2006; Persson ба бусад 2010; Heeks, Mathisen 2012; Heywood 2015*). Энэ нь магадгүй хийгдсэн судалгааны олонх нь хохирлын үнэлгээний гол нэгжээр тусгаар улсыг авч

үзэж ирсэн, ялангуяа авлигыг хэмжих, түүний шалтгааныг тодорхойлох зорилгоо тусгаар улс руу түлхүү чиглүүлэн авч үзэж ирсэнтэй холбоотой. Практикт бодит авлигын тохиолдол нь орон нутгийн шинж чанартай, тодорхой нөхцөлд үйлдэгдэж, салбар доторх болон салбар хоорондын ялгаанаас болж улс орны хүрээнд шууд нөлөө өгдөггүй ч олонх тохиолдолд авлига нь улс орон дамнасан шинжтэй байдаг (*Heywood 2015*).

Дийлэнх судалгаанд авлига, ялангуяа улс төрийн авлигыг төрийн албаны асуудал гэж үздэг. Үүний зэрэгцээ хувийн хэвшил төрийн албатай ямар ч холбоо хамааралгүйгээр авлигажсан байж болно (*Hough 2015; Heywood 2015*) гэдэг асуудал хүлээн зөвшөөрөгдөхийн хэрээр авлигыг төрийн албаны асуудал гэх ойлголт аажмаар хувьсан өөрчлөгдөж байна. Төрийн албыг цомхотгон, төрийн ажлыг хувийн салбараар гүйцэтгүүлэх болсноор төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх хэлбэрт томоохон өөрчлөлт орж байна. Энэ нь ‘авлигажсан’ хэмээн муу хэлэгддэг улсын салбар (*Tanzi 1998, 2000*) ба хувийн хэвшлийн ялгааг бүдгэрүүлж эхэлсэн бөгөөд улсын болон хувийн хэвшлийн хооронд үүсэх хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой авлигын шинэ эрсдэлийг үүсгэх боллоо.

Тиймээс авлигын асуудалд зөвхөн төрийн албаны авлигыг онцлон авч үзэх нь төөрөгдөл үүсгэх төдийгүй авлигын цар хүрээ, буруутныг алдаж харсан хэрэг болох юм. Хэйвүүд (*Heywood 2015*) тэмдэглэхдээ авлига гэсэн ойлголтыг хэрхэн авч үзэх, жишээ, баримтыг хэрхэн судлан шинжлэхээ сайтар нягталсны дараа сая үр дүнтэй тэмцэх боломжтой болно гэсэн байдаг. Энэ номын зорилго нь энэхүү хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулахаас гадна авлигыг тайлбарлах, ойлгох, бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэхэд хэрэг болох байдлаар социологи болон криминологийн онолын аргачлалыг хэрэглэхэд анхаарал хандуулахад оршино.

Эрх мэдлээ урвуулан ашиглах, олон нийтийн итгэлийг алдах, хүлээсэн үүргээ зөрчих, хувьдаа болон байгууллагадаа санхүүгийн ашиг тус хүртэх зэрэг нь авлигын нийтлэг бүрдэл хэсэг (*Bowman, Gilligan 2007; Brooks нар 2013*) юм. Энд дурдсан бүрдэл хэсэг нь бүрэн бус бөгөөд авлигыг ангилах оролдлого нь авлигад хандах соёл, нийгэм, хууль зүйн хандлагаас хамааран өөр өөр байж иржээ. Авлигын тухай тов тодорхой тодорхойлолт гаргах нь боломжгүй асуудал биш гэлээ ч хэцүү зүйл бөгөөд ийм тодорхойлолттой байлаа ч гэсэн авлигыг хэмжихэд (*Anderson, Heywood 2009; Brooks нар 2013*) хүндрэлтэй, авлига нууцлаг түвшинд явагддаг, илрүүлэхэд хэцүү (*Sandholtz, Gray 2003*) гэх асуудал байсаар байна Ялангуяа үндэстэн дамнасан авлига нь тодорхой байршилд уягдахгүй, улсын хил хязгаарт (*Becker нар 2009*) баригдахгүй. Эдгээр нарийн төвөгтэй асуудлаас гадна улс орнуудын соёл, нийгэм, улс төрийн хөгжлийн ялгаа нь авлига гэж юу болох, аль улсын мөрдөн шалгах харьяалалд байх вэ гэдэг асуудлыг улам хүндрүүлнэ. Цаашлаад авлигын талаарх олон улсын ихэнх хууль тогтоомжуудыг барууны орнууд гаргасан байгаа бөгөөд үүнийг хүчтэй өрсөлдөгч болон гарч ирж буй хөгжиж буй орнуудыг дарамтлах шинэ төрлийн хяналтын хэлбэр хэмээн харж (*Brooks нар 2013*) болно. Авлигыг бүхлээр нь цогц ойлголт гэж харах нь хамгийн зөв хувилбар байж болох юм. Яагаад гэвэл авлига нь ёс зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдөхгүй ч хууль ёсны үйлдлээс авахуулаад ноцтой хууль зөрчсөн үйлдэл, улсын болон хувийн хэвшилтэй холбогдсон гэмт үйлдэл, ганцаар эсвэл хамтран үйлдэгдэх гэсэн янз бүрийн хэлбэртэй байж болно. Барууны орнуудад төр нь үйлчилгээ хүргэх тал дээр монопол байсан уламжлалтай. Харин төрийн үйлчилгээний ихэнх хэсэгт бодлогын шийдвэрийг бодлогын хэрэгжилтээс салгахыг дэмжсэн улсын салбарын шинэ менежмент (NPM) хэрэгжих болсноор энэхүү монопол нь

төрийн аппаратын ‘Балканжилт’⁴-тай хамт аажмаар хоцрогдож эхэлсэн (*Heywood, Wright 1997:91*) юм.

Гэсэн ч улсын салбарын шинэ менежментийн (NPM) шинэчлэл нь авлигын шинэ боломжуудыг нээжээ. Төрийн албан хаагчид хэдэн жил ажилламагцаа, эсхүл тэтгэвэрт гармагцаа хувийн хэвшлийн өндөр цалинтай албан тушаалд томилогдох юм уу эргээд төрийн албанд орж ирэх буюу төр, хувийн хэвшил хоёрыг сэлгэн ажиллах болсноор ашиг сонирхлын зөрчил нэмэгджээ.

Хувийн хэвшлийнхэнд төрийн албаны процедур, үйл явцын тухай мэдлэг, танил тал маш үнэ цэнэтэй байж ирсэн. Улсын салбарын шинэ менежмент нь дор дурдсан хүмүүст шинэ бололцоо нээсэн хэдий ч тэднийг авлигажсан хүмүүс гэж хэлж болох юм.

Жишээлбэл, Английн Баглан хамгаалахын сайд байсан Жеофф Хүүн 2011 онд AgustaWestland⁵ компанитай сонгон шалгаруулалтгүйгээр гэрээ байгуулсан байдаг. Үүний дараа Жеофф Хүүн нь тус компанийн Олон улсын худалдаа хариуцсан Дэд ерөнхийлөгч болжээ.

Мөн Онц ноцтой залиланг мөрдөх алба нь ‘BAE Systems’ компанийг Саудын Арабад зэвсэг нийлүүлсэн хэрэгт шалгаж байв. Гэвч Саудын Араб дахь Их Британийн элчин сайд байсан Сер Күпер-Колес мөрдлөгийн ажлыг зогсоох шахалтыг Онц ноцтой залиланг мөрдөх албанд үзүүлж байжээ. Үүнийхээ дараа 2011 оны 2 дугаар сард Сер Күпер-Колес нь ‘BAE Systems’ компанийн Олон улсын бизнесийн хөгжлийн албаны даргаар томилогджээ.

4 18 дугаар зууны сүүл 19 дүгээр зууны эхэнд Австри-Унгарын эзэнт улс ба Оттоманы эзэнт улсын задралын дараагаар Балканы хойгт бие биедээ дайсагнасан, хамтран ажилладаггүй олон жижиг улс бий болж хуваагдсантай зүйрлэсэн хэллэг. (Орч.)

5 Нисдэг тэрэг үйлдвэрлэгч Англи Италийн хамтарсан компани. (Орч.)

Авлигын криминологи

Агаарын хүчний боловсон хүчний албаны дарга асан, агаарын ахлах маршал Сер Глен Торпи ч 2011 оны нэгдүгээр сард тус компанийн Ахлах зөвлөх болсон (*Heywood 2015:10*) байна.

Хүмүүсийн ийм хөдөлгөөн нь нэг байгууллага нууц мэдээллийг дангаараа төвөггүй олж авах, эсхүл нууц мэдээллийн гарцыг ганцхан компанид нээж өгөх гэх мэт тэнцвэргүй байдлыг бий болгодгоороо онцлогтой. Энэ нь төрийн худалдан авалтанд оролцохоор тендерийн материалаа шударгаар бүрдүүлж байгаа маш олон байгууллагыг хохироож байдаг юм.

Тиймээс нууц мэдээллийг хувийн хэвшилд хэрхэн ашиглуулах чиглэлээр хэд хэдэн улсын хуулийн байгууллага анхаарлаа хандуулах (*Della Porta, Vannucci 1997:75*) болжээ. Үүний үр дүнд хувьчлал нэмэгдсэн байна. Түүнээс гадна өмнөх хамтран ажиллагсдаа лоббидох, албаны мэдээллийг зүй бусаар ашиглах, хуулийн хүрээнд эсхүл хуулиас гадуур албан тушаалаа урвуулан ашиглах, ямар нэгэн хэлэлцээрт зуучлал хийх үйлдэл хийж түүнийхээ төлөө шан харамж, хээл хахууль авсан, хөрөнгө завшсан байх гэж сэжиглэгдсээр байдаг ‘бизнес-улс төрчид’ ч олширчээ.

Ирээдүйд авлига нь хамгийн зохицуулалт багатайгаараа онцлогтой санхүү болон улс төрийн салбар хоорондын талбарт оршин тогтнох чиг хандлагатай болжээ. Энэ нь авлигын шинэ талбар болох бөгөөд түүнд авлигатай тэмцэх байгууллагууд хүрч ажиллаж чадахгүй байж мэдэх юм. Үүнийг Мексикийн картелийн хөрөнгийг Deutsche Bank-ны хөрөнгөтэй нийлүүлж ЛИБОР⁶-ын зээлийн хүүг барихад оролцсон HBOS нэгдлийн жишээ, (*Hosking, Wilson 2015; Wilson 2015*) болон 2015 оны АНУ-ын сонгуульд нэр дэвшсэн зарим улстөрчийн

6 Лондонгийн мөнгөний зах зээл дээр гарсан тодорхой банкнуудын банк хоорондын дундаж хүүг тооцож гаргасан хүүг ингэж товчилсон үгсээр нэрлэдэг. (орч.)

санхүүжилтийг Воол Стрийт даасан баримтаас харж болно. Воол Стрийтийнхан улстөрчид угаасаа татвар төлөгчдийн мөнгөөр ‘баталгаа’ гаргана гэдгийг мэдэж байсан бөгөөд ингэхдээ тэд Додд Франкын⁷ хуулийн (*эрсдэлтэй зээл олгох, далд төлбөрийн заль хэрэглэхээс сэргийлсэн хууль*) зарим хэсгийг хүчингүй болгоно, улмаар тэд урьдын адил эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийх боломжтой болно гэсэн ойлголцол дээр үндэслэн улстөрчдийн сонгуулийн кампанид санхүүжилт хийсэн. Үүнийг мөрий тавьсан хэрэг хэмээн нэрлэх нь илүү оновчтой биз ээ.

Тиймээс дээр дурдсан шинэ нөхцөл байдлын улмаас “Транспэрэнси интернэшнл”-ийн (2012) олон удаа эшлэгддэг ч бас сул тал бүхий хэллэг болох ‘өөрт нь олгосон эрх мэдлийг хувьдаа ашиглах’ гэдэг хэллэгийг хэрэглэхээс зайлсхийх болно. Маш өргөн хүрээг хамардаг, улс төрийн болон соёлын үүднээс тодорхойлогддог зүйлийг бүхий л нөхцөл байдлыг багтаасан нэг тодорхойлолтод уях гэж оролдох нь авлигын үйлдлийг багтаана гэхээс илүү орхигдуулах талтай. Харин криминологи, социологи нь нөхцөл байдалд хамаагүй илүү оновчтой аргачлалыг санал болгож, авлигыг цогц хэлбэрээр авч үзэн, хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, гэмт хэрэгт тооцогдохгүй үйлдлээс гэмт үйлдэл хүртэлх бүхий л төрлийн үйлдлийг цогцоор нь тодотгон, шинжлэхэд тус болно.

Номын товч агуулга

Уншигчид сонирхлоосоо хамаарч энэхүү номын бүлгүүдийг дэс дарааллаар нь эсвэл энд тэндээс нь нэг нэгээр нь сонгон уншиж болно. Бүлэг бүрт онолын аргачлалын тухай товч тойм оруулаад дараа нь онолын хэрэглээ, авлигыг ойлгоход хэрэгцээтэй эсэх талаарх шинжилгээг оруулсан байгаа.

7 АНУ-д тухайн хуулийг хууль санаачлан, өргөн барьсан гишүүдийн нэрээр нэрлэх явдал түгээмэл байдаг. (Орч.)

Авлигыг судлах нь: Салбар дамнасан асуудал гэсэн гарчигтай II бүлэгт авлигыг тайлбарлах социологи болон криминологийн онолын аргачлал дээр голчлон төвлөрнө. Ингэхдээ авлигын цар хүрээг бүхэлд нь хамрах салбар хоорондын аргачлал хэрэгтэй болохыг тодотгодог хууль, улс төр, эдийн засаг, соёлын аргачлалыг хэрэглэнэ. Тиймээс энэ бүлэгт салбар хооронд маргаангүйгээр хүлээн зөвшөөрөгдөх ‘зөв тодорхойлолт’ гаргахад учирч болох саадыг нарийвчлан авч үзнэ. Хэдийгээр салбар бүр өөрийн түлхүүр ойлголтыг товойлгон гаргаж янз бүрээр тайлбарлах нь хэрэгтэй ч энэ нь авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг улам төвөгтэй болгодог. Гэхдээ эрх мэдэл гэдэг ойлголт, түүний хэрэглээ, ашиглалтыг тайлбарладаг социологи болон криминологийн онолын аргачлал нь авлигыг тодорхойлоход чухал болохыг тэмдэглэх хэрэгтэй. Тиймээс энэ бүлэгт авлигыг нийгэм, улс төрийн агуулгаар авч үзэнгээ социологи/криминологийн бүтээлүүдэд түшиглэн ‘авлига’ гэж юу вэ гэсэн асуудлын нарийн төвөгтэй талыг харуулна. Мөн авлига түүний янз бүрийн талуудыг тодотгосон онолын аргачлалыг цогцоор авч үзэх болно.

Авлигын цар хүрээ гэсэн гарчигтай III бүлэгт авлигын цар хүрээг хэмжих асуудалд анхаарал хандуулна. Энд одоогоор бий болоод буй янз бүрийн хэмжих аргачлалыг авч үзсэн бөгөөд мөн хэвлэгдэн гарсан төсөөллийн судалгаа, өөрөө мэдүүлэх судалгаа, ажиглалтын судалгааны хамрах хүрээ (*McCusker 2006; Heywood нар 2015*) ба тэдгээрийн давуу болон сул талуудыг багтаасан болно. Дараа нь авлигын цар хүрээ эсхүл авлигатай тэмцэх стратеги/санаачилгууд амжилтад хүрсэн эсэхийг зөвөөр ойлгоход учирч буй бэрхшээлийн талаар авч үзнэ. Түүврийн хэмжээ болон тодорхой хэмжилтүүд, нарийн төвөгтэй болсон явдлын аль аль нь өмнө нь бидний хүрч чаддаггүй байсан авлигын цар хүрээг баримжаалах боломжийг олгож буй гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Авлигыг тайлбарлах нь: Ялгаатай нөхөрлөлийн онол гарчигтай IV бүлэгт цагаан захтны гэмт хэргийн талаарх Садерландын (1939)-ын тайлбарыг авч үзнэ. Энд авлигыг ойлгоход тус болох жишээнүүд бий. Садерландын тайлбар нь гудамжны биш цагаан захтны гэмт хэрэгт төвлөрсөн учраас ‘костюмтай хүний гэмт хэрэг’-ийг ойлгох эхлэлийн цэг болж өгдөг. Нөгөө талаар социологи/криминологийн хөгжил болоод хувь хүн ба байгууллагын авлигыг тайлбарлахад чухал байр суурь эзэлдэг юм.

Уг тайлбар нь Зөрчилдөөний онолтой холбоотой мэдлэгийн салбарын нэг хэсэг гэж тооцогддог ч ‘корпорац’-ыг ‘мөлжлөгийн байгуулал’ гэж (VII бүлэгт дурдсан зөрчилдөөний онолын бусад эрдэмтэдтэй адилгүй) үздэггүй. Энэ нь авлигын гэмт хэрэг үйлдэгчдийг улс төрийн бус өнцгөөс харах боломжийг олгох ба цаашид авлигын талаар онолын хэлэлцүүлэг өрнүүлэх талбарыг бий болгоно. Жишээг автомашин үйлдвэрлэгчид болон дайны бүсэд ‘ажиллаж’ буй хувийн цэргийн гэрээлэгчийн асуудлаар харуулсан болно.

Авлигыг тайлбарлах нь: ‘Орчин үеийн’ дэлхий ертөнцөд дарамтыг мэдрэх нь гарчигтай V бүлэгт ‘дарамт’-ын талаарх ойлголт нь авлигын талаарх бидний ойлголтод ямар хувь нэмэр оруулахыг судална. Гол төлөв хувь хүний болон байгууллагын санхүүгийн амжилт, хэрэглээгээр хэмжигддэг капитализм хэт давамгайлсан ертөнцөд дарамт нь болзошгүй авлигын үйлдлийн талаар багагүй төсөөлөл (Merton 1938; Agnew 1992; Schoepfer, Piquero 2006; Langton, Piquero 2007) өгнө. Сансрын тандан судалгаа болон эрүүл мэнд зэрэг өргөн цар хүрээтэй салбар дахь авлигын үйлдлийг шинжлэхэд дарамтын онолыг хэрэглэнэ. Тиймээс ‘орчин үеийн ертөнц’-д дарамтад автаж буй хувь хүн, байгууллага, улс орон дээр төвлөрч, өнгөрсөн, одоо, ирээдүйн авлигын үйлдлийг тайлбарлана.

Авлигыг тайлбарлах нь: Авлигын ертөнц рүү гулсан орж гарах ба саармагжуулах арга хэрэгсэл гарчигтай VI бүлэгт авлига бол сонголт бөгөөд хувь хүн, байгууллага нь олон янзын хүчин зүйлээс хамаарч гулсан орж ч болдог, гарч ч болох зүйл гэдэг тайлбарыг (*Matza 1964*) авч үзнэ. Мөн хувь хүн, байгууллагууд авлигажсан үйлдлээ зөвтгөхөд ашигладаг саармагжуулах арга хэрэгслийн талаар (*Sykes, Matza 1957*) үзнэ. Энэ хэсэгт авлига бол тогтсон зүйл биш уян хатан зүйл гэж харах болно. Энэ аргачлал нь хувь хүн/байгууллага нь санхүүгийн, спортын, автомашины салбарын эдийн засгийн нөхцөл байдалд үзүүлэх хариу үйлдэл болгон тодорхой цаг хугацаанд яагаад авлигажсан болон ёс зүйтэй үйлдлийг зэрэгцүүлэн хийж, авлигын үйлдэл рүү гулсан орж, гарч байдгийг ойлгоход тустай.

Авлигыг тайлбарлах нь: Бид яагаад бүгдээрээ авлигын үйлдэл гаргадаггүй вэ гарчигтай VII бүлэгт авлигын талаарх ихэнх онолын тайлбараас ялгаатай арга зүйд түшиглэсэн бөгөөд яагаад авлигын хэрэг өдүүлдэг вэ гэдэгт биш хүмүүс хэрхэн авлигаас ангид байдаг вэ гэдэгт төвлөрсөн (*Hirschi 1969; Hirschi, Gottfredson 1987*) болно. Авлигаас ангид байхын гол түлхүүр нь хуулийн сүрдүүлэг, шийтгэл биш нийгэмд нөхцөлдүүлэх (*social conditioning*⁸) явдал болон хувь хүний дотоод хяналт болж таарна. Энэ тухай онолын тайлбарыг авч үзсэний дараа бид анхаарлаа гадаад хяналт руу чиглүүлнэ. Учир нь урьдчилан сэргийлэх боломжийн талаарх тайлбар үүнд хамаатай байдаг.

Авлигыг тайлбарлах нь: Зөрчилдөөний ‘тогтолцоонд’ авлига гарцаагүй юу гарчигтай VIII бүлэгт ‘бизнес’ нь эцэстээ хэрхэн зөрчилд хүргэдгийг судлаад, авлига нь мөлжлөг дээр суурилсан тогтолцооны нэг хэсэг болохыг (*Quinney 1969, 1975, 1977*) харуулна. Энэ бүлэгт ‘шинэ капиталист улс’ болох ОХУ-аар жишээ татлаа. Авлига болон зөрчилдөөний тогтолцоон

8 Social conditioning гэдэг нь хувь хүмүүсийг нийгэмд нийтээр хүлээн зөвшөөрсөн биеэ авч явах дадалд сургах үйл явцыг заасан социологийн ойлголт. Socialization буюу нийгэмшихээс илүү хүчтэй ойлголт. (Орч.)

дээр бий болсон (*Rawlinson 2012*) тус улсад өсөн нэмэгдэх ашгийн төлөөх мөлжлөг, заль мэх явагдсаар байгаа бөгөөд энэ нь иргэд, нөөц болон улс орны асуудал болон тэлж байна. Өөр өөр төрлийн капиталист улсууд болон социалист улсууд бүгд л авлигатай нүүр тулдаг тул авлигаас сэргийлэх эрс тэс арга хэмжээ авахыг би санал болгохгүй. Гэхдээ тэдэнд ялгаа бий. Капиталист улсад ихэвчлэн санхүүгийн системд гол эрх мэдэл оршиж байдаг бол социалист улсад албан тушаалын эрх мэдэл нь хүнд суртлын бүтцэд багтаж, авлигад өртөх боломжийг бүрдүүлж байдаг. Мөн энэхүү бүлэгт баялгийг бий болгон хуваарилах бүхий л улс төрийн тогтолцоо, арга барил нь авлигажсан хүн, байгууллагатай зөрчилддөг болохыг онцлон авч үзнэ.

Авлигыг тайлбарлах нь: Байгууллага, институц, хувь хүмүүст авлигажсан гэх нэр шошго зүүх эрх мэдэл гэсэн гарчигтай IX бүлэгт хувь хүн/байгууллага/улсыг дур зоргоороо, хууль зөрчдөг, авлигажсан гэж хаяглах эрх мэдлийн талаар авч (*Becker 1966*) үзнэ. Тиймээс эрх мэдэл гэдэг ойлголт энэ бүлгийн гол хэсэг байх болно. Эрх мэдлийн талаарх энэ санааг шүүмжилж болох бөгөөд ерөөс ийм шүүмжлэл үүсдэг ч, аливаа үйл явдал эсхүл хувь хүнийг тодорхойлох эрх мэдэл нь үргэлж маргаантай байж ирсэн юм. Жишээлбэл, 1989 оны Английн Хилсбороу цэнгэлдэх хүрээлэнгийн ослыг нэрлэж болох юм. Энэ үеэр хөл бөмбөгийн дэмжигчдэд ‘араатнууд’ гэсэн шошго зүүсэн байдаг. Үүнээс гадна ОУВС, Дэлхийн банк авлигын талаарх яриа хэлэлцээрт давамгайлах нөлөөтэй байж төрийн албыг авлигын эх үүсвэр гэж хаяглах асуудал одоо ч байсаар байна. Мөн энэ бүлэгт хувь хүн/байгууллага/улс орон бусдад нэр шошго зүүх эрх мэдлийн талаар авч үзэх бөгөөд энэ нь авлигын талаарх баруунд төвлөсөн үзэлд хүргэдэг.

Авлигыг тайлбарлах нь: Рационал, тооцоолсон сонголт уу гэсэн гарчигтай X бүлэгт авлига бол зардал-үр өгөөжийн шинжилгээнд үндэслэсэн рационал сонголт болохыг батална.

Энэхүү онолын чиг хандлагын түлхүүр бүрэлдэхүүн хэсгийг хэрэглэн (*Clarke 1980*) байгаль орчныг сүйтгэх болон түүнээс урьдчилан сэргийлэх орчин үеийн стратеги, ийм үйлдэл гаргасан этгээдийг хэрхэн шийтгэх талаар авч үзнэ.

Авлигыг тайлбарлах нь: 'Бизнесийн' хэвшмэл үйл ажиллагаа юу гэсэн гарчигтай XI бүлэгт тодорхой хэдэн тогтолцоо байхгүй л бол авлига авах боломж байсаар байдаг, авлига нь байнга давтагддаг зүйл гэсэн үзлийн талаар судална. Тиймээс энэ аргачлалын түлхүүр бүрэлдэхүүн хэсгүүдийг авч үзэн, санхүүгийн тогтолцоонд авлигаас урьдчилан сэргийлэхэд уг онолын тайлбарыг хэрхэн хэрэглэх талаар хэлэлцэнэ. Мөн зарим орчин үеийн шинэ санааг танилцуулж санхүүгийн салбар зэрэг зарим газарт гэмт хэрэг/авлига нь хэвшмэл зүйл болсон харагдаж байгааг хүлээн (*Cohen, Felson 1979*) зөвшөөрнө.

Эргэцүүлэл ба дүгнэлт гэсэн гарчигтай XII бүлэгт эдгээр онолын тогтолцоо болон хэлэлцүүлэг нь авлигыг ойлгох, түүнээс сэргийлэх холбогдох аргачлал, стратегийг хэрэглэхэд оруулах хувь нэмрийн талаар эргэн авч үзнэ.

Ашигласан материал⁹

Acharya, V. V., Cooley, T.F., Richardson, M. P., & Walter, I. (2010). *Regulating Wall Street: The Dodd-Frank Act and the new architecture of global finance*. Winchester: John Wiley & Sons.

Agnew, R. (1992). Foundation for a general strain theory of crime and delinquency. *Criminology*, 30 (1), 47–87.

Agnew, R., & White, H. (1992). An empirical test of general strain theory. *Criminology*, 30 (1), 475–499.

9 Ашигласан материал хэсэгт ном болон сэтгүүлийн нэрийг *налуугаар*, артикл буюу бичвэрийн болон хэвлэлийн компанийн нэрийг энгийнээр гэх мэт ном зүйн жагсаалтыг форматыг баримтлан бичсэн байгааг анхаарна уу. Зохиогч энэ бүтээлдээ APA загварыг ашиглажээ. (Орч.)

- Anderson, S., & Heywood, P. M. (2009). The politics of perception; use and abuse of Transparency International's approach to measuring corruption. *Political Studies*, 57 (4), 746–767.
- Becker, H. S. (1963). *Outsiders: Studies in the sociology of deviance*. New York: Free Press.
- Becker, H. S. (1966). *Outsiders: Studies in the sociology of deviance*. New York: Free Press.
- Becker, S., Egger, P., & Seidel, T. (2009). Common political culture: Evidence on regional corruption contagion. *European Journal of Political Economy*, 25 (3), 300–310.
- Bottomley, K., & Coleman, C. (1981). *Understanding crime rates*. Farnborough: Gower.
- Bottomley, K., & Pease, K. (1986). *Crime and punishment: Interpreting the data*. Milton Keynes: Open University Press.
- Bowman, D., & Gilligan, G. (2007). Public awareness of corruption in Australia. *Journal of Financial Crime*, 14 (4), 438–452.
- Brooks, G., Walsh, D., Lewis, C., & Kim, H. (2013). *The prevention of corruption: Investigation, enforcement and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Button, M., Gee, J., & Brooks, G. (2011). Measuring the cost of fraud: an opportunity for the new competitive advantage. *Journal of Financial Crime*, 19 (1), 65–75.
- Chambliss, W. (1975). Toward a political theory of crime. *Theory and Crime*, 2, 152–153.
- Clarke, R. (1980). *Situational crime prevention*. *British Journal of Criminology*, 20 (2), 136–147.
- Clarke, R. V. G. (1997). *Situational crime prevention*. Monsey, NY: Criminal Justice Press.

Авлигын криминологи

- Cohen, L. E., & Felson, M. (1979). Social chance and crime rates trends: A routine activity approach. *American Sociological Review*, 44 (4), 588–608.
- Coleman, C., & Moynihan, J. (1996). *Understanding crime data: haunted by the dark figure*. Milton Keynes: Open University Press.
- Crawford, A. (2009). *Crime prevention policies in comparative perspective*. Devon: Willan Publishing.
- Currie, E. (1985). *Confronting crime: An American challenge*. New York: Pantheon.
- Dahrendorf, R. (1958). *Class and class conflict in industrial society*. Stanford, CA: Stanford University Press.
- Della Porta, D., & Vannucci, A. (1997). The 'perverse effects' of political corruption. *Political Studies*, 45 (3), 516–538.
- Ditton, J. (1979). *Controlology*. London: Macmillan.
- Doig, A. (2011). *State crime*. Cullumpton: Willan Publishing.
- Erickson, K. T. (1966). *Wayward puritans: A study in the sociology of deviance*. New York: Wiley.
- Farrington, D. P., MacKenzie, D. L., Sherman, L. W., & Welsh, B. C. (2003). *Evidence-based crime prevention*. Basingstoke: Routledge.
- Ferguson, J. E. (2010). *White collar crime*. New York: Chelsea House Publishers.
- Gardiner, J. (2002). Defining corruption. In A. Heidenheimer & M. Johnson (Eds.), *Political corruption, concepts and contexts*. New Brunswick, NJ: Transaction Publishers.
- Garland, D. (2001). *The culture of control: Crime and social order in contemporary society*. Oxford: Oxford University Press.

- Golden, M., & Picci, L. (2005). Proposal for a new measure of corruption, Illustrated with Italian data. *Economics and Politics*, 17 (1), 37–55.
- Gottschalk, P. (2010). White-collar crime: Detection, prevention and strategy in business enterprises. Boca Raton, Florida: Universal Publishers.
- Hagan, F. (2012). *Introduction to criminology: Theories, methods and criminal behavior*. Thousand Oaks, CA: Sage.
- Heeks, R., & Mathisen, H. (2012). Understanding success and failure of anticorruption initiatives. *Journal of Crime, Law and Social Change*, 58 (5), 533–549.
- Heywood et al. (2015). *Routledge handbook of political corruption*. London: Routledge.
- Heywood, P. M. (2015). *Routledge handbook of political corruption*. Abingdon: Routledge.
- Heywood, P. M., & Wright, V. (1997). Executives, bureaucracies and decision making. In M. Rhodes, P. M. Heywood, & V. Wright (Eds.), *Development in West European politics*. London: Macmillan.
- Hirschi, T. (1969). *Causes of delinquency*. Berkeley, CA: University of California Press.
- Hirschi, T., & Gottfredson, M. (1987). Causes of white-collar crime. *Criminology*, 25 (4), 949–974.
- Hopkins-Burke, R. (2013). *An introduction to criminological theory*. Abingdon: Routledge.
- Hosking, P., & Wilson, H. (2015, April 24). How Deutsche cheated and misled. *The Times*, p. 38.
- Hough, D. (2015). *Corruption, anti-corruption and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.

Авлигын криминологи

- Huisman, W., & Vande Walle, G. (2010). *The criminology of corruption. The good cause. Theoretical perspectives on corruption*. Barbara Budrich: Opladen.
- Johnston, M. (2005). *Syndromes of corruption: Wealth, power and democracy*. Cambridge: Cambridge University Press.
- Jones, S. (2006). *Criminology* (3rd ed.). Oxford: Oxford University Press.
- Langton, L., & Piquero, N. L. (2007). Can general strain theory explain white collar crime? A preliminary investigation of the relationship between strain and select white collar offenses. *Journal of Criminal Justice*, 35 (1), 1–15.
- Levi, M. and Burrows, J. (2008). Measuring the impact of fraud in the UK: A conceptual and empirical journey. *British Journal of Criminology*, 48 (3), 293–318.
- Lilly, R. J., Cullen, F. T., & Ball, R. A. (1989). *Criminological theory: Context and consequences*. Thousand Oaks, CA: Sage Publications.
- Matza, D. (1964). *Delinquency and Drift*. New York: Wiley.
- McCusker, R. (2006). *Review of anti-corruption strategies*. Canberra: Australian Institute of Criminology.
- McLaughlin, J., & Newburn, T. (2013). *The sage handbook of criminological theory*. London: Sage.
- Merton, R. K. (1938). Social structure and anomie. *American Sociological Review*, 3, 672–210.
- Murray, C. (1990). *The emerging British underclass*. London: Institute for Economic Affairs.
- O'malley, P. (1992). Risk, power and crime prevention. *Economy and Society*, 21 (3), 252–275.
- Payne, B. (2013). *White collar crime*. Thousand Oaks: Calif: Sage.

- Persson, A., Rothstein, B., & Teorell, J. (2010). *The failure of anti-corruption policies: A theoretical mischaracterisation of the problem* (QoG Working paper Series 19).
- Philip, M. (1997). Defining political corruption. In P. Heywood (Ed.), *Political corruption*. Oxford: Blackwell.
- Quinney, R. (1969). *Criminal justice in American society*. Boston: Little Brown.
- Quinney, R. (1975). *Criminology: Analysis and critique of crime in America*. Boston: Little Brown.
- Quinney, R. (1977). *Class, state, and crime: On the theory and practice of criminal justice*. New York: David McKay.
- Rawlinson, P. (2012). Corruption, organised crime and the free market in Russia. In P. Gounev & V. Ruggiero (Eds.), *Corruption and organised crime in Europe*. Abingdon: Routledge.
- Sandholtz, W., & Gray, M. M. (2003). International integration and national corruption. *International Organization*, 57 (4), 761–800.
- Schoepfer, A., & Piquero, N. L. (2006). Exploring white collar crime and the American dream: A partial test of institutional anomie theory. *Journal of Criminal Justice*, 34, 227–235.
- Shover, N., & Hochstetler, A. (2006). *Choosing white collar crime*. Cambridge: Cambridge University Press.
- Siegal, L. (2012). *Criminology: Theories, patterns and typologies*. Belmont, CA: Wadsworth Cengage Learning.
- Sutherland, E. H. (1939). *Principles of criminology* (3rd ed.). Philadelphia, PA: Lippincott.
- Sykes, G. M., & Matza, D. (1957). Techniques of neutralization: A theory of delinquency. *American Sociological Review*, 22, 664–670.

Авлигын криминологи

- Tanzi, V. (1998). *Corruption around the World: Causes, consequences, scope and cures* (Working Paper 98/63). Washington, DC: IMF.
- Tanzi, V. (2000). *Policies, institutions and the dark side of economics*. Cheltenham: Edward Elgar.
- Tierney, J., & O'Neill, M. (2009). *Criminology: Theory and context*. Harlow: Person Longman.
- Timmer, D. A., & Eitzen, S. (1989). *Crime in the streets and crime in the suites: perspectives on crime and criminal justice*. New Jersey: Prentice Hall.
- Transparency International (2012). *Corruption Perception Index 2012*. London: Transparency International.
- Treadwell, J. (2012). *Criminology: The Essentials*. London: Sage.
- Turk, A. T. (1969). *Criminality and legal order*. Chicago: Rand McNally.
- van Erp, J., Huisman, W., & Walle, G. V. (2015). *The Routledge handbook of white-collar and corporate crime in Europe*. London: Routledge.
- Vito, G. F., & Maahs, J. R. (2015). *Criminology: Theory, research and policy*. Burlington, MA: Jones and Bartlett Publishers.
- Weisburd, D., & Waring, E. (2001). *White-collar crime and criminal careers*. New York: Cambridge University Press.
- Weisburd, D., Wheeler, S., Waring, E., & Bode, N. (1991). *Crimes of the middle classes: White collar offenders in the federal courts*. New Haven, CT: Yale University Press.

Wheeler, S., Weisburd, D., & Bode, N. (1982). Sentencing the white-collar offender: Rhetoric and reality. *American Sociological Review*, 47 (5), 641–659.

Wilson, H. (2015, November 13). How bankers in last chance saloon fixed forex markets. *The Times*, p. 50.

Wilson, J. Q., & Herrnstein, R. (1985). *Crime and human nature*. New York: Simon and Shuster.



Авлигыг судлах нь: Салбар дамнасан асуудал

Удиртгал

Энэ бүлэгт бид авлигыг тайлбарлахад хэрэг болох социологи болон криминологийн онолын аргачлалд анхаарлаа хандуулна. Тиймээс энэ бүлэгт социологи/криминологийн бүтээлүүдэд түшиглэн ‘авлига’ гэж юу болох, судалгааны салбараас хамаарч авлигыг хэрхэн тодорхойлж, юу гэж хардаг вэ гэдгийг нийгэм, улс төрийн агуулгаар авч үзнэ. Аливаа ойлголт, юмс үзэгдэл, нэр томъёог судалгааны талаар бага мэдлэгтэй хүмүүст ойлгогдохуйц томъёолоход бэрх. Ялангуяа авлига гэсэн ойлголтыг томъёолох нь амаргүй (*Heywood 2015*). Филп (*Philp 2015*) тэмдэглэхдээ аливаа тодорхойлолт хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй байж болно гэжээ. Тодорхойлолт нь үгийн хэрэглээ, утга агуулгаар томъёолол хийх буюу утгыг тайлбарлах хэрэгсэл болж болно. Нийгмийн шинжлэх ухааны хувьд хоёр дахь бүрэлдэхүүнтэй илүү хамаатай. Хэрэгсэл болохын хувьд тодорхойлолт нь тухайн үйлдэл хийгдэх зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөлийг илэрхийлэх хэд хэдэн шалгуурыг тогтоохыг зорилго болгоно. Эдгээр шалгуур нь судалгааны салбар болон онолын чиг хандлагаас хамааран янз бүр байдаг.

Авлига гэж юу вэ?

Авлигын талаар олон тодорхойлолт (*Iyer ба Samociuk 2006; Brooks нар 2013; Heywood 2015*) байдаг. Ихэвчлэн төрийн үйл ажиллагааг авлигын шалтгаан, эсхүл дамжуулагч болдог гэж үздэг. Гэвч I бүлэгт тэмдэглэснээр ингэж үзэх нь хувийн хэвшил болон энэ салбар дахь хээл хахууль авах сонирхлын талаар бүрэн харуулж чадахгүй. Нийгмийн шинжлэх ухааны хүрээнд хувь хүн, байгууллага, улс орны түвшинд авлигад тооцогддог зан үйлийг тодорхойлохыг зорьж байна.

Авлигын үйлдэл нь рационал, тооцоологдсон, эсхүл түр зуур хэм хэмжээнээс гажих үйлдэл буюу сэдэлжсэн нийгмийн үйлдэл байдаг учир ингэж тодорхойлоход хүндрэлтэй байдаг. Тиймээс хүмүүс хоорондоо харилцах нөхцөл байдал дунд авлигыг авч үзнэ. Улс орнууд нь ардчилсан уу, эсхүл дарангуйллын тогтолцоотой юу гэдгээрээ маш их ялгаатай. Түүнчлэн газрын тос, эрүүл мэнд, санхүүгийн гэх зэргээр салбар хоорондын маш том ялгаатай байдаг ч шинжлэх ухааны ихэнх бүтээл нь чөлөөт зах зээл, либерал үндсэн хуулийн дүрэм журмын талаарх барууны ойлголтод үндэслэсэн байна.

Олон улсын валютын сан (ОУВС), Дэлхийн банк зэрэг гол байгууллагууд одоо ч гэсэн авлига бол улсын секторын асуудал гэж харсаар (*Hough 2015*) байна. Дээр тэмдэглэсний дагуу энэ нь буруу ойлголт юм. Төрийн үйлчилгээг хувьчлах болсноор төрийн болон хувийн секторын нөлөөллийн хүрээ, эрх мэдлийн ялгаа бүдгэрсэн. Хувийн сектор нь улсын сектортой огт харилцахгүйгээр авлигын үйлдэл гаргаж болно.

‘Энрон’ компанийн удирдах ажилтнууд бүтэлгүйтсэн төслүүдийнхээ олон тэрбум долларын өрийг нуусан жишээ үүнийг харуулна. Тэд өрийн асуудлыг компанийн хувьцаа эзэмшигчид болон захирлуудаасаа нуухын тулд ‘бүтээлчээр’ санхүүгийн тайлан гаргасан юм. Үүний хариуд байгууллагын

2 Авлигыг судлах нь: Салбар дамнасан асуудал

санхүүгийн нөхцөл байдал, статусыг аль болох тайлан мэдээнд үнэн зөв тусгахыг шаардсан бөгөөд хувьцаа эзэмшигчдийг залилах зорилгоор баримтыг устгах, өөрчлөх, хуурамчаар үйлдэхэд оноох шийтгэлийг нэмэгдүүлсэн 2002 оны Сарбанес-Окслэйн хууль зэрэг хууль тогтоомжийг шинээр батлан (*McClellan, Elkind 2013*) гаргажээ.

Улсын секторт анхаарлаа хандуулснаар бид бусад салбар дахь авлигын бодит жишээг харалгүй өнгөрөөнө гэсэн үг. Улсын сектор болон улс орон дахь институцэд анхаарлаа хандуулсан ч улс доторх тодорхой салбар нь газарзүйн байршлаас хамааран ялгаатай байж болно. Үүнийг умард болон өмнөд хэсэгтээ авлигын түвшин нь ялгаатай байдаг, авлигажсан гэх тодотголтой Италийн жишээ (*Golden, Picci 2005; Heywood 2015*) харуулна. Ийм ялгаа нь Италийн өмнөд хэсэг дэх зохион байгуулалттай гэмт хэргийн нөлөөтэй холбоотой болов уу.

Авлигыг тодорхойлоход түгээмэл хэрэглэдэг тодорхойлолт нь ‘хувийн ашиг сонирхлын төлөө өөрт олгогдсон эрх мэдлийг ашиглах’ (*TI 2012*) гэсэн тодорхойлолт юм. Энэ тодорхойлолт нь улсын сектор дахь авлигыг заасан энгийн тодорхойлолт биш боловч ихэвчлэн энэ хэлбэрээр хэрэглэгдсээр байна. Мөн авлига нь үнэлгээний талаарх ойлголт бөгөөд сөрөг үнэлгээтэй хамаатай. Түүнчлэн авлига нь тусгайлсан, техникийн, мэргэжлийн зэрэг янз бүрийн утгатай боловч бас авлигажсан гэдгийг олон нийт юу гэж ойлгох вэ гэдэг нийгмийн утгыг бас агуулдаг.

Үүний улмаас авлигын талаарх бүтээлүүдэд авлигын талаар нэгдсэн тодорхойлолт байхгүй гэсэн нийтлэг зөвшилцөл бий болж байна. Шууд ойлгогдох, хоёрдмол утгагүй авлигын тодорхойлолт гаргах оролдлогод олон асуудал тулгардаг бөгөөд ялангуяа авлигыг олон улсын хэмжээнд судалж үзэх үед энэ нь тод илэрдэг. Үүний үр дүнд авлигын талаарх маргаангүй тодорхойлолтыг олоход хүндрэл тулгарсаар байгаа

Авлигын криминологи

бөгөөд авлигаас сэргийлэх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.

Тиймээс авлигыг нарийн төвөгтэй, олон янзын шалтгаан, үр дагавар бүхий үзэгдэл гэж харах нь зүйтэй. Учир нь авлига бол хууль болон хувь хүний амьдралын хэв маяг, ёс зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн бүлэг хүмүүс, эсхүл нийгмийн хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчсөн нэг удаагийн үйлдэл зэрэг маш их ялгаатай нөхцөл байдал дунд олон янзын хэлбэрээр илэрдэг (*Heywood 2015*) зүйл юм.

Хэрэв бид авлигыг орон нутгийн шинж чанартай зүйл гэж харвал соёлын ялгаагаар харьцуулсан шинжилгээг хийх боломжгүй болно. Гэвч янз бүрийн улсад авлигын ижил төстэй үйлдлүүд үйлдэгдсээр байна. Ингэж харьцуулах тал дээр ‘Транспэрэнси интернэшнл’-ийн Авлигын төсөөллийн индекс болон Дэлхийн засаглалын индекс хэрэгцээтэй байдаг ч энэ нь бас хязгаарлагдмал талтай. Эдгээр индекс нь судалгаа авах тухайн цаг үед судалгаанд оролцогчид улс орон нь хэр авлигажсан гэж бодож байна гэдэг мэдээллийг өгөх боловч тэдгээр оролцогчид нь тухайн улсын нийт иргэн болоод улсынхаа талаар баримтлах байр суурийг оновчтой илэрхийлж чадахгүй байж болно. Угаасаа бодит нөхцөл байдлын талаар тийм ч их мэдээлэл өгдөггүй.

Яг юуг авлига гэж тооцох вэ гэдэг нь харьцангуй ойлголт боловч тэр талаарх бидний ойлголт нийгэм, улс төр, соёлын тогтолцоонд үндэслэсэн байдаг. Авлига нь хүрээлэн буй орчин, түүх, нийгмийн хөгжлийн бүтээгдэхүүн юм. Тиймээс бид авлигыг техникийн асуудал талаас нь дүгнэж, процессыг өөрчилснөөр шийдвэрлэж болох асуудал гэж харах нь явцуу, буруу хандлага юм. Энэ нь эдийн засаг давамгайлсан ойлголт учир хэдийгээр өргөн цар хүрээтэй, янз бүрийн авлигажсан үйлдэл байдаг ч авлигажсан үйлдэл гаргахад өдөөх шалтгааныг устгах ёстой гэж үзэж буй хэрэг болно. Түүнчлэн дээрх хүчин

2 Авлигыг судлах нь: Салбар дамнасан асуудал

зүйлээс шалтгаалан ёс зүйн хувьд ялзарсан байгаа нь авлигын үйлдлээр илэрдэг гэж үздэг. Гэвч зөвхөн ёс зүйд анхаарал хандуулах нь мөн л сул талтай бөгөөд зан үйлийг илэрхийлэгч болон түүний болзошгүй илрэлд төвлөрөн авлигыг тайлбарлах нь нийгмийн шинжлэх ухаанд оруулах хувь нэмрийн хувьд бага байх болно.

Гэхдээ авлигын ямар ч тодорхойлолтод **context** буюу орчин байдал чухал үүрэгтэй. Жишээлбэл, дарангуйлагч дэглэм нь авлигажсан байдаг боловч улсын цэрэг, эсхүл хувийн цэргийн гэрээлэгч гэх мэт цэргийн байгууллага нь улс төр, захиргааны эрх мэдлээ хадгалахын тулд цэргийн хүчээ ашигладаг. Дарангуйлагч дэглэм нь хувийн хэвшлийн, заримдаа барууныхны дэмжлэгтэйгээр хүн амын цөөн хувиар хүлээн зөвшөөрөгддөг ч тэдгээр тогтолцоо нь хүч хэрэглэх, сүрдүүлэх болон үзэл сурталдахад түшиглэсэн эрх мэдэл бүхий ноёрхол, балмад мөлжлөгийн тогтолцоо (*Philp 2015*) юм. Дарангуйлагчид нь хууль дүрэм тогтоох, өөрчлөх, эсхүл үл хэрэгсэх эрх мэдэлтэй. Энэ нь тэдэнд ядаж өөрийн улсдаа авлигын аливаа хэл аманд өртөхгүй байх боломжийг олгодог. Тэднийг ил тод шүүмжилсэн хүмүүсийг ямар нэг хэрэгт буруутган хорьж эсхүл зүгээр л сураггүй алга болгоно. Гэвч тийм тогтолцоонд улсын салбар нь асуудлыг хувийн, намын эсхүл хэсэг бүлэг хүний ашиг сонирхолд нийцүүлэхийн тулд төрийн албаны чиг үүргийг гуйвуулан ашигладаг учраас угаас авлигажсан байдаг. Ийм зүйл ардчилсан хариуцлагын түвшин сул бөгөөд газрын тосоор баялаг Нигер, Ангол, Ойрх дорнодын улс орнууд болон Венесуэл, эсхүл гэмт хэрэг нь төрөө тогтворгүйжүүлж, авлигажуулах хэмжээнд хүртэл зохион байгуулалттай болон хүчирхэгжсэн Мексик зэрэгт ихэвчлэн тохиолддог.

Ялангуяа төрийн албан дахь хувийн эрх ашгаа харсан ийм үйлдэл нь дайн байлдаан, иргэний дайнтай үед бол авлигын зайлшгүй нөхцөл хэмээн харагддаг ч энх тайван цаг дахь авлигын шинж чанарыг хэрхэн, яаж тодорхойлох вэ гэдэг

асуудал нь бүрхэг байгаа юм. Дайны нөхцөлд хүмүүс амьд үлдэхийн тулд тодорхой үйлдэл хийхээс өөр аргагүй болно. Иргэний дайн бүс нутгийг хамрах үед мэдээж хэрэг хохирогчид гарах боловч төрийн албан хаагчдыг үргэлж амин хувиа хичээсэн байдаг гэж тодорхойлох боломжгүй. Төрийн албанд ажилладаг хүмүүс төрийн байгууллагаас тогтоосон стандарт, чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой ч үймээн самуунтай үед гэр бүлийн үүрэг, эсхүл шашны үнэнч байдлын үүднээс стандартад нийцэхгүй нөөцийн хуваарилалт хийх явдал гаргаж болно.

Хэрэв улс орон нь иргэний дайнтай байгаа бол олон улсын байгууллага, институц нь стандарт тогтоохыг оролдоод, түүндээ хүрч чадна гэвэл хэт гэнэн хэрэг болно. Хэрэв бид хүмүүсийн дайны болон энх тайван цагт хийх үйл хөдлөлийг өөрчлөхийг хүсвэл тэднийг авлигажсан үйлдэл хийхэд өөрийн эрх ашгаа харахаас илүү чухам юу нөлөөлдөг вэ гэдэг талаар илүү тодорхой ойлголттой болох хэрэгтэй. Яг энэ тал дээр өнөөгийн улс төр, эдийн засгийн онолын тайлбараас хамаагүй илүү ихийг социологи болон криминологиор хийх боломжтой. Гэхдээ авлигын талаарх криминологийн төрөл бүрийн, өргөн цар хүрээтэй тайлбар руу орохоос өмнө бид авлигын талаарх судалгааны гол бүтээлүүдийг эргэн авч үзэх хэрэгтэй.

Авлигыг тайлбарлах нь: Рационал эдийн засаг, улс төрийн шинжлэх ухаан ба хууль зүйн аргачлал

Авлигын шалтгаан болон шийдвэрлэх арга замын талаарх өнөөгийн судалгааг рационал эдийн засгийн, улс төрийн, хууль зүйн гэсэн өргөн цар хүрээний гурван чиг хандлагад хувааж болно. Рационал эдийн засагт хувь хүн, байгууллага, улс орон нь зүгээр л өөрийн ашиг сонирхлын үүднээс үйл хөдлөл хийдэг хэмээн үздэг. Энэ үзэл нь авлигын талаарх ихэнх хэлэлцүүлэгт давамгайлж иржээ. Авлигыг бууруулах хамгийн сайн арга

2 Авлигыг судлах нь: Салбар дамнасан асуудал

бол анхнаасаа авлига авах боломжийг бууруулах, баригдах магадлалыг өсгөх замаар дүрэм, журмыг зөрчих сонирхлыг бууруулах гэж үздэг аж.

Гэхдээ хүний үйл хөдлөлийн бусад сэдлийг орхигдуулан, тэд зөвхөн өөрийн эрх ашгаа харж үйлдэл хийдэг гэж үзвэл, хүний үйл хөдлөл нь зардал-үр өгөөжийн шинжилгээнд үндэслэн дүрэм, журмыг мөрдөх, эсхүл зөрчих үйлдэл болох болно. Гэвч хэрэв хувь хүмүүс хамгийн их давуу талыг олохын тулд зөвхөн өөрийн эрх ашгаа харж үйлдэл хийвэл бизнесийг, ялангуяа олон улсын бизнесийг амжилттай болгож, удаан хугацаанд явуулах, эцсийн дүндээ ашиг хүртэхэд шаардлагатай албан харилцааг ядаж богино хугацаагаар ч үүсгэх боломжгүй болно. Тэгэхээр хувь хүн, байгууллагууд амжилтад хүрэхийн тулд зарим үйлдлээсээ татгалзаж, заримдаа дүрэм, журмыг мөрдөх хэрэгтэй. Тэгвэл дүрэм, журмыг сахин биелүүлж байна гэдэг нь хувь хүн, эсхүл байгууллага нь авлигажсан, эсхүл авлигажаагүй гэсэн утга илэрхийлэхгүй болно. Дүрэм, журмыг дагах шийдвэр нь ёс зүйн, хууль эрх зүйн, улс төрийн хүрээнд гарах учраас тогтвортой нөхцөл байдалд жижиг өөрчлөлт хийх, эсхүл улс төрийн ба нийгмийн бүтцийг л өөрчлөх арга зам бидэнд (*Philp 2015*) үлдэнэ. Хувийн эрх ашиг гэдэг нь эцэстээ бусад хүн, байгууллагад очих тэр ашиг тусыг л булаан авч буй хэрэг билээ. Аж үйлдвэрийн капитализм нь улс төрийн болон захиргааны нөөцийг ганцаар эзэмших арга замыг хайх, олж авах туйлын ашиг сонирхол бүхий өрсөлдөөнд суурилдаг боловч олон улсын авлига нь ихэвчлэн эрүүл мэндийн бүтээгдэхүүний үнэ, эсхүл зээлийн хүүг залж удирдах зэрэг хамтын авлигын хэлбэртэй байдаг.

Улс төрийн шинжлэх ухааны үүднээс бол авлигын туйлын эх үүсвэр нь ‘мөнгө саах’ явдал бөгөөд энэ нь хувь хүн, байгууллагууд шинэ баялаг бүтээлгүйгээр өөрсдийн баялгаа нэмэгдүүлэхийг эрмэлзэх үйлдэл юм. Үүнд төрөөс татаас авахаар лоббидох, өрсөлдөгчдөдөө зориулан стандарт тогтоох,

эсхүл татварын байцаагч хувь хүн, байгууллагын татварын өрийг бууруулж оронд нь хахууль авахыг эрмэлзэх үйлдэл багтана.

Мөнгө саах үйлдэл нь улсын секторт гардаг ба ямар нэг хязгаарлалт, төрийн оролцоо нь ашиг дагуулах үед гарах боломжтой (*Warner 2015*) байдаг. Энэ асуудлын эсрэг ихэвчлэн санал болгодог шийдэл нь төрийн зохицуулалттай, татаастай ‘зах зээл’-д өрсөлдөөн нэвтрүүлэх явдал (*Bliss and Di Tella 1997*) юм. Гэхдээ улс төрийн суурь ойлголт нь тухайн нөхцөл байдлаас хамааран ялгаатай, үргэлж маргаантай байдаг. Энэ суурь ойлголт нь нэгдсэн зөвшилцөлд хүргэж чадахгүйгээс тогтвортой бус байдлыг бий болгож, мөн авлигын маргаантай тодорхойлолтод хүргэж болзошгүй тул учир дутагдалтайд (*Heywood 2015*) тооцогддог. Үүний зэрэгцээ коммунизм нуран унахтай хамт ‘Барууны капитализм’ өөрийн гар хөлийг сунган, бусад улсуудад өөрийг нь хүлээн зөвшөөрөх улс төрийн институт үүсгэх шахалтыг үзүүлж эхэлсэн. Энэ үүднээс улс төрийн авлига бол бүрдүүлэх ёстой бүтэц, тогтолцоог бүрдүүлж чадаагүйн үр дагавар гэж үздэг. Энэ нь Дэлхийн банк, ОУВС гэх мэт олон улсын байгууллага болон зарим улсууд өөрсдийнх нь худалдааны үзэл санааг дагаагүйнх нь төлөө бусад улс орныг авлигажсан хэмээн нэрлэхэд (*IX бүлэг*) хүргэж (*Hough 2015*) болзошгүй.

Тиймээс улс төрийн авлигыг ‘төрийн албан хаагч (А) нь албаны дүрэм, стандартыг олон нийтийн эрх ашигт (В) халтайгаар зөрчих’ хэмээн урьдчилсан байдлаар тодорхойлж болно. Онолын хувьд (В) нь төрийн албаны үр ашгийг хүртэх ёстой. Гэвч түүний оронд (А) нь өөртөө ашиг хүртээд, гуравдагч этгээд (С) нь өөрөөр бол олж авч чадахгүй байсан бүтээгдэхүүн эсхүл үйлчилгээг олж авахын тулд (А)-г урамшуулж, эсхүл өөр байдлаар түлхэц өгөх үйлдэл (*Philp 2015:22*) юм.

2 Авлигыг судлах нь: Салбар дамнасан асуудал

Энд гол анхаарах зүйл нь авлигыг түүний үр дагавраар тодорхойлохгүй байгаа бөгөөд авлигыг үүсгэж буй улс төрийн процессын гажуудал ба сэдлийн нийлбэр хэлбэрээр тодорхойлж байна. Түүнээс гадна бид хувьдаа ашиг хүртэх авлигажсан үйлдлийг авлига гэж хардаг боловч туслалцаа хэрэгтэй байгаа хэн нэгэнд туслахаар дүрэм, журмыг зөрчсөн тохиолдлыг байж болох зүйл хэмээн хүлээн зөвшөөрдөг. Жишээлбэл, ямар ч төлбөр шаардлагагүй эмчилгээг бичихдээ эмч төлбөр шаардаж байгаа бол үүнийг авлигажсан гэнэ. Гэвч эмнэлгээс тодорхой өвчтөнд хийх бүхий л эмчилгээг зогсоохыг эмчид даалгасан, түүнчлэн даатгалын компани тухайн эмчилгээний төлбөрийг төлөхөөс татгалзсан ч гэсэн эмч нь өвчтөнд хийх эмчилгээг үргэлжлүүлж, тэр нь тогтоосон дүрэм, журмыг зөрчиж байсан ч энэ үйлдлийг нь олон нийт болон өвчтөнүүд хүлээн зөвшөөрөх хандлагатай байдаг. Харин эмнэлэг, даатгалын компани үүнийг хүлээн зөвшөөрөхгүй.

Гэхдээ улс төрийн тогтолцоо дээрээс доош чиглэлд авлигажсан байж болно. Иймээс ‘загас толгойноосоо өтдөг’ гэж анхааруулсаар ирсэн. Их биеэсээ эхлэн авлигажих нь улс төрийн процессыг ялзруулж, төрийн албан хаагчдыг хахуульдах, лоббидох, сүрдүүлэх замаар хууль бус үйлдэл рүү түлхэж болно. Энэ нь авлигын дөрвөн гол синдром буюу зах зээл, элит картел, олигарх болон бүлэглэл, эрх мэдэлтэй албан хаагчдад нөлөөлөх эрх мэдлийн талаарх Жонстоны (*Johnston 2005*) үзэлд хамаатай. Эдгээр эдийн засаг, улс төрийн үзэл нь хувь хүн, түүний сонирхлыг онцлон үздэг. Ингэхдээ авлигажсан төрийн алба, хөтөлбөрүүдэд ‘зохицуулалтын баланс’ хэмээн нэрлэгддэг зүйл байсаар атал монополийг эсэргүүцэхэд шаардлагатай хяналт, тэнцэл хангалтгүй байгаад ихэвчлэн анхаарлаа хандуулдаг (*Philp 2015*) байна.

Хууль зүйн үүднээс хийх тайлбараар бол авлигын шалтгаан нь ихэвчлэн төрийн албанаас үүдэлтэй, хувийн дотоод ашиг сонирхол (*vested interest*) нь дүрэм журмын хэрэгжилтийг

зогсоох, эсхүл түүнээс сэргийлэх чадвартай байдагт оршино. Нөлөө бүхий этгээдүүд хууль гаргах, түүнийг хэрэгжүүлэхэд хэрхэн нөлөөлдөг вэ гэдгийг ойлгосон үед энэ тайлбарын асуудлууд ойлгомжтой харагдана. Хуульд оруулах аливаа өөрчлөлт нь нөлөө бүхий этгээдүүдийн ашиг сонирхолтой зөрчилдсөн тохиолдолд тухайн хууль үлбэгэр болон батлагдахад хүрдэг. Хууль зүйн энэхүү тодорхойлолтод үндэслэвэл авлигын үйлдлийг буруу хэмжээтэй шугам гэж харахад хүрдэг. Тэдгээр үйлдэл нь авлигаас илүү эрх мэдлийн нөлөөллийг хэмжихэд илүү хэрэгцээтэй (*Becker 1968; Hasnas 1995; Brooks нар 2013*) байна. Үнэндээ ихэнх тохиолдолд хуулийг хэрэгжүүлэх ёстой тэдгээр хүмүүс хамгийн их авлигажсан байдаг аж. Тэд тогтолцоо болон хуулийн засаглалыг хамгийн ихээр хувийн ашиг сонирхолдоо ашиглана. Гэхдээ хувийн ашиг сонирхлыг ихэнхдээ ‘бүгд л тэгдэг шүү дээ’ (*энэ нь мөн саармагжуулах арга хэрэгсэл болдог*) хэмээн хамгаалдаг.

Хуучны жишээ боловч 1970-аад оны Нью-Йоркийн Цагдаагийн газар дахь авлигын талаар хийсэн Кнаппын комиссын мөрдлөг нь ‘Бүгд л тэгдэг шүү дээ’ гэсэн санааг харуулдаг бөгөөд тэд хахуулийг цагдаагийн соёл хэмээн хүлээн авагсдыг ‘өвсөн тэжээлтэн’ гэж, харин идэвхтэйгээр сүрдүүлэх болон айлгах замаар мөнгө шаардсан хүмүүсийг ‘махан тэжээлтэн’ хэмээн нэрлэсэн. Эдгээр өвсөн тэжээлтэн болон махан тэжээлтнүүд аль аль нь л авлигажсан байв. Салбараас үл хамааран зохицуулалт дутагдалтай байгаагийн шалтгаан нь нөөцийн хүрэлцээгүй байдлаас боллоо гэсэн тайлбарыг түгээмэл дагуулдаг ч, энд байгууллагын болон зохицуулах субъектийн хяналт дутуу байх болон шийтгэлийн гүйцэтгэл мөн чухал нөлөөтэй. Энэхүү тайлбарын гол түлхүүр нь ямар ч байгууллагад нөөц хуваарилах монопол эрх өгөхөөс зайлсхийх явдал байдаг (*Manzetti and Blake 1996; Andrews and Montinola 1998*) боловч ардчилсан улсад хүртэл цагдаагийн байгууллагын жишээн дээр ч ийн зайлсхийх боломж ховор байдаг.

2 Авлигыг судлах нь: Салбар дамнасан асуудал

Хууль зүйн тайлбар нь мөн зарим талаар ялангуяа нэгээс олон хууль хүчний байгууллага оролцсон, үндэстэн дамнасан авлигыг тодорхойлж, тайлбарлах тал дээр тодорхой бус байдаг талтай. Хууль зүйн талаас нь олон улсад тогтсон ойлголтгүйгээр тодорхойлолт гаргахыг оролдох нь үйл ажиллагааг зохион байгуулах, авлигын эсрэг стратеги (*ямар нэг байдлаар хэрэгцээтэй*) боловсруулахад учрах хүндрэлийг нэмэгдүүлнэ. Хууль зүйн тодорхойлолт нь хууль зүйн тодорхойлолтынхоо дагуу авлигын үйлдэл нь хууль ёсны зарчмыг зөрчсөн байхыг шаардана. Гэхдээ авлигажсан үйлдэл бүр хууль бус байдаггүй. Авлигажсан гэдгийг хууль бус гэдэгтэй андуурвал буруу ойлголт үүснэ. Нийгмийн хэм хэмжээ нь хуулийн нэгэн адилаар үнэт зүйлээр тодорхойлогддог боловч тэдгээр нь хуультай адилтгах хэмжээний үзэл суртал болон үндэслэлээс урган (*Brooks нар 2013*) гардаггүй.

Түүнчлэн дэлхий дээрх соёлын ялгаатай хүчин зүйлсийг аваад үзвэл хууль зүйн тодорхойлолт нь ерөөс шаардлага хангадаггүй. Жишээлбэл, Оливиер Дэ Сардан (*Olivier de Sardan 1999:40*) Африкт Европоос хамаагүй илүү өргөн хүрээтэй эв нэгдлийн сүлжээ (*solidarity network*) байгааг харуулсан. Тиймээс Африкийн гэр бүлүүд нь ‘өргөн хүрээг хамарч, тоохгүй байхад хэцүү дарамт шахалт, өдөөн хатгалгаар дүүрсэн байдаг бөгөөд анги хамт олны (*бага сургуулийн, дунд сургуулийн, их сургуулийн*) хүрээнд үүссэн холбоо сүлбээ нь тэтгэвэрт гарах хүртэл үргэлжилдэг’. Хүмүүс нь гэр бүлийн гишүүн, хөрш, намын нөхөр болон найз нартаа үйлчилгээ үзүүлэх, давуу тал олгохоос татгалзах аргагүй байдаг.

Эдгээр бүхий л тайлбар, тэр дундаа авлигын үйлдлийг гаргах рационал эдийн засгийн шалтгаанд анхаарлаа хандуулдаг ихэнх тайлбар нь эзэн-ажилтны онолыг хэрэглэснийг харж болно. Уг онолоор авлигыг эзэн ба (*ажил олгогч, сайд зэрэг удирдах албан тушаалтан, компанийн захирал*), ажилтан (*төрийн албан хаагч, хувийн секторын ажилтан*) хоёрын хоорондын

тогтсон харилцааг зөрчих явдал гэж үздэг. Ажилтан нь өөрийн хувийн ашиг сонирхлын төлөө эзний (*төрийн албаны*) ашиг сонирхлоос урвах үед авлига үйлдэгдлээ гэж үздэг (*Jensen and Meckling 1976; Klitgaard 1998; Heywood 2015*) байна.

Авлигыг ингэж авч үзэх нь улмаар нөөцийг ганцаар эзэмших, хариуцлага алдагдахад хүргэдэг авлигын үйлдэл гарах нөхцөл байдал руу бидний анхаарлыг чиглүүлнэ. Түүнчлэн авлигаас сэргийлэхийн тулд ажилтан нь зохих ёсоор биеэ авч явахад урамшуулах арга замыг бодож олохоор эрэлхийлнэ гэсэн үг. Гэвч шалтгааныг тайлбарлах эдгээр нөхцөл нь хязгаарлагдмал юм. Төрийн албан дахь шударга занг монополгүй, хариуцлага өндөртэй байдлаар тайлбарлана. Гэвч энэхүү ‘төгс’ нөхцөл байдал нь үнэхээр л бүх юм ‘төгс’ үед боломжтой боловч бодит байдал хамаагүй илүү төвөгтэй байдаг. Жишээлбэл, чиг үүрэг, үүрэг хариуцлагаас урвасан гэдэгт юуг оруулж тооцох вэ. Урвах гэдэг нь улс орон, институц дотор болон хооронд аваад үзвэл харьцангуй ойлголт бөгөөд нөхцөл байдлаас хамаарч өөрийн ашиг сонирхлоо хөөцөлдөх үйлдлийг заах (*Heywood 2015*) болно. Тиймээс авлигын тухай бүтээлүүдэд түгээмэл орсон хүний үйл хөдлөлийн талаарх энэ тодорхойлолт нь харилцааны хүрээг тогтоох хүлээлт болон бүтцээс хэт их хамаардаг учир хязгаарлагдмал ойлголт ажээ.

Хүний үйл хөдлөлийг ийм байдлаар ойлгох нь чөлөөт зах зээл болон үндсэн хуульт либерал тогтолцоог магтан дуулдаг барууны шийдэл болон үзэл бодлын онцлог юм. Гэвч энэ нь шийдэлд бус ‘хэрэглэж болох’ дүгнэлт хийхэд төвлөрсөн, шинэ тодорхойлолт боловсруулахад бидэнд саад болохгүй. Авлигын талаарх бидний одоогийн ойлголт нь өнөө үед хэрэглэгдэж буй үзэл баримтлалын аргачлал, олж авсан баримтаар хязгаарлагдаж байдаг.

Авлигын социологи ба криминологийн хэрэгцээ шаардлага

Энэ номыг бичих болсон шалтгаан нь авлигыг үргэлж биш ч ихэвчлэн гэмт хэрэг гэж хардаг явдлыг засах байв. Хэдийгээр буруу ойлголт төрүүлж болох ч түүний оронд авлигыг зарим хүний хувьд хэм хэмжээг зөрчих үйлдэл, зарим хүний хувьд зүгээр л ‘бизнес хийх’ арга болдог гэж харах нь дээр байж болох юм.

Хэдийгээр криминологийн судлагдахуунд гэмт хэрэг бөгөөд авлигын гэмт хэргийн олон янзын үйлдэл байдаг ч криминологийн судалгааны асар их бүтээл дунд авлигыг онцолж үзсэн бүтээл ховор байна. Авлигыг судлахдаа эрүүл мэндийн болон аюулгүй байдлын гэмт хэрэг (*Slapper and Tombs 1999; Tombs and Whyte 2007; Gray 2009; Tombs 2009*), зохион байгуулалттай гэмт хэрэг (*Rawlinson 2012*) зэрэг ихэвчлэн өргөн хүрээтэй ойлголтод хамааруулан авч үзсэн байна. Энэ нь онолын аргачлалаа хязгаарлагдмал байдлаар хэрэглэсэн хэрэг боловч тэдгээрийн ойлголтууд нь авлигад криминологийн шинжилгээ хийхэд төгс зохицох (*Whyte 2015*) боломжтой. Гэхдээ социологи нь хүний өргөн хүрээний харилцаа болон институцэд анхаарч үздэг учраас криминологиос хамаагүй илүү өргөн цар хүрээтэй.

Номын энэ хэсэгт авлигыг шинжлэхэд ашиг тусаа өгч ирсэн криминологийн болон социологийн ойлголтуудад анхаарлаа төвлөрүүлэх болно. Эдгээр нь зохион байгуулалттай гэмт хэрэг (*Gounev and Ruggiero 2012; Schmidt-Pfister and Moroff 2012*), ажил мэргэжлийн гэмт хэрэг (*Friedrichs 2002; Gray 2013*), компанийн гэмт хэрэг (*Braithwaite 1984, Slapper and Tombs 1999*), төрийн компанийн гэмт хэрэг (*Kramer and Michalowski 2006*), төрийн гэмт хэрэг (*Green and Ward 2004; Brooks et al. 2013*) юм.

Авлигын криминологи

Криминологид гэмт хэргийг ихэвчлэн эрүүгийн хуулийг үндэс болгон тодорхойлдог. Авлигын тухайд эрүүгийн хуулийн тодорхойлолт нь олон үйлдлийн цогцыг хамардаг боловч дээр дурдсанчлан энэ тодорхойлолт нь авлига гэсэн цогц ойлголтын нэг хэсэг болсон олон тооны гэмт үйлдлийг агуулалгүй орхигдуулдаг. Хуулиар гэмт хэрэгт тооцсон зүйлээр авлигын шинжилгээг хязгаарлахын (*Nelken 1994*) оронд хуулийн хүрч үйлчилж чаддаггүй үйлдлүүдээр цар хүрээг өргөтгөх хэрэгтэй. Ялангуяа хуйвалдах, лоббидох, холбоо сүлбээг ашиглах үйлдэлд анхаарах хэрэгтэй. Эдгээр үйлдэл нь гэмт хэрэг биш байж болох ч авлигын гэмт хэргийн ‘дамжуулах хоолой’ болдог.

Гэмт хэргийн учир шалтгааны талаарх онолын аргачлалыг товч хэрэглэсэн ихэнх хүмүүс авлига нь ганцаар, эсхүл бусадтай хамтран үйлдэх үйлдэл бус байгууллага дотор ажиллаж буй хүний үйлддэг зүйл гэсэн таамаглалд үндэслэсэн байдаг. Тиймээс энд олон түвшний тайлбарыг хэрэглэн, шалтгаан болох хүчин зүйлсийг макро түвшин (**тусгаар улс**), дунд түвшин (**байгууллага**), микро түвшин (**хувь хүний харилцаа**)-д авч үзнэ.

Судалгаагаар зохион байгуулалттай, корпорацийн, улсын болон ажил мэргэжлийн гэмт хэргийн холбоо, сүлжээг тодруулсан учраас авлигыг бие даасан тусдаа тохиолдол гэж харалгүй, эдгээр түвшинг дамнан холбогдсон хэрэг гэж харах ёстой. Судалгааны энэ бүдгэрсэн байдлыг Крамер, Михаловский нарын (*Kramer and Michalowski 2006*) бүтээл дэх төрийн-корпорацийн (*state-corporate*) болон төрийн-зохион байгуулалттай (*state-organized*) гэмт хэрэг гэсэн ойлголтоос харж болно.

Криминологид авлигын талаар хамгийн үр дүнтэй хийгдсэн судалгаа нь зохион байгуулалттай гэмт хэргийн талаарх судалгаа байна. Энэ нь зохион байгуулалттай гэмт хэрэг

2 Авлигыг судлах нь: Салбар дамнасан асуудал

олон улсыг хамарсан байдал, олон улсын хууль, эдийн засагт учруулах аюулаас үүдэлтэй (*Gounev and Ruggiero 2012*) юм.

Зохион байгуулалттай гэмт хэргийн хууль бус сүлжээнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй хийгдсэн ажил бага. Улс орнууд түүнтэй янз бүрийн аргаар тэмцэх гэж оролдож байсан нь авлигын талаар судалгаа бага хийгдэхэд нөлөөлжээ. Ялангуяа мөнгө угаах гэмт хэргийн судалгаанд маш их анхаарал хандуулсан байна (*үүнээс заримыг дурдвал: McCusker 2000; Levi 2002; Levi and Gilmore 2002; McCusker 2005; Levi and Reuter 2006; Chaikin and Sharman 2009; Brooks 2012; Belaisha and Brooks 2014*). Авлигын хувьд улс орнуудын хооронд байдаг ялгаа нь улс төрийн хэрэгжилтийн болон захиргааны түвшинд гардаг. Судалгаагаар (*Gounev and Ruggiero 2012*) зохион байгуулалттай гэмт хэрэг агаад хууль ёсны бизнесийн дотор оршдог хоорондын холбоос болон үйл хөдлөлийн хэлбэр нь зарим тохиолдолд төстэй байдгийг харуулсан. Энд бид бүх бизнес авлигажсан байдаг гэж хэлэх гээгүй. Зөвхөн зарим бизнес зохион байгуулалттай гэмт бүлэглэлтэй хамтардаг, эсхүл санаатайгаар хуйвалдах байдлаар гэмт хэрэг үйлддэг. Түүнчлэн дотоод зохицуулалт болон хяналтын тогтолцоо сул байгаагаас гэмт үйлдэл гаргаж болно.

Зохион байгуулалттай гэмт хэргийг олон улсын бизнесээс үндсэндээ ялгаатай, ондоо зүйл гэж харж болно. Хууль ёсны болон хууль бус бизнесийн хооронд шимэгчлэх, нэгнийгээ дэмжин хамтран амьдрах харилцаа үүсдэг. Зохион байгуулалттай гэмт хэргийн талаар илүү бодитой дүр зургийг ‘хууль ёсны болон хууль бус ертөнц’-ийн хоорондын талбарт тусгайлан анхаарал хандуулсан судалгаагаар (*Rider 1997; Ruggiero 1996; Kleemans 2008; Gounev and Ruggiero 2012*) харуулсан. Хууль ёсны болон хууль бус ертөнц хооронд шимэгчлэх болон биенээ дэмжих харилцаа (*symbiotic relationship*) тогтож, бизнесийн хамтын нэгдэл дотор шингэсэн байдаг.

Шимэгчлэх харилцаанд хууль ёсны эдийн засагтай харилцах цэг харьцангуй хязгаарлагдмал байдаг бөгөөд зөвхөн ‘доод ертөнц буюу эрүүгийн ертөнц’-ийн эрх ашгийг тусгасан байдаг. Гэхдээ боломж байвал гэмт бүлэглэл ‘дээд ертөнц буюу хууль ёсны ертөнц’-ийн оршин суугчдыг авлигажуулна. Нэгнийгээ дэмжин хамтран амьдрах харилцаа нь илүү нарийн төвөгтэй, гэмт бүлэглэл болон ‘дээд ертөнц’-ийн харилцан ашигтай байдал дээр суурилна. Энэ тохиолдолд авлига нь илүү нарийн төвөгтэй, илрүүлж гаргахад хэцүү байдаг. Гэмт бүлэглэл нь гол хүмүүсээ байршуулах замаар ‘дээд ертөнц’-д хэсэгчлэн шингэж, хууль ёсны бизнестэй (*Rawlinson 2012*) холилдог. Тиймээс зохион байгуулалттай гэмт хэргийн талаарх судалгаа авлигад анхаарлаа хандуулдаг байна. Хууль бус үйл ажиллагаагаа хөгжүүлэх, үргэлжлүүлэхийн тулд авлига зайлшгүй гэсэн нэгдсэн ойлголт тэдний дунд байхгүй байсан ч авлига нь ‘гэмт хэргийн дамжуулах суваг, хурдасгуур’ болсоор байдаг. Хууль бус бүлэглэлтэй холбогдох энэ холбоос нь авлигын зөвхөн нэг тодорхой хэмжээс юм.

Садерландын (*Sutherland 1939*) бүтээл гарч, нийгэм-эдийн засгийн дээд давхрааны эрх мэдэлтэй гишүүдийн авлига нь социологичдын, дараа нь криминологичдын сонирхлыг татахаас өмнө үүнийг цагаан захтны гэмт хэрэг гэдэг ойлголтод багтаан үздэг байв. Садерланд цагаан захтнуудын гэмт үйлдлийн ихэнх нь эрүүгийн шүүхээс гадуур, иргэний хуулийн процедураар, эсхүл сахилгын дүрмээр шийдвэрлэгдэж ирсэн. Одоо ч хэвээр байгаа учраас эрүүгийн хууль цагаан захтны гэмт хэргийн бүх төрлийг хамарч чаддаггүй байсан гэдэгт итгэлтэй байв. Эрх мэдэл бүхий эрэгтэй, эмэгтэй хүмүүс ихэвчлэн бусдад мэдэгдэлгүйгээр ажилладаг. Мэдэгдлээ гэхэд яллагддаггүй, ялагдсан ч шүүхээр буруутай нь тогтоогдохгүй байж болохыг тооцоод үзвэл шүүхээс ял сонссон авлигачдын тоо нь нийт цагаан захт гэмт хэрэгтний тооноос хамаагүй бага байж (*Slapper and Tombs 1999:3*) (*санхүүгийн гэмт хэрэг үйлдсэн хувь хүн,*

байгууллагад оноосон шийтгэлийн талаар 11 дүгээр бүлгээс үз) таарна.

Иргэний хуулийн хүрээнд тодорхойлогдсон хуулийн этгээдийн гэмт хэрэгтэй хамт цагаан захтны гэмт хэрэг гарч байна уу, эсхүл төрөөс эрүүгийн хуулийг хэрэгжүүлж, эрх мэдэл бүхий хүмүүсийн нөлөө уг хуульд их ордог учир эрүүгийн хуулиар цагаан захтны гэмт хэргийг үгүйсгэж байна уу гэдэг талаар хэлэлцүүлэг явагдсаар байна. Ардчилсан улсад хүртэл цагаан захтны хэрэгт сахилгын шийтгэл оноох, эсхүл нотлох баримт хангалтгүй гэж үзээд буцааж буй явдал нь сүүлийн үзэл бодлыг дэмжих баримт (*Warren 2016*) болно. Хэрэв авлига нь хувийн секторын асуудал бөгөөд ихэнхдээ хувийн хүрээнд шийдвэрлэгдэж, эсхүл зах зээлийн механизмаар шийтгэгдэнэ гэвэл энэ санаа бүр илүү тодорхой болно. Ялангуяа Өмнөд Солонгос (*Hough 2015*), Япон улсад авлигын үйлдэлд хорих шийтгэл оноож байгаагүй гэдгээс энэ санаа илүү тодорхой (*Suda 2011*) харагдана.

Цагаан захтны ажил мэргэжлийн гэмт хэргийн талаарх энэ ойлголт нь идэвхгүй авлигын ойлголттой бас хамаатай. Энэ нь төрийн, эсхүл хувийн байгууллагын албан хаагч албан тушаалаа хувьдаа ашиг хүртэх зорилгоор ашиглах явдал юм. Энэ тохиолдолд хэрэгтэн нь идэвхгүй авлигын үйлдэл гаргасан гэдгээр хувь хүний хувьд хариуцлага хүлээх ч байгууллагын болон нийгмийн нөхцөл байдлыг харгалзахгүй байж болохгүй. Энэ хэрэг нь ихэнхдээ хувь хүний шинж чанар, байгууллагын бүтэц, соёл, нийгмийн уялдаа холбоо, бизнес дэх манлайлагчийн хэв маягаас гадна (*Mars 2006; Tillman 2009; Huisman and Vande Walle 2010*) байгууллагын гадаад зүйлс буюу даяарчлал, хууль зүйн зохицуулалт, хууль хэрэгжилтийн нөлөөтэй холимог (*Box 1983*) хамааралтай.

Панч (*Punch 2000*) цагдаагийн авлигын талаарх өөрийн судалгаагаар ажил мэргэжлийн гэмт хэргийн нарийн төвөгтэй

байдлыг харуулаад ‘муудсан алим’-ны ойлголтыг үгүйсгэж, ‘үхмэл мод’ болон байгууллагын институцийн орчин байдал, ажлын төрөл, соёлд түлхүүр үүрэг гүйцэтгэх тал дээр анхаарлаа (*Huisman and Vande Walle 2010*) хандуулсан. Үнэндээ бол ‘муудсан алим’ нь бүхий л торхыг муутгах учир авлигатай тэмцэх стратегитай байх хэрэгтэй болно. Үүнийг магадгүй Англи дахь институцчилэгдсэн, арьс өнгөөр ялгаварлах үзлийн талаар судалсан Макперсоны илтгэлээс (*Macpherson Report 1999*) харж болно. Тодорхой нэг талаас нь авч үзэхэд авлига нь ажил мэргэжлийн гэмт хэргийн тодорхойлолтод тохирч болох ч хянамгай байж, шалтгааныг тогтоох (*Punch 2000*) шаардлагатай. Үүнийг байгууллага дахь эрүүл мэнд ба аюулгүй байдлын асуудал (*Slapper and Tombs 1999; Pearce and Tombs 1998; Tombs and Whyte 2007*), байгаль орчны гэмт хэрэг (*Payne 2012*), хүнсний аюулгүй байдлын дуулиант хэрэг, эсхүл санхүүгийн гэмт хэрэг гэж харж болно. Ажил мэргэжлийн гэмт хэрэг нь ажил олгогчдоод хэрэгтэй байх нь бий. Төрийн авлигын хувьд хувь хүний үйлдлээс байгууллага ашиг хүртэх тохиолдол олонтаа байдаг. Хувийн хэвшлийн авлигын хувьд байгууллагын болон хувь хүний ашиг сонирхол нэгдэн, олон нийтээр хүлээн зөвшөөрөгдөх байдлаа хадгалах, сөрөг нэр зүүхээс зугтахын тулд ажилтны авлигажсан үйлдлийг нуухад хүргэнэ.

Социологи болон криминологид авлига нь хоёрдмол утгатай ойлголт байдаг. Авлигыг нийгэмд хүлээн зөвшөөрөгдөж буй байдлаас нь хамаарч цагаан авлига, саарал авлига, эсхүл хар авлига гэж үзэж болно гэж Хайденхаймэр (*Heidenheimer 1989*) тэмдэглэжээ. Ийнхүү тодорхойлолт бүдэг байх нь судалгааны салбарт, ялангуяа эрүүгийн хуулийн тодорхойлолтоос хамааралтай салбарт авлигыг судлах явдлыг хязгаарлаж ирсэн байна. Үүнд ил харагдах хохирогч байдаггүй нь нэрмээс болно. Улстөрчид санхүүгийн, биеийн, болон сэтгэл зүйн ноцтой үр дагавар бүхий хохирогч олонтой дуулиант хэрэг, осолд эмзэг ханддаг. Авлига нь хэдийгээр ажилгүйдэл, эрүүл мэндийн

2 Авлигыг судлах нь: Салбар дамнасан асуудал

үйлчилгээ хомстох, өлсгөлөнд нэрвэгдэх зэрэг гунигт явдлыг үүсгэдэг ч ялангуяа зарим улсад соёлын эсхүл уламжлалын нэг хэсэгт тооцогдон, хэтэрхий амархан хүлээн зөвшөөрөгддөг хөшингө асуудал (*Heywood 2015*) юм.

Гэхдээ криминологи дахь компанийн болон төрийн гэмт хэргийн судалгаа нь авлигыг судлахад үнэтэй ач холбогдолтой. Хувийн байгууллага судалгааны төвд орж ирсэн тэр цагаас хуулийн этгээдийн гэмт хэргийн тодорхойлолтын талаарх маргаанд илүү хэцүү хэмжээс нэмэгдсэн юм. Хуулийн этгээд нь гэмт хэрэгтэн хэмээн харагдаж, илэрч, яллагдалгүйгээр цагаан захтны гэмт хэргийг үйлдэж болохыг Садерланд (*1961:248*) онцлон тэмдэглэжээ. Хуулийн этгээдийг гэмт хэргийн тодорхойлолтод оруулахгүй байсан, одоо ч тийм байгаа гэсэн нэг тайлбар нь нийгмийн сүлжээ буюу төрд ажиллаж байгаа хүмүүс болон бизнес хийж буй хүмүүсийн соёлын ижил төстэй талын тайлбар (*Huisman and Vande Walle 2010*) юм. Төрийн байгууллагад ажиллаж буй олон хүн өмнө нь хувийн компанийн захирал, нэгжийн дарга байсан, эсхүл өмнө нь бизнестэй холбоогүй байсан ч дараа нь дарга, захирал болж байна (*I бүлгийг үз*).

Соёлын ийм ижил төстэй байдал, хувь хүний харилцаа холбоо, эрх мэдлийн холбоо нь бизнес эрхлэгчдийг гэмт хэргийн ноцтой тодорхойлолтоос хамгаалж байгаа юм. Баян улсуудад хүмүүс хуулийн дагуу хийж болох лобби зэрэг механизмыг ашиглахыг илүүд үздэг байхад ядуу улсуудад хүмүүс авлигад найдахаас аргагүй байдаг гэж Кампос, Жиованнони нар (*Campos and Giovannoni 2006*) тэмдэглэжээ. Үүнд ялангуяа АНУ дахь эмийн бүтээгдэхүүний үйлдвэр болон эмч нар хоорондын харилцааны жишээ тохиромжтой. Эмч нар уулзалт, хуралд оролцсоныхоо төлөө эмийн бүтээгдэхүүний үйлдвэрээс тоног төхөөрөмж хүлээн авдаг бол эмийн үйлдвэрийнхэн өөрсдийн бүтээгдэхүүнийг ‘хөхиүлэн дэмжиж’, эмч нарт тухайн эмээ өвчтөнд санал болгон (*Braithwaite 1984; Thomas 2014, Thomas*

and Abrams 2014) уруу татдаг. Энэ тохиолдолд ёс зүйгүй, эсхүл хууль бус үйлдэл болсон гэх зүйл байхгүй ч эм зүйн тоног төхөөрөмж болон эмийн сурталчилгаанууд эмч нар зөвлөх болов уу гэсэн итгэлээр эм зүйн тоног төхөөрөмж болон эмийг сурталчлах нь нийтлэг жишиг болоод байна.

‘Өөрийн’ ба ‘бусдын’ гэсэн зааг ялгаа, түүнчлэн хувийн байгууллага болон төр хоёрын хоорондын хамаарлаас зайлсхийхийн тулд төрийн компанийн гэмт хэргийн шинжилгээ зайлшгүй хэрэгтэй. Энэхүү шүүмжлэл нь зарим үйлдлийг гэмт хэрэг хэмээн тодорхойлох болон хянах, бусад үйлдлийг байж болох хэмээн хүлээн зөвшөөрөх явдал нь нийгмийн тогтсон процессын үр дүн гэсэн Күиннэйгийн (*Quinney 1977*) саналд (*Kramer et al. 2002*) үндэслэдэг. Компани болон төрийн огтлолцол дээр хийгдэх тодорхой үйлдлийг гэмт хэрэг гэж үздэггүй. Энэ нь тэдгээр үйлдлийн нийгэмд учруулж буй хор нөлөөнөөс үл хамааран нэг бол хуулиар гэмт хэрэгт тооцоогүйгээс, эсхүл хуулийг хэрэгжүүлж, хяналт тавьж буй хүмүүс түүнийг хууль бус гэж үзэхгүй байгаатай холбоотой (*Kramer et al. 2002*) байдаг. Улс төрийн түвшин дэх төрийн-зохион байгуулалттай гэмт хэрэгт мөн адил зүйл хамаарахыг Турк дэх барилгын үйлдвэрлэлийн авлига (*Green 2005*), газар хөдлөлтийн дараах хүмүүсийн зовлонгоор харуулсан.

Төрийн-компанийн гэмт хэрэг нь компанийн гэмт хэргийн цаад эздийн сүлжээг илүү бүрнээр харахад хувь нэмэр оруулсан. Хувийн байгууллага чухал байгаад зогсохгүй, хууль баталдаг институт бөгөөд хэрэгжүүлэгчийнхээ хувьд төр ч чухал. Төрийн-компанийн гэмт хэрэг гэдэг ойлголт мөн авлигын талаарх эрүүгийн хууль дахь тодорхойлолт бөгөөд тэр нь эдгээр салбар хоорондох нийгмийн хор хохирол, хөнөөлтэй үйлдлийг багтааж чадахгүй байгаа талаарх маргааныг тодотгож өгдөг. Швендингэр (*Schwendinger*) нар (*Taylor et al. 1973:138 дэх*) гэмт хэргийн хүний эрхийн тодорхойлолт гаргахыг уриалсан бол дараа нь Грийн, Вард (*Green and Ward 2004*) нар нийгмийн

2 Авлигыг судлах нь: Салбар дамнасан асуудал

хор хохирол бүхий хүний эрхийн зөрчлийг төрийн гэмт хэргийн тодорхойлолтын нэг хэсэг болгон заасан.

Гэхдээ илэрхий төрийн гэмт хэрэг гэж газар зүйн хяналтдаа буй дотоодын иргэд рүүгээ, эсхүл түрэмгийлэл болон колоничлох зэрэг аргаар бусад улсын иргэд рүү чиглэсэн хөнөөлтэй үйлдэл гаргахыг (*Barak 1991, 1993; Chambliss 1989; Brooks et al. 2013*) хэлдэг. Гэвч Каузларич болон Крамер нар тайлбарлахдаа (*Kauzlarich and Kramer 1998*) хөнөөлт үйлдлийн энэхүү тодорхойлолт нь хувь хүний үйлдэл, байгууллагын шаардлагаас үүдсэн үйлдлийн ялгаа буюу цагаан захтны гэмт хэргийн бүхий л судалгаанд байдаг суурь асуудлыг хадгалсаар байна гэсэн. Түүний оронд байгууллагыг чулуунд цутгачихсан ёс зүйн хөдөлшгүй шинж чанартай гэж биш, тодорхой нөхцөл байдалд үйл ажиллагаа явуулж буй ‘нийгмийн тоглогч’ гэж харах нь (*Huisman and Vande Walle 2010*) зүйтэй.

Гэхдээ төрийн гэмт хэрэг гэж юу болох, түүнийг хэрхэн тодорхойлох талаар хэд хэдэн онолын тайлбар байдаг. Каузларич болон Крамерийн (*Kauzlarich and Kramer 1998*) олон түвшний шинжилгээний арга нь олон улсын хуульд үндэслэжээ. Түүнчлэн төрийн гэмт хэргийн учир шалтгааны механизмыг тодруулахад макро, дунд (*байгууллагын*), микро (*ялгаатай нөхөрлөлийн*) тайлбарыг хэрэглэжээ. Мөн уг арга нь төрийн гэмт хэргийн хэсэг болсон үйлдэхүйн болон эс үйлдэхүйн гэмт хэргийг судлахад хэрэг болно.

Гэвч уг арга нарийвчлалтай бус харагдаж байгаа гэдэг талаас шүүмжлэгдэж (*Green and Ward 2000, 2004*) болзошгүй. Каузларич, Крамер нараас (*1998*) эсрэгээр Грийн, Вард (*Green and Ward 2000*) нар хэм хэмжээг зөрчих үйлдэлд суурилсан төрийн гэмт хэргийн тодорхойлолтыг санал болгож, төрийн үйлдэлд зөрчилтэй гэсэн хаяг зүүхэд оролцох нийгмийн үзэгчдийн үүргийн ач холбогдлыг цохон тэмдэглэжээ. Төрийн үйл хөдлөлийн олон янзын байдал болон үйл хөдлөлийг орон

зай, цаг хугацааны дунд ойлгох боломжийг бүрдүүлэхийн тулд тэд төрийн гэмт хэргийг иргэдэд суурилж тодорхойлохыг уриалсан. Бид нийгмийн тодорхой оролцогчдын төсөөлөлд давуу эрх олгож, бусдынхаас нь татгалзах ёстой учир энэ тодорхойлолт ч хязгаарлагдмал талтай. Энэ нь өөрсдийн хувийн, үзэл суртал, улс төрийн дур сонирхолдоо үндэслэн, зарим нэг тодорхойлолтыг бусдаас дээгүүрт тавьж үзэх, үүнийгээ сонгох ёстой гэсэн нөхцөл байдалд оруулна. Түүнчлэн тодорхойлолт үнэн зөв эсэх талаарх субъектив дүн шинжилгээ хийх нь бас асуудалтай. Орчин үеийн аль ч ардчилсан улсад аль нь хүлээн зөвшөөрөх ёстой тодорхойлолт вэ гэх талаар олон янзын үзэл бодол байдаг бөгөөд тэр талаар хэзээ ч маргалдах (*Brooks et al. 2013*) боломжтой.

Грийн, Вард нарын бүтээл (*Green and Ward 2000*) улс дотроо нэр шошго бий болгож, хэрэглэж буй иргэдэд голлон анхаарсан учир төрийн гэмт хэргийн чухал талыг орхигдуулжээ. Тэд эрх мэдэл бүхий этгээд хүн ам дотроо үзэл суртлыг хэрхэн үүсгэж, хадгалдаг вэ гэдгийг авч үзэлгүй орхигдуулсан байна. Мэдээллийн хэрэгслийг удирдах, эсхүл албаны илтгэл яриа хийх замаар олон нийтийн санаа бодлыг үүсгэж, савлуулж, нөлөөлж болох бөгөөд ингэснээр гэмт зан үйлийг зарим тохиолдолд иргэдээр хүлээн зөвшөөрүүлж (*албаны мэдээлэл болон 'үнэн'-ийг гуйвуулах талаар IX бүлгээс үз*) болно. Тодорхойлолтын талаар субъектив хэмжүүрт найдсанаар ижилхэн үйлдлийг нэг улсад төрийн гэмт хэрэг гэж үзэж байхад нөгөөд нь тэгж үзэхгүй байхад хүрнэ. Тиймээс төрийн гэмт хэргийн тодорхойлолт нь объектив байдлаар хэрэглэж болохоор байх ёстой.

Төр нь 'гэмт хэргийн дамжуулагч' (*conduit of crime*) байж, капиталын хуримтлалын төлөө, эсхүл эрүүл мэндийн болон аюулгүй байдлын хуулийг сулруулах замаар хувь хүмүүсийн аюулгүй байдлыг золионд гаргаж болзошгүй гэдэг нь хүлээн (*Slapper and Tombs 1999; Tombs and Whyte 2007*) зөвшөөрөгдсөн. Гэсэн ч төр үйл ажиллагаагаа явуулахдаа олон нийтээр хүлээн

2 Авлигыг судлах нь: Салбар дамнасан асуудал

зөвшөөрүүлэхийг эрмэлздэг учраас хуулийг сулруулах явдал нь улс төрийн асуудал байдаг бол төр нь эрх мэдлээ ашиглан ашиг сонирхлоо хөөцөлдөх нь капитал хуримтлуулахтай хамаатай байдаг. Ийм онолын тайлбар нь анги давхраа бөгөөд тэгш бус байдал нь гэмт хэрэг үүсгэх хүчний үүргийг гүйцэтгэдэг гэж онцолдог. Тэгвэл төрийн гэмт хэрэг гэдэг нь нийгмийн нөөц болон төрийн түлхүүр институцэд хэт их хяналттай байх (*Tittle 1995*) явдал болно. Бүхий л төрийн албаа хяналтдаа байлгадаг, иргэний байгууллагуудын хөгжлийн түвшин буурай улсад ийм хяналт нь хамаагүй илүү шууд байна. Гэхдээ ардчилсан төр нь элитүүдийн ямар нэг нөлөөгүйгээр өөрийн ашиг сонирхлын үүднээс үйлдэл хийж, эсхүл нөлөөгөө, эсхүл хүлээн зөвшөөрөгдөх байдлаа тэлэх болон хадгалах зорилгоор үйлдэл хийдэг. Улс төрийн институцийг хянах энэхүү хяналт, эсхүл тэдэнд нөлөөлөх эрх мэдлийг магадгүй тогтсон, хөдөлшгүй зүйл бөгөөд гэмт хэрэг гэх цогц ойлголтын нэг хэсэг гэж биш уян хатан зүйл гэж харах нь дээр болов уу.

Гэхдээ ардчилсан болон ардчилсан бус аль ч улсад төр нь **state capture** буюу ‘төр хувийн ашиг сонирхолд автагдах’ үзэгдэл нь эрсдэлтэй. Ялангуяа зохицуулах тал дээр (*Dal Bo 2006*) хувийн ашиг сонирхолд автагдах буюу төрийн хяналт нь хувийн дотоод ашиг сонирхлоор залагдаж, саатуулагдаж, будилаантаж (*Brooks нар 2013*) болно. Төр хувийн ашиг сонирхолд автагдах үзэгдэл нь төрийн дэд бүтэц ба төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээг бүхэлд нь, эсхүл түүний зарим хэсгийг хамарч болно. Криминологийн үүднээс төрийн гэмт хэргийг ‘бусдын’ ба ‘өөрийн’ гэсэн өнцгөөр хардаг. Бид өөрсдөө ч гэсэн авлигажсан байдаг ч (*Whyte 2015*) барууныхан бид өөрсдийгөө цагдаа гэж (*Green and Ward 2004*) хардаг. Харин ядуу улсуудыг дээрэмчид удирддаг, эсхүл үл бүтэх улс юм уу, нурж унасан улс гэж хардагт асуудал байна.

Авлигын тодорхойлолтод хүний эрх болон хохирлыг оруулснаар ядаж л төр, өрсөлдөж буй байгууллагууд

болон хамтын нэгдлийн хохирогч болсон төрөл бүрийн хохирогчдыг тодруулан гаргаж ирнэ. Зарим тохиолдолд гэмт хэрэг хохирогчгүй (*Croall 2001*), эсхүл гэмт хэрэгтэн болон хохирогчдын хооронд газар зүйн болон санхүүгийн хувьд хэт хол зай байх нь хохирол харагдахгүй байхад нэмэр болдог. Мөн хохирогч нь хохирлоо ухамсарлахгүй байх үед хохирлын талаар зохих хүмүүс мэдэхгүй байдаг. Түүнчлэн хүмүүс хохирч байгаагаа ухамсарлаж байсан ч тэдний эзэлж буй нийгмийн байр суурь нь хариу үйлдэл үзүүлэх бараг боломжгүй нөхцөлд хүргэх үе байдаг. “Транспэрэнси интернэшнл”-ээс гаргадаг Дэлхийн авлигын хэмжүүр (*Global Corruption Barometer*) нь орлого багатай өрх хамгийн их авлига төлөх шаардлагатай байдаг агаад голчлон хамгийн сул, дорой, мэдээлэлгүй хүмүүс нь хохирогч болж байгааг харуулж байна.

Социологи, криминологийн бүтээлүүд нь хувь хүн, байгууллага, төр зэрэг олон төрлийн тоглогчдод анхаарал хандуулаад гэмт хэргийн болон авлигын үйлдлийг хийх шалтгаанд бас анхаарчээ. Хуулийн этгээдийн гэмт хэргийн тухайд бол байгууллага дахь хувь хүн гэрээ байгуулахын тулд бусдад хахууль өгч магадгүй. Хүлээн авах талдаа бол байгууллагынхаа ашиг сонирхолд нийцэхгүй үйлчилгээ, эс үйлдэхүйн хариуд өөрийн ашгийн төлөө хахууль авч буй төрийн эсхүл хувийн байгууллагын албан хаагч байж (*Huisman and Vande Walle 2010*) болно. Энэхүү ‘солилцоо’ нь сэдэл, боломж, нийгмийн хяналтын бэлэн байдалтай хамааралтай байдаг. Коулман (*Coleman 1987:409*) үзэхдээ сэдэл гэдэг нь тодорхой төрлийн зорилго, зорилтын зохимжтой, хүсмээр зүйл хэмээн тодорхойлдог ‘бэлэг тэмдгийн байгууламжийн’¹⁰ иж бүрдэл юм гэсэн байдаг. Эдгээр бэлэг тэмдгийн байгууламж нь нийгмийн

10 Symbolic construction – Английн эрдэмтэн нийгмийн антропологич Антони Кохэн нийгэм бол бэлэг тэмдгийн хувьд байгуулагдсан үнэт зүйл, хэм хэмжээ, ёс зүйн дүрмийн тогтолцоо бөгөөд эдгээр нь хүмүүст өөрсдийгөө бусдаас өвөрмөц хэмээн харах боломж олгодог гэж тодорхойлсон болохыг зохиолч энд хэрэглэжээ. (Орч.)

2 Авлигыг судлах нь: Салбар дамнасан асуудал

тодорхой хэдэн нөхцөл бүрдсэнээр хийх боломжтой болж, болзошгүй үйлдлийн чиглэлийг санал болгож байдаг. Хяналтын бэлэн байдал нь ‘боломж’-ийн эсрэг ойлголт буюу жишээ нь, гэмт хэрэг гарч буй ресторанд ажилладаг хамгаалагчийн үзүүлэх албан ёсны болон албан бус хяналт (**X, XI бүлгийг үз**) юм. Сэдэл буюу мотиваци нь сэтгэлзүйн дур хүслийн субъектив байгууламж болдог бөгөөд хянах боломж нь нийгмийн объектив нөхцөл дээр суурилдаг ч эдгээр хувьсагч нь салшгүй уялдаатай.

Тэгвэл авлигын үйлдлийн тайлбар нь хэд хэдэн түвшинд хийгдэх боломжтой болно. Өөрөөр хэлбэл хувь хүний нийгмийн харилцааны түвшин, байгууллагын бүтцийн болон соёлын шинж чанарын түвшин, улс төрийн эдийн засаг, бизнесийн зохицуулалтын хүрээний институцийн түвшинд (*Shover and Bryant 1993; Kramer and Michalowski 2006*) хийгдэж болно. Вауган (*Vaughan 2002*) макро түвшинд гэмт хэргийг үүсгэгч нь ‘өрсөлдөөний соёл’ гэж үзсээр ирсэн өнөө үед авлигын үйлдлийг тайлбарлахдаа эдгээр уялдаа холбоог болон гадаад орчин, байгууллагын нөхцөл байдал, хувь хүний зан үйл хоорондын хамаарлыг ойлгох нь чухал болохыг онцлон (*Coleman 1995:363*) тэмдэглэжээ.

Энэ өнцгөөс харахад эд баялаг, амжилтыг чухалчлан үзэж, хүмүүс бол юмыг үндэслэлтэй харж, чөлөөтэй сонгох эрх мэдэлтэй, тиймээс өөрийн нөхцөл байдалд өөрсдөө хариуцлага хүлээх бие даасан хувь хүн гэж үздэг. Өрсөлдөөний соёл нь хувийн амжилтын төлөөх өрсөлдөөн тэмцлийг сөрөг, эсхүл хувиа хичээсэн зүйл гэж бус эерэг зүйл гэж хардаг. Өрсөлдөөн нь нийгэмд бүхэлд нь хамгийн их эдийн засгийн нэмүү өртөг авчирдаг боловч амжилт, баялгийг хөөцөлддөг чанар нь өөрөө гэмт хэрэгт уруу татдагдах нөхцөлийг бий болгодог гэж зарим судлаачид үздэг (*Merton 1938; Punch 1996; Slapper and Tombs 1999*) байна. Гэхдээ Пассас (*Passas 1990*) амжилт эрсдэлийг дагуулж болохыг тэмдэглэсэн. Өөрөөр хэлбэл, хэрвээ амжилт нь аюулд өртсөн нөхцөлд баялгийг олж авах цор ганц арга нь хууль

бус арга гэж үзвэл зарим хүмүүс гэмт хэрэгт уруу татагдана гэж тэрээр бичсэн. Түүнчлэн тооцоологдсон хувийн ашиг сонирхлын зарчим нь нээлттэйгээр хуваалцах болон харилцан солилцооны зарчимтай сөргөлдөнө. Хувийн ашиг сонирхол ба уламжлалт харилцан солилцооны энэхүү зөрчил нь ихэвчлэн зах зээл даяарчлагдахтай холбоотой гэгддэг ‘авлигын тэсрэлт’-тэй (*corruption eruption*) хамааралтай зүйл (*Beare 1997*) юм. Гэхдээ хувийн ашиг сонирхол нь зөвхөн капиталист улсуудад л байдаг онцлогтой юм биш. Энэ нь коммунизмд ч илэрхий байдаг. Харин тэнд жинхэнэ эрх мэдэл нь төрийн байгууллага, захиргааны эрх мэдэлд байдаг.

Даяарчлал нь хуулийн этгээдийн гэмт хэргийн үндэс болсон гэмт хэргийг үүсгэгч зан үйлийг үржүүлэн, өсгөж, идэвхжүүлж байна. Пассас (*1998:26*) эдгээр тэгш хэмт бус байдлыг ‘улс төр, соёл, эдийн засаг, хуулийн хүрээн дэх бүтэцлэгдсэн тэгш бус байдал, үл зохицол, тусгаарлагдмал байдал’ юм хэмээн тодорхойлжээ. Эдгээр нь хууль бус талбарыг бий болгож, сэдэл төрүүлж, гэмт хэрэгтнүүд илрэхгүй бултах, илэрсэн ч шүүгдэхгүй байх боломжийг олгодог учраас гэмт хэргийн шалтгаан болдог байна. Энэ нөхцөл байдал нь нийгэм, эдийн засаг, улс төрийн дэвшилд саад (*III бүлэг дэх ‘Арааг тослох нь’, ‘Арааг элсээр бөглөх нь’ хэсгийг үз*) болдог.

Системийн онол нь авлигыг авч үзэх суурийг санал болгодог гэдгээр танигдсан онол бөгөөд нийгэм дэх тогтолцоонуудын хоорондын холбооны талаар болон тэдгээр нь авлигад хэрхэн нөлөөлөх талаарх ойлголтыг өгдөг онол юм. Хувийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид төлбөр төлөх аргадаа өөрчлөлт хийж, авлигажсан хувь хүн, байгууллагууд аргаа өөрчилж, шинэ тогтолцоонд дасан зохицсон ч хандлага, зан үйл нь өөрчлөгдөхгүй байгаа нь улс төрийн тогтолцоо авлигад хэрхэн шууд нөлөөлж болохыг харуулах жишээ (*Sparrow 2000*) болно. Өөр нэг жишээ нь санхүүгийн салбарыг чөлөөлөх жишээ юм. Санхүүгийн хямралаас өмнө Понтелл (*Pontell 2005:319*)

2 Авлигыг судлах нь: Салбар дамнасан асуудал

‘цагаан захтны гэмт хэргийг цайруулах төрийн бодлого болон ... залилангийн авчирч болзошгүй сүйрлийг онцгойлон хүлээн зөвшөөрөөгүй бодлого нь үр ашиггүй байгаад зогсохгүй санхүүгийн сүйрлийн бодит гар зураг болох болно’ хэмээн хэлж байв. Тийм ч зүйл болжээ. Түүнчлэн зохицуулалт, чөлөөлөлт, авлигын түвшин улс улсад өөр өөр, тухайлбал, заавал дагаж мөрдөх стандарт огт байхгүй байх, өөрсдөө зохицуулалт хийх, эсхүл авлигыг гэмт хэрэгт тооцдог байх гэх мэт янз бүрийн хэлбэртэй байж болно. Хууль тогтоогчдын тавих шаардлага, хүлээн зөвшөөрөгдөх зан үйлийн зах хязгаар тодорхойгүй байх нь авлига гэсэн цогц ойлголтын хаана байгаагаас үл хамааран цагаан захтны гэмт хэрэг, авлигын үйлдэл гарах нийтлэг шинж чанарт (*Nelken 1994; Weisburd and Waring 2001; Zimring and Johnson 2005*) тооцогддог.

Авлигыг ойлгох, тайлбарлахад оруулах социологи, криминологийн бүтээлийн хувь нэмэр нь өргөн цар хүрээтэй байна. Өөрөөр хэлбэл, хувь хүн, байгууллага, төрд анхаарсан, ганцаар эсхүл хамтран үйлдэл хийх сэдэл, эрх мэдлийн талаарх ойлголт, авлигажсан байна гэж юу болохыг тодорхойлох чадварыг авч үзсэн нийгмийн бүтцэд эзэлж буй байр сууриар хязгаарлагддаг ч ‘чөлөөт’ рационал хувь хүнийхээ үүднээс сэтгэж, үйл хөдлөл хийх чадвар, авлига гэх сонголтоос татгалзах чадвар, ‘бусдад’ авлигажсан гэх, ямар нэг юманд ‘гаднын’ гэсэн нэр шошго зүүх чадвар, авлигын үйлдлийг зөвтгөх чадвар зэргийг авч үзсэнээрээ маш өргөн цар хүрээтэй байна. Тиймээс дараах бүлгүүдэд авлигыг тайлбарлахад ялгаатай нөхөрлөл (*Sutherland 1939*), дарамт (*Merton 1938*), саармагжуулах арга хэрэгсэл (*Sykes and Matza 1957*), гулсах (*Matza 1964*), нэр шошго зүүх (*Becker 1966*), зөрчилдөөн (*Quinney 1977*), рационал сонголт (*Wilson and Herrnstein 1985*), хэвшмэл үйл ажиллагаа (*Felson and Cohen 1979*) зэрэг онолын аргачлалд түшиглэнэ.

Дүгнэлт

Энэ бүлэгт авлигыг тодорхойлоход учирдаг хүндрэлийг эхлээд авч үзлээ. Гэхдээ бид зохих тодорхойлолтыг гаргах оролдлогоос ухрах ёсгүй. Мөн авлигын талаарх бүтээл дэх рационал-эдийн засаг, улс төр, хууль зүйн талаас хүмүүс яагаад авлигажсан байдаг вэ, яагаад авлигын үйлдэл гаргадаг вэ гэдэг талаар онолын тайлбарыг товч авч үзсэн. Түүний дараагаар цагаан захтны гэмт хэрэг, хувь хүний болон хуулийн этгээдийн гэмт хэрэг, төрийн компанийн гэмт хэрэг, төрийн гэмт хэрэг, дутмаг зохицуулалт, капиталист нийгэм дэх авлигын талаарх судалгаанд социологи, криминологийн оруулсан хувь нэмрийг авч үзсэн.

Түүнчлэн энэ бүлэгт авлигын тодорхойлолтод өнөөгийн хуулийн тодорхойлолтын хүрээнээс хальж, хохирол болон нийгэмд хөнөөлтэй бусад хэлбэрийн үйлдлийг оруулах ёстой эсэх тухай асуудал дэвшүүлсэн. Ингэж өргөтгөх нь зайлшгүй бөгөөд тороо өргөтгөх нь үр нөлөө дагуулах (*Cohen 1985*) болно. Хэрвээ тэгэхгүй бол авлига нь ердийн сэжигтнүүдээр хязгаарлагдах (*Passas 1998*) болно. Хэдийгээр криминологид хэрэгтэй зүйл олон байгаа ч судалгааны объект болохын хувьд авлига нь цагаан захтны гэмт хэрэгт эшлэгдэхээс өөрөөр криминологийн судалгааны сэдэв болох тохиолдол ховор (*Huisman and Vande Walle 2010*) байна.

Зарим үед авлига нь гэмт хэргийн хэлбэртэй бөгөөд мөн хэм хэмжээг зөрчих үйлдэл байдаг. Криминологид байдаг авлига бол өөр төрлийн гэмт хэргийн шалтгаалагч хүчин зүйл, дам нөлөөний аль аль нь болдог гэсэн санаа юм. Энэ нь криминологийн оруулах хувь нэмэр болно. Авлига нь хууль бус үйлдлийг далдлах замаар, зохион байгуулалттай гэмт хэрэг цэцэглэх боломжийг бий болгодог учраас түүний шалтгаалагч хүчин зүйл болдог бол авлигад хүргэдэг залилах, байгаль

орчныг бохирдуулахад чиглэсэн байгууллагын болон төрийн-компанийн гэмт хэргийн дам нөлөө нь авлига байдаг.

Зохион байгуулалттай гэмт хэрэг болон байгууллагын гэмт хэрэгт үзүүлж байгаа хариу үйлдлийг харахад төр, иргэний болон эрүүгийн тогтолцооны байгууллагуудын ихэвчлэн оноож буй шийтгэл нь цээрлүүлж (*тухайн үйлдэл гарахаас сэргийлэх*) чадахгүй байгаа учир эрүүгийн хууль болон бусад хуулийн шийтгэлийн цээрлүүлэх үл нөлөө нь харьцангуй хязгаарлагдмал байна гэж үзэж болохоор байна. Гэхдээ эдийн засаг, улс төр, хууль зүйн аргачлалаас илүү ихийг авлигын асуудал дээр хэрэглэн, бидэнд байгаа онолын аргачлалаа нэмэгдүүлснээр бид хүмүүс *яагаад, хэрхэн* авлигажсан байдаг талаарх ойлголтоо нэмэгдүүлж чадах болно.

Ашигласан материал

- Andrews, J., & Montinola, G. R. (1998). *Corrupt democratization: The importance of institutional design in the multidimensional political environments of transition*. Boston: Annual Meeting of the American Political Science Association.
- Barak, G. (1991). Toward a criminology of state criminality. In G. Barak (Ed.), *Crimes by the capitalist state: An introduction to state criminality*. New York: State University of New York Press.
- Barak, G. (1993). Crime, criminality and human rights: Toward an understanding of state criminality. In K. Turnell (Ed.), *Political crime in contemporary America: A critical approach*. New York: Garland Press.
- Beare, M. E. (1997). Corruption and organized crime: A means to an end. In B. Rider (Ed.), *Corruption: The enemy within*. The Hague: Kluwer Law International.

- Becker, H. (1966). *Outsiders: studies in the sociology of deviance*. New York: Free Press.
- Becker, G. S. (1968). Crime and punishment—Economic approach. *Journal of Political Economy*, 76, 169–217.
- Belaisha, B. B., & Brooks, G. (2014). Money laundering in Dubai: Strategies and future directions. *Journal of Money Laundering Control*, 17 (3), 343–354.
- Bliss, C., & Di Tella, R. (1997). Does competition kill corruption. *Journal of Political Economy*, 105 (5), 1001–1023.
- Box, S. (1983). *Power, crime and mystification*. London: Routledge.
- Braithwaite, J. (1984). *Corporate crime in the pharmaceutical industry*. London: Routledge and Kegan Paul.
- Brooks, G. (2012). Online gambling and money laundering: Views from the inside. *Journal of Money Laundering Control*, 15 (3), 304–316.
- Brooks, G., Walsh, D., Lewis, C., & Kim, H. (2013). *The prevention of corruption: Investigation, enforcement and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Campos, N., & Giovannoni, F. (2006). *Lobbying, corruption and political influence* (IZA Discussion Paper 2313).
- Chaikin, D., & Sharman, J. C. (2009). *Corruption and money laundering: A symbiotic relationship*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Chambliss, W. (1989). State organized crime. *Criminology*, 27 (2), 183–208.
- Cohen, S. (1985). *Visions of social control*. Cambridge: Polity Press.
- Coleman, J. W. (1987). Toward an integrated theory of white-collar crime. *American Journal of Sociology*, 93 (2), 406–439.

- Coleman, J. W. (1995). Motivation and opportunity: Understanding the causes of white-collar crime. In G. Geis, R. Meier, & L. Salinger (Eds.), *White collar crime* (3rd ed.). New York: Free Press.
- Croall, H. (2001). *Understanding white-collar crime*. Buckingham: Open University Press.
- Dal Bo, E. (2006). Regulatory Capture: A Review. *Oxford Review of Economic Policy*, 22 (2), 203-225
- Felson, M., & Cohen, L. (1979). Social change and crime rate trends: A routine activity approach. *American Sociological Review*, 44 (4), 588–608.
- Friedrichs, D. O. (2002). Occupational crime, occupational deviance, and workplace crime: Sorting out the difference. *Criminology and Criminal Justice*, 2 (3), 243–256.
- Golden, M., & Picci, L. (2005). Proposal for a new measure of corruption, Illustrated with Italian data. *Economics and Politics*, 17 (1), 37–55.
- Gounev, P., & Ruggiero, V. (2012). *Corruption and organized crime in Europe: Illegal partnerships*. Abingdon: Routledge.
- Gray, G. C. (2009). The responsabilization strategy of health and safety neoliberalism and the reconfiguration of individual responsibility for risk. *British Journal of Criminology*, 49 (3), 326–342.
- Gray, G. C. (2013). Insider accounts of institutional corruption examining the social organization of unethical behaviour. *British Journal of Criminology*, 53 (4), 533–551.
- Green, P. (2005). Disaster by design: Corruption, construction and catastrophe. *British Journal of Criminology*, 45 (4), 528–546.

- Green, P., & Ward, T. (2000). State crime, and human rights and the limits of criminology. *Social Justice*, 27 (1), 101–120.
- Green, P., & Ward, T. (2004). *State crime, governments, violence and corruption*. London: Pluto Press.
- Hasnas, J. (1995). Back to the future: From critical legal studies forward to legal realism, or how not to miss the point of the indeterminacy argument. *Duke Law Journal*, 45, 84–132.
- Heidenheimer, A. J. (1989). Perspectives on the perception of corruption. In A. J. Heidenheimer, M. Johnston, & V. T. Levine (Eds.), *Political corruption: A handbook*. New Brunswick, NJ: Transaction.
- Heywood, P. M. (2015). *Routledge handbook of political corruption*. Abingdon: Routledge.
- Hough, D. (2015). *Corruption, anti-corruption and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Huisman, W., & Vande Walle, G. (2010). *The criminology of corruption. The good cause. Theoretical perspectives on corruption*. Barbara Budrich: Opladen.
- Iyer, N., & Samociuk, M. (2006). *Fraud and corruption: Prevention and detection*. Aldershot: Gower Publishing.
- Jensen, M., & Meckling, W. (1976). Theory of the Firm: Managerial behavior, agency costs and ownership structure. *Journal of Financial Economics*, 3, 305–360.
- Johnston, M. (2005). *Syndromes of corruption: Wealth, power and democracy*. Cambridge: Cambridge University Press.
- Kauzlarich, D., & Kramer, R. (1998). *Crimes of the American nuclear state: At home and abroad*. Boston: Northeastern University Press.

- Kleemans, E. R. (2008). Introduction to special issue: Organized crime, terrorism and European criminology. *European Journal of Criminology*, 5 (1), 5–12.
- Klitgaard, R. (1998). *Controlling corruption*. Berkeley, California: University of California press.
- Kramer, R. C., & Michalowski, R. J. (2006). *State-corporate crime. Wrongdoing at the intersection of business and government*. New Brunswick, NJ: Rutgers University Press.
- Kramer, R., Michalowski, R., & Kauzlarich, D. (2002). The origins and development of the concept and theory of state-corporate crime. *Crime and Delinquency*, 48 (2), 263–282.
- Levi, M. (2002). Money laundering and its regulation. *Annals of the American Academy of Political and Social Sciences*, 31 (3), 181–194.
- Levi, M., & Gilmore, W. (2002). Terrorist finance, money laundering and the rise and rise of mutual evaluation: A new paradigm for crime control? *European Journal of Law Reform*, 4 (2), 337–364.
- Levi, M., & Reuter, P. (2006). Money laundering. *Crime and Justice*, 34 (2), 289–375.
- Macpherson, S. W. (1999). *The Stephen Lawrence inquiry: Report of an inquiry*. London: The Stationary Office.
- Manzetti, L., & Blake, C. (1996). Market reforms and corruption in Latin America. *Review of International Political Economy*, 3, 671–682.
- Mars, G. (2006). Changes in occupational deviance: Scams, fiddles and sabotage in the twenty-first century. *Crime, Law and Social Change*, 45, 285–296.
- Matza, D. (1964). *Delinquency and Drift*. New York: Wiley.

Авлигын криминологи

- McClellan, B., & Elkind, P. (2013). *The smartest guys in the room: The amazing rise and scandalous fall of Enron*. New York: Portfolio Penguin.
- McCusker, R. (2000). Money laundering control: Elusive dream or achievable reality? *Journal of Money Laundering Control*, 3 (3), 214–222.
- McCusker, R. (2005). *Underground banking: Legitimate remittance network or money laundering system?* Canberra: Australian Institute of Criminology.
- Merton, R. K. (1938). Social structure and anomie. *American Sociological Review*, 3, 672–210.
- Nelken, D. (1994). White-collar crime. In M. Maguire, R. Morgan, & R. Reiner (Eds.), *The Oxford handbook of criminology*. Oxford: Oxford University Press.
- Olivier de Sardan, J. P. (1999). A moral economy of corruption in Africa? *The Journal of Modern African Studies*, 37 (1), 25–52.
- Passas, N. (1990). Anomie and corporate deviance. *Crime, Law and Social Change*, 14 (2), 157–178.
- Passas, N. (1998). Structural analysis of corruption: The role of criminogenic asymmetries. *Transnational Organized Crime*, 4 (1), 42–55.
- Payne, B. K. (2012). *White collar crime: A Text/Reader*. Thousand Oaks, CA: Sage Publications.
- Pearce, F., & Tombs, S. (1998). *Toxic capitalism: Corporate crime and the chemical industry*. Aldershot: Ashgate.
- Philp, M. (2015). The definition of political corruption. In P. M. Heywood (Ed.), *Routledge handbook of political corruption*. London: Routledge.

- Pontell, H. N. (2005). White collar crime or just risky business? The role of fraud in major financial debacles. *Crime, Law and Social Change*, 42 (4), 309–324.
- Punch, M. (1996). *Dirty business. Exploring corporate misconduct, analysis and cases*. London: Sage publications.
- Punch, M. (2000). Police corruption and its prevention. *European Journal on Criminal Policy & Research*, 8(3), 301–324.
- Quinney, R. (1977). *Class, state, and crime: On the theory and practice of criminal justice*. New York: David McKay.
- Rawlinson, P. (2012). Corruption, organised crime and the free market in Russia. In P. Gounev & V. Ruggiero (Eds.), *Corruption and organised crime in Europe*. Abingdon: Routledge.
- Rider, B., (Ed.). (1997). *Corruption: The enemy within*. The Hague: Kluwer Law International.
- Rose-Ackerman, S., & Palifka, B. J. (2016). *Corruption and government: Causes, consequences, and reform*. Cambridge University Press.
- Ruggiero, V. (1996). *Organized and corporate crime in Europe. Offers that can't be refused*. Aldershot: Dartmouth.
- Schmidt-Pfister, D., & Moroff, H. (2012). *Fighting corruption in Eastern Europe: A multi-level perspective*. Abingdon: Routledge.
- Shover, N., & Bryant, K. M. (1993). Theoretical explanations of corporate crime. In M. B. Blankenship (Ed.), *Understanding corporate criminality*. New York: Garland Publishing.
- Slapper, G., & Tombs, S. (1999). *Corporate crime*. Essex: Pearson.
- Sparrow, M. (2000). *License to steal: How fraud bleeds America's health care system*. Boulder, CO: Westview.

Авлигын криминологи

- Suda, K. (2011). Creative accounting and accounting scandals in Japan. In M. Jones (Ed.), *Creative accounting, fraud and international accounting scandals*. Chichester: Wiley.
- Sutherland, E. H. (1939). *Principles of criminology* (3rd ed.). Philadelphia, PA: Lippincott.
- Sutherland, E. H. (1961). *White collar crime*. New York: Holt, Rinehart and Winston.
- Sykes, G. M., & Matza, D. (1957). Techniques of neutralization: A theory of delinquency. *American Sociological Review*, 22, 664–670.
- Taylor, I., Walton, P., & Young, J. (1973). *The new criminology*. London: Routledge.
- Thomas, K. (2014, November 29–30). Doctors under a cloud, helped market drug. *International New York Times*, p. 16.
- Thomas, K., & Abrams, R. (2014, December 8). A payoff for eye doctors in promotion of new drug. *International New York Times*, p. 16.
- Tillman, R. (2009). Making the rules and breaking the rules: The political origins of corporate corruption in the new economy. *Crime, Law and Social Change*, 51 (1), 73–86.
- Tittle, C. R. (1995). *Control balance: Toward a general theory of deviance*. Boulder, CO: Westview press.
- Tombs, S. (2009). Official statistics and hidden crimes: researching health and safety crimes. In H. Croall (Ed.), *Corporate Crime, Vol. 1. Issues of Definition, Construction and Research*. SAGE Library of Criminology. London: SAGE Publications Ltd., pp. 281–296.
- Tombs, S., & Whyte, D. (2007). *Safety crimes*. Cullumpton: Willan.

- Transparency International (2012). *Corruption Perception Index 2012*. London: Transparency International.
- Vaughan, D. (2002). Criminology and the sociology of organizations: Analogy, comparative social organization, and general theory. *Crime, Law and Social Change*, 37 (2), 117–136.
- Warner, C. M. (2015). Sources of corruption in the European Union. In P. M. Heywood (Ed.), *Routledge handbook of political corruption*. London: Routledge.
- Warren, E. (2016). *Rigged Justice 2016: How weak enforcement lets offenders off easy*. Office of United States Senate: Office of Elizabeth Warren.
- Weisburd, D., & Waring, E. (2001). *White-collar crime and criminal careers*. New York: Cambridge University Press.
- Wilson, J. Q., & Herrnstein, R. (1985). *Crime and human nature*. New York: Simon and Shuster.
- Whyte, D. (2015). *How corrupt is Britain*. London: Pluto Press.
- Zimring, F. B., & Johnson, D. T. (2005). On the comparative study of corruption. *British Journal of Criminology*, 45, 793–809.

III

Авлигын цар хүрээ

Удиртгал

Авлигын талаар олон улсад нэг мөр хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт байдаггүй талаар II бүлэгт дурдсан. Энэ нь уг асуудлыг туршилтаар судлахад хүндрэлтэй болгодог. Гэхдээ статистик нь хэдий хэр баримжаалсан байгаагаас үл хамааран хэрэв авлигыг хэмжиж болно гэвэл авлигын түвшинг мэдэж байх нь аль хүчин зүйл нь авлигыг ямар нэг байдлаар бууруулахад нөлөөтэй байна вэ гэдгийг онцлон харахад чухал (*Collier 2000; Brooks нар 2013; Heywood 2015*) ач холбогдолтой. Тиймээс хэмжилт нь авлига нэмэгдсэн эсэх талаар баримжаалах, цар хүрээг ойлгох, авлигын тохиолдлын түвшинг бууруулахад ямар зүйл үр дүнтэй байна вэ гэдгийг тодорхойлоход амин чухал зүйл болно. Тиймээс энэ бүлэгт авлигын цар хүрээ, хүмүүст үзүүлэх нөлөө, авлигатай тэмцэх санаачилга, шинэчлэлийн үр нөлөөг хэмжих гэсэн түүхэн болон өнөөгийн оролдлогуудын талаар авч (*Hough 2015*) үзнэ.

Геркулесийн даалгавар буюу боломжгүй даалгавар: Авлигыг хэмжих

Авлигыг хэмжих хамгийн түгээмэл хандлага нь асуулгаар гаргах төсөөлөлд үндэслэсэн, улс орнуудыг хамарсан индекс юм. Эдгээр нь об'ектив болон суб'ектив хэмжүүрийн аль алиныг агуулдаг. Об'ектив хэмжүүр нь ихэвчлэн тоогоор илэрхийлэгдэж болохуйц бөгөөд нягталж болохуйц өгөгдөлд суурилна. Жишээлбэл, цагдаагийн газар эсхүл авлигатай тэмцэх байгууллагад ирүүлсэн гомдол мэдээллийн албан ёсны тоо, авлигын хэргээр ялласан бодит тоо, компанийн дансанд хийсэн аудит зэрэг нь үүнд (**Brooks нар 2013**) хамаарна. Гэхдээ тийм хэмжүүр нь тухайн улс дахь авлигын бодит түвшин бус түүний тусгал байх магадлалтай бөгөөд авлигын эсрэг чиглүүлж буй нөөц бололцоо, хандлагын илэрхийлэл байх талтай. Үүний үр дүнд албан ёсны тоо баримтаас бусад суб'ектив аргачлалыг илүүд үзэж (*гэхдээ бүхэлдээ тийм биш гэдгийг энэ бүлэгт үзнэ*) нэлээд тоо баримтыг гаргахаа больжээ. Гэвч тэдгээр суб'ектив аргачлал нь өөрийн гэсэн хязгаарлагдмал талтай (**Bradburn 1983**) байдаг.

Суб'ектив хэмжүүр нь санал асуулга, асуумж дээр суурилах хандлагатай байна. Судалгаанд оролцогчдоос авлигын түвшинг үнэлэх зорилгоор зохиогдсон асуултаар тэдний авлигын талаарх төсөөлөл, туршлагыг лавлана. ‘Ердийн’ иргэдийн нүдээр амьдрал дээрх авлигын талаарх туршлагыг харуулахыг зорьдог “Транспэрэнси интернэшнл”-ийн Авлигын төсөөллийн индекс, Дэлхийн авлигын хэмжүүрээс туршлага нь төсөөллийг таамаглахад муу хүчин зүйл болдог бөгөөд үзэл бодол ба туршлага хоорондын ‘зай’ нь улс хооронд маш их ялгаатай байдаг болох нь (**Weber Abramo 2008**) харагддаг. Гэхдээ эдгээр асуулга нь оновчтой бус статистикийн хэмжээг харуулдаг байх магадлалтай ч авлигын талаарх төсөөлөл нь нөлөө ихтэй байдаг.

Хэмжилт хийх объектив болон субъектив аргачлалд тулгарах саад бэрхшээлийг даван туулахын тулд 1990-ээд оноос нэгдсэн индикатор буюу нэгдсэн шалгуур үзүүлэлтийг *(хэд хэдэн объектив болон субъектив шалгуур үзүүлэлтийг нийлүүлсэн)* их хэрэглэх болжээ. Кауфман нар (*Kaufmann et al. 1999*) нэгдсэн индекс нь авлигыг үнэлэх илүү боловсронгуй арга бөгөөд тэдгээрийг хоёрдугаар үеийн хэмжүүр (*Johnston 2002*), эсхүл холимог шалгуур үзүүлэлт гэж нэрлэсэн (*Arndt and Oman 2006*) байна. Нэгдсэн шалгуур үзүүлэлт нь нөлөөтэй болж иржээ. Яагаад гэвэл тэдгээр нь илүү олон улсыг хамардаг, олон янзын хувь шалгуур үзүүлэлтийг нийлүүлдэг. Эдгээр хувь шалгуур үзүүлэлтийн дунджийг гаргадаг иж бүрдэл өгөгдөл нь алдааны зааг болон хувь хэмжүүрт тохиолддог хазайлтыг багасгаж, илэрхий алдааны заагийг тооцдог (*Kaufmann and Kraay 2007*) юм.

Нэгдмэл шалгуур үзүүлэлт олон байдаг ч тэдгээрээс гурвыг нь авлигатай тэмцдэг мэргэжилтнүүд хамгийн найдвартай, оновчтой (*Lambsdorff 2006*) хэмээн харж өргөн хэрэглэдэг ба арай илүү боловсронгуй учраас авлигын үнэлгээнд давамгайл хэрэглэгддэг байна. Үүнд “Транспэрэнси интернэшнл”-ээс (TI) жил болгон гаргадаг Авлигын төсөөллийн индекс (CPI), Дэлхийн банкны боловсруулсан Дэлхийн засаглалын индикатор (WGI) болон Бизнесийн орчин, компанийн гүйцэтгэлийн судалгаа (BEEPS) багтана.

Авлигын төсөөллийн индекс нь авлигын харьцангуй үнэлгээ бөгөөд улс орнуудыг тухайн улс орны төрийн албан хаагчид, улстөрчид, олон улсын бизнесийн төлөөлөгчид авлига хэр байгаа хэмээн төсөөлж байгаагаар жагсаадаг. Авлигын шалтгаан болон үр дагаврыг судалж, шинжлэх боломж олгох илүү оновчтой өгөгдөл бий болгох гэсэн “Транспэрэнси интернэшнл”-ийн санаачилгаар ийм индекс гаргаж (*Knack 2006*) эхэлжээ. Энэ индекст мөн ‘мэргэжилтнүүдээс’ авсан статистик

Авлигын криминологи

болон бие даасан байгууллагуудын хийсэн бизнесийн судалгааг хэрэглэдэг.

Улс орны авлига бараг байхгүй, ялимгүй түвшинд байвал Авлигын төсөөллийн индексийн (АТИ) дээд тал нь 100 оноо авна. Эсрэгээр 0 оноо нь өндөр авлигатай нөхцөл байдлыг заана. “Транспэрэнси интернэшнл” нь 50-иас доош оноо авсан улс орнуудыг авлигын ноцтой асуудалтай улсад тооцдог. 2012 оны судалгаагаар 176 улсаас 53 нь энэ босгоос дээгүүр оноо авсан (*гэвч улс улсад хийсэн нэгдсэн судалгааны тоо харилцан адилгүй*) нь авлига ямар өргөн тархсаныг харуулсан юм.

Гэхдээ Авлигын төсөөллийн индексэд дараах хязгаарлагдмал тал ч байдаг. Үүнд: дэлхийн улсуудыг жагсаах аливаа оролдлогод авлига гэдэгт юуг тодорхойлох вэ гэсэн олон улсын нэгдмэл ойлголт байхгүй нь илэрхий нөлөөлдөг, Авлигын төсөөллийн индексийн ашигладаг өгөгдлийн эх сурвалж нь ихэвчлэн олон улсын бизнес эрхлэгч зэрэг авлигатай тулгардаг хэсэг хүмүүсийн сэтгэгдэлд тулгуурладаг, Авлигын төсөөллийн индекс нь төсөөллийг баримжаалдаг учир хэв шинжит үзэл бодлын нөлөөгөөр бодит байдалд нийцэхгүй байж болзошгүй гэсэн хязгаарлалтууд багтана. Тиймээс Авлигын төсөөллийн индекс нь авлигын давтамж бус авлигын талаарх төсөөллийг хэмждэг. Ийм арга нь улс орныг буруугаар үнэлэхэд хүргэж болно. Швейцар нь авлигын асуудал багатай улс гэж харагддаг бөгөөд тэнд амьдарч буй хүмүүсийн хувьд ч үүнд эргэлздэггүй боловч тус улс нь зохион байгуулалттай гэмт хэрэг, авлигажсан улс төрийн байгуулалттай холбоо бүхий татвараас зугтах ажиллагаа болон хууль бус сангийн агуулах болдог гэдгээрээ (*Shaxson 2007*) алдартай.

Авлигын талаарх төсөөлөл гэхээр хүмүүс голчлон хахуулийн талаарх төсөөлөл гэж боддог бөгөөд ингэснээр авлигын олон янз хэлбэр болон авлигын үр нөлөөг харуулж чаддаггүй. Мөн хахууль өгөгчдөөс илүү авагчдад анхаарал

хандуулдаг нь цаагуураа хахуулийг гэрээ байгуулахад идэвхтэйгээр ашигладаг зүйл (*Heywood 2015*) гэхээс илүү хахууль өгөхийг шаардсан нөхцөлд л өгдөг зүйл хэмээн харж байна гэсэн үг. Гэхдээ Авлигын төсөөллийн индекст эдгээр хязгаарлагдмал тал байдаг ч гэсэн өндөр нэр хүндтэй, нөлөөтэй (*Johnston 2005*) байдаг.

Авлигын төсөөллийн индексээс өөр нэг сонголт нь Дэлхийн засаглалын индикатор юм. Энэ нь зөвхөн авлигын шалгуур үзүүлэлт биш өргөн хүрээтэй шалгуур үзүүлэлтийг хэмжихийн зэрэгцээ авлигын хяналтыг ч (*Kaufmann et al. 2006*) хэмждэг. Дэлхийн банк Авлигын төсөөллийн индексийн суурь аргыг авч түүнийг сайжруулахыг оролдсон (*Kaufmann et al. 1999*) байна. Жишээлбэл, нэгдсэн өгөгдлийг авч, үйлдвэржсэн болон хөгжиж буй орнуудын аль алин дахь олон тооны аж ахуйн нэгж, иргэд, мэргэжилтнүүдээс санал асуулга явуулж, түүнийг эх сурвалжаа болгодог. Нэгдмэл шалгуур үзүүлэлтийн ард буй хувь өгөгдлийн санг олон янзын судалгааны институт, тинк танк, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас авдаг. Дэлхийн засаглалын индикатор нь бас төрийн эрх мэдлийг төрөл бүрийн авлига гэх мэт хувьдаа ашиг олохын төлөө хэрэгжүүлж буй явдал, түүнчлэн төр хувийн ашиг сонирхолд автагдсан (*бусад улсад бус элитүүд ба хувийн ашиг сонирхолд автагдах*) (*Brooks et al. 2013*) байдлыг хэмжих хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг оруулжээ. Гэвч нэгдсэн Дэлхийн засаглалын индикаторын хэмжээс нь ‘дэлхий нийтийн дундаж хандлагын талаарх мэдээллийг (*Kaufmann et al. 2009:22*) агуулдаггүй’.

Бизнесийн орчин, компанийн гүйцэтгэлийн судалгаа нь Зүүн Европ, Төв Азийн (*ихэвчлэн шилжилтийн эдийн засаг гэж нэрлэгддэг*) 20 улсын хувийн секторын хандлагыг хэмждэг. Энэ судалгаа нь авлига бол хөрөнгө оруулалтын хүлээгдэх, хүсүүштэй үр өгөөжид саад учруулдаг зүйл гэсэн ойлголтоос (*Brunetti et al. 1997*) үүдэлтэй. Гэхдээ уг судалгааны түүврийн

хэмжээ (*ОХУ-ын 19 бүс нутагт 986 компани*), судалгаанд хариу ирүүлсэн хувь бага байсан тул Киселев (*Kiselev 2012*) төлөөлөл болж чадахгүй байж болзошгүй хэмээн шүүмжилж байжээ.

Эдгээр судалгааны асуудал нь авлигын талаарх өөрийн гэсэн ойлголтод үндэслэсэн байж болох бөгөөд зарим тохиолдолд төрийн албан хаагчид хахууль авах, эсхүл төрийн хөрөнгийг шамшигдуулах зэрэг авлигын өөр өөр талд анхаарал хандуулж, түүнийхээ цар хүрээг хэмжихийг зорьсон байдаг явдал (*Lambsdorff 2005*) юм. Эдгээр судалгаа нь мөн авлигыг багаас их хэмжээс рүү (*эсхүл өөр ямар нэг хэлбэрээр*) жагсаадаг мэргэжилтнүүдийн бүлэгт үндэслэдэг. Эдгээр ‘мэргэжилтнүүд’ нь энэ хэмжээс дээрх авлигын байршлын талаар ижил үнэлгээтэй эсэхийг мэдэх боломжгүй.

Мөн тухайн улс дахь гадаадын бизнес эрхлэгчид, мэргэжилтнүүд ардчилсан хариуцлага, засаг захиргааны чанар, улс төрийн манлайлагчдын үнэнч байдал, Засгийн газрын тогтвортой байдал, хахууль өгөхөөс аргагүй болох магадлал, улс орон дахь хууль, журамт байдал зэргийн талаарх мэдлэгт үндэслэн авлигыг шууд эсхүл шууд бусаар хэмждэг Улс төрийн эрсдэлийн үйлчилгээ (*Political Risk Services*) байгууллагаас жил бүр гаргадаг Олон улсын эрсдэлийн зааварчилгаа (*ICRG*) гэх мэт хувийн хэвшлийн судалгаа ч байдаг. Одоо эдийн засагчдын мэдээллийн нэгж (*Economist Intelligence Unit*) байгууллагын удирдаж буй Олон улсын бизнес (*BI*) байгууллага нь ихэвчлэн мэргэжилтнүүд, шинжээчдийн сүлжээнд суурилж, улс орнуудын эрсдэлийн хүчин зүйлийн индексийг гаргаж байна. Олон улсын бизнес байгууллага нь улс төрийн өөрчлөлт, нийгмийн тогтвортой байдал, хуулийн болон шүүхийн тогтолцоо, хүнд суртал/улаан тууз¹¹ болон авлига зэрэг хэд

11 Шийдвэр гаргалт, уян хатан үйл ажиллагаанд саад болсон хэт олон, хатуу, илүүдэл дүрэм журам, стандарт, албан журмыг зааж red tape буюу ‘улаан тууз’ гэж нэрлэдэг. (Орч.)

хэдэн хүчин зүйлээр тус тусад нь индекс тооцдог. Түүнчлэн Дэлхийн банкнаас гаргадаг Дэлхийн бизнесийн орчны судалгаа нь авлигын хүчин зүйлийг бизнесийн борлуулалтыг хөрөнгө оруулалттай холбож авч үздэг бол Өв уламжлал сангаас (*Heritage Foundation, төрийн нийгмийн баталгааны хөтөлбөрт шүүмжлэлтэй ханддаг АНУ-ын консерватив улс төрийн байгууллага*) жил бүр гаргадаг Эдийн засгийн эрх чөлөөний индекс¹²(*Index of Economic Freedom*), Воол Стрийт сэтгүүл нь эдийн засаг дахь төрийн оролцоонд анхаардаг. Мөн Эрх чөлөөний хаусын (*Freedom House*) гаргадаг Шилжилтийн улс орнууд (*Nations in Transition*) нэртэй судалгааны эмхтгэл нь Зүүн Европ болон Төв Азийн хуучин социалист системтэй байсан орнуудын ардчилал ба хуулийн засаглалын талаар бичдэг. Харин PricewaterhouseCoopers-ийн¹³ Ил тод байдал ба тогтвортой байдлын судалгааны сангаас гаргадаг Хаалттай байдлын индекс (*Opacity Index*) нь ‘гадаад улсад’ өндөр албан тушаал хашиж буй бизнесийн удирдагчдын судалгаанд ихээр төвлөрсөн (*Brooks et al. 2013*) байдаг.

Гэхдээ эдгээр олонх индекс ба авлига хоорондын хамаарал нь тодорхой бус байдгийг дурдах нь зүйтэй. Кнак (*Knack 2002*) засаглалын индикатор нь шинэчлэлийн арга хэмжээтэй хамаарал багатай боловч заримдаа авлигын хэмжүүр болох тал дээр авлигажсан практик ба засаглалын хэмжүүр хоёр нь бүдэг хамааралтай байдаг гэж үзжээ. Яагаад гэвэл тухайн улсын оноо бага байгаа нь авлигатай хамаатай бус эдийн засгийн болон

12 Эдийн засгийн эрх чөлөөний дөрвөн багана байдаг. Эдгээр нь: Хуулийн засаглал (өмчлөх эрх, авлигаас ангид байх эрх чөлөө), Засгийн газрын хэмжээ (төсвийн эрх чөлөө, Засгийн газрын зардал), Зохицуулалтын үр ашиг (бизнесийн эрх чөлөө, хөдөлмөрийн эрх чөлөө, мөнгөний эрх чөлөө), Зах зээлийн нээлттэй байдал (худалдааны эрх чөлөө, хөрөнгө оруулалтын эрх чөлөө, санхүүгийн эрх чөлөө) бөгөөд улс орны эдийн засгийн өсөлтийг үнэлдэг.

13 PWC гэдэг товчлолоор алдартай АНУ-ын аудитын компани. (Орч.)

төсвийн менежментийн үр дүнгүй бодлого зэрэг Засгийн газрын үр дүн сул байгаагаас шалтгаалж болно.

‘Сайн засаглал’-ыг (*энэ нь юу ч байлаа гэсэн*) эдийн засгийн хөгжлийн таамаглагч хүчин зүйл мөн гэж үзэхэд асуудал (*Mauro 2004*) үүснэ. Үнэндээ засаг захиргааны шударга байдал, үр ашгийг хэмжихийг зоригчид нь төрийн бодлогыг дэмжиж, эсхүл няцаах тал дээр гүн гүнзгий суусан үзэл бодолтой, өмнөх үеийн эдийн засгийн гүйцэтгэлийн нөлөөнд автсан байдаг учир дээрх логикт бие биеэ тойрсон логикийн асуудал үүснэ гэдгийг Куртз, Шранк нар (*Kurtz and Schrank 2007*) үзүүлжээ. Орчин үед ‘сайн засаглал’ ба өсөлт хоёрын хооронд хамаарал байгаа нь хүлээн зөвшөөрөгдсөн гэх үзэл маш өргөн тархсан байна. Куртз, Шранк (*2007*) нарынхаар бол энэ үзэл нь буруутгаж болох таамаглал гэхээс илүү бүрэн итгэж болох зүйл, эсхүл дүн шинжилгээний эхлэлийн цэг юм.

‘Сайн засаглал’-ыг ялангуяа нео-либерал үзэлтнүүд авлигыг шийдвэрлэх зорилгоор ардчилал, эдийн засгийн хөгжлийг бий болгох арга зам гэж сурталчилдаг. Гэвч энэ бол шийдвэрлэгдсэн зүйл биш зарим тохиолдолд илүү шүүмжлэлд өртдөг санаа юм. Африк дахь авлигыг судлаад Де Мариа (*De Maria 2008*) барууны эдийн засгийн ашиг сонирхлын тулд төрийн захиргааг сулруулахад Авлигын төсөөллийн индексийг ашиглаж болно гэж тэмдэглэжээ.

Нэр шошго зүүх онолын нэг хэлбэр болсон (*IX бүлгийг үз*) ‘хэмжилтээр дамжсан шинэ колончлол’ (*neo-colonialism through measurement*) гэдэг үзлээр бол авлигыг бодитоор туулсан туршлагагүйгээр ойлгох боломжгүй бөгөөд туршилтын судалгаагүйгээр судлах боломжгүй гэж (*De Maria 2008; Heywood 2015*) шүүмжилдэг.

Авлигын хэмжилтийн гол шүүмжлэл нь ‘сайн засаглал’ гэж юу вэ, түүнийг юу дагалдах ёстой гэдэг талаарх бизнесийн манлайлагчдын төсөөлөл зэрэг хувь шалгуур үзүүлэлтэд

уулаасаа өрөөсгөл хандлага (*bias*) байдаг гэх шүүмжлэл юм. Жишээлбэл, бизнес эрхлэгчдийн бүлэгт бол ‘сайн засаглал’ гэдэг нь шударга татвар болоод ‘зохих ёсны’ зохицуулалт гэхийн оронд бага татвар болон зохицуулалт бага байх гэсэн утгыг илэрхийлж болно. Түүний үр дүнд ядуу, эрх мэдэлгүй болсон хүмүүсийн туршлагыг тоолгүй орхиж, бизнес эрхлэгчдийн бүлэг дэх хүмүүс авлигыг ‘бизнес эрхлэх’ арга зам хэмээн тэвчин өнгөрүүлдэг болж болох юм. Судалгаанд оролцогчид болон тухайн судалгаагаар үнэлэх эрх мэдэлтнүүдийн хооронд улс төрийн үзэл санааны мөргөлдөөн байвал судалгаанд оролцогчдын төсөөлөл бүр ч илүү нөлөөнд автсан байх болно. Түүнтэй адилаар судалгаанд оролцогчидтой харилцаа сайтай хүмүүсийн зүгт эерэг төсөөлөл илүү үүсэж, улс төрийн чиг хандлага нь зөрчилддөг хүмүүсийн зүгт бол эерэг төсөөлөл бага байж болно. Тиймээс Хэйвүүд (*Heywood 2015:144*) ‘төсөөлөл, бодлого, үйл ажиллагаа уулзах цэгт дээр сайн засаглал нь чөлөөт худалдааг зөөлрүүлж хэлэх хэллэг, мөн практикт ховорхон тохиолддог иргэний нийгмийн төгс чиг үүрэг, төрийн захиргаа болон улс төрийн нөлөөллийг тодорхой зааглах зүйл болж болно’ гэдэг санааг дэвшүүлжээ. Гэхдээ төсөөлөл нь авлигын цаад далд шалтгааныг даамжруулснаар бизнесийнхэн төрийн бодлогыг тойрох, эсэргүүцэх, өөрчлөхийн тулд хууль ёсны болон хууль бус бүхий л зүйлийг хийж болох юм. Энэ агуулгаар бол хөгжил нь авлигын занга руу чиглэх буюу хөгжлийн тусламж олгоход тухайн тусламжгүйгээр хүрэх боломжгүй цогц шинэчлэлийг хэрэгжүүлсэн байх нөхцөл тавигдах гэсэн логик зөрчил (*Anderson and Heywood 2009*) үүснэ.

Зах зээлд үл оролцох хэлбэрийн төр, хязгаарлагдмал хөнгөн хэлбэрийн зохицуулалтыг дэмждэг бизнесийн манлайлагчдын үзлийг эдийн засгийн эрүүл сэтгэлгээ хэмээн танилцуулж, төсөөллийн индексийг улс төржүүлэх явдал гарч байна. Түүнчлэн байгууллагын удирдлага нь ялангуяа зах зээлд нэвтрэх, эсхүл зах зээлээ тэлэхийг оролдож байх үедээ ‘юуг улс

төрийн хувьд эмзэг асуудал гэж үзэж байна вэ' гэсэн асуултад хариулт өгөхдөө дурамжхан байж болно. Энэ дурамжхан байдал нь нийгмийн, улс төрийн, эдийн засгийн шалтгаантай байж болно. Женсен нарын (*Jensen et al.2010*) олж тогтоосноор хэвлэл мэдээллийн болон улс төрийн эрх чөлөө хязгаарлагдмал улс оронд судалгаанд хариулахгүй байх болон буруу хариулах үзэгдэл гардаг ажээ. Ерөнхийлөн асуух нь тухайн байгууллагын авлигын туршлагын талаарх мэдээллийг гаргаж ирэхгүй байж болох бөгөөд тодорхой асуулт нь хуулийн болон улс төрийн үр дагаврыг багасгах үүднээс буруу мэдээлэлд хүргэж болзошгүй.

Засаглал, өсөлт хоёрын хоорондын холбоо нь цаадах учир шалтгааны тусгал гэхээс илүү хэмжилтийн бүтээгдэхүүн юм. Гэхдээ эдгээр шүүмжлэл нь төсөөллийг объектив судалгаатай холбох замаар авлигын хэмжилтийг урагш (*Уганда улсын жишээн дээр Svensonn 2003; Индонезийн жишээн дээр Olken 2007; Бразилын жишээн дээр Ferraz ба Fiinan 2008-г үз*) ахиулжээ. Гэвч талбар дээрх (*field*)¹⁴ эдгээр аргачлал нь төсөөллийн индексийн хязгаарлагдмал талыг даван гарахгүй. Харин жижиг хэмжээтэй авлигын хэмжүүрийн онолын талын ажлыг нарийн туршилтын судалгаагаар сольсноор, магадгүй илүү нөхцөл байдалд тохирсон авлигын асуудлыг орон нутгийн байдлаар шийдвэрлэхэд хүргэж болох (*Heywood 2015*) юм.

Судалгаа шинжилгээнийхэн ч гэсэн асуудлын нэг хэсэг болж байдаг. Судлаачид авлигын статистикийг өргөнөөр хэрэглэдэг ч НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс (*UNDP 2008:45*) судлаачдыг 'статистик нь чанараас илүү чухал' байгаа бөгөөд тэд өөрсдөө асуулга авалгүйгээр, гараад ирсэн асуулгын дүнг ямар ч асуултгүйгээр хэрэглэдэг хэмээн шүүмжилсэн. Үрра (*Urра 2007*) нэгдсэн өгөгдлийн гурван асуудлыг тодорхойлжээ. Эдгээр нь төсөөллийн ба алдааны, хэрэглээний асуудал болно. Үррагийн хувьд төсөөллийн асуудал гэдэг нь мундаг тоотой

14 Талбар гэдэгт анхдагч судалгааг хэлж байна (хүмүүстэй ярилцлага хийх г.м)

харагдах хуурмаг дүр төрхийг гаргаж чадах нарийн төвөгтэй статистикийн бүтцийг бий болгохын тулд субъектив шалгуур үзүүлэлтийг хэрэглэх үед үүссэн алдааны зааг (*margins of error*) юм. Алдааны асуудал гэдэг нь авлигын талаарх өгөгдлийн янз бүрийн сурвалжид агуулагдаж ирсэн дотоод алдааны зааг бөгөөд тухайн ухагдахуунд өөрт нь хамаарах алдаа юм. Гэхдээ авлигын судалгаанд ч түүврийн алдаа (*аль ч нийгмийн шинжлэх ухааны адил*) байдаг. Мөн авлигыг орлуулах ямар ч зүйл төгс бус байдаг. Хэрэглээний асуудал гэдэг нь авлигын ерөнхий хэмжүүрийг авлигатай тэмцэхэд бодитоор хэрэглэхэд боломжгүй биш юм аа гэхэд хүндрэлтэй байдаг явдал буюу хэмжилт ба шийдэл хоёрын хоорондын зөрүү юм. Гэвч энэ шүүмжлэл нь бид авлигыг хэмжих бүх оролдлогоосоо татгалзах хэрэгтэй гэсэн үг биш юм. Гэмт хэргийн статистикийн талаар мэдлэгтэй хүмүүс мэдэж байгаачлан (*Coleman and Moynihan 1996*), бүхий л төрлийн гэмт хэрэгт байдагтай адилаар авлигын хэмжүүр нь төгс бус юм. Авлигын үйлдэл, гэмт хэрэг нь нууц байдаг нь түүнийг үнэлэхэд нэмэлт хүндрэлийг бий (*Levi and Burrows 2008; Button et al. 2011*) болгодог.

Авлигын төсөөллийн индекс, Дэлхийн засаглалын индикаторын аль аль нь олон янзын эх сурвалжийн мэдээллийг нэгтгэдэг нэгдмэл шалгуур үзүүлэлтийг ашигладаг. Тэдгээр нь хэд хэдэн ижил эх сурвалж дээр тулгуурладаг. Гэвч Дэлхийн засаглалын индикатор нь зургаан нэгдмэл шалгуур үзүүлэлтээс (*засаглалын хэмжээс гэж нэрлэгддэг: иргэдийн дуу хоолой ба хариуцлага, улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийлэлгүй байдал, Засгийн газрын үр дүнтэй байдал, зохицуулалтын чанар, хуулийн засаглал, авлигын хяналт*) бүрддэг бол Авлигын төсөөллийн индекс нь авлигыг зөвхөн хэд хэдэн байгууллагын статистикаар хэмждэг. Дэлхийн засаглалын индикаторын хяналтын шалгуур үзүүлэлт нь эдгээр ижил статистикийг ашиглаад зогсохгүй төр ба хувийн хэвшлийн (*зарим эх сурвалж нь гэр бүлийн түвшний авлигын талаарх*

мэдээлэл өгдөг) авлигыг хэмжих 14 өөр төрлийн статистик ашигладаг. Авлигын төсөөллийн индекс нь мэргэжилтнүүдийн төсөөлөлд үндэслэн зөвхөн төрийн албан дахь авлигыг (*Rohwer 2009*) хэмждэг.

Дэлхийн засаглалын индикатор нь ихэнхдээ төсөөллийн судалгаа (*хэдийгээр Авлигын төсөөллийн индексээс өргөн хүрээтэй үзэл бодол, итгэл үнэмшлийг агуулдаг ч*) учир дээр дурдсантай ижил төрлийн асуудалтай байдаг. Статистикийг нягтлах, тайлбарлахад анхааралтай байх хэрэгтэй хэдий ч тэдгээр нь авлигын талаарх одоо байгаа хамгийн сайн төсөөллийн судалгаа юм. Авлигын үйлдлийн төрөл, эсхүл байршил, гэмт этгээд, эсхүл хохирогчийн талаарх шаардлагатай мэдээллийг аль ч индекс нь өгдөггүй. Гарахаасаа өмнө нэгтгэгддэг хэд хэдэн эх сурвалж дээр тулгуурлагддаг нь тэдгээр статистикийн гол түлхүүр асуудал нь байдаг. Энэ нь авлигын эсрэг үр дүнтэй стратегийг загварчлах, хэрэгжүүлэх, үнэлэхэд хүндрэл учруулснаар авлигын халуун цэгийг тодорхойлж, эсхүл авлигыг мэргэжлээр, хүн ам зүйн талаар, нийгэм, эдийн засгаар бүлэглэн авч үзсэн стратеги гаргаж чадахгүйд (*Brooks et al. 2013*) хүрдэг.

Авлигын төсөөллийн индекс (АТИ), Дэлхийн засаглалын индикатор (ДЗИ) нь өргөн хүрээтэй эх сурвалжаас ирэх их хэмжээний мэдээллийг хэрэгцээт байдлаар шүүж чаддаг ч энэ аргачлалд угаас байх сул тал нь хэмжилтийн алдаа юм. Авлигын ялгаатай хэлбэрүүд ба тодорхойлолтын ялгааг орхигдуулсан байх аюул бий. Ямар мэдээлэл өгөгдөж, юуг харьцуулж байгаа нь бүдэг бадаг байж магадгүй учраас улс хоорондын харьцуулалтад асуудал (*Thompson and Shah 2005*) үүсгэнэ.

Түүнчлэн Кнак (*Knack 2006*) ДЗИ, АТИ-ийн аль алиных нь өгөгдлийн эх сурвалжийг олон нийт бүрэн авах боломжгүй тул асуудлыг баталгаажуулах боломжгүй гэсэн асуудлыг тавьсан байдаг. Энэ нь авлигын талаарх эх өгөгдлийг олж авахад хүндрэлтэй болгож, оронд нь биднийг төсөөллийн асуулгад

найдахад хүргэдэг. Гэхдээ төсөөллийн асуулга нь ялангуяа анхааралтай загварчилж, боловсруулсан үед нөхцөл байдлын талаарх үзэл бодлыг тусгаж чадах ч объектив байдал султай, төсөөллийн өгөгдөл хэвээр үлддэг бөгөөд ийм асуулгын үр дүн нь бодит амьдралтай нийцэхгүй байж (*Maurseth 2008*) болно.

Өмнө нь тэмдэглэснээр авлигын талаарх асуулгууд нь бүхэлдээ, эсхүл ихэнхдээ найдваргүй байдлыг агуулсан төсөөллийн асуулгад үндэслэж байна. Хэр найдваргүй вэ гэдгийг зөвхөн таамаглах л боломжтой. Дончев, Үжелюи (*Donchev and Ujhelyi 2011*) нар үзэхдээ АТИ, Бизнесийн орчин, компанийн гүйцэтгэлийн судалгаа, Олон улсын эрсдэлийн зааварчилгаа, ДЗИ зэрэг төсөөллийн индекс нь бодож байгаагаас ч нарийвчлал багатай гэсэн байдаг. Тэд бодитой авлигын туршлагын статистик ба мэдээлэгдсэн авлигын төсөөллийн талаарх статистик хоорондын хамаарлыг тооцсон. Тэд төсөөллийн асуулгаас авлигыг бууруулахын тулд зөвлөмж болгодог эдийн засгийн өсөлт, ардчилсан институцүүд, соёлын болон шашны тодорхой уламжлал зэрэг хүчин зүйлс ба авлигын бодит туршлага хооронд ямар ч хамаарал олоогүй. Тиймээс эдгээр хүчин зүйлс байхгүй байх нь авлигын төсөөллийг сөргөөр гажуудуулдаг гэж Дончев, Үжелюи нар үзсэн байна. Энэ үүднээс өөр төрлийн хэмжих арга гарч ирэхийг дэмжих хэрэгтэй. Эдгээр нь асуулгын өгөгдөлд суурилсан хэвээр байгаа жижиг хэмжээст судалгааны (*Hunt 2007; Svensson 2003*) хэлбэрээр хийгдэж байна. Харин Банерjee нар (*Banerjee et al. 2004*) ба Атанассова нар (*Atanassova et al. 2009*) хямд, эсхүл үнэгүй байх ёстой бараа, үйлчилгээний төлбөрийг бодитоор төлсөн дүнтэй харьцуулах судалгааны шинэ парадигм гаргажээ. Эдгээр судалгаанд өөрөө мэдүүлэх (*self reporting*) өгөгдөл нь найдвартай байдал болон нарийвчлалын тал дээр асуудалтай байдаг нь сайтар судлагдчихаад байна. Арга зүй нь ойлгож болохуйц шалтгааны улмаас авлигын тийм ч ноцтой бус хэрэгт

анхаарах хандлагатай болгодог гэсэн хязгаарлагдмал тал оршиж байдаг.

АТИ, ДЗИ нь бизнесийн хүрээнийхний ашиг сонирхол ба үзэл бодлыг илэрхийлдэг гэсэн асуудлыг даван туулахын тулд “Транспэрэнси интернэшнл” байгууллага 2003 онд өөр нэг индекс буюу Дэлхийн авлигын хэмжүүрийг (*Global Corruption Barometer*) бий болгосон. Дэлхийн авлигын хэмжүүр нь жил бүр дор хаяж 100 улс дахь 1000 гаруй хүнээс асуулга авч ‘ердийн’ хүмүүсийн авлигын талаарх туршлага, үзэл бодлыг судалдаг. Түүнээс гадна одоо хэрэглэгдэхээ больсон Дэлхийн шударга байдлын индекстэй (*Global Integrity Index*) төстэйгөөр ихэнх тохиолдолд орхигддог авлигыг хүлцэх асуудлыг тусгадаг. Мөн асуулгад оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтүүдийг тодорхойлж, нас, хүйс, орлого, байршил зэрэг олон янзын үзүүлэлтээр ангилдаг байна. Энэхүү дэлгэрэнгүй өгөгдөл нь авлигатай тэмцэх стратегиар зохих асуудалд чиглэсэн хариу үйлдэл үзүүлэх боломжийг олгоно. Дэлхийн авлигын хэмжүүр нь авлигыг байгууллагаар тодорхойлдог учраас ингэх боломжтой. Гэсэн хэдий ч Дэлхийн авлигын хэмжүүр нь жижиг авлигыг харуулах магадлал илүүтэй. Гэхдээ Малайз, Вьетнам зэрэг зарим улс уг индексийг дэмжиж байгаагаа “Транспэрэнси интернэшнл”-д мэдэгдсэн. Дэлхийн авлигын хэмжүүр нь “Транспэрэнси интернэшнл” хүртэл зөвшөөрч буйгаар дангаар хэрэглэгдэх, ялангуяа авлигыг эрт илрүүлэх зүйл гэхээс илүү бусад асуулгатай хамтад нь хэрэглэх нь зүйтэй зүйл юм. Өөрөө мэдүүлдэг өгөгдлийн найдвартай байдлын асуудал нь Дэлхийн авлигын хэмжүүрт угаас байх боловч уг асуудлыг түүврийн хэмжээгээр сайтар зохицуулж (*Brooks et al. 2013*) болно. Энд авч үзсэн авлигын бүх индекст тэдгээр нь яг юу гэсэн үг вэ, жагсаасан байр нь тухайн улсын авлигын түвшин, төрлийн талаар тодорхой мэдээлэл өгч чадах уу гэсэн асуултад хариулж чаддаггүй, энэ тал дээр тодорхой бус байдаг. Тодорхой хэлбэл, АТИ, ДЗИ-д агуулагдах мэдээлэл нь тухайн улсыг өөр нэг улсаас

илүү, эсхүл бага авлигажсан гэх утгыг гаргаагүй, энэ асуултын хариу тодорхой хардаггүй. Өмнө нь тэмдэглэснээр авлигын түвшин өндөртэй гэх улсад шударга бус байдал илэрхий өргөн тархсан байж болно. “Транспэрэнси интернэшнл” болон Дэлхийн банкны өгөгдлийн сан нь авлигын эх сурвалж, авлигын хэрэгт авсан арга хэмжээний төрлийн талаарх мэдээллийг агуулдаггүй учраас авлига өндөр буй гэсэн үзүүлэлтийн ард авлигатай тэмцэх хүсэл зориг илүү их байж болох юм.

Тухайлбал, 2011 онд Дэлхийн шударга байдал байгууллага (*Global Integrity*) өөрийн цахим хуудаснаас Дэлхийн шударга байдлын индексийг арилгахдаа дор дурдсан мэдэгдлийг хийж байсан юм:

‘... энэ төрлийн ажлыг олон жил хийж ирсэн ч ... индекс нь ховор тохиолдолд өөрчлөлт авчирдаг. Индекс гаргах нь гаргаж буй байгууллагадаа аймшигтай байдаг. Учир нь мэдээллийн хэрэгслээр гардаг, эхний нүүрэнд гардаг, маргаан үүсгэдэг ... Маш үр дүнтэй олон нийтийн харилцааны арга хэрэгслүүд байна. Гэвч нэг улсыг нөгөөтэй нь харьцуулж оноосон нэг л тоо ... бидний туршлагаас харахад тухайлан үр дүнтэй бодлого байж чадаагүй ... Улс орнуудыг эрэмбэлэх нь ... бодит хэлэлцүүлэгт мэдээлэл өгч, бодлогын өөрчлөлт авчрахад хэтэрхий болхи (*Heywood 2015:148*) хэрэг’

Түүнээс гадна 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралаас хойш эдийн засаг сайн байх үетэй харьцуулахад улстөрчдийн авлигажсан үйлдлийг үл тэвчих олон нийтийн хандлага ихэссэн гэж үзэх боломж бий. Жишээлбэл, 2010-2011 онд Англид ардчилсан байдлаар сонгогдсон парламентын гишүүд тодорхойгүй, зарим тохиолдолд хууль бус зардлын нэхэмжлэл гаргажээ. Энэ асуудал нь олон жил үргэлжилж ирсний улмаас зарим хүний хувьд бүр институцчилэгдсэн зүйл болон хувирсан нь хожим илэрхий болсон юм. Төрийн мөнгийг буруугаар ашиглах үйлдлийг үл тоох хандлага бараг 60 жилийн дараа,

ноцтой хямралын үеэр ил болсноор олон нийтийн дургүйцлийг (*Worthy and McClean 2015*) хүргэжээ.

АТИ-ийн өөр нэг асуудал нь улс орны авлигын үнэлгээ сайжирсан, эсхүл муудсан болон аливаа шинэчлэл үр дүнтэй байсан эсэх талаар буруу мэдээлэл өгч болох явдалд оршдог. “Транспэрэнси интернэшнл” нь аль нэг улс үнэлгээнд оролцохгүй байх (*мэдээлэл дутуугийн улмаас*) асуудалд ямар ч хяналт байхгүй. Мөн өмнөх жилийн үнэлгээнд ороогүй, эсвэл бүр ерөөсөө үнэлгээ хийлгэж байгаагүй улс шинээр орж ирвэл мөн төстэй асуудал үүснэ. Эдгээр тохиолдол нь өөр нэг улс өндрөөр эрэмбэлэгдэн, нөхцөл байдал сайжирсан гэсэн сэтгэгдлийг төрүүлэх ч үнэндээ бол нөхцөл байдал сайжирсан ямар ч дэвшил гараагүй байх болно. Эрэмбэ нь харьцангуйгаар, тэднээс илүү авлигажсан өөр улс байгаатай холбоотой тогтоно. Мөн АТИ-ийн жил бүрийн тайлан нь бага үнэлгээгээ сайжруулахаар хичээж буй улсад саад болж (*Galtung 2006*) болно. АТИ-ийн жил бүрийн тайлан нь тухайн улсын талаарх сөрөг төсөөллийг багжуулснаар, бага үнэлгээтэй улс орнуудыг бараг дээш ахих боломжгүй болгож болно. Авлигыг бууруулах хэдэн ч санаачилга хэрэгжүүлсэн байсан зарим үед бодит үр дүн гарахад хэдэн жил зарцуулагдаж магадгүй. Тиймээс АТИ-ийг дөрөв юм уу таван жилээр тайлагнаж байхыг Галтунг (*Galtung 2006*) зөвлөсөн байна. Нэг жилээс урт хугацааны гүйцэтгэлийн дунджийг авах нь улс орнуудад нэг удаагийн авлигын дуулиант хэргийн улмаас авлигажсан хэмээн үнэлэгдэж, доогуур эрэмбэлэгдэхээс зайлсхийх боломж олгоно.

Эдийн засагчдын мэдээллийн нэгж (*EIU*), “Транспэрэнси интернэшнл”, Дэлхийн банкны хийж буй асуулгын арга зүй, цар хүрээг харахад тэд дэлгэрэнгүй онолын аргачлал боловсруулахад хүрэлцээтэй нарийвчлалгүй байгаа нь харагддаг. Гэсэн хэдий ч ялангуяа “Транспэрэнси интернэшнл” болон ДЗИ-ийн ашигладаг өгөгдөл бүрэн цогцоороо улс орны талаар болон улс хоорондын харьцуулалтын талаар санаа

өгдөг учир тэдгээрийг дээр дурдсан асуудлуудтай байдаг гээд тоолгүй орхиж болохгүй. Үүнийг жижиг хэмжээст дотоодын судалгаатай хамтад нь ашиглаад, авлигын амьдрал дээрх бодит байдал, түвшнийг ойлгоход ач холбогдолтой агуулга бүхий дүр зураг бий болгож (*Heywood 2015*) байна.

Авлигын цар хүрээг баримжаалах зорилгоор Чаудхури нар (*Chaudhury et al. 2006*), Банерже нар (*Banerjee et al. 2007*), Олкен, Баррон нар (*Olken and Barron 2007*), Дубло нар (*Dufl o et al. 2008*) төрийн албан дахь авлигын түвшинг хэмжихийн тулд жижиг хэмжээст ажиглалтын аргыг хэрэглэсэн байна. Эдгээр судалгаанууд бүгд зүй бус практикийг ил болгож байгаа ч тэдгээр үйлдэл нь захиргааны үр ашиггүй, ур чадваргүй байдал болон хөнгөрүүлэх нөхцөлтэй харьцуулахад яг авлигажсан зүйл мөн үү гэдгийг тогтоож чадаагүй. Энэ асуудлыг даван туулахын тулд Рейникка, Свенссон (*Reinikka and Svensson 2005*) болон Олкены (*2007*) судалгаагаар төв Засгийн газрын санхүүжилтийн мэдээллийг төлөвлөсөн хүмүүс нь бодитоор хүлээн авсан санхүүжилтийн хэмжээ, эсхүл санхүүжилтийн төсөл дээр зарцуулах ёстой байсан дүнтэй харьцуулсан. Хоёр тооны хоорондын ямарваа нэг зөрүү нь хэр хэмжээгээр идэж ашигласан бэ, хэр хэмжээтэй авлигажсан бэ гэдгийн баримжааг гаргаж өгнө гэж тэд үзжээ. Гэхдээ эдгээр судалгаа нь бодитоор авлига байсан гэдгийг харуулж чадах эсэх нь нэлээд эргэлзээтэй. Үнэндээ бол албан хаагчид төсвийг шаардлагатай бусад газар руу нь хуваарилсан, хулгайлалгүйгээр олон нийтийн тусын тулд ашигласан байж болно.

Тусламжийг хуваарилах ажлын ач холбогдол нэмэгдсээр байгаа ч залилан, авлига болон муу засаглалын учруулах алдагдлыг хэмждэг Төрийн зардлыг мөрдөх судалгаа (*Public Expenditure Tracking Survey – PETS*) нь үргүй зардал, залилан, авлигыг үнэлэхэд хэрэглэгддэг. Уг судалгаа нь анхны хуваарилсан төсөв нь засаг захиргааны шат дамжлагыг дамжин явж, эцсийн хүлээн авагчид очих хүртлээ хэр зэрэг өөрчлөгдсөнийг

Авлигын криминологи

үнэлэхийг зорьдог. 1996 онд Төрийн зардлыг мөрдөх анхны том судалгаагаар Уганда улсын Боловсролын яамны төсвийг үнэлжээ. Зардал дорвитой өссөн ч бага сургуулийн элсэлт хангалттай өсөөгүй байв. Энэхүү Төрийн зардлыг мөрдөх судалгаагаар 1991-1995 онд жилийн **(оюутны)** тогтмол зардлын зөвхөн 13 хувь нь сургуулиудад очиж, 87 хувь нь алга болох буюу хамааралгүй зорилгод зарцуулагдсаныг илрүүлсэн **(Reinikka and Svensson 2004)** байна. Үүний нөлөөгөөр Төрийн зардлыг мөрдөх судалгааг бусад орнуудад хийхэд мөн их хэмжээний алдагдал ил **(Button et al. 2015)** болжээ.

Төрийн зардлыг мөрдөх судалгааны өөр хувилбар нь Тэргүүн эгнээнд ажиллагсдын судалгаа буюу Үйлчилгээ хүргэгчдийн тоон судалгаа **(Quantitative Service Delivery Survey—QSDS)** юм. Энэ судалгаагаар хуваарилсан төсвийн дагуу хийгдэх ёстой үйлчилгээг бодитоор үзүүлсэн үйлчилгээтэй хамтад нь үнэлдэг байна. Үйлчилгээ хүргэлтийг үнэлэхийн тулд тодорхой байршлуудыг статистикийн үндэслэлтэйгээр сонгоод урьдчилж мэдэгдэлгүйгээр очно. Үйлчилгээ хүргэгчдийн тоон судалгааг Бангладеш улсад хийхэд эрүүл мэндийн ажилтнууд, эмч нар тус бүр харгалзан 35-40 хувь дутагдалтай байгааг олж **(Reinekka and Svensson 2006; Reinekka and Smith 2004)** тогтоожээ. Төрийн зардлыг мөрдөх судалгаа нь залилан, авлига, алдаа, хүнд суртал, үр ашиггүй байдал зэрэг төсөв дэх үргүй зардлыг ил болгодог. Эдгээр судалгаа нь зардал их шаарддаг, залилан ба алдаанаас **(error)** илүү өргөн хүрээтэй мөнгөний урсгалыг ил болгоно. Судалгааны зардал нь 50–100 мянган ам.доллар байдаг **(Koziol and Tolmie 2010; Reinekka and Smith 2004; Button et al. 2015)** байна.

Хууль бус шинж чанартай учраас энэ бүх аргачлалаар авлигыг хэмжих явцад сорилтууд тулгарч, тогтоох боломжгүй олон асуудлыг үүсдэг. Жишээлбэл, хахууль гэсэн нэр томъёоны хувьд авлигажсан үйлдэлд хэн уруу татагдсаныг нарийн тогтоодог ч аливаа ажил хэрэгт хэр их оролцоотой

байсныг тоогоор илэрхийлэхэд хэцүү. Хэмжилтийн тогтолцоо нь авлигын цар хүрээг нарийвчлан тогтоох оролдлогыг саармагжуулах, хариулт үйлдэл гарахад түлхэж болзошгүй. Хяналтын тогтолцоо хэрэгжиж эхэлснээр авлигажсан үйлдлээ зогсоолгүй үргэлжлүүлэхээр шийдсэн хүмүүс шинэ тогтолцоог тойрох арга замыг боловсруулж, эсхүл өөр төрлийн авлигажсан үйлдэлд анхаарлаа хандуулан, өөрсдийн зан үйлдлээ өөрчлөн (*криминологийн нэр томъёогоор displacement буюу 'сэлгээ хийх'*) хууль бус үйлдлээ үргэлжлүүлдэг. Үүний үр дүнд авлигыг хянах, хэмжих эдгээр оролдлого нь авлигыг дутуу үнэлсэн хэвээр байх боломжийг олгох эрсдэлтэй.

Авлигын цар хүрээг тогтоох өөр арга нь хохирогчийн судалгаа юм. Эдгээр судалгааг Англи дахь гэмт хэргийн түвшинг хэмжихэд хэрэглэж байсан бол АНУ-д Үндэсний гэмт хэргийн хохирогчийн судалгааг хэрэглэж байжээ. Албаны статистик бол гэмт хэргийн түвшинг үнэн зөв тусгадаг зүйл гэж итгэх нь олон хүчин зүйлийн улмаас төөрөгдөл болох талтай гэсэн агуулгатай мэтгэлцээн криминологид сайн хийгдэж ирсэн (*Coleman and Moynihan 1996*) байна. Эдгээр судалгаанд дараах зүйлийг олонтаа тэмдэглэж иржээ. Тухайлбал, хохирогч гэмт хэргийн талаар цагдаад мэдэгдэх юм бол гэмт хэрэгтнүүд эргэж өшөө авна гэдэг бодлоор айж эмээх, цагдаа гэмт хэргийг үнэнээсээ авч хэлэлцэхгүй байх (*цахим залилангийн жишээн дээр*) гэх зэрэг олон шалтгааны улмаас гэмт хэргийн талаар мэдээлэхгүй байж болно. Гэхдээ албан ёсны статистикийг нөөцөд тавигдах шаардлага, эсхүл юуг илүү ноцтой зорилго, тэргүүлэх зүйл гэж үзэх вэ гэх мэтээр дээд түвшний цагдаагийн албан тушаалтнууд, эсхүл улс төрчдийн тэргүүлэх зүйлсийг тусгасан цагдаагийн үйл ажиллагааны арга хэмжээ гэж харах нь илүү зүйтэй. Гэхдээ хохирогчдын судалгаа нь илүү боловсронгуй болсоор гэмт хэргийн түвшинг тооцох илүү найдвартай эх сурвалжид тооцогдох болжээ. 1990-ээд оны дунд үеэс хойш Олон улсын гэмт хэргийн хохирогчийн Судалгаа (*ICVS*) нь авлигыг баримжаалах

суурь судалгаа болсон (*Brooks et al. 2013*) байна. НҮБ-ын Олон улсын гэмт хэргээс сэргийлэх Төвөөр (*Centre for International Crime Prevention*) манлайлуулсан уг судалгаа нь хохирлын ба гэмт үйлдлийн шинж чанар, ноцтой байдал, холбогдох авлигын талаар дэлгэрэнгүй мэдээллийг олж авахыг зорьдог. Олон улсын гэмт хэргийн хохирогчийн судалгаа нь өмнөх жилд гарсан гэмт хэргийн хохирогчийн туршлагаар дамжуулан авлигын түвшин, үр нөлөөний аль алинд анхаардаг. Цаг хугацааны хувьд ойрын үеийн хохирогчдын өгөгдлийг цуглуулах нь хандлагыг жил жилээр тодорхойлох боломж олгох бөгөөд авлигын хохирогч болсон саяхны туршлагын улмаас илүү дэлгэрэнгүй, илүү үнэн зөв мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлнэ. Энэ аргачлал нь мөн авлигын эсрэг хэрэгжүүлсэн стратегийн үр дүнг хэмжих боломжийг олгодог. Олон улсын гэмт хэргийн хохирогчийн судалгааны үр дүнг удалгүй Дэлхийн банк нэгдмэл статистиктаа нийлүүлэн ашиглажээ. Гэхдээ авлигын хохирогчийн судалгаа нь үнэндээ бүхий л төрлийн гэмт хэргийн судалгаа болон өгөгдлийг хөрвүүлэхэд учирдаг сорилтоос ангид байж чадахгүй.

Энэ хүртэл авлигыг ядаж зарим талаар үр өгөөжтэй зүйл гэж бус сөрөг үйлдэл гэдэг үүднээс нь авч үзлээ. Сөрөг үр дагаврыг хэмжихэд төвлөрөхөөс өөрөөр авлигад эерэг тал гэж бий юу. Одоо бид энэхүү маргаантай сэдэв рүү орох болно.

Бүх авлига муу юу: Үр ашиг муутай улс дахь авлигын үр нөлөөг хэмжих нь

Хэт их зохицуулалттай (*Huntington 1968; Leff 1989*), эсхүл нөөцийн хуваарилалт үр ашиг муутай улсад (*De Soto 1989; Mauro 1998*) хийх хөрөнгө оруулалтад авлига эерэг нөлөөтэй байж болно гэсэн санал гарч байв. Хэт их зохицуулалт, үр ашиггүй хуваарилалт гэсэн энэхүү хоёр шинж чанар нь (*Leff 1964; Leys 1965; Huntington 1968*) нарын баримталдаг ‘арааг тослох’ таамаглал ба (*Myrdal 1968; Kurer 1993; Mauro 1998*;

Rose-Ackerman 1997) нарын дэмждэг ‘арааг элсээр бөглөх’ таамаглалыг бүрдүүлдэг.

‘Арааг тослох нь’

Энэ аргачлал нь үр ашиггүй захиргаа нь эдийн засгийн үйл ажиллагаанд голчлон саад болдог бөгөөд ‘хурдасгах’, эсхүл гар ‘тослох’ мөнгө нь түүнийг тойроход чухал хэрэгцээтэй гэдгийг санал болгодог. Лүи (*Lui 1985*) энэ тухай зураглалыг албан ёсоор гаргаж, авлига нь дараалалд зогсох зардал, цаг хугацааг багасгах эсхүл захиргааны саадын зардлыг бууруулснаар эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлдэг гэдгийг харуулсан. Энэхүү үзэл нь засаглалын бусад тал нь согогтой улсад авлига нь үр дүнтэй гэдгийг санал болгодог боловч өөр газарт бол хохиролтой учир авлига бүхий л газар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлдэггүй гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Тийм учир, авлига нь эдийн засагт түлхэц болох боломжтой бөгөөд институцийн байгууламж нь үр дүнгүй улсуудад тийм түлхцийг хэмжиж болох ба хэмжих ч ёстой гэдэг. Гэхдээ ‘үр дүнгүй’ гэж юуг хэлж байна вэ гэдгийг харуулсан ойлголтууд нь тодорхойгүй бөгөөд авлигыг хэрхэн тодорхойлох талаар дээр авч үзсэн асуудлууд байсаар (*Brooks et al. 2013*) байна.

Авлига нь захиргааны үр ашиггүй байдлыг хэрхэн бууруулж чадах вэ гэдэг талаар хэд хэдэн ялгаатай үзэл байдаг. Лэйс (*Leys 1965*) хашин хойрго Засгийн газрын захиргааны ажилтнуудад хахууль өгч, шинэ компани байгуулах ажлыг эхлүүлбэл, авлига нь процессыг илүү хурдасгах түлхэц болж болохыг онцлон тэмдэглэжээ. Лүи (*1985*) дараа нь адил санааг баримтлан, албан ёсны загвар дотор авлига нь ‘үйлчилгээний’ төлөө дараалалд зогсох цагийг үр ашигтайгаар бууруулж чадахыг харуулсан. Түүнээс гадна Байлэй (*Bailey 1966*) авлига нь төрийн албан хаагчдын чанарыг нэмэгдүүлэх замаар захиргааг засах бололцоотой гэж бичжээ. Жишээлбэл, цалин бага боловч ажилтай нь холбоотой нэмэгдэл давуу тал байх юм

бол энэ боломж нь нэмэгдэл давуу тал байхгүй л бол өөр ажлыг сонгох гэж байсан чадварлаг ажилчдыг татах болно.

Түүгээр ч зогсохгүй Лефф (*Leff 1964*), Байлей (*1966*) нар авлига нь төрийн муу бодлогоос хамгаалах хэрэгсэл болж болно гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, ялангуяа засаг захиргааны ажилтан нь үзэл суртлын шалтгааны улмаас аж ахуйн үйл ажиллагаа бус төрийн албаны талыг барьсан өрөөсгөл (*bias*) бодолтой байх, эсхүл цөөнхийн бүлгийн эсрэг ялгаварласан үзэлтэй байх үед хамгаалалт болно гэж үзсэн (*Brooks et al. 2013*) байна.

Түүнчлэн Эрлич, Луи (*Ehrlich and Lui 1999*) нар засаг захиргаагаа төвлөрсөн байдлаар жолоодож, хувийн орлогоо ихэсгэх боломжтой дарангуйллын дэглэм ч бас авлигатай хамаарал бүхий зардлыг өөрийн нэг хэсэг болгодог хэмээн тайлбарласан байдаг. Ихэвчлэн сайн засаглалын үр дүн гэж харагддаг хувийн салбарын бүтээмж унавал авлигаас олох ашиг нь буурах учраас дарангуйллын тогтолцоо нь хувийн салбарын бүтээмжид гай болохоос зайлсхийх сонирхолтой байна. Гэхдээ хахууль бүтээмжид сөргөөр нөлөөлдөг гэж үздэг төрийн албан хаагчгүй төвлөрсөн бус дэглэмд тийм сонирхол байхгүй. Хэрэв тийм гэж үзвэл авлига нь сайн процедурыг хэрэгжүүлэх сонирхлыг ардчилсан дэглэмд бус дарангуйллын дэглэмд илүү төрүүлдэг гэж хэлж болно. Бүх нөхцөл нь ижил байвал авлига нь бага ардчилалтай улсад илүү ач тустай байна. Мөн Оолсон (*Olson 1993*) авлигажсан дарангуйлагч нь өсөлт ба хөгжлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх сонирхолтой байж болох юм гэсэн санааг дэвшүүлсэн байдаг. Энэ нь үнэндээ өмчийг өөрийн ашгийн төлөө булаах боловч өсөлт явагдаж байвал хэрэглэж буй хэмжүүрээс шалтгаалан үүнийг сайн засаглалд тооцогдож магадгүй. Түүнчлэн зарим тохиолдолд авлига нь хөрөнгө оруулалтын чанарыг сайжруулж болох юм гэж тайлбарладаг. Леффийн (*Leff 1964*) тэмдэглэлд хэрэв авлига нь татвараас зугтах хэрэгсэл болбол энэ нь төрийн татварын орлогыг бууруулна. Гэхдээ хангалттай хөрөнгө оруулах боломж байвал

хөрөнгө оруулалтын нийт үр ашгийг нэмэгдүүлнэ гэжээ. Гэвч даяарчлагдсан эдийн засагтай болсон үед хууль ёсны болон хууль бус мөнгөөр дотоодын эдийн засгаар тогтохгүй дэлхийн хаана ч хөрөнгө оруулж болно гэсэн байдаг. Үр ашгийн талаарх эдгээр үзэл санаа нь хахуулийг өргөтгөсөн (*Bailey 1966*) бөгөөд өрсөлдөөнт дуудлага худалдаатай төстэй зүйл гэж нэрлэсэн байна. Дараа нь Бек, Махер (*Beck and Maher 1986*), мөн Лиен (*Lien 1986*) авлига нь төрийн худалдан авалтын төлөөх өрсөлдөөнт дуудлага худалдааны үр дүнтэй ижил үр дүнг гаргаж ирнэ. Яагаад гэвэл авлигын эрэмбэ нь компаниудын үр ашгийн эрэмбийг харуулна гэж үзжээ.

Дээрх бүх үзэл бодолд бүгдэд нь хэрэв тухайн улсад тодорхой хэдэн нөхцөл бүрдсэн байвал авлига нь бүтээмжид эерэгээр нөлөөлөх боломжтой гэсэн адилхан урьдач нөхцөл тавигддаг. Яагаад гэвэл авлига нь үр ашиггүй засаг захиргаа, сул хуулийн засаглал, улс төрийн хүчирхийлэл зэрэг согогтой институцийн бүтцийн үр дагаврыг саармагжуулдаг. Гэхдээ авлигад бас сул талууд бий.

‘Арааг элсээр бөглөх’

‘Арааг элсээр бөглөх’ таамаглал нь авлигын зарим зардал нь сул институцийн буюу сул байгууллын нөхцөлд илрэн гарч эсхүл үржигдэн нэмэгддэг гэдгийг онцолдог. Жишээлбэл, авлига нь ердийн үедээ хашин хойрго засаг захиргааг хурдасгана гэсэн санаа нь алдаатай юм. Мирдал (*Myrdal 1968*) авлигажсан төрийн албан хаагч нь хахуулиас өөр шалтгаанаар саатал үүсгэж болно гэж үздэг. Гэхдээ Күрэр (*Kurer 1993*) авлигажсан албан тушаалтнууд хууль бус орлогын эх үүсвэрээ хадгалахын тулд эдийн засагт гажуудал бий болгох сонирхол төрүүлдэг гэсэн. Түүнээс улбаалж засаглалын шалгуур үзүүлэлтүүдийг гажуудуулснаар авлигын аливаа хэмжүүрт нөлөөлнө гэж үздэг. Тэд томсгосон түвшинд юу ч авлигын аюулаас ангид байж чадахгүй, авлигаар ажил олж авах нь заавал ч үгүй хамгийн үр

ашигтай хувилбар байдаггүй гэдгийг онцолсон байна. Тухайн ажил ашигтай байх эсэх нь тодорхойгүй байгаа дуудлага худалдаанд ялагчийн санал нь авлигажсан гэхээс илүү өөдрөг үзлийн илэрхийлэл байж болно. Роуз-Акерман (*Rose-Ackerman 1997*) хамгийн өндөр хахууль төлж байгаа хүн бол тухайн ажлыг авсныхаа дараа нийлүүлэх бүтээгдэхүүний чанарт хамгийн их буулт хийхэд бэлэн байдаг гэдгийг харуулсан. Эдгээр нөхцөл байдал дор авлига нь үр ашгийг нэмэгдүүлэх бус ердөө бууруулна. Тиймээс авлига хөрөнгө оруулалтын чанарыг нэмэгдүүлэх боломжтой гэдэг үзэл бодол нь эргэлзээтэй. Мауро (*Mauro 1998*) авлигын үр дүнд төрийн төсөв, хөрөнгө үр ашиг багатай хуваарилалт руу сарнидаг гэдгийг ажигласан байна. Тиймээс авлига нь төрийн хөрөнгө оруулалт нь үр ашиг эсхүл эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх магадлал багатай, бүтээмж муутай салбар руу ороход хүргэдэг учир муу засаглал гэж харагддаг.

Улс төрийн тодорхойгүй орчин нөхцөлд авлига нь саармагжуулах үүрэг гүйцэтгэх эсэх нь ч бас эргэлзээтэй. Хахууль бол энгийн гүйлгээ биш. Хахууль авсны хариуд хийгдсэн 'тохиролцооны нөхцөл' нь заримдаа хууль бус байдаг учир түүнийг дагаж мөрдөх баталгаа нь үнэндээ маш сул байж болох учир талуудад ялангуяа хүлээн авагчийн зүгээс боломж хайх үйлдэлд хүргэж (*Meon and Weill 2010*) болно. Түүнчлэн авлигаас үүдэн тодорхой бус байдал нэмэгдэх нь эдийн засгийн бусад хэсэгт нөлөөлж болзошгүй. Жишээлбэл, авлига нь сүүдрийн эдийн засагтай холбоотой. Сүүдрийн эдийн засаг дахь гүйлгээ нь тодорхойлолтын дагуу зохицуулалтгүй байдаг учир албан ёсны гүйлгээнээс бүр ч илүү тодорхойгүй байдал байж, хэмжих боломжгүй болно. Гэвч хамгийн гол нь авлига нь институцийн бүтцийн бусад хэсгийг сулруулах замаар эдийн засгийн гүйцэтгэлд (*Dreher and Siemers 2009*) нөлөөлнө. Авлига ба хөрөнгийн урсгалын хязгаарлалт нь харилцан бие биеэ дэмждэг учир авлига нь илүү хатуу хязгаарлалтад хүргэж

тэр нь тухайн салбар, эсхүл улс орон дахь авлигыг дэмжиж, авлига нутагшиж, улмаар түүнийг устгахад хүндрэлтэй болно.

Ийм учраас Бардхан (*Bardhan 1997*) угаасаа авлигад байдаг тодорхойгүй байдал нь өмнө тайлбарласан ‘арааг тослох’ таамаглалын дэвшүүлдэг эдийн засгийн үр ашгийг үр дүнгүй болгодог гэж үзжээ. Ийм орчин нөхцөл нь хөрөнгийг өөр тийш нь хялбархан шилжүүлж болох бөгөөд бүтээмж муутай тодорхой капиталд бус олон улсын капиталд хөрөнгө оруулах сонирхлыг бий болгоно. Түүний үр дүнд авлига нь улс төрийн хүчирхийлэл, эсхүл хуулийн сул засаглал хөрөнгө оруулалтад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах бус бүр (*Henisz 2000*) муутгана.

Хийсвэр түвшинд ‘арааг тослох’ ба ‘арааг элсээр бөглөх’ таамаглалын аль аль нь (*Meon and Weill 2010*) хэрэгцээтэй. Эдгээр таамаглалаас авлига нь үр ашигтай институцийн тогтолцооны үед эдийн засгийн үр ашгийг бууруулна гэж таамаглал гаргаж болно. Харин согогтой институцийн тогтолцоонд авлигын үр дүн ямар байх талаар эдгээр таамаглал ялгаатай. ‘Арааг тосолдог’ гэсэн онолоор бол авлига нь үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой гэж таамагладаг бол ‘арааг элсээр бөглөж гацаадаг’ гэх онолоор авлига нэмэгдэх нь согогтой институцийн тогтолцооны үед ч үр ашгийг бууруулна гэж таамагладаг. Буурай хөгжилтэй оронд нефтийн орд илрүүлэх буюу ‘баялгийн хараалд’ унах нь чиг үүрэг нь хангалттай бус үр дүн муутай байгууллагуудын авлигыг ихэсгэдэг гэдгийн жишээ болж өгдөг учир энэхүү институцийн орчин нөхцөл нь чухал хүчин зүйл болно.

Дүгнэлт

Энэ бүлэгт авлигыг хэмжих талаар хийгдэж ирсэн оролдлогуудын талаар болон тогтсон, өргөн хэрэглэгддэг АТИ, ДЗИ, Дэлхийн авлигын хэмжүүр зэрэг индексийн талаар товч авч үзлээ. Авлигыг хэмжих гэсэн оролдлогын тоо асар

Авлигын криминологи

өндөр хурдтайгаар өсөж иржээ. Зарим нь дэлхийн түвшинд хийгдсэн байна. Авлига нь нуугдмал шинж чанартай байдаг бөгөөд олон янзын хэлбэртэй байдаг учир авлигыг хэмжинэ гэдэг хэцүү даалгавар (*Svensson 2005*) юм. Авлигын талаар объектив статистикийг улс орны болон олон улсын түвшинд аль алинд нь олоход хэцүү. Төсөөллийн судалгаа нь субъектив чанартай, өрөөсгөл ойлголтоос ангид бус учраас авлигын бодит түвшинг орлуулах төгс бус зүйл болдог. АТИ нь төрийн албан дахь авлигыг голчлон анхаардаг. ДЗИ нь хувийн салбарын авлигыг багтаахыг оролддог боловч ингэхдээ бусдаас ялгаатай авлигын тодорхойлолт хэрэглэдэг. Олон улсад авлига гэж юу болох талаар нэгдсэн зөвшилцөл байдаггүй учир улс орнуудыг авлигаар эрэмбэлэх асуудал маргаантай хэвээр байна. Олон улсын авлигын үнэлгээг нэгтгэх гэж оролддог боловч тэдгээр санаачилга нь улс орнууд дахь авлигын өөр өөр төрөлд өгөх харьцангуй ач холбогдлын ялгааг тооцдоггүй.

Ярилцагчийн туршлагад үндэслэсэн асуулга нь бас асуудалтай. Учир нь тэдгээр оролцогчид авлигын гүйлгээнд шууд оролцсон байх үед тэдний өгч буй мэдээлэл хэр найдвартай вэ гэдэг асуудал үүснэ. Ийм төрлийн судалгаа нь төсөөллийн судалгаатай адил хүмүүсийн өрөөсгөл ойлголтоос ангид байж чаддаггүй. Нэг ширхэг ямар ч шалгуур үзүүлэлт уг үзэгдлийн нарийн төвөгтэй байдлыг бүхэлд нь харуулж чадахгүй учир хэд хэдэн арга хэрэгслийг хослуулан хэрэглэх нь илүү ашигтай байж болох юм. Хэдийгээр баримжаалсан хэрэгсэл ч гэсэн авлигын хэд хэдэн хэмжүүрийг авч үзсэнээр ямар арга хэмжээ авбал авлигыг бууруулах хандлагатай болохыг мэдэж (*Collier 2000*) болно. Энэ нь мөн авлигатай тэмцэх санаачилгуудын явцыг харуулж чадна. Авлигын хэмжүүрийн талаарх шүүмжлэлээс үл хамааран энэ бүлэгт ‘олон шог яриа нийлээд мэдээлэл болно’ гэдэг хэлцийг санаж байх нь зүйтэй бөгөөд эдгээр нь хэдийгээр сул талтай ч гэсэн өрөөсгөл ойлголт, улстөржсөн ярианаас дээр юм.

Ашигласан материал

- Anderson, S., & Heywood, P. M. (2009). The politics of perception; use and abuse of Transparency International's approach to measuring corruption. *Political Studies*, 57 (4), 746–767.
- Arndt, C., & Oman, C. (2006). *Uses and abuses of governance indicators*. Paris: OECD.
- Atanassova, A., Bertrand, M., Mullainathan, S., & Niehaus, P. (2009). *Targeting with agents: Theory and evidence for India's below poverty line cards*. Mimeo: UC San Diego.
- Bailey, D. H. (1966). The effects of corruption in a developing nation. *Western Political Quarterly*, 190 (4), 719–732.
- Banerjee, A., Deaton, A., & Duo, E. (2004). Health care delivery in rural Rajasthan. *Economic and Political Weekly*, 39 (9), 944–949.
- Banerjee, A., Dufl o, E., & Glennerster, R. (2007). Putting a band-aid on a corpse: Incentives for nurses in the Indian public health care system. *Journal of the European Economic Association*, 6 (2–3), 487–500.
- Bardhan, P. (1997). Corruption and development: A review of issues. *Journal of Economic Literature*, 35 (3), 1320–1346.
- Beck, P. J., & Maher, M. W. (1986). A comparison of bribery and bidding in thin markets. *Economics Letters*, 20 (1), 1–5.
- Bertrand, M., Djankov, S., Hanna, R., & Mullainathan, S. (2007). Obtaining a driver's license in India: An experimental approach to studying corruption. *Quarterly Journal of Economics*, 122 (4), 1639–1676.
- Bradburn, N. M. (1983). Response effects. In R. Peter, H. Rossi, J. D. Wright, & A. B. Anderson (Eds.), *Handbook of survey research*. New York: Academic Press.

- Brooks, G., Walsh, D., Lewis, C., & Kim, H. (2013). *The prevention of corruption: Investigation, enforcement and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Brunetti, A., Kisunko, G., Weder, B. (1997). *Institutional obstacles to doing business*. (Policy Research Working Paper 1759). Washington, DC: World Bank.
- Button, M., Gee, J. & Brooks, G. (2011) Measuring the cost of fraud: an opportunity for the new competitive advantage. *Journal of Financial Crime*, 19 (1), 65–75.
- Button, M., Lewis, C., Shepard, D., & Brooks, G. (2015). Fraud in overseas aid and the challenge of measurement. *Journal of Financial Crime*, 22 (2), 184–198.
- Chaudhury, N., Hammer, J., Kremer, M., Muralidharan, K., & Rogers, F. (2006). Missing in action: Teacher and health worker absence in developing countries. *Journal of Economic Perspectives*, 20 (1), 91–116.
- Coleman, C. & Moynihan, J. (1996). *Understanding crime data: haunted by the dark figure*. Milton Keynes: Open University Press.
- Collier, P. (2000). *How to reduce corruption*. *African Development Review*, 12 (2), 191–205.
- De Maria, W. (2008). Measurements and markets: Deconstructing the corruption perception index. *International Journal of Public Sector Management*, 21 (7), 777–797.
- De Soto, H. (1989). *The other path. The invisible revolution in the Third World*. New York: Harper and Row.
- Donchev, D. & Ujhelyi, G., 2007. Do Corruption Indices Measure Corruption? *Economics & Politics*, 26 (2), 309–331.

- Dreher, A., & Siemers, L. H. R. (2009). The nexus between corruption and capital account restrictions. *Public Choice*, 140 (1–2), 245–265.
- Duflo, E., Hanna, R., & Ryan, S. (2008). *Monitoring works: Getting teachers to come to school* (CEPR Discussion Papers 6682).
- Ehrlich, I., & Lui, F. (1999). Bureaucratic corruption and endogenous economic growth. *Journal of Political Economy*, 107 (6), 270–293.
- Ferraz, C., & Finan, F. (2008). Exposing corrupt politicians: The effects of Brazil’s publicly released audits on electoral outcomes. *Quarterly Journal of Economics*, 123 (2), 703–745.
- Galtung, F. (2006). Measuring the immeasurable: Boundaries and Functions of (Macro) corruption indices. In C. Sampford, A. Shacklock, C. Connors, & F. Galtung (Eds.), *Measuring corruption*. Aldershot: Ashgate.
- Henisz, W. J. (2000). The institutional environment for economic growth. *Economics and Politics*, 12 (1), 1–31.
- Heywood, P. M. (2015). *Routledge handbook of political corruption*. Abingdon: Routledge.
- Hough, D. (2015). *Corruption, anti-corruption and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Hunt, J. (2007). *Bribery in Health Care in Peru and Uganda* (NBER Working Papers 13034). Cambridge, MA: National Bureau of Economic Research.
- Huntington, S. P. (1968). *Political order in changing societies*. New Haven, CT: Yale University Press.
- Integrity, G.F. (2011). Illicit financial flows from developing countries: 2000–2009. Update with a Focus on Asia, Global

Financial Integrity Executive Report, Washington: Global Integrity.

Jensen, N. M., Li, Q., & Rahman, A. (2010). Understanding corruption and firm responses in cross-national firm-level surveys. *Journal of International Business Studies*, 41 (9), 1481–1504.

Johnston, M. (2002). Measuring the new corruption rankings: Implications for analysis and reform. In A. J. Heidenheimer & M. Johnson (Eds.), *Political corruption—Concepts & contexts*. New Brunswick, NJ: Transaction Publishers.

Johnston, M. (2005). *Syndromes of corruption: Wealth, power and democracy*. Cambridge: Cambridge University Press.

Kaufmann, D., Kraay, A., & Mastruzzi, M. (1999). *Governance matters* (World Bank Policy Research Working Paper 2196). Washington, DC: World Bank.

Kaufmann, D., Kraay, A., & Mastruzzi, M. (2006). Measuring corruption: Myths and realities. *Development Outreach*, 8 (2), 124–137.

Kaufmann, D., Kraay, A., & Mastruzzi, M. (2007). Growth and Governance: A Reply. *The Journal of Politics*, 69 (2), 555–562.

Kaufmann, D., Kraay, A., & Mastruzzi, M. (2009). *Governance matters VIII: Aggregate and individual governance indicators 1996 – 2008* (World Bank Policy Research Working Paper 4978). Washington, DC: World Bank.

Kiselev, E. (2012). *Bribe-taking and bureaucratic competition: A search cost model of corruption*. Waltham, MA: Brandeis University International Business School.

Knack, S. (2002). Social capital, growth and poverty: A survey of cross-country evidence. In C. Grootaert & T. van Bastelaer

- (Eds.), *The role of social capital in development: An empirical assessment*. Cambridge: Cambridge University Press.
- Knack, S. (2006). *Measuring corruption in Eastern Europe and Central Asia: A critique of the cross-country indicators* (World Bank Policy Research Working Paper 3968). Washington, DC: World Bank.
- Koziol, M., & Tolmie, C. (2010). *Using public expenditure tracking surveys to monitor projects and small-scale programs—A guide*. Washington, DC: The World Bank.
- Kurer, O. (1993). Clientelism, corruption and the allocation of resources. *Public Choice*, 77 (2), 259–273.
- Kurtz, M., & Schrank, A. (2007). Growth and governance: Models, measures, and mechanisms. *Journal of Politics*, 69 (2), 538–554.
- Lambsdorff, J. G. (2005). *The methodology of the 2005 corruption perceptions index*. Germany, Passau: Transparency International and University of Germany.
- Lambsdorff, J. G. (2006). Causes and consequences of corruption: What do we know from a cross-section of countries? In S. Rose-Ackerman (Ed.), *International handbook on the economics of corruption*. Cheltenham: Edward Elgar.
- Leff, N. H. (1964). Economic development through bureaucratic corruption. *American Behavioral Scientist*, 8 (3), 8–14.
- Leff, N. H. (1989) Economic Development through Bureaucratic Corruption, in A.J. Heidenheimer, M. Johnston and V.T. LeVine (eds.) *Political Corruption: A Handbook*, New Brunswick NJ: Transaction Books, pp: 389–403.
- Levi, M. & Burrows, J. (2008). Measuring the Impact of Fraud in the UK A Conceptual and Empirical Journey. *British Journal of Criminology*, 48(3), 293-318.

- Leys, C. (1965). What is the problem about corruption? *Journal of Modern African Studies*, 3 (2), 215–230.
- Lien, D. H. D. (1986). A note on competitive bribery games. *Economics Letters*, 22, 337–341.
- Lui, F. T. (1985). An equilibrium queuing model of bribery. *Journal of Political Economy*, 93 (4), 760–781.
- Mauro, P. (1998). Corruption and the composition of government expenditure. *Journal of Public Economics*, 69 (2), 263–279.
- Mauro, P. (2004). *The persistence of corruption and slow economic growth*. IMF staff papers. Washington, DC: IMF.
- Maurseth, P. B. (2008). *Governance indicators: A guided tour* (NUPI Working Paper 754).
- Meon, P.-G., & Weill, L. (2010). Is corruption an efficient grease? *World Development*, 38 (3), 244–259.
- Myrdal, G. (1968) Corruption: its causes and effects. In *Asian drama: An inquiry into the poverty of nations*. Vol. II. New York: Pantheon. Reprinted in *Political corruption: A handbook*. Edited by a Heidenheimer et al. New Brunswick: Transaction Publishers, 1989: 953–961.
- Olken, B. (2007). Monitoring corruption: Evidence from a field experiment in Indonesia. *Journal of Political Economy*, 115 (2), 200–249.
- Olken, B. and Barron, P. (2007). The Simple Economics of Extortion* Evidence from Trucking in Aceh, *Journal of Political Economy*, 117(3), 417–452.
- Olson, M. (1993). Dictatorship, democracy, and development. *American Political Science Review*, 87 (3), 567–576.

- Reinekka, R. & Smith, N. (2004). Public expenditure tracking surveys in education. International Institute for Educational Planning. Paris. UNESCO.
- Reinikka, R. and Svensson, J. (2004). Local Capture: Evidence from a Central Government Transfer Program in Uganda. *The Quarterly Journal of Economics*, 119(2), 679–705.
- Reinikka, R., & Svensson, J. (2005). Fighting corruption to improve schooling: Evidence from a newspaper campaign in Uganda. *Journal of the European Economic Association*, 3 (2–3), 259–267.
- Reinekka, R. & Svensson, J. (2006). Using micro surveys to measure and explain corruption. *World Development*, 34 (2), 359–370.
- Rohwer, A. (2009). Measuring corruption: A comparison between the Transparency International’s Corruption Perceptions Index and the World Bank’s Worldwide Governance Indicators. Ifo Institute for Economic Research at the University of Munich. *CESifo DICE Report*, 7, 42–52.
- Rose-Ackerman, R. (1997). The political economy of corruption. In K. A. Elliott (Ed.), *Corruption and the global economy*. Washington, DC: Institute for International Economics.
- Shaxson, N. (2007). Oil, corruption and the resource curse. *International Affairs*, 83 (6), 1123–1140.
- Svensson, J. (2003). Why conditional aid does not work and what can be done about it? *Journal of Development Economics*, 70, 381–402.
- Svensson, J. (2005). Eight questions about corruption. *Journal of Economic Perspectives*, 19, 19–42.
- Thompson, T., & Shah, A. (2005). Transparency International’s Corruption Perceptions Index: Whose Perceptions are they anywhere?, cited in A. Rohwer. (2009). Measuring corruption:

A comparison between the Transparency International's Corruption Perceptions Index and the World Bank's Worldwide Governance Indicators. CESifo DICE Report. Ifo Institute for Economic Research at the University of Munich.

Urta, F., J. (2007) Assessing Corruption An analytical review of Corruption measurement and its problems: Perception, Error and Utility. Edmund A. Walsh School of Foreign Service: Georgetown University. UN. (2008). *United Nations Development Programme*. Washington, DC: UN.

Weber Abramo, C. (2008). How much do perceptions of corruption really tell us? Economics-The Open-Access. *Open-Assessment E-Journal*, 2, 1–56.

Worthy, B. & McClean, T. (2015). Freedom of Information and Corruption in P. Heywood et al (2015) *Routledge Handbook of Political Corruption*, pp.347–359. Abingdon: Routledge.

IV

Авлигыг тайлбарлах нь: Ялгаатай нөхөрлөлийн онол

Удиртгал

Энэ бүлэгт Садерланд (*Sutherland 1939, 1947*), Коулман (*Coleman 1992*) болон Ашфорд ба Ананд (*Ashforth and Anand 2003*) нарын ялгаатай нөхөрлөлийн (*differential association*) талаарх бүтээлд голчлон анхаарах ба бусад хэрэгтэй онолын аргачлалыг ч бас авч үзэх болно. Ялгаатай нөхөрлөлийн онол нь гэмт үйлдлийг бусадтай харилцах үйл явцдаа суралцдаг гэж онцолдог бөгөөд ингэхдээ хууль зөрчихийг дэмжсэн өгүүлэмж гэж нэрлэгддэг зүйлсийг ажиглах замаар суралцдаг гэж үздэг. Суралцах үйл явц гэдэгт гэмт хэргийн цогц үйлдэлд хандах хандлага, логик үндэслэл, хөдөлгөгч хүч, сэдэл, техникт суралцах гэх мэт санааг хамруулна. Авлигын болон эрүүгийн үйлдэл хийхийн тулд тухайн үйлдлийг хүлээн зөвшөөрөгдөх үйлдэл хэмээн зөвтгөх, логик үндэслэлийг гаргах (*rationalize*) давамгайлсан хандлагын соёл хүнд хэрэгтэй болно. Энэ онол нь бүхий л гэмт зан үйлийн шалтгаан судлалын ерөнхий тодорхойлолт болж болох боловч ялгаатай нөхөрлөлийн түлхүүр санаа нь бүхий л гэмт зан үйлийг хүн нийгмийн харилцааны үйл явцад суралцдаг гэсэн ойлголт юм.

Ялгаатай нөхөрлөл

Энэ онолд есөн суурь зарчим байдаг. Үүнд:

1. Гэмт зан үйлийг суралцдаг;
2. Хүмүүс гэмт зан үйлийг бусадтай харилцах үйл явцдаа суралцдаг;
3. Гэмт зан үйлийг суралцах явдал голчлон найз нөхдийн, жижиг бүлэг дунд явагддаг;
4. Гэмт хэрэгт суралцах нь дараах зүйлсийг агуулна:
 - а) энгийн, эсхүл нарийн төвөгтэй байж болох гэмт хэрэг үйлдэх техник;
 - б) гэмт хэргийн сэдэл, хандлага, төлөвлөгөө, логик үндэслэл.
5. Хууль тогтоомж нь юу хүлээн зөвшөөрөгдөх, юу хүлээн зөвшөөрөгдөхгүй вэ гэдгийг харуулдаг ба тэндээс гэмт хэргийн сэдэл бий болдог;
6. Хууль зөрчихийг буруутгасан өгүүлэмжээс хууль зөрчихийг дэмжих өгүүлэмж нь давсан үед хүн гэмт хэрэгтэн болдог. Энэ бол ялгаатай нөхөрлөлийн зарчим;
7. Ялгаатай нөхөрлөл нь давтамж, үргэлжлэл, тэргүүлэх чиглэл, нягтшилтаараа өөр байж болно;
8. Харилцаан дундаас гэмт зан үйлийг суралцах нь бусад бүхий л төрлийн суралцах үйлдэлтэй төстэй;
9. Гэмт хэргийн болон гэмт хэргийн бус зан үйл нь ижилхэн хэрэгцээ ба үнэт зүйлсийн илэрхийлэл бөгөөд ямар ч гарал үүсэлтэй, ямар ч хүн гэмт хэрэгтэн болж (*Lilly et al. 1989:57–58*) болно.

4 Авлигыг тайлбарлах нь: Ялгаатай нөхөрлөлийн онол

Эдгээр зарчмыг хэрэглэх нь заримдаа гэмт хэрэгтнүүд нь эмгэгтэй бөгөөд янз бүрийн дотоод зөрчилдөөнөөс үүдэн гэмт хэрэг үйлддэг буюу ‘сэтгэцийн эрүүл мэндийн согог’ гэдэгт хамрагддаг тайлбараас эрс ялгаатай. Бусдын талаар огт санаа зовдоггүй, эсхүл нийгэмд зохицдоггүй сэтгэлгээний нөхцөл байдалтай ‘ядуу хүмүүс’ ихэвчлэн гэмт хэрэг үйлддэг гэж үзэж ирсэн. Харин түүний оронд Садерланд хуулийг зөрчдөг ба дагаж мөрддөг хүмүүсийн ялгаа нь тэдний ёс зүйн зан авир, эсхүл ёс зүйгүй байдлын асуудал бус тэдний суралцах үйлдлийн агуулга, ялангуяа орчин нөхцөл юм гэж тайлбарласан ажээ.

Гэр бүл нь хувь хүний нийгмийн болон эдийн засгийн хэрэгцээг хангадаг агаад боломжтой бол жигд тууштай хүлээлтийн цогцыг өгч байдаг. ‘Гэр бүл’-ийг тогтвортой байдлын тулгуур суурь гэж үздэг боловч барууны нийгэм нь бас зөрчил бүхий хандлага, стандарт, үзэл санаатай гэж үздэг бөгөөд өндөр түвшний нийгмийн зохион байгуулалтгүйдлийн (*social disorganization*) нөлөөнд байдаг гэж үздэг. Энэхүү зохион байгуулалтгүйдэл нь эдийн засгийн хувь үзэл (*individualism*) ба хувийн эд хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх явдалд хүргэж, эсхүл түүний шалтгаан нь болж, улмаар материализм буюу мөнгө, эд зүйлийг гүнзгий шүтэх үзлийг бий болгон, тэр нь эргээд гэмт зан үйлийг өөгшүүлдэг гэж (*Coleman 1992*) үзжээ. Ялгаатай нөхөрлөл нь нийгэм, улс төрийн орчин нөхцөлд гэмт хэргийн нийтлэг тайлбар болон тавигдсан бөгөөд олны хүндэтгэлийг хүлээж, нийгмийн байр суурь бүхий хүн ажил мэргэжлийн хүрээнд гэмт хэрэг үйлдэх буюу анх 1940 онд Садерландын ‘цагаан захтны гэмт хэрэг’ хэмээн томъёолсон гэмт үйлдлийг тайлбарлаж чаддагаараа (*Lilly et al. 1989*) алдаршжээ. Тэрээр судалгаагаараа улс төр, бизнес, мэргэжлийн орчинд гэмт хэрэг түгээмэл тархсаныг илрүүлсэн ба Америкийн байгууллагууд нь хуулийн стандартыг үе үе (*Sutherland 1949*) ‘зөрчиж, мөлжлөгийн эзэн’ ба ‘архаг гэмт хэрэгтэн’-ий шинжтэй байгааг цохон тэмдэглэсэн юм.

Садерланд хууль бус практик нь ‘бизнес хийх арга’ нь болж, олон салбарт тархан өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн байгааг тэмдэглэжээ. Энэ нь гадаад орчин, нөхцөлөөс хамаараад ирээдүйд гэмт үйлдэлд хүргэж болзошгүйг онцлон хэлсэн агуулгатай юм. Гэхдээ хуулийн засаглалыг хүндэтгэхийг гэртээ, эсхүл цөөн найз нөхдийн хүрээнд заалгасан хүн авлигын болон гэмт үйлдлийг хүлээн зөвшөөрч, дэмждэг өөр ёс зүйтэй бизнесийн орчинд орж ирснээр өөрчлөгдөж магадгүй юм. Зан үйлийн ийм системтэй танилцаж, өдөөгдсөнөөр (*Sutherland 1940*) харилцаа нь тэднийг цагаан захт ажилтнаас цагаан захт гэмт хэрэгтэн болгож өөрчилнө.

Харилцааны түвшинд ялгаатай нөхөрлөлийн таамаглал нь гэмт зан үйлийг дэмжихгүй хүмүүсээс тусгаар байх үед, тухайн зан үйлийг дэмждэг хүмүүстэй ойр харилцаатай байх үед суралцдаг гэж үздэг. Хууль бус үйлдлийг дэмжсэн өгүүлэмжийн жин нь дэмжээгүй өгүүлэмжийн жингээс илүү болох үед, зөвхөн ийм тохиромжтой нөхцөл бий болоход л хүн тийм зан үйл (*Sutherland 1949:234*) гаргадаг. Эхэн үед гарсан өмч шамшигдуулах зэрэг үйлдлийн талаарх судалгаагаар энэхүү тайлбар (*Cressey 1953*) дэмжигддэг. Крессэй мөн ялгаатай нөхөрлөлийн талаар дэлгэрүүлж тухайн үйлдлийг зөвтгөх зүйл нь *ex post facto* буюу *аль хэдийн дууссан* үйлдлийг логик үндэслэлтэй болгох, эргэж үйлчлэх зүйл бус сэтгэлзүйн хувьд гэмт хэрэг үйлдэгдэх, үйл хөдлөл хийх сэдлийн голлох хэсгээс өмнө байдаг зүйл гэдгийг онцолсон. Сайкес, Матза (*Sykes and Matza 1957*) нар мөн эдгээр логик үндэслэлийг *саармагжуулах арга хэрэгсэл* гэж нэрлэсэн (*VI бүлгийг үз*). Гэхдээ Садерланд тийм зан үйлийг бусдаас суралцдаг гэж бодсон бол Крессэй (*Cressey 1953*) нийгмийн бодит байдлыг бий болгох үйл явц ба хувь хүн авлигад автсан байсан ч өөрийн талаар эерэг ойлголтоо хадгалах боломж олгодог ертөнцийн талаарх ойлголтын ач холбогдлыг онцлон тэмдэглэжээ.

Ашфорт, Ананд (*Ashforth and Anand 2003*) нар өөрийн талаарх эерэг ойлголт (*positive self-concept*) нь институцчилэл (*institutionalization*), логик үндэслэл (*rationalization*), нийгэмшлийн (*socialization*) хольц байдаг гэж үзсэн байна. Тэдний санал болгосон загварт эдгээр элементүүдийн хольц гэдэгт анхны авлигажсан үйлдэл нь бүтэц болон процесст нэгдэж орохыг институцчилэл гэж, авлигажсан үйлдлийг гаргахын тулд тавьж буй өөрийгөө илүүд үзсэн зөвтгөлийг логик үндэслэл гэж, шинэ ажилтнуудад авлигыг хүлээн зөвшөөрөгдөх зүйл гэж харуулахаар уруу татах эсхүл өдөөхийг нийгэмшил гэж үздэг. Гэхдээ энэ үзэл нь криминологи болон авлигын талаарх бүтээлд тэр бүр дэмжигдээгүй юм. Харин Хирши, Готтфредсон (*Hirschi and Gottfredson 1987*) нар хүн бол хамгийн их таашаал өгөх бөгөөд хамгийн бага зовлон бүхий үйлдлийг сонгодог гэж үздэг (*VII бүлгийг үз*). Энэ нь хүний зан үйлийг нэлээд хязгаарлагдмал байдлаар харж байгаа хэрэг юм. Яагаад гэвэл бидэнд эргэцүүлж үзэх чадвар, чадамж байдаг ба бид өөртөө ухамсартай байж, бэлэг тэмдгийн харилцаанд (*symbolic interaction*) үндэслэн юмыг ойлгож авдаг. Хүмүүс зөвхөн таашаалыг хайж, зовлонгоос (*Coleman 1992*) зугтдаггүй. Ямар ч хэлбэртэй бай биологийн таашаал нь өдөр тутмын амьдралын бэлэг тэмдгийн байгууламжтай (*symbolic construction*) холбогддог.

Институцчилэл болон хоорондын харилцаа байхгүй үед авлигын үйлдэл нь байгууллагын бүтэц, процессын дотор орж улмаар хэвшил болон ‘бизнес хийх’ аргын нэг хэсэг болох нь эргэлзээтэй учир тийм үйлдлийн логик үндэслэлийг гаргаж, нийгэмшүүлэх зүйл ч байхгүй юм. Гэвч байгууллагын бүхий л хэсэгт бус түүний жижиг хэсэг, бүлэгт авлига оршин байж болно. Мөн зарим ажилтны албадлага нь логик үндэслэл ба нийгэмшлийг орлож болно. Энэ нь зарим ажилтан авлигажсан болох нь баригдах үед ‘шалтаг’ болон ашиглагдаж болно. Аливаа практиктай адилаар авлига тогтвортой, өөрчлөлтийг эсэргүүцэж,

хамтран ажиллагсад руу уламжлагдах үед институцчилэгдсэн гэж (*Oliver 1992; Zucker 1977*) хэлдэг. Ийм практиктай ойр буй хүмүүсийн хувьд авлигын практикийг шүүмжлэх итгэл үнэмшлийн зөрүү (*cognitive dissonance*) үүсдэггүй учир удаан хугацаанд оршин тогтнодог байна. Байгууллагын нийгэмшлээр хүмүүсийг нийгмийн бүрхүүлд (*social cocoon*) оруулахын ард хувь хүн авлигыг хүлээн зөвшөөрөх, эсхүл ёс зүйн сэрэмжээ унтраах хүч чадал оршиж байдаг. Түүнчлэн нийгэмших практик нь өөрөө институцчилэгдэж, шинэ ажилтнуудад хүчтэй нөлөөлж болно. Шинэ ажилтнууд тогтсон практикийн ‘сэнхрүүлэг’ болон ‘бид ингэж ажилладаг’ гэсэн санаа бодлыг байгууллагын хуучин гишүүдээс (*Jones 1986*) авна. Жишээлбэл, Волксваген компани машиныхаа утаа хаялтыг нуусан хэрэг нь байгууллагын бүтэц, менежментийн үр дүн байсан гэж (*Stewart 2015:1*) үздэг. Институцчилэгдсэн нийгэмшил нь шинэ ажилчид байгууллагын практикийг хүлээн зөвшөөрөх явдлыг нэмэгдүүлж бизнесийн практикийг шүүмжлэх явдлыг багасгадаг. Тиймээс авлигыг санал зөрөлдөөнөөс сэргийлж, практик тогтолцоог бодит байдлын объектив илэрхийлэл гэж харагдуулах байдлаар ‘боож савласан’ байдаг чухам тэр шалтгааны улмаас л авлига нь хүлээн зөвшөөрөгдөх илүү магадлалтай (*Zucker 1977*) болно.

Нийгэмшил ба логик үндэслэл нь нэг нэгнийгээ дэмжиж авлигын үйлдлийн зөвтгөл, зөөлрүүлэх тайлбар болдог. Нийгмийн бүрхүүл нь байгууллагын соёлд уусаагүй байсан бол магадгүй шинэ ажилчдын татгалзах байсан тэр үйлдлийг хамгаалах гадаад орчныг бий болгох чадвартай. Хэрэв дотооддоо юм уу, гаднаас хэн ч эсэргүүцэхгүй бол авлига нь байгууллагын ширхэг судал, практик руу институцчилэгдэх процессоор дамжин нэвчин орж хувь хүмүүсийн үйл хөдлөлд нөлөөлөх (*Ashforth and Anand 2003*) боломжтой. Хэрэв эсэргүүцвэл авлигыг илрүүлсэн үр дагавар нь тухайн хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдэд халтай байх (*Near and Miceli 1995; Gobert and Punch 2000*) болно.

Хууль, соёл, капитализм гэсэн цагаан захтны гэмт хэргийн бүтцийн хэмжээсүүд болон нийгмийн тэгш бус байдал, байр суурийн өрсөлдөөн нь энэ төрлийн гэмт хэргийг тайлбарлахад хувь нэмэртэй гэдгийг харуулдаг. Брайтвайт (*Braithwaite 1988*) энэ дүгнэлттэй санал нийлэлгүй, цагаан захтны гэмт хэрэг нь социалист болон капиталист улсын аль алинд нь гардаг учир зөвхөн капитализмаас шалтгаалдаггүй гэж бичжээ. Энэ талаар зарим баримт байгааг Коулман ч тэмдэглэсэн (*Coleman 1992*) байна. Албан ёсны үзэл сурталтай нь эсрэгээр коммунист улсад тэгш бус байдал үргэлж өндөр түвшинд байсан бөгөөд иргэд нь захиргааны эрх мэдэл, давуу эрхээ хадгалахын тулд байр сууриар өрсөлдөж, нийгмийн шилжилт хөдөлгөөнд найдаж ирсэн байдаг. Улс төрийн тогтолцоо гэхээс илүү тэгш бус байдал нь цагаан захтны ба гудамжны гэмт хэргийн шалтгаан болдог. Цагаан захтны гэмт хэргийн эсрэг хуулийн хэрэгжилт, шийтгэл үр дүн муутай байх нь бас ихэвчлэн цагаан захтны гэмт хэргийн шалтгаан хэмээн эшлэгддэг (*XI бүлгийг үз*).

Капитализмд бол асар их хэмжээний эдийн засгийн баялаг нь хувь хүн, байгууллагад их хэмжээгээр хахууль өгөх, бизнесийн сонирхлыг дэмжих улс төрчид ба улс төрийн байгууллагуудыг лоббидох, байгаль орчныг хамгаалах хууль зэрэг бизнесийг хязгаарлах хуулийн өөрчлөлтийг зогсоох, тэтгэвэрт гарсных нь дараа хувийн салбарын, олон улсын удирдах зөвлөлд өндөр цалинтай ажил санал болгох, цаг уурын өөрчлөлт, эрүүл мэндийн судалгаа зэрэг нийгмийн олон янзын асуудлаар эргэлзээтэй судалгаа хийж, үр дүнг тархаадаг байгууллага байгуулах зэрэг зүйлсийг хийх боломж олгодог. Тийм хүч нь (*XI бүлгийг үз*) цагаан захтай гэмт хэрэгтнүүдийг хууль хүчний байгууллага хэрхэн авч үзэхэд нөлөөлдөг бөгөөд үүнийг гажуудсан шударга ёс (*rigged justice*) гэж (*Warren, 2016*) нэрлэдэг. Гэхдээ эдгээр үзэл нь аливаа хууль, эсхүл зохицуулах байгууллага нь хэрхэн бий болж, янз бүрийн салбаруудыг хянах эрх мэдэлтэй болдог вэ гэдгийг тайлбарлаж чаддаггүй.

Энэ нь гэхдээ улс улсад ялгаатай байдаг ч, зарим зохицуулах байгууллага ба авлигатай тэмцэх санаачилга нь олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх байдлаа хадгалах чадамжгүй, улс төрийн тоглолт төдийхөн байдаг учир үүнийг плюрализм ба барууны ардчилсан улс дахь байгууллагын суларсан хүч гэж үзэж болох юм. Одоо ч гэсэн ЛИБОР¹⁵-ын дуулиант хэрэг, санхүүгийн салбарын жигшүүрт авлига гарсаар байгаа ч тэдгээрт ихэвчлэн торгуулийн хэлбэртэй шийтгэл оногдуулж байгаа нь цагаан захтны гэмт хэрэг, авлигад нөлөө багатай харагдаж (*Warren 2016*) байна.

Ашиг багатай эсхүл ашиг нь буурч буй байгууллагууд хууль зөрчих хандлагатай байдгийг судалгаа (*Lane 1954, Staw and Sz wajkowski 1975, Clinard and Yeager 1980; Slapper and Tombs 1999*) харуулдаг. Ашиг бол байгууллагын хөөцөлдөх олон зорилгын зөвхөн нэг л юм. Гросс (*Gross 1978*) амжилт гаргахыг шаардах шахалт нь гэмт хэргийг бий болгох гол буруутан гэх санаа гаргажээ. Өөр өөр асуудлыг хариуцсан бөгөөд нэг нэгнээсээ юу хүлээгдэж байгааг ойлгосон нэгжүүдээс бүтдэг аливаа байгууллагын зорилго(ууд) нь тодорхой зорилгуудад задарч байх ёстой. Жишээлбэл, бүтээгдэхүүн зохион бүтээж, загварчлах нэгж нь бүтээгдэхүүнийг сурталчилдаг нэгжээс өөр зүйлийг хүлээдэг. Энд Волксваген компани тохиромжтой жишээ болно. **Тухайлбал:** хаягдал утааны шалгалтыг хуурах технологийг ашиглах шийдвэр гаргаж, үйлдвэрлэх асуудлыг бүх ажилтан мэдэж байсан гэж хэлэх боломжгүй. Гэхдээ зорилго(ууд) тодорхой болсон цагт хууль зүйн ба эдийн засгийн орчин нь үйл хөдлөл, үйлдэлд нөлөөлнө. Хатуу хуулийн зохицуулалттай боловч түүний хэрэгжилт нь үр дүн муутай орчинд ажиллаж буй байгууллагууд гэмт хэрэг үйлдэж болзошгүй байдаг. Байгууллага нь хууль, зохицуулалтын орчин, хууль хэрэгжих байдлыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгээр хүчингүй болгохоор лоббидох замаар, эсхүл өөрт ашиггүй хууль батлагдахыг

15 1 дүгээр бүлгийн хөл тайлбараас хар.

4 Авлигыг тайлбарлах нь: Ялгаатай нөхөрлөлийн онол

зогсоох замаар нөлөөлөх боломжтой бөгөөд ийн нөлөөлдөг гэдгийг анхаарах хэрэгтэй. Тодорхой салбар дахь байгууллага үйл ажиллагаа явуулахад гадаад орчинд нь гурван хүчин зүйл нөлөөтэй байдаг. **Эдгээр нь:**

a/ тухайн байгууллагын улс төрийн эрх мэдэл, /эдийн засгийн хүч чадал ба улс төрийн эрх мэдэлтнүүдтэй тогтоосон холбоо харилцаа;

b/ үр дүнтэйгээр лобби хийх чадавх;

c/ тухайн асуудал нь улс орны ашиг сонирхолд хортой бус бөгөөд тухайн асуудлын талаарх түгээмэл үзэл санаа болон олон нийтийн санаа бодлоор тэгж үзэхгүй байсан ч гэсэн уг асуудлыг ‘бидний (улс орны) ашиг сонирхолд хохиролтой’ зүйл гэж харуулж олон нийтийн дэмжлэгийг авах чадвар юм.

Хамгийн чухал хүчин зүйлс нь зах зээлийн бүтэц, салбарын эдийн засгийн зохион байгуулалт юм. Авлигажсан гэх муу нэртэй автомашин үйлдвэрлэлийн салбар нь энд тохирох жишээ (*Higgins 2015; Stewart 2015, Jensen and Ivory 2015; Ivory and Tabuchi 2015; Vlasic 2015; Nixon et al. 2015*) болно. Энэ салбар дахь хууль бус үйлдлийг ховорхон тохиолдолд шийтгэж байгаа үлгэр жишээг зарим байгууллагууд сайтар анхаарч, бүтээгдэхүүнийхээ үнэ, зардлыг бууруулах замаар авлига авах, авлигажсан зан үйл гаргах бололцоог ашиглаж болзошгүй юм.

Түүнчлэн байгууллагын хэмжээнээс илүү дотоод бүтэц нь авлигын боломжид илүү нөлөөтэй. Клайнрад (*Clinard 1979*) чиг үүрэгт үндэслэсэн нэгжийн босоо тогтолцооны ‘бүлэглэл’ нь эрх мэдлийн задрал, төвлөрлийг сааруулдаг гэж үзжээ. Энэ бүтэц нь хувь хүнийг хариуцлагаас татгалзах боломж олгож, байгууллагын бүх хэсэгт мэдэгдэлгүйгээр хахууль, хулгай, тендер будилуулах ажил хийхэд хүргэж болзошгүй. Тиймээс байгууллага дотор авлигыг няцаах, эсхүл зөвтгөх буюу зүгээр л ямар ч ёс зүйн ач холбогдолгүй хэвшсэн ажлын нэг хэсэг

гэж харах дэд соёлыг үүсгэж (*Perrow 1972; Coleman 1992*) болно. ‘Ёс зүйн мэдээ алдалт’ хэмээн танигдсан энэ үзэгдлийг хувь хүмүүсийн авлигад хандсан хариу үйлдлээс тусад нь авч үзсэн болохыг Олон улсын хөл бөмбөгийн холбооны Удирдах зөвлөлийн зарим гишүүдийн жишээ (*Brooks et al. 2013a*) харуулдаг. Олз омогтойгоор албан тушаал дэвшиж, амжилттай явахын тулд ‘ёс зүйн хувьд уян хатан’ байж, авлигыг үл тоож эсхүл оролцох хэрэгтэй гэж Гросс (*1978*) тэмдэглэжээ. Брэйтвэйт (*1985*) бас зохицуулалтын төрөл нь байгууллага ямар ч үйлдэл гаргахад нөлөөлж болох ба зохицуулах байгууллага яаж хандахаас хамааран эсэргүүцэх, эсхүл дагаж мөрдөх соёл бий болно. Хэрэв шударга бөгөөд хатуу арга хэмжээ авбал түүнийг нь дагаж мөрдөх ч, зохицуулагчид нь авлигажсан гэж харагдвал эсэргүүцэл гарна. Энэ нь хувь гэмт хэрэгтнүүд гэмт хэргээс үл хамааран шийтгэлийг хэрхэн харахтай төстэй. Хэрэв шийтгэлийг шударга гэж үзвэл хүлээн зөвшөөрөх илүү магадлалтай гэжээ. Автомашин, газрын тосны бүтээгдэхүүн, санхүүгийн салбарын зөөлөн зохицуулалтын жишгээс харахад зохицуулалтыг сайн дураар дагаж мөрдөөгүй, эсрэгээр хүчээр хэрэгжүүлсэн тохиолдолд л хэрэгжсэн гэдэг нь Брэйтвэйтийн үзлийн асуудалтай талыг харуулж байна.

Тиймээс цагаан захтны гэмт хэргийг хувь хүний, байгууллагын, нийгмийн түвшинд ойлгох онолын тогтолцоо нь нарийн төвөгтэй байна. Бүхий л түвшинд зөрчилдөөн байдаг ч, хувь хүний түвшинд бол их ашиг хүртэх болон өөрийгөө эерэгээр харах хоёрын хооронд зөрчил үүсдэг. Гэхдээ бид одоо Садерландын онол болон түүний цагаан захтны гэмт хэрэг, авлигын үйлдлийн талаарх тайлбараас хамаагүй илүү урагш ахисан бөгөөд төр хувийн ашиг сонирхолд автагдах үйлдлийн хүрээнд авлигыг төрийн-компанийн гэмт хэрэг хэмээн шинжилж харах түвшинд ирээд (*Brooks et al. 2013a*) байна. Үүнийг доор тайлбарласан хувийн цэргийн гэрээлэгчдийг авлигад ашиглах гэсэн жишээ дэлгэрэнгүй харуулна.

Ялгаатай нөхөрлөлийн ойлголт нь ‘нийгмийн ялгаатай зохион байгуулалт’ (*differential social organization*) гэсэн ойлголт дээр үндэслэдэг ба уг ойлголт нь харилцааг ‘нийгмийн хувьд зохион байгуулалтгүй’ биш ялгаатайгаар зохион байгуулагдсан зүйл гэж хардаг бөгөөд үнэт зүйлийн үнэлгээ нь ‘баримт’ гэж танилцуулагдах байдал давамгайлдаг. Нийгмийн ялгаатай зохион байгуулалтгүйдэл гэсэн ойлголт нь нийгэм нь зөрчилдөөн дээр бус нийтийн зөвшилцөл дээр суурилдаг гэсэн санааг шүүмжилдэг нэг төрлийн онолын чиглэлийг (*VIII бүлгийг үз*) төлөөлдөг. Цагаан захтны гэмт хэргийг тайлбарлах нь гэмт хэрэгтнүүд нийгмийн бүтцэд үзүүлэх хариу үйлдлийг судалсан, нийгмийн сэтгэлзүйн тайлбар ба хуулийн этгээдийн гэмт хэргийн онолоос үүсчээ. Гэхдээ бүхий л онолын чиг хандлагатай адилаар энэхүү онол нь бас хязгаарлагдмал талуудтай байдаг ба энэ талаар одоо авч үзье.

Ялгаатай нөхөрлөлийн онолын хязгаарлагдмал тал

Энэ онолыг туршилтаар үнэлэх гэсэн оролдлого шүүмжлэл (*Braithwaite 1992*) дагуулдаг. Тэдгээр оролдлогоор огт ач холбогдолгүй үр дүн бус холимог үр дүн гарсан. Судалгааны ихэнх нь судалгаа авч болох оролцогчид буюу найз нөхөрлөлийн хүрээнээс гэмт хэрэг үйлдэх арга техникт суралцах нь түгээмэл байдаг (*Hirschi 1969; Farrington 1982; Akers 2011*) эрэгтэй ажилчин ангийнханд төвлөрсөн (*Reiss and Rhodes 1964*) байжээ. Гэхдээ энэ аргын хамгийн том асуудал нь гэмт хэргийг нэг хүчин зүйлээр тайлбарлах Садерландын санаачилгын эцсийн үр дүн нь (*Jones 2006*) байв. Өөрөөр хэлбэл, уг онолоор гэмт зан үйлийн үүсэл гарлыг тайлбарлаж чаддаггүй. Тухайлбал, хэрэв зан үйл, үйлдэл нь өмнө нь байгаагүй бол хэрхэн түүнд суралцсан байх вэ. Мөн энэ онол нь сексийн гэмт хэрэг ба ганцаар үйлдэх олон гэмт хэрэг зэрэг сэтгэл хөдлөлийн гэмт хэргийг тайлбарлаж чаддаггүй. Гудамжны гэмт хэрэг ба костюмтай этгээдийн гэмт

Авлигын криминологи

хэргийн аль алины тайлбар болгон тэгш бус байдлыг авч үзэлгүй (*Braithwaite 1992*) орхидог. Онолын аргачлалынхаа хувьд хоорондоо холбоо хамаарал бүхий олон таамаг дэвшүүлдэг (*дээрээс үз*) боловч гэмт хэрэгтнүүд зан үйлийг хэрхэн суралцдаг талаар дэлгэрэнгүй тайлбар байдаггүй. Түүнчлэн Садерландын бүтээл нь социологи, криминологид маш чухал ач холбогдолтой ч цагаан захтны гэмт хэргийн агуулгыг тодорхой болгоогүй юм. Ажилтан өөрийн байгууллагын төлөө гэмт хэрэг үйлдэх ба байгууллагын төлөө бус өөрийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэхийн ялгааг гаргаагүй.

Гэхдээ институцчилэгдэх, логик үндэслэл гаргах ба нийгэмших үйлдлийн нийлбэр цогц нь юмсыг тайлбарлах ач холбогдолтой байдаг. Үйл явдал/үйлдлийн нөхцөл байдлын үр дагаварыг ялангуяа байгууллагад, ноцтой тохиолдолд хувь хүнд хамаатуулж ойлгох алдаатай хандлагад асуудал (*Ross 1977*) байдаг. Хувь хүн ба ‘менежмент’-ийг буруутгах, ‘муудсан алим’ эсхүл ‘шуналт худалдаачин’ гэх мэт нэр шошго зүүх замаар авлигын бурууг бусад руу чихэхэд амархан. Институцчилэл, логик үндэслэл гаргах болон нийгэмших гурвын орооцолдсон процесс нь хүчирхэг процесс (*Coleman 1998: 196*) юм. Муудсан алим нь торхыг муудуулах бөгөөд ингэсэн тохиолдолд торхыг солих шаардлагатай болно. Өөрөөр хэлбэл тогтолцооны авлигыг зөвхөн тогтолцооны хариу үйлдлээр засах боломжтой. Авлига нэг хоногшвол институцчилэгдэх, логик үндэслэлтэй болох хийгээд нийгэмших процесс нь бизнесийн практикийн улмаас өөрчлөлтийг идэвхтэйгээр эсэргүүцэх чөтгөрийн гурвалыг үүсгэнэ.

Хувь хүмүүс авлига байгаад байна гэдгийг мэдэж болох боловч ихэвчлэн шийдвэрлэх хүчгүй байдаг. Авлигыг нийгэд ил болгохыг оролдсон хүмүүсийг удирдлага нь, эсхүл хамтран ажиллагсад нь (*Near and Miceli 1985; Glazer 1987; Near and Miceli 1996; Mesmer-Magnus and Viswesvaran 2005; Miceli et al. 2013; Brooks et al. 2013a*) сүрдүүлдэг. Аливаа практик

4 Авлигыг тайлбарлах нь: Ялгаатай нөхөрлөлийн онол

институцчилэгдэж мөн логик үндэслэлтэй болбол ажилтнууд түүнийг авлигажсан гэж боддоггүй. Ихэнхдээ уг зан үйлдлийг үргэлжлүүлэх сонирхолтой (*Miceli and Near 1992*) болдог. Авлига ийнхүү өөрийгөө авч явах чадвартай учир зөвтгөхийн аргагүй авлигын үйлдэл гарч, дараа нь олон нийтэд ил болох хүртэл ихэнхдээ түүнийг даван туулах явдал гардаггүй.

Авлигыг үндсээр нь устгахын тулд ихэнхдээ гүн бат тогтсон бизнесийн практикийг өөрчлөх байгууллагын нэлээд том хүчин чармайлт шаардлагатай болох бөгөөд ‘стратегич, эрх мэдэл, бүтэц, тогтолцоо’-г өөрчлөх шаардлагатай (*Tushman and Romanelli 1985:173*) байдаг. Ийм хүчин чармайлтыг гаргахад мэдээж хэрэг тогтолцооны нэг хэсэг, эсхүл асуудлын суурь шалтгаан болж байсан удирдлагын оролцоо, дэмжлэг (*Boeker 1997; Tushman and Romanelli 1985*) хэрэг болно. Институцчилал, логик үндэслэл ба нийгэмшлийн нөлөөг тодорхойлох явдал нь академик дасгал болохын хувьд хэрэгцээтэй боловч практик хэрэглээ нь хязгаарлагдмал юм. Байгууллагын өөрчлөлтийн талаарх ихэнх бүтээлд (*Boeker 1997; Tushman and Romanelli 1985; Zimmerman 2001*) авлигаас сэргийлэхэд ахиц гаргая гэвэл тогтолцооны хэсэг болж байгаагүй гаднын хүмүүсийн оролцоо байх хэрэгтэй хэмээн дурдсан байдаг. Авлигаас урьдчилан сэргийлэх арга барилын талаар баялаг судалгаа байдаг боловч тэр бүгд нь хэрэгжүүлэлт ба өөрчлөлтийг хадгалах тал дээр практик хүндрэлтэй (*Heywood 2015*) тулгардаг.

Хуулийг хэрэгжүүлэхэд тулгардаг чадваргүй, хүсэлгүй эсхүл нарийн төвөгтэй байдлыг дор дурдсан автомашин үйлдвэрлэл, дайны бүсэд хувийн цэргийн гэрээлэгчдийг ашигласан болон олон улсын хуулийг хэрхэн байнга зөрчиж, түүнд саад болж буй жишээгээр үзүүлэв.

Ялгаатай нөхөрлөл: Автомашин үйлдвэрлэлийн салбар дахь авлига

Автомашин үйлдвэрлэлийн салбарын авлига нь одоо ч оршин буй асуудал юм. Энэ нь аюулгүй байдлыг алдагдуулсан, чанаргүй машин үйлдвэрлэх, шударга бусаар өрсөлдөх, зардал бууруулахаар худалдааны төлөөлөгчдөд шахалт үзүүлэх, хаягдал утааг хуурамчаар гаргах технологи нэвтрүүлэх, хууль тогтоомж дүрэм журмыг өөрчлөх, хойшлуулах эсхүл бүр бүхэлд нь хүчингүй болгохоор улс орнуудыг лоббидох зэрэг жишээгээр илэрч байв.

Жишээ нь 1970-аад онд Леонард, Вебер (*Leonard and Weber 1970*) болон Фарберман (*Farberman 1975*) нар АНУ дахь машин үйлдвэрлэлийн салбарын эдийн засгийн зохион байгуулалт нь сэжиг бүхий бизнесийн үйл ажиллагааг хувь худалдааны төлөөлөгчдөөр дамжуулан хүчээр гүйцэтгүүлж байсныг харуулжээ. Шинэ машины нийлүүлэлтийг хянадаг олигополь шинжтэй худалдааны ширүүн дарамт нь тэднийг ийм алхам хийх боломжтой болгож байсан юм. Жишээлбэл, борлуулалтын хэмжээг ихэсгэхийн тулд машинаа ашиггүй хямд үнээр зарахаас өөр аргагүй болоход хүргэх дарамтыг худалдааны төлөөлөгчдийг үзүүлдэг байжээ. Энэ санааг тэд хүмүүсийг хүчээр гэмт үйлдэлд оруулсан гэж шүүмжилсэн бөгөөд үүнийг ‘гэмт хэрэгт хүчилсэн’ (*crime-coercive*) гэж ярих бус ‘гэмт хэрэгт өдөөсөн’ (*crime-facilitative*) гэж ярих нь дээр ч (*Coleman 1992:67*) гэдэг.

Энд бид автомашины салбар дахь ‘гэмт хэрэгт өдөөсөн’ ба ‘гэмт хэрэгт хүчилсэн’ явдлын аль алиныг дагуулдаг орчин үеийн авлигажсан үйлдэлд анхаарах болно. Женерал моторс компани 124 хүнийг үхэлд, 275 хүнийг гэмтэхэд хүргэсэн зарим төрлийн машиныхаа асаах очлуурын асуудлаа нуусан. АНУ-ын Шүүх яам тус компанийг яллахаас түдгэлзэн, 900 сая долларын торгууль тавьсан нь компанийн жилийн орлогын 1 хувиас ч

4 Авлигыг тайлбарлах нь: Ялгаатай нөхөрлөлийн онол

бага байсан бөгөөд ямар ч хувь хүнийг хариуцлагад татаагүй юм. Яллахаас түдгэлзэх тохиролцоог (*deferred prosecution settlement*) Женерал Моторс биелүүлбэл санхүүгийн луйвар ба худал мэдүүлсэнтэй холбогдох эрүүгийн ялыг хойшлуулсан шийдвэрээ хүчингүй болгоно (*Warren 2016*) гэсэн юм.

Волксвагений жишээ ба түүний хаягдал утааны туршилт нь дээр дурдсан институцчилэх, логик үндэслэл гаргах, нийгэмших асуудлын хослолыг харуулна. Волксвагений хэргийн зарим агуулгыг дэлгэрүүлж авч (*Brunsdon and Oliver 2015; Ewing and Bowley 2015; Higgins 2015; Stewart 2015*) үзье. Волксвагенийг Порше болон Пиечийн гэр бүлүүд голчлон эзэмшдэг. Волксвагены захирал асан Фердинанд Пиеч нь Фердинанд Поршегийн ач хүү бөгөөд хэрэг гарахаас өмнө Волксвагены Хяналтын зөвлөлд ноёлж байв. Энэ үедээ цэцэрлэгийн багшаар ажиллаж байсан эхнэрээ хувьцаа эзэмшигчид нь шаардлага хангахгүй, тохирохгүй хэмээн эсэргүүцэж байсан ч үл тоон Хяналтын зөвлөлд оруулсанаас хэр нөлөөтэй байсан нь харагдана.

Порше болон Пиечийн гэр бүл нь бүх хувьцааны болон саналын эрхийн талаас илүүг хянадаг бөгөөд бодлогын асуудлыг шийдвэрлэх, удирдах зөвлөлийн гишүүдийг томилох эрх мэдэлтэй байжээ. 2015 оны байдлаар Порше болон Пиечийн гэр бүл ихэвчлэн саналаа нэг цул байдлаар өгч байсан ба Доод Саксон муж компанийн 20 хувийг, Катар холдинг (улсын баялгийн сан) 17 хувийг эзэмшиж (*Higgins 2015*) байжээ.

Удирдах зөвлөлд гэр бүлүүд, ажилтан/эвлэлийн төлөөлөгчид, Саксон мужийн гишүүд дийлэнх нь байдаг. Уг зөвлөлийг гаднаас ‘үзэл бодол огт эсхүл ховорхон нэвтгэрдэг битүү хөндий’ гэж (*Stewart 2015*) нэрлэдэг. Удирдлагын дарангуйлсан хэлбэр, гадаад орчны асуудлын талаарх үзэл бодол ба явцуурсан гэр бүлийн харилцаатай, Волксвагенаас эдийн засгийн хувьд хамааралтай Доод Саксоны мужийн хувьд

удирдах зөвлөл нь халдашгүй зүйл шиг санагдаж байжээ. Эздүүд болон үйлдвэрчний эвлэлүүд нь хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийн оронд ажил эрхлэлтийг их байлгах тал дээр хамтран ажилласан боловч энэ загвар нь Германд тийм ч онцгой зүйл биш байв. Харилцаа холбоо нь рационалчлагдсан харагддаг тусгаарлагдмал, институцчилэгдсэн бүтэцтэй бөгөөд ажилчдын ялангуяа төрийн албан хаагчид, гэр бүлийн гишүүд, үйлдвэрчний эвлэлийн нийгэмшил нь цогц зан үйл, үйлдлийг сургах хүчирхэг гурвал гэж тооцогдоно. Нийгэмшил нь бүдүүн баараг, эв хавгүй харагддаг ба тусгай соёл гэж тодорхойлогдож байв. Өөрөөр хэлбэл, ‘хөдөлмөрийн хуарангүй л болохоос Хойд Солонгос шиг байсан, тэнд хүн соёлыг дагахаас өөр аргагүй’ (*Ewing and Bowley 2015:17*) байжээ. Тэнд ажилтан ажилдаа үлдэх, эсхүл дээш дэвшихийн тулд тодорхой төрлийн зан үйлийг суралцах ёстой байлаа.

Гэхдээ энэ нь яагаад Волксваген Европын холбоонд одоог хүртэл байсаар, ийнхүү бизнесээ хийж болоод байгааг тайлбарлаж чадахгүй. Тэгвэл Брүнсдэн ба Оливер (*Brunsdan and Oliver 2016*) яагаад гэдгийг тайлбарлажээ. Саяхан машины хаягдал утааг зам дээр болон лабораторид шалгах дараалалд өөрчлөлт орж, ‘унтраах төхөөрөмж’¹⁶-ийг хэрэггүй, утгагүй болгосон юм. Энэхүү санаачилгыг амжилтад хүргэхийн тулд бүх 28 муж энэхүү өөрчлөлтийг батлах ёстой байлаа. Европын холбооны гол машин үйлдвэрлэгчид болох Герман, Испани, Франц, Итали, Британи улсууд энэ өөрчлөлт нь эдийн засагт сөргөөр нөлөөлж, чадварлаг ажилтнуудыг эрсдэлд оруулна хэмээн эсэргүүцсэнд нэг их гайхах зүйл байхгүй. Өөрчлөлт оруулах схемийн арай зөөлрүүлсэн хэлбэр нь батлагдан, 2017 оны есдүгээр сараас хэрэгжихээр болсон бөгөөд аюултай хүхрийн ислийн хязгаарыг давсан хаягдлыг 2020 он хүртэл

16 Автомашин хэрэглээнд очиж зам дээр гарах үед ялгарах утааны хяналтыг зогсоож, унтраах үйлчилгээтэй төхөөрөмж тавьж лабораторийн шалгалтыг зальдаж байсан учир унтраах төхөөрөмж гэж нэрлэгджээ. (Орч.)

хүлээн зөвшөөрч, цаашид энэ хязгаарын хэмжээг 50 хүртэл хувиар давахыг хугацаагүйгээр зөвшөөрсөн аж. Аж үйлдвэр дэх нийт ажиллах хүчний 7 хувьтай тэнцэх ойролцоогоор 12.1 сая хүн ажилладаг автомашин үйлдвэрлэлийн салбар нь Европын холбооны улсуудтай холбоо тогтоосноор эрчим хүчний салбар болон банкны салбартай адилаар хүчрэгдэшгүй салбарт тооцогдож байна.

Энэ нь Европын холбоонд одоо буй бүтцийн улмаас хүндрэл учруулж байна. Машинаас гарч буй бохирдлыг хүрээлэн буй орчны болон үйлдвэрлэлийн салбар хянадаг. Хүрээлэн буй орчны салбар нь нүүрсхүчлийн давхар исэл ба агаарын чанарын асуудлыг хариуцдаг бол үйлдвэрлэлийн салбар нь хүхрийн ислийн асуудал шалгадаг. Хэрэглээнд гарсан автомашиныг шалгадаг тогтолцоо руу шилжихийн тулд энэ хоёр салбарын зөвшөөрөл аль алины зөвшөөрөл шаардлагатай боловч үйлдвэрлэлийн салбар нь Европын холбооны аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилготой байдаг Энэ жишээн дээр Волксвагены зарим хүмүүс Садерландын үзлийн дагуу үйл хөдлөл хийж Европын холбооны дүрэм, журмыг санаатайгаар болон санаатай бусаар зөрчсөн байж магадгүй байна.

Дайны бүс дэх ялгаатай нөхөрлөл: Хувийн цэргийн гэрээлэгчид ба хууль зөрчихийг дэмжих нь

Дайнаас үүдэн гарах санхүүгийн болон хүний хохирол, дайны шинж чанарын өөрчлөлтийн (*жишээлбэл цахим дайн руу чиглэсэн*) улмаас хувийн цэргийн гэрээлэгчдийг¹⁷ зөрчилдөөнт бүс нутагт ашиглах явдал ихэссэн (*Singer 2003, 2004; Rothe and Ross 2010; Brooks et al. 2013a*) байна. Улсууд өөрийнхөө ‘байгууллагын зорилго’-ыг гүйцэлдүүлэхийн тулд

17 Private Military Contractor буюу хувийн цэргийн гэрээлэгч гэдэг нь орчин үеийн мөргөлдөөнт бүс нутагт өргөнөөр ашиглагдах болсон хөлсний цэргийг заасан нэр томъёо юм. (Орч.)

баримталж буй хариуцлагаас зугтах стратеги нь ихэвчлэн өөрөө болон хувийн цэргийн гэрээлэгч гэх гүйцэтгэгч хооронд зай барьж, хууль бус үйл ажиллагаа явуулах (*Green and Ward 2004*) болов. Хувийн хэвшлийн, гэрээт цэргийн эдгээр байгууллагын зорилт нь ойлгож болохоор буюу ашиг олох явдал юм. Тэд ашгийг зөвхөн хүч хэрэглэх, үйлчилгээ, нөөцийг булаан авах замаар олж болох бөгөөд олон улсын хуулийн хариуцлагын сул талыг үүндээ ашигладаг. Энд бид суралцсан зан үйл, ялангуяа хууль зөрчих талаар суралцсан зан үйлд анхаарах болно.

Цэрэг, тагнуул, хамгаалалтын үйл ажиллагаанд хувийн байгууллагыг ашиглах нь улам бүр барууны батлан хамгаалах бодлогын чухал хэсэг болсоор (*Singer 2003*) байна. Афганистан болон Гуантанамо булан дахь АНУ-ын Тагнуулын төв газрын хөлсөлсөн хувийн цэргийн гэрээлэгчдийн үйл ажиллагаа, ялангуяа саатуулах төв дэх үйл ажиллагаа нь үүний цар хүрээг харуулна. Абу Гхрайбын хоригдлуудыг тамласан хэрэгт буруутгагдсан АНУ-ын цэргүүд нь АНУ-ын цэргийн дотоод журам, цэргийн шүүхээр шийтгэгдсэн байна. Эсрэгээрээ гэмт хэрэг үйлдсэн хувийн гэрээлэгчид нь тухайн улсын нутаг дэвсгэрийн харьяалалд хамааран шалгагдах ёстой ч тэд Иракийн орон нутгийн шүүхэд (*Singer and Biverson, 2004*) очилгүй, АНУ дахь шүүхэд дуудагдсан аж. Хувийн цэргийн гэрээлэгчид нь ийнхүү дайны зөрчилдөөнтэй бүсэд цэргийн үйл ажиллагаа явуулж, шийтгэлгүйгээр хууль зөрчиж (*Kierpaul 2008; Jordan 2009*) байна.

Ийм гэрээлэгчид олширсноор тэд дэлхий даяарх зөрчилдөөнтэй газрын гол тоглогчид болж, техник хэрэгсэл нийлүүлж, дайны үйлчилгээ үзүүлж (*Singer 2005:1*) байна. Одоогоор дэлхийд ойролцоогоор хувийн цэргийн 90 гэрээлэгч байгууллага байна гэж тооцдог бөгөөд тэд тээврийн дэмжлэг үзүүлэх, аюулгүй байдлыг хамгаалах, тусгай ажиллагаа, байцаалт, тулаан явуулах зэрэг төрөл бүрийн үйлчилгээ үзүүлж (*Rothe and Ross 2010*) байна. Түүнчлэн, дарангуйлагчид,

цэргийн бүлэглэлүүд, картелүүд, ардчилсан улсууд, НҮБ ба хүний эрхийн болон байгаль орчны байгууллагууд тэднийг хөлслөн үйлчилгээ авдаг. Эдгээр хувийн байгууллагууд нь (*Bechtel, Blackwater, CACI International, DynCorp, Halliburton, Logo Logistics, Titan*) 2001 оны есдүгээр сарын 11-нээс хойш нэлээд өсөж хөгжжээ. Энэхүү хөгжлийн зэрэгцээгээр захиалгат аллага, зэвсгийн худалдаа, НҮБ-ын зэвсгийн худалдааны хоригийг зөрчих, тамлах, хүн алах, залилах, хууль бусаар очир эрдэнэ тээвэрлэх зэрэг гэмт хэрэгт сэжиглэгдсэн үйл ажиллагааг ч илрүүлэх явдал (*Mullins and Rothe 2008; Brooks et al. 2013a*) өссөн.

Гэхдээ бүх хувийн цэргийн гэрээлэгчид ижил биш. Тэдний үзүүлдэг үйлчилгээнд ч ялгагдахуйц онцлог байдаг бөгөөд өөр өөр салбарт үйлдэж буй гэмт хэрэг нь ялгаатай байдаг (*Garmon 2003; Rothe and Ross 2010; Brooks et al. 2013a*). Хувийн цэргийн гэрээлэгчдийн төрөл, эсхүл үзүүлж буй үйлчилгээнээс үл хамааран тэд гэмт үйлдэл гаргах хандлагатай байдаг. Тиймээс хувийн цэргийн гэрээлэгч авлигын үйлдэл гаргаж буй нь хэдийгээр ёс зүйгүй ч гэсэн магадгүй ойлгож болох зүйл юм. Гэхдээ улс орнууд болон тэдний албан тушаалтнууд хувийн гэрээлэгчидтэй хуйвалдан, сүлбэлддэг болохыг Ирак дахь Халлибуртоны хууль зөрчсөн үйл ажиллагаа шиг тохиолдол илүү тод харуулах (*Rothe 2006a, b*) болов уу. Тэдгээр үйл ажиллагаа олон улсын шинжтэй болохын хэрээр гэмт хэрэг нь олон улсын шинж чанартай болж (*Friedrichs and Friedrichs 2002; Kinsey 2006; Rothe et al. 2006; Chesterman and Lehnardt 2007; Singer 2007; Dorn and Levi 2009*) байна. Вайтын (*Whyte 2003*) тэмдэглэснээр улс орнууд болон олон улсын бизнесүүд бие биенээ дэмжих хандлагатай бөгөөд энэ нь олон улсын хөрөнгийн зах зээлийн гол цөмд байдаг. Тухайлбал, ‘байгууллага гэмт хэрэгт оролцох уугуул сонирхол нь байгууллагын өөрийнх нь бүтцэд шингэсэн’ (*Gross 1978:56*) байдаг. Энэ уугуул сонирхол нь капитализм ба олон улсын байгууллагын харилцаанд оршдог. Ашиг олох зорилго

нь тэднийг гэмт хэргийн талаар сэжигтэй байдалд (*Box 1983*) оруулна. Хувийн цэргийн гэрээлэгчид ч ялгаагүй, ашиг олох, өргөжих, хувьцаа эзэмшигчдээ урамшуулах зорилготой байдаг боловч ‘бизнес’-ийнхээ шинж чанарын улмаас гэмт хэрэгт орооцолдож, олон тооны хууль зөрчих илүү магадлалтай байдаг.

Гэмт хэрэг үйлдэхэд хүргэх хамгийн их хамааралтай хүчин зүйл нь хэм хэмжээний үл нийцлийн¹⁸ нөхцөл (*V бүлгийг үз*), хуульгүй нөхцөл, хяналтгүй байдал, нийгмийн зохион байгуулалтгүйдэлтэй холбоотой. Роте, Росс (*Rothe, Ross 2010*) нарын хувьд ийм байгууллагын зорилт нь ашиг, өргөжилт, байгууллагын соёл, харилцааны бүтэц бөгөөд мэдээллийн хяналттай холбоотой байхын зэрэгцээ бүтцийн ба байгууллагын гадаад орчин нь үл нийцсэн, ихээр нийгмийн зохион байгуулалтгүйдэлтэй байх үед бусад хүчин зүйлс хоёрдогч үүрэг гүйцэтгэдэг ажээ. Байгууллагын зорилт ба түүнд хүрэх арга зам хоёрын дунд тасалдал үүссэн, (*Kauzlarich and Kramer 1998*) амжилтад хүрэх хууль ёсны ба хууль бус арга зам хоёрын дунд тодорхойгүй байдал байх үед юу хүлээн зөвшөөрөгдөх вэ, юу хүлээн зөвшөөрөгдөхгүй вэ гэдгийг үнэлэхэд хэцүү (*Passas 1990*) болно. Улмаар хууль зөрчихийг дэмжихгүй өгүүлэмжийн оронд хууль зөрчихийг хүлээн зөвшөөрөх явдал газар авах нь мэдээж. Энэ бол ялгаатай нөхөрлөлийн түлхүүр зарчим юм.

Роте, Росс (**2010**) нар хууль дүрэмгүй, улс орны болон олон улсын зохицуулалт, стандартууд хэм хэмжээгүй нөхцөл байдалд орсон үед хувийн цэргийн гэрээлэгчид ‘бизнесээ хийдэг’. Тийм учраас гэмт хэргийн зан үйл гэх мэт Садерландын дэвшүүлсэн

18 Нийгмийн шинжлэх ухаанд аномн байдал (anomie) гэж орчуулдаг ойлголт бөгөөд ёс зүйн үнэт зүйл, стандарт, чиглүүлэх зүйлгүй болсон нөхцөл байдлыг заасан нэр томъёо юм. Уг нэр томъёог анх Дюркейм гаргахад, үл нийцэл гэсэн санаа агуулагдаж байсан хэмээн үзэж, дагаж мөрдөх хэм хэмжээнд хүмүүс татагдахгүй байгаа буюу хувь хүний хэм хэмжээ нь нийгмийн хэм хэмжээтэй үл нийцэж байгаа гэдэг агуулгаар ийнхүү орчуулав. (Орч.)

4 Авлигыг тайлбарлах нь: Ялгаатай нөхөрлөлийн онол

олон зарчим ойрын, жижиг бүлэг хүмүүс (армийн нэгж) дунд гардаг гэж үзсэн байна. Тийм гэмт хэрэг нь:

(a) гэмт хэрэг үйлдэх энгийн эсхүл нарийн төвөгтэй техник,

(b) гэмт хэргийг зөвтгөх тайлбар, сэдэл, хандлага, төлөвлөгөөг агуулна. Дайны бүсэд ёс зүйгүй нөхцөл байдалд ажиллах үедээ гаргасан хэдэн цадиггүй зөрчилд нь тэдгээр гэрээлэгчдийн төлж чадахааргүй их торгуулийг ногдуулснаар хууль зөрчихийг дэмжихгүй өгүүлэмжээс дэмжсэн өгүүлэмж нь даван гарна. Тиймээс ялгаатай нөхөрлөл нь хувь хүн ба байгууллагын ажиллаж буй нөхцөл байдал, агуулгаас хамааран давтамж, үргэлжлэх хугацаа, тэргүүлэх чиглэл, нягтшилтаараа ялгаатай байж болно. Хувийн цэргийн гэрээлэгчийн хувьд дайны бүсэд ажиллах, эсхүл дарангуйлагчийн төлөө ажиллахын тулд ихэвчлэн мөрдөх ёстой хуулиудыг зөрчдөг.

Энэ нь хувийн цэргийн гэрээлэгчдийг гэмт хэрэгт хүргэсэн нөхцөл, байдлыг ойлгоход чухал үүрэгтэй. Энэ нь зарим хувийн цэргийн гэрээлэгчдийг хамгаалах гэсэн оролдлого бус тэдний үйл ажиллагааны онцлог, шинжийг ойлгох гэсэн оролдлого юм. Нийгмийн зохион байгуулалтгүй орчин нь гэмт хэрэгт уруу татах хүчтэй (*Rothe and Mullins 2009*) нөлөөтэй. Үүнийг колонийн дарлал нь уламжлалт хамтын нэгдлийн бүтцийг устгасан бүс нутагт цэргийн бүлэглэлүүд үүсэж, оршин буйг нийгмийн зохион байгуулалтгүйдлээр тайлбарлаж (*Rothe and Mullins 2008*) ирсэн. Зохион байгуулалтгүй орчин нөхцөл нь Зөвлөлт Холбоот Улсын задралын дараа бий болсон янз бүрийн түвшний зохион байгуулалт бүхий гэмт хэргийн компаниудыг үүсгэх илэрхий хандлагатай (*Rothe and Mullins 2008*) байдаг. Тэгэхээр нийгмийн зохион байгуулалтгүйдэл нь хөршүүд нь нийгмийн албан бус хяналтыг бий болгосон ч үүнийгээ дэмжих чадвар нь сул байх юм бол гэмт хэрэг өсөхийг (*Bursik and Grasmick 1993; Shaw and McKay 1942*) харуулна. Энэ нь төрөөс гадуур цэргийн бүлэглэлүүд үүсэж, эсхүл төрд хөлслөгдсөн

байдалтай иргэний дайнд хүрсэн нийгмийн ноцтой зохион байгуулалтгүйдэл бүхий хар тамхичдын улсын (*narco-state*) статустай Мексик зэрэг газар нутагт ч (*Bailey and Taylor 2009; Grayson 2011; Rhos 2013*) хамааралтай. Туйлын ядуурал, дэд бүтэцгүй байх, нийгмийн институцүүдийн чадавхийн доройтол нь нийгмийн эмх замбараанд илэрхий вакуум үүсгэдэг. Тийм нөхцөл байдалд хувийн цэргийн гэрээлэгчид ба зохион байгуулалттай гэмт хэрэг өсөж, хууль зөрчихийн зэрэгцээ нэг төрлийн эмх замбарааг бий болгохыг оролддог.

Гэхдээ эх захгүй байдал дундаас эмх цэгц тогтдог. Тухайлбал, дайны бүс дэх хувийн цэргийн гэрээлэгчид ‘хамтрагчид’-тайгаа нэгдэн өндөр зохион байгуулалтад орж, магадгүй амьд үлдэхийн төлөө гэдэг нэрийн дор зан үйлийг суралцах, улмаар гэмт үйлдлийг зөвтгөн, логик үндэслэл гаргадаг. Хууль зөрчих боломжтой нөхцөл байдалд, хууль зөрчихийг буруутгасан өгүүлэмжийн оронд түүнийг хүлээн зөвшөөрөх хандлага давамгайлах бөгөөд ийм тогтвортой бус орчинд ажиллах хүлээлт нь гэмт хэрэгт хүргэдэг. Энэ нь хувийн цэргийн гэрээлэгчдийн хувьд уугуул зөрчилдөөн болдог (*Brooks et al. 2013a*) байна. Ихэнх байгууллагын хувьд албан ёсны хяналт, хууль, журам байдаг боловч эдгээр нь хэрэгжих үү, үгүй юу гэдэг нь өөр асуудал юм. Хэрэгжилтийн асуудал нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр шуугих, эсвэл тэдний хууль зөрчсөн үйлдлийг нуун дарагдуулах улс төрийн дарамт шахалт байсан эсэхээс хамаарсан асуудал болно. Гэхдээ хувийн цэргийн гэрээлэгч ажиллагааг бүтэлгүйтүүлэх, эсхүл амласан ‘үйлчилгээ’-г хүргэж чадахгүй байх нь ирээдүйд хийх гэрээний тоог ихээр бууруулна. Тиймээс ажиллагаагаа амжилттай гүйцэтгэх, үйлчилгээг үзүүлэх нь ирээдүйд олж авах гэрээ болон ашиг олох боломжийг өсгөнө. Ямар ч төрлийн бизнест байдаг шиг ялгаатай нөхөрлөл нь хууль бус үйлдэл гарахад хүргэнэ.

Дүгнэлт

Энэ бүлэгт дурдагдаж буй цагаан захтнууд яагаад гэмт хэрэг үйлддэг талаарх Садерландын онол нь автомашин үйлдвэрлэлийн салбар, хувийн цэргийн гэрээлэгчид ба бусад асуудлуудын жишээн дээр өдийг хүртэл ашиглагдсаар байгааг уншигч та анзаарсан байх. Энэ номд дурдсан бүхий л онолын тайлбартай адилаар энэхүү онолд мөн хязгаарлагдмал тал бий. Энэ нь уг онолыг бүрэн үгүйсгэнэ гэсэн хэрэг бус түүний хөгжлийг ялангуяа институцчилэл, логик үндэслэл, нийгэмшлийн хослол гэсэн цагаан захтны гэмт хэргийн соёлын элемент болохын хувьд харна гэсэн үг. Хувийн цэргийн гэрээлэгч нь ялгаатай нөхөрлөлийн ердийн бус жишээ боловч тэдгээр нь өргөн тархаж буй учир анхааран авч үзлээ. Машин үйлдвэрлэлийн салбарыг бид ажил эрхлэлт ба тээврийн тал дээр найдлага тавьж хардаг бизнес боловч доголдолтой машины үйлдвэрлэл, түүнээс гарч буй бохирдол нь хувь хүмүүс, байгаль орчинд хохирол учруулж байна. Авлигаас урьдчилан сэргийлэх бодлогын жор хязгаарлагдмал боловч дэвшүүлэх нэг санал (*VII ба XI бүлгээс дэлгэрэнгүйг үз*) бий. Энэ бол асуудлын хууль зүйн шийдэлд удирдлагууд хувиараа хариуцлага хүлээдэг болгох явдал юм. Ингэснээр хэрэв олон нийтийн компани бус хувийн эзэмшлийн компани байвал аливаа байгууллага дахь хувь эзэмшигчид нь хуулийн хариуцлагатай, сахилга баттай болж, хуулийг дагаж мөрдөх соёл сайжрах болно. Хэрэв дотоод болон гадаад зохицуулалт үр дүнгүй нөхцөлд, хувь хүмүүс санхүүгийн торгуулийн зарим хувийг төлөх гэрээтэй болчих юм бол дураараа аашилдаг хүмүүсийг хянах боломжтой болгохын зэрэгцээ хууль зөрчихийг дэмжсэн өгүүлэмж хүлээн зөвшөөрөгдөхгүй байх соёлыг нэмэгдүүлж болох юм.

Ашигласан материал

- Ashforth, B. E., & Anand, V. (2003). The normalization of corruption in organizations. *Research in Organizational Behavior*, 25, 1–52.
- Akers, R. L. (2011). *Social learning and social structure: A general theory of crime and deviance*. Transaction New Brunswick, NJ: Publishers.
- Bailey, J., & Taylor, M. M. (2009). Evade, corrupt, or confront? Organized crime and the state in Brazil and Mexico. *Journal of Politics in Latin America*, 1 (2), 3–29.
- Boeker, W. (1997). Strategic change: The influence of managerial characteristics and organizational growth. *Academy of Management Journal*, 40 (1), 152–170.
- Box, S. (1983). *Power, crime and mystification*. London: Routledge.
- Braithwaite, J. (1985). White Collar Crime. *Annual Review of Sociology*, 11 (1), 1–25.
- Braithwaite, J. (1988). White-collar crime, competition and capitalism: Comment on Coleman. *American Journal of Sociology*, 94, 628–632.
- Braithwaite, J. (1992). Penalties for white collar crime. In P. Grabosky (Ed.), *Complex commercial fraud*. Canberra: Australian Institute of Criminology.
- Brooks, G., Azeem, A., and Button, M. (2013a). *Fraud, Corruption and Sport*. Basingstoke: Palgrave.
- Brunsdon, J., & Oliver, C. (2015, January 18). Noxious omissions. *The Financial Times*, p. 7.
- Brunsdon, J., & Oliver, C. (2016). Noxious omissions. *Financial Times*, Monday January 18, 7.

- Bursik, R. J. Jr., & Grasmick, H. G. (1993). Economic deprivation and neighborhood crime rates 1960–1980. *Law and Society Review*, 27 (2), 276–280.
- Chesterman, S., & Lehnardt, C. (2007). *From mercenaries to market: The rise and regulation of private military companies*. Oxford: Oxford University Press.
- Clinard, M., & Yeager, P. (1980). *Corporate crime*. New York: Free Press.
- Clinard, M. B. (1979). *Corporate crime*. Washington, DC: Government Printing Office.
- Coleman, J. W. (1985). *Utopia on trial*. London: Shipman.
- Coleman, J. W. (1992). The theory of white-collar crime: From Sutherland to the 1990s. White-collar crime reconsidered. In K. Schlegel & D. Weisburd (Eds.), *White collar crime reconsidered*. York, PA: The Maple Press.
- Coleman, J. W. (1998). *The criminal elite: Understanding white-collar crime* (4th ed.). New York: St. Martin's Press.
- Cressey, D. (1953). *Other people's money: A study in the social psychology of embezzlement*. New York: Free Press.
- Dorn, N., & Levi, M. (2009). Private–public or public–private? Strategic dialogue on serious crime and terrorism in the EU. *Security Journal*, 22 (4), 302–316.
- Eichenwald, K. (1995). *Serpent of the rock*. New York: Harper Business.
- Ewing, J., & Bowley, G. (2015, December 15). At Volkswagen, an environment that sowed the seeds of forceful ambition. *International New York Times*, p. 17.
- Faberman, H. A. (1975). A criminogenic market structure; the automobile industry. *Sociology Quarterly*, 16, 438–457.

Авлигын криминологи

- Farrington, D. (1982). Longitudinal analyses of criminal violence. In M. Wolfgang & N. Weiner (Eds.), *Criminal violence*. Beverly Hills, CA: Sage.
- Friedrichs, D. O., & Friedrichs, J. (2002). The World Bank and crimes of 'lobalization: A case study. *Social Justice*, 29 (1/2), 15–37.
- Garmon, T. (2003). Domesticating international corporate responsibility: Holding private military firms accountable under the Alien Tort Claims Act 11. *Tulane Journal of International and Comparative Law*, 11, 325–328.
- Glazer, M. (1987). Whistleblowers. In M. D. Ermann & R. J. Lundman (Eds.), *Corporate and governmental deviance: Problems of organizational behavior in contemporary society*. New York: Oxford University Press.
- Gobert, J., & Punch, M. (2000). Whistleblowers the public interest and the Public Interest and Disclosure Act 1998. *The Modern Law Review*, 63 (1), 25–54.
- Grayson, G. W. (2011). *Mexico: narco-violence and a failed state?* New Brunswick, NJ: Transaction Publishers.
- Green, P., & Ward, T. (2004). *State crime, governments, violence and corruption*. London: Pluto Press.
- Gross, E. (1978). Organizational crime: A theoretical perspective. In N. K. Denzin (Ed.), *Studies in symbolic interaction*. Greenwich, CT: JAI Press.
- Heywood, P. M. (2015). *Routledge handbook of political corruption*. Abingdon: Routledge.
- Higgins, A. (2015). Why Europe failed to halt emissions ruse. *International New York Times*, Wednesday, September 30, 16.

- Hill, C., & Painter, R. W. (2015). *Better bankers, better banks*. Chicago: University of Chicago Press.
- Hirschi, T. (1969). *Causes of delinquency*. Berkeley, CA: University of California Press.
- Hirschi, T., & Gottfredson, M. (1987). Causes of white collar crime. *Criminology*, 25 (4), 949–974.
- Hough, D. (2015). *Corruption, anti-corruption and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Ivory, D., & Tabuchi, H. (2015). Takata no to fund for airbag defect toll. *International New York Times*, Saturday-Sunday, July 11–12, 9.
- Jensen, C. & Ivory, D. (2015). Cars with faulty airbags are recalled once more. *International New York Times*, Monday, February 2, 16.
- Jones S. (1986). *Criminology*. Oxford: Oxford University Press.
- Jones, S. (2006). *Criminology* (3rd ed.). Oxford: Oxford University Press.
- Jordan, C. S. (2009). Who will guard the guards? The accountability of private military contractors in areas of armed conflict. *New England Journal of Civil and Criminal Confinement*, 35 (2), 309–336.
- Kauzlarich, D., & Kramer, R. (1998). *Crimes of the American nuclear state: At home and abroad*. Boston: Northeastern University Press.
- Kierpaul, I. (2008). The mad scramble of congress, lawyers and law students after Abu Ghraib: The rush to bring private Military contractors to justice. *University of Toledo Law Review*, 39, 407–442.

Авлигын криминологи

- Kinsey, C. (2006). *Corporate soldiers and international security: The rise of private military companies*. Abingdon: Routledge.
- Lane, R. E. (1954). *The regulation of businessmen: Social conditions of government economic control*. New Haven, CT: Yale University Press.
- Leonard, W. N., & Weber, M. G. (1970). Automakers and dealers: A study of criminogenic market forces. *Law and Society Review*, 4 (3), 407–424.
- Lilly, R. J., Cullen, F. T., & Ball, R. A. (1989). *Criminological theory: Context and consequences*. Thousand Oaks, CA: Sage Publications.
- Mesmer-Magnus, J. R., & Viswesvaran, C. (2005). Whistleblowing in organizations: An examination of correlates of whistleblowing intentions, actions, and retaliation. *Journal of Business Ethics*, 62 (3), 277–297.
- Miceli, M. P. & Near, J. P. (1992). *Blowing the Whistle: The Organizational and Legal Implications for Companies and Employees*. New York: Lexington Books.
- Miceli, M. P., Near, J. P. and Dworkin, T.M. (2013). *Whistle-blowing in organizations*. Abingdon: Routledge.
- Mullins, C. W., & Rothe, D. L. (2008). Gold, diamonds and blood: International state-corporate crime in the Democratic Republic of the Congo. *Contemporary Justice Review*, 11(2), 81–99.
- Near, J. P., & Miceli, M. P (1985). Organizational dissidence: The case of whistle-blowing. *Journal of Business Ethics*, 4 (1), 1–16.
- Near, J., & Miceli, M. (1995). Effective whistleblowing. *Academy of Management Review*, 20 (3), 679–708.

- Near, J. P., & Miceli, M. P. (1996). Whistle-blowing: Myth and reality. *Journal of management*, 22 (3), 507–526.
- Nixon, R., Ivory, D., & Tabuchi, H. (2015). Takata's side airbags could expand recalls. *International New York Times*, Saturday-Sunday, October 24–25, 13.
- Oliver, C. (1992). The antecedents of deinstitutionalization. *Organization Studies*, 13 (4), 563–588.
- Passas, N. (1990). Anomie and corporate deviance. *Crime, Law and Social Change*, 14 (2), 157–178.
- Perrow, C. (1972). *Complex organizations*. New York: Scott Foresman.
- Poveda, T. G. (1994). *Rethinking white-collar crime*. Westport, CT: Praeger.
- Reiss, A., & Rhodes, A. (1964). An empirical test of differential association theory. *Journal of research in Crime and Delinquency*, 1, 5–18.
- РНОС, V. (2013). Why did Mexico become so violent? A self-reinforcing violent equilibrium caused by competition and enforcement. *Trends in organized crime*, 16 (2), 138–155.
- Ross, L. (1977). The intuitive psychologist and his shortcomings: Distortions in the attribution process. In L. Berkowitz (Ed.), *Advances in experimental social psychology*. New York: Academic Press.
- Rothe, D. L. (2006a). Iraq and Halliburton. In R. Michalowski & R. Kramer (Eds.), *State corporate crime: Wrongdoing at the intersection of business and government*. Piscataway, NJ: Rutgers University Press.
- Rothe, D. L. (2006b). Halliburton. In E. Jensen (Ed.), *Encyclopedia of white collar crime*. Santa Barbara, CA: Greenwood.

- Rothe, D. L., & Mullins, C. W. (2009). Toward a criminology of international criminal law: An integrated theory of international criminal violations. *International Journal of Comparative and Applied Criminal Justice*, 33 (1), 97–118.
- Rothe, D. L., Muzzatti, S., & Mullins, C. W. (2006). Crime on the High Seas: Crimes of globalization and the sinking of the Senegalese Ferry Le Joola. *Critical Criminology: An International Journal*, 14 (3), 159–180.
- Rothe, D. L., & Ross, J. I. (2010). Private military contractors, crime, and the terrain of unaccountability. *Justice Quarterly*, 27 (4), 593–617.
- Shaw, C., & McKay, H. D. (1942). *Juvenile delinquency and Urban areas*. Chicago: University of Chicago Press.
- Singer, P. W. (2003). *Corporate warriors: The rise of the privatized military industry*. London: Cornell University Press.
- Singer, P. W. & Bason, L. (2004). *The Private Military Industry and Iraq: What have we learned and where to next?* Geneva: Geneva Centre for the Democratic Control of Armed Forces.
- Singer, P. W. (2005). Outsourcing war. *Foreign Affairs*, 84 (2), 119–132.
- Singer, P. W. (2007). *Can't Win with 'em, Can't go to War without 'em: Private Military Contractors and Counterinsurgency*. Washington, DC: Brookings Institution.
- Slapper, G., & Tombs, S. (1999). *Corporate crime*. Essex: Pearson.
- Staw, B. M., & Sz wajkowski, E. (1975). The scarcity-munificence component of organizational environments and the commission of illegal acts. *Administrative Science Quarterly*, 20 (3), 345–354.

- Stewart, J. (2015, September 26). VW problems started with the boardroom. *International New York Times*, p. 1.
- Sutherland, E. H. (1939). *Principles of criminology* (3rd ed.). Philadelphia, PA: Lippincott.
- Sutherland, E. H. (1940). White collar criminality. *American Sociological Review*, 5, 1–12.
- Sutherland, E. H. (1947). A theory of crime: Differential association. *Crime: Readings*, 1, 170–172.
- Sutherland, E. H. (1949). *White collar crime*. New York: Dryden Press.
- Sykes, G. M., & Matza, D. (1957). Techniques of neutralization: A theory of delinquency. *American Sociological Review*, 22, 664–670.
- Tushman, M. L., & Romanelli, E. (1985). Organizational evolution: A metamorphosis model of convergence and reorientation. In L. L. Cummings & B. M. Staw (Eds.), *Research in organizational behavior*. Greenwich, CT: JAI Press.
- Vlasic, B. (2015). Fiat Chrysler fined for recall failures. *International New York Times*, Tuesday, July, 28, 14.
- Warren, E. (2016). *Rigged Justice 2016: How weak enforcement lets off offenders of easy*. Washington: Office of United States Senate, Office of Elizabeth Warren.
- Whyte, D. (2003). Lethal regulation: State-corporate crime and the United Kingdom government's new mercenaries. *Journal of Law and Society*, 30 (4), 575–600.
- Zimmerman, J. (2001). Effects of Bureaucratization on Corruption, Deviant and Unethical Behavior in Organizations. *Journal of Managerial Issues*, 13 (1), 119–128.

Zucker, L. G. (1977). Where do institutional patterns come from? Organizations as actors in social systems. In L. G. Zucker (Ed.), *Institutional patterns and organizations: Culture and environment*. Cambridge, MA: Ballinger.

V

Авлигыг тайлбарлах нь: ‘Орчин үеийн’ дэлхий ертөнцөд дарамтыг мэдрэх нь

Удиртгал

Мертоны бүтээл (*Merton 1938*) болон гэмт хэргийн шалтгааны талаарх түүний тайлбар нь нийгэм, эдийн засгийн хямралын үед хүмүүс хэм хэмжээнд үл нийцсэн зүйл боддог гэсэн Дюрхэймийн (*Jones 2006*) бүтээлд суурилсан аж. Хүний хүсэл хоол хүнс, орон байр руу чиглэсэн байх үед (*Масловын шаталсан хэрэгцээний дарааллыг үз*) нийгмийн бүтэц дэх гэнэтийн өөрчлөлт нь нийгмийн зохицуулалтыг бууруулахад хүргэж, улмаар нийгмийн хямралт байдлыг өсгөдөг байна. Гэхдээ Мертоны хувьд ‘Америк мөрөөдөл’-д хүрэх хууль ёсны боломж дутмаг байвал баялгийн төлөөх туйлын зорилго нь түүнд хүрч эс чадах хүмүүсийн хувьд хууль бус аргаар амжилтад хүрэх, энэ зам руу урин дуудагдах утгыг илэрхийлнэ. АНУ-д баялаг олж авах нь хүсэл эрмэлзлээс илүүд тооцогдож байсан бөгөөд энэ нь одоо ч хэвээр, баялаг нь хувь хүний үнэ цэн, нийгмийн байр суурьтай ижилд (*Jones 2006*) тооцогддог. Баялгийн төлөөх соёлоос үүдэлтэй шунал хийгээд амжилтад хүрэх боломж хоёрын зөрүү нь дарамтыг (*strain*) төрүүлдэг.

Соёлоос үүдсэн материаллаг баялаг хөөх зорилго ба түүнд хууль ёсоор хүрч болох боломжтой холбоотой дарамт нь энэ бүлгийн гол сэдэв байх бөгөөд Мертон (1938), Агню (Agnew 1992), Шопфер, Пикүэро (Schoepfer and Piquero 2006), Лангто, Пикүэро (Langton and Piquero 2007) нарын бүтээлд дурдсан зүйлд бид анхаарал хандуулах болно.

‘Орчин үеийн’ дэлхий ертөнцөд дарамтыг мэдрэх нь

Мертоны (1938) авч үзсэн АНУ-ын нийгмийн бүтцийн тэгш бус байдал нь бүх хүнд дарамт ижил нөлөөлөхгүй гэсэн санааг агуулдаг байна. ‘Америк Мөрөөдөл’-д бие, сэтгэлээ зориулах байдал нь хувь хүн мөрөөдөлдөө өөрийгөө зориулах эрч хүч болон түүнд хүрэх институцийн арга хэрэгслээс хамаарна. Тэрхүү арга хэрэгсэл нь протестант шашны ажлын ёс зүй, боловсрол, шударга байдал, дур хүслээ дарах явдалд үндэслэсэн байдаг. Гэхдээ эдгээр нь соёлын хувьд нэг талыг барьсан бөгөөд хүн бүхэнд нээлттэй байгаагүй. Эд баялагтай болох нь тухайн соёлын туйлын зорилго байх үед зарим хүмүүс түүнд хүрч эс чадах нь зайлшгүй агаад түүнд хүрэх өөр арга хайх болно. Амжилтын мөнгөн хэмжүүр нь бусад бүхий л хэмжүүрийг даван гарна. Боловсролыг хувь хүний хөгжлийн арга зам гэж харахын оронд аятайхан ажилд орох, өндөр орлого олох арга гэж үзэх бөгөөд ийм тохиолдолд боловсролын жинхэнэ үнэ цэн үгүй болно. Түүнээс гадна хэрэв гэр бүлийн амьжиргааг залгуулах үйлдлийг ажил эрхлэлт хэмээн тооцлоо ч цалинтай ажил эрхлэлтээс доогуур хэлбэрийн ажил эрхлэлт гэж тооцож улмаар хүмүүс нэг нэгнээ хэрэглээгээр тодорхойлоход (Orru 1990; Jones 2006) хүрдэг.

АНУ-ыг бусад үйлдвэржсэн орнуудаас ангид болгодог хоёр ялгаатай шинж чанар байдаг гэж (Schoepfer and Piquero

2006) ярьдаг. Үүний нэг нь Америк мөрөөдлийг соёлын хувьд онцлох, нөгөө нь АНУ дахь гэмт хэрэг маш өндөр хувьтай (*харьцангуй тогтвортой*) байдаг явдал юм. Эдгээр ялгааны шалтгааныг олохын тулд Месснер ба Росенфелд (1994) институцийн үл нийцлийн онолыг (*institutional anomie theory*) боловсруулжээ. Тэд Америк соёл нь хязгаарлагдмал нөөцийн төлөөх өрсөлдөөний хэлбэрээр хувь хүний мөнгөн амжилтаар торлогдож, баригдсан байна гэж үзсэн. Эл байдал нь эдийн засагт хэт анхаарах байдлыг өсгөн, улмаар хувь хүмүүсийг бид 'хэн бэ гэдгээр бус, хэн юу хэрэглэж, худалдаж авч байгаа'-гаар үнэлэхэд хүргэнэ. Гудамжны гэмт хэрэг болон цагаан захтнуудын гэмт хэрэг хэдийгээр хоорондоо нэлээд ялгаатай боловч нийгмийн гарал, статусын шинж чанар, ихэвчлэн санхүүгийн амжилтаар хэмжигддэг 'Америк мөрөөдөл'-ийн соёлын суурь онцлог нь яагаад нийгмийн ялгаатай гарал бүхий хүмүүс гэмт хэрэг хийдэг вэ гэдэг дээр нэгдмэл тайлбар өгдөг (Weisburd et al. 1991; Benson and Moore 1992; Benson and Kerley 2001) ажээ. Түүнчлэн мөнгөн амжилтад хязгаар үгүй. Яагаад гэвэл илүү их мөнгө, баялаг олж авах боломж үргэлж (Messner and Rosenfeld 2001) байдаг. Тиймээс мөнгөн амжилт нь баян ба ядуу хүмүүсийн аль алиныг ялгаагүй сэдэлжүүлнэ.

Мертон (1938) хүмүүс баялаг олж авах энэхүү дарамтад хариу үзүүлэх таван боломжийг анх боловсруулсан бөгөөд үүнд дуулгавартай байх, инновац хийх, ёслол хийх, хойш суух, бослого гаргах багтдаг. Эдгээрийн талаар товч авч үзье.

Дуулгавартай байх: Энэ нь амжилтад хүрэх эсэхээс үл хамааран оролдлого хийсээр байдаг хүмүүст хамаатай. Дундаж давхрааны зарим хэсэг болон баялагт итгэдэг нийгмийн бүтцийн зарим хэсэг нь хүмүүсийн соёлын хүлээлтийг дагахад уруу татсаар байна. Мертон (1938) тэмдэглэхдээ хэрэв хүмүүс тэгж оролддоггүй байсан бол албан ёсны гэмт хэргийн статистик хэт өндөр байх байсан юм гэжээ. Гэмт хэргийн түвшин нь бодит гэмт хэргийн хязгаарлагдмал хэмжүүр болдгийг ойлгож болохоор

авч, уг түвшин нь нийгэм дэх гэмт хэргийн нарийвчлалтай бус хэмжүүр болдог нь *(Coleman and Moynihan 1996)* нуугдмал болон авлигын гэмт хэргийн хувьд бүр ч тодорхой *(Brooks et al. 2013)* харагддаг.

Инновац хийх: Энэ нь материаллаг баялагт хүрэх туйлын зорилгыг хүлээн зөвшөөрөх боловч түүнийг олж авах байгууллын арга хэрэгслээс таггалзах явдал юм. Мертоны хувьд амжилт нь боловсрол болон ажил эрхлэлтийн хүрээн дэх институцийн хууль ёсны замаар хязгаарлагдаж байв. Тиймээс энэ бүтцийн тэгш бус байдал нь боломжийн хүрээг хязгаарлаж, яагаад ядуу хүмүүс ихэнх гэмт хэргийг *(эсхүл бүртгэгдсэн гэмт хэрэг)* үйлддэгийг тайлбарласан. Улмаар өндөр карьерт хүрэх хязгаарлагдмал хууль ёсны боломж нь хүмүүсийг Америк мөрөөдөлд хүрэхийн тулд гэмт ‘хэрэг рүү түлхдэг’ аж. Мөн Мертоны үзсэнээр хүмүүс цагаан захтны гэмт хэрэг үйлддэг бөгөөд ямар нэг шийтгэл байхгүй бол ийм үйлдэл гаргасаар байна. Учир нь энэ төрлийн гэмт хэрэг нь амжилтад хүрэх хамгийн үр ашигтай арга байдаг ажээ. Гэвч энэ нь хэрхэн хүрснээс үл хамааран баялагт зорих соёл бат бөх тогтож, хүмүүсийг инновацлаг, авлигажсан үйлдэлд уруу татах үед л боломжтой.

Ёслол хийх: Энд туйлын зорилго болох материаллаг баялгийг үгүйсгэхгүй боловч түүнийг умартаж, арга хэрэгсэлд анхаарлаа хандуулдаг хүмүүст *(Jones 2006)* хамаатай. Энэ бүлгийн хүмүүс соёлын амжилтаас үр дүнтэй зайлсхийдэг. Тэд магадгүй төрийн байгууллага дахь институцийн арга замыг дагах замаар бага зэрэг амжилтад хүрэх боловч өсөн дэвжих ямар ч итгэлгүй, мөн олж авсан жаахан юмаа алдахаас айдаг байна. Бас тэд амжилтад хүрэх эрсдэлээс илүү бүтэлгүйтэх магадлалаас айдаг. Мертон тэдгээр хүмүүсийг ‘аймхай албат’ гэж нэрлэжээ.

Хойш суух: Энд ухамсар зэрэг дотоод дарамт шахалтын улмаас баялгийн төлөөх туйлын зорилго болон түүнд хүрэх арга замаас татгалздаг хүмүүс багтана. Энэ ангиллын хүмүүсийн татгалзах сэтгэлгээг соёлоос татгалзаж байна хэмээн үзэхгүй боловч түүнд хүрэх төлөв байдлаас татгалздаг гэж Мертон үзэж байв. Энэ утгаараа хүмүүс нийгэмд оршин байгаа хэдий ч түүний нэг хэсэг байдаггүй бөгөөд хэрэв тэд гэмт хэрэг үйлдвэл тэр нь өөрийнхөө байр суурийг хадгалах болон хэрэгцээнээс үүдсэн байдаг.

Бослого гаргах: Энэ нь баялаг хуримтлуулах туйлын зорилго болон түүнд хүрэх арга замаас татгалзаж, тэдгээрийг өөр зорилго, арга хэрэгслээр орлуулдаг хүмүүст хамаатай. Хүмүүс ертөнцөөс бүрэн тасарч, заримдаа оюун санааны шалтгаанаар хөндийрч болох ч хорлон сүйтгэх үйлдэл мөн хийж болно.

Эдгээр тайлбар нь хувь хүний хэв шинжийн тодорхойлолт биш боловч хүмүүс дарамтын дор ямар хариу үйлдэл гаргаж болохыг тайлбарладаг. Гэхдээ хариу үйлдэл нь хоорондоо ялгаатай байна гэсэн үг биш. Төрийн албан хаагч (*ёслол хийдэг*) ажил олгогчоосоо хулгай хийж (*инновац гаргаж*), заримдаа согтууруулах ундаагаар цэнгэж (*хойш сууж*) (*Jones 2006*) болно. Түүнээс гадна эдгээр тайлбар нь хүмүүс гэмт хэрэг хийх сонголт хийдэг гэсэн үг биш. Инновацлаг хүн хууль бус биш боловч ёс зүйн хувьд буруушаамаар үйлдэл гаргаж болно.

Олон эрдэмтэд дарамтын онолыг авч, өөрчилсөн (*Dubin 1959; Cloward and Ohlin 1960; Albert Cohen 1965; and Elliot and Voss 1974*) боловч хамгийн анхаарал татахуйц нь Агнью (*1992*), Шопфер, Пикүэро (*2006*), Лангтон, Пикүэро (*2007*) нарын бүтээл юм. Агньюгийн (*1992, 1995, 2001*) хувьд дарамт нь хувь хүнээс хүлээгдэх тэмүүлэл болон соёлын хүлээлтэд хүрэхээс илүү зүйл юм. Тэрээр Ерөнхий дарамтын онолоо (*General strain theory*) танилцуулахдаа **дарамт нь:** хүссэн зорилгодоо хүрч чадахгүй бүтэлгүйтэх, эсхүл хувь хүний

хэр хэмжээнээс хэтэрсэн зүйлийг хэрэглэхээс үүддэг бөгөөд ажил дээрээ эсхүл гэртээ гаргасан шударга бус шийдвэр, мөн хайртай хүмүүсийн үхэл, шинэ газар руу нүүх, эсхүл гэр бүл, хамтран ажиллагсадтайгаа муу харилцаатай байхаас, эсхүл бие махбодын өвдөлт, шийтгэл, доромжлол, эсхүл сэтгэлзүйн шокноос үүддэг гэсэн байгаа. Эдгээр дарамтын аль ч төрөл нь айдас, гомдол, уур уцаарт хүргэж болох ба улмаар гэмт хэрэг, эсхүл авлигын үйлдэлд түлхэж болно. Дарамт нь мөн үр дагавар, нягтшилт, үргэлжлэх хугацаагаар ялгаатай байж болно. Гэхдээ бид бүгдээрээ эдгээр дарамттай тулгарч байдаг учир эдгээр нь гэмт хэргийг урьдчилан таамаглах бус түүнд хүргэж болзошгүй нөхцөлүүдийг санал болгож буй хэрэг юм. Эдгээр нөхцөл нь бүгдэд хамаатай учир болзошгүй гэмт хэрэг ба авлигаас сэргийлэхийн тулд дарамтаас хэрхэн сэргийлэх талаар ямар нэгэн санаа өгдөггүй. Тэрээр сөрөг харилцаатай байдлыг мөн онцолсон. Эерэг харилцаа байхгүй байна гэхээс илүүтэй сөрөг харилцаа байгаа нь болзошгүй зөрчилтэй үйлдлийн сайн хэмжүүр болно гэж үзжээ. Энэ санааг хэрцгий, шунахайн сэдэлтэй гэмт хэргийн хувьд батлах зарим туршилтын судалгаа байдаг ч (*Agnew and White 1992; Paternoster and Mazerolle 1994; Hoffman and Su 1997; Piquero and Sealock 2000*) эдгээр судалгааны ихэнх нь цагаан захтай хэрэгтэн ба авлигын үйлдлийн талаар бус энгийн субъектүүдийн талаар авч үзсэн байдаг.

Институцийн үл нийцлийн онол (*Institutional Anomie Theory*) нь мөн бүхий л гэмт хэргийг хамарсан тайлбар болдог. Институцийн үл нийцлийн онол нь Америкийн соёл ба нийгмийн бүтцийн харилцан хамаарлыг авч үздэг макро түвшний онол юм. Уг онолоор бол дөрвөн онцлог үнэт зүйл байдаг. Эдгээр нь хувь хүний зорилгод хүрэх буюу ололт амжилт, индивидуализм буюу хувь хүний бие даасан байдал, юниверсализм буюу амжилтад хүрэх боломж байгаа эсэхээс үл хамааран амжилтад хүрэх хүсэл, мөн амжилтыг санхүүгийн

амжилтаар хэмждэг (*Messner and Rosenfeld 2001*) материализм гэсэн дөрвөн суурь үнэт зүйл юм. Соёлын энэ тайлбарыг эдийн засаг, улс төр, гэр бүл, боловсрол зэрэг нийгмийн институцүүд хамт хийдэг. Институцийн үл нийцлийн онолын гол ойлголт нь нийгмийн янз бүрийн институцүүд хоорондын эрх мэдлийн тэнцвэр (*эсвэл тэнцвэргүй байдал*) юм. Тиймээс Америкт гэмт хэргийн түвшин өндөр байгаагийн нэг шалтгаан нь эдийн засаг нь бусад нийгмийн институцүүдийн нөлөөнөөс давамгайл, илүү нөлөөтэй байгаагаас улбаатай болно.

Өрсөлдөөнт капитализмд нийтлэг байдаг амжилт гаргах гэсэн зорилт нь дэлхий нийтээр дэлгэрсэн бөгөөд хэм хэмжээний үл нийцлийг дэвэргэж байж болзошгүй юм. Өрсөлдөөний соёл болон хэм хэмжээний үл нийцэл нь ихэнхдээ авлига гэх мэт цагаан захтны гэмт хэрэг өндөр байхтай холбогдоно. Илүү их ашиг олох шаардлага нь эцсийн дүндээ хувь хүн, байгууллагыг бодитой бус зорилтод тэмүүлэх нөхцөл байдалд хүргэж улмаар зөрчилдөөнийг бий болгодог. Макро онол учир зарим хүмүүс ийм арга барил сонгодоггүй байхад яагаад зарим хүн, байгууллага нь ажил, эсхүл тусгай зөвшөөрөл олж авахын тулд эсхүл шийтгэлээс зугтахын тулд хахууль өгөхөд бэлэн байдаг вэ гэдгийг бүрэн тайлбарлаж чадахгүй. Макро онол нь ижил макро хувьсагчтай тулгарсан хувь хүмүүс/бүлэг, байгууллага дотор ба тэдгээрийн хооронд хууль дагаж мөрдөх ялгааг чухам юунаас үүсдэг болохыг тайлбарладаггүй. Тийм учраас хүмүүсийнхээ зан үйлд нөлөө үзүүлж магадгүй байгууллагын шинж чанаруудыг ч гэсэн харах шаардлагатай (*Kramer 1982*) болно.

Дунд түвшинд (*Meso-level*) өрсөлдөөний соёл нь нэг талаас хүсэл эрмэлзэл, нөгөө талаас түүнд хүрэх чадвар, эсхүл арга хэрэгслийн хооронд үүсэх дарамтын үр дүн болсон хуулийн этгээдийн гэмт хэрэгтэй хамааралтай байж болно. Америк мөрөөдөл буюу эдийн засгийн амжилт нь нийгмийн бүхий л гишүүдийн хувьд хамааралтай бөгөөд соёлын хувьд

тодорхойлогдсон уг амжилтад хүрэх арга хэрэгсэл нь тэгш хуваарилагдаагүй байх аваас энэ нь баялагт хүрэх хууль ёсны арга хэрэгслээр дутмаг хувь хүн/бүлэг өөр арга, магадгүй хууль бус арга хайхад хүргэж (**дээр дурдсан инновацын ангиллыг хар**) болно. Кловард, Олин (**Cloward and Ohlin 1960**) нар энэ санааг дэлгэрүүлэн амжилтад хүрэх хууль ёсны бололцоотой байх эсэхээс гадна нийгэмд амжилтад хүрэх хууль бус бололцоо ч гэсэн тэгш бус хуваарилагдсан байдаг гэдгийг онцолсон. Жишээлбэл, өргөн цар хүрээтэй албан бус эдийн засаг бүхий орчинд өссөн өсвөр насныханд тохиолдох хууль бус бизнесийн боломж нь эдгээр гэмт хэрэгт уруу татах бүтэц байдаггүй орчинд өссөн хүүхдүүдээс илүү их байх болно. Дарамтын онол нь нийгмийн доод давхрааны хүмүүсийн үйлддэг гэмт хэргийг тайлбарлахаар боловсруулагдсан боловч өдгөө цагаан захтны гэмт хэргийг тайлбарлахад өргөн хэрэглэгдэж байна. Ялангуяа үл нийцлийн талаарх ойлголттой (**Passas 1990; Cohen 1995; Schoepfer and Piquero 2006; and Langton and Piquero 2007**) цуг ихээхэн хэрэглэгдэж байна. Мөн ашиг олох боломж нь аюулд орсон буюу байгууллага цааш оршин тогтнох эсэх нь тодорхойгүй, эрсдэлд орсон үеийн тайлбарт ч их хэрэглэгддэг. АНУ-ын бизнесийн орчин дахь компанийн гэмт хэргийн талаарх дэлгэрэнгүй судалгаагаар Клайнрад, Еагер (**Clinard and Yeager 1980:129**) нар ‘хямралтай салбар дахь компаниуд мөн аль ч салбарынх байхаас үл хамаарч, ажил нь муу явж байгаа компаниуд ... хэмжээгээр хууль зөрчих хандлагатай байдаг’ гэдгийг тогтоожээ. Гэхдээ дарамтын онолын хэрэглээ нь бизнес дэх ‘дундаж’ эсхүл хямралтай байгууллагаар хязгаарлагддаггүй ажээ.

Бүхий л төрлийн байгууллагууд нь ашгаас өөр зорилго, зорилттой, түүндээ хүрэх дэвшилтэт арга барилтай байдаг бөгөөд ердийн арга хэрэгсэл нь хаагдсан үед тэдгээрийг ашигладаг. Авлига нь хувь хүний амжилтын хэмжүүртэй нягт холбоотой байж болох бөгөөд байгууллагын амжилтын хэмжүүрт

хүрэх инновацлаг стратеги (*авлига нь стратеги байж болно*) болохын хувьд улс төрийн нам болон төрийн бус байгууллага зэрэг ашгийн бус байгууллагуудад ч байх боломжтой. Хаягдал утааны шалгалтыг хуурмагаар давах Волксвагений технологи (*Huggins 2015; Stewart 2015*) болон санхүүгийн салбарын урамшуулалд зарцуулах мөнгө олохын тулд хөрөнгө оруулалтыг эрсдэлд оруулсан явдал нь орчин үеийн хоёр жишээ болно. Нэлээд ашигтай, эдийн засгийн хувьд, эрүүл компанид ч гэсэн дарамт нь хэт өндөр амбицид тооцогдож, түүнд зөвхөн инновацлаг аргаар л хүрч чадна. Ийм тохиолдолд дүрэм зөрчих сэдэл болж болно. Тийм учраас дарамтын онолоор эшлэл бүлэг (*reference group*¹⁹) (*байгууллага дахь хүмүүс, ижил бизнес эрхэлдэг байгууллагууд*) ба харьцангуй гачигдлаас (*relative deprivation*²⁰) хамааран аль ч түвшний бүх байгууллагад дүрэм зөрчих явдал байж болно. Клайнардын (*1983*) судалгаагаар удирдах зөвлөлийн түвшин дэх амбиц нь ямар ч бодитой бус байсан хамаагүй зорилтыг биелүүлэх үүрэг хүлээсэн хүмүүст дотоод дарамт шахалт үүсгэж, ихэвчлэн ашгийн төлөө хууль зөрчихөд хүргэдэг гэдгийг харуулсан. Лангтон, Пикүэро (*2007*) нарын ерөнхий дарамтын онолд түшиглэсэн бүтээлд сулавтар нотолгоо гаргасан авч тэр нь цагаан захтны гэмт хэргийг таамаглах тал дээр шийдвэрлэх ач холбогдолтой зүйл болж чадахааргүй байна.

‘Хүнс тэжээлийн гинжин хэлхээ’-ний нэлээд доод хэсэгт байгаа субъектүүд нь хахууль өгөх замаар ажил олж авах зэрэг авлигын үйлдлийг хийхээс аргагүйд хүрдэг байна. Байгууллага ба хувь хүний аль аль нь түүнээс ашиг хүртдэг. Үнэндээ хувь хүний амжилт нь байгууллагын хөгжил дэвшлээс

19 Reference group гэдэг нь хүн/байгууллагын хамаарч байхыг хүсдэг бүлэг эсхүл үнэт зүйл, хэм хэмжээ, хандлага зэргээр эшлэл буюу жишиг болгон харж байдаг бүлгийг хэлсэн социологийн ойлголт. (Орч.)

20 Relative deprivation хүн/бүлэг нь байж байгаагаасаа бүр муу ч байж болох ч тэр байдлаа бүр илүү бүлэгтэй харьцуулан гачигдлыг мэдрэх тухай ойлголт. (Орч.)

хамаарч, уялдаатай байж болох ба карьер дээшлэх, хувьцаа, эсхүл урамшуулал олгох зэргээр илэрч болно. Хувь хүний ашиг сонирхол ба байгууллагын зорилго хоёр нийцэх явдал худалдааны ертөнцөөр хязгаарлагддаггүй. Хууль зөрчих үйлдэл нь тухайн байгууллагад давамгайлж буй хүлээлт, стандартад нийцсэн үйлдэл болж болно. Пассас (*Passas 1990:165*) тэмдэглэхдээ ‘ийм стандарт нь асуудалтай нөхцөл байдал, бүтцийн ... дарамтыг шийдвэрлэх оролдлогоос үүсдэг’ гэжээ.

Үйл ажиллагааны албан бус стандарт нь хуульд нийцээгүй ‘бизнес хийх’ албан бус арга болж болох боловч тэр нь хүлээн зөвшөөрөгдөхүйц гэмт хэрэг бус хэмээн харагдаж, зөвтгөгдсөөр байна гэсэн **(ялгаатай нөхөрлөлийн талаар IV бүлгийг үз)** үг. Учир нь шууд хохирогч байхгүй, эсхүл тухайн салбарт түгээмэл ердийн практик гэж харагдаж, бугшсан байдаг. Гейс (*Geis 2006*) 1950-аад оны АНУ дахь цахилгаан төхөөрөмжийн хүнд үйлдвэрлэлийн салбарт үнэ тогтоох тохиолдлын судалгаа хийхэд нэг оролцогч нь ‘хууль бус гэж үү? Магадгүйэ, гэхдээ гэмт хэрэг биш’ хэмээн хариулжээ. Энэ хандлага нь тэтгүүлэх ба ивээн тэтгэх явдал нь хэм хэмжээ болсон, системчлэгдсэн авлигатай улсад бүр илүү түгээмэл байдаг бөгөөд тийм газарт хэрэв түүнд нь оролцохгүй бол ердийн бус үйлдэл гаргаж байна хэмээн харагдана.

Эдгээр рационалчлал буюу логик тайлбар нь ердийн зүйлийн талаарх түгээмэл буруу ойлголт болдог бөгөөд улмаар байгууллагын соёлд гүн шингэж, тэр нь байгууллагын шинэ гишүүдэд уламжлагдана. Шовер ба Хохстетлер (*Shover and Hochstetler 2002*) нар хуулийн этгээдийн гэмт хэргийг тайлбарлахад байгууллагын соёлыг хэрэглэхдээ уян хатан бус өрөөсгөл үзлээс болгоомжлохыг анхааруулж соёл бол ‘үйлдлийн хувьд номхтгох хувцас’ болдог хэмээн тэмдэглэжээ. Тэд ёс зүйн үйлдэл ба хууль хэрэгжүүлэх хандлага нь ихэвчлэн байгууллагын манлайлагчдын ёс зүйн хэм хэмжээ, түүний чанар, соёлоос хамаардаг гэсэн баримтыг дурджээ.

Авлигын талаарх зохицуулалт болон хэрэгжүүлэгч байгууллагын чадавхгүй байдал, эсхүл ойлгомжгүй, хууль ёсны ба хууль бус зан үйлийн зааг ялгаа бүдэг байх үед авлигын үйлдэл гаргах шинэлэг стратегийг сонгох нь илүү хялбар байна. Дээрх шинжилгээ нь дарамт ба хэм хэмжээний үл нийцсэн байдлууд хоорондоо бие биенээ дэмжих хамааралтай болохыг харуулна. Түүнчлэн дарамт нь хүлээн зөвшөөрөгдөх зан үйлийн хэм хэмжээг бүдгэрүүлж, авлигажсан дэд соёл бий болгоход хувь нэмэр оруулдаг. Аль дүрэм үйлчлэх нь, эсхүл тодорхой дэд соёл дотор тухайн зан үйл нь өршөөгдөх эсэх нь тодорхойгүй байх үед хууль ёсны ба хууль бус авлигын үйлдэл нь байгууллагын, эсхүл хувь хүний амжилтад хүрэх хүлээн зөвшөөрөгдөх арга хэрэгсэл болон харагдах ба тэгснээр энэ албан бус 'бизнес хийх арга' нь илүү гүн үндэстэй болно.

Захиргааны байгууллагын шаталсан тогтолцоо нь мэдээлэл, дотоод хяналтыг тодорхойгүй болгосноор зүй бус үйлдлийг дэмждэг бол авлигын зан үйл нь орчин үед байгууллага доторх дотоод хамаарал сулрах хандлагатай холбоотой байна. Дотоод хамаарал сул байгаа нь байгууллагын гадаад орчны тодорхойгүй байдалд үзүүлэх хариу үйлдэл болно. Тодорхойгүй байдал нь зарим талаар зах зээл даяарчлагдсанаас үүдэлтэй байдаг бол сул хамаарал нь байгууллагууд гадаад орчны аюул занал ба боломж олгосон өөрчлөлтөд уян хатнаар хариу үйлдэл үзүүлэх чадавх (*Heywood 2015*) олгодог. Сул дотоод хамаарал гэдэг бол салбар нэгжүүд эх байгууллагаас хэсэгчлэн салж, тодорхой хэмжээний бие даасан байдлыг олох хэлбэрээр төвлөрлийг сааруулах зүйл юм. Хэдийгээр дотоод хамаарал сул байдаг бүтэц нь байгууллагад өөрчлөлтөд илүү сайн дасан зохицох боломжийг олгодог боловч бас муу нэртэй, хууль бус, авлигажсан үйлдлийн өдөөгч болох үйл ажиллагааны доголдлыг дагуулж (*Tombs 1995; Keane 1995*) болно. Ингэснээр хариуцлага, үр дагавраас өөрийгөө салгаж болох юм. Олон хуваагдмал, дотоод хамаарал султай тогтолцоо нь нэгжүүдийн бие даасан байдлын улмаас

дотоод хяналтгүй болгож болох ба авлигын үйлдэл нь толгой компанийн анхааралд өртөхгүй байж болно. Энэ нь хүмүүсийн хүсэхгүй дам нөлөө байж болох ч үйл ажиллагаа явуулдаг байгууллага дотооддоо тусгаарлах нь авлигажсан зах зээлд хууль бус үйлдэл гаргах өндөр магадлалтай нэгжээ санаатайгаар тусгаарлан, олны шүүмжлэл дагуулах эрсдэлээс зугтах стратеги ч байж болно.

Дээрх хэсэгт авлига оршин байх байгууллагын нөхцөл байдал болон болзошгүй дарамтын талаар авч үзсэн хэдий ч авлигын үйлдлийг хувь хүн, эсхүл бүлэг хүн гаргадаг. Энэ салбарын олон судлаачид хэрэгтнүүд нь энгийн хүмүүс байдаг агаад зан чанар, хүн ам зүйн ба нийгмийн шинж чанар, хувь хүний сэтгэлзүй нь цагаан захтны гэмт хэргийн эх үүсвэр болоход чухал үүрэг гүйцэтгэдэггүй гэж (*Coleman 1995*) үздэг. Гэмт хэрэгтний дүр төрхийн талаарх судалгаагаар уг үзэл (*Mars and Gerald 1982; Benson 1985; Weisburd and Waring 2001; Holtfreter 2005; Blickle et al. 2006; Ragatz et al. 2012*) батлагддаг.

Байгууллага нь хувь хүний зан үйл ба ёс зүйн мэдрэмжийг алдагдуулж чадах хэдий ч нийгэмших үйл явц нь мөн ёс зүйгүй, авлигажсан, эсхүл хууль бус үйлдлийг өдөр тутмын амьдралын нэг хэсэг гэж харах байдлаар ‘ёс зүйг мэдээгүйжүүлж’ болно. Кохений (*Cohen 1995*) хувьд нийгэм дэх зан үйлийн хэм хэмжээ ба байгууллага дахь дэд соёлд давамгайлж буй хэм хэмжээ хоёрын хоорондох зөрчилтэй тулгарсан байгууллагын гишүүд нь сэтгэлзүйн хувьд үл нийцлийн нөхцөл байдалд орж болзошгүй хэмээн үзсэн байдаг. Гэхдээ энэхүү хэм хэмжээг зөрчих үйлдлийг нийгэмшүүлэх процесс нь хямралаас гарах боломжийг олгоно. Пассас (*1990:166*) ‘хэм хэмжээний үл нийцлийн нөхцөлд гэмт хэрэгтнүүд нь өөрийгөө үнэлэх үнэлэмжээ хадгалангаа, үйлдлээ сэтгэлзүйн хувьд саармагжуулах, зөвтгөх тал дээр илүү давуу байдаг’ хэмээн бичсэн. Цагдаагийн байгууллагын дэд соёлын жишээнээс (*Punch 2009*) харвал байгууллагын дэд соёл нь

гишүүддээ 'цэвэр' ба 'бохир' авлигыг ялгах зохих зөвтгөлөөр хангадаг байна.

Катз (*Katz 1988*) дарамт ба эдийн засгийн хямрал, анги ба үндэс угсаа зэрэг нийгмийн суурь хүчин зүйлийг шалтгаалагч элемент хэмээн анхаарсан энэхүү ойлголтод шүүмжлэлтэй хандаж байжээ. Катз 'гэмт хэргийн ертөнцийг биеэр туулсан' хүмүүс л ойлгох тэр зан үйлийн утгад анхаарлаа хандуулж байв. Биеэр туулалгүйгээр санааг нь ойлгох боломгүй юм гэж тэр маргасан юм. Тэр бидний үйлдэл хэрхэн санаатай болдог тал дээр юмс үзэгдлийн дүн шинжилгээг хэрэглээд, үүндээ нүүрэн талын хүчин зүйл хэмээн нэрлэсэн гэмт хэрэгтний мэдүүлсэн сэдэл зэрэг зүйлийг онцолж байв. Катз түүний судалсан гэмт хэрэг бүрт өөрийн гэсэн сэтгэл хөдлөл байна гэдэг санааг дэвшүүлээд, гэмт хэрэгтэнд өөрийгөө үнэлүүлэх, хэрэгцээтэй гэж үзэгдэх, доромжлолоос зайлсхийх, үйлдэл нь зөвтгөгдөж, бусдад ойлгогдох 'ид шидийн орчныг' (*Jones 2006:228*) бүрдүүлэх зэрэг хэрэгцээ байдаг хэмээн үзсэн байна. Катзын бүтээл зарим төрлийн гэмт хэргийн сэдэл болох хүчин зүйлийн талаар хязгаарлагдмал ойлголтыг бий (*рационал сонголтын талаар X бүлэг, гэмт хэргийг үйлдэх хэвмэл үйлдлийн сэдлийн талаар XI бүлгийг үз*) болгосон. Гэхдээ бүхий л гэмт хэрэгтний тухайд сэтгэл хөдлөл, сэтгэлийн хөөрөл байдаг хэмээн тайлбарлах нь ойлгомжгүй юм. Учир нь биеэ үнэлэгчид үл таних хэрцгий хүнтэй секс хийхдээ сэтгэл хөдөлдөг гэхэд эргэлзээтэй. Мөн тэрээр гэмт хэрэгтнийг зургаан төрөлд ангилсан боловч цагаан захтны гэмт хэргийн талаар тайлбарлаж чадаагүй гэдэг нь тодорхой бөгөөд гэмт хэрэгтэн гэмт үйлдэл хийх сэдлийн тайлбарыг хэтэрхий хялбараар хүлээн зөвшөөрсөн байна.

Дарамтын онолын хязгаарлагдмал тал

Энэ онолын хандлага нь 1950, 1960-аад онд түгээмэл байсан боловч эцэстээ хяналт (*VII бүлгийг үз*) гэсэн ерөнхий ойлголтод багтах зүйлс хүлээн зөвшөөрөгдөх болсноор

шүүмжлэгдэж эхэлжээ. Бусад онолтой адилаар энэ онол өдийг хүртэл оршсоор байна. Гэхдээ онолын тайлбарыг эргэн засаад ч шийдвэрлэгдэхээргүй хязгаарлагдмал тал энэ онолд байсан бөгөөд байсаар ч байна. Дарамтын талаарх нийтлэг шүүмжлэл бол Америк болон өөр бусад капиталист оронд хүмүүсийн туйлын зорилго нь баялаг хуримлуулах гэж таамагладаг. Мөн амьдралын утга учрыг ойлгох, тогтооход хүмүүс хоорондоо хэрхэн харилцдаг талаар тодорхой таамаглалд уг онол үндэслэсэн байна гэсэн шүүмжлэл (*Jones 2006*) юм. Уг онол нь олон талт байдал, угсаатны талыг хүлээн зөвшөөрч чаддаггүй учир нийгэм дэх соёлын хандлагыг хэт ерөнхий тодорхойлдог. 1950, 1960-аад оны Америк улс цагаачлалын улмаас өөрчлөгдсөн учир энэ шүүмжлэл одоо улам их хамаатай. Ихэнх хүмүүсийг дундаж давхрааны статустай байхыг хүсдэг гэж үзлээ ч гэсэн орчин үеийн аль ч нийгэмд үнэт зүйл нь нэгэн цогц байна гэж хэлэхэд хэцүү. Авлига гэсэн сэдэвтэй хамаатуулан үзэхэд хүмүүс баялаг хуримтлуулах гэсэн ижил зорилготой байсан ч түүнд хэрхэн хүрэх вэ гэдэг дээр нэгдсэн ойлголттой байхгүй. Энэ онол нь мөн л эрх мэдэл гэсэн ойлголтын ач холбогдол бөгөөд хэрэв тийм нэгдсэн ойлголтыг хүмүүс хүлээн авах юм бол эцсийн дүндээ яагаад хүчтэй өрсөлдөөний замаар зөрчилдөөн, авлигад хүрдэг вэ гэдгийг дутуу үнэлдэг.

Эрх мэдэл гэх ойлголтын талаарх хэлэлцүүлэг нь бизнесийн эрх мэдэл ба Америкийн нийгэм дэх хувийн дотоод ашиг сонирхлын талаарх Мертоны тайлбарыг сайжруулахаар байсан боловч түүний онолд үүнийг тодорхой тусгасан зүйл байхгүй. Мөн тэрээр авлига ба ядуурлын хооронд илэрхий хамаарал байхгүй зөвхөн корреляци байж болзошгүй хэмээн тодорхой хэлсэн. Гэхдээ Бокс (*Box 1983*), Пассас (*1990*) нар дарамт нь ялангуяа цагаан захтны гэмт хэрэг, бодитой бус зорилтыг биелүүлэх шахалт, ашгийн төлөөх улам нэмэгдсээр буй хөөрлийг тайлбарлахад чухал гэж үзсэн.

Мөн Мертон баялгийг олж авахыг оролдох дарамтыг тайлбарлахад албан ёсны статистик ашигласан. 1950, 1960-аад онд хүмүүс албан ёсны статистикт итгэдэг, зөрчилдөөнийг онцолсон онолыг баримтлагчид л биш бол шүүмжилж, сэжиглэдэггүй байсныг тухайн үедээ бол ойлгож болохоор зүйл (*VIII бүлгийг үз*) юм. Гэхдээ гэмт хэргийг хэрхэн ялладаг, эсхүл хэрэгсэхгүй болгодог талаарх мэдлэгтэй хүн улс орон ба олон улсын корпорац нь хулгай хийх, гадаад орчныг сүйтгэх (*X бүлгийг үз*), төрийн гэмт хэргийг өргөн цар хүрээтэйгээр үйлдэх (*VIII бүлгийг үз*) замаар хувь хүмүүст хохирол учруулдаг гэдгийг анхаарч үзвэл албан ёсны статистик нь хөдөлшгүй бодит баримт бус гэмт хэргийн түвшний илэрхийлэл гэдэг нь тодорхой болох болно. Түүнээс гадна, гэмт хэргийн тодорхойлолт нь хувийн өмчийг хамгаалахад анхаарлаа хандуулсан хамгийн их эрх мэдэлтэй хүмүүсийн боловсруулсан зүйл гэдэг үзлээр бол албан ёсоор бүртгэгдсэн гэмт хэргийн ихэнх нь 'ажилчин эсхүл доод давхрааны' хүмүүсээс гаралтай байдаг нь тийм ч гайхмаар зүйл биш. Энэ нь эрүүгийн ялын тогтолцоонд уулаас байдаг тогтсон өрөөсгөл үзэлтэй нийлж бүр дорддог.

Эцэст нь энэ онолд болзошгүй гэмт хэрэг эсхүл авлигын үйлдэл эхлэх үе дэх нийгмийн хяналтын талаар тайлбар байхгүй. Гэмт үйлдлээс хойш суух ангилалд хамаарах хүн ямар хэлбэр, төрлийн үйлдэл хийх талаар заалт байхгүй, эсхүл донтолт зэрэг нийгмийн асуудал нь хэм хэмжээний үл нийцэлт байдлын үр дүн үү эсхүл түүнд хүргэдэг зүйл үү гэдгийг өгүүлсэн тайлбар (*Jones 2006*) байдаггүй. Гэхдээ нийгмийн хамгийн ядуу хэсэг нь зурагт, интернэт зэрэг мэдээллийн хэрэгслээр хамгийн баян хүмүүсийг харж, харилцах хэрээр энэ нь баялагтай болох дарамтыг нэмэгдүүлж, гэмт хэргийн болон авлигын замаар баялагтай хүнийг хурцаар шүүмжлэхэд хүргэж болзошгүй юм.

Доорх жишээ нь хувь хүмүүс, сансрын тандан судалгаа, эрүүл мэндийн салбар дахь байгууллагад дарамт хэрхэн хүрч нөлөөлөхийг харуулна.

Олон зориулалтат, дахин ашиглах хөлөг: Зорилтын дарамт ба төсөв таналт

Хуучны жишээ боловч хосолмол зориулалттай, олон зориулалтат, дахин ашиглах хөлөг буюу арилжааны болон цэргийн зориулалтаар ашиглах сансрын хөлөг барих жишээ нь хувь хүн ба байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэх стресс, дарамтыг харуулах баримт болдог. Энэ бол нэг талдаа Үндэсний агаарын тээвэр, сансрын нислэгийн алба (*NASA*) ба хувийн бизнес буюу Morton Thiokol Inc. Корпорацын хоорондын харилцаанаас үүссэн дарамт, нөгөө талдаа цэргийн ба улсын зорилго хоорондын зөрүүнээс үүссэн дарамтыг харуулахад тохиромжтой жишээ юм. 1986 оны нэгдүгээр сарын 28-нд хөөрөнгүүтээ дэлбэрсэн *Чалленжер* сансрын хөлгийг аюулд өртүүлэхгүй байх боломжтой байв. Энэ бол төрийн-корпорацийн гэмт хэргийн төрөлд багтах хэрэг (*Kramer and Michalowski 1990*) юм. Төрийн-корпорац нь зорилгодоо хүрэхийн тулд улс төрийн эрх мэдэл бүхий нэг буюу хэд хэдэн институц болон үйлдвэрлэл, хуваарилалтын салбарын нэг буюу хэд хэдэн институцтэй шууд хамтран ажиллаж, хувь хүний болон байгууллагын хувьд ноцтой үйлдэл гаргавал гэмт хэрэг үйлдэх хэмжээнд хүрдэг.

Жишээг тайлбарлахын тулд эхлээд олон зориулалтат, дахин ашиглах хөлөг боловсруулах процессын нийгэм, улс төрийн агуулгыг авч үзье. АНУ, ЗХУ хоёрын хүйтэн дайны зэвсгийн өрсөлдөөнөөс болж 1958 онд НАСА-г байгуулжээ. Энэхүү шинэ агентлагийг иргэний удирдлагад өгсөн боловч анхнаасаа л тэдний үйл ажиллагааны чиглэлд нөлөөлөхийг оролдох хандлага гарч, цэргийнхэнтэй зөрчилдөж ирсэн аж. 1960-аад онд НАСА зорилгодоо хүрэхийн тулд аюулгүй байдал ба чанарыг онц анхаарч ажиллахад хүрэлцээтэй овоо их төсөвтэй, хязгааргүй дэмжлэгтэй болсон байв (Trento 1987).

Гэвч 1970-аад онд НАСА-гийн улс төр, эдийн засгийн орчин нөхцөлөөрчлөгдөж эхлэв. Эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн асуудал үүсэж, улс төрийн дэмжлэг (*Lewis 1988*) буурлаа. 1969 онд Засгийн эрхийг авсан Никсоны засаг захиргаа тодорхойгүй нөхцөл байдалтай учирмагц сансарт эдийн засгийн гарц нээх олон зориулалтат, дахин ашиглах хөлөг бүтээхийг тушаасан байна. Энэ хөлөг нь НАСА-гийн ойрын ирээдүй болсон аж. Энэ үед Менежмент ба төсвийн албанаас (*OMB*) тавьсан санхүүгийн хязгаарлалт нь хөлгийн загварт онц нөлөөлөөд зогсохгүй улс төрийн дэмжлэг авахын тулд НАСА-г цэргийнхний оролцоог үг дуугүй зөвшөөрөхөд хүргэсэн байна. Цэргийнхэн оролцсоноор хөлөг эдийн засгийн хувьд боломжийн бөгөөд цэргийн ажиллагаанд зохицсон байх ёстой болжээ. Тиймээс тэд загвараа олон удаа өөрчилсөн бөгөөд төсвийн тал дээр буулт хийснээр НАСА анхны загвараасаа татгалзаж 'стандартад нийцүүлэх бус үнэд тааруулсан' хөлөг (*Lewis 1988: 54*) хийжээ. Үр дүнд нь шингэн түлшний хөдөлгүүрээс хямд боловч хамаагүй аюултай хатуу түлштэй пуужин ашиглахаар шийджээ. Мөн нисгэгч нарт зориулсан ослын хаалгыг хийхээ больсон (*Kramer 1992*) байна. Хөлгийг бага зардлаар бүтээх болсноос гадна хөлөг цэргийнхэн оролцсоноор улс төрийн буулт дээр суурилсан холимог зүйл болов. Менежмент ба төсвийн алба болон Конгрессын аль аль нь үнэтэй бус, үр ашигтай, дахин ашиглаж болох хөлгийг шаарджээ. НАСА өөрийн оршин тогтнолыг хамгаалахын тулд тийм хөлөг хийхээр хөдөлснөөр хосолмол зориулалттай олон дахин ашиглах хөлгийн домог үүсжээ.

1980-аад онд Рейганы үед хөлгийг бэлэн болгох дарамт, шахалт нэлээд нэмэгдсэн байна. НАСА олон дахин ашиглах хөлгийг худалдааны зориулалтаар ашиглан, эдийн засгийн хувьд өөрийгөө авч явах хүлээлттэй байв. Харилцаа холбооны хиймэл дагуулыг сансарт тээвэрлэдэг компани маягаар ажиллаж болно гэж тэд үзэж (*Trento 1987*) байжээ. Түүнчлэн сансрын хөлгийг үндэсний аюулгүй байдлын төлөө цэрэгжүүлэх дарамт

ирж байсан аж. Энэ нь ялангуяа Үндэсний сансрын бодлогын талаарх 1982 оны Ерөнхийлөгчийн зарлиг, ‘Оддын дайн’ төлөвлөгөөнд тусгалаа олжээ. НАСА-гийн зорилго нь эдгээр улс төр, худалдаа, цэргийн шаардлагын нөлөөн дор тодорхойлогдож, жилд 24 нислэг үйлдэх түргэвчилсэн төлөвлөгөөнд хүргэсэн (*Kramer 1992*) байна. Хөрөнгө хүрэлцэхгүй, аюулгүй байдлын стандарт байхгүй нь НАСА-г нислэг бүрийн дараа хөлгийг нөөц сэлбэгэнд тонон ашиглахад хүргэжээ.

Morton Thiokol Inc. корпорацийн загварын гол алдаа нь пуужинд байв. Мортонь хүмүүс эхэн үеийн туршилтаар алдаа байгааг илрүүлсэн боловч асуудал болохгүй гэж үзэн нэмэлт туршилт хийгээгүй байна. НАСА-гийн зарим инженерүүд энэ алдааны талаар мэдээлэл дутуу байгаа талаар хэлж байв. 1981 оны 11 дүгээр сард хийсэн хоёр дахь туршилтын нислэгээр баруун пуужингийн хүчлүүр эвдэрсэн нь мэдэгдсэн боловч энэ тухай мэдээллийг Маршалын Сансрын нислэгийн төвөөс цааш дамжуулаагүй бөгөөд тэнд ажиллаж байсан инженерүүд нь НАСА-гийн өөр хэсэгт очиж ажиллажээ. Энэ алдаа нь явсаар 1982, 1983 онд ‘ноцтой’ хэмээн тодорхойлогдсон байна. Түүнээс өмнө Маршал төвд ажиллаж байсан хэн нь ч хөтөлбөрийг зогсоох талаар санал гаргалгүй, удирдлагууд уг алдааг ‘хүлээн зөвшөөрөгдөх эрсдэл’ гэж хэмээн үзэж (*McConnell 1987:120*) байв. Гэхдээ 1985 оны 7 дугаар сар гэхэд Мортон ба НАСА (*эсвэл нэгжүүд нь*) асуудлыг засаж ‘болохооргүйг, хөөргөх төхөөрөмжөөс болж нислэг бүтэлгүйтэх’ (*Ерөнхийлөгчийн Комиссын илтгэл 1986:249*) нөхцөл байдалд орсон гэдгийг мэдэх болжээ.

Алдаатай загварын талаарх мэдээлэл нь НАСА ба Мортонь аль алины хувьд дарамтын эх үүсвэр болох нь илэрхий байсан (*Kramer 1992*) ажээ. Тэдний аль аль нь асуудлыг мэдэж байсан боловч алдааны үр дагавар нь засагдаагүй юм. Энэ нь олон дахин ашиглах хөлгийн хөтөлбөрийг урт хугацаагаар зогсоох, олон дахин ашиглах хөлгийн нислэгийн хуваарийг хойшлуулснаар

Мортоны ашгийг бууруулах гинжин урвалтай байв. Түүний оронд НАСА ба Мортон эрсдэлийг зайлшгүй, эсхүл хүлээн зөвшөөрөхүйц гэж үзэж олон дахин ашиглах хөлгийг нисгэсээр байх хариу үйлдэл хийжээ. Цэргийнхэн болон улс төрчдийн зүгээс хосолмол зориулалттай хөлөг хий гэсэн шахалт НАСА-д ирж үед гадаад нийгмийн хяналт бага байсан ба НАСА-гийн дотоод зохицуулалт, дотоод мэдээлэл солилцоо нь харамсмаар хангалтгүй байдалтай байсан нь аюулгүйн стандартыг бүрэн зөрчихөд хүргэжээ. Хэдийгээр аюулгүй байдлыг сулруулсан ч гэсэн НАСА-д баталгаажуулах нэгжүүд байсаар байсан боловч аль нь ч бие даан арга хэмжээ авах боломжгүй байв.

Улстөрчдөөс арилжааны зорилгоор ашиглаж болох олон зориулалтат, дахин ашиглах хөлөг нэхсэн, цэргийнхнээс болохоор дайны үед ашиглаж болохуйц хөлөг хийхийг шаардсанаас үүдсэн дарамт нь НАСА-г амьд үлдэхийн тулд аюулгүйн стандартаа буулгахаас өөр аргагүй байдалд оруулжээ. Энэ нь НАСА-г хамгаалж буй хэрэг биш юм. Гэхдээ дотоод аюулгүй байдлын процесс нь хангалтгүй байсан ч байгууллага татан буулгуулалгүй цааш үргэлжлүүлэх хүсэл, амжилтад хүрэхийг шаардсан гадаад шаардлагын хослол нь НАСА-г нэлээд их дарамт үүсгэх үйлдэл, нислэгийн хуваарь руу түлхжээ. Эдгээр нөхцөл байдалд эсэргүүцсэн дуу хоолойг (*хэрэв байсан бол*) ихэнхдээ үл тоосон байхад гайхах зүйлгүй. Хэдийгээр энэ нь хувь хүнд бус байгууллагад ирэх дарамтын жишээ боловч 1986 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр осолдсон *Чалленжер* хөлгийн дэлбэрэлтээс болж нас барсан хүмүүсийн хувьд шалтаг болж өгөхгүй билээ.

Дунд Стаффордшайрын²¹ Үндэсний эрүүл мэндийн албаны сангийн трест: Зорилгын ба төсвийн таналтын дарамт

Английн Эрүүл мэндийн салбарыг шалгах Комиссоос (2009) Дунд Стаффордшайрын Үндэсний эрүүл мэндийн албаны сангийн Трестэд явуулсан ‘хэт олон’ хүн, ялангуяа эмнэлэгт яаралтай тусламжаар ирсэн хүмүүс нас барсан асуудлын талаарх шалгалт нь эрүүл мэндийн үйлчилгээн дэх дарамтыг харуулахад тохиромжтой жишээ болно. Гэхдээ энэ жишээ нь эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх явцад гарсан дарамт биш удирдлагын баг нь үйлчилгээний чанар буурахыг үл анзааран зардал хэмнэх, ажиллах хүчээ бууруулах хэт их сонирхолтой байсныг харуулсан. Удирдлагын баг нь эрүүл мэндийн үйлчилгээг золиослон санхүү, бизнесийн асуудалд анхаарал хандуулах шийдвэр (*Healthcare Commission 2009*) гаргажээ. Шалгалтын үеэр өвчтөний эмчилгээний стандарт дээр хяналт тавьж байсан тухай ямар ч баримт гаргаж ирж чадаагүй юм. Зардлыг анхааралтай тооцох болон эмчилгээний чанарыг хослуулан авч үзэхгүй, ердөө зардалд анхаарч байсан нь хиртхиймээр бөгөөд энэ нь эмчилгээний стандарт ба эмх замбараагүй тогтолцоонд хүргэж, эмчилгээний тогтолцоо хангалтгүйгээс ‘өвчтөнүүдийг хохироосон (*Doig 2011:45*) юм’. Муу эмчилгээ олон жилийн турш ердийн зүйл болсон байсан 2005-2009 оны хооронд яг хэдэн хүнийг эмчлэхгүй үл тоож байсны улмаас хэдийг нь яваандаа үхэлд хүргэснийг мэдэх боломжгүй байна.

Тус эмнэлэгт өөрөө өөрийгөө хянах, нөхцөл байдлын талаар ойлгоц муутай байх, өөрийгөө зохицуулах, гадаад шүүмжлэлийг үл хүлээх соёл бүрэлдсэн байжээ. Байгууллагын ийм авлига нь ёс зүйн хувьд, эсхүл магадгүй зарим тохиолдолд гэмт хэргийн авлига байдаг боловч нотолгоо гаргах боломжгүй. Энэ төрлийн

21 Баруун Английн засаг захиргааны нэгжийн нэр (Орч.)

авлига нь хүчтэй өрсөлдөөний сэтгэлгээтэй нийгэмд үүсдэг. Слалпер, Томбс (*Slapper and Tombs 1999 :161–162*) нар 'нийгэмд бий болсон бүтэлгүйтэхээс айх айдас хүмүүсийн харилцаа ба практикийн тавааржилт ихсэх; хяналт, зохицуулалт багатай шилжүүлэг өсөх; хүмүүсийг үргэлж хүрэх ёстой зорилтоор шахах; албан тушаал дэвшихийг хүсэх, буурахаас зайлсхийх; хямралтай тулгарах гэх мэт шалтгаан нь компанийн гэмт хэргийг бий болгодог' хэмээн тэмдэглэжээ. Жишээнд дурдагдаж буй Сангийн трест нь компани, эсхүл корпорац гэж харагдахгүй ч тэд нэлээд хугацааны турш эмнэлгийн дүгнэлт ба өвчтөний эмчилгээнээс илүү бизнес хөгжилд анхаарч байсан ажээ.

Дээрх жишээнд зардал ба ашгийг тооцох боломж байсан учир өөртөө үүсгэсэн дарамт гэж харж болно. Гэхдээ энэ дарамтыг хоёр түвшинд авч үзэж болно:

1/ улсаас ирэх эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг бууруулах шахалт, (*энэ нь одоо ч байсаар буй*)

2/ эмнэлгийн зардлаа бууруулахын зэрэгцээ боломжгүй байсаар ирсэн эрүүл мэндийн үйлчилгээний түвшнийг мөрдөх шахалт. Гэхдээ энэ талаар 'харамсалтай нь трестийн зарим айдсын шалтгаан нь Үндэсний эрүүл мэндийн албанаас санхүүгийн шахалтын хэлбэрээр ирсэн' гэж Франсис (*Francis 2010:184*) тэмдэглэжээ. Айх соёл нь нэг шөнийн дотор үүсэхгүй боловч бүх түвшинд, удаан хугацаанд эерэг, үр дүнтэй зааварчилгаа байхгүй явж ирсний шинж тэмдэг юм. Энэ соёлын үр дагавар нь эмнэлэг дээр шахалтад байхдаа нэг ч гэсэн алдаа гаргахгүй байх, ажилчдад зөрчилтэй шаардлага тавигдах, 'тогтсон зорилт ялангуяа осол аваарын үеийн хүлээлгийн цагийг' тэргүүлэх чиглэлээ болгоход хүргэсэн (*Doig 2011:204*) байна. Үндэслэлтэй ч бай, үгүй ч бай алдаа гаргавал ажилгүй болно гэдэг айдас хаа сайгүй байжээ. Энэ байнгын дарамт нь эмчилгээний чанарыг стандартаас доогуур оруулж, ажилтнуудын сэтгэлзүйд нөлөөлснөөр ажилтнууд өвчтэй,

чөлөөтэй байх нь их болж, эмзэг өвчтөнүүдийг ойлгох нь явдал нь багасаж, ерөнхийдөө ажилдаа сэтгэл гаргахаа больсон (*Francis 2010*) байна.

Алдахаас айх айдас хэрхэн гэмт хэрэгт хүргэдэг тухай судалгаа бий. Вэйсбурд нар (*Weisburd et al.1991*) цагаан захтны гэмт хэрэг хийх хоёр төрлийн замыг тодорхойлсон байна. Нэг нь хэрэгтнүүд өндөр эрсдэлийг хүсдэг ба эго буюу аминч хүслээ хангах хэрэгцээтэй байдаг гэж үздэг бол нөгөө нь унахаас айх айдас буюу эдийн засгийн аюулгүй байдал ба хүнд хүчир хөдөлмөрийн үр дүнд олж авсан зүйлээ алдахаас айх айдсыг заадаг. Яагаад цагаан захтнууд гэмт хэрэг үйлддэг болохыг ойлгохын тулд, нийгмийн байр суурь, нэр хүндээ алдах дээр Вийлерийн (*Wheeler 1992*) бололцооны онол²² хэмээн нэрлэгддэг онолыг хэрэглэхийг санал (*Kahneman and Tversky 1979*) болгосон. Унахаас айх айдсын ард буй логик нь ‘бодитой хэмжээг бус өөрчлөлт, ялгааг үнэлэх хүний ойлголт, дүгнэлтэд үндэслэдэг’. Тиймээс одоогийн түвшинтэй харьцуулсан хүний эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлтийг мөн байр суурь, нэр хүндэд хэрэглэж (*Wheeler 1992*) болно. Энэ нь эдгээр хоёр хувилбар нь зөвхөн цагаан захтан гэмт хэрэгтэнд хамаатай хэмээн үзэж буй хэрэг биш бөгөөд алдах зүйл ихтэй хэсэг бүлэг хүмүүст яагаад авлигажсан үйлдэл хийх сэдэл төрдөг вэ гэдгийг тайлбарлахад тустай.

Дунд Стаффордшайр эмнэлэг шиг орчин нөхцөлд муу захиргаа нь хуулийн засаглал, эмчилгээний чанар, хүмүүсийг хүндэтгэх асуудлын хувьд хангалтгүй үр дүнг хялбархан гаргах нь илэрхий байжээ. Баригдах магадлал бага, баригдсан ч хүлээлгэх шийтгэл бага нь байсан, түүнчлэн зохицуулах байгууллагууд (Эрүүл мэндийн салбарыг шалгах комисс, дараа нь Эмчилгээний чанарыг хянах комисс болсон) болон Эрүүл мэндийн яамнаас зөвлөмж өгч байсан ч менежмент

²² Prospect theory буюу бололцооны онолоороо Даниел Канеман Нобелын шагнал хүртсэн. (Орч.)

болон эмнэлгийн удирдах зөвлөл муу ажиллаж байсан нь нэрмээс болжээ. Магадгүй дарамтаас үүдсэн олон түвшний бүтэлгүйтлийн үр дүнд дээр дурдсан Агньюгийн тодорхойлсон (1992) хувь хүний дарамт бий болж, эмнэлэг дээр хүмүүст муу асаргаа үзүүлжээ.

Дүгнэлт

Энэ бүлэгт амжилтад хүрэх боломж муутай хүмүүс яагаад хууль бус үйлдэл хийдгийг тайлбарлахад хэрэглэдэг дарамт нь хүчтэй, эрх мэдэлтэй хүмүүсийн үйлдлийг тайлбарлахад ч үнэ цэнэтэй байдгийг үзлээ. Энэ номд дурдсан бүхий л онолтой адилаар энэ онолд ч гэсэн хязгаарлагдмал тал бий. Гэхдээ энэ нь тэглээ гээд энэ онолоос татгалзана гэсэн үг биш 'гудамжны гэмт хэрэг' ба 'цагаан захтнуудын гэмт хэрэг'-ийг тайлбарлахад тустай зүйл гэж харна гэсэн үг. Түүнээс гадна компанийн ашиг, цэргийнхний шаардлага, улс төрийн шахалт зэрэг олон янзын шахалт нь эрүүл ухаан, тайван байдал, рационал шийдвэр шаардлагатай орчинд дарамт үүсгэж болно. Дарамт нь тэгэхээр гадаад эсхүл дотоод эх үүсвэртэй, эсхүл өөрөө өөртөө бий болгосон ч бай зарим гэмт хэргийг үүсгэж болох ба бид бүгдээрээ нүүр тулгардаг зүйл бөгөөд тэр утгаараа бид ойлгож чадах зүйл юм. Гэсэн ч хорхой хүргэх нөхцөл байдалтай тулгарсан бид бүгд авлигын хууль ёсны болон хууль бус үйлдлийн эрхэнд ороод байдаггүй (*VII бүлгийг үз*). Бидний дарамт нь бидний нөхөрлөж буй хүмүүсээс хамааран ялгаатай нөхөрлөлтэй хослон институцчилэгдэж, логик үндэслэлтэй болж болно.

Ашигласан материал

Agnew, R. (1992). Foundation for a general strain theory of crime and delinquency. *Criminology*, 30 (1), 47–87.

Agnew, R. (1995). Controlling Delinquency: Recommendations from General Strain Theory.' In Barlow, Hugh D (Eds.), *Crime*

and Public Policy: Putting Theory to Work, pp43–70. Colorado: Westview Press. 43–70.

- Agnew, R. (2001). Building on the Foundation of General Strain Theory: Specifying the Types of Strain Most Likely to Lead to Crime and Delinquency. *Journal of Research in Crime and Delinquency* 38 (4), 319–361.
- Agnew, R., & White, H. (1992). An empirical test of general strain theory. *Criminology*, 30 (1), 475–499.
- Agnew, R., Brezina, T., Wright, J. P., & Cullen, F.T. (2002). Strain, Personality traits, and Delinquency: Extending General Strain Theory. *Criminology* 40(1), 43–72.
- Benson, M. L. (1985). Denying the guilty mind: Accounting for involvement in white-collar crime. *Criminology*, 23 (4), 583–607.
- Benson, M. L., & Kerley, K. R. (2001). Life course theory and white collar crime. In H. N. Pontell & D. Shichor (Eds.), *Contemporary issues in crime and criminal justice: Essays in honor of Gilbert Geis*. Upper Saddle River, NJ: Prentice Hall.
- Benson, M. L., & Moore, E. (1992). Are white-collar and common off enders the same? An empirical and theoretical critique of a recently proposed general theory of crime. *Journal of Research in Crime and Delinquency*, 29 (3), 251–272.
- Blickle, G., Schlegel, A., Fassbender, P., & Klein, U. (2006). Some personality correlates of business white-collar crime. *Applied Psychology*, 55 (2), 220–233.
- Box, S. (1983). *Power, crime and mystification*. London: Routledge.
- Brooks, G., Walsh, D., Lewis, C., & Kim, H. (2013). *The prevention of corruption: Investigation, enforcement and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.

- Clinard, M., & Yeager, P. (1980). *Corporate crime*. New York: Free Press.
- Clinard, M. B. (1983). *Corporate ethics and crime*. Beverley Hills, CA: Sage.
- Cloward, R., & Ohlin, L. (1960). *Delinquency and opportunity*. London: Collier Macmillan.
- Cohen, A. (1965). The sociology of the deviant act: Anomie theory and beyond. *American Sociology Review*, 30 (1), 5–14.
- Cohen, D. V. (1995). Ethics and crime in business firms: Organizational culture and the impact of anomie. In F. Alder & W. S. Laufer (Eds.), *The legacy of anomie theory: Advances in criminological theory*. New Brunswick, NJ: Transaction Books.
- Coleman, J. W. (1995). Motivation and opportunity: Understanding the causes of white collar crime. In G. Geis, R. Meier, & L. Salinger (Eds.), *White collar crime* (3rd ed.). New York: Free Press.
- Coleman, C., & Moynihan, J. (1996). *Understanding crime data: haunted by the dark figure*. Milton Keynes: Open University Press.
- Doig, A. (2011). *State crime*. Cullumpton: Willan Publishing.
- Dubin, R. (1959). Deviant behaviour and social structure: Continuities in social theory. *American Sociological Review*, 24, 147–164.
- Elliot, D., & Voss, H. (1974). *Delinquency and dropout*. Lexington: D. C. Heath.
- Francis, R. (2010). *Independent inquiry into care provided by Mid-Staffordshire NHS Trust: January 2005–March 2009. (Vol. 2)*. London: Her Majesty's Stationary Office.

- Geis, G. (2006). *White collar criminal: The off ender in business and professions*. New Brunswick, NJ: Transaction Publishers.
- Healthcare Commission (2009). *Mid Staffordshire NHS Foundation Trust: A review of lessons learnt for commissioners and performance managers following the Healthcare Commission investigation*. London: Mid Staffordshire NHS Foundation Trust Public Inquiry.
- Heywood, P. M. (2015). *Routledge handbook of political corruption*. Abingdon: Routledge.
- Holtfreter, K. (2005). Is occupational fraud ‘typical’ white-collar crime? A comparison of individual and organizational characteristics. *Journal of Criminal Justice*, 33 (4), 353–365.
- Hoffman, J., & Su, S. (1997). The conditional effects of stress on delinquency and drug use: A strain theory assessment of sex differences. *Journal of Research in Crime and Delinquency*, 34, 46–78.
- Huggins, A. (2015, September 30). Why Europe failed to halt the emissions ruse. *International New York Times*, p. 16.
- Jones, S. (2006). *Criminology* (3rd ed.). Oxford: Oxford University Press.
- Kahneman, D., & Tversky, A. (1979). Prospect theory: An analysis of decision under risk. *Econometrica*, 47, 263–291.
- Katz, J. (1988). *Seductions of crime*. New York: Basic Books.
- Keane, C. (1995). Loosely coupled systems and unlawful behaviour: Organization theory and corporate crime. In F. Pearce & L. Snider (Eds.), *Corporate crime: Contemporary debates*. Toronto: University of Toronto Press.

- Kramer, R. C. (1982). Corporate crime: An organizational perspective. In P. Wickman & T. Daily (Eds.), *White collar and economic crime*. Lexington, KY: Lexington Books.
- Kramer, R. C. (1992). The space shuttle *challenger* explosion: A case study of state-corporate crime. In K. Schlegel & D. Weisburd (Eds.), *White collar crime reconsidered*. Boston: Northeastern University Press.
- Kramer, R. C., & Michalowski, R. J. (1990, November). Toward an integrated theory of state-corporate crime. Paper presented at American Society of Criminology Meeting, Baltimore, MD.
- Langton, L., & Piquero, N. L. (2007). Can general strain theory explain white collar crime? A preliminary investigation of the relationship between strain and select white collar offenses. *Journal of Criminal Justice*, 35 (1), 1–15.
- Lewis, R. S. (1998). *Challenger: The final voyage*. New York: Columbia University Press.
- Mars, G., & Gerald, M., (1982). *Cheats at work: An anthropology of workplace crime*. London: Allen & Unwin.
- McConnell, M. (1987). *Challenger: A major malfunction*. Garden City, NY: Doubleday and Company.
- Merton, R. K. (1938). Social structure and anomie. *American Sociological Review*, 3, 672–210.
- Messner, S. F., & Rosenfeld, R. (1994). *Crime and the American dream*. Belmont, CA: Wadsworth.
- Messner, S. F., & Rosenfeld, R. (2001). *Crime and the American dream* (3rd ed.). Belmont, CA: Wadsworth.
- Orru, M. (1990). Merton's instrumental theory of anomie. In J. Clake, C. Modgil, & S. Modgil (Eds.), *Robert K Merton: Consensus and controversy*. London: Falmer Press.

- Passas, N. (1990). Anomie and corporate deviance. *Crime, Law and Social Change*, 14 (2), 157–178.
- Paternoster, R., & Mazerolle, P. (1994). General strain theory and delinquency: A replication and extension. *Journal of Research in Crime and Delinquency*, 31 (3), 235–263.
- Piquero, N. L., & Sealock, M. D. (2000). Generalizing general strain theory: An examination of an offending population. *Justice Quarterly*, 17 (3), 449–484.
- President's Commission on the Space Shuttle *Challenger* Accident. (1986). Report of the Presidential Commission on the Space shuttle *Challenger* accident (Vols. 1–4). Washington, DC: US Government Printing Office.
- Punch, M. (2009). Police corruption: Deviance, accountability and reform in policing. Abingdon: Routledge.
- Ragatz, L. L., Fremouw, W., & Baker, E. (2012). The psychological profile of white-collar offenders demographics, criminal thinking, psychopathic traits, and psychopathology. *Criminal justice and behavior*, 39 (7), 978–997.
- Schoepfer, A., & Piquero, N. L. (2006). Exploring white collar crime and the American dream: A partial test of institutional anomie theory. *Journal of Criminal Justice*, 34, 227–235.
- Shover, N., & Hochstetler, A. (2002). Cultural explanation and organizational crime. *Crime, Law and Social Change*, 37 (1), 1–18.
- Slapper, G., & Tombs, S. (1999). *Corporate crime*. Essex: Pearson.
- Stewart, J. (2015, September 26). VW problems started with the boardroom. *International New York Times*, p. 1.

- Tombs, S. (1995). Corporate crime and new organizational forms. In F. Pearce & L. Snider (Eds.), *Corporate crime contemporary debates*. Toronto: University of Toronto Press.
- Trento, J. J. (1987). *Prescription for disaster: From the glory days of Apollo to the betrayal of the shuttle*. New York: Crown Publishing.
- Weisburd, D., & Waring, E. (2001). *White-collar crime and criminal careers*. New York: Cambridge University Press.
- Weisburd, D., Wheeler, S., Waring, E., & Bode, N. (1991). *Crimes of the middle classes: White collar offenders in the federal courts*. New Haven, CT: Yale University Press.
- Wheeler, S. (1992). The problem of white-collar crime motivation. In K. Schlegel & D. Weisburd (Eds.), *White-collar crime reconsidered*. Boston: Northeastern University Press.

VI

Авлигыг тайлбарлах нь: Авлигын ертөнц рүү гулсан орж гарах ба саармагжуулах арга хэрэгсэл

Удиртгал

Авлигыг тайлбарлахад хамааралтай эрүүгийн ертөнц рүү гулсах (*drift*) ба саармагжуулах арга хэрэгслийн (*techniques of neutralization*) талаарх ойлголт нь бусад сурах бичигт нийгмийн хяналтын бүлгийн нэг хэсэг болж ордог боловч энд тусад нь бүлэг болгон орууллаа. Хяналтын онолын хамтаар (*VII бүлгийг үз*) Сайкес, Матза нар (*Sykes and Matza 1957*) АНУ-д ихэвчлэн ядуусын хороололд амьдардаг хүмүүс яагаад эдийн засгийн хууль ёсны боломжгүй байдаг ба тэд гэмт хэргээр хүрээлэгдсэн орчинд өссөн ч насанд хүрэхийн хэрээр дүрэм зөрчих (*delinquency*) болон гэмт хэргийн үйлдлээс яагаад холддогийг тайлбарлахыг оролджээ. Дүрэм зөрчих нь өсвөр наснаас насанд хүрэх шилжилтийн үеийн зүйл үү, эсхүл түр зуурын төөрөгдөл үү. Бид дүрэм зөрчих ба гэмт хэргийн ертөнц рүү гулсан орж гарч байдаг уу. Хэрэв тийм бол үргэлж биш ч ихэнхдээ хууль даган мөрддөг хүмүүс үүнд хэрхэн ханддаг вэ?

Сайкес, Матза нар (*1957*) үүнийг шалтаг болон ‘саармагжуулах арга хэрэгсэл’-д суралцах зэргээс бүрдсэн

уламжлалт нийгмийн хэм хэмжээ нь тодорхой тохиолдолд хууль зөрчихийг хүлээн зөвшөөрдөг ч уламжлалт зан үйлийг бүрэн үгүйсгэдэггүй хэмээн тайлбарласан байна. Энэ бүлэгт бид энэхүү гулсах үйл явц ба саармагжуулах арга хэрэгсэлд анхаарлаа хандуулах ба тохиромжтой үед Диттенхофер (*Dittenhofer 1995*), Зейлтинс (*Zeiltin's 2001*) нарын шударга бусын синдром ба сэтгэл үл ханамжийн талаарх ойлголтыг эшлэх болно.

Гулсах ба саармагжуулах арга хэрэгсэл

Сайкес, Матза нарын (*1957*) хувьд 1950-иад оны үеийн америкчууд, ялангуяа залуучууд нийгмийн зонхилох дэг журмыг эсэргүүцээгүй бөгөөд үүнийг дэд соёлын онолоор ч мөн эсэргүүцэл гэж тайлбарлаагүй. Дэд соёлын онол нь дэг журмыг дагаж мөрддөг ба мөрддөггүй хүмүүсийн ялгааг хэт их онцлох хандлагатай байж ирсэн. Сайкес, Матза нар яагаад залуу хүмүүс ихэвчлэн уламжлалт ёс зүй болон хуулийг зөрчсөн ч нийгмийн хууль журмын ихэнхийг хүлээн зөвшөөрч, түүнд нэгдэж байдгийг тайлбарлахыг зорьсон юм. Үүнийг шалтагт суралцах (*learning excuse*) ба 'саармагжуулах арга хэрэгсэл' гэж нэрлэгдсэн зүйлээс бүрдсэн нийгмийн хэм хэмжээг суралцах процесс хэмээн тайлбарлажээ. Эдгээр арга хэрэгсэл нь хувь хүн болон бүлгээс хүлээгдэх зан үйл ба хуулийг даган мөрдөх үүрэг амлалтыг түр зуур саармагжуулах, эсхүл хойшлуулах боломж олгодог. VI бүлэгт бид хүн хууль зөрчиж байгаа бусад этгээдийг ажиглаж, тэдэнтэй харилцах замаар зан үйлд суралцдаг бөгөөд үүгээр арга хэрэгсэл, сэдэл, хөдөлгөгч хүч, логик үндэслэл, гэмт үйлдэлд хандах хандлагад суралцдаг гэсэн Садерландын онолыг үзсэн. Гэмт хэрэгтэн хууль зөрчихийг зөвтгөх явдалтай нэгэн адилаар гэмт хэргийг саармагжуулах арга хэрэгслийг бас 'суралцдаг' гэж би үздэг. Үүнд дараах арга хэрэгсэл багтана:

- Хариуцлагыг үгүйсгэх,

- Хохирлыг үгүйсгэх,
- Хохирогчийг үгүйсгэх,
- Яллагчдыг буруутгах,
- Илүү үнэнчээ харуулах,
- Бурууг бусад руу чихэх,
- Үр дагаврыг буруу тайлбарлах.

Эдгээр арга хэрэгслийн талаар өөр бүтээлүүдэд (*Agnew 1985; Piquero et al. 2005; Jones 2006*) дэлгэрэнгүй дурдсан байдаг учир энд зөвхөн товч авч үзье. Энэ онолд хязгаарлагдмал тал байдаг ч эдгээр арга хэрэгсэл нь авлигыг тайлбарлахад тустай байдаг. Энд хэдийгээр бие даасан тайлбар шиг танилцуулж байгаа ч дурдагдсан ‘хүчин зүйлс’-ийн олонх нь нэгдмэл учраас тус тусад нь бус хамтад авч үзэх ёстой.

Диттенхофер (*1995*) үзэхдээ хүмүүс авлигын үйлдлийг төсөөлсөн, эсхүл бодитой санхүүгийн хэрэгцээ ба баялаг хуримтлуулах хувь хүний шуналаас үүдэлтэй гэж үзсэн нь дарамтыг санагдуулж (*V бүлгийг үз*) байна. Баялгийн төлөөх энэ хэрэгцээ нь мөнгөний шуналаас үүсэж болох ч бас байр суурийн төлөөх шуналаас үүсэж болно. Гэхдээ хууль бус үйлдэлд гараа дүрэх нь эцэстээ ихэнх тохиолдолд ердийн зан үйл болж дараа нь ‘энгийн зүйл’ гэсэн логик үндэслэлтэй болж ирдэг. Тиймээс тогтсон практик гэж харагдан зөвтгөгдөнө. Эдгээр арга хэрэгслийг хувийн болон байгууллагын авлигыг тайлбарлахад хэрэглэж болно. Тухайн үеийн криминологийн олон онолд гэмт хэрэгтнүүд нь хууль дагаж мөрддөг энгийн хүмүүсээс ялгаатай гэж үзэж байсан бол Матза, Сайкес (*1957*) нар залуу хүмүүс гэмт хэргийн ертөнц рүү гулсан орж, гардаг ба тийм зан үйл/үйлдлээ саармагжуулдаг хэмээн үзжээ.

Үйлдсэн гэмт хэргээс үл хамааран олон хэрэгтнүүдэд *хариуцлагыг үгүйсгэх* явдал байсан, байсаар ч байна. Энэ нь

гэмт хэрэгтэн өөрийгөө нөхцөл байдлын хохирогч болсон гэх буюу ёс зүйгүй үйлдлээ арилгахыг оролдох үедээ өөрсдийнх нь хянаж чадахгүй нөхцөл байдалд орсон гэж үзэх тохиолдол юм. Дараагийн арга хэрэгсэл нь *хохирлыг үгүйсгэх* юм. Энэ нь гэмт хэрэгтэн өөрийн үйлдлийг ямар ч хохирол, хор хөнөөл учруулаагүй буюу хэн ч бие махбодын хувьд аюулд өртөөгүй гэх зэргээр маргах тохиолдол юм. Энэ нь улмаар *хохирогчийг үгүйсгэхэд* хүргэдэг. Энэ нь орон байрны хулгайн жишээн дээр эзэмшигч нь хулгайлагдсан зүйлсээ (*эсхүл хулгайлагдаагүй зүйлс нэхэмжлэх буюу өсгөн нэхэмжлэх*) даатгалаас нэхэмжлэх тохиолдлыг хэлнэ. *Яллагчдыг буруутгах* нь цагдаа нар ёс зүйн хувьд бохирдсон учир гэмт хэрэг үйлдсэн хүнийг буруутгах эрхгүй гэж үздэг. *Илүү үнэнчээ харуулах* нь гэмт хэргийг байгууллагын нэрийн өмнөөс үйлдсэн, эсхүл найзыгаа болон хамтран ажиллагчийнхаа амжилтыг хамгаалахын тулд үйлдсэн гэх тайлбар юм. **‘Компанийнхаа төлөө байсан** юм’ гэх тайлбар нь харин тэс өөр байдлаар хэрэглэгдэж болно. Хамтран үйлдэгчдээсээ тусламж гуйхын оронд ‘бурууг бусдад тохох’ эсхүл *бурууг бусдад чихэх* арга хэрэгслийг хэрэглэгчид тэднийг ‘дотоод журам зөрчсөн, эсхүл хууль зөрчсөн үйлдэл гаргаж байгааг байгууллага нь сайн мэдэж байсан бөгөөд нэг бол уг үйлдлийг идэвхтэйгээр дэмжиж байсан, эсхүл зогсоож чадаагүй’ гэж хэлдэг. Бурууг бусдад чихэх нь дээр дурдсан бусад ‘үгүйсгэл’ дээр үндэслэдэг. Шүүхээр орсон жишээнээс харахад санхүүгийн зууч нарыг даргынхаа үгэнд оролгүй, дураар дургисан луйварчин хэмээн буруутгажээ. Сүүлийн үед санхүүгийн салбарт дуулиант хэргүүд олон гарах болсноор ийм шалтаг тавих нь цөөрч байна. Бурууг бусдад чихэх явдал нь *үр дагаврыг буруу тайлбарлах* арга хэрэгслийн шалтгаан болно. Хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хохироосон хүн амины хэрэг, байгаль орчин бохирдуулах, хууль бус болон хорт хаягдал хаях зэрэг байгаль орчны гэмт хэргийн хохиролтой үр дагаврыг гэмт хэрэгтэн сэтгэлзүйн хувьд багаар бодож, зөвхөн

урамшуулалд анхаарах нь энэ арга хэрэгслийн жишээ болно. Хувь хүн, байгууллага, ба улс орон бүгд л эдгээр арга хэрэгслийг хэрэглэж болно. Жишээлбэл, хувь хүн хариуцлагыг үгүйсгэж, байгууллага илүү үнэнчээ харуулахыг оролдож болно.

Эдгээр арга хэрэгслийг тус тусад нь авч үзэх ёсгүй, тэдгээр нь нэгдэн ‘зөвтгөлийн хана’ үүсгэдэг ба ялангуяа баригдсан тохиолдолд хийсэн хэргийн үр нөлөө, ноцтой байдлыг бууруулахын тулд хэрэглэгддэг байна. Ихэвчлэн авлигын хэрэгт эдгээр арга хэрэгслийн жишээ харагддаг ч энд хийж буй тайлбарын гол санаа нь тэдгээр арга хэрэгслийг ашигласнаар бид ихэнх тохиолдолд улс орны хуулийг сайн дураар хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөж байвч түр зуур хуулиас татгалзаж, авлигын үйлдэл болон гэмт хэргийг хүлээн зөвшөөрөх сэтгэлзүйн орон зай үлдсэн байдаг гэдгийг харуулах санаа юм. Энд даатгалын залилангийн жишээ тохирно. Худал, эсхүл хэтрүүлэн нэхэмжлэл гаргах нь нийгмийн гарлаас үл хамааран ихэнх хүмүүст хүлээн зөвшөөрөгдөх зүйл байдаг гэдгийг судалгаа харуулсан (*Tennyson 1997; Button and Brooks 2014*) байна. Тэдгээр арга хэрэгслийг үндэстэн дамнасан байгууллага ямар ч хууль зөрчилгүйгээр татвараас зайлсхийх зэрэг зарим хүний хувьд ёс зүйгүй гэж тооцогдохоор үйлдэлд ч хэрэглэж болно гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Хууль журмыг дагаж мөрдөх үйлдлийг түр зуур хойш тавих энэхүү үйлдлийг ‘гулсах’ (*drift*) гэж (*Matza 1964*) нэрлэжээ. Дүрэм зөрчигчид нь энгийн үйлдлээс дүрэм зөрчих үйлдлийг илүүд үздэггүй гэж тооцогддог. Тиймээс саармагжуулах арга хэрэгсэл болон албан ёсны ёс зүйн тогтолцоог төлөөлөх эрх мэдэлтнүүдийн үзэл санаа хоёрын хооронд ‘далд нийлэмж’ (*subterranean convergence*) (*Lilly et al. 1989:100*) явагддаг гэж үздэг. Энгийн үгээр хэлбэл энэ нь эрх мэдэлтэй хүмүүс ихэнх тохиолдолд залуу хүмүүсийн гаргасан зөрчилд тэдний эцэг эхийг нь буруутгах, хохирогч өөрөө өдөөн хатгасан гэж үзэх, хэрэг золгүй явдал байсан, эсхүл өөрийгөө хамгаалах үйлдэл

байсан гэх тайлбарыг нь хүлээн авах замаар уучилж буйг хэлж байна. Матза ба Сайкес нарын хувьд (1961) эдгээр ‘далд үнэт зүйл’ нь Веблэний (Veblen 1899) Зав чөлөөт давхрааны онол (*Theory of the Leisure Class*) бүтээлдээ үзүүлсэн шиг хууль бусаар их хэмжээний санхүүгийн ашиг олох хүсэлтэй бизнесийг зүгээр л дуурайж байгаа хэрэг юм. Мөн гэмт хэрэг үйлдэхдээ хувь хүний зан үйл болон үйл хөдлөлийн талаар тогтсон шалтаг (‘*золгүй явдал болсон*’ гэх, *сэтгэцийн хувьд эрүүл бус* гэж *өргөдөл гаргах, шүүхээр орж чадахааргүй өвчтэй эсхүл хөгширсөн гэх*) тоочиж буй хэрэг аж.

Гэхдээ дүрэм зөрчих үйлдэл нь хяналтаа бүрэн алдаж дэлбэрсэн гэхээс илүү чөлөөт сонголтын хүчин зүйлтэй холбоотой байдаг. Гулсах үйл явц явагдахын тулд бэлтгэх болон арга барагдахын (*desperation*) аль аль нь шаардлагатай гэж Матза (1964) үзжээ. Бэлтгэх гэдэг нь хүн ёс зүйн дүрмийг эсхүл хууль, журмыг зөрчих үйлдлийг амжилттай хийж болно гэдгийг мэддэг болсон байх, мөн бүх хүн ижил төстэй үйлдлийг баригдалгүйгээр хийх чадвартай гэдгийг ойлгох үйл явцтай холбоотой (*Lilly et al. 1989*). Хэрэв хүн баригдах аюул, эрсдэлийг бууруулж чадна гэж өөртөө итгэлтэй байвал гулсах боломжтой юм. Арга барагдахыг Матза хүн өөрөө бус хувь тавилан л хэт их зүйлийг шийдэж байна гэх сэтгэгдэл ба хувь хүнийхээ хувьд үйлдэл хийх хэрэгцээ гэж тайлбарласан. Эдгээр хүчин зүйл нь өсвөр насныхантай холбоотой боловч авлигын үйлдлийн хувьд төлөвлөх, үйлдэл хийх, түүнийгээ зөвтгөхөд бэлтгэл хийгдсэн байх шаардлагатай ба санхүүгийн салбарт аргаа барсан байдал байсан нь (*доороос үзнэ үү*) харагддаг.

Диттенхофер (1995), Зэйтлин (2001) нарын бүтээл болон шударга бус байдал ба сэтгэл ханамжгүй байдлын (**injustice and dissatisfaction**) синдром нь саармагжуулах арга хэрэгслийг дэмжих үндэслэл болдог. Ажил олгогчийг шударга бус гэж харсны улмаас ийм төрлийн зан үйлийг зөвтгөн үздэг. Ялангуяа ажлын нарийн зохицуулалттай орчин нөхцөлд (*Zeitlin 2001*)

ийм байдаг. Энэ нь нарийн зохицуулагдсан, дүрэм журамд баригдсан орчин нөхцөлд авлигын үйлдэл яагаад боломжтой байх вэ гэдэг асуулт төрүүлдэг. Хувь хүн өсөж дэвшиж чадахгүй байх, эсхүл ажил олгогчийн зүгээс чухал бус гэж тооцогдох, албан тушаал дэвшиж чадалгүй орхигдохтой холбоотой сэтгэл ханамжгүй байдал ба шударга бус байдлыг мэдрэхээс үүдэн ихэвчлэн авлигын үйлдэл (*Tucker 1989*) гардаг. Ингэж орхигдуулах эсэх нь тухайн хувь хүний байгууллагадаа эзлэх байр суурь хийгээд ажил эрхлэлтийн нөхцөлөөс хамаарна. Хэрэв байгууллага нь ажилтнуудыг цалин, урамшууллаар нь ялгаварлахаар бүтэцчилэгдсэн бол ажилтнууд багаар ажиллахын оронд хоорондоо илүү их өрсөлдөх болно. Ийм өрсөлдөөнийг дэмжиж болох ч энэ нь удирдлагад юмыг зөвхөн өөрийнхөөрөө ялгамжтай харж, ажиллах нөхцөлийг сайжруулж, цалинг нэмэгдүүлэх хувийн хариуцлагаас зугтах боломж олгоно. Хангалттай цалин өгсөн ч гэсэн зарим ажилтнууд авлигын үйлдэл (*Brooks et al. 2013*) гаргана.

Энэ шударга бус байдлын нэг хэсэг нь нэг компанид удаан ажилласан ажилтан компанидаа зориулсан хувийн хичээл зүтгэл нь бүрэн үнэлэгдээгүй гэж үзэх хандлага буюу ‘надад өртэй’ гэх хандлага гэж нэрлэгддэг. Марс (*Mars 1982, 1984*), Холлингер ба Кларк (*Hollinger and Clark 1983*) нар ‘надад өртэй’ гэсэн ойлголтоос үүддэг энэ төрлийн залилан нь ихэвчлэн бага хэмжээтэй, голчлон санхүүгийн урамшууллын дутуугаа нөхөх хэмжээд байдаг гэж үзжээ. Энэхүү синдром дээр үндэслэн Марс (*1984*) эго-д үүрэг роль байна гэдэг санаа дэвшүүлсэн байна. Санхүүгийн урамшуулал нь хүлээн зөвшөөрөгдөх хэрэгцээтэй холилдоно. Бизнесийн хувьд энэ хэрэгцээ нь хувийн харилцаа ба гэр бүлдээ хүлээн зөвшөөрөгдөх хэрэгцээ байж болох боловч бас олон нийтээс амжилт, үр дүнг сайшаах хэлбэртэй байж болно. Энэ бүх тайлбар нь мэдээж хязгаарлагдмал боловч хүмүүс яагаад авлигын үйлдэл хийдэг болохыг ойлгох ерөнхий бүтцийг бидэнд өгч байна. Хувь хүний авлигын үйлдэл нь нийгмийн

вакуум орчинд үйлдэгддэггүй учир эдгээр ялгаатай онолын аргачлал нь нэг нэгийгээ нөхөж тал бүрээс нь тайлбарлаж байдаг. Тиймээс бид хувь хүн, байгууллага үйл ажиллагаа явуулж буй нийгмийн орчин нөхцөлийг анхаарах хэрэгтэй.

Ийм арга хэрэгсэл цахим гэмт хэрэг, эсхүл онлайн орчинд дэггүйтэх үйлдэл гаргадаг хүмүүсийн хувьд ч гэсэн ажиглагддаг боловч тэд үүнийгээ цахим эрэл хайгуул хийсэн гэж (*Jar 2013*) зөвтгөдөг. Ийм үйлдлийн жишээ нь Ашлэй Мадисоны болзооны сайтыг хакердаад үйлчлүүлэгчдийг нь ‘ёс зүйгүй’ хэмээн ил зарласан тохиолдол юм. Мөн програм хангамж, мэдээлэл, кино, дуу хөгжмийг цахимаар хулгай хийсэн ч тэдгээр ‘хакер’-ууд нь цахим орчинд хүмүүс тэдгээр соёлын үзүүлбэрүүдийг үзэх эрхтэй бөгөөд аль ч байгууллага интернэтэд онцгой эрхтэй байх ёсгүй хэмээн тайлбарлах жишээнээс үүнийг харж болно.

Коулман (*1987, 1995*) цагаан захтан гэмт хэрэгтнүүдийн хэрэглэдэг саармагжуулах арга хэрэгслийн ангиллыг бий болгожээ. Үүнээс хамгийн түгээмэл арга хэрэгсэл нь хор хохирлыг үгүйсгэх байдаг. Ялагдсан цагаан захт гэмт хэрэгтнүүд ихэвчлэн тэдний үйлдэл нь хэнийг ч хохироогоогүй, тийм учраас тэд ямар ч буруу зүйл хийгээгүй гэгцгээдэг гэж Коулман бичжээ. Энэ арга хэрэгсэл нь авлигын хэргийг саармагжуулахад нэлээд илэрхий харагддаг. Хэдийгээр авлигажсан үйлдэлд холбогдогчдын харилцан хамаарал нь авлигын үйлдэл, хахууль авагч, хохирогч гэсэн гурвалсан хамаарал байна гэж тодорхойлогддог ч ихэвчлэн хохирогчийг тогтооход илүү хүндрэлтэй байдаг. Мэдээж бусдыг хохироосон үйлдлийг олж харъя гэвэл үргэлж олж харж болно. Жишээлбэл, гэрээгээр гүйцэтгэх ажил авахаар тендерт оролцоод авч чадаагүй бизнесийнхэн, орон нутгийн албан хаагчдад бага хахууль өгснөөсөө болоод бага тусламж авч буй дүрвэгч нар (*Button et al. 2015*), улс төрийн тогтолцооны шударга байдал (*Heywood 2015*) алдагдах зэрэг байж болно. Гэхдээ хэрэв хоёр

тал аль аль нь авлигаас ашиг тус хүртэж байвал ихэвчлэн ямар ч хор хохирол гараагүй гэдэг байр сууриа хадгалахад амар байдаг.

Коулманы тэмдэглэхдээ (1987, 1995) саармагжуулах арга хэрэгслүүд нь цагаан захтны гэмт хэргийн шалтгааныг сүүлд нь зөвтгөж тайлбарлаад зогсохгүй дүрэм зөрчихийн өмнө явагдаж болох бөгөөд тэгснээр үл дагаж мөрдөх явдлыг ёс зүйн хувьд дэмжиж болно гэжээ. Рационалчлал буюу логик үндэслэл гаргах нь хэн нэгэн өөрийн зан үйлийг зөвтгөхөөр бодож олсон үйл явдал болсны дараах шалтаг бус ‘үйлдэл гаргагчийн мотиваци буюу үүдлэгийн салшгүй хэсэг (Coleman 1987:411) юм’. Энэ нь хүн саармагжуулах арга хэрэгсэлтэй байх нь авлигад оролцож, хахууль өгч, эсхүл авах амин чухал нөхцөл болно гэсэн таамаглалд хүргэнэ. Илэрхий бололцоо ба хяналтын механизм хязгаарлагдмал байхаас гадна эдгээр саармагжуулах арга хэрэгсэл нь авлигын судалгааны чухал судлагдахуун болдог.

Цагаан захт гэмт хэрэгтнүүдийн хэрэглэдэг хоёр дахь саармагжуулах арга хэрэгсэл нь тэд зөрчиж буй хуулиа шаардлагагүй, эсхүл бүр шударга бус гэж үзэх арга юм. Энэхүү логик үндэслэлд түшиглэдэг гэмт хэрэгтнүүдийг нөлөө ихтэй нео-либерал эдийн засгийн үзэлтнүүд дэмждэг ба тэд зах зээл нь төрийн оролцоо зэрэг хүний бий болгосон саадгүй тохиолдолд л хамгийн их үр ашигтай байдаг гэж үздэг аж. Авлигын тухайд бол энэ нь сонирхолтой хэрэг болно. Учир нь олон улсын бизнесийн шахалтаар Дэлхийн банк, ОУВС, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Европын Холбоо зэрэг олон улсын байгууллагууд улс авлигыг хориглож, авлигаас сэргийлэхийг ‘хүчээр’ тулгадаг. Энэ нь үндэстэн дамнасан корпорациуд зах зээлд нэвтрэх боломжоор ижил байх тоглоомын талбайг үүсгэх гэсэн оролдлого юм. Үндэстэн дамнасан байгууллагууд дэлхий нийтэд аль болох зардал багатай бөгөөд рационалаар үйл ажиллагаа явуулах боломжтой байхыг хүсдэг. Хэдийгээр бизнесүүд нь янз бүрийн улсад, эсвэл бүр бүтээн байгуулалтын нэг том төслийн хүрээнд ч хууль ёсны

ба хууль бус аль аль төрлийн үйлдлийг хийдэг ч гар цайлгах, хахууль өгөх тогтолцоо нь урьдчилан таамаглах бололцоогүй, найдваргүй, зардал ихтэй (*Beare 1997*) байдаг. Гэхдээ эдгээр зохицуулалт нь орон нутгийн эдийн засгийг золиослох замаар зөвхөн олон улсын бизнесийг дэмжиж магадгүй ба тэгснээр орон нутгийнхан тусламжид найдах бодлогыг нэмэгдүүлж, бараа, үйлчилгээний далд зах зээлийг хөгжүүлнэ.

Гурав дахь саармагжуулах арга хэрэгсэл буюу зохицуулалтыг зөрчих нь: Үүнийг эдийн засгийн гол зорилтдоо хүрэх, эсхүл өрсөлдөөнт орчин нөхцөлд амьд үлдэхэд шаардлагатай зүйл гэж үзэх явдал юм. Авлигын идэвхтэй болон идэвхгүй аль аль талд энэ саармагжуулалтыг ажиглаж болно. Хахууль өгч буй хүмүүст хэдийгээр энэ нь хүсмээр зүйл биш ч бизнес хийхэд зайлшгүй гэж хэлнэ. Хахууль хүлээн авч буй хүн цалин нь амьдралд хүрэлцэхгүй тул гэр бүлээ тэжээхийн тулд нэмэлт орлого хэрэгтэй гэж хэлж магадгүй. Яллагдсан цагаан захт гэмт хэрэгтнүүд өөрсдийн зан үйлээ зөвтгөхөд эдгээр гурван төрлийг хэрхэн хэрэглэдгийг Бенсон (*1985, 1998*) тодруулан судалжээ. Эдгээр хэрэгтнүүдийн өгсөн мэдүүлэг нь үйлдэлдээ төвлөрдөг ба зан үйлийнхээ ердийн, хүлээн зөвшөөрөгдөх байдлыг (*ердийн бизнес*) хэмээн онцлох, эсхүл үйлдлээ тэдний энгийн үеийн зан үйлийн хэв байдлыг төлөөлөхгүй жирийн бус зүйл байсан гэж тодорхойлдог. Эсхүл тэд гэмт үйлдлийн шинж чанарыг эцсийн эцэст юу ч гэж тодорхойлсон бай тэр нь тэдний 'бодит' шинж чанарыг илэрхийлэхгүй. Тэд өөрсдөө бол энгийн, ойлгож болох хувь хүмүүс гэх байдлаар өөрсдийгөө гэмт үйлдлээс тусгаарлан үзэж, түүний онцлог шинж чанарыг тодотгон тайлбарладаг байна.

Дөрөв дэх саармагжуулах арга хэрэгсэл нь хариуцлагыг гэмт хэрэгтнээс бүлэгт шилжүүлэх явдалд байдаг. Энэ нь ялангуяа авлига бугшмал шинжтэй байх үед хэрэгтэй байдаг. Хахууль өгч, эсхүл авч байгаа аль аль тал нь 'бүх хүн л тэгж байна' гэж хэлэх байх. Энэ арга хэрэгсэлд тохирох логик

үндэслэл нь бусад бүх хүнийг яллаагүй цагт хуулиар тавигдсан хязгаарыг давсан нэг хүнийг яллах нь шударга бус гэх тайлбар байдаг.

Тав дахь саармагжуулах арга хэрэгсэл нь хүн өөрийн зан үйлээ бусдын хүлээлтэд тохируулсан төдий үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй бөгөөд тиймээс гэмт хэрэгтэн гэж хочлогдох боломжгүй гэх хэрэгсэл юм. Дунд түвшний менежерүүдийн логик үндэслэл ихэвчлэн ийм байдаг. Тэд нийгэмшүүлэх үйл явцаар дамжсан дарамтын (*V бүлгийг үз*) нөхцөл байдалд байдаг. Ийм нөхцөлд хүмүүс дээд түвшний менежерүүдийн тогтоосон зорилтод хүрэх хүлээн зөвшөөрөгдөх арга нь хахууль гэж үздэг ба тэтгүүлэх болон ивээн тэтгэх явдал бугшмал үед хахууль өгөх ба авах нь мэдээжийн зүйл болсон байдаг. Түүнчлэн мэргэжлийн олон гэмт хэргийн хувьд хэрэг үйлдсэн этгээд нь мөнгө авах гавьяатай хүмүүс юм гэдэг үндэслэлээр зөвтгөгддөг. Энэхүү логик үндэслэл нь өдөр тутмын хэлбэрийн хахуульд илүү давамгайлах боловч байгууллагын авлигын тухайд хэрэглэхэд хязгаарлагдмал байдаг.

Саармагжуулах арга хэрэгслийн хязгаарлагдмал талууд

Социологи болон криминологийн энэхүү онол, зөрчлийн үйлдэл (**заавал хууль бус биш**) нь ердийн зүйл бөгөөд хүмүүсийн ихэнх нь мансууруулах бодис хэрэглэх зэргээр зөрчлийн үйлдлийг гаргаж болзошгүй хэмээн тайлбарлаж байсан 1960-аад онд түгээмэл байлаа. Гэхдээ одоо бол эдгээр арга хэрэгсэл нь онц хэрцгий үйлдэл болон ноцтой зөрчлийг давтан гаргаж буй хувь хүн, эсхүл байгууллагын талаар олигтой тайлбар өгч чадахгүй байна. Мөн энэ онолыг хураангуйлж болохоор харагдаж байна. Тухайлбал, залуу хүмүүст зөрчлийн үйлдэлд оролцох, эсхүл түүнээс татгалзах эсэх талаар ямар нэг хэмжээгээр хяналт, сонголт байдаг ч гэсэн тэд өөрсдийн

удирдаж чадахгүй гадаад нөхцөл байдлын улмаас дүрэм зөрчих үйлдэл рүү гулсан орж байна гэж Матза бичжээ. Тийм учраас саармагжуулах арга хэрэгсэл нь хувь хүмүүсийг өөрсдийнх нь дотоод үнэт зүйл ба бусдын хариу үйлдлээс бүрэн хамгаалах хүчгүй байж (*Lilly et al. 1989*) болно. Түүнээс гадна зарим хувь хүмүүс хуулийг дагаж мөрдөх ертөнцтэй ямар ч хамааралгүй байвал тэдгээр арга хэрэгсэл нь тэдний бодол, үйлдэлд ямар ч нөлөөгүй байж болох юм.

Эдгээр арга хэрэгслийг цаашид судлах, ялангуяа авлигын үйлдэл ба түүний дагалдах зөвтгөлийн талаар судлах хэрэгтэй. Зарим хувь хүн/бүлэг тэдгээр арга хэрэгсэлд илүү өртөмтгий байж болох учир судлаачид саармагжуулах арга хэрэгслийн нас, нийгмийн анги давхраа, үндэс угсааны тархалтыг ойлгож авах хэрэгтэй байна. Энэ нь тодорхой төрлийн үйл хөдлөл, зан үйлтэй хамаарах хамаарал, хандлагын тогтолцоо болохын хувьд саармагжуулалтын дотоод бүтцийг ойлгох шаардлагатай болно гэсэн үг. Тодорхой арга хэрэгсэл нь тухай үйлдэлд бусад үйлдлээс илүү тохирсон байж болох ч үүнийг хөгжүүлэх шаардлагатай байж болно.

Авлигын агуулгад: Гулсах ба саармагжуулах үйлдлийг тайлбарлах нь

Энэ хэсэгт хувь хүн ба байгууллагын авлигын үйлдлийг үйлдэл гарсан нийгмийн орчин нөхцөлд авч үзнэ. Тэгэхдээ маш олон тооны жишээ байгаа учир энд нэг тохиолдлыг гүнзгий шинжлэлгүйгээр олон давтагдаж буй арга хэрэгсэл ба үйлдлийг тодруулж үзэх болно. Энэ нь авлигын үйлдлийн ач холбогдлыг түүхийн хуучирсан зүйл хэмээн бууруулах бус дээр дурдагдсан арга хэрэгслийг гарсан орчин нөхцөлд нь ойлгох оролдлого болно.

Авлигын талаарх олон бүтээлд хүмүүс залилан болон авлигын үйлдлийг тусгаарлагдмал байдлаар үйлддэггүй. Харин ганцаараа үйлдэл хийх боловч ихэвчлэн байгууллагын нэг хэсэг болж байдаг ба байгууллага нь хүний зан үйлд нөлөөлөх боломжтой бөгөөд нөлөөлж байдаг гэж (*Gobert and Punch 2007*) тэмдэглэжээ. Яагаад хүмүүс авлигын үйлдэл гаргадаг вэ гэдгийг тайлбарлахад байгууллагын соёл чухал хүчин зүйл болно гэж үздэг. Марс (*1982, 1984*) байгууллагын соёл хэрхэн ялгагддаг, боломж, харилцаа, ажлын байрны динамик нь авлигын үйлдэл гаргах дур сонирхолд хэрхэн нөлөөлдөг болохыг харуулсан. Хувь ажилтны үйл хөдлөлд байгууллагын соёлын үзүүлэх нөлөөллийн хэмжээ нь олон хүчин зүйлээс хамаарна. **Үүнд:** ажилтны ажил мэргэжил нь тогтсон дүрэм журмаар зохицуулагдах хэмжээ; байгууллагадаа гүйцэтгэх үүрэг нь ялгагдах байдал; ажилтнууд бие биеэсээ тусдаа байгаа эсэх багтана. Мөн ажилтнуудын нэг нэгнийхээ талаар авах төсөөлөл, байгууллагын соёл зэрэг нь бусдаас хамаарах эсхүл бусадтай өрсөлдөх хэмжээний шалтгаан болж (*Brooks et al. 2013*) өгдөг.

Хэдийгээр байгууллагын соёл чухал ч компанийн зарим хэсэг нь хууль бус зан үйлийг хянах, эсхүл дэмжихэд гол үүрэг гүйцэтгэж болно. Жишээлбэл, үнэтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг орчин нөхцөлд ажиллах нь авлигад хүргэж болох боловч тэр хэсгийн соёлыг нөлөө бүхий нэг хүн тодорхойлж болно. Тэр хүн нь хувийн болон мэргэжлийн хувьд шударга байвал түүнийг дагаад бусад нь авлигын үйлдэл гаргах хүсэл буурна. Тиймээс бид байгууллагыг зүгээр л авлигажсан гэж харж болохгүй. Учир нь тухайн орчин нөхцөлд ажиллаж буй зарим хүмүүс хууль бус үйлдэл гаргах өдөөлтийг эсэргүүцнэ. Тэгэхээр залилан болон авлигын үйлдэл гаргах сонирхолтой байж болзошгүй байгууллага дахь нөлөө бүхий хувь хүмүүс ба хэсгүүд, мөн бүлэглэлийн бүтцэд анхаарсан нь дээр. Гэхдээ байнга хэрэг, дуулиан гарах нь үнэнч шударга ажилчдын шударга

байдлыг гэмтээдэг аюултай. Гэтэл шударга бус зүйл хийдэг зарим ажилтнууд тодорхой хугацаагаар ажлаас түдгэлзэх, эсхүл байгууллагадаа албан тушаал хаших боломжгүй болохоос өөрөөр шийтгэл хүлээлгүй өнгөрдөг.

Байгууллагын авлига гэж юу болох, хэрхэн үүсдэгийг ойлгохын тулд дээр дурдсан шиг мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд гэмт хэрэг үйлдэх үйлдэл болон байгууллагад системтэйгээр, хамтарсан байдлаар дүрэм зөрчих явдал хоёрыг ялгаж үзэх (*Braithwaite 1985*) хэрэгтэй. Гэхдээ Смит нар (*Smith et al. 2012*) тодорхойлолтын дагуу байгууллага өөрийн үйлдлийг ухамсарлан бодож, үйл хөдлөл хийх боломжгүй. Залилан гэх мэт гэмт хэргийг байгууллага үйлдэх боломжгүй гэж үзсэн. Коулман (*1999*) үүний эсрэг санал дэвшүүлж, хэдийгээр байгууллагыг хувь хүмүүсийн нэгдэл удирддаг боловч хувь хүмүүсийн гүйцэтгэж буй чиг үүргийн энэхүү нэгдэл нь эдгээр ажилтнуудын зан үйлийг тодорхойлдог гэсэн. Тэр утгаар хувь хүний ажиллаж буй бүтцэд хувь хүний ёс зүй ач холбогдол (*Boisjoly 1995*) багатай. Байгууллагын үйл хөдлөлийг хувь хүний ёс зүйн стандарт ба сайн чанар шийдэхгүй. Харин эсрэгээрээ байгууллагын бүтэц ба соёл нь бүтэцчилэгдсэн орчин нөхцөл ба саармагжуулах арга хэрэгслээр дамжин хүний үйлдэл, харилцааг ‘чиглүүлдэг’.

Энэ үзэл бол шинэ зүйл биш. Эдвин Садерланд (*1949*) яагаад ‘амжилттай’ яваа хүмүүс цагаан захтны гэмт хэрэг үйлддэг вэ гэдгийг ойлгохыг эрэлхийлсэн. Ялгаатай нөхөрлөлийн онолд түшиглэн гэмт хэрэг гэдэг бол гэмт хэргийн хандлага нь гэмт хэргийн бус хандлагыг давамгайлах нөхцөл ба хууль зөрчсөн хүмүүстэй хамт ажиллах замаар түүнд суралцдаг зүйл гэж (**IV бүлгийг үз**) тайлбарласан. Гэхдээ энэ нь ажилтнууд яагаад, хэрхэн цагаан захтны гэмт хэргийн хандлагыг хүлээн авахгүй байна вэ гэдгийг тайлбарлаж чаддаггүй. Үнэндээ Брэйтвэйт (*1985*) ялгаатай нөхөрлөлийг хуулийн этгээдийн гэмт хэргийг тайлбарлах гэсэн ‘улиг болсон оролдлого’ гэж үгүйсгэсэн.

Энэ онол нь ядаж л ‘эрх мэдэлтэй хүмүүсийн гэмт хэрэг’-ийг тайлбарлахыг оролдсон ба гэмт хэргийн дэд соёлыг анхаарах явдлыг (*V бүлгийг үз*) нэмэгдүүлжээ.

Хүний үйлдэл, харилцааг чиглүүлдэг байгууллагын бүтэц хийгээд соёлын жишээ нь хохирогчийг үгүйсгэх арга хэрэгсэл юм. Энэ нь гэмт этгээдүүд хохирогчид хүртэх ёстойгоо хүртэж байна хэмээн үзэж, ‘зүй бус’ зан үйл, биеийн ба сэтгэл зүйн үйлдлийн үр дагавар, хувь хүмүүст эсхүл байгууллагын нэр хүндэд үзүүлэх нөлөөллийг хүлээн зөвшөөрөхгүй байх тохиолдол юм. Жишээлбэл, цагдаагийн байгууллагын соёл ба авлигын талаарх бүтээлд энэ талаар арвин баримт (*Sherman 1978; Shearing 1981; Punch 1985, 2000*) байдаг. Гэхдээ цагдааг дарангуйлагч болон ардчилсан зэрэг янз бүрийн улс орон ба нийгмийн янз бүрийн хэсэгт ялгаатайгаар хардаг.

Брэйтвэйтын хувьд (*1995*) байгууллага гэмт хэрэгтэн мөн үү, эсхүл гэмт хэрэгтэн болох уу гэдэг асуудал нь зорилгодоо хууль ёсны дагуу хүрч чадах боломжийн хэмжээнээс хамаарна гэжээ. Хэрэв байгууллага хууль зүйн дагуу түүнд хүрч чадахгүй бол амжилтад хүрэх зорилгоо биелүүлэхийн тулд хууль бус арга барилыг (*дарамтын талаарх V бүлгийг үз*) ашиглаж (*Levi 2008*) болзошгүй. Гэхдээ ихэнх байгууллагууд нь хууль ёсны дагуу, эсхүл хууль бус маягаар удирдаж болохоор бүтэцчилэгдсэн байдаг. Бүтэц бол асуудлын зөвхөн нэг хэсэг. Дээд түвшний удирдлагын үүрэг ба хандлага хууль ёсны байгууллагыг угаас гэмт хэрэг гаргах хандлагатай байгууллага болгож хувиргаж болно. Слаппер, Томбс (*Slapper and Tombs 1999*) нарын үзүүлснээр ашгийн төлөөх шаардлагын улмаас байгууллагууд эдийн засгийн, санхүүгийн, хууль зүйн дарамтад хариу үйлдэл болгон авлигын үйлдлийг гаргадаг байна. Энэ нь бүх байгууллага хууль бус үйлдэл гаргана, эсхүл эдийн засгийн болон санхүүгийн дарамтад хариу үйлдэл болгон авлигын үйлдэл гаргана гэсэн үг биш. Гэхдээ хямралыг даван туулсан

даруй тэд хүлээн зөвшөөрөгдөх бизнесийн үйл ажиллагаандаа эргэн шилжих магадлалтай гэсэн үг.

Бокс (1983) хямралын үед байгууллагын хэмжээнээс үл хамааран залилан өсдөгийг (*Cook and Zarkin 1985; Dow 1998; Knoop 2004*) харуулсан. Энэхүү өсөлтийн зарим нь 1980, 1990-ээд оны үеийн хөрөнгийн ба бизнесийн зах зээлийн зохицуулалтыг сулруулснаас үүдэлтэй байжээ. Энэ тайлбар нь хурдацтай шинэчлэл нь зохион байгуулалттай эрүүгийн бизнесийн бүлэглэлийг үүсгэж, дэлхий өөрөө бүтээгдэхүүн, үйлчилгээнд нээлттэй болохын хэрээр дэлхий даяарх бизнесээс хөрөнгө ба ур чадварыг олж авч, шинэ зах зээл хайх болсон ОХУ дахь авлигыг тайлбарлахад зарим талаар ач холбогдолтой байдаг. Улс төр болон Оросын нийгмийг зах зээлчлэх явдал нь номенклатур буюу намаас сонгогдсон эрх мэдэлтнүүдийн давхаргад илүү ашигтай байв. Тэд зарим талаар дасан зохицож, зарим талаар өөрчлөгдөн шинэ элитүүд (*Goldman 2003; Rawlinson 2012*) болжээ. Тэд бизнесийн туршлага бүхий хагас хууль ёсны үйлдвэрлэгчид болон хувирч, өршөөлгүй үйл ажиллагааны арга барилтай, чөлөөт бизнесийн яахаас ч буцахгүй ертөнцөд амьд үлдэхэд шаардлагатай ур чадварт суралцсан бөгөөд хууль ёсны зааг дээрх тогтворгүй нөхцөлд амьдрах чадвартай болсон аж. Энэ нь хүмүүс хувийн амжилтаас байгууллагын зорилтыг дээгүүр тавьдаг болж нийгэмчлэгдэх хэрээр олон улсын өрсөлдөөн ширүүссэн явдал ба дэлхий нийтийн зах зээл дээр амьд үлдэхийн төлөөх тэмцэл нь хувь хүний хариуцлагагүй байдлын этикийг нэмэгдүүлсэн гэх Тэйлорын үзэлтэй нийцэж (1999) байна. Ашгийн төлөөх энэ өсөн нэмэгдсэн өрсөлдөөн дунд зарим бизнесүүд гэмт хэргийг үүсгэгч болжээ.

Энэ номд дурдагдсан өндөр албан тушаалтнуудын олон дуулиант хэрэг нь бизнес дэх ёс зүйн шударга байдал буурсных уу, эсхүл хууль зөрчих болон түүнийг нь мэдээллийн хэрэгслээр мэдээлэх явдал ихэссэнийг нийгэм хүлцэн тэвчихгүй болж ирснийх үү гэдгийн аль нь болох нь маргаантай. Гэвч 'шударга

байдал' ба 'шударга байдлын менежмент' гэж юуг хэлээд байна вэ. Шударга байдал гэдэг нь хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйл ба институцүүд дэх нийтлэг сахилгын дүрмийг баримтална гэсэн үг. 'Шударга байдлын менежмент' нь тэгвэл удирдлагын зүгээс шударга байдлыг өдөөж, баталгаажуулах болон тухайн байгууллага дахь зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд авах арга хэмжээ, тогтоосон процессыг хэлнэ.

Шударга байдлын менежментэд хандах хоёр төрлийн аргачлал байдаг. **Үүнд:** дүрэмд суурилсан гадаад аргачлал ба үнэт зүйлд суурилсан аргачлал багтдаг. Гадаад аргачлал нь албан ёсны тогтолцоо бөгөөд авлигыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх дэлгэрэнгүй процессыг агуулна. Үнэт зүйлийн аргачлал нь зааварчилгаа ба дотоод хяналтад анхаарсан арга юм. Үнэт зүйлийн аргачлалыг байгууллагын гишүүд хэрэгжүүлж, хувь гишүүдийг хянахаас илүү тэднийг дэмжихийг зорьдог. Эдгээр аргачлалыг дангаар нь хэрэглэхээс илүү аль алиныг хослуулан хэрэглэх нь үр дүнтэй. Тухайлбал, дүрэмд суурилсан аргаар анхан шатны хуулийн тогтолцоог бий болгох бөгөөд хэрэв байгууллага доторх үнэт зүйлс нь зөв бол хувь гишүүд нэг нэгийгээ хянах нь үр (*Maesschalck and Vanden Auweele 2010*) дүнтэй.

Байгууллагын ийм үйлдэл амжилтад хүрэхэд олон саад бий. Эдгээр нь ихэвчлэн дээд түвшний удирдлагын зүгээс гардаг бөгөөд аливаа юмыг буруу гэх соёл ба үгүйсгэх арга хэрэгслийг дэмжсэний үр дагавар байдаг. Байгууллагад шударга байдлын асуудал байж болох боловч шударга байдлын менежментийн тогтолцооны нэг хэсэг болсон зохих ёсны илрүүлэх тогтолцоогүйгээр тийм гэж хэлэх боломжгүй. Түүнээс гадна хэдийгээр зөрчил бага байсан ч бүх байгууллага зөрчилдөөнт хэцүү сонголттой тулгардгаа хүлээн зөвшөөрдөг бөгөөд удирдлагын ямар ч тогтолцоо нь асуудлыг үгүйсгэж, байхгүй гэхийн оронд уян хатан байж, тохирох хариу үйлдлийг олох хэрэгтэй байдаг.

Хэрэв тийм арга шударга байдлын менежментийн тогтолцоог байгуулж буй компаниас анхаарлыг нь холдуулж чадахгүй бол байгууллага доторх үл итгэлцэх явдлыг хүчирхэгжүүлж сөрөг үр дагавар үүсгэж магадгүй юм. Энэ бол харалган хэрэг. Байгууллага доторх авлигыг ил болгож арга хэмжээ авах замаар ирээдүйн хэрэг дуулианыг бууруулах боломжтой. Хэрэв ач холбогдол өгөхгүй бол ирээдүйн авлигын үйлдэл ихээр нэмэгдэж тэр нь байгууллагын шударга байдлыг бүр илүү гэмтээж болно. Энд тохирох жишээ бол хөл бөмбөгийн ба маркетингийн ертөнцийн зарим хүмүүс авлигын үйлдэл гаргаснаа зөвшөөрснөөр ОУ-ын хөл бөмбөгийн холбоонд ажилладаг бүх хүний нэр хүндийг ихээр унагасан жишээг дурдаж болох юм.

Түүнчлэн байгууллага дахь авлигын тохиолдлыг багасгахад учирч болзошгүй саад нь байгууллагын шударга байдлын ач холбогдлыг доошлуулах явдал юм. Ямар ч тогтолцоо авлигыг бүрэн зогсоохгүй. Харин бууруулах оролдлогоос зайлсхийх нь зүй бус зан үйлийг өөгшүүлнэ. Жишээлбэл, байгууллага сахилгын дүрэмтэй ч хэрэгжүүлэхгүй бол хүмүүс нь шударга байдлын тогтолцоогоо зөвхөн бусдад харуулах зүйл гэж харахад (*Trevino and Weaver 2003*) хүргэнэ. Эрсдэлийн шинжилгээ, ёс зүйн асуудлын шинжилгээ, ажилтан ба харилцагчидтай зөвлөлдөх, сахилгын дүрэм, сургалт, зөвлөгөө өгөх, шүгэл үлээгчийн бодлого, мөрдөн шалгах, шийтгэх гэсэн шударга байдлын менежментийн хэрэгслүүд нь бүгд чухал.

Эрсдэлийн шинжилгээ нь бизнесийн эмзэг хэсгийг тодруулж шинжилдэг нэг хэрэгсэл боловч дангаараа бол тийм ч хэрэгтэй бус. Жишээлбэл, эрсдэлийн шинжилгээгээр тодорхой тогтолцоог санал болгож болох ч хэт хязгаарласан тогтолцоо байвал менежментийн зүгээс итгэл хүлээлгэхгүй байгаагийн илрэл хэмээн харагдаж ажилчдын шинэ санаачилга, ажлын ёс зүйд муугаар нөлөөлж болзошгүй. Ёс зүйн, эсхүл сахилгын дүрэм боловсруулах нь урагшлах нэг зам боловч бүх

ажилтнуудыг оролцуулах нь чухал юм. Хэрэв тэгэхгүй бол тэдгээр дүрэм нь институц дахь бүх хүний эзэмшлийн зүйл гэхээс илүү удирдлагын өмч гэж харагдана. Гэхдээ сахилгын дүрэм нь ёс зүйн дүрмээс маш их ялгаатай. Сахилгын дүрэм нь дүрэмд суурилсан зүйл бөгөөд хүмүүс өөрсдийн сонирхолд үндэслэн үйл хөдлөл хийдэг ба хариуцлага хүлээлгэх айдсын дор л шударга ажилладаг гэсэн таамгаас үүдэлтэй. Ёс зүйн дүрэм нь үнэт зүйлд үндэслэсэн арга ба хүмүүсийг ёс зүйн дүгнэлт гаргах чадвартай гэж (*Maesschalck and Vanden Auweele 2010*) үздэг. Аль ч тогтолцоог үл тоож, эсхүл тэр тогтолцоог зөвхөн цаасан дээр байлгаж байх нь учир утгагүй юм. Энрон компани Ёс зүйн хороотой байсан боловч тэр нь жигшмээр авлигын үйлдэл гаргахаас сэргийлж чадаагүй юм.

Байгууллага дахь хүмүүсийг сэлгэх нь ухаалаг хэрэг болно. Учир нь ажилтан нэг ижил үүргийг олон жил гүйцэтгэвэл буруу дадал олж авах эрсдэл (*Gill 2005; Gobert and Punch 2007; Gill and Goldstraw-White 2010*) нэмэгдэнэ. Энд мөн л Олон улсын хөлбөмбөгийн холбоог 17 жил тэргүүлсэн Сепп Блаттерийн жишээ тохирно.

Давиес (*Davies 2000*) худалдааны болон санхүүгийн байгууллагад залилан ба авлигыг өөгшүүлэх, урьдчилан таамаглах нөхцөлийг нэгтгэн тодорхойлжээ. Жишээлбэл, хэрэв байгууллага нь нэг хүний, хязгаарлагдмал хариуцлагатайгаар их хэмжээний хяналтын эрхийг атгасан дарангуйллын хэлбэрийн удирдлагатай бол авлига гарах боломж байна. Хандлага нь байгууллагад хамгаас чухал. Хэрэв удирдлагад ажиллаж буй хүмүүс ‘хэрхэн хийх нь гол бус, хийх нь л чухал’ гэдгийг хүлээн зөвшөөрч, эсхүл энэ санааг идэвхтэйгээр дэмжвэл энэ нь байгууллага даяар тархаж зан үйлд нөлөөлнө. Ажилтнууд тийм соёлд янз бүрийн хариу үйлдэл үзүүлж болно. Тухайлбал, тэд авлигын үйлдэл гаргаж болно. Байгууллагаас зайгаа барьж, ажлаа алдчихгүй байхад шаардлагатай хамгийн бага зүйлийг хийж болно, эсхүл нөхцөл бүрдэхэд ажлаас гарахаар төлөвлөж

болно. Гэхдээ байгууллага дотроо байж болох бүхий л арга хэмжээг авсны дараа бүтэхгүй бол ‘олон нийтэд ил тод’ зарлах нь байгууллагын тийм соёлыг туйлын байдлаар эсэргүүцэх явдал болно. Ёс зүйн бүтцийн нэг хэсэг болгон шүгэл үлээгчийн бодлого байх нь хэрэгцээтэй. Гэвч зохих ёсоор хэрэгжүүлж, асуудлыг тухай бүрт нь шалгахгүй бол байгууллага шүүмжлүүлэх (*Near and Miceli 1985, 1996; Mesmer-Magnus and Viswesvaran 2005; Miceli et al. 2013 Brooks et al. 2013*) магадлалтай.

Ихэнхдээ зүгээр л ‘цаасан дээр байдаг бодлого’ нь байгууллагад итгэх итгэлийг бууруулна. Заримдаа холбогдох хүмүүс ‘цөмийн бөмбөг дэлбэлэх’ гэж нэрлэгддэг сонголт хийж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбогддог нь гайхаад байхаар зүйл биш юм. Энд Английн Брайтон хотын Роял Сассекс эмнэлгийн өндөр настай өвчтөнийг голлон сувилдаг байсан сувилагч Маргарет Хэйвүүдийн жишээг авч болно. 2005 онд Хэйвүүд BBC телевизийн *Панарома* нэртэй нэвтрүүлэгт зориулан аймшигтай эмчилгээний бичлэгийг хийжээ. Тэр өөрийн шууд удирдах болон хяналтын удирдлагатайгаа ярьсан боловч хэн нь ч сонсоогүй ажээ. Тэр ямар ч сонголтгүй болоод *Панароматай* холбогджээ. Гэвч Хэйвүүдийг сахилгын зөрчил гаргасан гэж үзжээ. Сахилгын хороо түүнийг *Панаромад* зориулан бичлэг хийж байхдаа сувилагчийнхаа үүргийг гүйцэтгээгүй гэж буруутгасан юм. Мөн хорооноос түүнийг өвчтөнүүдэд мэдэгдэж, зөвшөөрөл аваагүй учир өвчтөний нууцыг задруулсан гэж үзжээ. Хэдийгээр Хэйвүүд үүнийг хүлээн зөвшөөрсөн ч тэр өвчтөний эмчилгээ муу, хариу үйлдэл үзүүлэхгүй байгаа учир асуудлыг дэлгэн тавьж, шийдэхээс өөр аргагүй байсан гэж үзсэн байна. Гэхдээ тэр Үндэсний эрүүл мэндийн албанд бичгээр гомдол гаргах зэргээр бүхий л боломжийг ашиглаагүй учир түүнийг сахилгын зөрчил гаргасан гэж үзжээ. Энэ үзсэн бөгөөд энэ шийдвэр нь хэвлэл мэдээллээр үргэлжлэн яригдаж байснаас хойш, нэг жилийн дараа гарчээ.

Сувилагчид сануулга өгөөд, хэрэв хүсвэл зохих журмын дагуу ажилдаа буцаж орж болох шийдвэр байсан байна.

Эрх мэдэл ба эрх мэдлийн харилцааны ойлголт энд чухал үүрэгтэй. Эрх мэдлийн эх үүсвэр нь материаллаг ба материаллаг бус хэлбэртэй байх боловч гол нь бусад тоглогчид ба бүлгүүдийн хувьд үнэтэй, амин чухал гэж харагдаж байх (*Pfeffer and Salancik 1978; Borum 1995*) ёстой. Эрх мэдэл нь эмч мэргэжил зэрэг мэргэшлийг дагалдаж, эсхүл албан тушаалыг (*гүйцэмгэх захирал г.м*) дагалдаж, эсхүл албан бус бүтэц ба сүлжээнд үндэслэсэн байж болно. Байгууллага дахь албан тушаал, ажлын хуваарь ба албан тушаал дэвшүүлэх асуудалд хяналттай байх, албан тушаалыг өөрчлөх, хувь хүний үйлдлийн улмаас чөлөөлөх боломж гэх мэт эрх мэдлийн эх сурвалж нь аливаа байгууллагад тэгш бус хуваарилагдсан байдаг. Хэрэв байгууллага дахь эрх мэдэлтэй хүний зүй бус үйлдлийг ил болгохыг оролдвол хувь хүний холбоо чухал үүрэгтэй. Учир нь буруутгагдсан хүн түүнийг үгүйсгэж, авлигыг ил болгохыг оролдож байгаа хүнд саад болж үйлдлийг нь хааж, нэр хүндийг нь гутааж болзошгүй юм. Тиймээс тухайн нөхцөл байдалд авлигажсан хүний эзлэх байр суурь чухал. Ажлын байран дахь байгууллагын соёл нь эрх мэдлийг ашиглах ба зүй бус үйлдлийг мэдээлэхтэй адил нөлөөтэй. Яагаад гэвэл хүмүүс авлига руу гулсан орж, гарч байдаг ба саармагжуулах арга хэрэгсэл хэрэглэн аливаа сэжиг, хувь хүн, эсхүл байгууллагын авлигын талаарх мөрдлөгийг үгүйсгэн хамгаалж, будилаантуулна.

Дүгнэлт

Энэ бүлэгт бид гулсах тухай ойлголт болон хувь хүн ба байгууллага ихэвчлэн хэрэглэдэг, ялангуяа авлигажсан үйлдлийг тогтоосны дараа хэрэглэдэг саармагжуулах арга хэрэгслийн талаар авч үзлээ. Янз бүрийн салбарын жишээгээр авлига нь ‘бизнес хийх’ ажлын нэг хэсэг гэдгийг харуулсан боловч эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан хувь хүн ба байгууллага

авлига руу гулсан орж, гарч байдаг. Энэ нь өмнө нь гарч байсан жигшүүрт авлигын үйлдлийн ач холбогдлыг бууруулах гэсэн бус харин эдгээр тайлбар нь хувь хүн ба байгууллагууд хэрэглэж болох уян хатан арга замыг харахад бидэнд тус болно. Түүнчлэн хэдийгээр авлигын үйлдэл нь нууц ба худал хуурмаг дээр үндэслэсэн байдаг учир тодорхойлж, ангилахад хэцүү байдаг ч болзошгүй авлигажсан хувь хүмүүсийг тогтооход тус болох шинж чанар, зан үйлийн дүрслэлийг гаргах оролдлого байсаар иржээ.

Ашигласан материал

- Agnew, R. S. (1985). Neutralizing the impact of crime. *Criminal Justice and Behavior*, 12 (2), 221–239.
- Beare, M. E. (1997). Corruption and organized crime: A means to an end. In B. Rider (Ed.), *Corruption: The enemy within*. The Hague: Kluwer Law International.
- Benson, M. L. (1985). Denying the guilty mind: Accounting for involvement in white-collar crime. *Criminology*, 23 (4), 583–607.
- Boisjoly, R. M. (1995). Commentary on ‘Technology and civil disobedience: Why engineers have a special duty to obey the law’. *Science and Engineering Ethics*, 1 (2), 169–171.
- Borum, F. (1995). *Organization, power and change*. Belgium: University of Leige.
- Box, S. (1983). *Power, crime and mystification*. London: Routledge.
- Braithwaite, J. (1985). White collar crime. *Annual Review of Sociology*, 15 (1), 1–25.
- Brooks, G., Walsh, D., Lewis, C., & Kim, H. (2013). *The prevention of corruption: Investigation, enforcement and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.

- Button, M., & Brooks, G. (2014). From 'shallow' to 'deep' policing: 'Crash-for-cash' insurance fraud investigation in England and Wales and the need for greater regulation. *Policing and Society*, 26 (2), 1–20.
- Button, M., Lewis, C., Shepard, D., & Brooks, G. (2015). Fraud in overseas aid and the challenge of measurement. *Journal of Financial Crime*, 22 (2), 184–198.
- Coleman, J. W. (1987). Toward an integrated theory of white-collar crime. *American Journal of Sociology*, 93 (2), 406–439.
- Coleman, J. W. (1995). Motivation and opportunity: Understanding the causes of white collar crime. In G. Geis, R. Meier, & L. Salinger (Eds.), *White collar crime* (3rd ed.). New York: Free Press.
- Coleman, J. W. (1999). Motivation and Opportunity: Understanding the Causes of White Collar Crime in M Levi (ed), *Fraud, Organisation, Motivation and Control* (Vol 1 The Extent and Causes of white Collar Crime). Aldershot: Aldgate.
- Cook, P., & Zarkin, G. (1985). Crime and the business cycle. *Journal of Legal Studies*, 14 (91), 115–128.
- Davies, D. (2000). *Fraudwatch*, London: KPMG.
- Dittenhofer, M. A. (1995). The behavioural aspects of fraud and embezzlement. *Public Money and Management*, 15(1), 9–14.
- Dow, C. (1998). *Major recessions: Britain and the World, 1920–1995*. Oxford: Oxford University Press.
- Gill, D. (2005). *Learning from fraudsters*. London: Protiviti Group.
- Gill, M., & Goldstraw-White, J. E. (2010). Theft and fraud by employees. In F. Brookman, M. Magurie, H. Pierpoint, & T. H. Bennett (Eds.), *Handbook of crime*. Cullumpton: Willan Publishing.

- Gobert, J., & Punch, M. (2007). Because they can: Motivations and intent of white collar criminals. In H. Pontell & G. Geis (Eds.), *International handbook of white collar crime*. New York: Springer.
- Goldman, M. (2003). *The privatisation of Russia: Russian reform goes awry*. New York: Routledge.
- Heywood, P. M. (2015). *Routledge handbook of political corruption*. Abingdon: Routledge.
- Hollinger, R., & Clark, J. P. (1983). *Thefts by employees*. Lexington, KY: Lexington Books.
- Jar, M. (2013). *Cybercrime and Security*. London: Sage.
- Jones, S. (2006). *Criminology* (3rd ed.). Oxford: Oxford University Press.
- Knoop, T. (2004). *Recessions and depressions: Understanding business cycles*. Westport, CT: Praeger.
- Levi, M. (2008). *The phantom capitalist: The organisation and control of long-firm fraud* (2nd ed.). Aldershot: Ashgate.
- Lilly, R. J., Cullen, F. T., & Ball, R. A. (1989). *Criminological theory: Context and consequences*. Thousand Oaks, CA: Sage Publications.
- Maesschalck, J., & VandenAuweele, Y. (2010). Integrity management in sport. *Journal of Community and Health Sciences*, 5 (1), 1–9.
- Mars, G. (1982). *Cheats at work: Anthropology of workplace crime*. London: Allen and Unwin.
- Mars, G. (1984). *Cheats at work: Anthropology of workplace crime* (2nd ed.). London: Allen and Unwin.
- Matza, D. (1964). *Delinquency and Drift*. New York: Wiley.

- Matza, D., & Sykes, G. M. (1961). Juvenile delinquency and subterranean values. *American sociological review*, 26 (5), 712–719.
- Mesmer-Magnus, J. R., & Viswesvaran, C. (2005). Whistleblowing in organizations: An examination of correlates of whistleblowing intentions, actions, and retaliation. *Journal of Business Ethics*, 62 (3), 277–297.
- Miceli, M. P., Near, J. P. & Dworkin, T. M. (2013). Whistle-blowing in organizations. Abingdon: Routledge.
- Near, J. P., & Miceli, M.P. (1985). Organizational dissidence: The case of whistle-blowing. *Journal of Business Ethics*, 4.(1), 1–16.
- Near, J. P., & Miceli, M.P. (1996). Whistle-blowing: Myth and reality. *Journal of management*, 22 (3), 507–526
- Pfeffer, J., & Salancik, G. R. (1978). *The external control of organizations: A resource dependence perspective*. New York: Harper & Row.
- Piquero, N. L., Tibbetts, S. G., & Blankenship, M. B (2005). Examining the role of differential association and techniques of neutralization in explaining corporate crime. *Deviant behaviour*, 26 (2), 159–188.
- Pomeranz, F. (1995). Fraud: The root causes. *Public Money and Management*, 15 (1), 15–18.
- Punch, M. (1985). *Conduct unbecoming: The social construction of police deviance and control*. London: Tavistock.
- Punch, M. (2000). Police corruption and its prevention. *European Journal on Criminal Policy and Research*, 8 (3), 301–324.

- Rawlinson, P. (2012). Corruption, organised crime and the free market in Russia. In P. Gounev & V. Ruggiero (Eds.), *Corruption and organised crime in Europe*. Abingdon: Routledge.
- Shearing, C. (1981). *Organisational police deviance*. Toronto: Butterworths.
- Sherman, L. (1978). *Scandal and reform: Controlling police corruption*. Berkeley, CA: University of California Press.
- Slapper, G., & Tombs, S. (1999). *Corporate crime*. Essex: Pearson.
- Smith, G., Button, M., Johnston, L., & Frimpong, K. (2012). *Studying Fraud as White Collar Crime*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Sutherland, E. H. (1949). *White collar crime*. New York: Dryden Press.
- Sykes, G. M., & Matza, D. (1957). Techniques of neutralization: A theory of delinquency. *American Sociological Review*, 22 (6), 664–670.
- Taylor, I. (1999). *Crime in context: A critical criminology of market societies*. Oxford: Polity Press.
- Tennyson, S. (1997). Economic institutions and individual ethics: A study of consumer attitudes toward insurance fraud. *Journal of Economic Behaviour and Organization*, 32 (2), 247–265.
- Trevino, K. T., & Weaver, G. R. (2003). *Managing ethics in business organisations*. Stanford, CA: Stanford University Press.
- Tucker, J. (1989). Employee theft as social control. *Deviant Behaviour*, 10 (4), 319–334.
- Veblen, T. (1899). *The Theory of the Leisure Class*. New York: The New American Library.
- Zeiltin, L. R. (2001). A little larceny can do a lot for employee morale. *Psychology Today*, 5 (1), 22–24.

VII

Авлигыг тайлбарлах нь: Яагаад бид бүгдээрээ авлигын үйлдэл гаргадаггүй вэ?

Удиртгал

Криминологид хүмүүс тухайн улс орныхоо хуулийг дагаж мөрдөхийг олон жилийн турш суурь аксиом гэж үзэж ирсэн. Гэмт зан үйлийг муу сүнсэнд эзлэгдсэн, биологийн гажигтай, зан байдлын өвчтэй, хамтын нэгдэл нийгмийн зохион байгуулалтгүйдэл, амьдралын дэд соёл ба эдийн засгийн тэгш бус боломж гэж тайлбарлахад анхаарч иржээ. Гэхдээ асуудлыг шийдвэрлэх хамгийн чухал алхам нь ‘зөв’ асуулт асуухад оршдог бөгөөд олон жилийн турш ‘гэмт хэрэг’-ийг тайлбарлахыг оролдохдоо хүний шинж чанар ба нийгмийн тогтолцооны тухайд хуулийг мөрдөх нь ихэнх иргэдийн хувьд ердийн зүй тогтол байдаг гэсэн нөхцөлийг тавьж ирсэн. Тиймээс хүмүүс яагаад хуулийг дагадаг вэ гэхээс илүү яагаад дагаж мөрдөхгүй ‘байна вэ гэсэн гэмт хэргийн асуудалд’ төвлөрөн судалж ирсэн (*Lilly et al. 1989*) ажээ. Харин хяналтын онолын хүрээнд багтдаг аргачлалаар бол гэр бүл, багш нар, цагдаа зэрэг нийгмийн хяналт нь гэмт хэргээс үр дүнтэй урьдчилан сэргийлж чадахгүй бол гэмт хэрэг, дүрэм зөрчих үйлдэл гардаг гэж (*Reiss 1951; Nye*

1958; Reckless 1967; Hirschi 1969; Hagan 1989) үздэг. Авлигыг ойлгоход эдгээр аргыг хэрэглэж үзье.

Хяналтын онол

Хяналтын онол (*Control theory*), түүний олон хувилбаруудын уг үндэс нь зарим талаар Дюрхэймийн бүтээлд үндэслэдэг. XIX зууны сүүлээр үйлдвэрлэлийн болон нийгмийн хурдацтай өөрчлөлт нь *community* буюу 'хамтын нэгдэл' гэх хүмүүсийн сэтгэлгээнд нөлөөлж улмаар нийлмэл ам бүлтэй гэр бүлүүд бутарч, хуваагдан дан ам бүлтэй гэр бүл гэх ойлголтоор солигджээ. Хөдөлмөрийн хуваарь нэмэгдсэнээр хувь хүмүүсийг үйлдвэрлэлийн процесс дахь мэргэжилтнүүд болгон салгаж нийгмийн эв нэгдэл (*social solidarity*) задран уналаа гэж хүмүүс үзжээ. Энэхүү нийгмийн эв нэгдэл нь Дюрхэймийн бүтээлийн эдийн засгийн гэхээс илүү ёс зүйн үндэс болсон ба нийгмийн хоёр чиг үүрэг дээр тогтож байв. **Эдгээр нь: Интеграц** ба **зохицуулах** чиг үүрэг юм. Тэрээр интеграц гэдэгт хамтын үйл ажиллагаагаар нийгмийн хүчтэй холбоо хамаарлыг үүсгэж, өөрийгөө нийтийн сайн сайхны төлөө зориулах явдал нь амьдралыг зорилготой, утга учиртай болгох холбоо хамааралтай байдлыг заажээ. Нийгмийн холбоо хамаарал зөөлөрснөөр тийм ёс зүйн хүч суларч, зэвэрсэн нь хэт их хувь хүний үзэл дэлгэрэхэд хүргэсэн байна. Гэхдээ зохицуулах чиг үүрэг нь үр дүнтэй байвал нийгмийн хүлээлт болон хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хүмүүст өгч, хувь хүмүүсийг нийгэмтэй уяж, хязгаарлах хүч болно гэж үзжээ. Энэ утгаар цагдаа хязгаарлах хүч болно. Учир нь цагдаа олон нийтийг хор хөнөөлөөс хамгаалдаг болохоор хувь хүний болон мэргэжлийн хувьд чөлөөтэй ажиллах явдал нь хүлээн зөвшөөрөгддөг. Гэхдээ энэ нь тодорхой улсуудад л хамаатай боловч тэндээ ч гэсэн маргаантай байдаг. Хүн төрөлхтний талаарх Дюрхэймийн үзэлд нийгмийн нөхцөл байдлын талаарх түүний үзлийг тусгасан байдаг. Хүн нийгмийн бие (*social self*) ба аминч бие (*egoistic self*) гэсэн хоёр талтай.

Эдгээрийн нэг нь нийгэмшил ба соёлжилтын бүтээгдэхүүн бол нөгөө нь хязгаарлагдах хэрэгцээтэй байдаг үндсэн суурь бие юм. Үүнээс гарах шууд бус санаа нь нийгмийн эв нэгдлийг хөгжүүлж, хадгалахгүй бол, мөн хувь хүний дотоодын болон гадаад хяналт байхгүй бол дүрэм зөрчих үйлдэл, гэмт хэрэг гарах боломж байсаар байх болно гэсэн санаа (*Lilly et al. 1989*) юм.

Күүлей (*Cooley 1922*) ‘шилэнд харагдах өөрийн бие’ (*looking glass self*) гэдэг ойлголтыг бий болгосон. Хүүхэд байхдаа бид өөрөө үнэндээ яг хэн бэ гэдэг ойлголтыг бусдад хэрхэн харагдаж, тэд үүнийг нь юу гэж тайлбарлан, үнэлж байгаа вэ гэдэг төсөөллөөс олж авдаг. Энэ үйл явцад оролцох гол бүлэг нь гэр бүл юм. Энэхүү нийгмийн гол биет болох нийлмэл ба дан ам бүлтэй гэр бүлийн гишүүд нь дагаж мөрдөх үйлдлийн эх үүсвэр, мөн зөрчлийн үйлдлийн тайлбар болж хяналтын онолд дахин дахин давтагддаг сэдэв юм. Мийд (*Mead 1934*) энэ онолыг бид ‘Би’ (**I**) ба ‘би өөрөө’ (**me**) гэсэн хэсэгт хуваагдана гэсэн өөрийн ойлголттойгоо нийлүүлж үзжээ. Хувь хүнийхээ хувьд би нь нийгмийн соргог байдлыг (*social awareness*) төлөөлөх ба ‘би өөрөө’-гийн хөгжлийг төлөөлнө. Түүнээс ‘би’ нийгмийн ертөнцөд амьдарч буй хүмүүсийн үзэл бодол, хандлагыг харж болно. ‘Би’ нь нийгэмшиж чадахгүй эсхүл бүтэлгүйтвэл ‘бие’-ийг (*self*) хувь хүний хувьд зохион байгуулалтгүйдэлд хүргэх, эсхүл дотооддоо интеграц болох буюу нийгэмд интеграцчилж чадахгүй байхад хүргэх, эсхүл аль алинд нь хүргэж болно.

Энэхүү хувь хүний зохион байгуулалтгүйдэл (*disorganization*) -ийг Чикагогийн сургуулийн урсгалынхан (*Shaw and McKay 1942; Logan and Molotch 1987; Stark 1987; Bursik 1988*) хамтын нэгдлийн түвшинд өргөтгөн авч үзсэн ба үүнийг хамтын нэгдэл сүйрч, хүмүүс нэг нэгнээ хайхрахгүй болох хотын амьдралын нэргүйжил (*anonymity*) гэж нэрлэжээ. Тэгснээр хамтын нэгдлийг гэх үзэл санаа ба хувь хүмүүсийн ёс зүйн интеграц сүйрч байна гэж үзсэн байна. Тиймээс үүний дараа

гарсан бүтээлүүд гишүүдээ (*ялангуяа залуу хүмүүсээ*) нийгэмд уусган авах гэр бүлийн хүч, эсхүл түүний хүчин мөхөсдсөн байдлын талаар анхаарчээ. Хяналтын онол нь хувь хүний болон нийгмийн зохион байгуулалтгүйдэл (*social disorganization*) мөн нийгмийн шилжилтийн (*social transformation*) үүднээс *яагаад хүмүүс гэмт хэрэг үйлддэг вэ* гэдэг талаарх хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулсан юм. Дараах онолын аргачлалуудаар нийгмийн сул хяналт, эсхүл хүмүүс, үзэл суртал, нийгмийн сул холбоо хамаарлыг онцолж үзэх болно. Ихэнх онол нь гэр бүл болон залуусын зөрчлийн үйлдэлд анхаарч, гэр бүлийг нийгэмших гол эх сурвалж гэж хардаг байна. Тиймээс зөрчлийн үйлдэл ба гэмт хэрэг нь дотоодчилогдсон хяналт (*internalized control*) буюу ‘ёс суртахууны луужин’, гадаад хяналт буюу шийтгэх занал байхгүй байдал хэмээн тайлбарлагдана.

Рейсс (*Reiss 1951*) үзэхдээ хувь хүний хяналт нь хамтын нэгдлийн хэм хэмжээ, дүрэмтэй зөрчилдсөн арга замаар хэрэгцээгээ хангахаас ангид байх чадвар гэж үзсэн байна. Нийгмийн хяналтыг нийгмийн бүлэг ба институцүүд тэдгээр хэм хэмжээ, дүрмийг үр ашигтай болгох чадвар гэж үзжээ. Тиймээс дүрэм зөрчих үйлдэл бол зан үйлийг захирах дотоодчилогдсон дүрэм, хэм хэмжээ байхгүй байх, өмнө нь тогтсон хяналт задран унах, мөн нийгмийн дүрэм, нийгмийн бүлэглэл эсхүл институцийн техникийн тал дээр харьцангуйгаар зөрчилдөөнгүй, дүрмийг хэрэгжүүлэхгүй байх явдлын үр дүн болж гарч ирдэг. Гэвч Рэйсс (*1951*) хувь хүн нь дотооддоо хэм хэмжээ болон дүрмийг хүлээн зөвшөөрснөөр, эсхүл тэдгээрт зүгээр л дагалдсаны улмаас дагаж мөрдөж болно гэжээ. Хуулийг мөрдөх нь ялангуяа залуу насандаа мөрдөх явдал нь хэм хэмжээ болон нийгмийн үүрэг нь бидний зан чанарын байнгын тогтсон хэсэг боллоо гэсэн баталгаа биш. Зөрчлөөс сэргийлэх түлхүүр бүлэглэл нь гэр бүл, хөрш, сургууль байдаг ба энэ нь гэр бүл ‘гишүүдийнхээ хэрэгцээнд нийцэж’ байх ёстой гэсэн 1950-аад оны АНУ-ын талаарх Рейссийн бодлыг тусгасан

байж магадгүй (*Reiss 1951 in Lilly et al. 1989:91*) байна. Цааш нь Рейсс гэр бүлийн гишүүдийн хяналт нь хэт их, эсхүл хэт бага байх эрсдэлтэй агаад энэ нь зөрчлийн үйлдэлд хүргэж болох юм гэдгийг онцолжээ. Гэхдээ ‘зохистой’ хяналтын хэмжээ нь юу вэ гэдгийг илэрхийлэх зүйл байхгүй.

Най (*Neu 1958*) шилжилтийн насныханд анхаарал хандуулж гэр бүлийг хамгийн чухал нийгмийн хяналт гэж үзсэн байна. Гол эх үүсвэр болохын хувьд гэр бүл нь *шууд хяналт, дотоодчилогдсон хяналт болон шууд бус хяналт, хэрэгцээг хангах бусад замаар хянаж* болно. Шууд хяналт нь эцэг эх, багш, цагдаа зэрэг гадаад хүчээр шууд хязгаарлалт хийж, улмаар шийтгэл хүлээлгэх замаар хувь хүнд очих хяналт аж. Дотоодчилогдсон хяналт гэдэг нь хувь хүн шууд хяналтгүй үед өөрийн зан үйлийг хянах чадвартай байхыг хэлнэ. Шууд бус хяналт нь хувь хүн эрх мэдэлтэй хүнтэй ялангуяа эцэг эхдээ татагдаж, ойр харилцаатай байх хэмжээ юм. Энэ төрлийн хяналт нь шууд, эсхүл дотоодчилогдсон хяналт бага байх үед хүнийг тогтсон хяналтын хүрээнд биеэ авч явахад итгүүлэх нөлөөтэй. Эцэст нь хэрэгцээг хангах бусад арга гэдэг нь хувь хүн дүрэм зөрчих болон эрүүгийн үйлдлээр бус хууль ёсны янз бүрийн аргаар ханамж авахыг хэлнэ. Эдгээр хяналт нь нөхцөл байдлаас хамаарч нэг нь нөгөөгөөс илүү ач холбогдолтой байдлаар тус тусдаа байж болох ч Най (*1958*) эдгээр хяналт нь харилцан үйлчилж зан үйлийг хүчитгэдэг хэмээн мөн тэмдэглэжээ. Цагаан захтны гэмт хэрэг ба авлигын хувьд асуудал нь амжилттай явж буй хүмүүст орлого, эд баялаг, байр суурийн хувьд баяжих хууль ёсны арга зам байсаар байтал яагаад гэмт хэрэг үйлддэг вэ гэдгийг тайлбарлаж чаддаггүй явдал юм.

Реклесс (*Reckless 1961*) криминологи нь яагаад зарим хүмүүс дүрэм зөрчих үйлдэл болон гэмт хэрэгт хүргэх нийгмийн дарамт шахалтад бууж өгдөг талаар ‘өөрийн хүчин зүйлс’-ийг (*self-factors*) хайх хэрэгтэй гэдгийг санал болгожээ. Татах ба түлхэх хүчин зүйлс гэж нэрлэгдсэн эдгээр хүчин зүйлсэд хүнийг

зөрчлийн үйлдэл рүү **түлхэж** болох сэтгэл зүйн дарамт болоод нийгмийн нөхцөл, мөн хүнийг зөрчлийн үйлдэл, эсхүл гэмт үйлдэлд уруу **tamах** хууль бус боломжууд агуулагдана. Энэ үзэл нь хүмүүсийг зөрчлийн үйлдэл ба гэмт хэрэг рүү хүчтэй түлхэх болон татахаас тусгаарлах *гадаад ба дотоод бүрхүүлийн (containment)* хослолыг нэвтлэн гарч байж хүн гэмт үйлдэл хийдэг гэж үздэг бүрхүүлийн онолд тусгалаа олсон (*Lilly et al. 2015*) байдаг. Гадаад бүрхүүлд чухал ач холбогдолтой гэж үзэх хүчин зүйлс нь Реклесс онолын аргачлалаа сайжруулахын хэрээр өөрчлөгдөж байсан боловч тэдгээр нь гэр бүл зэрэг гол чухал бөгөөд дэмжих харилцааны хүчин зүйлсийн хүрээнд л эргэлдэж байжээ. Харин дотоод бүрхүүл нь өөрийн талаарх ойлголт буюу өөрийн талаарх төсөөлөл, эерэг чиг баримжаа буюу чиглэлийн мэдрэмж, хууль ёсны ололтын төлөө зүтгэхийг голлон авч үздэг. Энэ үзлээр амжилтад хүрэх нь боломжтой асуудал агаад үүнд хүрэх боломж байдаг гэж (*боломж хязгаарлагдмал гэж үздэг дарамтын онолын талаар V бүлгээс үз*) үздэг. Реклесс нь мөн бухимдлыг тэвчих хэмээн нэрлэсэн биофизикийн хүслийн бүрхүүлийг гэр бүлийн, эдийн засгийн, улс төрийн агуулгад өөрийн хяналттай байх замаар тохируулж байх хэрэгтэй гэдгийг санал болгосон байдаг. Эцсийн хүчин зүйл нь хэм хэмжээг санаж байх буюу ‘хууль ёсны ... хууль, дүрэм, институц, заншлыг мөрдөх, дагах, хүлээн зөвшөөрөх, таних’ явдал (*Reckless 1967:476*) юм. Гэвч энэ онолоор ‘хэм хэмжээний элэгдэл’ (*norm erosion*) гэж юу вэ гэдгийг тайлбарлахад асуудал үүсдэг.

Энэ онол цаашид орчин цагийн дэлхий ертөнцийн бүтээгдэхүүн гэгддэг гэмт хэргийн өсөлтийг тайлбарлахыг оролджээ. Тэгэхдээ эдийн засгийн тэгш бус байдлыг (*дарамтын талаар V бүлгээс, зөрчлийн талаар VIII бүлгээс үз*) онцолж үзэлгүй, нийгмийн ёс суртахууны эмх журам бөгөөд хувь хүн амьдралынхаа шунал хүслийн талаар тохиролцоо хийх, бүтэлгүйтлийг даван туулах үүрэгт анхаарчээ. 1960-аад оны

эсрэгцэх соёлыг (*counterculture*) тайлбарлахыг оролдсон хүмүүс хувь хүний хувьд өөрийгөө хянах байдал алдагдсан бөгөөд шашин, гэр бүл, боловсролын институц, эдийн засгийн эмх журам ба улс төрийн гэсэн зохион байгуулалттай нийгмийн хяналт алдагдсан гэж үзсэн (*Lilly et al. 1989*) байдаг. Бүх л онол цаг хугацаа ба орон зайг тусгадаг бөгөөд хувь хүн талаас нь авч үзвэл эдгээр онолбуудын ихэнх нь боловсруулагдах үеийнхээ нөхцөл байдлыг тусгасан байдаг. Мөн эдгээр онол нь хяналтын онолын бүрдэл хэсгүүдийг давтаж, гэр бүл ба рационал сонголт дахь ёс суртахуунт хийгээд ёс суртахуунгүй хүний үйл хөдлөлийг онцлон (*Wilson ба Herrnstein 1985; Murray 1990*) (*Х бүлгийг үз*) үздэг.

Хирши (*Hirschi 1969*) хүн аливаа зүйлийг дагаж мөрдөхдөө түүнийг ёс суртахууны хувьд хүлээн зөвшөөрөхийн оронд нийгмийн зохицуулалтад бууж өгсний улмаас тэгдэг байж болохыг зөвшөөрсөн. ‘Зөв’ төрлийн нийгэмшлийн үр дүнд дотоодчилогдсон хэм хэмжээний улмаас хүмүүс угаасаа ёс суртахуунтай гэж үзэх нь түүний хувьд буруу таамаглал байв. Хирши мөн ёс суртахуун нь тогтсон, хувиршгүй зүйл бус өөрчлөгдөж байдаг. Хүмүүс цөхөрсөндөө хөдөлдөг бус рационал бөгөөд урам зоригтой үйл хөдлөл хийдэг гэж үзжээ. Хэрэв ёс суртахуун нь хувирамтгай бол ‘зөв’ төрлийн нийгэмшил гэж юу вэ гэдгийг ямар хэмжээгээр тайлбарлаж болох вэ? Түүнээс гадна энэ үзэл нь хүмүүс авлига руу гулсан орж, гарч байдаг талаарх ойлголттой төсөөтэй байгаа бөгөөд шалтгааны тайлбар нь ялгаатай боловч зөрчлийн болон авлигын аль аль үйлдэл нь хүний зан үйлийн байнгын салшгүй зүйл бус хэмээн тайлбарлаж байна.

Хэм хэмжээнээс гажих үйлдэл болон ирээдүйн гэмт хэргээс сэргийлэх явдал нийгмийн дөрвөн харилцаанд үндэслэдэг. Үүнд: эзэнэгших (*attachment*), биеэ зориулах (*commitment*), оролцох (*involvement*), итгэх (*belief*) багтана. Гэхдээ энд нэг зүйлийг анхаарна уу. Хирши сэтгэл судлалын бус социологийн

тайлбарыг санал болгосон ба хувь хүний дотоод сэтгэлд анхаарсан энэ тайлбар нь ч олны дэмжлэгийг олсон байна. Тэрээр ээнэгших гэдэгт гэр бүл ба сургуулийн харилцааны *үргэлжилсэн дотно байдлыг* тэмдэглэсэн. Энд тэмдэглэсэн ээнэгшил нь Садерландын ялгаатай нөхөрлөлийн онолтой ойролцоо ба харилцаа үүсгэх нь суралцах зүйлийн агуулгаас чухал гэдгийг тодотгодгоороо (*Lilly et al. 1989*) ялгаатай. Ээнэгшлийн энэ хэлбэр нь субъектив сэтгэл зүйн шинж чанарын аргачлалаас зайлсхийж, ээнэгшлийг хувь хүн ба бүлэгтэй тогтоосон нөхөрлөл гэж үздэг. Биеэ зориулах гэдэг нь *хувь хүний өөрийн ашиг сонирхлыг байршуулж буй хэмжээ гэж хардаг*. Энэ нь ямарваа нэг хүн зөрчлийн болон гэмт үйлдэл хийхээр завдах үедээ боломжит ашиг, алдагдлыг рационалаар тооцоолно гэсэн (*мөн Х бүлэг дэх рационал сонголттой төстэй*) үг. Энэ нь хувь хүн хууль тогтоомжийг дагаж мөрдөхөө байвал хэр их зүйл алдах магадлалтай вэ гэдэг тухай юм. Ийм тогтолцоо нь зөвхөн шагналыг зөрчлийн үйлдлийг болиулах шийтгэл болгон барьж байх үед л боломжтой. Дарамтын онолоор их хүсэл тэмүүлэлтэй байх нь ирээдүйд бухимдал үүсгэж, үр дүнд нь хэм хэмжээнээс гажих үйлдэлд хүргэнэ гэж үздэг. Харин Хирши (*1969*), Реклесс (*1961*) нар хэрэв хүн нийгмийн уламжлалт хэв журмыг зөвхөн шаардах бус түүнд хөрөнгө оруулсан бол, тэр хүсэл тэмүүлэл нь хууль ёсных бол энэ нь нийгмийн уламжлалт хэв журмыг дагаж мөрдөх түлхэц болно гэж үзжээ. Гэхдээ уг онолд бидний амьдран буй нийгмийн бүтцийг бодитоор хүлээн зөвшөөрсөн зүйл байдаггүй бөгөөд хүн бүхэн амжилтад хүрэх ижил боломжтой, мөн нийгэмд оруулсан зүйл нь тэнцүү гэж таамаглахтай туйлын ойр байдаг. Оролцоо нь *тодорхой үйлдэлд зориулсан цаг, энергийн хэмжээ юм*. Энэ нь хэрэв завгүй байлгавал хэм хэмжээнээс гажихаас сэргийлж (ихэвчлэн хүүхэд, залууст чиглэсэн) болно гэдэг эртний үзлийг эш татдаг. Тэд итгэл гэдэгт гүнзгий суусан үнэмшлийг заагаагүй. Харин дээр дурдсан шиг дагаж мөрдөх дотоод хүсэл бус нийгмийн байнгын

хүчитгэлээс хамаарсан үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрөх, батлах үйлийг хамруулсан байна. Энэ агуулгаар итгэл нь ёс суртахууны найдваргүй байр суурь бөгөөд үргэлж ээнэгшил хэрэгтэй болно.

Үл дагаж мөрдөх ихэнх үйлдлийг тайлбарлахыг оролдсон Реклессийн онолыг эс тооцвол бусад нь хэдийгээр бүх хүний гэмт хэргийг тайлбарлаж чадна гэгцгээдэг ч, залуу хүмүүст төвлөрсөн байдаг. Тиймээс нийгмийн хяналтын нөлөө нь голлон гэр бүл, сургуульд байдаг гэж үзэж байсанд тийм ч гайхах зүйлгүй. Эдгээр аргачлалд давтагддаг нийтлэг сэдэв, ялангуяа хууль ёсны хүсэл эрмэлзэл нь хууль тогтоомжийг даган мөрдөх чухал элемент болдог бөгөөд хувь хүний хяналт нь нийгмийн хяналтаар дамжиж илэрдэг гэх явдал юм. Тиймээс энэ онол нь бодлогын хувьд нийгмээс тусгаарлах агаад шийтгэхийн оронд уламжлалт тогтолцооноос хамаарах хамаарлыг хүчирхэгжүүлэхийг санал болгодгоороо рационал сонголтын онолоос ихээхэн ялгаатай.

Хаген (*Hagen 1989*) ирээдүйд хэм хэмжээнээс гажих эсэхийг тодорхойлох боломжтой гэсэн үзүүлэлт нь гэр бүл дэх эрх мэдлийн хяналтын тэнцвэр гэж үзжээ. Эцэг, эхчүүд хоорондын эрх мэдлийн тэнцвэр нь тэдний асаргааны төрөл, бодит байдалд нөлөөлж улмаар хүүхэд гэмт хэрэгт орох магадлалыг тодорхойлно. Энэ эрх мэдлийн тэнцвэрийг эрэгтэй эмэгтэй хүмүүс хоорондын гэмт хэрэг үйлдэх хувийн ялгааг тайлбарлахад хэрэглэжээ. Эцгийн эрхт ёст гэр бүл нь хөвгүүд/залуусаас илүү охид/эмэгтэйчүүдээ илүү хянадаг. Тиймээс залуу хөвгүүдийг эрсдэлтэй алхам хийхийг илүү их урамшуулдаг нь зарим тохиолдолд гэмт хэрэгт хөтөлнө.

Дээр дурдсан онолууд нь авлигын үйлдлийг шууд тайлбарлахад хамаарал багатай, эсхүл ач тус багатай гэдэг нь харагдаж байгаа ч Тителийн (*Tittle 1995*) санал болгосон өөр төрлийн хяналтын ойлголт нь авлигын үйлдэл болон авлигын гэмт хэргийг тайлбарлахад зарим талаар ач холбогдолтой.

Тител (1995) дээр дурдагдсан онолын тайлбарыг үгүйсгэсэн ба оронд нь хяналт бол зан үйлийн сонголтын хязгаарлалт гэж үзжээ. Хэм хэмжээнээс гажих үйлдэл эсхүл гэмт хэргийн сэдэл нь нөхцөл байдлаас хамаарсан нөлөө болон ‘хяналтын харьцаа’ (*control ratio*) гэж нэрлэгддэг бие даах хүсэл зэрэг хүчин зүйлсийг араасаа дагуулдаг. Гэхдээ Савелсберг (*Savelsberg 1996*) бие даах хүсэл нь хүн төрөлхтний нийтлэг зүйл мөн эсэхийг шүүмжилжээ. Хяналтын харьцаа гэдэг нь хувь хүний хүлээн авч буй хяналттай харьцуулсан бусад хүнд тавьж чадах хяналтын хэмжээ юм. Хүн өөрийн байр суурь болон хувь хүний хүч чадалдаа тохируулан бусад хүмүүс өөрт нь тавих хяналтаас илүү их хяналтыг тавих чадвартай бол ‘хяналтын илүүдэл’-гэй (*Jones 2006*) гэдэг.

Байр суурь доогууртай бөгөөд бусдыг хянах боломж багатай, нэлээд их хяналтад байдаг хүнийг ‘хяналтын дутагдал’-тай гэдэг. Хүн хэм хэмжээнээс гажиж, эсхүл гэмт хэргийн үйлдэл гаргахын тулд хяналтын илүүдэлтэй хүмүүс түүнийгээ ихэсгэх сэдэлтэй болох, мөн хяналтын дутагдалтай хүмүүс түүнийгээ устгах сэдэлтэй болох хэрэгтэй. Гэхдээ энд ч гэсэн хязгаарлах хүчин зүйл байна. Хүн авлигын болон гэмт хэргийн үйлдэл гаргахгүй байхад үйлдлийн ноцтой байдал, илрэх магадлал, тийм үйлдэл гаргах боломж чухал ач холбогдолтой. Энэ нь илүүдэл юм уу, дутагдал гэсэн хяналтын тэнцвэргүйдэлд хүргэх ба тэр нь гэмт хэрэгт хөтөлж болзошгүй. Ийм зүйл болохын тулд давхцах шаардлагатай шалтгаалагч зүйлс байдаг. **Үүнд:** үйлдэл хийх сэдэл, гэмт хэрэг хийх боломжтой зэрэгцсэн хяналтгүй байдал орно. Тител үзэхдээ эрх мэдэлтэй хүмүүс эсхүл эрх мэдэлтэй албан тушаалд буй хүмүүс хяналтын илүүдлийн давуу талаа ашигладаг гэжээ. Гэвч энэ илүүдлийг буруугаар ашиглах нь хяналтын дутагдалтай хүмүүсийг ч бас авлигын үйлдэл, гэмт хэрэг үйлдэхэд хүргэж болно. Жишээлбэл, удирдах зөвлөлийн гишүүд, эсхүл тэдний зарим нь авлигажсан гэж харагдаж буй байгууллагад ажилтнууд нь авлигад орооцолдох

илүү магадлалтай. Гэхдээ тэдний байгууллагад хашиж буй албан тушаалаас хамааран үйлдэх авлигын үйлдлийн төрөл нь ялгаатай байна.

Хяналтын тэнцвэргүйдлийн гурван түвшин байдаг. Үүнд: өөрсдөд нь ирж буй хяналтаас дөнгөж илүү хяналт хэрэгжүүлдэг хүмүүс багтах бөгөөд илүүдэл нь мөнгө салгах, үнэ тогтоох, хахуулийн үйлдэлд зориулагддаг хүмүүс; хяналтын илүүдэлтэй бөгөөд байгаль орчны гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүс; ял зэмгүйгээр үйлдэл хийдэг дарангуйлагч зэрэг туйлын их хяналтыг атгасан хүмүүс багтана. Гэхдээ энэхүү хяналтын тэнцвэр, эсхүл тэнцвэргүйдлийг баримтжуулах өгөгдөл байдаггүй. Хөнгөн хэлбэрийн хяналтын дутагдалтай үед хориглохгүй бол хүчирхийллийн үйлдэл гарч болно. Дунд түвшний хяналтын дутагдалтай үед архидалт зэрэгтэй нэгэн адилаар хяналтыг зарим талаар эсэргүүцэх, эсхүл зугтах явдал илэрхий байдаг. Хүлцэнгүй дарангуйллын үеийн хяналтын дутагдал буюу боолчлол зэрэг нөхцөлд хүмүүс шунахайн сэдэлт гэмт хэрэг, эсхүл хэм хэмжээнээс гажих үйлдлийг гаргахаас айдаг талаар Тител дурджээ.

Брэйтвэйтийн (*Braithwaite 1997*) шүүмжлэлийг хүлээн аваад Тител (*2004*) өөрийн бүтээлийг эргэн харж бүхий л төрлийн дутагдлыг хяналт гэсэн цогц ойлголт дээр хураангуйлжээ. Гэвч хяналттай хамааралтай сэтгэлзүйн асуудал нь хэмжихэд хэцүү гэсэн асуудал хэвээр үлдсэн байна. Хяналтын онолын энэ хувилбар нь рационал сонголтын бүрдэл хэсэг болох сонголтод нөлөөлдөг хүчин зүйлс болоод, гэмт хэрэг хийх сэдэл, хүний сэтгэл хөдлөлийг агуулдаг. Энэ онол нь хүмүүс гэмт хэрэг болон авлигын үйлдэл гаргахдаа хяналтаас ангид байх, эрх чөлөөгөө хамгийн их байлгахыг оролддог гэж таамагладаг учир цагаан захтнуудын гэмт хэрэг (*хяналтын илүүдэл*) ба гудамжны гэмт хэргийг (*хяналтын дутагдал*) тайлбарлаж чаддаг.

Хяналттай байх, эсхүл түүнээс эрх чөлөөтэй байх энэхүү хүсэл нь зарим талаар тайлбарлах ач холбогдолтой. Эдгээр аргачлалын ихэнх нь зөрчлийн үйлдэл ба гэмт хэргийн гол шалтгаан нь хяналтыг гартаа авах хүсэл бус өөрийгөө хянах хяналт сул байх явдал гэж үздэг. Бүргер, Күүпер (*Burger and Cooper 1979*) нар хяналттай байх хүсэл ихтэй хүмүүс нь өөртөө итгэлтэй, шийдэмгий, идэвхтэй байх хандлагатай агаад давуу талтай үедээ бусдад нөлөөлөхийг эрмэлзэж, бусдыг мэхлэн удирдах замаар таагүй зүйлээс зайлсхийхийг оролддог гэжээ. Хяналттай байх хүсэл буюу үйл явдал болон хүмүүсийг хянах хувь хүний хүсэл нь хувь хүний амжилтыг дөвийлгөх мэдрэмж, үйл явдлыг хянаж байна гэсэн хий хоосон мөрөөдөл, авлигын бололцоог тайлбарлахад хэрэгтэй (*Piquero et al. 2010-г үз*) байдаг.

Хяналтын хязгаарлагдмал тал

Дээр дурдагдсан судлаачдын бүтээлийг бодит байдал дээр авч үзэхэд дутагдалтай тал олон (*Bernard 1984; Polk 1991; Jones 2006*) харагддаг. Мөн эдгээр онол нь рационал байдлыг таамаглал болгон үзэх нь бий. Хүмүүс өөрийнхөө амьдарч буй ертөнцийг хэрхэн утга учиртай болгодгийг судлахад цар хүрээ гэж байхгүй. Сул нийгмийн харилцаа нь зөрчлийн үйлдэлд хүргэдэг бус зөрчлийн үйлдэл нь нийгмийн харилцааг сулруулахад хүргэдэг байх магадлал байгаа. Түүнчлэн эдгээр онол нь ‘сайн эцэг, эх’ хүүхдүүддээ дундаж ангийн үнэт зүйлсийг (*эдгээр нь юу ч гэж тодорхойлогдсон байсан*) заахыг оролдох болно гэж таамагладаг. Тэдгээр үнэт зүйлсийг барьж, дагадаг хүмүүс ч үнэт зүйлс нь илүү сайн гэдгийг бус үнэт зүйлсээ ялгаатай гэдгийг тэмдэглэхээс өөрөөр тэдгээр нь юуг төлөөлж байгаа вэ гэдэг дээр шийдэлд хүрч чаддаггүй учир үнэт зүйл нь шийдэл гэхээс илүү асуудал болдог.

Мөн эдгээр онол нь эрх мэдэлтэй хүмүүсийн гэмт хэргийг хангалттай тайлбарладаггүй. Боксын (*1981*) хувьд тийм гэмт

хэрэг нь хууль тогтоомжийг дагаж мөрдөхгүй бол их зүйлийг алдах болон бусад гол хүмүүст ээнэгших гэсэн ойлголт, эсхүл уламжлалт ёс суртахуунтай хамааралгүй зүйл юм. Готтфредсон (*Gottfredson*) ба Хирши нар цагаан захтны гэмт хэргийн ихэнхийг ач холбогдолгүй зүйл гэж үзсэн учир цагаан захтны гэмт хэргийн тэдний онол нь ойлгох боломжгүй зүйл гэж Жонс (*Jones 2006*) тэмдэглэжээ. Вейсбүрд (*Weisburd 1991, 2001*) үүнийг ердийн зүйл гэж хардаг боловч авлигын үйлдэл нь өргөн цар хүрээтэй байдаг бол бусад гэмт хэрэг нь хүрээлэн буй орчин ба амьдралд нэлээд хор хөнөөлтэй байдаг. Эдгээр онол, ялангуяа Хиршигийн (*1969*) онол нь улс төрийн хүрээнд, ялангуяа уламжлалт үнэт зүйлс болон гэр бүлийн үүргийг дэмждэг хүмүүсийн дэмжлэгийг авчээ. Энэ онол бол улс орны бүтэц, тэгш бус байдлыг үндсээр нь шүүмжилдэггүй, ердийн сэтгэлгээний онол юм.

Эдгээр онол нь бусдын адил олон маргаантай асуудал дагуулдаг. Хиршигийн хувьд хяналтын онолын давуу тал нь туршилтад үндэслэсэн байдал агаад уг онолын судалгаа болон үндэслэл нь бодит баримт юм гэдэг ч тэдгээрт нь олон асуудал байдаг. Энэ онол нь сэдлийг жижиг асуудал гэж үзэх, зөрчлийн үйлдлийг хэт их таамаглах (*ядаж л зарим тохиолдолд*) хандлагатай бөгөөд эрүүгийн хууль болон нийгмийн эмх журмыг хангах явдлыг асуудалгүй зүйл гэж харах хандлагатай байдаг. Эдгээр онолыг Европоос илүү АНУ-д дэмждэг бөгөөд Европын улсууд сүүлийн үеийн түүхээсээ болоод хяналт гэдгийг төрийн хяналттай адилтган үздэг бол Америкчууд хяналтыг хувь хүн ба тэдний хүрээлэл хоорондын харилцаа гэж хардаг бөгөөд Их Британи нь дундын байр суурийг (*Jones 2006*) барьдаг.

Ихэвчлэн залуу хүмүүст анхаардаг онолын аргачлалын бүлэг болохын хувьд эдгээр нь авлигыг тайлбарлахад их зүйл санал болгож чадахгүй боловч хувь хүн ба байгууллагыг хянах урамшуулал ба шийтгэлийн тогтолцоо гэж харвал зарим талаар хэрэг болно.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал дутагдах нь: Хуулийн сул хэрэгжилт ба нийгмийн гадаад хяналт

Энэ бүлэг дэх онолын аргачлалууд нь хоорондоо зарим талаар ялгаатай ч хүн нийгэмшихэд гэр бүл чухал гэж бүгд үздэг. Нийгмийн хяналт нь бидний дотоод хяналт буюу дотоод ёс суртахууны луужин, гадаад хяналт буюу цагдаа, эсхүл чадамжтай асран хамгаалагчид (*capable guardian*) гэсэн эрх мэдэлтнүүдийн үүргийн (*энэ талаар XI бүлгээс бас үз*) асуудал гэж мөн үздэг байна. Тэдгээрийг бид хүндлэх эсэх нь хуулийг дагаж мөрдөхгүй байхын шалтгаан болдог ажээ. Дотоод хяналтын талаар бидний хийж чадах зүйл бага боловч эдгээр онол нь бид хууль, дүрэм, журмыг дагаж мөрдөх болон дагаж мөрдөхгүй байхын болзошгүй үр дагавартай зарим талаар хамааралтай байна. Гэхдээ энд анхааралтай хандах хэрэгтэй. Хиршигийн тэмдэглэхдээ (*1969*) ёс суртахуун нь хатуу тогтсон зүйл бус хувийн болон гадаад нөхцөл байдлаас хамаарч өөрчлөгддөг, уян хатан зүйл учир бид залуудаа хууль, дүрмийг дагаж мөрдөж байлаа ч сүүлдээ гэмт хэрэг үйлдэж болно гэсэн. Энэ нь бидний хянаж чадахгүй зүйлс, бидний амьдралын хэв маягийг хааж, эсхүл саад болох үед түүнд үзүүлэх бидний хариу үйлдэл гэж харвал ойлгож болох зүйл юм. Энэ бүлгийн энэ хэсэгт үүнийг санангаа авлига, олон нийтийн сэтгэл зүй, гэмт хэргийн динамик, дураараа хувь хүмүүс/байгууллагуудад хууль дүрэм мөрдүүлэх, авлигын гэмт хэрэгтнүүдийг мөрдөх, яллах асуудалд анхаарал хандуулна.

Авлигын динамикийг харахад дөрвөн үндсэн хэв маяг ажиглагддаг. Үүнд: авлигаас хүртэх олон янз хэлбэртэй олз ашиг; авлигын сэдлийг онож тогтоох явдал; хохирлын цар хүрээ; авлигын үйлдэлд хариу үйлдэл үзүүлж улмаар яллахад учирдаг бэрхшээл багтана. Авлигад санхүүгийн, байр суурийн, хувь хүний урамшууллын, албан тушаал ахих, хувь хүн ба

байгууллагын зах зээл дээр эзлэх хувийг өсгөх гэх мэт тодорхой ашиг тус оршин байдаг. Түүнчлэн илэрсэн ч гэсэн шүүхээр яллахад хэцүү байдаг. Энэ нь зарим талаар сэдлийн нарийн төвөгтэй байдлаас (*Payne 2012*) болдог. Панч (*Punch 2000a*) авлигын гэмт хэрэг дэх удирдлагын оролцоог тогтоох нь ямар хэцүү болохыг харуулсан. Жишээлбэл, байгууллагын удирдлага эсхүл гол хүмүүс нь тодорхой цаг үед хуйвалдаанд оролцсон эсэх үйлдэл нь ур чадваргүйгээс болсон уу, эсхүл үл тоосноос болсон уу, эсхүл ял шийтгэгдэх эрсдэлийг мэдээгүй байсан эсэхийг тогтооход хэцүү.

Нарийн төвөгтэй байдлаас нь үл хамааран зарим авлигын үйлдлийн учруулах хор хохирол нь асар их байдаг. Тиймээс хохирлын цар хүрээ нь чухал динамик юм. Ялангуяа хэрэгтнийг ‘хууль шүүх’-ийн өмнө авчрах нь чухал. Шичор (*Shichor 1989*) энэ асуудлыг харуулахад хэрэг болох хохирлыг ангилах анхдагч, хоёрдогч, гуравдагч гэсэн тогтолцоог боловсруулжээ. Анхдагч хохирогч нь жишээлбэл, аюултай гаж нөлөө бүхий эм гэх мэт хортой бүтээгдэхүүнийг мэдэлгүй хэрэглэсэн хүн зэрэг гэмт үйлдлийн улмаас хохирсон хүн юм. Хоёрдогч хохирогч гэдэг нь барилгын ажлын тендерийг авахын тулд өгсөн хахууль гэх мэт авлигын улмаас тендер авч чадалгүй хохирсон бизнесийн байгууллага зэрэг хувь хүн бус этгээд юм. Гуравдагч хохирогч нь хүрээлэн буй орчны бохирдол зэргээр сөрөг үр дагавар амссан хамтын нэгдлийн гишүүд юм. Гэхдээ энэ бүх түвшин нь давхцаж болно.

Тухайлбал: голын усны бохирдол нь хүмүүсийн эрүүл мэндэд шууд сөрөг нөлөө үзүүлж, мөн хогоо гол руу хаях нь байгууллагад шударга бус давуу талыг олгож байж болно. Учир нь байгууллага энэ үйлдлийнхээ нөлөөгөөр зах зээлд эзлэх хувиа өсгөх, илүү их нөөцтэй болно. Үүнээс гадна байгууллагын авлигын хохирогчид (*ажилтнууд, хэрэглэгчид, хөрөнгө оруулагчид, татвар төлөгчид, бусад байгууллагууд*) ч байж болно. Мөн бүлэглэн шамшигдуулах гэдэг үйлдлээр

дарга нар нь ашиг олно гэдгээ мэдэж байгаа учир байгууллагаа бүтэлгүйтүүлэх явдлыг хүлээн зөвшөөрч болно.

Сүүлчийн динамик нь авлигын үзүүлэх хариу үйлдэл юм. Санхүүгийн, автомашины, газрын тосны, эмийн бүтээгдэхүүний зэрэг зарим байгууллага, салбар нь хүч нөлөөтэй байх үедээ улс орны дүрэм журам, шийдвэрт нээлттэй лобби хийх болон хахууль өгөх зэрэг авлигажсан үйлдлээр нөлөө үзүүлэх чадвартай бөгөөд бодитоор ч нөлөөлдөг. Зохицуулалтын байгууллага, хууль хэрэгжүүлэгчид хуулийг ирээдүйд ч дагаж мөрдүүлэхийн тулд ийм гэмт хэрэгт шийтгэл оноовол салбарын дотоод эрх ашигт баригдаагүй, ‘шударга’, хууль ёсны байна гэж харагдах болно.

Эрүүгийн шүүх яагаад хүлээн зөвшөөрөгдөх хэрэгтэй байдаг ба хүлээн зөвшөөрөгдөхийг эрмэлздэгийг, ялангуяа ардчилсан улсад (*Sunshine and Tyler 2003; Tyler 2003, 2006, 2007; Hinds and Murphy 2007; Mazerolle et al. 2009; Hough et al. 2010; Sargeant et al. 2012*) цагдаагийн ажлыг хэрэгжүүлэхэд энэ нь хэр зэрэг тустай вэ гэдгийг тайлбарласан криминологийн бүтээл ховор байдаг. Гудамж, ойр орчимд нь өрнөж буй гэмт хэргийг нүдээр харсан, эсхүл хохирогч нь болсон байж магадгүй иргэдтэй цагдаа нар харилцаж, ажлаа хийхэд хүлээн зөвшөөрөгдсөн байх нь хамаагүй илүү үр дүнтэй байдаг учраас тийм байх шаардлагатай. Цагдаагийн ажил ба тэд олон нийттэй харилцах харилцаа нь бүгдэд ил байдаг тул хүлээн зөвшөөрөгдсөн байвал үр дүнтэй ажиллаж чадна. Гэхдээ цагаан захтнуудын гэмт хэрэгт гэрч байхгүй, эсхүл гадаад орчинд үзэгдэхүйц хохирол байхгүй үед ихэвчлэн байгууллага доторх хүн ил болгодог ба хэрэгтнүүдийн үйлдэлд нөхөн хариуцлага тооцдог. Асуудал нь ердөө л цагдан сэргийлэх асуудал бус хуулийг дагаж мөрдөх асуудал юм.

Бид энд төрд байх эцсийн шийтгэл буюу хэрэгжүүлэлтийг ярихаас өмнө хуулийг дагаж мөрдөх талаар, эсхүл үл дагаж

мөрдөх талаар авч үзнэ. Гэхдээ иргэний ба эрүүгийн процессыг цогц авлигыг тусгасан цогц шийтгэлийн шугам гэж харах ёстой болно.

Олон улсад үйл ажиллагаа явуулдаг хувийн салбарын үндэстэн дамнасан корпорацууд нь олон улсын, европын ба пан-европын байгууллагууд, шахалт үзүүлэх бүлэглэлүүд, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан үйл ажиллагааны үр дүнд ёс зүйн дүрмийг (*эсхүл батлахаас аргагүй болсон*) баталсан. Гэхдээ энэ номд үзүүлснээр дагаж мөрдөх тогтолцоо нь одоо хэрэгжүүлж байгаа байдлаараа бол авлигын эрсдэлийг удирдаж, тийм эрсдэлээс сэргийлэх ёс зүйн соёлыг (*Hough 2015*) төлөвшүүлэхэд үр дүнтэй эсэх нь тодорхойгүй байна. Хувь хүн, байгууллага ашигт анхаарч буй үед авлига зарим талаар гарцаагүй гэдгийг ойлгож болно. Эшфорт, Ананд (*Ashforth and Anand 2003:3*) нар ‘авлигыг хүлээн зөвшөөрөх ёс зүйн уур амьсгал ... ердийн болж (эсхүл институцчилэгдэж) болно’ гэсэн санаа дэвшүүлсэн. Авлигын үйлдлийг системтэйгээр ердийн зүйл болгож харах үйл явцыг буцаахын тулд байгууллагын бүтцийн дорвитой өөрчлөлт шаардсан, ёс зүйн хүчтэй соёлыг бий болгох шаардлагатай. Авлигын үйлдлийн эсрэг системтэй хариу үйлдэл үзүүлэх аргыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Ийм системтэй хариу үйлдлээр авлигыг хориглож, ёс зүйн стандартыг ил тод зарлах ёстой. Дагаж мөрдөх тогтолцоог амжилттай хэрэгжүүлэхийн тулд тодорхой дүрэм тогтоож, түүнийг баримтлах хэрэгтэй. Кларке (*Clarke 1992:20*) гэмт хэргийн нөхцөл байдлаас сэргийлэх болон гудамжны гэмт хэргийн (*XI бүлгийг үз*) талаар авч үзээд ‘гэмт хэргийн нөхцөл байдлаас сэргийлэх нэг гол багана ... бол шинэ дүрэм, журам нэвтрүүлэх болон өмнө хэрэгжиж байсан дүрэм, журмыг сайжруулах’ хэмээн тэмдэглэжээ. Эдгээр нь хүлээн зөвшөөрөгдөх ба зөвшөөрөгдөхгүй үйлдэл хоорондын хоёрдмол утгыг арилгахад чиглэнэ. Нөхцөл байдлаас үл хамааран энэ нь гудамжны ба цагаан захтнуудын гэмт хэргийн

аль алинд хамаатай. Зан үйлдлийн тодорхой дүрэмтэй болох нь төлбөрийг хурдасгах, бэлэг ба дайллага, ашиг сонирхлын зөрчил ба зуучлал ашиглах зэрэг ёс зүйн хувьд эргэлзээтэй талбарт чухал үүрэг гүйцэтгэнэ. Учир нь ажилтны буруу үйлдэл нь байгууллагын дотоод зохицуулалтаар юуг хориглож, юуг хүлээн зөвшөөрдөг талаар тодорхой ойлголт байхгүйн улмаас сэдэлжүүлэгдсэн байж (*Stevens 2007*) болно. Түүнээс гадна дагаж мөрдөх тогтолцоо, хяналт, ёс зүйн үнэт зүйл ба хэм хэмжээг хувь хүн, нэгж, байгууллага, үйлдвэрлэлийн түвшинд ялгаатай суулгаж, институцжүүлдэг.

Гэхдээ ёс зүйн стандартыг дагаж мөрдөх явдлыг гадаад хэрэгжүүлэлтийн тогтолцоог байгуулах замаар баталгаажуулах хэрэгтэй. Энэ бүлэг дэх зарим онол үүнтэй хамааралтай. Дотоод зохицуулалтын дүрэм, тодорхой заавар чиглэл байхгүй байх, ажилчдын сургалт муу байвал авлигаас урьдчилан сэргийлэх ажил үр дүн муутай байдаг. Брэйтвэйт (*1982*) хувийн байгууллага нь байгууллагын шинж чанар ба 'бизнесийн арга барил'-д тааруулан дүрмээ өөрчлөх боломжтой бөгөөд өөрчлөгдөж буй нөхцөл байдалд хурдан дасан зохицох чадвартай, тэдгээр нь байгууллагын соёлд уусан шингэсэн байдаг учир бизнесийн үйл ажиллагаагаа зохицуулж, өөрийн байгууллагад гэмт хэрэг гарахаас сэргийлэх талаар төрийн албаны бүтцээс илүү чадвартай байдаг гэж үзсэн хэдий ч гэсэн тэдгээр байгууллага нь ёс зүйн стандартаа тогтмол мөрдөх эсэх нь эргэлзээтэй гэжээ.

Үүнийг байн байн гарсаар байгаа санхүүгийн хямрал ба авлигын хэрэг, мөн авлигыг илрүүлсэн хүмүүсийг санхүүгийн салбарт хэрхэн авч үзэж байгаа нь харуулж байна. JPMorgan Chase компанийн хамтрагч Флэйшманн (*Fleischmann*) 2006, 2007 онд банк нь өөрийнхөө зээлийн стандартыг хангахгүй орон сууцны зээлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зараад байгаа талаар дарга нартаа мэдэгдэж байв. Флэйшманныг 2008 оны 2 дугаар сард халсан бөгөөд санхүүгийн салбараас үндсэндээ гаргаж хаясан байна. Энэ арга хэмжээний улмаас тэр Үнэт цаас, валютын

комисст өөрт байсан бүх мэдээллээ өгөхөөс аргагүй болсон бөгөөд уг мэдээлэл нь 2013 онд JPMorgan Chase компани Үнэт цаас, валютын комисс болон Шүүх яамтай 13 тэрбум долларын тохиролцоонд хүрэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. III Ричард Бовен, Майкел Винстон, Гэри Ж.Агүайр нар ч санхүүгийн салбарт байж боломжгүй гэж харсан үйлдэл, практикийг ил (*Cohan 2016*) болгосон бөгөөд дараа нь бусад хүмүүстэй хамтран 'Банкны шүгэл үлээгчдийн нэгдэл'-ийг (*Bank Whistleblowers United*) байгуулж Воол Стрийтийг зохицуулж буй байдлыг өөрчлөхийг улс төрчид, зохицуулагчдаас шаардсан 29 хүсэлт бүхий тунхаг бичиг боловсруулан нийтэд танилцуулжээ.

Газрын тос, эмийн бүтээгдэхүүн, автомашин үйлдвэрлэлийн салбарт санхүүгийн хямрал гарч, давтан хэрэгтнүүд байсаар байгаа үед байгууллага өөрийгөө зохицуулах чадвартай байлаа ч тэр нь тийм ч хүсмээр зүйл биш юм. Өөрийгөө зохицуулахын үндсэн сул тал нь цаасан дээрх бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, түүнийг даган мөрдөх тогтолцоо байнга дагалдаж байдаггүй явдал юм. Хувийн байгууллага дахь өөрийгөө зохицуулах тогтолцоог олон нийт хэрэгжүүлэх явдал нь авлигаас урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл болж байгааг онцлох болсон ч (*Ruhnka and Boerstler 1998; Gobert and Punch 2003; Hess 2009*) Европын холбооны хэдхэн гишүүн улс тийм тогтолцоог нэвтрүүлээд (*Martun 2012; Asser Institute 2012*) байна. Харин түүний оронд шахалт үзүүлэх бүлэглэлүүд, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, олон улсын ба бүс нутгийн байгууллагуудын хамтарсан үйл ажиллагаа нь үндэстэн дамнасан байгууллагуудыг нийгмийн хариуцлагатай иргэн шиг ажиллуулахад хүргэж байгаа харагдаж (*Lambooy 2010*) байна.

Гэвч энэ нь хангалтгүй. Хамтын нэгдлүүдийн санхүүгийн сонирхлыг хамгаалах 1997 оны конвенцийн хоёрдугаар протоколд заасан хуулийн стандартаар гишүүн орнуудаас хэрэг хийсэн хүнд хариуцлага тооцохыг, мөн олон улсын түвшинд 1997 оны Эдийн засгийн нөхөрлөл, хөгжлийн байгууллагын

Гадаадын төрийн албан хаагчдыг хахуульдахтай тэмцэх конвенциор хуулийн этгээд гадаадын төрийн албан хаагчийг хахуульдах үйлдэлд (*2 дугаар зүйл*) оноох хариуцлагыг тодорхой болгох арга хэмжээ авахыг шаардсан байдаг. Мөн 2003 оны НҮБ-ын Авлигын эсрэг конвенциор (*21 дүгээр зүйл*) хуулийн этгээдийн идэвхтэй ба идэвхгүй авлигад хариуцлага тооцох хууль боловсруулахыг гишүүн улсуудад зөвлөмж болгосон байдаг ч Европын холбооны улсуудад жигшүүрт авлигын хэрэг гарсаар байна.

Тэдгээр хуулиар эрүүгийн хариуцлагыг нэмэгдүүлсэн ч хэрэгжүүлэхгүй бол утга байхгүй. Европын холбооноос хувийн салбарын авлигаас сэргийлэх талаар бараг оролдлого хийгээгүй (*Asser Institute 2012*) ба нийгмийн хариуцлагатай бизнесээс хүлээгддэг гурван бүрэлдэхүүн буюу ‘дэлхийн бөмбөрцөг, хүмүүс, ашиг’-н (*planet, people, profit*) шаардлага нь хий хоосон сонсогдохоор байна. Эмийн бүтээгдэхүүний салбар энд тохиромжтой жишээ болно. Эдийн засгийн өсөлт ба нийтийн эрүүл мэндэд хувь нэмэр оруулахад чухал үүрэгтэй уг салбарыг олон хүчин зүйл авлигын эрсдэлтэй (*Cohen et al. 2007*) болгодог. Жишээлбэл, энэ салбар нь эдийн засгийн тогтолцоонд эмийн үнийн өсөлт ба өрсөлдөөний практикаар нөлөөлөх боловч сая сая хүний эрүүл мэндэд эм, эмчилгээний чанар, хүртээмжийн хувьд нөлөөлнө. Эмийн бүтээгдэхүүний зах зээлийн авлигад эмзэг байдлыг дэлхий дээрх төрийн байгууллагууд эмийн бүтээгдэхүүний циклд гүйцэтгэх чиг үүргээр тайлбарлаж болно. Клиникийн туршилт эхлэхээс өмнө ихэвчлэн төрөөс зөвшөөрөл авах хэрэгтэй байдаг. Эмийг зах зээлд оруулахыг зөвшөөрснөөс хойш бүртгэх, үнэ тогтоох, худалдан авах, түгээх, устгах бүх шатанд салбар, үйлдвэр ба зохицуулах байгууллага хоорондын харилцан үйлчлэл далдуур явагддаг. Гэвч авлига эмч нарт тодорхой эмийн жор бичихийг итгүүлэхийн тулд төлөөлөгчөөр дамжуулан өгөөмрөөр бэлэг, зуучлалын хөлс өгөх; сэтгүүлчдээр бүтээгдэхүүндээ талтай

бичвэр бичүүлэх, эрүүл мэндийн сэтгүүлд илэрхий авлига өгөх болон төлбөр төлөх; их сургуулийн эмнэл зүйн судалгааны институтэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, эсхүл эмнэлзүйн судалгаанаас ашиг хүртэх байгууллагад ажилладаг эрдэмтдэд хувьцааг тодорхой үнээр худалдан авах сонголт өгөх зэргээр янз бүрийн хэлбэрээр оршин, илрэн гарсаар (*Vander Beken 2007; Goldacre 2012*) байна. Маш сайн үр дүнтэй эмийн патентын орлогыг хэвээр хадгалахын тулд эмийн бүтээгдэхүүний салбарт нийт үйлдвэрлэл болон эмийн өрсөлдөөнийг хаах, эсхүл хойшлуулахыг зорьсон практикийг авч хэрэгжүүлсээр байгаа нь эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг ихээхэн хэмжээгээр хязгаарлаж (*Karanikolos et al. 2013*) байна.

Тиймээс зохицуулах дүрэм журам, эрүүгийн хууль нь зөвхөн хэрэгжиж байгаа хүрээгээрээ л үр дүнтэй. Хэрэв яллах магадлал бараг үгүй, шийтгэл ч үр дүн муутай, гэмт үйлдлийг цээрлүүлж чадахгүй бол нягтлан бодох бүртгэлийн хуулийн учир утга, үр нөлөө бага байна. АНУ-д хууль хэрэгжүүлэх өнөөгийн аргачлалаар бол үндэстэн дамнасан корпорацад ихэвчлэн ажилладаг цагаан захт гэмт хэрэгтнүүд буруу үйлдлийг нь яллахаас тогтмол зугтаж чадна гэж Варрен (*Warren 2016*) бичжээ. Хуульд хэрэв хуулийн этгээд хууль зөрчсөн нь тогтоогдсон бол хувь хүмүүс ч гэсэн хууль зөрчсөн байх ёстой хэмээн хоёрдмол утгагүй заасан байлаа ч ийм байдал байсаар байна. Гэвч энэ номд орсон олон тодорхой жишээн дээр гэмт үйлдлийг шийтгэх, ялангуяа ардчилсан улсад шийтгэх явдал дөнгөж л оог цоог байдлаар хэрэгжсэн байна. Варрен (*2016*) хууль хэрэгжүүлэх зарим байгууллага, ялангуяа Шүүх яам хувь хүмүүсийг ховорхон ялладаг асуудлыг гаргаж тавьжээ. Үнэндээ хууль хэрэгжүүлэгчид, шүүх үндэстэн дамнасан корпорациуд болон тэдгээрийн удирдлагыг ховорхон ялладаг. Хууль бус үйлдэл, зан үйлээ хүлээн зөвшөөрөхийг ховорхон шаардаж, үүний оронд иргэний болон эрүүгийн тохиролцоонд хүрэхийг зөвшөөрдөг учраас удирдлагууд нь ямар шийтгэлгүй, хувь

хүний хариуцлага үүрэхгүйгээр ялаас мултардаг байна. Зарим тохиолдолд удирдлагууд нь дотоод шаардлага, эсхүл хувьцаа эзэмшигчдийн эсэргүүцэлтэй тулгарч албан тушаалаасаа огцорсон ч их хэмжээний тэтгэмж аваад эрүүгийн хариуцлага хүлээдэггүй.

АНУ дахь Үнэт цаас, валютын комисс хууль хэрэгжүүлэх арга хэрэгслийн цогцоо бүгдийг нь ашигладаггүй хэмээн шүүмжлүүлдэг. Уг агентлаг хариуцлага шаардахгүй байгаад зогсохгүй гэм бурууг тогтоохгүй байх сонголтоо ашигладаг учир ихэвчлэн үндэстэн дамнасан корпорацууд буруу үйлдлээ давтсаар байгаа хэрнээ тусгай давуу эрх эдэлсэн хэвээр байна. Хэрэв тэдний гэм бурууг тогтоовол тэдгээр үр ашгийг хүртэх эрхгүй болгох болно. *Citigroup, JPMorgan Chase & Co, Barclays, UBS AG*, Шотландын эзэн хааны банкны 'картел' нь таван жилийн турш валютын ханшийг удирдан үйлчлүүлэгчид, хөрөнгө оруулагчдыг хохироосон хэрнээ нийт 5.6 тэрбум долларыг Шүүх яаманд тохиролцооны мөнгө болгон төлсөн. Гэхдээ UBS шүүхийн өмнө валютын ханшийг удирдсантай холбогдуулан залилангийн төлбөрийг шилжүүлсэн гэм буруугаа хүлээсэн. Хэдийгээр Шүүх яам ял сул байгаа байдлыг эргэн харж, гэм буруугаа хүлээхийг тохиролцооны нэг хэсэг байхыг шаарддаг болсон хэдий ч 2016 оны байдлаар Шүүх яам ямар ч хувь хүнд эрүүгийн ял тулгаагүй байна. Түүнчлэн Үнэт цаас, валютын комисс банкнуудад дагалдах үр дагавраас зайлсхийх боломж олгосноор эдгээр үйлдлийн үр дүнг үзэхээс татгалзжээ. Энэ бол шүүхийн өмнө гэм бурууг нь хүлээлгэсэн авлигыг шийдвэрлэх практик оролдлого байсан гэхээс илүү бэлэг тэмдгийн чанартай ичмээр зүйл болсон гэсэн үг. АНУ дахь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн захиргаа зэрэг бусад газар дахь хууль журмын хааш яайш хэрэгжүүлэлт нь голчлон хууль хэрэгжүүлэх, дүрэм зөрчигчдийг цээрлүүлэх хууль зүйн хүчин чадал болон удаан хугацаанд санхүүжилт дутуу байснаас голлон үүддэг.

Хэрэв хувь хүн, байгууллага тохиролцооны нэг хэсэг болгон гэм буруугаа хүлээхээс татгалзвал хууль зөрчсөн байлаа ч гэмт хэрэг үйлдсэн гэж хэлэх боломжгүй. Гэхдээ хэрэв хэрэг шүүхийн шатанд хүрвэл эдгээр хувь хүмүүс ба байгууллагын зарим нь өөрсдийн үйлдсэн (ба үйлдээгүй) үйлдлийн ‘шударга’ шалгууртай тулгарна. Хувь хүн ба байгууллагууд шүүхээр орохын оронд ‘тохиролцоо хийдэг’-г гол согог байна. Хэргийг шүүхээр оруулах нь зардал ихтэй боловч хэрэв эрүүгийн шүүх тогтолцоо хүлээн зөвшөөрөгдөх байдлыг эрэлхийлдэг гэвэл энэ нь шалтаг болохгүй. Ялангуяа энэ номд дурдагдсан зарим үйлдэл нь хүн амь насаа алдах, амиа алдсаны үр дагаврыг хувь хүн ба гэр бүлүүд тэсвэрлэн амьдрах ёстой болох үед шалтаг болох ёсгүй.

Тэгэхээр зарим хүний хувьд хуулийг дагаж мөрдөх эсэх нь сонголт болж харагддаг байна. Торгууль нь авлигаар олж авсан ашгийн цөөн хувьтай тэнцүү байвал хууль зөрчих нь ‘бизнес хийх’ зардлаас бага зэрэг л их болно. Эррик Холдер (*АНУ-ын шүүх яамны сайд асан*) 2014 онд ‘байгаа бүхий л хууль тогтоомжийг хатуу чанд хэрэгжүүлнэ гэдэг хүлээлтийг хүмүүст суулгах нь ... тэд сонирхлоо зөвөөр үнэлж ашгийн төлөө сохроор хөөцөлдөж, том эрсдэлийг тоолгүй орхихгүй байхад ... зайлшгүй шаардлагатай’ гэж тодорхой (*Warren 2016*) хэлсэн. Эдийн засагт үзүүлж буй авлигын нөлөө, улс төрийн хүсэл сонирхолгүй байх, хангалттай хөрөнгө мөнгөгүй байх, сул, үр дүнгүй хууль, хэрэгжүүлэлт нь бүгд эрүүгийн шүүн таслах тогтолцооны (*criminal justice system*) хүлээн зөвшөөрөгдөх байдлыг ихээр муутгадаг. Учир нь байгууллагууд дахин дахин хууль зөрчсөн ч тэдэнд амархан төлчих санхүүгийн шийтгэлээс өөр шийтгэл ногдуулахгүй байдалтай байна.

Дүгнэлт

Энэ бүлэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамгийн сайн арга бол ‘зөв нийгэмшил’ гэж үздэг онолын аргачлалыг товч

Авлигын криминологи

танилцуулахаас эхэлсэн. Гэхдээ юу зөв бэ гэдгийг тодорхойлох боломжгүй боловч иргэний ба хуулийн зохицуулалтын хэлбэртэй нийгмийн гадаад хяналт нь мэдээж нийгмийн хяналтын тодорхой хэлбэр болно. Гэхдээ авлигын үйлдэл гаргадаг хувь хүн, байгууллага нь ихэвчлэн авлигаас олсон ашгийнхаа багахан хувьтай тэнцэх санхүүгийн шийтгэл хүлээж байна. Нийгмийн гадаад хяналт нь үр нөлөөтэй байх, гэмт хэрэг хийхээс цээрлүүлдэг байх, мөн 'шударга' гэж харагдах хэрэгтэй. Хэрэв тэгэхгүй бол энэ номд үзүүлсэн орчин үеийн олон авлигын жишээтэй адил хууль хэрэгжүүлэлт нь өөрийгөө зохицуулах процесстой гэж хоосон амлалт өгдөг хувь хүн ба байгууллагын эрх мэдлээс хамааран зүгээр л хэлэлцээ хийх сонголт болж харагдана.

Авлигажсан практикийг институцийн ердийн зүйл болгох явцыг өөрчлөх нь хэцүү боловч түүнийг шүүмжилж, ил болгож болно. Авлигыг зогсоохын тулд иргэний, ялангуяа эрүүгийн шүүх тогтолцоо бизнесийн тохиролцоотой төсөөтэй байж болохгүй. Хууль хэрэгжих арга замыг өөрчлөхийн тулд ихийг хийх хэрэгтэй. Тухайлбал, авлигыг шийдвэрлэх, төрийн зохицуулалтын болон эрүү, шүүхийн байгууллагад хөрөнгө оруулах болон хууль хэрэгжилтийг эрчимжүүлэхэд улс төрийн хүсэл зориг хэрэгтэй. Гэвч одоогоор капиталист тогтолцоотой улсуудад авлигаар дамжуулж хүмүүс болон байгаль орчныг сорон мөлжих цагаан захтнуудын гэмт хэрэг нь таагүй бодит байдал хэвээр байсаар байна.

Ашигласан материал

- Ashforth, B. E., & Anand, V. (2003). The normalization of corruption in organizations. *Research in Organizational Behavior*, 25, 1–52.
- Asser Institute. (2012). *Prevention of fraud, corruption and bribery committed through legal entities for the purpose of financial and economic gain: Comparative overview*. The Hague: The Asser Institute.
- Bernard, T. (1984). Control criticism of strain theories: An assessment of theoretical and empirical adequacy. *Journal of Research in Crime and Delinquency*, 21 (4), 353–372.
- Box, S. (1981). *Deviance. Reality and Society*. London: Holt, Rinehart and Winston.
- Braithwaite, J. (1982). Enforced self-regulation: A new strategy for corporate crime control. *Michigan Law Review*, 80 (7), 1466–1507.
- Braithwaite, J. (1997). Charles Tittle's control balance and criminological theory. *Theoretical Criminology*, 1 (1), 77–97.
- Burger, J. M., & Cooper, H. M. (1979). The desirability of control. *Motivation and Emotion*, 3 (4), 381–393.
- Bursik, R. J. (1988). Social disorganization and theories of crime and delinquency: Problems and prospects. *Criminology*, 26 (4), 519–552.
- Clarke, R. V. G. (1992). *Situational Crime Prevention: Successful Case Studies*. Guildersland, NY: Harrow and Heston.
- Cohan, W. D. (2016, February 16). Band of whistle-blowers aims for reform. *International New York Times*, p. 17.

Авлигын криминологи

- Cohen, J. C., Mrazek, M., & Hawkins, L. (2007). Tackling corruption in the pharmaceutical system with courage and conviction. *Clinical Pharmacology and Therapeutics*, 81 (3), 445–449.
- Cooley, C. H. (1922). *Human nature and social order*. New York: Scriber.
- Gobert, J., & Punch, M. (2003). *Rethinking corporate crime*. London: Butterworths.
- Goldacre, B. (2012). *Bad pharma*. London: Fourth Estate.
- Hagan, J. (1989). *Structural criminology*. New Brunswick, NJ: Rutgers University Press.
- Hess, D. (2009). Catalysing corporate commitment to combating corruption. *Journal of Business Ethics*, 88 (4), 781–790.
- Hinds, L., & Murphy, K. (2007). Public satisfaction with police: Using procedural justice to improve police legitimacy. *Australian & New Zealand Journal of Criminology*, 40 (1), 27–42.
- Hirschi, T. (1969). *Causes of delinquency*. Berkeley, CA: University of California Press.
- Hough, D. (2015). *Corruption, anti-corruption and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Hough, M., Jackson, J., Bradford, B., Myhill, A., & Quinton, P. (2010). Procedural justice, trust, and institutional legitimacy. *Policing: A Journal of Policy and Practice*, 4 (3), 203–210.
- Jones, S. (2006). *Criminology* (3rd ed.). Oxford: Oxford University Press.
- Karanikolos, M., Mladovsky, P., Cylus, J., Thomson, S., Basu, S., Stuckler, D., Mackenbach, J. P., & McKee, M. (2013). Financial crisis, austerity, and health in Europe. *The Lancet*, 381 (9874), 1323–1331.

- Lambooy, T. E. (2010). *Corporate social responsibility: Legal and semi-legal frameworks supporting corporate social responsibility*. Deventer: Kluwer.
- Lilly, R. J., Cullen, F. T., & Ball, R. A. (1989). *Criminological theory: Context and consequences*. Thousand Oaks, CA: Sage Publications.
- Lilly, R. J., Cullen, F. T., & Ball, R. A. (2015). *Criminological theory: Context and consequences* (5th ed.). Thousand Oaks, CA: Sage Publications.
- Logan, J., & Molotch, H. (1987). *Urban fortunes. The Political Economy of Place*. Berkeley, University of California.
- Martin, A. N. (2012). Cosmetic use and lack of precision in compliance programs: Any solution? *EUCRIM, The Criminal Law Associations' Forum*, 3, 124–127.
- Mead, G. H. (1934). *Mind, self and society*. Chicago: University of Chicago Press.
- Murray, C. (1990). *The emerging British underclass*. London: Institute for Economic Affairs.
- Mazerolle, L., Bennett, S., Davis, J., Sargeant, E., & Manning, M. (2009). *Legitimacy in Policing*. Nydalen, Norway: The Campbell Collaboration.
- Mazerolle, L., Bennett, S., Manning, M., Ferguson, P., & Sargeant, E. (2009). *Legitimacy in Policing. Research Preview*. Brisbane, Queensland: ARC Centre of Excellence in Policing and Security.
- Nye, I. F. (1958). *Family relationships and delinquency behavior*. New York: Wiley.
- Payne, B. K. (2012). *White collar crime: A Text/Reader*. Thousand Oaks, CA: Sage Publications.

- Piquero, N. L., Schoepfer, A., & Langton, L. (2010). Completely out of control or the desire to be in complete control. How low-self control and the desire for control relate to corporate off ending. *Crime and Delinquency*, 56 (4), 627–647.
- Polk, K. (1991). Book reviews. *Crime & Delinquency*, 37 (4), 575–579.
- Reckless, W. C. (1961). *The crime problem* (3rd ed.). New York: Appleton-Century Crofts.
- Reckless, W. C. (1967). *The crime problem* (4th ed.). New York: Meredith.
- Reiss, A. J. (1951). Delinquency as a failure of personal and social controls. *American Sociological Review*, 16, 196–207.
- Ruhnka, J. C., & Boerstler, H. (1998). Governmental incentives for corporate self-regulation. *Journal of Business Ethics*, 17 (3), 309–326.
- Sargeant, E., Murphy, K., Davis, J., & Mazerolle, L. (2012). Legitimacy and policing. In *Policing and Security in Practice* (pp. 20--36). Basingstoke: Palgrave Macmillan UK.
- Savelsberg, J. J. (1996). Review: *Control balance: Toward a general theory of deviance*. *American Journal of Sociology*, 102, 620–22.
- Shaw, C., & McKay, H. D. (1942). *Juvenile delinquency and Urban areas*. Chicago: University of Chicago Press.
- Shichor, D. (1989). Corporate deviance and corporate victimization: A review and some elaborations. *International Review of Victimology*, 1 (1), 67–88.
- Stark, R. (1987). Deviant places: A theory of the ecology of crime. *Criminology*, 25 (4), 893–910.

- Stevens, B. (2007). Corporate ethical codes: Effective instruments for influencing behaviour. *Journal of Business Ethics*, 78 (4), 601–609.
- Sunshine, J., & Tyler, T. R. (2003). The role of procedural justice and legitimacy in shaping public support for policing. *Law and Society Review*, 37 (3), 513–548.
- Tittle, C. R. (1995). *Control balance: Toward a general theory of deviance*. Boulder, CO: Westview press.
- Tittle, C. R. (2004). Refining control balance theory. *Theoretical Criminology*, 8 (4), 395–428.
- Tyler, T. R. (2003). Procedural justice, legitimacy, and the effective rule of law. *Crime and Justice*, 30, 283–357.
- Tyler, T. R. (2006). *Why people obey the law*. Princeton: Princeton University Press.
- Tyler, T. R. (2007). *Legitimacy and Criminal Justice: An International Perspective*. New York: Russell Sage Foundation.
- Vander Beken, T. (2007). *The European pharmaceutical sector and crime vulnerabilities*. Antwerpen-Apeldoorn: Maklu Publishers.
- Warren, E. (2016). *Rigged Justice 2016: How weak enforcement lets offenders off easy*. Washington: Office of United States Senate, Office of Elizabeth Warren.
- Weisburd, D. (1991). *Crimes of the middle classes: White-collar offenders in the federal courts*. Yale: Yale University Press.
- Weisburd, D., & Waring, E. (2001). *White-collar crime and criminal careers*. Cambridge University Press.
- Wilson, J. Q., & Herrnstein, R. (1985). *Crime and human nature*. New York: Simon and Shuster.

VIII

Авлигыг тайлбарлах нь: Зөрчилдөөний 'тогтолцоонд' авлига гарцаагүй юу?

Удиртгал

Гэмт хэргийг хэрэгтэнтэй холбоотой биологийн, сэтгэлзүйн, эсхүл нийгмийн асуудал хэмээн тайлбарлахыг оролдсон онолууд нь гэмт хэргийн талаарх ойлголт нь бодитоор, эсхүл төсөөллөөр хэрхэн бий болдгийг ихэвчлэн үл тоодог. Нэр шошго зүүх (*IX бүлгийг үз*) онол нь энэхүү дутууг засахыг оролдон процесс, түүний үр дагаврыг тайлбарлан, улс төрийн ашиг сонирхол ба эрх мэдэл нийгмийн хариу үйлдэлд нөлөөлдөг арга замыг өндрөөр үнэлсэн боловч эрх мэдлийн ялгааны тал дээр, хувь хүн болон бүлэг хүний хоорондын тэмцлийг тайлбарлах тал дээр бага зүйл хийсэн юм. Энэ бүлэгт нэр шошго зүүх асуудлаас илүүтэйгээр зөрчилдөөн (*conflict theory*) гэдэг талбарт харьяалагдах онолын аргачлалуудыг авч үзнэ. Эдгээр зөрчилдөөний эх үүсвэр, хэрхэн явагддаг ба зөрчилдөөнийг арилгах талаар Бонгер (*Bonger 1916*), Селлин (*Sellin 1939*), Волд (*Vold 1958*), Дарендорф (*Dahrendorf 1958*), Түрк (*Turk 1969*), Күинни (*Quinney 1969*), Тэйлор нарын (*Taylor et al. 1973*) бүтээлд түшиглэн авч үзнэ. Энэ бүлгийн гол зорилго

нь хэдийгээр бүх тогтолцоонд эрх мэдлийн ялгаа ба авлигажсан хувь хүн, байгууллага байдаг ч капитализм дахь зөрчилдөөнийг тайлбарлах явдал юм. Дээр дурдсан эрдэмтэд дарангуйлал эсхүл хэмжээгүй эрхт хаант засагт бус капитализм дахь зөрчилдөөний талаар хэлэлцэж ирсэн байна.

Капитализм ба гэмт хэрэг

Зөрчилдөөний янз бүрийн онолыг Маркс, Энгелсийг товч эргэж харахгүйгээр авч хэлэлцэх боломжгүй юм. Тэд гэмт хэргийн талаар бага авч үзсэн боловч 1800-аад оны дундаас нийгмийн эв нэгдэл задарч ирэхийг хараад гэмт хэрэг бол хурдацтай үйлдвэржилтийн үр дагавар гэж үзэж байв. Нийгмийн задралын талаарх тэдний энэ үзэл Дюрхэймийн онолоос өмнө гарсан бөгөөд нийгмийн задралын талаарх Дюрхэймийн шинжилгээ, шийдлийн талаар ялгаатай байр суурьтай байжээ. Дюрхэймийн хувьд ийм өөрчлөлт нь ёс суртахууны асуудал бөгөөд нийгмийн эв нэгдэл нь ирээдүйд үр дүнтэй төрөл бүрийн хяналт, нийгмийн нийлэмж ба зохицуулалтын түвшнээс хамаарна гэж үзсэн байна. Маркс, Энгелс асуудлыг нийгмийн нэг анги нөгөө ангийг мөлжих эдийн засгийн асуудал гэж хараад, зөрчилдөөн зайлшгүй бөгөөд тэр нь үйлдвэрлэсэн капиталын хуримтлалаас үүдсэн ашиг сонирхол ба эрх мэдлийн ялгаа маш их байгаа тогтолцоонд угаас байдаг зүйл гэж үзжээ (*Lilly et al. 1989*). Хэдийгээр Маркс, Энгелсийн бүтээл нарийн төвөгтэй ч тэдний бүтээлд үндэслэсэн бүхий л зөрчилдөөний талаарх онолд дараах түлхүүр бүрэлдэхүүн хэсэг байдаг. **Үүнд:** хязгаарлагдмал нөөцийн төлөөх өрсөлдөөн нь (*хүнс, хувцас, гэр орон*) зөрчилдөөнд хүргэх; хамгийн бага нөөцтэй нь нөөцийн хуваарилалтын хууль ёсны байдлыг шүүмжлэх; нөөцийн ‘хэрэгцээтэй’ байгаа хүмүүс зохион байгуулалтад орох; зөрчилдөөн нь харагдахуйц, ил тод болж зөрчилдөөний эргэн тойронд хуваагдал үүсэх ба хүчирхийлэлд (*ингэснээр нөөцийн*

дахин хуваарилалт явагдах магадлалтай) хүргэх гэсэн хэсэг багтана.

Бонгер (1916) зөрчилдөөний онолыг гэмт хэрэгт хэрэглэж, хүн нь төрөлхөөсөө нийгмийн амьтан учраас гэмт хэрэг нь хүний зан үйлийг гажуудуулдаг зохимжгүй гадаад орчноос болдог гэж үзжээ. Энэхүү гажуудал нь капитализм ба эдийн засгийн тогтолцооны хурц ялгарлаас болно. Хүмүүс нөөцийн төлөө зөрчилдөх тийм ялгарал ихтэй орчин нөхцөл нь хувь хүмүүс бусдыг үл тоон таашаал хөөх сонголт руу түлхдэг бөгөөд үүний тулд мөнгөтэй байх шаардлагатай болсноор 'эгоизм' буюу 'амин үзэл'-д (Lilly et al. 1989:141) хүргэж, энэ нь хүмүүсийг гэмт хэрэг үйлдэх илүү магадлалтай болгодог аж. Энэ аминч үзлийг орчин үеийн хууль, хяналт, бизнес дэх төрийн оролцоо, Удирдах зөвлөлд дарга бус төлөөлөл оруулах, Ёс зүйн хороо байгуулах гэх мэт нийгмийн хяналтаар бууруулж чадахгүй. Капитализм нь энэхүү аминч үзлийн эх сурвалж юм. Бонгер гэмт хэрэг бол капитализмын үр дагавар болсон ядууралд үзүүлэх шууд (*амьд үлдэхийн тулд гэмт хэрэг зайлшгүй*) ба шууд бус (*шударга бус байна гэсэн мэдрэмж ба хувь хүний ёс суртахуунгүйдэл*) хариу үйлдэл гэж үзсэн байна. Ийм зөрчилдөөний улмаас эрх мэдэлтнүүд гэмт хэрэг үйлддэг, учир нь тэдэнд боломж байдаг төдийгүй тэд капитализмаас үүдэлтэй ёс суртахууны доройтолд орсон байдаг гэж Бонгер бас тэмдэглэжээ. Гэмт хэрэг нь ёс суртахуунгүй үйлдэл гэж тооцогддог ч ёс суртахууны тодорхойлолт нь янз бүр байдаг (*IX бүлгээс нэр шошго зүүх талаар үз*) гэж Бонгер цааш бичсэн байна. Гэхдээ тэрээр нийтлэг тодорхойлолт ба түүний хувилбарууд нь эрх мэдэлтнүүдийн ашиг сонирхлоос урган гардаг гэдгийг онцолсон байна. Үйлдэл нь эрх мэдэлтнүүдийн ашиг сонирхолд занал учруулж байгаа үед гэмт хэрэг гэж тодорхойлогддог ба эдгээр 'ашиг сонирхолд' аюул учруулахгүй бараг бүх үйлдэл шийтгэгддэггүй гэж тэр үзжээ.

Садерланд нэр хүндтэй, нийгмийн өндөр байр суурьтай хүмүүс ажил мэргэжлээ гүйцэтгэх үедээ хийсэн хэргийг ялгаатай нөхөрлөлийн онолоор тайлбарлаж болохыг харуулсан бөгөөд энэ нь улс төр, бизнес, мэргэжлийн хүрээнд өргөн тархаж, Америкийн корпорацууд хуулийн стандартыг дахин дахин зөрчиж, архаг гэмт хэрэгтэн болж байгааг ил болгосон юм. Мөн Селлин (1939) ‘соёлын зөрчилдөөн’-ий асуудал нь гэмт хэргийн эх үүсвэр бөгөөд ‘үйл хөдлөлийн хэм хэмжээ’ (Lilly et al. 1989:143) нь бусдынхтай зөрчилдөж болзошгүй гэдгийг анхааруулсан байна. Ямар ‘үйл хөдлөлийн хэм хэмжээ’ нь гэмт хэрэгт тооцогдож болзошгүй вэ гэдэг талаар Селлин (1938:3) ‘төрөөс гэмт хэрэгт тооцдог үйлдэл нь ... нийгэмд хортой бөгөөд ... сүүлийн үеийн шинжилгээгээр, улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг, улмаар хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх эрх мэдлийг хянадаг хүмүүст хортой үйлдэл байдаг ...’ гэж тэмдэглэжээ. Тэдгээр хүмүүс нь бизнест таатай ханддаг учраас дур зоргоороо аашилдаг хүмүүс/байгууллагыг шийтгэхээр баталсан хуулиа хэрэгжүүлэхдээ төр эргэлзэнгүй байдалд ордог хэмээн тэр үзсэн байна.

Энэ санааг баримтлан Волд (1958) зөрчилдөөн нь нийгмийн амьдралын үндсэн зүйл бөгөөд нийгмийн харилцаа нь эсрэг хүчнүүдийн зарим талаар тогтвортой тэнцвэрт өөрчлөлт оруулж байдгийг хүлээн зөвшөөрчээ. Энэ үзлээр нийгмийн дэг журам нь зөвшилцөл дээр бус зөрчилдөөн дээр тогтдог аж. Учир нь зөрчилдөөн нь олон талт нийгмийг бүрдүүлдэг янз бүрийн эсрэгцсэн хүчнүүдийн хооронд хүчний тэнцвэр үүсгэдэг. Волдын хувьд зөрчилдөөн нь зайлшгүй бөгөөд практик буулт хийх нь ардчилсан тогтолцооны нэг хэсэг юм. Тэрээр залуу хүмүүсийн үйлдсэн гэмт хэрэг эсхүл дайныг эсэргүүцсэн хөдөлгөөн зэрэг шинж чанараас үл хамааран гэмт хэрэг бол улс төрийн зүйл учир, норматив буюу ‘хэм хэмжээ тогтоосон’ шинжилгээнээс тэр зайлсхийсэн юм. Волд судалгаагаа өргөжүүлэн үйлдвэрчний эвлэл ба удирдлага хоорондын

зөрчилдөөн, зохион байгуулалттай гэмт хэрэг ба цагаан захтны гэмт хэрэг, зөрчилдөөнд ашиглагдах стратеги, тактикийг авч (*Vold 1958*) үзжээ.

Зөрчилдөөний онолоор юмс үзэгдлийг тайлбарлах явдал 1960-аад онд оргилдоо хүрчээ. Энэ цаг үед өмнөх үеийн болон тухай үеийн криминологийн онолын талаар чухал, эрс шүүмжлэлүүд гарсан ч зөрчилдөөн, хяналт, нэр шошго зүүх талаарх онолууд түүнээс өмнөх цаг үеэс эхтэй байдаг. АНУ-д зөрчилдөөн нэмэгдсэн явдлыг тайлбарлахад гурван чухал хүчин зүйл байна гэдгийг Сайкес (*1974*) цохон тэмдэглэжээ. Үүнд: Вьетнамын дайны үр нөлөө, сөрөг-соёл (*counter-culture*), улс төрийн тэмцлийн өсөлт хамаарна. Эрх мэдэлтэй байгаа хүмүүсийн хүлээн зөвшөөрөгдөх байдал ба итгэж болохуйц байдалд эргэлзэж, шүүмжлэх болсноор арьс өнгөний ялгаварлал, эмэгтэйчүүдийн хөдөлгөөний өсөлтийн эсэргүүцлийг дарахын тулд цагдаа хүч хэрэглэх болсон нь улс төрийн тэмцлийн жишээ болно. Хүмүүс суурь зөрчилдөөний талаар хэлэлцэн, ил тод тэмцэх болсон бөгөөд төр хүмүүсийг ялгаатай үзэл бодолтой байсных нь төлөө гэмт хэрэгтнүүд шиг баривчилж, эсхүл суллах хариу үйлдэл үзүүлж байв. Түүний зэрэгцээгээр 1950-аад онд зарим газраа МакКартизмийн²³ ажиллагаа явуулж, өөр бусад газраа үл тоож байсан төрийн өөрийнх нь хууль, дэг журмын бэлэг тэмдэг болсон Холбооны мөрдөх товчоо (FBI) ба Тагнуулын төв газар (CIA) нь хууль ёсны улс төрийн эсэргүүцлийг дарахын тулд хууль бус тактик (*Lilly et al. 1989*) хэрэглэн буруу мэдээллийг түгээхэд (*dissemination of disinformation*) (*төр худлаа хэлэх үйлдлийг заасан захиргааны нэр томъёо*) оролцсон болох нь ч мөн ил болжээ. Иргэдийг хамгаалж, тэдэнд үйлчлэх тангараг өргөсөн хүмүүс нь төрийн дарангуйлагч аппаратын төлөөлөл байсан нь эндээс харагдаж

23 АНУ-д 1950-1954 онд коммунист хэмээн сэжиглэгдсэн төрийн албан хаагчдын эсрэг Сенатор МакКартигийн зохион байгуулсан ялгаварлан, хэлмэгдүүлсэн үйл ажиллагааг хэлж байна. (Орч.)

байв. Тухайлбал, өмнөд мужид цагдаа нар хар арьст иргэдийг айлган сүрдүүлж, конгрессын гишүүн нь тэднийг улс төрийн дэг журмыг эсэргүүцдэг радикал үзэлтэн, эсхүл коммунист хэмээн дуудаж байв. Хууль, дэг журам ба хуулийн тогтолцоо нь тогтсон дэг журам болон эрх мэдэлтнүүдийн ашиг сонирхолд үйлчлэх, тэдэнд аюул учруулагчдыг гэмт хэрэгтэн хэмээн тамгалдаг гэсэн ойлголт эндээс үүссэн бөгөөд энэ нь зөрчилдөөний онол хөгжих хамгийн үржил шимтэй хөрс болжээ. Гэхдээ хүмүүсийг нийгэм, улс төрийн ялгаатай үзэл бодолтой байгаагийнх нь төлөө үл тоох тактик нь түүхийн тодорхой цаг үед болоод өнгөрсөн зүйл биш, одоо ч байгаа асуудал юм.

1960-аад онд хувь хүнийг биологийн, сэтгэхүйн эсхүл социологийн үүднээс буруутгаж, хангалттай нийгэмшээгүй (*дор хаяж сургуульд*) хэмээн үздэг онолын хандлагын тухайд хангалттай эргэлзээ үүсээд байв. Энэхүү эргэлзээ нь хэд хэдэн шалтгаанаас үүдэлтэй байв. Үүнд: эрүүгийн шүүн таслах тогтолцоонд ажиллаж буй хүнд бус, тогтолцоонд өөрт нь асуудал байна гэж харах болсон, хууль нь хүмүүсийн хүсэл зоригийг тусгасан зөвшилцөл дээр суурилж гардаг болсон, мөн объектив туршлагын шинжилгээнд үндэслэсэн криминологийн шинжилгээ хийдэг болсон гэх шалтгаанууд багтана. Тийм учраас хүмүүс гэмт хэргийн түвшин нь гэмт зан үйлийг тусгаж чадахгүй ба хүчтэй ашиг сонирхлын үүднээс хүмүүст гэмт хэрэгтэн гэх нэр шошго зүүх чадварын тусгал гэж үзэх болжээ.

Садерланд (*1939*), Волд (*1958*), Дарендорф (*1958*) нарын бүтээлд үндэслэн Түрк (*1969*) зөрчилдөөнийг амьдралын суурь баримт гэж хараад гэмт хэргийг бус эрүүгийн хэрэгт тооцох болон гэмт хэргийн статустай болгох процессыг тайлбарлахыг зорьсон байна. Түрк (*1969*) үйлдлийг бус хүнийг гэмт хэрэгтний статустай болгох төрийн байгууллагын чадамж, эрх мэдлийг онцлон үзжээ. Түүний онол нь үйлдэл бодитой, төсөөлөгдсөн эсхүл хуурамчаар үйлдэгдсэнээс үл хамааран *юу хийсэн бэ* гэдгийг бус *хэн хийсэн бэ* гэдэгт анхаарчээ. Энд дурдсан

төрийн байгууллага гэдэгт эрх мэдэл нь түүний субъект болж буй хүмүүсээр хүлээн зөвшөөрөгдсөн байдаг хууль ёсны эрх мэдэлтэй байгууллагыг хэлж байна. Түрк хүлээн зөвшөөрөх явдал нь дотоодчилогдсон үйл явцын үр дүн юм гэдэг санааг *(нийгмийн дотоод ба гадаад хяналтын талаар VII бүлгээс үз)* үгүйсгэсэн бөгөөд оронд нь тэр хүлээн зөвшөөрөх явдал нь хүмүүсийн *статуст* оногдсон *суралцах үүргийн* үр дагавар гэж тайлбарлажээ. Энэ тохиолдолд хэм хэмжээний хууль ёсны байдал нь эрх мэдэлд буй хүмүүсийн үг ба зан үйлээр тодорхойлогдож, тэдгээрийг субъектүүд нь дагах болно *(Turk 1969)* гэжээ.

Тиймээс энэ онол зарим хүмүүс субъект нь болдог эрх мэдэл нь бусад хүмүүст байгаагийн логик үр дагаврын талаар авч үзэж байна. Зөрчилдөөн дээр суурилсан тогтолцоонд ийм байх нь зайлшгүй учир тэрээр ийм байх нь шударга эсхүл шударга бус болох талаар судлаагүй аж. Гэхдээ Түрк соёлын ба нийгмийн гэсэн хоёр төрлийн хуулийн хэм хэмжээ зөрчилдөөнд хүргэдэг гэж үзсэн байна. Соёлын хэм хэмжээ нь хүлээгдэх зан үйлийн талаар байдаг тул хэл яриагаар тодорхойлогддог, мөн нийгмийн хэм хэмжээ гэдэгт үйлдэл бодитоор хийгдсэн нийгмийн нөхцөл байдал хамаарна гэж тэр үзжээ. Эдгээр хэм хэмжээний ялгаа нь соёлын ба нийгмийн нөхцөл байдал нь нийлэмжтэй байх эсхүл сөргөлдөхөөс хамаарч зөрчилдөөнд хүргэж *(Lilly et al. 1989:152–154)* болно. Зарим тохиолдолд авлигын үйлдэл гаргагчид шиг зохион байгуулалтгүй, нийгмийн туршлагатай субъектүүдтэй бол хамгийн бага зөрчилдөөн үүсэх магадлалтай байх нь мэдээж гэж тэр үзжээ. Авлигын гэмт хэргийн үйлдэл нь ихэвчлэн рационал *(X бүлгийг үз)* байдаг. Мөн хувь хүн/бүлэг хүмүүс өндөр зохион байгуулалттайгаар үйлддэг, түүнчлэн соёлын болон нийгмийн тогтсон заншлыг хүлээн авч буй байдал үзүүлэнгээ хууль бус үйлдэл хийдэгтэй зөрчилдөж байгаад энэхүү дүн шинжилгээний асуудал оршино. Түркийн шинжилгээний үр дүн нь зөрчилдөөн гарах магадлал

нь ‘эрх мэдэлтнүүд ба субъектүүд хоорондын хамаарлын шинж чанар’-аас хамаардаг (*Turk 1969:61*) гэсэн үр дүн бөгөөд энэ нь Хиршигийн (1969) хүрсэн үр дүнтэй (*VII бүлгийг үз*) адил байна. Гол ялгаа нь Хиршигийн хувьд эдгээр хамаарал нь хяналт тавихад чухал үүрэгтэй бол Түркийн хувьд ийм хамаарал нь үргэлжлэн буй зөрчилдөөний үйл явц дунд бий болдог аж. Гэвч нэг зүйлийг анхаарах хэрэгтэй нь Хирши өсвөр насны хэрэгтнүүдэд анхаарсан бол Түрк зохион байгуулалттай гэмт хэрэг, улс төрийн гэмт хэрэг, цагаан захтны гэмт хэрэгт анхаарсан учраас дээрх ялгаа нь байж болох зүйл юм.

Түркийн эхний алхам нь зөрчилдөөнийг шинжлэх байв. ‘Зөрчилдөөн нэгэнт эхэлбэл’ эрүүгийн хэрэгт тооцох үйл явцад нөлөөлөх магадлалтай ‘нөхцөл юу вэ’ (*Turk 1969:64*) гэдэгт түүний анхаарал татагджээ. Хэрэв хуулийн ба соёлын хэм хэмжээ нь ойр хамааралтай байвал хуулийг хэрэгжүүлэх болно гэж тэрээр үзсэн аж. Гэхдээ цагдаа нарт их хэмжээний эрх чөлөө байдаг учир баривчлах магадлал болон гэмт хэрэгт тооцох боломжид нөлөөлөх нь тэднээс, мөн тэдний хуулийн хэм хэмжээг хэрхэн хүлээн зөвшөөрч байгаагаас хамаарна гэжээ. Гэмт хэрэгт тооцох боломж нь цагдаагаас болон цагдаа эрх мэдлээ хэрхэн ашиглахаас хамаараад зогсохгүй бас зөрчилдөөнөөс зайлсхийхийг оролдож буй хүмүүсийн үйлдлээс хамаарна. Ардчилсан улс нь зөвшилцлийн тогтолцоо эсхүл хэсэгчилсэн зөвшилцөл дээр суурилсан үед л зөвхөн эрх мэдэлтэй байж, тэгснээр ‘шударга ёсыг тогтоох’ хууль ёсны эрх мэдэл гэж харагдана.

Цаасан дээрх хууль, түүний хэрэгжилтийн ялгаанд анхаарсан Чамблес, Сийдман (*Chambliss and Seidman 1971*) нарын онолын загвараар бол технологийн хөгжил ба нийгмийн чиг үүргийн ялгаралтай хамт үүссэн нарийн төвөгтэй байдлын улмаас зөрчилдөөн үүсдэг байна. Энэ нь шийтгэлийг хуулиар тогтоох/хууль батлах албан ёсны институт байхыг шаарддаг. Шийтгэлийг боловсруулах даалгавар авсан хүмүүсийг

хоорондоо өрсөлдөх, ашиг сонирхлуудын дунд эмх журмыг тогтоох үүрэгтэй хүмүүс гэж харсан байна. Нийгэм улам нарийн төвөгтэй болохын хэрээр энэ өрсөлдөөн илүү илэрхий болж зарим ашиг сонирхол нь бусдаас илүү эрх мэдэл, эд баялагтай болох нийгмийн давхраажилтад хүргэнэ. Нийгэм нь эдийн засгийн олон давхраатай болох тусам үйл хөдлөлийн хэм хэмжээг хүчээр хэрэгжүүлэх илүү их хэрэгцээ үүснэ.

Чамблес, Сийдман (1971) нар цааш нь шийтгэл нь давамгайлалч бүлгийн сонирхолд нийцсэн байдлаар зохион байгуулагддаг боловч ижил сонирхол бүхий захиргааны институцүүд шийтгэлийг хэрэгжүүлдэг гэжээ. Энэ утгаар хуулийн хэрэгжилт нь эрх мэдэлтэй хүмүүсийн ашиг сонирхол ба дүрэм журмыг хэрэгжүүлэхийн тулд байгуулагдсан захиргааны байгууллагын ашиг сонирхлын хослол болно. Тиймээс эрүүгийн хуулийг шударгаар ялгаварлалгүй хэрэгжүүлэх гэдгээс илүү хуулийн тогтолцоог бүрдүүлж буй байгууллагуудад илүүдэл дарамт ирүүлэхгүй хэсэгт төвлөрдөг байна. Ийм тогтолцоо нь байгууллагын дарамтыг хамгийн бага байлгах үүднээс улс төрийн хувьд хүчтэй хүмүүсийн асуудлыг авч үзэхээс зайлсхийж, улс төрийн хувьд сул, эрх мэдэлгүй хүмүүсийн асуудлыг авч (*Chambliss and Seidman 1971*) үздэг. АНУ-ын цагдаагийн жишээн дээр Чамблес, Сийдман (1971:391) нар захиргааны байгууллагын хувьд 'нэгжлэг хийх хөрөнгө хураан авах, баривчилгаа хийх, мэдүүлэг авахдаа тэд хууль бус үйлдэл хийж, зохих журмын (*due process*) дагуу хэрэгжүүлэх хэм хэмжээг зөрчиж ... харгислал үйлдсэн' баримтыг ил болгожээ. Гэхдээ энэ нь цагдаагийн албан хаагчид угаас муу, авлигажсан байдгаас болоогүй. Харин дагаж мөрдөх зохих дүрэм журамд ач холбогдол өгөхгүй байх, үйл ажиллагааны асар их эрх чөлөөтэй байх, дур зоргоороо авлигажсан үйлдэл гаргасан цагдаад байгууллагуудаас тавих хяналт сул байхаас болдог байна. Энэ аргачлал нь капиталист тогтолцоон дахь эрүүгийн

хэрэгт тооцох явдлыг тайлбарлахад анхаарсан боловч үүнийг коммунист болон хэмжээгүй эрхт хаант засагт ч хэрэглэж болно.

Сэжигтэн баривчлагдсаны дараа өөрөө, эсхүл өмгөөлөгч нь прокурортой ял тохиролцох чадвар болон хүч чадалтай байх нь чухал боловч ял тохиролцох чадвар нь хэрэгтэн улс төр, эдийн засгийн хувьд хэр зэрэг эрх мэдэлтэй вэ гэдгээс хамаарна (*энэ санааг онцолсон VII бүлгийг үз*) гэж Чамблес, Сийдман (1971) нар бас үзжээ. Түүн дээр нэмээд тэд хууль хэрэгжүүлэгчид нь үнэндээ ‘мэргэжлийн гэмт хэрэгтэн’-ий өгөх нууц мэдээлэлд үндэслэн ажлаа хялбарчилдаг учраас тэд хуулийг хэрэгжүүлэхийн оронд хэрэгтнүүдтэй хамтран ажиллах хандлагатай болдог гэжээ. Чамблес, Сийдман (1971: 489) нар энэхүү харилцан ашигтай харилцааг ‘зохион байгуулалттай гэмт хэрэг өргөн тархсан байгаагийн хамгийн чухал онцлог ... бол тэдгээр нь хууль хүчний тогтолцоотой хамтран ажиллахгүйгээр оршин тогтнох боломжгүйд байдаг’ гэж дүгнэсэн байна. Чамблес шийтгэлийн тухайд (1969) эрүүгийн шүүн таслах тогтолцоо нь гэмт үйлдлээ зогсоож магадгүй ихэнх цагаан захт гэмт хэрэгтнүүдэд хүнд шийтгэл онооход чиглэхийн оронд мансууруулах бодист донтсон эсхүл алуурчин зэрэг гэмт үйлдлээ зогсоохгүй хүмүүст ноцтой шийтгэл хүлээлгэх, онооход чиглэдэг гэдгийг тайлбарлажээ. Энэ нь эрх мэдэлтнүүдийг шийтгэхийг оролдох үед үүсэх байгууллагын дарамтаас зугтахын зэрэгцээ, эрх мэдэлгүй хүмүүст хатуу хандах байдлаар эрүүгийн таслан шийтгэх тогтолцооны үр дүнг шүүдэг захиргааны логикт нийцэж байна.

Гэхдээ 1970-аад оны дунд гэхэд нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал ахин өөрчлөгдсөн учир тэдний энэ үзэл улс төрийн хувьд ач холбогдолгүй болжээ. Энэхүү өөрчлөлт (*Chambliss 1975*) болон эрүүгийн хуулийн агуулга ба хэрэгжилтийн хувьд үйлдэл нь эрх баригч ангийн эрх ашигт тустай нөхцөлд эрүүгийн гэж тодорхойлогдох болжээ. Эрх баригч анги нь хуулийг шийтгэл хүлээхгүйгээр зөрчиж

чадах ба хууль нь эрх мэдэлгүйчүүдийг хянахын тулд хүрээгээ тэлнэ. Гэмт хэрэг нэмэгдвэл ажилчдын илүүдэл буурах үр дүнг авчирна. Учир нь гэмт хэрэгтнүүд нэмэгдвэл ихэвчлэн төрд ажилладаг цагдаа, нийгмийн хамгааллын ажилтан, тэнсэх ялд хяналт тавигчид, гэмт хэрэг судлаачдын хэрэгцээ нэмэгдэнэ. Түүнээс гадна гэмт хэрэг нь доод давхрааны анхаарлыг мөлжлөгөөс сарниулж, ижил давхрааны бусад гишүүд рүү хандуулах учир 'гэмт хэрэг бол нийгэмд гэмт хэрэг оршин байснаар ашиг сонирхол нь хангагдаж буй хүмүүсийн үүггэсэн зүйл' (*Chambliss 1975:152–153*) аж.

Күинни (*Quinney 1969*) ч бас хэрэгжилт дээрх хуулийг авч үзжээ. Тэр эхлээд зөрчилдөөний социологид анхаарлаа хандуулсан байна. Гэхдээ тэрээр өөрийн байр сууриа эргэн харж өөрчилсөөр байсан болохоор гэмт хэрэг ба капитализмын талаарх түүний бодит үзэл юу байсныг хэлэхэд хэцүү болсон байна. Тэр нийгэм нь Дарендорфынхтой (*Dahrendorf 1958*) төстэй ашиг сонирхол дээр суурилдаг ба хууль нь хүчтэй эрх мэдлийг тусгадаг гэж үзжээ. 1970-аад оны эхэнд тэрээр '... гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй байна гэсэн албан ёсны дүгнэлтэд үндэслэн ... үйлдэл ба хувь хүнд хууль зүйн статусыг нийгэм дэх эрх мэдэлтэй бусад хүн өгдөг' (*Quinney 1970:6–7*) гэдэг агуулгаар гэмт хэрэг нь харьцангуй зүйл юм гэж үзэж байв. Мөн тэрээр зөрчилдөөний талаарх өмнөх үзлээ давтан 'нийгмийн өөрчлөлт нь нарийн төвөгтэй, ялгаатай, хоорондоо өрсөлдсөн хэм хэмжээг бий болгосон учир зөрчилдөөн зайлшгүй' гэж итгэж байжээ. Түүний Түрк, Чамблес нараас ялгарах тал нь шинжлэх ухаан бол бодит байдлын хуулбар учир позитивист буюу харж болох шалтгааныг эрэх хэрэгтэй гэж үзсэн явдал юм. Дэлхий ертөнц бол сэтгэхүйн бүтээгдэхүүн гэж үзэх Европын философийн идеализмд түшиглэн тэр 'хүний оноосон ойлголтоос өөр бодит байдал гэж байхгүй': 'бодит байдал бол оюун санааны зүйл' (*Quinney 1970, in Lilly et al. 1989:166*) бөгөөд ямар ч зүйлийн бодитой оршихуйд итгэх шалтгаан

байхгүй гэж үздэг байжээ. Үйлдэл/зан үйлийн тогтсон тодорхойлолтыг шүүмжлэн яагаад хүмүүсийн дунд хамтын ойлголт боловсруулагдаж, хадгалагддаг болоход түүний бүх анхаарал нь татагдсан байв. Ялангуяа тэрээр дээр дурдсан ашиг сонирхол, эрүүгийн хуулийн хэрэгжилт ба зохион байгуулах үйл ажиллагааны хэлбэрийг тодорхойлох эрх мэдэлтэй хүн, хэргийн харагдах байдал, хэргийг мэдээлэх тогтолцоо, мэргэжлийн байгууллага, эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх эрх мэдлийг төлөөлөн авсан хуулийн хамтын нэгдлийн үзэл суртал ба үйл ажиллагааны талаарх хамтын ойлголтод анхаарчээ. 1974 оны үед Күинни үзэл бодлоо ахин сольж, энэ удаад Марксын үзэлд илүү ойртжээ.

Гэхдээ эдгээр бүх тайлбарын түлхүүр бүрэлдэхүүн хэсгүүд нь түвшингээрээ ялгаатай:

1. Америкийн мужууд капиталист эдийн засагт суурилна,
2. Давамгайллагч ангийн эдийн засгийн ашиг сонирхолд үйлчлэхээр муж зохион байгуулагдана,
3. Эрүүгийн хууль нь эрх баригч анги тухайн үеийн нийгэм, эдийн засгийн эмх журмыг хадгалах хэрэгсэл болно,
4. Капиталист мужид ангийн ашиг сонирхлыг төлөөлсөн Засгийн газрын элитүүдийн байгуулж, удирддаг институцүүдээр дамжуулан гэмт хэргийг хянадаг бөгөөд доод ангийг хянахын тулд хуулийн тогтолцоог ашиглана,
5. Капиталист мужийг нурааж социалист зарчимд үндэслэсэн мужаар сольж байж л сая гэмт хэргийн асуудал шийдэгдэнэ (*Quinney 1974; Lilly et al. 1989*).

Күинни өөрийн онолоо ахин өөрчилж элитүүд болон ард иргэдийн хооронд сөргөлдөөн байна гэж үздэг ямар ч онол капитализмын хүчийг бүрэн ойлгох хангалттай ойлголт

өгч чадахгүй гэжээ. Тэрээр улс төрийн элит анги хувийн үр ашгийн төлөө капитализмыг хянадаг гэж үздэг инструментал Марксизмаас эдийн засгийн тогтолцооны улмаас аяндаа улс төрийн үр дагавар гарна гэж үздэг бүтцийн Марксизм руу шилжсэн байна. Энэ нь гэмт хэргийн ангиллаас хамгийн тодорхой харагдана. Тэр гэмт хэргийг дарангуйллын гэмт хэрэг ба орон байрны болон төрийг эсэргүүцэх гэмт хэрэг гэж ангилжээ. Дарангуйллын гэмт хэрэг нь хяналтын гэмт хэрэг (*цагдаагийн хүчирхийлэл зэрэг*), эдийн засгийн дарангуйллын гэмт хэрэг (*цагаан захтны гэмт хэрэг ба зохион байгуулалттай гэмт хэрэг*), төрийн гэмт хэргийг (*Уотэргэйт²⁴ хэргээр төсөөлөгддөг*) агуулна. Орон байрны болон төрийн эсрэг гэмт хэрэг нь капитализмын нөхцөл байдлаас үүдэлтэй хулгай зэрэг шунахайн гэмт хэрэг, хүн алах зэрэг хувь хүний гэмт хэрэг ба тухайн үеийн төртэй улс төрийн тэмцэл хийхтэй холбоотой терроризм зэрэг төрийг эсэргүүцэх гэмт хэргийг (*Quinney 1977*) агуулна.

Английн жишээн дээр тэр зөрчилдөөнийг радикал криминологиор тайлбарласан байна. Радикал криминологи нь криминологийг дэлгэрэнгүй шүүмжилж, гэмт хэргийн нийгмийн байгууламжийн талаарх шинэлэг онолын төлөв байдлыг бий болгохыг оролдсон урсгал юм. Тэйлор нар (*1973*) криминологи нь ажилчин ангийн гэмт хэргийг бий болгодог нийгмийн нөхцөл байдалд анхаарах хандлагатай болсон боловч цагаан захтны гэмт хэрэгт бага анхаардаг болчихлоо хэмээж байв. Михаловски (*Michalowski 1981*) радикал криминологи нь аргачлал, криминологийг дүн шинжилгээний нэгж болгож байгаа байдлаараа болон төрийн хуулийн шүүмжээрээ төр

24 АНУ-ын Ерөнхийлөгч Никсоны засаг захиргаа Үндэсний Ардчилсан намын хорооны байранд тагнах хэрэгсэл байрлуулах, бичиг баримтыг нь хулгайлах ажилд оролцсон болох нь илэрсний дараа нуун далдлахыг оролдсон, улмаар огцорсон дуулиант хэрэг. (Орч.)

болон зөрчилдөөнийг шүүмжлэх бусад шүүмжээс ялгаатай гэж *(нэр шошго зүүх талаар IX бүлгээс үз)* тэмдэглэсэн.

Ийм үзэл бодол байсан ч радикал дүн шинжилгээ нь нийгмийн тусгаарлалт, харьцангуй доройтол ба цагдаагийн ардчилсан бус хэв маягт анхаарлаа хандуулсан бодитой дүн шинжилгээ болсон юм. 1970-аад оны сүүл, 1980-аад онд хувь хүнд анхаарах болж өөрчлөгдсөнөөр, ялангуяа АНУ, Их Британи зэрэг барууны орнуудад хувь хүнд төвлөрч, төрийг хэрэгтэн, эсхүл гэмт хэргийн шалтгаан гэж харахаа больсноор энэ онол нь ерөнхийдөө академик дасгал болжээ. Радикал криминологи хүчирхэг өв үлдээсэн ч Яангийн *(Young 1988:164)* тэмдэглэснээр ‘хүч алддаггүй криминологи’ буюу их сургууль, коллежид зааж буй криминологид уг онолын нөлөө нь суурилдаг байна.

Зөрчилдөөний онолын хязгаарлагдмал тал

Өргөн цар хүрээтэй аливаа тайлбарын адилаар зөрчилдөөний талаарх эдгээр тайлбар ч ялгаагүй хязгаарлагдмал талтай. Энэ бүлэг дэх тайлбарууд нь хэрэгтнүүдийн зан үйлд бус эрүүгийн хэрэгт тооцох үйл явц ба эрх мэдэлтнүүдийн зан үйлд анхаарсан байдаг. Гэхдээ эдгээр тайлбарт хэрэгтнүүд хэрэг үйлдсэн талаар дурдсан ч тэдний үйлдлийг үүнийг мөлжлөгийн эсрэг рационал хариу үйлдэл ба ‘бодол санаа’-гаа илэрхийлж, нийгмийн бүтцийг өөрчлөх цор ганц зохистой боломж хэмээн тайлбарладаг. Эдгээр онолын хувьд гэмт хэргийн шалтгаан нь чухал боловч шалтгааныг хувь хүн гэж үзэлгүй эрх мэдэлтнүүд гэмт хэрэгт тооцсоны үр дүн гэж үздэг. Тэд ийм замаар өөрөөсөө анхаарлыг холдуулдаг. Энэ бүгд нь нийгмийн ба эрүүгийн шүүн таслах бодлогод нөлөө багатай байсан боловч судалгаа шинжилгээ, ялангуяа криминологи, социологид нөлөөтэй байжээ.

Капиталист нийгэм дэх боломж хязгаарлагдмал байдал ба ёс суртахуунгүйдлийн улмаас гэмт хэрэг гардаг гэж үздэг учир радикал криминологийг дарамттай төстэй гэж шүүмжилдэг. Гэвч ёс суртахуунгүйдэл нь хэрхэн хэм хэмжээ зөрчих үйлдэлд хүргэдэг, эсхүл яагаад зарим хүмүүс гэмт хэрэгтэн байдаг бол бусад нь ижил төстэй нөхцөл байдалд гэмт хэрэг хийдэггүй вэ гэдэг талаар ихийг хэлдэггүй. Радикал криминологи нь дарангуйлал нь капитализмаас үүсдэг бөгөөд капитализмыг дарангуйллаар тайлбарлаж болно гэж үздэг учраас тойрсон логик гэж шүүмжлэгдэх боломжтой. Рокын (*Rock 1973:103*) шүүмжлэлд радикал криминологи нь 'бүх гэмт хэрэгтнийг энгийн хялбар гэм буруугүйтнүүд бөгөөд ... институцийн эрх мэдэлтэй хийх сайтар тодорхойлогдсон улс төрийн зөрчилдөөнд оролцогч гэж үзсэн уянгын халил' гэжээ. Барк (*Burke 2001*) онолын хувьд радикал криминологи нь гэмт хэрэг, хэм хэмжээнээс гажих үйлдлийг хангалттай тодорхойлоогүй гэж шүүмжилсэн байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг нь нэг бол хэт сэтгэл хөөрсөн үйлдэл, эсхүл зүгээр л хуулийг зөрчсөн үйлдлийн үр дүн гэж үзсэн. Мөн радикал криминологийн хүрсэн цорын ганц амжилт нь уламжлалт криминологийг улстөржүүлсэн явдал гэсэн юм. Гэхдээ дээрх үзлээс үл хамааран зөрчилдөөний талаарх бүх тайлбарын шийдвэрлэх хязгаарлагдмал тал нь тэдгээр нь эрэгтэй хүмүүст анхаарсан явдал бөгөөд Жаггер (*Jagger 1983:78*) үүнийг 'нийгмийн бодит байдлыг төвөгтэй болгож, эмэгтэйчүүдийг дарангуйлах явдлыг хууль ёсны болгодог' ба 'эрэгтэйчүүдийн дарангуйллын өөр нэг үзэл санаа' гэжээ. Эдгээр радикал болон шүүмжлэлт үзэл нь криминологийн судалгаанд чухал хувь нэмэр оруулсан боловч практик хамаарал холбоо болон хэрэглээ нь одоо ч шүүмжлэлд өртөж байдаг. Гэхдээ капитализм дахь төрийн гэмт хэргийг тайлбарлахад эдгээр арга нь хэрэгтэй байдаг.

Ашгийн төлөө: Шилжилтийн капитализм ба авлига

Улс дамнасан гэмт хэрэг, түүний улс орны аюулгүй байдалд учруулах заналын талаар хэлэлцэх нь өнөө үед давамгайлж буй төрийн нео-либерал соёлын нэг хэсэг болж байна. Харин авлигын асуудал нь заримдаа эрх мэдлийн хууль ёсны бүтэц дотор чухал үүрэг гүйцэтгэх байдлаар, үндэстэн дамнасан хууль ёсны бизнестэй холбоотой байдаг бөгөөд соёлын хувьд тодорхойлогддог учраас харьцангуй хязгаарлагдмал түвшний аюул занал үүсгэж (*Rawlinson 2012*) иржээ. Мөн түүнчлэн бүх соёлд ялангуяа бизнест авлига хаа саагүй, зайлшгүй байдаг гэж хүлээн зөвшөөрөх хандлага (*Olimpieva and Panchekov 2008*) байдаг. Энэ нь авлигын үйлдлийг ердийн зүйл болгож, эсхүл эрүүгийн тогтолцоогоор бус иргэний тогтолцоогоор авч үзэхэд хүргэснээр авлигыг тодорхойлох асуудлыг улам хүндрүүлж байна.

Авлигын алдаагүй тодорхойлолт, ангиллыг гаргах нь хэцүү зүйл болох тухай бид 2 дугаар бүлэгт үзсэн боловч авлига бол нийт хүн амд хохиролтой, ялангуяа эмзэг бүлэгт илүү аюул занал учруулдаг зүйл юм. Үүнийг Зөвлөлтийн тогтолцоо нуран унасны дараа авлига ба зохион байгуулалттай гэмт хэрэг устахгүй ч хязгаарлагдана гэж үзэж байсан гэнэн таамгаас харж болно. Гэхдээ энэ таамаг нь зүүн Европ ба Балтын тэнгисийн улсууд коммунизмын гинжнээс мултрахад шок эмчилгээг зөвлөсөн нео-либерал онолтой таарч байсан юм. Энэ таамаглал авлига нь ихэвчлэн төрийн албаны үзэгдэл (*Heywood 2015*) (*холбогдох шүүмжийг II бүлгээс үз*) бөгөөд төрийн эрх мэдлийг бууруулбал төрийн албыг буруугаар ашиглах болон төрийн албан дотор эрх мэдлийг буруугаар ашиглах бололцоог бууруулна гэсэн ойлголтод үндэслэжээ.

Зөвлөлтийн коммунизм чөлөөт зах зээл ба ардчиллыг (*хүмүүс ихэвчлэн эдгээр нь хамт явдаг гэж буруу боддог*)

нэвтрүүлэхдээ гэмт хэргийг дэмжсэн (*Rawlinson 2012*) гэх үзэл баруунд давамгайлдаг. Коммунизмын үлдэгдэл алга болохын хэрээр яваандаа хуулийн засаглал болон эрүүл эдийн засгийн зан үйл дагалдан гарах болно гэж үзэж байв. Энэ үндэслэл нь хувийн эзэмшил нь өмчлөх эрхийг үр дүнтэй баталгаажуулах хуулийг боловсруулж, хэрэгжүүлэх явдлыг дэмжинэ гэдэг санаанд үндэслэдэг. Гэхдээ хурдацтай орчин үежилт нь шилжилт хийх явдлын оронд дасан зохицох явдлыг бий болгов. Сохроор шинэчлэл хийж байсан үед засаг захиргааныхан зүүн Европын ихэнх хэсэгт хувийн салбарыг эзэмших (*Bezlov and Gounev 2012*) болжээ. Төр нь хүн амынхаа хууль зүйн аюулгүй байдлыг хангаж чадахгүй болоод ирэхээр зохион байгуулалттай гэмт хэрэг өргөжин (*Volkov 2002*) дэвжив. Төрийн энэ байдал нь зохион байгуулалттай гэмт хэрэг болон засаг захиргааныхан гэмт хэргийн бизнес үйл ажиллагаа явуулж зах зээл нь бараа, үйлчилгээнд нээлттэй болохын хэрээр дэлхий даяарх бизнесүүдтэй өрсөлдөн капитал, ур чадварыг олж авах боломж олгожээ. Оросын нийгэмд тодорхой харагддаг улс төр зах зээлжих (*marketization*) энэ үйл явц нь номенклатур буюу намаас сонгогдсон эрх мэдэлтнүүдийн давхаргад ашигтай байсан ба тэд зарим талаар дасан зохицож, зарим талаар өөрчлөгдөн шинэ элитүүд (*Goldman 2003; Rawlinson 2012*) болсон аж. Тэд чөлөөт бизнест шаардлагатай ур чадваруудад бас суралцжээ.

Оросын шок эмчилгээний жилүүдийн онцлог болсон хуульгүй цаг үед сүүдрийн эдийн засагт хөгжсөн бизнес эрхлэх ур чадвар нь чөлөөт зах зээл ба бизнесийн соёлыг хөгжүүлэх гол нуруу (*Rawlinson 2012*) болжээ. Эдийн засгийн энэ шинэ нөхцөл байдалд далд эдийн засагт оролцогчдын сувдаг шунал болон түүнийг нь дэмжих улс төрийн авлигажсан харилцаа холбоо нь капиталист эдийн засаг руу шилжих шилжилтийг манлайлахад туйлын тохиромжтой байр сууринд байв. Тиймээс олон улсын бизнесүүд хуучин дэглэмтэй төсөөтэй бүхэнд итгэхгүй гэдэг байдлаар эдгээр бүлэглэлүүдтэй харилцжээ. Ялангуяа барууны

бизнесүүд зах зээлийн эмчлэх хүчинд сохроор итгэсэн бөгөөд тэр нь өөрөө, одоо Оросын зарим хэсэгт буй ‘дээрэмчин төрийн капитализм’-д (*gangster state-capitalism*) хувь нэмэр оруулах хүчин зүйл болсон юм. Хурдацтай хувьчлал ба үнэ чөлөөлөх үйл явц нь эд баялаг хуримтлуулах ур чадваргүй эсхүл тийм хүсэлгүй хүмүүсийг хажуу тийш түлхэн гаргав. Энэхүү хурдацтай шилжилтийг эсэргүүцсэн хэн бүхнийг олон улс болон дотоодод коммунист үзэлтэн эсхүл капитализмыг эсэргүүцэгч хэмээн хочилж, зүхэн буруушааж байв .

Нэр шошго зүүх хүч эсхүл ‘ондоошуулах’ хүч нь магадгүй ардчилсан улсаас илүү дарангуйлагч улс болон шилжилтийн улсад илэрхий байдаг. Үүнийг Орос дахь авлига болоод түүний зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбогдох холбоосууд дэлгэрэнгүй харуулдаг. Авлига болон зохион байгуулалттай гэмт хэргийг (*Finckenauer and Waring 1998; Holmes 2006; Wright 2005; Rawlinson 2012*) юу гэж тодорхойлох вэ гэдэг тал дээр өөр соёлтой улс орнуудын дотор болон тэдний хооронд нарийн төвөгтэй утгазүйн асуудал (*II бүлгийг үз*) байдаг. Ялангуяа соёлын ба үзэл суртлын ялгаа бүхий нөхцөлд харьцуулан харахад ийм байдал тод харагдана. Утга зүйн энэ хоёрдмол байдал нь Орос дахь улс төрийн авлигажсан эрх мэдэлтнүүдийг хүчирхэг дуу хоолойтой болгож, үзэл суртлын тайлбар хийх боломж олгодог. Ихэнх хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь уг тайлбарыг дэвэргэж, дэмжин зохиомол эсхүл хэтрүүлсэн аюулыг сурталчлан бодит байдал ба туршлагаар нотлогдсон баримтыг ч хүнд харагдахааргүй болгодог (*Rawlinson 2012*) аж.

Нам жим, тайван амьдралын эсрэг эдгээр зохиомол, хэтрүүлсэн аюул занал нь хувь хүн ба байгууллагыг болзошгүй аюул гэж, улмаар ёс суртахуунгүй, эх оронч биш гэх мэтийн нэр шошго зүүхэд тусалдаг. Гэмт хэрэгт тооцох үйл явдлын гол тодорхойлогч нь улс төрийн боломж хайх соёл, түүнчлэн биет болон соёлын, нийгмийн, улс төрийн эрх мэдэлтэй ойр байх, тэдгээрийг хянаж байх явдлын үр дүн байдаг бөгөөд тийм

байсаар байна. Улс орны нийтлэг соёлтой холбоотой хүмүүсийг дарангуйлахын зэрэгцээ өгүүлэмжээ нотолж хамгаалангаа, дамжуулах хэрэгсэлтэй ойр байх, түүнийг хянах нь мөн гэмт хэрэгт тооцох явдлыг тодорхойлно. Түүнээс гадна зохион байгуулалттай гэмт хэрэг нь ардчилал ба капитализмын суурь болсон үзэл суртлыг дэмждэг үнэт зүйлстэй харшилдаг бөгөөд ёс суртахууны хувьд тэдгээрийн үндэс болсон иргэнших үйл явцаас ёс суртахууны хувьд ялгаатай зүйл гэж тайлбарлагдана. Оросын зохион байгуулалттай гэмт хэрэг ба түүний өөрийн болон бусад улсын хуулийн байгууллагад учруулах аюул занал, ялангуяа 1990-ээд оны үеийн аюул занал (*Sterling 1994; Freeh 1994*) нь Оросын талаарх яриа хэлэлцүүлгийн хүрээг тогтоох болжээ. Орос дахь зохион байгуулалттай гэмт хэргийн аюул занал нь бодитой оршин буйн зэрэгцээ, төрийн эрх мэдлийн сүүдэр нь болдог тул тэнд оршин буй капитализмын одоогийн хувилбарын сул хамтрагч болно.

Нийгэм, эдийн засгийн хямрал тулаад ирэхэд төрийн албан хаагчид ялангуяа хууль хэрэгжүүлэх байгууллагын албан хаагчид ажилгүй болох эрсдэлтэй болдог бөгөөд шинэчлэлийн арга хэмжээ нь тэдэнд болон өөрчлөгдөн буй нийгмийн бүтэц дэх бусад эмзэг албан тушаалын хүмүүст аюул учруулж байдаг. Зохион байгуулалттай гэмт хэрэг болон авлига хоорондын шууд холбоо нь нийгэмд хортой нөлөө учруулж, ялангуяа хамгийн эмзэг бүлгийнхэнд ийм нөлөө үзүүлдэг байна. Төрөөс үзүүлж буй халамжаас маш багаар хүртдэг, эсхүл хүртэж чаддаггүй хүмүүс, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд нь мөлжлөг, хүний наймаа, хууль бус үрчлэлт гэсэн олон улсын капитализмд түгээмэл үзэгдэлд өртөхөд ойрхон байдаг. Капитализм дахь хямд хөдөлмөр, улмаар бүтээгдэхүүн, секс, садар самууны хэрэгцээ нь хүний зовлон дээр тогтсон худалдааг өргөжүүлсээр (*Rawlinson 2012:17-171*) байна.

Нийгмийн харилцааны тавааржилт нь капитализмын нэг хэсэг бөгөөд МакКүллоу (*McCullough 2007*) хохирол,

хүчирхийлэл, ашиг нь нео-либерал дэг журмын нэг хэсэг юм хэмээн тэмдэглэжээ. Тэгэхээр Барууны улсууд бол асуудлын нэг хэсэг болохоос шийдэл болохгүй. Барууныхан Оросын авлигыг буруушаадаг ч тэдэнтэй хууль ёсны эсхүл хууль бус бизнес хийхдээ дуртай байдгийг Siemens корпорацийн жишээ (*Rawlinson 2012*) үзүүлнэ. Гэхдээ тэдгээр хүмүүс нь нийгмийн нэг л хэсэг бөгөөд нео-либерализмтай зөрчилдөж буй бус, ашгийн төлөө хөөцөлдөхдөө хууль ёсны болон хууль бус үйлдлийн зааг нь алга болчихоод буй тийм хүмүүс юм.

Ашгийн төлөө: Улс орныг эзлэн түрэмгийлэх

Улс орнууд өөрийн эзэмшлийн нөөц, газар, геополитикийн хүч чадлаа тэлэх, тэдгээрийг шинээр олж авахаар дотоодод болон гадагшаа чиглэн зөрчилдөж байдаг нь капитализмын суурь чанар юм. Үүнийг улс орныг эзлэн түрэмгийлэх явдал бүрэн харуулна. Түүнээс гадна улс орныг эзлэн түрэмгийлэх нь төрийн гэмт хэргийн талаарх онолын тогтолцоонд хамаарах боловч төр улс нь дотоодын хүн амын хяналтаас гарч ардчилсан зарчим, дарангуйлагдсан хүмүүсийг чөлөөлөх нэрийн дор бусад улсын дэд бүтцийг булаах явдлыг заана (*Brooks et al. 2013*). Тухайн бүсэд энх тайван тогтоохыг оролдож нөгөө улсын төр дахь хувийн дотоод хүчирхэг ашиг сонирхолтой хамтран, нэг улс нөгөөгөө өөрийн цэргийн хүчээ ашиглан эзлээд тухайн улсын нийгэм, эдийн засгийн дэд бүтцийг ажиллуулахын тулд хувийн гэрээлэгчдийг хөлсөлдөг. Тэдний гэрээ нь эмзэг улсыг эзлэн авсан улсын компаниудад ихэвчлэн очдог бөгөөд ингэснээр нийгэм, улс төр, соёлын түүх нь ялгаатай нэг улс илүү хүчирхэг улс, түүний худалдааны эрх ашгийн хавсарга болдог. Иракийг эзлэн түрэмгийлж, газрын тосны цооногийг эзэлсэн нь үүний жишээ болно.

Төрийн гэмт хэрэг гэдэг нь төр газар нутгийн хувьд хянаж буй өөрийн иргэдийн эсрэг, эсхүл зарим тохиолдолд эзлэн түрэмгийлэх болон колоничлох замаар бусад улсын иргэдийн эсрэг хийх хөнөөлт зан үйл гэж (*Barak 1991, 1993; Chambliss 1989*) тодорхойлогддог. Гэхдээ хөнөөлт зан үйлийн энэ тодорхойлолт нь цагаан захтны гэмт хэргийн бүх л судалгаанд байдаг суурь сөргөлдөөнт талыг буюу байгууллага болон түүний хэрэгцээгээр өдөөгдсөн хувь хүний үйлдэл үйлдлийн ялгааг агуулж байна гэж Каузларич, Крамер (*Kauzlarich and Kramer 1998*) нар тайлбарлажээ. Оронд нь байгууллагыг хөдөлшгүй тогтсон ёс суртахуунтай зүйл бус тодорхой нөхцөл байдалд ажиллаж буй нийгмийн тоглогч гэж харсан нь дээр.

Гэхдээ төрийн гэмт хэрэг гэдэг ойлголтыг тодруулахын тулд төр өөрийн ашиг сонирхлын үүднээс өөрөө үйлдсэн гэмт хэрэг болон төр элитүүдийнхээ ашиг сонирхлын үүднээс үйлдсэн гэмт хэрэг хоёрыг ялгах шаардлагатай. Месснер, Розэнфелд (*Messner and Rosenfeld 2000*) нар, Квинни (*Quinney 1975*), Спитзер (*Spitzer 1980*) нар улс төрийн үйл явц дахь бодлогод үзүүлэх элитүүдийн нөлөөг авч үзээд төрийн гэмт хэрэг нь плюралист ардчилсан улсад ч хувийн секторын дотоод ашиг сонирхлыг тусгадаг гэжээ. Төр нь 'гэмт хэргийн дамжуулах хоолой' болж, капиталыг хуримтлуулах, эсхүл эрүүл мэнд болон аюулгүй байдлын хуулийг сулруулах, хүлээн зөвшөөрөгдөх байдлаа нэмэгдүүлэхийн тулд хувь хүмүүсийн аюулгүй байдал дээр (*Slapper and Tombs 1999*) буулт хийдэг болох нь хүлээн зөвшөөрөгдөх болжээ. Төр нь өөрийн эрх ашгийг хамгаалсан улс төрийн институт бол элитүүд нь төрийн эрх мэдлийг ашиглан өөрийн ашиг сонирхлоо ахиулахад анхаардаг. Ийм онолын аргачлал нь нийгмийн анги, тэгш бус байдлыг гэмт хэрэг үүсгэгч хүч гэж үздэг. Төрийн гэмт хэрэг гарах үед нийгмийн нөөц ба түлхүүр институцүүдийг хэт хянасан байдалтай (*Tittle 1995*) байдаг. Энэ хяналт нь иргэний байгууллагууд багатай, бүх

үйлчилгээгээ хяналтдаа байлгадаг улсад хамаагүй илүү хялбар байх болно.

Ардчилсан улсад төр нь элитүүдийн нөлөөгүйгээр өөрийн ашиг сонирхлын төлөө ажиллаж, нөлөөгөө болон хүлээн зөвшөөрөгдөх байдлаа өсгөж, хадгалах үйлдэл гаргах боломжтой. Улс төрийн институциудыг хянах, эсхүл түүнд нөлөөлөх хүчийг тогтмол, хөдөлшгүй зүйл бус хувирамтгай зүйл гэж харах нь зүйтэй бөгөөд харин эдгээр үйлдэл нь гэмт хэрэг гэсэн цогц ойлголтод багтах үйлдэл юм. Төрийн гэмт хэргийн цогцод үйлдэхүй ба эс үйлдэхүйн аль аль нь багтана. Үйлдэхүй нь төрийн гэмт хэргийн идэвхтэй, зорилготой, ухамсартай үйлдэл бол эс үйлдэхүй нь төр нөхцөл байдлыг үл тоох, эсхүл үл тоомсорлох явдал юм. Үйлдэхүй нь идэвхтэй шийдвэр гаргалт, ухамсартай, зорилготой зан үйлийг заах бол эс үйлдэхүй нь үйлдэл хийхгүй байх, эсхүл ‘зохих ёсоор’ үйлдэл хийхгүй байхыг (*Kramer and Michalowski 1990, Aulette and Michalowski 1993; Friedrichs 1996*) хэлдэг.

Крамер, Михаловски (*Kramer and Michalowski 1990*) нар төр-эхлүүлсэн ба төр-дэмждэг гэсэн хоёр төрлийн төрийн корпорацийн гэмт хэргийн төрлийг тодорхойлжээ. Эхнийх нь төрийн ажиллуулж буй байгууллагууд нь төрийн хүсэлтээр, эсхүл төрөөс дуугүй хүлээн зөвшөөрснөөр хэм хэмжээнээс гажих (*deviance*) үйлдэл хийхийг хэлнэ. Төр-дэмждэг гэмт хэрэг нь ‘бизнес ба төр шууд сүлбэлдсэн, эсхүл тэд хүчтэй зохицуулалт хийвэл түүнд нь саад болох нэг ижил зорилгод тууштай’ байдгийн улмаас ‘зохицуулах институц’-үүд гэмт хэргийн үйлдлийг хязгаарлаж чадаагүй үед гардаг (*Kramer and Michalowski 1990:6*) бөгөөд ихэнхдээ үйлдэхүйн бус эс үйлдэхүйн хэрэг байдаг.

Эдгээр эрдэмтдийн бүтээлээс Каузларич нар (*Kauzlarich et al. 2003*) дөрвөн цэг бүхий шулуунаар дүрсэлсэн цогц ойлголтыг боловсруулжээ. Шулуун дээрх эхний цэг нь төрийн материаллаг

зорилго, эсхүл элит идеологийн сонирхлыг хангахыг оролдсон нээлттэй, зорилготой үйлдлийг төлөөлөх үйлдэхүйг заана. Төрийн хамгийн ноцтой гэмт хэргүүд шулууны энэ хэсэгт бөөгнөрнө. Эдгээр гэмт хэрэг нь хүний эрхийн зөрчил болон улс төрийн тэрс үзэлтнийг дарамтлах зэргээр хамгийн харагдахуйц байх хандлагатай байдаг. Шулуун дээрх хоёр дахь цэг нь төр нь нийгэмд хөнөөлтэй үйлдлийг чимээгүй дэмжих далд үйлдэхүйг заана. Гэвч энэ хамаарал нь төр нь голлох байгууллагаараа дамжуулах бус хувийн байгууллага, эсхүл дотоодын юм уу олон улсын байгууллага, жижиг төрийн байгууллагаар дамжуулан санаатайгаар нийгэмд хор учруулах зэргээр илрэх бөгөөд энэ нь нийтэд илэрхий бус илүү бүдэг бадаг байна. Шулуун дээрх гурав дахь цэг нь эс үйлдэхүйн илэрхий үйлдлийг заана. Тийм гэмт хэрэг нь төрд нөхцөл байдлыг, орчныг аюулгүй болгох тодорхой үүрэг байсан ч хортой, аюултай нөхцөл байдлыг үл тоох үед гарна. Энэ төрөлд багтах байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын гэмт хэргийн үед капиталын хуримтлал нэрийн дор аюулгүй байдлын тал дээр ихэвчлэн буулт хийдэг. Шулуун дээрх дөрөв дэх цэг нь далд эс үйлдэхүйг заадаг бөгөөд магадгүй хамгийн маргаантай нь юм. Эдгээр нь илүү идеологийн талын зүйл бөгөөд дарангуйлагч төртэй харьцуулахад илүү тодорхой бус зүйлс юм. Ядуурлын нөхцөл байдал, гэр оронгүй хүмүүсийн асуудал, түүнийг дагалдаж гарах зовлон зэрэг нийгмийн асуудлаас урьдчилан сэргийлэх, шийдвэрлэхийн тулд юу ч хийхгүй, эсхүл бараг юу ч хийхгүй байх нь төр өөрөө гэмт хэрэгт оролцож буй хэрэг юм. Учир нь төр холбогдох институцүүд ба оролцогчдыг бусдад шударга бус, хохиролтой хандах боломжийг олгож (*Brooks et al. 2013*) байна.

Энэ онолыг шүүмжлэхэд нээлттэй. Гэхдээ энэ онол нь төрийн гэмт хэрэг нь нэгэн янз, таамаглаж болох зүйл биш, ялангуяа плюралист ардчилсан улсад тийм байдаг гэдгийг харуулж байна. Тиймээс төр улс янз бүр байх бөгөөд янз бүрийн гэмт хэрэг үйлдэж, тоо ба чанарын хувьд ялгаатай нийгэм,

эдийн засгийн нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлнэ. Түүнээс гадна, зарим улс байнга өөрчлөгдөж, төр доторх хүчирхэг ашиг сонирхол нь мөн өөрчлөгдөж байдаг.

Энд авч үзсэн улс дамнасан гэмт хэрэг ба төрийн гэмт хэргийн жишээ нь зохион байгуулалттай гэмт хэрэг болон хууль ёсны бизнес дангаар болон хамтран үйлдэх авлига нь капитализмын нэг хэсэг байдаг бөгөөд нөөц, хүн, газарзүйн хяналт, эсхүл бүс нутгийн төлөөх зөрчилдөөн гэх мэт асуудлыг гарцаагүй дагуулна гэдгийг харуулж байна. Хэдийгээр онолын түвшинд авч үзсэн ч эндээс ижил төрлийн авлигын асуудалд өртөхгүй байх сонголтыг гаргаж чадаагүй байна. Улс орноос хамаарч санхүүгийн, засаг захиргааны эсхүл эзэн хааны эрх мэдлийн ялгаа өөр өөр байж, үргэлж л эрх мэдлийн тэнцвэрт бус байдал болон нөөцийн төлөөх тэмцэл оршин байсаар байх тул авлигын эрсдэл байсаар байх болно.

Дүгнэлт

Энэ бүлэгт зөрчилдөөнийг тайлбарласан онолын аргачлалуудын гол, түлхүүр шинж чанарыг онцлов. Гэхдээ эдгээр нь аливаа нийгэм, улс төрийн тогтолцоонд зөрчилдөөн яагаад гарцаагүй болох тухай жишээ юм. Үүнийг байгууллагууд нь хийсэн ажлаас үл хамааран үргэлжид ашгаа нэмэгдүүлэхийг эрэлхийлж байдаг олон улсын санхүүгийн салбарт харж болно. Тийм нөхцөлд хувь хүн ба байгууллага авлигын үйлдэл гаргах нь тийм ч гайхмаар зүйл биш юм. Энэ нь авлига, эсхүл гэмт хэргийг зөвтгөж буй хэрэг биш бөгөөд хөгжин дэвжихийн тулд биш юмаа гэхэд амьд үлдэхийн тулд, ялангуяа хямралын үед хувь хүн болон байгууллагууд гэмт хэрэг үйлдэнэ гэдгийг хүлээн зөвшөөрч буй хэрэг юм.

Гэхдээ ийм зүйл төрийн түвшинд бас гардаг. Ардчилсан ба шилжилтийн улсад харагддагаар төр *доторх* ба *төрийн* хүчирхэг хувийн дотоод ашиг сонирхол нь тогтсон ашиг

сонирхолд нийцэх гэмт хэргийг үйлдэж болох бөгөөд үйлддэг. Тиймээс төрийн хэлбэр болон бизнестэй холбогдох хамаарлаас үл хамааран ховор нөөцийн (*хүнс, хувцас, гэр орон*) төлөөх өрсөлдөөн нь хувь хүн, байгууллага, улс орнуудын хооронд зөрчилдөөнд хүргэнэ. Хамгийн бага нөөц оногдсон нь нөөцийн хуваарилалтын хууль ёсны байдлыг шүүмжилнэ. Санхүүгийн, газар зүйн хяналт, зах зээл дээрх бүтээгдэхүүнийг монополчлох зэрэг зөрчилдөөнөөс хамаарч тийм зөрчилдөөн нь эрх мэдэл, хяналт тавих байр суурийг олж авах эсхүл хадгалахын тулд залилан, хууль ёсны болон хууль бус авлигын гэмт хэрэг, хүчирхийллийн заналхийлэл, улмаар төрийн хүчирхийлэлд хүргэнэ. Гэхдээ зөрчилдөөн түр зуур намжиж болох ч орчин үеийн ертөнц дэх хүмүүсийн харилцаанд зайлшгүй суусан байдаг тул энэ хяналт нь одоо ч үргэлжилж буй тэмцэл юм.

Ашигласан материал

- Aulette, J., & Michalowski, R. (1993). Fire in the hamlet: A case study of state-сздорporate crime. In K. Tunnell (Ed.), *Political crime in contemporary America: A critical approach*. New York: Garland Press.
- Barak, G. (1991). Toward a criminology of state criminality. In G. Barak (Ed.), *Crimes by the capitalist state: An introduction to state criminality*. New York: State University of New York Press.
- Barak, G. (1993). Crime, criminality and human rights: Toward an understanding of state criminality. In K. Turnell (Ed.), *Political crime in contemporary America: A critical approach*. New York: Garland Press.
- Bezlov, T., & Gounev, P. (2012). Bulgaria: Corruption and organised crime in flux. In P. Gounev & V. Ruggiero (Eds.), *Corruption and organised crime in Europe: Illegal partnerships*. Abingdon: Routledge.

Авлигын криминологи

- Bonger, W. (1916). *Criminality and economic conditions*. Bloomington: Indiana University Press.
- Brooks, G., Walsh, D., Lewis, C., & Kim, H. (2013). *The prevention of corruption: Investigation, enforcement and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Burke, R. (2001). *An introduction to criminological theory*. Devon: Willan Publishing.
- Chambliss, W. (1969). *Crime and the Legal Process*. New York: McGraw-Hill.
- Chambliss, W. (1975). Toward a political theory of crime. *Theory and Crime*, 2, 152–153.
- Chambliss, W. (1989). State organized crime. *Criminology*, 27 (2), 183–208.
- Chambliss, W., & Seidman, R. T. (1971). *Law, order and power*. Reading, MA: Addison-Wesley.
- Dahrendorf, R. (1958). *Class and class conflict in industrial society*. Stanford, CA: Stanford University Press.
- Finckenauer, J. O., & Waring, E. J. (1998). *Russian mafia in America: Immigration, culture and crime*. Boston: Northeastern University Press.
- Freeh, L. (1994). *Statement before the Permanent Subcommittee on Investigations. United States Senate Governmental Affairs Committee*. Washington, DC: United States Senate Governmental Affairs Committee.
- Friedrichs, D. O. (1996). Governmental crime, Hitler and white collar crime: A problematic relationship. *Caribbean Journal of Criminology and Social Psychology*, 1 (2), 44–63.
- Goldman, M. (2003). *The privatisation of Russia: Russian reform goes awry*. New York: Routledge.

- Heywood, P. M. (2015). *Routledge handbook of political corruption*. Abingdon: Routledge.
- Hirschi, T. (1969). *Causes of delinquency*. Berkeley, CA: University of California Press.
- Holmes, L. (2006). *Rotten states: Corruption, post-communism and neo-liberalism*. Durham, NC: Duke University Press.
- Jagger, A. (1983). *Feminist politics and human nature*. Totawa, NJ: Rowman and Littlefield.
- Kauzlarich, D., & Kramer, R. (1998). *Crimes of the American nuclear state: At home and abroad*. Boston: Northeastern University Press.
- Kauzlarich, D., Mullins, C., & Matthews, R. (2003). A complicity continuum of state crime. *Contemporary Justice Review*, 6 (3), 241–254.
- Kramer, R. C., & Michalowski, R. J. (1990, November). Toward an integrated theory of state-corporate crime. Paper presented at American Society of Criminology Meeting, Baltimore, MD.
- Lilly, R. J., Cullen, F. T., & Ball, R. A. (1989). *Criminological theory: Context and consequences*. Thousand Oaks, CA: Sage Publications.
- McCullough, J. (2007). Transnational crime as productive fiction. *Social Justice*, 34 (2), 19–32.
- Messner, S. F., & Rosenfeld, R. (2000). Market dominance, crime, and social dynamics of crime and control. In S. Karstedt & K.-D. Bussman (Eds.), *Transition in social dynamics of crime and control: New theories for a World in transition*. Portland, OR: Hart Publishing.

- Michalowski, R. J. (1981). Conflict, radical, and critical approaches to criminology. In Barak-Glatz & C. R. Huff (Eds.), *The mad, the bad and the different*. Lexington, MA: Lexington Books.
- Olimpieva, I., & Panchekov, O. (2008). Who fights Corruption in Russia? In R. W. Ortung & A. Latta (Eds.), *Russia's Battle with crime, corruption and terrorism*. London: Routledge.
- Quinney, R. (1969). *Criminal justice in American society*. Boston: Little Brown.
- Quinney, R. (1970). *The Social Reality of Crime*. Boston: Little Brown.
- Quinney, R. (1974). *Critique of Legal Order: Crime Control in Capitalist Society*. Boston: Little Brown.
- Quinney, R. (1975). *Criminology: Analysis and critique of crime in America*. Boston: Little Brown.
- Quinney, R. (1977). *Class, state, and crime: On the theory and practice of criminal justice*. New York: David McKay.
- Rawlinson, P. (2012). Corruption, organised crime and the free market in Russia. In P. Gounev & V. Ruggiero (Eds.), *Corruption and organised crime in Europe*. Abingdon: Routledge.
- Rock, P. (1973). *Phenomenalism and essentialism in the sociology of deviancy*. *Sociology*, 7(1), 17–29.
- Sellin, T. (1938). *Culture, conflict and crime*. New York: Social Sciences Research Council.
- Sellin, T. (1939). *Social conflict and conduct norms*. New York: Social Science Research Council.
- Slapper, G., & Tombs, S. (1999). *Corporate crime*. Essex: Pearson.
- Spitzer, S. (1980). 'Left-Wing' Criminology – an Infantile Disorder? In J. Inciardi *Radical Criminology: The Coming Crises* pp. 169–90. Beverley Hills, Calif: Sage.

- Sterling, C. (1994). *Crime without frontiers: The worldwide expansion of organized crime and the Pax Mafiosa*. London: Little Brown.
- Sutherland, E. H. (1939). *Principles of criminology* (3rd ed.). Philadelphia, PA: Lippincott.
- Sutherland, E. H. (1949). *White collar crime*. New York: Dryden Press.
- Sykes, G. M. (1974). The rise of critical criminology. *Journal of Criminal Law and Criminology*, 65 (2), 206–213.
- Taylor, I., Walton, P., & Young, J. (1973). *The new criminology: For a social theory of deviance*. London: Routledge and Kegan Paul.
- Tittle, C. R. (1995). *Control balance: Toward a general theory of deviance*. Boulder, CO: Westview press.
- Turk, A. T. (1969). *Criminality and legal order*. Chicago: Rand McNally.
- Vold, G. B. (1958). *Theoretical criminology*. New York: Oxford University Press.
- Volkov, V. (2002). *Violent entrepreneurs: The use of force in making Russian capitalism*. Ithaca, NY: Cornell University Press.
- Wright, A. (2005). *Organised crime*. Cullumpton: Willan.
- Young, J. (1988). Radical criminology in Britain: The emergence of a competing paradigm. *British Journal of Criminology*, 28 (2), 159.

IX

Авлигыг тайлбарлах нь: Байгууллага, институц, хувь хүмүүст авлигажсан гэх нэр шошго зүүх эрх мэдэл

Удиртгал

Бидний ихэнх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд эрүүгийн шүүн таслах тогтолцоо шаардлагатай зүйл хэмээн хардаг бөгөөд уг тогтолцоо нь шийтгэл хүлээлгэн гэмт хэрэг хийхээс цээрлүүлэх, эргэн нийгэмшүүлэх, эрх хасах замаар гэмт хэргийг бууруулдаг ч гэж бас үздэг. Нэр шошго зүүх онолыг (*labelling theory*) барьдаг хүмүүс дээрх тайлбарыг тууштай шүүмжилдэг ба эрүүгийн шүүн таслах тогтолцоо нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн оронд хүмүүст гэмт хэрэгтэн гэх нэр шошго зүүдгээрээ асуудлын нэг хэсэг гэж үздэг. Нэр шошго зүүх явдал нь хууль бус үйлдлийг хязгаарлах бус хүмүүсийг ‘гэмт хэргийн карьер’-тай холбогдоход хүргэдэг. Эрүүгийн шүүн таслах ажиллагаа ба төрийн оролцооны тогтолцоо нь гэмт хэрэг ихээр үүсгэдэг гэж тооцогддог. Гэмт хэрэгт үзүүлэх ‘нийгмийн хариу үйлдэл’ гэж нэрлэгддэг онол нь 1960 болон 1970-аад оны эхэнд Бекер (*Becker 1963*), Эриксон (*Erikson 1966*) ба Китсүсэ (*Kitsuse 1964*) нарын бүтээлээр нийтэд дэлгэрсэн ба гэмт

хэргийн нийгмийн байгуулал (social construction), гэмт хэрэг гэж юу вэ, энэ нь нийгмийн хариу үйлдэлтэй хэрхэн холбогддог вэ гэдгийг авч үздэг.

Гэмт хэргийн нийгмийн байгуулал

Нэр шошго зүүх онолоос өмнө ‘гэмт хэрэг’-ийг капитализмын бүтээгдэхүүн буюу нөхцөл гэж үзэхээс бусад үед ихэвчлэн шууд хүлээн зөвшөөрдөг, шүүмжилдэггүй байв. Гэмт хэргийн тодорхойлолт нь эрүүгийн тогтолцоонд оролцогчдод гэмт хэргийн шалтгаан нь юу болох, тэр талаар ямар арга хэмжээ авах, шалтгааныг нь хэрэгтнүүдээс, эсхүл тэднийг байгаа орчноос олж харахад төвлөрөх боломжийг олгодог байлаа. Энэ нь бид юу гэмт хэрэг вэ, мөн юу гэмт хэрэг биш вэ гэдэг нийгмээс байгуулагддаг үзэгдэл нь түүхийн хувьд өөрчлөгддөг бөгөөд улс дотор болон улс хооронд ялгаатай байдаг гэдгийг ойлгоход саад болж (*Lilly et al. 1989*) байв. Энэхүү гүнзгий ойлголтуудыг эрдэмтэд аль зан үйл нь гэмт хэрэг вэ, яагаад зарим нь тийм гэж нэрлэгддэг болох, энэ нь нэр шошго эсхүл ‘ондоочлол’-ын үр дүн үү гэх мэтийг тодорхойлдог нийгмийн нөхцөл байдлыг таньж мэдэж чадаагүй байв.

Энэ эндүүрлийг засахын тулд Бекер (*1963*) ба Эриксон (*Erickson 1966*) нар үйлдлийг гэмт хэрэг болгодог зүйл нь заавал ч үгүй түүний учруулах хохирол биш төрөөс уг үйлдэлд оноосон нэр шошго гэсэн онолыг дэвшүүлжээ. Тиймээс тухайн үйлдлийн шинж байдал бус нийгмийн хариу үйлдэл ба түүний байгуулах бодит байдлын шинж байдал нь гэмт хэрэг мөн эсэхийг тодорхойлдог байна. Үүнийг Фоол (*Pfohl 1985*) хүн амины хэргээр жишээ татан дэлгэрэнгүй үзүүлжээ. Янз бүрийн хэлбэрийн аллага байдаг ба үйлдэл нь ялгагдахгүй боловч нийгмийн хариу үйлдэл нь ялгаатай байдаг аж. Жишээлбэл, цагдаагийн офицерыг алах, эсхүл цагдаагийн офицер хүн алах, согтуу жолооч хүн дайрч алах, эсхүл бохирдлоос үүдэлтэй хорт хавдраас болж удаан хугацаанд зовж үхэхийг нэр шошго

зүүх эрх бүхий хүмүүс ялгаатайгаар танилцуулж, нэр шошго зүүдэг. Тэдгээр хүмүүс мөн энэ нэр шошгоо хэвлэл мэдээллийн хэрэгслээр албан ёсны эсхүл ердийн яриа хэлцэл рүү нэвтрүүлдэг. Аль аль нь л хүн алах үйлдэл мөн боловч заримыг нь гэмт хэрэг гэдэг ч бусдыг нь хүлээн зөвшөөрч, зөвтгөж, эсхүл бохирдлын жишээн дээр зүгээр л эдийн засгийн хөгжилд зайлшгүй байх байгаль орчны эрсдэл гэж тайлбарладаг байна. Юу гэмт хэрэг болох вэ гэдгийн хэлбэр ба агуулга нь нийгмийн орчин, нөхцөл, хувийн дотоод ашиг сонирхлоос хамаарна. Түүнээс гадна Түрк (*Turk 1969*) үйлдэлд бус хувь хүнд эрүүгийн статус оноох төрийн байгууллагын чадварыг онцолжээ. Түүний онолоор үйлдэл нь бодит, төсөөлөгдсөн, хуурамчаар хийгдсэн эсэхээс хамаарахгүй *юу хийсэн бэ* гэдэгт бус *хэн хийсэн бэ* гэдгийг онцолдог аж. Энд тэр төрийн байгууллага гэдэгт эрх мэдэл нь түүний субъект болж буй хүмүүсээр хүлээн зөвшөөрөгдсөн байдаг хууль ёсны эрх мэдэлтэй байгууллагыг авч үзжээ.

Төр юуг гэмт хэрэгт тооцох нь тогтсон зүйл бус хүмүүс ялгаатай бодит байдлыг байгуулахыг оролдох буюу тодорхой зан үйлийг албан ёсоор хэрхэн тодорхойлсон байгааг өөрчлөхийг оролдсоны үр дүн байдаг. Түүнчлэн үйлдлийн хор хохирлын цар хүрээ нь гэмт хэрэгт тооцохыг тодорхойлдоггүй. Бусад онолын аргачлалын хувьд хувь хүн хориглогдсон, хууль бус үйлдэлд оролцож, яллагдсанаар хэрэгтэн гэсэн нэр шошго зүүдэг гэж үздэг. Гэхдээ тэдгээр онолд нийгмийн хариу үйлдэл нь нийгмээр байгуулагдаж, өөрчлөгддөг зүйл бус харин асуудалгүй бөгөөд тааж болох зүйл хэмээн таамаглаж байна гэсэн үг. Энэ нь эцэстээ төр, түүний оролцоо нь гэмт хэргээс хамгаалах бамбай юм уу, урьдчилан сэргийлэх тогтолцоо бус гэмт хэргийн шалтгаан гэж харахад хүргэжээ. Үүнийг магадгүй 1960, 1970-аад онд бол ойлгож болох зүйл юм. Ялангуяа АНУ-д төрийг манлайлагч, ядуурал гэмт хэргийг шийдвэрлэхэд голлох, чухал үүрэг гүйцэтгэдэг хэмээн хардаг байснаа удалгүй авлигажсан ба арьс өнгөний үзлийг шийдвэрлэх хүсэлгүй төр

гэж харах болсон нь Иргэний эрхийн хөдөлгөөн, Вьетнам дахь дайн, Уотэргэйт хэрэг дуулиан, оюутны жагсаалын эсрэг цагдаа нар хүч хэрэглэсэн жишээнээс харагдах болов. Ийм үед бол үүнийг ойлгож болохоор зүйл (*Lilly et al. 1989*) юм. Тийм болохоор төр нь хүлээн зөвшөөрөгдөх байдлын түр зуурын хямралыг тэсвэрлэхээс аргагүй байлаа. Хүмүүсийг гэмт хэрэгтэн гэж харах нь болиулах гээд буй зан үйлээ сэргээн бий болгох, санаандгүй үр дагаврыг бий болгосон учир хувь хүн эсхүл тэдний амьдарч буй гадаад орчноос илүү нийгмийн хариу үйлдэл нь хамгаас илүү чухал байв.

Энэ үзэл нь олон жилийн өмнө гарсан бөгөөд одоо ч байсаар байна. Жереми Бэнтам (*1748–1832*) хүмүүсийг шоронд хийснээр гэмт хэргийг өсгөж байна гэж, Цезаре Ломброзо (*Cesare Lombroso 1835–1909*) шоронгийн амьдрал муутгах нөлөөтэй, шийдсэн гэмт хэрэгтнүүдтэй харилцсанаар криминалойд буюу гэмт хэргийн шинж чанараа нуун далдлагчдыг үүсгэдэг гэж үзсэн ба Бонгер (*Bonger 1969*) хөнгөн гэмт хэрэг үйлдсэн залуу хүмүүсийг хорих нь мэргэжлийн гэмт хэрэгтнүүдийг бий болгоно гэжээ. Гэхдээ энэ нь ингээд шулуухан тайлбарлахчиг энгийн асуудал биш юм. Лемерт (*Lemert 1951*) ‘гэмт хэрэгтэн’ гэх нэр шошгод үзүүлэх хариу үйлдлийг тайлбарлахдаа хэм хэмжээнээс гажих анхдагч ба хоёрдогч гэсэн хоёр төрлийг ялган хэрэглэжээ. Анхдагч гажуудал гэж хэрэгтэн зан үйлээ түр зуурын хазайлт гэж тайлбарлан зөвтгөх (*VI бүлгээс гулсах тухай ойлголтыг үз*) эсхүл нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх дүр төрхийн (*энэ нь цагаан захтны гэмт хэрэгтэй холбоотой бөгөөд авлигыг хүлээн зөвшөөрдөг эсхүл үйлдлийг нь авлига гэж хардаггүй орчин нөхцөлтэй хамааралтай*) нэг хэсэг хэмээн харахыг хэлнэ. Хоёрдогч гажуудал гэж нийгмийн хариу үйлдэл хүчтэй болж хэрэгтэн буруутгагдах үеийг хэлнэ. Бусдын хариу үйлдэл нь хэрэгтний амьдралд шийдвэрлэхгүй бол болохгүй тэргүүлэх асуудал болохын хэрээр эхний дур зоргын үйлдэл нь ач холбогдлоо алдана. Тийм учраас хэрэгтэн энэ

статусыг хүлээн зөвшөөрч, амьдралаа зохион байгуулж эхлэх ба гэмт хэргийн амьдрал руу гулсан орж эхэлнэ.

Энэ санааг санал болгогчид гэмт хэрэг үйлдэгчдэд ямар нэг арга хэмжээ авах, эсхүл шийтгэх хүлээлгэх ёсгүй гэж үзэж буй хэрэг биш, харин зүүгдсэн нэр шошго нь хэрэгтний зан үйлийн талаарх нийгмийн дүгнэлт болоод зогсохгүй энэ нь тухайн хүний ёс суртахууны шинж чанарыг олон нийтийн өмнө муутгаж, дордуулж харагдуулдаг хэмээн (*Garfinkel 1956*) хэлдэг. Энэ санаа Мүррэй (*Murray 1990*), Вилсон, Херрнштайн (*Wilson and Herrnstein 1985*) нарын бүтээлд бас (*Х бүлгийг үз*) давтагддаг. Гэмт хэргийн үйлдэл болон зан үйлийг зөвхөн ёс суртахуунгүй гэж харж буй хэрэг бус хүнийг ч тэгж хардаг ба ёс суртахууны луужингүй хүн гэмт хэргийг дахин давтан хийнэ гэж хүмүүс үздэг. Тиймээс хэрэгтний талаарх таамаглал нь бидний үзүүлэх хариу үйлдлийг хэлбэржүүлдэг ба энэ нь ‘өөрийгөө биелүүлэх зөгнөл’ буюу тухайн хүмүүс гэмт үйлдэл хийхээс аргагүй байдалд хүргэж байж болзошгүй юм. ‘Өөрийгөө биелүүлэх зөгнөл’ нь эргэлзээтэй ч гэмт хэрэг нь түүнийг тодорхойлох эрх бүхий хүмүүсээр тодорхойлогддог гэсэн энэ онол нь гудамжны гэмт хэргийг цагаан захтнуудын гэмт хэргээс өөрөөр нэр шошго зүүх хандлагатай байдаг учраас чухал ач холбогдолтой онол (*Braithwaite 1989; Katz 2002*) юм.

Хэрэгтний нэрийг олон нийтэд зарлах, ичээх нь зарим хүний ирээдүйд үйлдэж болох гэмт хэргийг таслан зогсоож болох боловч бусдын хувьд гэмт хэрэгтэн хэмээх сэжиг төрүүлэх (**байнгын сэжиг**) бөгөөд түүнийг дагалдах нийгмийн буруутгал нь тэднийг гэмт хэргийн зам руу улам (*Braithwaite 1989; Katz 2002*) түлхэнэ. Хүн өөрийгөө хэн гэж бодож явдаг вэ гэдэг нь тухайн хүний талаарх олон нийтийн тодорхойлолт, түүнийг дотооддоо оруулж ирснээр тодорхойлогдон, явцын дунд өөрчлөгддөг. Ийм байдлаар хүмүүс өөрсдийгөө гэмт хэрэгтэн гэж тодорхойлдог болно. Энэ нь нийгэмд хэрэгтэй харилцаанаас гарснаар улам дордож, нийгмийн эсрэг үнэт

зүйлсийг хүчирхэгжүүлэх гэмт хэргийн дэд соёлыг үүсгэхэд хүргэдэг. Ялангуяа төрийн оролцоо ба гэмт хэрэгтэн гэсэн албан ёсны нэр шошго зүүгдсэн үед нийгэмд хэрэгтэй харилцаа нурах явдал улам ноцтой болно. Нэр шошго зүүх бүхий л процесс нь эрүүгийн шүүн таслах тогтолцооны ирмэг дээр байгаа хүмүүсийг гэмт хэргийн амьдрал руу түлхэх хүчирхэг (*Jones 2006*) нөлөөтэй.

Энэ тайлбарыг зөвхөн онолын тайлбар гэж шүүмжилдэг ч (*доорхыг хар*) хүмүүсийг эрүүгийн шүүн таслах тогтолцоо руу оруулж ирэх нь гэмт хэрэгт хувь нэмэр оруулдаг гэдэг утгаар бодлогод зарим талаар нөлөөтэй (*Morris and Hawkins 1970; Scull 1984; Lilly et al. 1989:131; Schiller 2000; Hopkin and Rodriguez-Pose 2007*) байжээ. Залуу хэрэгтнүүдийг чиглэл өөрчлөх бодлогод²⁵ хамруулах асуудал нь ялангуяа барууны зарим улсын хувьд нийгэм ба улс төрийн нөхцөл байдлаас хамаарч, эрүүгийн шүүн таслах тогтолцоонд олон давтагдаж буй сэдэв болоод байна. Шоронд хорих шийтгэлийн зардал нь ёс суртахууны асуудал бус улс төрийн асуудал болсонтой холбоотойгоор хэрэгтнүүдийг хамтын нэгдлийн хөтөлбөрт хамруулах, тэнсэн харгалзах, нарийн хяналтад байлгах, электрон ажиглалтын багажтай хяналтад байлгах асуудал дэлгэрч байна.

Гэвч асуудал нь (*Cohen 1985-д дэлгэрэнгүй авч үзсэн*) эдгээр чиглэл өөрчлөх хөтөлбөрийн олонх нь нэмэгдэл ял болсон бөгөөд эрүүгийн шүүн таслах тогтолцооны хүрээг багасгах бус нэмэгдүүлсэнд оршино. Зохих ёсны процесс ба хууль зүйн хамгаалалт нь нэр шошго зүүх онолын тайлбарыг гаргасан хүмүүсийн анхаарлыг татжээ. Тэд ял шийтгэл буурах, эрүүгийн шүүн таслах тогтолцооны оролцоо хязгаарлагдмал болно гэж

25 Policy of diversion буюу хэрэгтнийг албан ёсны шүүн таслах тогтолцоогоор оруулахаас зайлсхийх янз бүрийн арга хэрэгслийн нэр. Энэ нь албан ба албан бус хэлбэртэй байж болно. Жишээлбэл, гэр бүлийн хөнгөн хүчирхийлэл үйлдсэн хүнийг уураа удирдах хөтөлбөрт суусан тохиолдолд хэргийг хаах гэх мэт тогтолцоо үүнд хамаарна. (Орч.)

итгэж (*Emprey 1982*) байв. 1960, 1970-аад оны гэмт хэрэг давтан үйлдэх үзэгдлийг шинжлээд шоронд хийх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлж чадахгүй гэж үзэх болсноор институцээс гаргах²⁶ ойлголт нь дэмжлэг авч (*Skull 1984*) эхэлжээ. Гэхдээ энэ цаг үеэс хойш барууны ардчилсан улсад, ялангуяа Их Британи, АНУ-д гэмт хэрэгтэн нь рационал, тооцоотой хүн байдаг гэж үзэх үзэл дэлгэрсэн ч энэ хэрээр хорих ялын хэрэглээ ихээр өөрчлөгдсөн боловч энэ үзлийг цагаан захтны гэмт хэрэг үйлдэгчдийн хувьд ховорхон хэрэглэж иржээ.

Нэр шошго зүүх онолын хязгаарлагдмал тал

Онолын энэ аргачлал нь гэмт хэргийг тайлбарлах янз бүрийн, өрсөлдөгч аргачлалуудын зүгээс ихээхэн шүүмжлэл хүртжээ. Уг онолыг баримтлагчид улс төрийн ашиг сонирхол ба нийгмийн сул тал нь нийгмийн хариу үйлдэлд нөлөөлдгийг ойлгосон боловч нэр шошго зүүх талаар эрүүгийн шүүн таслах тогтолцоо болон цаана нь буй эдийн засгийн эмх журам хоорон дахь тодорхой хамаарлыг тогтоогоогүй гэж Тэйлор нар шүүмжилж (*Taylor et al. 1973*) байв. Тийм учраас уг аргачлал эрх мэдлийн бүтэц ба институц нь гэмт хэргийг тодорхойлох арга замыг судлахад хүрэлгүй зогссон гэжээ. Түүнчлэн туршилтын үндэслэл багатай буюу уг онолын гол бүрэлдэхүүн хэсгүүд нь туршилтаар шалгагдаж тогтоогдоогүй гэсэн шүүмжлэл ч (*Hirschi 1975; Gove 1980*) бий. Гэхдээ гэмт хэргийн хүнд хөнгөнийг тооцоод үзсэн ч залуу хүмүүст хэв журам сахиулах үедээ цагдаа нар чинээлэг газартай харьцуулахад ядуу, хар арьст хүмүүс олноор амьдардаг газраас илүү их баривчилгаа хийдгийг зарим судалгаа харуулжээ. Энэ бол цагдаагийн ‘бодлого’-ын асуудал мөн нөөц дутагдалтай байгаатай холбоотой зүйл

26 De-institutionalization буюу сэтгэл мэдрэлийн өвчтэй хүмүүсийг тусгаарладаг институцээс нь гаргаж гэр бүлд нь эсхүл нийгэмд нь буцаахыг заасан нэр томъёог хоригдлуудын жишээн дээр хэрэглэсэн ойлголт. (Орч.)

боловч, хэв журам сахиулах ажил залууст янз бүрээр хэрэгжиж байгааг харуулж байна.

Мөн уг онолд үйлдсэн үйлдлийн шинж чанарын талаар бодитой ойлголт байхгүй байна. Жишээлбэл, гэмт хэрэг нь хэрэгслийн (*instrumental*), сэтгэл хөдлөлийн (*expressive*), ганцаарчилсан эсхүл бүлэглэсэн байсан уу. Түүнээс гадна нийгмийн хариу үйлдэл ямар хэлбэртэй байсан бэ. Жишээлбэл, ноцтой, албан бус, эсхүл албан ёсны байсан уу. Магадгүй бүр илүү чухал асуулт бол үйлдлийн талаар давсалж, хэтрүүлж ярьсан уу гэдэг асуулт юм. Хэрэгтний гэмт зан үйл нь ноцтой байдлын хувьд өссөн үү эсхүл чиглэлээ өөрчилсөн үү, эсхүл хэрэгтэн зүгээр л гэмт хэрэг хийхээ болсон уу гэдэг талаар тодорхой ойлголт (*Holdaway 1988*) байдаггүй. Төрийн оролцоо нь гэмт хэргийг үүсгэж байгаа эсэхийг нотлох боломжгүй юм. Олон хэрэгтэн нь эрүүгийн шүүн таслах тогтолцооны анхааралд өртөхөөс өмнө аль хэдийн гэмт хэрэгт гүн орооцолдсон байдаг. Хүмүүс яагаад гэмт хэрэг үйлддэгийг тайлбарлаж буй мэт харагддаг нэр шошго зүүх явдал нь өөрөө хуулийн шийтгэл бус харин нийгмийн нөхцөл байдал нь хэрэгтэнд нөлөөлж байдаг. Гэхдээ гэмт хэрэгт үзүүлэх нийгмийн хариу үйлдэл нь нарийн төвөгтэй үйл явц бөгөөд түүний үр дүнг бүрэн ойлгож, эсхүл таньж мэдээгүй байгаа гэдгийг анхаарах хэрэгтэй. Нэр шошго зүүх болон 'үнэн'-г гуйвуулах эрх мэдэл байх боломжтой гэдгийг доорх жишээ харуулна.

Нэр шошго зүүх эрх мэдэл: Цагдаа ба Хилсбороу

Нэр шошго зүүх ба хувь хүн, байгууллага, эсхүл төрийг дураараа, авлигажсан гэж тодорхойлж, хохирогч бус хэрэгтэн гэж дүрслэх эрх мэдэл нь ардчилсан ба ардчилсан бус улсын аль алинд нь байдаг. Ардчилсан улс дахь нэр шошго зүүх эрх мэдлийг харуулсан жишээнд 1989 онд Английн Хилсбороу

хөл бөмбөгийн цэнгэлдэх хүрээлэнд гарч, 96 хүн нас барж, ойролцоогоор 766 хүн (*Scraton 1999*) шархадсан осолд Цагдаагийн байгууллага болон бусад ашиг сонирхлууд холбоотой байсан тохиолдол багтана. Эцэст нь 2016 оны сонсголоор амиа алдсан 96 дэмжигчийг хууль бусаар алагдсан хэмээн дүгнэсэн байна. Энэ нь олон жилийн өмнөх үйл явдал боловч нэр шошго зүүх ба ‘үнэн’-ийг гуйвуулж, дахин бий болгох дотоод хувийн ашиг сонирхлын орчин үеийн жишээ болж байна.

Хилсбороу дахь ослын ‘үнэн’ ба ‘шударга ёс’-ыг олохыг хичээсэн хангалттай их, сэтгэл хөдөлгөсөн илтгэл (*Scraton 1999, 2000, 2004*) байдаг учир энд тэдгээрийг давтахын оронд энэхүү гамшгийн хохирогчдыг муучилж, үл тоох болон ‘үнэн’-ийг бий болгох эрх мэдэл, түүний хэрэглээнд анхаарал хандуулья. Авлигын олон хэрэг дээрх шиг үнэн гэдэг бол оньсого шиг ойлголт бөгөөд хэргийг тодорхойлох, илрүүлэх, батлах нь шулуухан мэт санагдах ч угаас нарийн төвөгтэй оюуны, улс төрийн, хуулийн үйл явцтай холбоотой ойлголт юм. Цаг хугацааны аль нэг үед, тодорхой нөхцөл байдалд ‘яг юу болсон бэ’ гэдгийг яг нарийвчлан, агуулгаар тогтоох нь нарийн төвөгтэй бус байх тохиолдол (*Scraton 1999*) ховор. Ардчилсан улсын үндэс болж буй хууль зүйн процесс ба шударга ёсны засаглал нь бид үйл явдлыг эргэн санах чадвартаа суурилан хувь хүний үнэнийг жигнэж, дэнслэх ба үйл ажиллагаа нь юу болсон бэ гэдгийг шинжлэн үзэхтэй зохицсон байх учиртай. Зарчмын хувьд ядаж л тэдгээр нь үнэнийг бий болгох бус нэгтгэн дүгнэдэг тогтолцоог санал болгох ёстой. Бид эрүүгийн ба иргэний мөрдлөг, албан ба албан бус сонсгол, шүүх ба трибуналуудыг нотолгоонд үндэслэсэн гэж хардаг. Гэхдээ эдгээр албан ёсны байгууллагууд нь капитализм, эцгийн эрхт ёс, нео-колонизмын хэсэг болсон бүтэцчилэгдсэн тэгш бус байдлыг ахин давтдаг. Эдгээр тэгш бус байдал нь зохиосон зүйл бус бодитой, улс орон ба түүний доторх иргэний нийгмийн эд ширхгийн хэсэг болсон зүйл юм. Ийм бүтэцчилэгдсэн тэгш бус байдал нь анхаарлыг ихэвчлэн үйл

явдлын талаарх үнэн, орчин нөхцөлийг тодорхойлох эрх мэдэл, хүч чадлаас холдуулдаг аж. Хэдийгээр эрх мэдэл нь үйлдвэрлэл, дахин үйлдвэрлэлийн материаллаг нөхцөлөөс урган гардаг боловч төр, институц, хөндлөнгийн оролцоонд бодитой болон гарч ирдэг. Энэ тохиолдолд төр нь үнэнийг тогтоохын тулд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг ашиглана. Фүкогийн (*Foucault 1980:131*) бичсэнээр ‘нийгэм болгон өөрийн гэсэн үнэний дэглэмтэй ... хүлээн авах мэдээллийн төрөл ... ялгах боломж олгодог механизм ба тохиолдол ... үнэнийг олж авахад үнэ цэнэ өгөх техник ба процедуртай байдаг’ гэсэн. Бекерийн (*1967*) хувьд зүгээр л эрх мэдэлтэй хүмүүс үнэнийг тодорхойлдог бөгөөд үнэний талаарх мэдлэг болон үзэл бодлоо сонсгох эрх нь тэгш бус хуваарилагдсан байдаг аж. институцийн эрх мэдэл нь эзэмшигчдээ үйлдэлд ‘хэм хэмжээнээс гажсан’ болон ‘гэмт хэргийн’ гэх нэр шошго зүүх бололцоо олгодог ба ‘үнэний’ тэдгээр хувилбар нь хамгийн их итгэл хүлээдэг. Ялангуяа хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нэг талыг барьсан сэтгүүл зүйн улмаас хамгийн их итгэл хүлээдэг (*William 2014*) байна.

Хилсбороу дахь гамшгийн талаарх давамгайлсан үзэл бодол бөгөөд дээр дурдсан маягийн үйл явцыг шүүмжлэх ажиллагаа аль хэдийнэ 26 жил үргэлжилчихээд байгаа хэдий ч түүнийг нь үгүйсгэх яриа алхам бүрт (*Scruton 1999*) гардаг. Үгүйсгэх яриа янз бүрийн хэлбэртэй байж болно. Үүнд албан ёсоор үгүйсгэх ‘сонгодог’ хэлбэр, шүүмжлэгчдийн эсрэг хамгаалах байр суурь танилцуулах (*яллагчдыг яллах гэж мөн хэлдэг, VI бүлгээс саармагжуулах арга хэрэгслийг үз*) хэлбэр, ялгаатай үзэл бодлыг хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх (*Cohen 1996*) хэлбэр багтана. Эдгээр үгүйсгэл дунд янз бүрийн байр суурь байдаг. Жишээлбэл, ‘сонгодог’ ярианы үед шууд үгүйсгэх (*юу ч болоогүй*), тайлбарын үгүйсгэл (*болсон зүйл бол үнэндээ өөр зүйл*), шууд бусаар үгүйсгэх (*болсон зүйлийг зөвтгөх*) хандлага болно. Эдгээр үгүйсгэл болон үнэнийг гуйвуулах үйлдэл нь үргэлж хувь хүн ба байгууллагын авлигын талаар ярих зүйлийн

нэг хэсэг байдаг бөгөөд харамсалтай нь ихэвчлэн албан ёсны яриа хэлцлээр дэмжигдэж эсхүл бизнес бол ‘зөв’ зүйл хэмээн идэвхгүйгээр хүлээн авах байдлаар (*авлигажсан байгууллагын тохиролцооны талаар VIII бүлгээс үз*) дэмжигддэг.

Ардчилсан улсад нүцгэн эрх мэдэл (*naked power*) буюу ямарваа холбогдох ашиг сонирхолгүй эрх мэдэл нь ‘үнэн’-ий талаар, эсхүл үнэнийг тодорхойлох талаар монополигүй байдаг учир ихэвчлэн шүүмжлэгддэг. Ялангуяа харилцаа холбоо өөрчлөгдсөнөөр тийм болсон байна. Хилсбороугийн гамшгийн шударга ёсыг тогтоохыг эрмэлзэгчид болон авлигажсан байгууллагуудаас нөхөн төлбөр авахыг эрмэлзэгч бүлэглэлд тулгарсан асуудал, тэнцвэргүй байдал нь хууль, хэв журмыг төлөөлөгчдийн ‘хуулийн үг хэллэг’ -ээр хүчирхэгжсэн хэт өндөр статустай холбоотой (*Cohen 1996*) байдаг. Төр, хууль хэрэгжүүлэгчид, ба авлигажсан байгууллагууд нь нарийн төвөгтэй ‘эрх зүйн хамгаалалт’ хийх, үнэнийг бүдгэрүүлэхэд өөрийн процесс, үйл ажиллагаагаа дайчилдаг.

Хилсбороуд болсон үйл явдалд цагдаа нар эхнээс нь хохирогчдыг буруутгах, цоожтой хаалгыг эвдэлснээс үүссэн нуралт болон түүнийг дагалдан гарсан үхлийн хариуцлагыг хөгжөөн дэмжигчдэд тохохыг оролдсон боловч сүүлдээ хаалгыг цагдаа нар өөрсдөө онгойлгосон болох нь илэрхий болжээ. Үйл явдал илэрхий болсны дараа цагдаа нар нуралтын бурууг согтуу, хүч хэрэглэсэн, тасалбаргүй хулигаанууд руу чихсэн байна. Энэ өнцөг нь олон жилийн турш ихээхэн нөлөөтэй яригдаж ирсэн бөгөөд зарим хийрхсэн Английн сонинууд энэ санааг үнэнчээр давтан (*Williams 2014*) мэдээлжээ. Тухайн үедээ Английн хөл бөмбөгт нөлөөтэй байсан хохирогчдыг хулигаанууд хэмээн тодорхойлсон нь үнэнийг тодорхойлох, чиглүүлэх, бүтээх, үгүйсгэх талаасаа нэр шошго зүүх эрх мэдлийг харуулж (*Hopkins and Treadwell 2014*) байна.

Гэхдээ энэ осол гарсан түүх ил болохын хэрээр цагдаагийн байгууллага шүүмжлэлийн зарим хэсгийг хүлээн зөвшөөрч, хариуцлагыг хүлээн авсан ч гамшигт нөлөөлсөн гол үүргээ үл тоон хүлээн зөвшөөрөхөөс татгалзжээ. Улстөрчид, сэтгүүлчдэд хийсэн албан бус мэдээлэл болон офицеруудын санаж буй зүйлүүд мэдүүлгийг өөрчлөн, амьд үлдсэн хүмүүсийн дурсамжийг өөрөөр харах, үгүйсгэхээр тооцоологдсон тактик байв. Мэдүүлэг авах, мөрдөн шалгах процесс *дунд* цагдаагийн байгууллага давуу эрхтэйгээр байр суурь эзэлж байсан учраас энэ нь боломжтой байсан юм. Хөл бөмбөгийн хулигаануудын ‘Мангасууд’ гэсэн нэр шошготой муу нэрийг тэд ашиглажээ. Хэрэг явдлыг согтуурал, эмх замбараагүйтэл, хүчирхийллийн зайлшгүй үр дүн хэмээн сэргээн дурсаж, түүнийг нь ихэнх хэвлэл мэдээлэл болон улстөрчид идэвхтэйгээр дэмжсэнээр хохирогчдод өөрсөддөө гамшиг авчирсан ‘амьтад’ гэсэн нэр шошго зүүв. Бөөгнөрсөн олныг удирдах болон сэргийлэх арга хэмжээ авах үүргийн талаарх гол асуудал нь өөрийгөө гэмтээсэн гэх санааг тойрсон яриа хэлэлцүүлэг болон өргөжиж, ийм хамгаалалтын үр дүнд сэдэв өөр тийш хазайн (*Scraton 1999, 2000; Williams 2014*) саармагжжээ.

Эрүүгийн шүүн таслах тогтолцоо нь ядаж л шударга гэж харагдах ёстойг VIII бүлэгт авч үзсэн. Хэрэв энэ нь албан ёсны болон хэсэгчилсэн үнэнийг бүдгэрүүлэх, эсхүл бүтээх хэрэгсэл болж ашиглагдвал хэргийн талаарх бүх л асуулга нь шударга ёсыг хайх хүсэл бус сэтгэл зовсноо харуулах, эсхүл худлаа өрөвдөхөөс хэтрэхгүй зүйл болно. Энэ жишээ нь хэдийгээр аймшигтай, ялангуяа амьд үлдсэн болон нас барсан хохирогчдыг авч үзсэн, дүгнэсэн байдлаараа аймшигтай ч үүнтэй төстэй байгаль орчныг бохирдуулсан тохиолдолд ч дахин давтагдсан (*1984 онд Энэтхэгийн Бопалд болсон Юнион Карбид ХХК-ын хэрэг, 2010 онд Мексикийн булангийн Дийнвотэр Хорайзон компани газрын тос асгасан хэргийг хар*) юм. Хариуцлагыг хамгийн бага байлгах, үнэнийг бүрхэгдүүлэхээр тооцоолсон

нарийн төвөгтэй хууль зүйн хамгаалалтын процесс, үйл явцын үр дүнд тэнд яг юу болсон тухай үнэн болон байгаль орчинд үзүүлсэн хор нөлөөний аль алиныг үгүйсгэж, эсвэл хэсэгчлэн зөвшөөрсөн ч ач холбогдолгүй болгон, эсхүл хэлэлцүүлгээр саармагжуулан эцэст нь үнэнийг тодорхойгүй болгожээ.

Энэ жишээн дээр бүтэц, процедур, албан ёсны сонголт, асуулга, эрүүгийн ял тулгах болон тэдгээрийн хоорондын хамаарал нь үнэнийг хувь хүн эсхүл нийтийн хувьд хангалтгүй тогтоосон асуудлыг дахин үнэлэх (*Scraton 1999, 2000*) ёстой. Энэхүү гамшигт шууд өртсөн хүмүүс төр нь үйл явдалд нэр шошго зүүх, муучлах, үгүйсгэх гүн суурьтай, бугшсан практикийг шийдвэрлэж чадахгүй байгааг бүрэн хүлээн зөвшөөрөөд үлджээ.

Нэр шошго зүүх эрх мэдэл: Төрийн албыг авлигад буруутгах нь

Ардчилсан ба ардчилсан бус ямар ч улс орон байсан төр нь авлигаас урьдчилсан сэргийлж буй байдлын талаар болон авлигажсан практикт гүн хутгалдаж буй талаар олон жилийн турш байнгын шүүмжлэлд өртөж (*Heywood 2015; Hough 2015*) ирлээ. Энэ шүүмжлэлийн ихэнхийг ОУВС, Дэлхийн банкны судалгаа шинжилгээ болон авлигын талаарх олон нийтийн сонголтын үнэлгээнд үндэслэн гаргадаг. Үнэндээ 1990-ээд онд ОУВС-гийн эдийн засагчид (*Tanzi 1994, 1998, 2000*) авлига нь төр, түүний эдийн засагт гүйцэтгэх үүрэг нэмэгдэхтэй холбоотой зүйл гэсэн аж. Дараа нь авлигыг бууруулахын тулд төр, түүний үүргийг их хэмжээгээр бууруулах ёстой гэдгийг санал болгосон байна. ОУВС мөн авлига нь эдийн засагт төрийн зохицуулалт ба оролцоо хэт их байх үед өргөн дэлгэрдэг гэсэн бол Дэлхийн банк авлигын үйлдэл гаргах бололцоог бууруулахын тулд эдийн засгийн үйлдвэрлэлийг чөлөөлөх хэрэгцээг (*үүнийг үзэл бодол гэж бус хэрэгцээ гэж харсан*) идэвхтэйгээр хүлээн авчээ.

Тэгэхээр улс орноос дээгүүрх эдгээр хүчирхэг байгууллагуудын зүгээс төрийн алба бол асуудлын шийдэл бус авлигын шалтгаан бөгөөд түүнээс урьдчилан сэргийлж, бууруулахад тулгардаг саад хэмээн харж, нэр шошго зүүдэг байна. Өөрөөр хэлбэл ОУВС ба Дэлхийн банкныхнаар бол төрийг хязгаарлаж, хазаарлах хэрэгтэй бөгөөд ил тод байдал болон хариуцлагын соёлыг нэвтрүүлэх хэрэгтэй (*Hough 2015*) аж. Ил тод байдал ба хариуцлага гэсэн энэ сүүлийн хоёр зүйл нь шүүмжлэгддэггүй, шүүмжлэгдсэн ч маш ховор шүүмжлэгддэг байна. Гэвч эрх мэдэлтэй хүмүүс ‘үнэн’-ийг тодорхойлж, үг хэлэх эрх болон үг хэлэх эрх нь тэгш хуваарилагдаагүй байдаг. Институцийн эрх мэдэл нь эзэмшиж буй этгээдэд, энэ тохиолдолд ОУВС ба Дэлхийн банканд, төрийн алба бол авлигын дамжуулах хэрэгсэл гэх санаа агуулсан нэр шошго зүүх бололцоо олгодог.

Төрийн зарим чиг үүргийг хувьчлах, түүний зарим үүргийг хязгаарлах, мөн төрийн үйл ажиллагааг ихэвчлэн хямдаар зарах нь тодорхой идеологийн схемд таардаг боловч эдгээр үзлийг дэмжсэн тоо баримтад эргэлзээтэй асуудал их байдаг. Хопкин, Родригүез-Позэ (*Hopkin and Rodriguez-Pose 2007*) нар өндөр үйлдвэржсэн орнууд буюу ихэнхдээ эдийн засгаа удирдаж, эсхүл эдийн засагтаа оролцож байсан орнууд нь авлигын түвшин багатай байдгийг онцолжээ. Түүнээс гадна ихэвчлэн төрийн албанд зүүдэг үр дүнгүй, авлигажсан гэх нэр шошго нь төөрөгдөлд хүргэдэг. Хамгийн бага авлигажсан улсууд нь (*авлигыг хэмжэдэг гэх байгууллагуудын хэлж байгаагаар—II бүлгийг үз*) төрийн алба, төрийн аппарат нь хамгийн бага байдаг улсууд байдаггүй. Хүмүүс тэгж боддоггүй ч эсрэгээрээ Швед, Финланд, Данид авлига бага байдаг.

Тэгвэл яагаад голлон төрийн албыг авлигажсан гэж хардаг байсан ба зарим газар одоо ч тэгж харсаар байна вэ. Төрийг авлигын шалтгаан, асуудлын нэг хэсэг нь, дамжуулах хэрэгсэл, гол авлигажсан газар, урьдчилан сэргийлэхдээ хязгаарлагдмал, эсхүл маш бүтэл муутай хэмээн хэлдэг байна. Үүний заримыг

засаглал ба түүнийг дагалдан гарах үр дагаврын ойлголтоор тайлбарладаг. Дэлхийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, ОУВС-ын хувьд ил тод байдал, үүнийг иргэний нийгмээс дэмждэг нь засаглалын үр дагавар болдог бөгөөд улмаар оролцоо ба хүний эрхийг дээдлэх явдлыг бий болгоно. Гэхдээ хэрэв эдгээр байгууллагаас тусламж хүсвэл энэ үзэл бодлыг тусгасан шаардлага тавигддаг. Тэд дараа нь тухайн улсад санхүүжилт хэрэгтэй байгаа бол тохиромжтой гэж үзсэн зүйлээ шаарддаг (*Грек нь онцгой тохиолдол боловч зээлдүүлэгчид нь төрийн албыг нь хувьчлахыг шаарддагийг тооцох хэрэгтэй*) байна. Улс орны үнэлгээ нь Дэлхийн банк ба ОУВС-гаас зохистой гэж үзсэн цогц үзүүлэлтүүд болоод тухайн цаг үеийн үзүүлэлтүүдийн утгад үндэслэдэг. Гэхдээ бодит асуудал нь үр нөлөөгүй байдал бөгөөд авлигатай тэмцэх тогтолцоо нь өдөр тутмын амьдралд үзүүлэх авлигын нөлөөг зөөлрүүлэхэд (*суурь шалтгааныг нь устгах бүү хэл*) системтэйгээр тус болсон талаар маш бага баримт (*Hough 2015*) байдаг. Сэмпсоны (*Sampson 2008*) ажигласнаар ‘зуу зуун сая доллар зарж, зуу зуун хөтөлбөр, төсөл, кампанит ажлыг авлигатай тэмцэх мэргэжилтнүүд зохион байгуулсан ч авлигын үйлдэл буурсан тухай баримт бидэнд маш бага байна’. Авлигатай тэмцэх хөдөлгөөнүүд нь мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлэхээс эхлээд (*ихэвчлэн төрийн албанд төвлөрсөн*) бодитой баримттай амжилт руу шилжилт хийж чадахгүй байгаа учир чимээгүй хямрал болж байна. Амжилттай байгаа газарт санамсаргүй тохиолдол ба гадаадын байгууллагуудаас нэвтрүүлэхийг шаардсан авлигатай тэмцэх стратегитай тухайн газрын онцлог нөлөө нь адилхан чухал байгаа харагддаг (*Hough 2015*) гэжээ.

Авлигатай тэмцэх салбар нь янз бүрийн үзэл санаа, үйл ажиллагааны хэлбэртэй, янз бүрийн тоглогчдоос бүрддэгт асуудал оршино. Гэхдээ ялангуяа 1990-ээд онд авлигын талаарх хэлэлцүүлэгт хэдхэн дуу хоолой давамгайлдаг байлаа. Вито,

Танзи нарын зэрэг улс төрийн гол эдийн засагчид тодорхой ач холбогдол бүхий авлигатай тэмцэх стратегийг боловсруулжээ. Энэ нь одоо ч бодит тоо баримттай үндэслэл нь хязгаарлагдмал байсаар байна. Тухайн үед давамгайлж байсан ийм дуу хоолой нь төр ба төрийн байгууллагууд нь асуудлын нэг хэсэг бөгөөд авлигын шалтгаан болдог. Тиймээс авлигаас сэргийлэх чадваргүй, эсхүл хүсэлгүй гэсэн дуу хоолой байв. Хувийн салбарын авлигын талаар дүн шинжилгээ дутагдалтай байв. Энэ үзэл нь тэгэхээр бодит тоо баримтад биш илүү улс төрийн үзэл санаанд үндэслэсэн боловч төрийн албанд ашиг сонирхлоо хөөдөг, үр ашиггүй, өрсөлдөх чадваргүй, эсхүл авлигажсан гэж нэр шошго зүүх нь хөрөнгө мөнгийг ихээхэн татжээ. Ялангуяа Эдийн засгийн хамтын нөхөрлөл, хөгжлийн байгууллага, ОУВС, Дэлхийн банк нь ийнхүү орж ирэх мөнгийг зарцуулах нөхцөлийг тодорхойлох эрх мэдэлтэй байсан бөгөөд одоо ч тийм байгаа тэдний хувьд ч ихээхэн хөрөнгийг татжээ. Хөрөнгийн энэхүү хуваарилалт ба түүнийг зарцуулах нөхцөл нь ойлгож болохоор зүйл боловч нэр шошго зүүх эрх мэдлийг энд авч үзэж байна. Төрийн зохицуулалт, ялангуяа эдийн засгийн хүрээн дэх зохицуулалт нь төрийн албан хаагчид мөнгө саах **(II бүлгийг үз)** бололцоог өргөжүүлдэг бөгөөд эдийн засгийн хөгжилд саад болдог авлигын гол шалтгаан гэсэн шошго зүүгдэж ирсэн байна.

Олон улсын авлигатай тэмцэх хөдөлгөөн нь өргөн, барагцаа утгаар ‘Төрийн үүрэг юу вэ’ гэсэн улс төрийн үзэл бодолд хувирсан авлигатай тэмцэх зарчмыг бий болгожээ. Авлигын талаарх анхаарал нь юу түүнийг үүсгэж байна, тэр талаар юу хийх ёстой вэ гэдэгт төвлөрч байсан боловч голлон эдийн засгийн үүднээс анхаарч ирсэн байна. Бид II бүлэгт энэ санааны суурь болсон онолууд ба хувь хүмүүс нь өөрийн ашиг сонирхлын үүднээс үйлдэл хийдэг рационал субъект гэж үздэг онолуудтай танилцсан. Судалгааны ихэнх нь энэ үзэлд үндэслэсэн ба дараагаар нь төрийн албыг **(үйлчилгээ авахын тулд төлбөр хийх шаардлагагүй л бол хувийн хэвшлийн**

талаар бараг дурдалгүйгээр) бүтээгдэхүүн, үйлчилгээг үр ашигтай, үр дүнтэйгээр хүргэх чадваргүй гэж харжээ. Мөн улстөрчдийн ихэнх нь авлигажсан байдаг гэсэн зан үйлийн цогц таамаглал тавьсан (*Hough 2015*) байна. Улс орноос хамааран энэ үзэл нь үргэлж ямар нэг ач холбогдолтой байдаг бөгөөд улстөрчдийг рационал, ашиг сонирхолдоо хөтлөгдсөн, хувийн ашгаа хамгийн их байлгахыг эрмэлздэг гэж үзсээр л байна. Хүний зан чанарыг ингэж харснаар төрийн оролцоо, ялангуяа эдийн засаг дахь оролцоо нь авлигын шалтгаан юм гэж зарим судлаачид үздэг. Бүхий л салбарт авлигаас сэргийлэх оролдлогыг хувийн ашиг сонирхолд үндэслэсэн зүйл гэж харж байв. Гэхдээ хамгийн их туйлширсан нь Нобелийн шагналт Гари Бекер байсан бөгөөд тэр ‘хэрэв бид төрийг байхгүй болговол авлигыг алга болгоно’ гээд авлигагүй төрийн үйлчилгээ гэсэн санаа нь үл гүйцэлдэх, хоосон мөрөөдөл хэмээн (*Hough 2015*) хэлжээ.

Энэ нь дээр дурдсан эрдэмтэд авлигын талаар болон түүнтэй тэмцэх хэрэгцээний талаарх хэлэлцүүлэгт оруулсан хувь нэмрийг үгүйсгэж буй хэрэг биш боловч тэдгээр онол нь хувийн хэвшлийн оронд төрийн албанд анхаарах хандлагатай байдаг нь хязгаарлагдмал тал нь болж өгдөг. Эдийн засгийн хүндрэлтэй үед зохицуулалтыг бууруулах, төрийн оролцоог багасгах тухай хүчтэй ашиг сонирхол нь санхүүгийн болон (*Warren 2016*) бусад салбарын өрмийг хураасан хэрэг гэж хэлж болох ба хэрэв төр үүргээ гүйцэтгэж чадаагүй гэвэл тэр нь ашиг сонирхлоо хэт их хөөснөөс болоогүй. Оролцоогоо хэт багасгаж, байх ёстой дүрэм журмыг хэрэгжүүлж чадаагүйгээс болсон (*санхүүгийн авлигын жишээг Х бүлгээс үз*) юм.

Энэ үзлийн онолын үндэс нь төр ба хувийн хэвшилд ажиллах бүх хүмүүс рационал, өөрийн ашиг сонирхлыг харж үйл хөдлөл хийнэ гэсэн таамаглал боловч онол боловсрогдох цаг үед, мөн түүнээс хойш ч тийм байгаагүй юм. Гэсэн ч ОУВС болон Дэлхийн банкны анхаарал, ярьдаг зүйл нь төрийн алба байсаар л ирлээ. Роуз-Акерман (*Rose-Ackerman 1999*) маш олон

тооны дүрэм, журамтай байвал авлига цэцэглэх учир татварын тогтолцоог энгийн байлгах ёстой гэх мэт хэрэгтэй санал дэвшүүлсэн ч дүрэм журмыг хэрэгжүүлэх зохион байгуулалттай, хүлээн зөвшөөрөгдсөн, үр дүнтэй байгууллагагүй улсад бол тэр нь бодитой бус юм. Роуз-Акерман үр дүнтэй зохицуулалтыг хэрэгжүүлэхийн тулд эрх зүйн орчин тогтвортой байх ба найдвартай хэрэгжүүлдэг байгууллага зайлшгүй шаардлагатай гэсэн. Түүнчлэн тэр авлигатай тэмцэх хамгийн шаардлагатай газрууд авлигатай тэмцэхгүй байна гэжээ. Олон нийтийн сонголтын (*public choice*) онолын урсгалынхан хүний шинж чанарын талаар тусгай ойлголттой байдаг учир хэрэв бид рационал тоглогчид юм бол авлигатай тэмцэх ямар ч стратеги хэрэггүй. Ялангуяа Дэлхийн банк, ОУВС, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Европын төв банкны төсөөлсөн хэмжээгээр бүр ч боломжгүй гэж үздэг байна.

1990-ээд оноос ОУВС авлига нь олон төрлийн эдийн засгийн үзүүлэлт болон хөрөнгө оруулалтад сөрөг нөлөөтэй гэсэн судалгааны ажлыг (*Tanzi 1994, 1998, 2000*) хэвлүүлжээ. Гэвч ОУВС-ын авлигын талаарх сонирхол нь сайн боловсруулагдаагүй гэвэл худлаа (*Hough 2015*) болно. Учир нь авлигад эдийн засагт үзүүлэх олон янзын муу нөлөө бий. Гэхдээ ОУВС-д ажиллагсдын анхдагч байр суурь нь төр авлигыг цэцэглүүлдэг гэх байр суурь юм. ОУВС-ын Төсвийн асуудлын газрын даргын орлогч Шиллер (*Schiller 2000*) худалдааны тогтолцоог чөлөөлөх, үнийг зохицуулалтгүй болгох, зах зээлд шилжүүлэх хүрээг өргөтгөх зэрэг тодорхой арга хэмжээнүүдийг эдийн засгийн өсөлтөд хүргэж, авлигыг бууруулах цор ганц арга зам хэмээн танилцуулаад, тэдгээр нь авлигыг амжилттай багасгасан гэжээ.

Гэхдээ энэ нь төөрөгдүүлэх ойлголт юм. Авлигын үр нөлөөний талаарх мэдлэг нэмэгдсэн боловч санал болгож буй шийдэл нь хязгаарлагдмал байна. Авлигын бодит байдалтай нүүр тулалгүй, бодлогын түвшинд ажиллаад, эдгээр улсаас

дээгүүрх байгууллагуудын нэг размер бүгдэд таарна гэсэн арга нь практикт нийцсэн гэхээс илүү үзэл санааны зүйл юм. Тиймээс авлигатай тэмцэх оролдлогууд тийм хязгаарлагдмал үр нөлөөтэй байгаад гайхах зүйлгүй. 1990-ээд оны сүүлээр Дэлхийн банк төрийн байгууллагуудын үүргийг үндсээр нь дахин үнэлэхийг санал болгосон ба зах зээлийн шинэчлэл нь авлигыг шийдэх хамгийн сайн арга зам юм гэсэн. Дэлхийн банк эдийн засгийг чөлөөлөх явдлыг улс төрийн институцүүдийг өөрчлөх хүсэлтэй хүмүүстэй холбон үзэх болсон үедээ ‘засаглал, ардчилал, институц-байгуулах’-ыг шинээр онцлох болжээ. Тиймээс уг банк нь (*неолиберал*) бүтцийн өөрчлөлтийг урагшлуулах бөгөөд авлигыг тодорхой төрлийн (*үндсэндээ илүү либерал*) эдийн засгийн бодлогыг институцийн болгоомжтой шинэчлэлтэй хослуулах замаар шийдвэрлэж болох техник асуудал гэж харах өөр нэг хэрэгсэл (*Hough 2015*) байв. Тэдгээр шинэчлэлийг нэвтрүүлэхдээ төрийн албанд авлигажсан гэх нэр шошго зүүж байжээ.

Дүгнэлт

Энэ бүлэгт хувь хүн, байгууллага, төрийн алба, төрийн үйлчилгээнд буруутан гэсэн нэр шошго зүүх эрх мэдэл нь бидний авч үзэж буй асуудлын шалтгаан, эсхүл нэг хэсэг болохыг онцлон үзүүллээ. Тэдэнд нийтлэг байгаа зүйл нь яриа хэлэлцээнд давамгайлах, ‘баримт’-ыг будилуулах эрх мэдэл байна. Хилсбороогийн жишээн дээр үнэнийг баллах гэсэн бүлэглэсэн оролдлого байсан бөгөөд одоо ч байсаар байна. Уг ослын үнэн нь өмнө нь ч, одоо ч гамшгийн талаарх яриа хэлэлцээн дунд нийгмээр байгуулагдсан ба аажмаар зөрчил нь ил болж ирсээр байна. Энэ жишээ бол цагдаагийн байгууллагын авлигын нэг жишээ бөгөөд тухайн үйл явдал болсны дараа гарч байсан анхны шийдвэрүүдэд авлига биш баримтыг будлиулах санаа оршиж байсан бол аажмаар улстөрчид ба сонинуудын тусламжтайгаар хөл бөмбөг сонирхогчдод ‘араатан’ гэх нэр

шошго зүүх гэсэн дараа дараагийн шатны оролдлого дахь авлигын жишээ болж өгсөн юм. Тухайн үед хөл бөмбөгийн хулигаанууд асуудал болж байсан учраас энэ нэр шошго нь дэмжигчтэй байсан бөгөөд албан ёсны яриа хэлцэл нь хэрхэн үнэн болж харагддаг болохыг эндээс хялбар харж болно.

Үнэнийг үгүйсгэх ба будилуулах нь ихэвчлэн хувь хүн ба байгууллагуудын ярьж түгээдэг авлигын талаарх үг хэллэгийн нэг хэсэг байдаг. Энэ нь ОУВС, Дэлхийн банк зэрэг том байгууллагуудын хувьд илүү илэрхий байдаг. Авлигын асуудлыг бодитойгоор үнэлэхийн оронд ихэнх зохиол бүтээл, ялангуяа 1990-ээд оны бүтээл нь төрийн албыг сөргөөр авч үзэж байв. Гэсэн ч Швед болон Дани улс төрийн оролцоо өндөр боловч авлигын түвшин багатай байдаг. Баримтыг янз бүрээр тайлбарлаж болох ба ОУВС болон Дэлхийн банк нь тэдэнд буй мэдээллээс үл хамааран хувьчлалыг дэмжсэн тодорхой үзэл санааны байр суурьтай байгаа харагддаг.

Энэ онолын аргачлал нь тэгэхээр ‘үнэн’ ба ‘баримт’ гэдэг нь нийгмээр байгуулагддаг бөгөөд тухайн улс, эсхүл олон улсын байгууллага дахь хамгийн эрх мэдэл бүхий хүмүүс түүнийг тодорхойлдог гэдгийг тодотгож өгдгөөрөө хэрэгцээтэй онол юм. Энэ онолын хязгаарлагдмал талуудыг энэ бүлэгт дурдсан ч шууд үгүйсгэх (*юу ч болоогүй*), тайлбараар үгүйсгэх (*болсон зүйл бол үнэндээ өөр зүйл*), далдуур үгүйсгэх (*болсон зүйлийг зөвтгөх*) үйл явц нь хувь хүн, эсхүл байгууллага нь ядаж л бидэнд мэдэгдэх авлигын үйлдэл гаргах бүрт авлигыг шинжлэхэд хэрэгцээтэй аргачлалыг бидэнд өгч байна.

Ашигласан материал

- Becker, H. (1967). Whose side are we on? *Social Problems*, 14, 241.
- Becker, H. S. (1963). *Outsiders: Studies in the sociology of deviance*. New York: Free Press.
- Bonger, W. (1969). *Criminality and economic conditions*. Bloomington: Indiana University Press.
- Braithwaite, J. (1989). *Crime, shame and reintegration*. Cambridge: Cambridge University Press.
- Cohen, S. (1985). *Visions of social control*. Cambridge: Polity Press.
- Cohen, S. (1996). Government responses to human rights reports: Claims, denials, and counterclaims. *Human Rights Quarterly*, 18 (3), 517–543.
- Empey, L. T. (1982). *American delinquency: Its meaning and construction*. Homewood, IL: Dorsey.
- Erickson, K. T. (1966). *Wayward puritans: A study in the sociology of deviance*. New York: Wiley.
- Foucault, M. (1980). *Power / Knowledge: Selected interviews and other writings 1972 – 1977*. (C. Gordon, Ed.). New York: Pantheon Books.
- Garfinkel, H. (1956). Conditions of successful degradation ceremonies. *American Journal of Sociology*, 61, 420–424.
- Gove, W. R. (1980). *The labelling of deviance: Evaluating a perspective*. Beverley Hills, CA: Sage.
- Heywood, P. M. (2015). *Routledge handbook of political corruption*. Abingdon: Routledge.
- Hirschi, T. (1975). Labelling theory and juvenile delinquency: An assessment of the evidence. In W. R. Gove (Ed.), *The labelling*

of deviance: Evaluating a perspective. Beverly Hills, CA: Sage.

Holdaway, S. (1988). *Crime and deviance.* Basingstoke: Macmillan Education.

Hopkin, J., & Rodriguez-Pose, A. (2007). 'Grabbing Hand' or 'Helping Hand'? corruption and the economic role of the state. *Governance*, 20(2), 187–208.

Hopkins, M., & Treadwell, J. (2014). *Football hooliganism, fan behaviour and crime: Contemporary issues.* Basingstoke: Palgrave Macmillan.

Hough, D. (2015). *Corruption, anti-corruption and governance.* Basingstoke: Palgrave Macmillan.

Jones, S. (2006). *Criminology* (3rd ed.). Oxford: Oxford University Press.

Kitsuse, J. L. (1964). Societal reaction to deviant behaviour: Problems of theory and method. In H. Becker (Ed.), *The other side.* New York: Free Press.

Katz, R. S. (2002). Re-Examining the Integrative Social Capital Theory of Crime. *Western Criminology Review*, 4(1), pp. 30–54.

Lemert, E. W. (1951). *Social pathology.* New York: McGraw-Hill.

Lilly, R. J., Cullen, F. T., & Ball, R. A. (1989). *Criminological theory: Context and consequences.* Thousand Oaks, CA: Sage Publications.

Morris, N., & Hawkins, G. (1970). Rehabilitation: Rhetoric and Reality. *Federal. Probation*, 34, 9.

Murray, C. (1990). *The emerging British underclass.* London: Institute for Economic Affairs.

- Pfohl, S. J. (1985). *Images of deviance and social control: A sociological history*. New York: McGraw-Hill.
- Rose-Ackerman, S. (1999). *Corruption and government. Causes, consequences and reform*. Cambridge: Cambridge University Press.
- Sampson, S. (2008). Corruption and anti-corruption in south-east Europe: Landscape and sites. In L. de Sousa, P. Larmour, & B. Hindess (Eds.), *Governments, NGOs and anti-corruption: The new integrity warriors*. London: Routledge.
- Schiller, C. (2000). *Improving Governance and Fighting Corruption: An IMF Perspective*. Washington D.C.: IMF: Fiscal Affairs.
- Scruton, P. (1999). Policing with contempt: The degrading of truth and denial of justice in the aftermath of the Hillsborough disaster. *Journal of Law and Society*, 26 (3), 273–297.
- Scruton, P. (2000). *Hillsborough: The truth*. Edinburgh: Mainstream.
- Scruton, P. (2004). Death on the terraces: The contexts and injustices of the 1989 Hillsborough disaster. *Soccer & Society*, 5 (2), 183–200.
- Scull, A. (1984). *Decarceration*. New Jersey: Rutgers University Press.
- Tanzi, V. (1994). *Corruption, government activities and markets* (Working Paper 94/99). Washington, DC: IMF.
- Tanzi, V. (1998). *Corruption around the World: Causes, consequences, scope and cures* (Working Paper 98/63). Washington, DC: IMF.
- Tanzi, V. (2000). *Policies, institutions and the dark side of economics*. Cheltenham: Edward Elgar.

Авлигын криминологи

- Taylor, I., Walton, P., & Young, J. (1973). *The new criminology: For a social theory of deviance*. London: Routledge and Kegan Paul.
- Turk, A. T. (1969). *Criminality and legal order*. Chicago: Rand McNally.
- Warren, E. (2016). *Rigged Justice 2016: How weak enforcement lets off enders of easy*. Washington, DC: Office of United States Senate, Office of Elizabeth Warren.
- Williams, J. (2014). Justice for the 96? Hillsborough, politics and English football. In M. Hopkins & J. Treadwell (Eds.), *Football hooliganism, fan behavior and crime: Contemporary issues*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Wilson, J. Q., & Herrnstein, R. (1985). *Crime and human nature*. New York: Simon and Shuster.

Х

Авлигыг тайлбарлах нь: Рационал, тооцоолсон сонголт уу?

Удиртгал

Мартинсон (1974:25) ‘цөөн хэдэн, тусгаарлагдсан онцгой тохиолдол гарсныг эс тооцвол ялтныг эргэн нийгэмшүүлэх оролдлогууд нь дахин гэмт хэргээс сэргийлэх тал дээр сайшаагдахаар үр дүн авчраагүй’ хэмээн зарлажээ. Энэ ‘юу ч нэмэргүй’ төрлийн мэдэгдэл нь орчин үеийн ардчилсан улс нь нийгэмшүүлэх, эсхүл хэрэгтнүүд ба давтан хэрэгтнүүдэд арга хэмжээ авах чадвартай гэх үзэлд нөлөөлсөн байна. Албан ёсоор бүртгэгдсэн гэмт хэрэг өсөөд ирэхээр гэмт хэргийн шалтгаан нь биологийн, эсхүл нийгмийн бүтэц дэх тэгш бус байдлаас бус хувь хүний дотор байгаа юм гэж үздэг ‘баруун реализм’-ын зүгээс олон жилийн турш гэмт хэргийн талаарх яриа хэлэлцээнд давамгайлж ирсэн нийгэм/био-сэтгэлзүйн аргачлалыг шүүмжилж эхэлжээ. Баруун реализм нь хүмүүс яагаад гэмт хэрэг хийдэг вэ (*хэдийгээр баруун реализм нь хүмүүс яагаад гэмт хэрэг хийдэг талаарх онол боловч*) гэдэг маргааны оронд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх прагматик, бодитой аргачлалыг илүүд үздэг. Эрүүгийн хуулийг төр тодорхойлж, гудамжны гэмт хэрэгт голлон анхаардаг, бүрэлдэхүүнийг нь асуудалгүй гэж үздэг болохоор хувь хүний хариуцлагын

(individual responsibility) ойлголт нь уламжлалт хувийн хариуцлага (*personal responsibility*), зан үйл, эгэх хариуцлагатай холбоотой олон янзын улс төр ба бодлогын гол бүрэлдэхүүн ойлголт болжээ. Эдгээр үзлийг нийгэм-биологийн (*Wilson and Herrnstein 1985*) рационал сонголт (*Clarke 1980; Cornish and Clarke 1986*) гэж нэрлэгддэг онолд гарган ирсэн бөгөөд тэд гэмт хэргийг ач холбогдолтой, утга учиртайгаар бууруулахын тулд гэмт хэрэг нь хагас-эдийн засгийн хичээл зүтгэл гэдгийг хүлээн зөвшөөрч, хүлээн авах хэрэгтэй гэдгийг онцолжээ. Хувь хүмүүсийг рационал гэж харж буй учир ихэвчлэн хорих гэх мэт хурдтай хэрэгжих шийтгэл нь бусдыг хэрэг хийхээс цээрлүүлж, гэмт үйлдэл хийх боломжгүй болгодог учраас түүнийг санал болгодог.

‘Баруун реализм’ ба Хувь хүний хариуцлага

Боловсруулагдаад буй онолын аргачлал боловсрогдсон нь хүний зан үйлийг гэнэт ойлгож, мэдэж авсан ялалтын агшин байгаагүй юм. Тэр бүх аргачлалууд нь түүхтэй, удаан аажуу хөгжиж ирсэн бөгөөд түүнийг нь дотоод ба гадаад түүх хэмээн нэрлэж (*Young 1994*) байв. Энэ хугацаанд бид санал болгож буй онолын аргачлал, тэдгээр нь хүний үйлдэл болон зан үйлийг зөв тайлбарлаж байна хэмээн үзэж буй нийгэм, улс төрийн орчин нөхцөл ба гэмт хэргийн цаад шалтгаан, түүнээс хэрхэн сэргийлэх талаарх тайлбарын аль алиныг ойлгохыг хичээцгээсэн. 1980-аад онд Вилсон, Хэррнштайн (*Wilson and Herrnstein 1985*) нар АНУ дахь гэмт хэрэгт хандах улс төрийн болон бодлогын хандлагад нэлээд нөлөөлжээ. Тэдний хувьд хүний зан үйл, ялангуяа залуу хүмүүс хүчирхийлэл үйлдэх явдал нь гурван зүйлийг агуулдаг. Үүнд: бие махбодын хүчин зүйл, хүчитгэгч хэмээн нэрлэгддэг зүйл байсан эсэх, ухамсрын шинж чанар багтана. Албан ёсоор бүртгэгдсэн гэмт хэргийн олонхийг хотын залуу эрчүүд үйлддэг ба үүнд эр хүйстэн,

залуу хүний бие махбодын болон нийгмийн уг сурвалж, залуу эрийн биологийн статус, хийгээд (*Wilson and Herrnstein 1985*) нас хүйс, ухаан, биеийн хэлбэр, зан чанар зэрэг хүчин зүйл нь нийгмийн халамжаас хамаарах хамаарал, хамрагдах боломжтой нийлээд гэмт зан үйлийг тайлбарлана гэж үзсэн. Энэ онол нь гэмт хэргийг зөвхөн биологийн үүднээс тайлбарладаггүй, зүгээр л эдгээр хүчин зүйлийг үйлдлийн шалтгаан, ялангуяа гэмт хэргийн шалтгаан гэж бус ‘бодит байдал’ гэж хүлээн авдаг. Тэд эдгээр ‘бодит байдал’ нь гэмт хэрэгт хандах хандлагыг тайлбарлаж чадна гэж үздэг.

Мөн хувь хүн нь ямар төрлийн зан үйл ямар нөхцөл байдалд шагнагдах вэ гэдэгт үндэслэн нийгмийн ертөнцөд хэрхэн биеэ авч явахад суралцдаг. Энэ хандлага нь тиймээс сэтгэлзүйн зан үйл судлал ба хүн гадаад орчин, эсхүл илүү шулуунаар өөрсдийн орчин нөхцөлд хэрхэн хариу үйлдэл үзүүлдэгт түшиглэдэг. Гэмт хэрэг үйлдэх магадлалыг ойлгохын тулд гадаад орчин хувь хүнд нөлөөлөх байдал болон хариу үйлдэл бий болгох бие махбодын ‘бодит байдал’ хоёрын аль алиныг ойлгох нь чухал. Вилсон, Хэррнштайн (*1985*) нар гадаад орчны нөлөөнөөс илүү хувь хүний ялгаа нь гол түлхүүр болохыг анхааралтай тайлбарласан байна. Тодорхой гэр бүлийн байдал нь гэмт хэрэг хийх магадлалыг илэрхийлж болох ч энэ нь үргэлж үр дүнг тодорхойлоод байдаггүй. Тэгэхээр бидний ухамсар бол нөхцөлт рефлекс юм гэж үздэг бөгөөд энэ утгаар хүмүүс гэмт хэрэг үйлдэх болон урхидалтаас сэргийлэх хандлагын цогцыг ихэнхийг нь хүүхэд насандаа, дотооджуулсан байдаг. Ухамсар нь бидний гэр бүл дэх, эсхүл илүү нарийнаар зөв нийгэмших (*Hirschi 1969*) хамгийн үр дүнтэй эх булаг болох дан ам бүлтэй гэр бүлийн нийгэмшлээр (*ижил төрлийн санааг VII бүлгээс үз*) нөхцөлддөг.

Энэ үүднээс бол бидний зарим нь нөхцөл байдлаас хамааран (*V бүлгээс ялгаатай нөхөрлөлийг үз*) үйлдлийн үр дүн багатай, сул дотооджилтын улмаас (*VII бүлгээс нийгмийн хяналтыг үз*)

хууль зөрчиж магадгүй ба зарим нь эдгээртэй хамааралгүйгээр гэмт хэрэг үйлдэнэ. Ухамсрын үр дүнтэй байдал, хувь хүний бие махбод болон гадаад орчинд үзүүлэх хариу үйлдлийн хослол нь гэмт хэргээс урьдчилан (*Walklate 1998*) сэргийлнэ. Эдгээр хүчин зүйлсийн хоорондын хамаарлаар гэмт хэргийг дараах зүйлсээр тайлбарлаж болно. Тухайлбал, гэмт хэргийн түвшин нь (*гудамжны гэмт хэрэг*) хүн амын насны бүтэц шилжих (*мөн залуу эрчүүдийн тооноос хамааран хүн амын өсөлт ба бууралт*), гэмт хэрэг үйлдэх явдлын зардал ба үр ашгийн талаарх санаа бодол (*баригдах, яллагдах магадлал ба ялын хэмжээ*), гэр бүл, сургууль, сүм дэх нийгэм, соёлын ерөнхий өөрчлөлт, өөрийгөө хянах дотоод амлалт, дүрмийг дагаж мөрдөх дур сонирхлоор тайлбарлаж (*Wilson and Herrnstein 1985*) болно.

Энэ аргачлалд эдийн засгийн онол дахь рационал сонголт/үйл хөдлөлийн цар хүрээтэй төстэй зүйл бий. Нийгэм, эдийн засгийн зан үйлийг ойлгоход хэрэглэгддэг энэ загварт тавигддаг урьдач нөхцөл нь ерөнхий нийгмийн зан үйл нь хувь хүний зан үйл ба сонголтоор тодорхойлогдоно гэсэн нөхцөл юм. Энэ загвар нь хувь сонголтын шалтгаанд анхаардаг бөгөөд бидний өмнө бий болсон сонголтуудаас алийг нь илүүд үзэх вэ гэсэн шалгуур бидэнд байдаг гэж таамагладаг. Тиймээс биднийг рационал гэж үзээд байгаа мэдээлэл, болзошгүй зардал ба үр ашгийг тооцон, юмыг илүүд үзэх шалгуураа тогтоодог бөгөөд өөрийн тодорхойлсон хамгийн сайн үйлдлийг үргэлж сонгодог гэж үздэг.

Гэхдээ хүчин зүйлс болон болзошгүй хувьсагчдын нарийн төвөгтэй харилцан үйлчлэл байгаа учир энэ аргачлалаар бид гэмт хэргийг бууруулж чадахгүй зүгээр л ‘амьдралын’ зайлшгүй үр дагавар хэмээн хүлээн авах ёстой гэж таамаглахад тийм ч хэцүү бус. Тиймээс Вилсон, Хэррнштайн (*1985*) нар хувь хүмүүсийн ‘согогтой’ нийгэмшил ба аврах аргагүй болсон хотын хэсэг, бүсийн асуудлыг шийдэх гэж оролдохын оронд

хүрч чадах зүйлдээ анхаарлаа хандуулах прагматик аргачлалыг санал болгожээ. Тиймээс бид мэдэж байгаа зүйл дээрээ үндэслэн хязгаарлагдмал нөөцийг зохих зүйлд нь чиглүүлж амжилтад хүрч болно. Тэгснээр анх удаа хэрэг хийсэн залуусыг *(эрүүгийн шүүн таслах тогтолцоотой анх удаа тулгарч буй хүмүүсийг хэлж байгаа бөгөөд гэмт хэрэг анх удаа үйлдэж буй хүмүүсийг хэлээгүй)* давтан хэрэгтэн болголгүй, анхнаас нь гэмт хэрэг хийхээс цээрлүүлэх буюу түдгэлзүүлж болох юм. Уламжлалт аргачлалууд нь харагдах гэмт хэргийг онцлон үзэж, хувь хүний бие ба хувийн эд зүйлийн бүрэн бүтэн байдлыг хамгаалахад анхаарч *(Jones 2006)* иржээ.

Энэ үзэл нь одоо шүүмжлэгдэж байна. АНУ-д хорих ял өсөж, дараа нь саатуулах ял өссөн нь залуу хүмүүст ихээхэн нөлөөлсөн гэх үзлийн талаар улс төрийн өнцгөөс янз бүрийн эргэлзээ гарч эхэлжээ. Гэхдээ энэ аргачлал нь ямар ч утгаар шударга ёсыг тодорхойлсон бай шударга ёсыг тогтоох тухай бус нийгмийн хэв журмыг сахиулах тухай аргачлал бөгөөд зөвхөн цагаан захтны гэмт хэрэг бус гудамжны гэмт хэргийг тайлбарладаг хэмээн Янг *(Young 1994)* тэмдэглэжээ. Вилсон, Келлин *(Wilson and Kelling 1982, 1989)* нар хэв журмыг сахиулах нь хамгийн чухал бөгөөд цагдаа нар архидалт болон зодооны асуудлыг шийдэж чадахгүй байх нь хамтын нэгдэл дэх хууль, хэв журам алдагдахад хүргэж магадгүй гэж үзсэн байдаг. Үүнийг Вилсон, Хэррнштайн *(1985)* нар ‘хагархай цонхны онол’ хэмээн нэрлэсэн бөгөөд энэ нь зарим талаар авлигын тухайд ч ач холбогдолтой. Энэ нь хэв журам нь бүрэн нурж уначихаагүй байгаа газарт төвлөрөх ёстой, өөрөөр хэлбэл найдваргүй газарт хязгаарлагдмал нөөцийг үргүй зарах хэрэггүй гэсэн үг юм.

Дээрх онолын аргачлалыг бий болгосон нийгэм, улс төрийн нөхцөл байдал нь рационал сонголтын онолыг хөгжүүлэхэд төгс тохирч *(Clarke 1980; Cornish and Clarke 1986)* байв. Рационал сонголтын онолд биднийг гэмт хэргийн талаарх сонголтыг эдийн засгийн сонголттой адил байдлаар хийдэг хэмээн дүгнэсэн *(ЭЗЭН-*

ажилтны харилцааны талаарх дэлгэрэнгүйг II бүлгээс үз) байдаг. Тиймээс рационал сонголт нь гэмт хэргийн шалтгааны талаар бус голчлон гэмт хэргийн менежментийн талаар авч үзнэ. Хүн бол ашгаа хамгийн их байлгах сэдлээр хөдөлдөг хэмээн ойлгодог энэ аргачлалд хувь хүмүүс нь өөрсдийн зардал-үр ашгийн шинжилгээнд үндэслэн рационал шийдвэр гаргадаг гэсэн таамаглал бий. Корниш, Кларк (*Cornish and Clarke 1986:1*) нар энэ талаар ‘хэрэгтнүүд гэмт зан үйлдлийн хувьд ашигтай байхыг эрмэлздэг: ... энэ нь жижиг ч гэсэн шийдвэр гаргах, сонголт хийхтэй холбоотой ... ба эдгээр процесс нь цаг хугацаа болон байгаа мэдээллийн хязгаарлалтаар хязгаарлагдах боловч рационал байдлын хэмжээг харуулдаг’ гэж тодорхой бичжээ. Рационал процессоор цаг хугацаа, байршил болон зөв ба зөв бус ч бай хамаагүй байгаа мэдээллийг үнэлэх замаар гэмт хэрэг үйлдэх, эсхүл үйлдэхгүй байх гэсэн шийдвэрийг гаргана. Рационал сонголт нь гэмт хэргийг тайлбарлахад учрах хязгаарлагдмал талыг хүлээн зөвшөөрдөг боловч гэмт хэрэг үйлдэх явдлыг хамгийн их боломжит хэмжээгээр хүндрүүлэх, яллагдсан хэрэгтнүүдийг шийтгэх замаар бусдыг гэмт хэргээс цээрлүүлэх аргаар түүнээс сэргийлэхийг эрмэлздэг. Тэгэхээр гэмт хэргийн цаад шалтгааны талаар бараг сонирхолгүйгээр, урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь цагаан захтны гэмт хэрэг бус гудамжны гэмт хэргээс сэргийлэх талаар бага зэрэг үр дүн авчрах нөхцөл байдлын арга хэмжээ авахад төвлөрдөг. Өнөөг хүртэл хэрэгжүүлээд буй авлигатай тэмцэх арга хэмжээ, стратеги нь хязгаарлагдмал амжилттай байгаа талаар II бүлэгт тайлбарласан.

Рационал сонголт нь эцэстээ бодит байдлаар хязгаарлагдах буюу хиллэгдэнэ. Тиймээс бидний рационал байдал нь хязгаарлагдмал байх бөгөөд бид сайндаа л хувь хүн болон бүлэг хүмүүс шийдвэрээ хялбарчлахад л туслах юм. Учир нь бүх мэдээлэл болон боломжит сонголтуудыг таамаглах, эргэцүүлж үзэх нь хүндрэлтэй байдаг. Танин мэдэх чадамжийн хязгаарлалт

ба хэт сэтгэл хөдлөлийн үйлдлийн улмаас хиллэгдсэн рационал байдал нь (*bounded rationality*) рационал байдлын цар хүрээг тогтоодог. Зарим тохиолдолд сэтгэл хөдлөл нь огцом, бидний ‘хяналтаас гадуур’ явагдаж, энэ үед рационал сэтгэлгээ явагдахгүй байж болно. Боломж, бололцоо нь рационал сонголтоос илүү гэмт хэргийг тайлбарлах боловч энэ боломж нь зардал-үр өгөөж, нийгэм эдийн засгийн статус, илрэх эрсдэл, нөхцөл байдлын агуулга, гэмт хэргийн төрөл, гадаад үр ашгийг хүртэх боломжтой холбоотой байж болно. Түүнчлэн боломж нь тухайн үеийн эргэн тойрны зүйлс ба дагалдах хүчин зүйлсээс хамаарна. Энэ утгаар рационал сонголт нь магадгүй зарим талаар сэтгэл хөдлөлийн, хэрцгий гэмт хэргийг бус хэрэгслийн гэмт хэргийг (*instrumental crime*) тайлбарлахад тустай байж магадгүй. Хэдийгээр бодит байдлаар хиллэгдэж, хязгаарлагддаг ч хорт хаягдал хууль бусаар хаях, байгаль орчин бохирдуулах зэрэг рационал авлигажсан хэрэг үйлдэгддэг. Энэ талаар дор авч үзэх болно.

Рационал сонголтын хязгаарлагдмал тал

‘Бодит’ гэж юу вэ, ‘баруун’ гэж юуг хэлж байна вэ²⁷ гэдэг ойлголт нь тайлбараас хамаарах боловч ‘реализм’ гэдэг нэр томъёотой хамт хэрэглэгдэх үед угаас улс төрийн ойлголт болдог. Уг онол нь гэмт хэрэг болон эрүүгийн шударга ёс нь бодитой асуудал бөгөөд нийгмийн асуудал гэж үздэг. Гэхдээ гэмт хэргийг ойлгох, шийдвэрлэхийн тулд нийгмийн бүтцэд бус хувь хүнд анхаардаг байна. Энэ бүлэгт дурдсан онолын аргачлалууд ба уламжлалт эрүүгийн бодлого нь хоорондоо заавал ч үгүй холбоотой байсангүй. Уламжлалт бодлого нь хувь хүний хариуцлагыг онцолдог талаараа уламжлалт үзэлтэй

27 Дээр дурдагдсан Right realism буюу баруун реализмын онолын түлхүүр үгс ‘real’ буюу бодит, ‘right’ буюу баруун гэдгийг заажээ. (Орч.)

хүмүүсийн дэмжлэг авч, ач холбогдолтойд тооцогдож (*Jones 2006*) байв.

Хувь хүнд хариуцлага оноож, хариуцлага тооцох нь төрийн зардлыг хассан эдийн засгийн хомс байдлын үед бол нийгмийн асуудлыг авч үзэх тохиромжтой арга юм. Гэхдээ энэ үзэл нь дотроо зөрчилтэй байна. Хувь хүнд анхаардаг, тэгш бус байдал нь нийгмийн нэг хэсэг бөгөөд асуудалгүй гэж үздэг бөгөөд эрүүгийн шүүн таслах бодлого нь нийгмийн асуудлыг шийдэх бус хувь хүнтэй ноцолдохыг зорьдог хэмээн үздэг. Мөн ил харагдах гудамжны гэмт хэрэг зэрэг тодорхой төрлийн гэмт хэрэгт төвлөрөх хандлагатай байдаг бөгөөд гэмт хэргийн хандлагыг нийгмийн хамгийн ядуу хэсэгтэй холбон, тиймээс гэмт хэргийг нийгмийн эд ширхэгт бус хүний шинж чанарт наалдсан (*эсхүл ядуу хүмүүсийн шинж чанарт*) гэж үздэг аж. Улмаар хэрэгтнүүд нь засаршгүй учир зөвхөн шийтгэл хяналт хэрэгтэй гэж үздэг (*Lilly et al. 2015*) байна. Тиймээс гэмт хэргийг энгийн шийдлээр шийдвэрлэж болох энгийн л зүйл хэмээн дүрсэлдэг.

Тийм аргачлалыг олон хүн дэмжин, уламжлалт улс төрийнхний хүрээнд дуу хоолойтой болоход хүргэдэг нийгэм, улс төрийн нөхцөл ч бас төрийн оролцоог бууруулахыг шаарддаг. Хэрэгтнүүдийг ингэж харах нь шийтгэлээр гэмт хэргээс сэргийлэх, эсхүл саатуулах ялыг дэмжих бодлого нь өөрөө төрд шоронгийн тоогоо нэмэгдүүлэх, аль эсхүл хувийн шоронгийн асуудлаар зохицуулалт, үүргээ нэмэгдүүлэх хэрэгцээг давхар бий болох далд үр дагавар үүсгэдэг. Эдгээрийн аль ч тохиолдолд төр нь хувь хүний амьдралд оролцох оролцоогоо бууруулах бус төрийн цар хүрээг нэмэгдүүлнэ. Энэ нь нийгмийн аюултай гэгддэг хэсэгт голлон чиглэсэн тороо өргөтгөх нэг хэлбэр (*Cohen 1985*) юм. Эрүүгийн тогтолцоон дахь төрийн оролцоон дундаас хүмүүсийг шоронд хийх нь хамгийн их зардалтай шийтгэл ба шоронд хорихтой хамааралтайгаар гэмт хэргийн түвшин олигтой буурдаггүй учир түүнийг зөвтгөх багахан ч

болтугай баримт байхгүй гэж шүүмжлэгддэг. Гэхдээ уламжлалт аргачлалыг дэмжигчид нь төр эдийн засгийн ба нийгмийн халамжийн хүрээнээс гарч, хууль, хэв журам дахь хүртээмжээ нэмэгдүүлэхийг хүсдэг учраас нийгэм, улс төрийн асуудлаас хамаараад жижиг төрийг илүүд үздэг байна.

Ядуурал, арьс өнгөний үзэл, ажилгүйдлийн түвшингээр илэрхий ялгаатай АНУ-ын өөр өөр хэсэгт гэмт хэргийн түвшин яагаад ялгаатай байдгийг тайлбарлаж чадаагүй эдгээр эрдэмтэд эрх мэдэл, анги, арьс өнгөний асуудлыг орхигдуулсан (*Currie 1991*) юм. АНУ-ын хар арьстнууд оршин суудаг зарим газарт цагдаа нар хүрч ажиллаж чадахгүй байгаа одоо цагт ч энэ шүүмжлэл ач холбогдолтой байна. Бүтцийн тэнцвэргүй байдалтай байхад хувь хүний хариуцлага ярих явдал АНУ-ын зарим хэсэгт байсаар байгаа ба тэнд гэмт хэргийг хамтын нэгдлийн асуудал гэж үзээд, гэмт хэргийг ихэвчлэн ядуу хорооллоос үүдэлтэй, хувь иргэдийн хариуцлагагүй шинж чанартай холбоотой хэмээн тайлбарладаг.

Рационал сонголт: Сүйтгэх дур сонирхол ба байгаль орчны авлига

Рационал сонголтын онол ихэвчлэн гудамжны гэмт хэрэгт анхаардаг ч хувь хүн, байгууллагын үйлддэг байгаль орчны гэмт хэргийг тайлбарлахад мөн хэрэгтэй байдаг. Эдгээр үйлдлийн ихэнх нь эрүүгийн хэрэг болдоггүй боловч байгаль орчин ба хүмүүст хор, хөнөөлтэй байдаг учир авлига гэх цогц ойлголтод (*Brooks et al. 2013*) багтана. Бүх үйлдэл нь зардлаас зугтаж, орлогыг хамгийн их байлгаснаар рационал гэж харагдах гэсэн нэг ижил ерөнхий сэдэвтэй байдаг.

Энд бид эхлээд байгаль орчны гэмт хэрэг гэж юу вэ гэдгийг тодорхойлъё. Байгаль орчны гэмт хэргийн иргэний болон эрүүгийн тодорхойлолт байдаг боловч эдгээр нь хязгаарлагдмал байна. Хувь хүмүүс хогоо хууль бусаар хаяхаас эхлээд ‘байгаль

экологийг ноцтой сүйтгэх' хүртэл хохирлын талаар голлон ярьж байвал өргөн утгаар байгаль орчны гэмт хэргийг томьёолох нь илүү хэрэгтэй байж болно (*Halsey 1997 :121*). Төрөл бүрийн байгаль орчны гэмт хэрэг нь хэрхэн авлигын үйлдэлд багтах талаар зарим тодруулга ч хэрэгтэй болно. Байгаль орчныг бохирдуулах үйлдэл нь дангаараа байгаль орчны гэмт хэрэг болохгүй. Учир нь хувь хүн ба бизнесүүд байгаль орчныг үргэлж бохирдуулж (*гэхдээ энэ нь одоо ч маргаантай*) байдаг. Байгаль орчинд хохирол учруулах рационал шийдвэр нь өдөр тутмын амьдралын хэв маягийн нэг хэсэг болно. Уурхай, машин үйлдвэрлэл, ойн аж ахуй нь бүгд л хор хохиролтой боловч зарим хүмүүсийн хувьд (*Beirne and South 2013; South and Brisman 2013*) ашигтай. Түүнчлэн хувь хүмүүс угаалгын машин зэрэг хэрэггүй эд бараагаа хууль бусаар хаях нь байгаль орчинд хөнөөлтэй бөгөөд хэрэв баригдвал магадгүй торгуулна. Гэвч эдгээр нь хорт хаягдлыг хортой эсхүл хүний аминд хүрч магадгүй гэдгийг нь мэдсээр байж гол, мөрөн рүү хууль бусаар хаях, эсхүл маш өндөр шатамхай чанартай хорт бодисыг тэдгээрийг хаях зөвшөөрөлгүй хогийн цэг рүү хаяхтай харьцуулбал ач холбогдол багатай зүйл (*АНУ-ын Байгаль орчныг хамгаалах газар (2010)*) юм. Энэ тохиолдолд хувь хүний ч бай, байгууллагын ч бай аль алиных нь үйлдэл рационал сонголт дээр үндэслэсэн байна. Цаг хугацаа, мөнгө зардаг учраас аль аль нь хэрэггүй бараа, эсхүл химийн процессын үр дагавар болох хөнөөлтэй бүтээгдэхүүнийг аюулгүй болгон хаяхыг хүсээгүй хэрэг.

Ихэнх тохиолдолд байгаль орчны бохирдлын хэргийг иргэний журмаар авч үздэг боловч энэ нь гаргасан үйлдэл, бохирдлын хэмжээ, бохирдол үргэлжилсэн хугацаа, нөлөөнд автсан хүний тоо, хувь хүн эсхүл байгууллагын алин болохоос хамаардаг. Байгууллага ба төр нь хууль бусаар бохирдол ялгаруулах, хог хаях, эд хөрөнгө, онгон байгалийг устгах зэргээр ихэвчлэн хамгийн жигшмээр, хөнөөлтэй, голлох байгаль орчны хохирлыг гаргаж (*Payne 2012*) байдаг. Мөн үл тоосны улмаас

хүсээгүй үр дүн гарах ч явдал байдаг. Жишээлбэл, 1989 онд Аляскагийн Виллиам хунтайжийн хоолойд Exxon Valdez хөлөг газрын тос асгасан явдал нь магадгүй архины асуудалтай ахмадыг авч ажиллуулсан явдал болон хэт их ажиллаад ядарсан ажилчдаас болсон болов уу. Тийм ахмад ба ядарсан ажилчдын ажлын үр дүнд болсон осол, хэрэг явдлыг Exxon Mobil компанид ажиллах зарим хүмүүс одоо ч санаатай биш ч рационал хэмээн харж байж болно. Ослын өмнөх үйл явдлуудын гинжин хэлхээс нь байгаль орчны хор хөнөөлийг үүсгэсэн гэж хэлэх бас боломжгүй ч, зардлыг тооцсон рационал сонголтууд нь Exxon Mobil-ийг ийм ослоос сэргийлж чадахгүйд хүргэжээ.

Ийм төрлийн осол гарвал бүхний нүдэнд илэрхий болох боловч ердийн үед хорт хаягдал хаях үйлдэл нь хийхэд хялбар ч, илрүүлэхэд хэцүү байдаг. Хоргүй бодис нь хортой бодистой холилдон хорыг шингэлсэн ч байж (*Dorn et al. 2007*) болно. Хэдийгээр тийм хохиролтой бус ч хувь хүмүүс хууль бусаар хог хаях нь бас л нөлөөтэй байж болно. Учир нь машины дугуй, хөргөгч, барилгын материал нь тухайн хөрсөнд нөлөө үзүүлэх бөгөөд бусад хүнийг ижил үйлдэл хийхэд нөлөөлж, уруу татна. Вилсон, Херрнштайн (*1985*) нарын бүтээл ба хагархай цонхны логик үүнтэй холбоотой. Хагархай цонхны логик нь эмх замбараагүй байдал (ж.нь хагархай цонх)-д анхаардаг бөгөөд хэрэв түүнийг шийдвэрлэхгүй бол илүү их эмх замбараагүй байдал, улмаар ноцтой гэмт хэрэгт хүргэнэ гэж үздэг. Эмх замбараагүй байдал нь илүү ноцтой гэмт хэргийн шууд шалтгаан болохгүй ч бодит гадаад орчныг үл тоож буй учир гэмт хэргээс айх айдсыг нэмэгдүүлж болно. Тэгвэл оршин суугчид нь хөршүүдтэйгээ, хамтын нэгдлээрээ харилцахаа больж эхэлснээр албан бус нийгмийн хяналтын түвшин буурч илүү ноцтой гэмт хэрэгт хүргэнэ. Гадаад орчинд анхаарах, арчлах явдал хангалтгүй байх нь яваандаа тухайн байршил/ хамтын нэгдэл/газарт бусад хүмүүс адилхан хортой, үл тоосон байдлаар хандахыг дэмжинэ. Хувь хүн ба байгууллага хог

ачуулахтай холбоотой зардлаас зугтах буюу хууль бусаар хог хаях нь голчлон эдийн засгийн шалтгааны улмаас үйлдэгддэг ч тийм үйлдэл нь юу хаяснаас хамаараад нутгийн оршин суугчдын эрүүл мэнд, бохирдсон байгаль орчныг цэвэрлэх зардал зэрэг хэлбэрээр нэлээд их эдийн засгийн нэмэлт зардал үүсгэнэ. Тиймээс ийм төрлийн авлига нь үйлдсэн хүмүүс дээр ирэхгүй ч зардалтай байдаг.

Байгаль орчны авлигад эд хөрөнгө, онгон байгалийг хордуулж устгах үйлдэл (*Beirne and South 2013; South and Brisman 2013*) ордог. Жишээлбэл, бизнесийн байгууллага барилга барихаасаа өмнө газраа цэвэрлэж амьдралын орчлыг устгахдаа зөвшөөрөл авах ёстой. Гэхдээ энэ нь улс орон ба хуулийн тогтолцооноос хамаарна. Зөвшөөрөл авахгүй байвал ихэвчлэн санхүүгийн шийтгэл хүлээлгэдэг бөгөөд зарим хуулийн тогтолцоонд саатуулах шийтгэлийн оронд магадгүй ирээдүйд гэрээ хийхгүй байх арга хэмжээ авна. Шийтгэл байна гэвэл энэ нь байгаль орчин аль хэдийн хохирсон үйл явдлын дараа оноогддог. Энэхүү үйлдэл олон улсын шинж чанартай болсноор байдал улам муудаж байна. Газрын тосны салбарынхан ашиг олж, байгаль орчныг бохирдуулахдаа авлигажсан улсуудтай ойрхон ажилладаг. Мэдээлэлгүйгээр, загас барих, хориглосон аргаар хууль бусаар барих, зохицуулагдаагүй, бүртгэлгүй хөлгөөр загас агнах зэргээр амьд эсхүл үхсэн болоод онгон байгалийн юмсыг аль алиныг нь (*Далай ба цаг агаарын үндэсний газрын 2010 оны тайланг үз*) наймаалцдаг. Түүнчлэн олон улс оронд зохион байгуулалттай гэмт хэрэг өдүүлэх, хог хаягдлаа хаях зөвшөөрөл авдаг бөгөөд хогийн цэгийн эздийг хахуульдаж, эсхүл айлгаж хүлээн авах ёсгүй хогийг авахуулдаг байна. Тэд хаягдлаа ус зайлуулах шугам, шуудуу, далай руу хаяж (*Albanese and Pursley 1993*) байна. Гэхдээ энэ бүх үйлдэл нь жишээлбэл, зааны соёоны хууль бус худалдааны хувьд авлигын үйлдлийг гаргаж буй хүн ба бүтээгдэхүүнийг нь худалдан авдаг хүмүүсийн хувьд ашиг

олох эсхүл хууль бус бүтээгдэхүүн олж авах болон хувь хүний таашаал авах зорилгоор хийгдэх рационал үйлдэл юм.

Тэдгээр үйлдэл нь төрийн зохицуулалт ба шийтгэл хязгаарлагдмал байгаагаас болоод улам дордож байна. Авлигажсан албан хаагчид хахууль авч хортой хаягдал хаяхыг зөвшөөрөх, хууль бусаар барилгын ажил хийх, газрын тос олборлох, уурхайн ажил явуулах, мод огтлох, ан амьтан, амьтны гаралтай бүтээгдэхүүн наймаалах явдлыг дэмждэг. Эдгээр нь бүгд л ашгийн төлөө, эсхүл ашгаа нэмэгдүүлэхийн төлөө хийгддэг үйлдэл гэвэл илүү зохимжтой бөгөөд байгаль орчин, хүмүүст хохирол учруулж байдаг. Байгаль орчны хуулийн зөрчил нь санамсаргүй, тохиолдлын шинжтэй бус байнгын, тогтмол шинжтэй оршин байдаг учир ‘нийгэмд загварчлагдсан’ байдаг талаар олон баримт (*Simon 1995:6*) бий. Байгаль орчны гэмт хэргийн эдгээр загвар нь гэхдээ хувь хүний бус байгууллагын авлигын нэг хэсэг юм. Түүнчлэн байгаль орчны гэмт хэрэг бүхий л салбар болон улсад ижил тархсан байдаггүй. Капитализмын төрлөөс үл хамааран капиталист тогтолцоо нь байгаль орчныг зарим талаар сүйтгэх нь зайлшгүй үр дагавартай баялгийн хуримтлалд хүргэдэг. Энэ нь тогтвортой хөгжих сонголтууд бий болсоор байгаа цаг үед байгаль орчны гэмт хэргийг зөвтгөж буй хэрэг биш юм. Улс дотор эрх мэдлийн тэнцвэргүй байдал ба улс хоорондох тэгш бус байдал нь хүчирхэг байгууллагууд авлигажсан тогтолцоотой хамтран ажиллах эсхүл ашгийн төлөө бие даан үйл ажиллагаа явуулахад хүргэдэг. Жишээлбэл, АНУ-д улсын болон орон нутгийн хэмжээнд удирдах албан тушаалтнууд нь байгаль орчныг хамгаалах зохицуулалтыг эсэргүүцэж ирсэн ч байгууллагын хувьд үүнээс эдийн засгийн ашиг ологчдыг хүлээн зөвшөөрч ирсэн (*Gedicks 1993; Hurley 1995*) байна.

Эрдэс баялаг тухайлбал, голчлон газрын тосноос хамаарах хамаарал нь ихэвчлэн эдийн засгийн хөгжлийн хараал болж таардаг агаад ширүүн зөрчилдөөн, мухардмал ардчилал,

авлигын өсөлтийг дагуулна. Байгалийн нөөц нь Нигер зэрэг улс шиг газрын тос олохоосоо өмнөх амиа аргацаасан эдийн засагтай явж ирсэн улсад ивээн тэтгэх улс төрийг хүчирхэгжүүлж байх шиг харагддаг. Баялгийн хараал нь нарийн төвөгтэй үзэгдэл юм. Авлигажсан улс төрийн тогтолцоотой, газрын тосоор баялаг улсууд нь байгаль орчиндоо хохирол учруулангаа өөрийн газар нутгаас газрын тос гаргадаг бөгөөд өөрийн хүн амаас дагалдах эх үүсвэрийг гаргаж (*Shaxson 2007*) авдаг. Энэ асуудал нь Ойрх дорнод, Бразил, Мексик, Венесуэл, Иранд газрын тосны орлогын (*эсхүл газрын тосны компанитай тохиролцсон хувийг*) хуваарилалтыг төр мэдэлдээ авч хянадаг, газрын тосны үндсэрхэг үзлийн (*oil nationalism*) улмаас улам дорддог байна. Газрын тосны салбарт үндсэрхэг үзэл нэмэгдэх нь нийгмийн олонхийн ядуурлын бурууг үндэсний дотоод улс төр рүү чихэхэд хангалттай тусалжээ. Гэхдээ эдгээр улсын олонх нь газрын тосыг олборлох мэдлэг, ур чадвар, технологи дутуу бөгөөд амжилтад хүрэхэд туслалцаа шаардлагатай (*Coll 2012*) байдаг. Тиймээс тэдгээр улс колонийн захиргаанд байхаа больсон ч одоог хүртэл гадаад тусламж, эсхүл оролцооноос хамааралтай, хувийн газрын тосны байгууллагууд нь тогтоосон ашгийн хувийг хүртэж чадахгүй бол туслалцаагаа татаж авах байр сууринд (*Brooks et al. 2013*) байдаг. Түүнчлэн газрын тосны салбар төлбөрийг нь төлдөг нийгмийн хөтөлбөрүүд нь үл мэдэгдэх хэмжээний буюу гадаадын хэвлэлүүдэд зориулсан өөрийгөө сурталчлах төдий ажилтай байдаг. Газрын тосны компани өөрөө ашиглах буюу газрын тос тээвэрлэх дэд бүтэц биш л бол дэд бүтцэд зарцуулсан мөнгө нь мөн л маш бага байдаг (*Coll 2012*) аж.

Газрын тостой олонх улс нь үндэстэн угсаатны хувьд янз бүр, иргэний дайн болох өндөр магадлалтай, туйлын ядууралтай, ивээн тэтгэх улс төртэй, хөрш улсуудын түрэмгийлэлд өртөх аюултай гэсэн олон асуудалтай тулгарсан байдаг. Байгаль орчны бохирдол нь олон эрүүгийн үйлдлийн зөвхөн нэгхэн хэсэг нь

байдаг. Баялгийн хараал нь тэгэхээр эдийн засаг, улс төр, аюулгүй байдлын олон асуудалтай холбоотой юм. Нөөцөөс хамааралтай улсууд нь ихэвчлэн хэт их институцийн консерватизм (*хадгалах үзэл*) ба төрийн үйл ажиллагаа бус төсвийн гуйвуулгаас хамаарсан тогтвортой байдлын инерцтэй (*Leander 2005*), (*Karl 1997; Leite and Weidmann 1999; Ross 1999; Auty 2001; Ross 2001*) байдаг. Түүнчлэн, тийм тогтворгүй байдлын улмаас, мөн ихэвчлэн хувийн болон гэр бүлийн аюулгүй байдлын төлөө хүмүүс нэлээд орлогоо төрд зарах ёстой болдог аж. Байгалийн нөөцийн их хэмжээний орлого нь зарим улсад нийгмийн амгалан тайван байдал, улс төрийн эсэргүүцэл, цэргийн хүчийг худалдан авах замаар тогтвортой дарангуйллын тогтолцоог хадгалах боломжийг олгодог байна. Эдгээр нөхцөлийн улмаас зарим эрх баригчид газрын тосыг аль болох хурдан олборлодог бөгөөд энэ нь эрх мэдлээ алдахаас айсны улмаас байгаль орчныг сүйтгэх болон хөрөнгө оруулалт хэрэгтэй байгаа улсаас хөрөнгөө олон улсын санхүүгийн тогтолцоогоор дамжуулан гарган авахад хүргэнэ. Тэгэхээр баялгийн хараал нь иргэдийн эрхийг зөрчиж, дүрэм журам, тогтолцоо, институцэд итгэх олон нийтийн итгэлийг үгүй болгож, байгаль орчныг сүйтгэдэг (*Shaxson 2007*) ажээ.

Эдгээр үйлдлийн үр дагавар нь олон янз байдаг. Ихэнх хүмүүс өвчин, эмгэг тусах, амь насаа алдаж асуудал оройтох хүртэл хохирогч болж байгаагаа мэддэггүй. Байгаль орчны гэмт хэрэг хортой химийн бодистой хүрэлцсэнээс шууд физик гэмтэл учрах, ирээдүйд эрүүл мэндийн асуудал гарах, ирээдүйд гэмтэх айдсаас үүдэн сэтгэл гутрах, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаа нь тасалдах, хөрөнгө ба экологи сүйрэх шалтгаан болж (*O'Hear 2004; Payne 2012 Beirne and South 2013; South and Brisman 2013*) болно. Ядуу, хөгжиж буй улсууд болон чинээлэг улсын ядуу хэсэгт багтдаг хувь хүмүүст очих зардал их байдаг. Үүнийг байгаль орчны ялгаварлан гадуурхалт гэж нэрлэдэг ба тодорхой гарал үүсэлтэй хүмүүс, ялангуяа АНУ-

д, байгаль орчны гэмт хэргийн хорт нөлөөнд хэрхэн автаж байгааг тодруулахад хэрэглэгдэж байна. Ширүүн өрсөлдөөний соёлын үүсгэх зардлыг Каролина дахь үерийн дараах сайртай газраас харж болно. Тэнд гэр бүлийн фермерүүдийг хурдацтай нэгтгэсэнээр өөр газарт ажил хийх боломж багатай хүмүүс газраасаа салжээ. Махны үйлдвэрлэлийг үйлдвэржүүлснээр голчлон африк гаралтай америкчуудыг нийгмийн халамж авч, малын баас, шивтэр, ус төрөгчийн сульфид, мах ихээр үйлдвэрлэхэд үүссэн цууны ба тосны хүчил холилдсон хаягдалтай газарт амьдрахад хүргэсэн (*Hefferman 2014*) аж.

Түүнчлэн байгаль орчны гэмт хэрэг нь хамтын нэгдэлд өөр ч зардал үүсгэнэ. Үүнд амьдралын чанар буурах, хөрөнгийн үнэ буурах зардал багтах ба ‘хамтын нэгдлийн ёс суртахууны суурь’-ийг ч элэгдүүлдэг (*Kramer 1984:8*) байна. Эдгээр зардлыг тоогоор илэрхийлэх боломжгүй боловч байгаль орчны гэмт хэргийн нөлөө туйлын өндөр юм. Иргэний ба эрүүгийн ийм төрлийн зөрчлийн шинж чанарын улмаас зардал нь мэдэгдэхгүй, судалгаа нь ч үйл явдлын дараа хийгдэх хандлагатай байдаг. Барууны орнуудад маш их бохирдолтой цэгүүдийн хооронд байрлах газрын агаар, ус цэвэр болохын хэрээр байгаль орчны гэмт хэрэг ч өөрчлөгдөж байна. Хятад зэрэг дэлхийн бусад орнуудад байдал Үйлдвэрлэлийн хувьсгалын дараа гол мөрөн, агаар, хөрс бохирдож, улмаар хүний амь нас эрсдэж байсантай адил байна.

Байгаль орчныг сүйтгэх үйлдлийг бууруулах нэг аргачлал нь 1980 онд батлагдсан Байгаль орчны цогц хариу үйлдэл ба хариуцлагын хууль (*Супер сангийн хууль гэх нэрээр танигдсан*) юм. Тус хуульд 1986 онд нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд энэ өөрчлөлтөөр АНУ-ын хамгийн муу хяналттай хорт хаягдлыг хаях цэгийн асуудлыг шийдэхийг (*Нью-Йоркийн Хайрын сувгийн жишээг хар; Payne 2012*) зорьжээ. Байгаль орчныг хамгаалах газраас хортой хогийн цэгийг цэвэрлэх ажлыг янз бүрийн эх үүсвэрээс санхүүжүүлдэг. Үүнд шатахуун-

химийн үйлдвэрлэлээс авах татвар, тогтоогдсон хэрэгтнүүдэд хууль хэрэгжүүлэхэд төсөвлөсөн зардал зэрэг багтана. Хууль хэрэгжүүлэлт нь хатуу хариуцлагатай байх урьдач нөхцөл дээр үндэслэдэг бөгөөд Супер сангийн цэгүүдэд үл тоосон, эсхүл хогийн цэгээ ажиллуулаагүй байснаас хортой нөхцөл байдлыг үүсгэсэн хүмүүсээс хариуцлага нэхдэг. Гэхдээ хогийн цэгийг цэвэрлэх үүрэг хариуцлагыг хуваах боломжгүй үед хариуцлагын харьцаанаас үл хамааран хариуцах этгээд бүрээс нийт зардлыг нэхэмжилж болно. Хорт хаягдлыг хаях цэгийг худалдан авч, зарж байдаг тул зарим тохиолдолд хэн хариуцлага алдсан болохыг тогтооход хэцүү байдаг. Энэ нөхцөлд шатахуун-химийн байгууллагууд хогийн цэгийн бүртгэлийг судлаад буруутгах эсхүл хариуцлага нэхэх өөр байгууллагыг хайдаг байна. Тухайлбал Монсанто компани өөр 20 хариуцагч ‘партнер’ олсноор 40 сая долларын торгуулиа 40% (*Payne 2012:432*) бууруулжээ.

Хэрэв байгууллага хогийн цэгийг цэвэрлэх зардлыг төлөхөөс татгалзвал Байгаль орчныг хамгаалах газар төлөөд зардлыг нөхөн төлүүлэх, зардлыг гурав нугалсантай тэнцэх торгууль оногдуулах зарга мэдүүлдэг. Бүх торгуулийг Супер санд төвлөрүүлэх ч аливаа зохицуулах тогтолцоотой адилаар хууль хэрэгжүүлэх аргачлал нь ялгаатай байдаг. Байгаль орчныг бохирдуулсан сэжигтэн нь химийн хувьсгалын ач тусыг бүх хүн хүртэж буй учир бүгд хувь нэмрээ оруулах ёстой гэж маргах нь тухайн үйлдвэрлэлд өргөн хүрээтэй татвар ногдуулахыг дэмжих болно. Шатахуун-химийн байгууллагууд өмгөөллийн зардлаа төлж чадах учир зөрчил үүсгэлгүйгээр дагаж мөрдүүлэх стратеги, эсхүл хогийн цэгийг цэвэрлэх төлбөрийг төлөөд дараа нь байгууллагаар нөхөн төлүүлэх, эсхүл хүч хэрэглэж хэрэгжүүлэх нь Байгаль орчныг хамгаалах газрын тактикийн асуудал болно. Гэхдээ Эрчим хүч, Батлан хамгаалах яамны хувьд өөрсдийн хорт хаягдлаа хаях цэг нь мөн л асуудалтай байдаг учир хорт хаягдал хаях нь зөвхөн хувийн хэвшлийн асуудал

биш юм. Зарим байгууллагууд хортой химийн бодисыг хаях асуудал дээр ёс зүйн хэмжүүр байхгүй гэсэн гомдол үүсгэдэг нь магадгүй эргэлзээгүй байх. Гэхдээ тэр бүх гэмт хэрэг нь зөвхөн ашгийг зорилгоо болгосон рационал үйлдэл байдаг.

Байгаль орчны гэмт хэрэг нь дэлхий нийтэд төрөл, хэмжээ, нөлөөгөөрөө ялгагддаг боловч тэдгээрийг холбодог зүйл нь зохицуулалт муутай, хүн ам болон байгаль орчны хамгаалалт султай улсад бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хогоо аль болох хямдаар хаях рационал сонголт байдаг. АНУ нь өөрийн хорт хаягдлын ихэнхийг мэдээлэх үүргээс чөлөөлж, цэргийн цөмийн хаягдлыг орон нутгийн иргэдэд ойр хадгалах болсноор энэ асуудал бүр ч дордсон гэж Засгийн газрын Аудитын алба үзсэн байна.

Гэхдээ татвар төлөгчид нь хууль хэрэгжүүлэх зардлыг төлөх, байгаль орчны бохирдлыг сэргээх шаардлагатай болно. Хорт хаягдал хаях үйлдэл нь байгаль орчныг сүйтгэхээс гадна хэрэв илэрвэл санхүүгийн төлбөр төлж, ажиллах хүчээ цөөлөхөд (*Barnett 1981*) хүргэнэ. Авлигын үйлдэлд ямар ч оролцоо байхгүй хүмүүс бохирдсон газарт, ажил олж хийж чадалгүй, эрүүл мэндээрээ хохирон амьдарч байж магадгүй. Тийм эрүүгийн болон иргэний авлигын хэрэг үйлдэх рационал сонголтын эдийн засгийн зардал нь өргөн хүрээтэй, тодорхойгүй, хүн ам буюу хорт хаягдлын нөлөөнд өртөж буй хүмүүс болон хууль хэрэгжүүлэх зардлыг төлж буй хүмүүст нөлөөлнө. 1990-ээд онд илүү их бохир, хортой хаягдлыг дэлхийн ‘хөгжил багатай’ хэсэг рүү шилжүүлэхийг дэмжсэн Дэлхийн банкны ажилтны дотоод тэмдэглэл олон нийтэд ил болж байсан нь энэ үзэлд итгэх итгэлийг илүү хялбар (*Rosen 1994:226*) болгожээ.

Олон улсын эрчим хүчний байгууллага дэлхий нийтээр байгалийн гаралтай түлш (*fossil fuel*) олборлох, хэрэглэхэд 490 тэрбум долларын татаас өгч байна хэмээн баримжаалжээ. Энэ татаасыг цэвэр эрчим хүч, эрүүл мэнд, боловсролд зарцуулах замаар шат дараатай байхгүй болгохыг уриалдаг

боловч хөгжиж буй улсууд шууд татаасын ихэнхийг өгч байгаа бөгөөд ингэж шилжих ёстой гэдгийг тэдэнд итгүүлэхэд хэцүү. Татаас өгснөөр түлшний үнийг бага байлгахад нөлөөлдөг. Энэ нь дэлхий нийтийн хэрэглэгчдэд таалагддаг ч зарим улсад шатахууны үнэ хэт бага, жишээ нь 2015 оны байдлаар Венесүэлд галлон шатахууны үнэ 2 цент (Schwartz 2015:7) байсан бөгөөд үнийг өсгөвөл улс төрийн хувьд амиа хорлосон хэрэг болох байв. Гэхдээ газрын тосны үнэ бага хэвээр байхад 2016 онд Венесүэлд төрийн татварын орлогыг нэмэгдүүлэхийн тулд шаталт өндөртэй шатахууны үнийг литр нь 0.60 доллар болгон өсгөжээ. АНУ зэрэг хөгжингүй орнууд бас байгалийн гаралтай түлшинд бага татвар оноож үнийг нь бага байлгадаг. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага хайгуул ба үйлдвэрлэлийг мөшгөж үзээд үйлдвэржсэн улсууд татвар төлөгчдийн мөнгийг дор хаяж 800 янзаар байгалийн гаралтай түлш үйлдвэрлэхэд зарцуулж байна хэмээн тооцсон байна. ОУВС эрчим хүч, эрүүл мэнд, байгаль орчин, цаг уурын өөрчлөлтийн зардлыг оруулаад 5.3 тэрбум доллар буюу дэлхийн ДНБ-ий 6.9 хувьтай тэнцүү татаас өгч байгааг тогтоожээ. Тэдгээр татаас нь байгаль орчны бохирдлыг муутгаж, нүүрс ба газрын тосны салбарт онцгой давуу тал олгож, эрчим хүчний бусад эх үүсвэрийг худалдан авахад хүндрэлтэй, удаан үргэлжлэх энергийн тогтолцоонд шилжих боломжгүй болгож байна. Цаг уурын өөрчлөлтийг тооцохгүй байсан ч тэдгээр татаасаар байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх талаар бага зүйлийг хийж байна. Байгалийн гамшиг нь хохирлыг нь дааж гарахад хүндрэлтэй хүмүүст ихээр нөлөөлдөг юм.

Дүгнэлт

Энэ бүлэгт рационал сонголтын онол авлигын зарим үйлдлийг хэрхэн тайлбарлахад хэрэг болдог талаар онцлон үзлээ. Хэдийгээр энэ онол нь голчлон гудамжны гэмт хэргийг тайлбарлахыг зорьдог ч байгаль орчны гэмт хэргийг ойлгоход

тус болно. Онолын энэ аргачлалд хязгаарлагдмал талууд байдаг боловч ослыг тооцохгүйгээр хорт хаягдлыг газарт, далайд, эсэргүүцэх чадваргүй хүн ам, хамтын нэгдэл, улсад хаях нь рационал сонголт болно. Байгаль орчны гэмт хэргээс сэргийлэх явдлыг ардчилсан улсад байгаль орчныг хамгаалах хууль батлахыг зогсоож, батлуулахгүй байх лобби хийснээр муутгадаг бол улс төрийн тогтолцоо нь ивээн тэтгэх болон гэр бүлийн харилцаанд суурилсан газрын тосоор баялаг улсуудад энэ нь бүр ч илүү муу байдаг ажээ. Түүнчлэн, татвар төлөгчдийн мөнгийг байгаль орчны бохирдол гаргаж, ашиг орлогоо нэмэгдүүлэхийг зорьсон дур зоргоор аашлах байгууллагын учруулсан гамшгийг засах гэх мэт зүйлд зарцуулснаар хууль хэрэгжилт үр дүнгүй болж байна. Тийм болохоор рационал бөгөөд авлигажсан байдлаар үйл ажиллагаа явуулах нь аргагүй юм. Өөрөөр хэлбэл байгаль орчны авлига нь ашигтай бөгөөд илэрсэн тохиолдолд ихэвчлэн санхүүгийн шийтгэл хүлээх ч энэ нь олсон ашгаас бага байна. Байгаль орчин буюу газар нутаг, агаар, далай сүйдсэн ч хувь хүн ба байгууллагууд хүн амын эрүүл мэнд болон байгаль орчны золиосоор санхүүгийн үр ашгийг хүртсээр байхыг зөвшөөрч, ирээдүйн бохирдлын үрийг тарьсаар байна.

Ашигласан материал

- Albanese, J., & Pursley, R. D. (1993). *Crime in America: Some existing and emerging issues*. Englewood Cliffs, NJ: Prentice Hall.
- Auty, R. (2001). *Resource abundance and economic development*. Oxford: Oxford University Press.
- Barnett, H. C. (1981). Corporate capitalism, corporate crime. *Crime and Delinquency*, 27 (1), 4–23.
- Beirne, P., & South, N. (2013). *Issues in Green Criminology*. Abingdon: Routledge.

- Brooks, G., Walsh, D., Lewis, C., & Kim, H. (2013). *The prevention of corruption: Investigation, enforcement and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Clarke, R. (1980). Situational crime prevention. *British Journal of Criminology*, 20 (2), 136–147.
- Cohen, S. (1985). *Visions of social control*. Cambridge: Polity Press.
- Coll, S. (2012). *Private empire: Exxon mobil and American power*. London: Allen Lane.
- Cornish, D., & Clarke, R. (1986). *The reasoning criminal: Rational choice perspective on offending*. New York: Springer.
- Currie, E. (1991). The politics of crime: The American experience. In K. Stenson & D. Cowell (Eds.), *The politics of crime control*. London: Sage.
- Dorn, N., Van Daele, S., & Vander Beken, T. (2007). Reducing vulnerabilities to crime of the European waste management industry: The research base and the prospects for policy. *European Journal of Crime, Criminal Law and Criminal Justice*, 15 (1), 23–36.
- Gedicks, A. (1993). *The new resource wars: Native environmental struggles against multinational corporations*. Boston: South End.
- Halsey, M. (1997). The wood for the paper. *Australian and New Zealand Journal of Criminology*, 30 (2), 121–148.
- Hefferman, M. (2014). Fishing with dynamite. *New Statesman*, pp. 35–37.
- Hirschi, T. (1969). *Causes of delinquency*. Berkeley, CA: University of California Press.

Авлигын криминологи

- Hurley, A. (1995). *Environmental inequalities: Class, race and industrial pollution in Gary, Indiana, 1845–1980*. Chapel Hill, NC: Univeristy of North Carolina Press.
- Jones, S. (2006). *Criminology* (3rd ed.). Oxford: Oxford University Press.
- Karl, T. L. (1997). *The paradox of plenty: Oil booms, Venezuela and other petrostates*. Berkeley, CA: University of California Press.
- Kramer, R. C. (1984). It corporate crime serious crime? Criminal justice and corporate crime control. *Journal of Contemporary Criminal Justice*, 2 (6), 7–10.
- Leander, A. (2005). The market for force and public security: The destabilizing consequences of private military companies. *Journal of Peace Research*, 42 (5), 605–622.
- Leite, C., & Weidmann, M. (1999). *Does mother nature corrupt? Natural resources, corruption and economic growth* (Working paper WP/99/85). Washington, DC: IMF.
- Lilly, R. J., Cullen, F. T., & Ball, R. A. (2015). *Criminological theory: Context and consequences* (5th ed.). Thousand Oaks, CA: Sage Publications.
- Martinson, R. (1974). What works?-Questions and answers about prison reform. *The public interest*, 1 (35), 22.
- National Oceanic and Atmospheric Administration. (2010). *New federal rule allows NOAA to deny port entry to illegal fishing vessels*: Press release, October, 13, 2010. Washington: US Dept. of Commerce.
- O’Hear, M. M. (2004). Sentencing the green dollar off ender: Punishment, culpability, and environmental crime. *Journal of Criminal Law and Criminology*, 95 (1), 133–276.

- Payne, B. K. (2012). *White collar crime: A Text/Reader*. Thousand Oaks, CA: Sage Publications.
- Rosen, R. (1994). Who gets polluted: The movement for environmental justice. *Dissent*, Spring, 223–230.
- Ross, M. L. (1999). The political economy of the resource curse. *World Politics*, 51 (2), 297–322.
- Ross, M. L. (2001). Does oil hinder democracy? *World Politics*, 53 (3), 325–361.
- Schwartz, J. (2015). On tether to fossil fuels, countries speak using money. International New York Times, Monday, December 7, 7.
- Shaxson, N. (2007). Oil, corruption and the resource curse. *International Affairs*, 83 (6), 1123–1140.
- Simon, D. R. (1995). *Social problems and the sociological imagination*. New York: McGraw-Hill.
- South, N., & Brisman, A. (2013). Routledge international handbook of green criminology. Abingdon: Routledge.
- United States Environmental Protection Agency. (2010). *Environmental justice*. Washington, DC: EPA.
- Walklate, S. (1998). *Understanding criminology*. Buckingham: Open University Press.
- Wilson, J.Q., & Kelling, G.L. (1982). Broken windows, in R.G. Dunham (ed) *Critical issues in policing: Contemporary readings*, pp. 395-407. Chicago, Illinois Waveland Press.
- Wilson, J. Q., & Herrnstein, R. (1985). *Crime and human nature*. New York: Simon and Shuster.
- Wilson, J.Q., & Kelling, G.L.(1989). Making neighborhoods safe. *Atlantic Monthly*, 263(2), 46–52.

Авлигын криминологи

Young, J. (1994). Incessant chatter: Recent paradigms in criminology.
In M. Maguire, R. Morgan, & R. Reiner (Eds.), *The Oxford handbook of criminology*. Oxford: Oxford University Press.

XI

Авлигыг тайлбарлах нь: 'Бизнесийн' хэвшсэн үйл ажиллагаа юу?

Удиртгал

Авлигыг тайлбарлах зорилгоор боловсруулагдаагүй ч авлигыг тайлбарлах боломжтой баруун реализмын хүрээнд багтах онолын аргачлалуудыг энэ бүлэгт авч үзнэ. Гэмт зан үйлийг тайлбарлахыг эрэлхийлсэн хэвшмэл үйлдлийн (*routine activity*) талаарх онолууд нь Х бүлэгт авч үзсэн Вилсон, Херрнштайн (*Wilson and Herrnstein 1985*) нар, Кларке (*Clarke 1980*), Корниш, Кларке (*Cornish and Clarke 1986*) нарын бүтээлтэй адил төстэй нийгэм, улс төрийн нөхцөл байдал дунд боловсруулагджээ. Энэ бүлэгт Коэн, Фелсон (Cohen and Felson 1979) нарын бүтээлд голчлон анхаарах боловч холбогдох бусад бүтээлийг ч эшлэх болно.

Гэмт хэрэг хэвшмэл зүйл болох нь: Байдаг л нэг зүйл үү?

Гэмт хэргийг тайлбарлах явдал нь биологийн болон сэтгэлзүйн, социологийн байр сууринд баригдсан байсныг энэхүү онол нь аргачлалын зүгээс ихээр шүүмжилж байв. Ингэснээр эрүүгийн шүүн таслах бодлого болон урьдчилан сэргийлэхэд ч нөлөөлжээ. Урьдчилан сэргийлэх тухайд тэдгээр байр суурийн аргачлал нь хэт өргөн хүрээтэй боловч мөн түүний зэрэгцээ гэмт хэрэг нь цөөн тооны идэвх өндөртэй, гэмт хэрэг хийх хандлагатай хувь хүний л хийдэг зүйл гэж үздэг. Гэвч гэмт хэргийг янз бүрийн нийгмийн гарал бүхий олон хүмүүс үйлддэг. Тиймээс эрүүгийн шударга ёсыг тогтоох нэрийн дор хувь хүний зан чанар, биологийг өөрчлөх хүлээн зөвшөөрөгдөх арга зам бий хэмээн үзэж, түүнд үндэслэн гэмт хэргээс сэргийлэх, бууруулахыг оролддог байр сууринд энэ аргачлал шүүмжлэлтэй хандаж байдаг. Мөн энэ аргачлал нь хүүхдүүдийг нийгэмшүүлэх, ядуурлыг устгах, залуу хэрэгтнүүд зөрчил гаргадаг насан дээрээ байгаа эсэхэд санаа зовохын оронд илүү практик талтай. Олон жилийн өмнөх сэтгэлзүйн үйл явдал ба нийгмийн процесст анхаарахын оронд хувь хүний нөхцөл байдал, орчин, өмнө нь байгаа сонголтод анхаарах нь дээр гэж үздэг. Энэ онол дахь илэрхий нэг асуудал нь зарим цочмог, сэтгэл хөдлөлийн гэмт хэрэг, согтууруулах ундаа эсхүл хууль ёсны ба хууль бус мансууруулах бодис, мөн сэтгэл санааны шокын нөлөөгөөр үйлдэгдсэн гэмт хэргийг рационал болон хэвшмэл хэмээн тайлбарлахад хэцүү байдагт оршдог. Хэрэгтний субъектив үнэлгээ гэх зүйл нь нөхцөл байдлын шууд хувьсагчид болоод гэмт хэрэг үйлдэх бидний сонголтод нөлөөлөх гадаад бодит орчинд анхаардаг учир тайлбарлах ач холбогдлоор хязгаарлагдмал байдаг.

Хэвшмэл үйлдэл нь анх Хавлейгийн (*Hawley 1950*) хүний экологийн онолоос (*human ecology*) үүссэн ба уг онол нь

11 Авлигыг тайлбарлах нь: 'Бизнесийн' хэвшсэн үйл ажиллагаа юу?

хамтын нэгдлийн орчин дахь хүний зан үйлийн цаг хугацааны талыг авч үзсэн аж. Хавлей хүний хамтын үйл ажиллагааны гурван түлхүүр талыг тодорхойлжээ. Үүнд: хэмнэл (*үйл явдлын ердийн давтамж*), темп (*тодорхой цаг хугацаан дахь үйл явдлын тоо*), цагаа оносон байдал (*орчин нөхцөл дэх зан үйлийн зохицуулалт ба огтлолцол*). Коэн, Фелсон (1979) нар эдгээр зарчмыг өөрчилж, гэмт хэрэг нь цаг хугацаа, орон зайг хослуулсан гурван хүчин зүйл буюу сэдэлжсэн хэрэгтэн (*motivated offender*), болзошгүй хохирогчтой (*potential victim*) байх, чадамжтай асран хамгаалагч (*capable guardian*) байхгүй байхын үр дүн гэсэн үзлийг гаргаж тавьжээ. Энэ аргачлал нь гэмт хэрэг хэзээ гарах вэ гэсэн тодорхой таавар бус гэмт зан үйлийн магадлалыг санал болгодог гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Сэдэлжсэн гэмт хэрэгтэн, тохиромжтой бай (*suitable target*), бодит хохирогч, эсхүл хохирогчийн эд зүйл хажууд байх, хамгаалагчгүй байсан ч гэсэн гэмт хэрэг зайлшгүй гарна гэсэн үг биш. Харин онолын энэ аргачлалаар гэмт хэргийн магадлал нь эдгээр гурван хүчин зүйл байгаа эсэхэд үндэслэн өсөж, эсхүл буурна гэж үздэг. Тэд гэмт хэргийн хандлагыг улс орон, газар нутгийн тодорхой хэсэг, эсхүл тодорхой гэмт хэрэгтний түвшинд буюу макро, микро түвшинд шинжилж үзээд юу тохиромжтой 'бай' мөн эсхүл биш байх вэ гэдэг нь хэрэгтний төсөөлөл, сонирхлоос хамаардаг хэмээн дүгнэжээ. Мөн Коэн, Фелсон (1979) нар эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт өсөж, гэртээ өдөржингөө байдаг хүний тоо цөөрсөн зэрэг нийгмийн гол өөрчлөлт нь тохиромжтой байны тоонд нөлөөлсөн гэж үзсэн байна.

Эдгээр гурван хүчин зүйлийг бидний өдөр тутмын амьдрал, хэвшлээс олж болох бөгөөд гэмт хэрэг гарах хүрээг бидэнд санал болгоно. Гэмт хэргийн давтамж нь

- (1) амжилтад хүрэх магадлал буурсан,
- (2) боломжит үр ашиг буурсан,

(3) болзошгүй зардал нэмэгдсэн тохиолдолд буурна гэж (*Cohen and Felson 1979*) үздэг. Хэрэв болзошгүй эсхүл бодит гэмт хэрэгтнүүдийн өмнөх оролдлого амжилттай болж, шийтгэлээс зугтаж чадсан бол тэд ахин хэрэг үйлдэх илүү (*Dugan et al. 2005*) магадлалтай. ‘Хэвшмэл үйлдэл’ гэдэгт хүн ам ба хувь хүмүүс хэрэгцээгээ хангахын тулд давтан үйлддэг аливаа үйлдлийг багтаан (*Gottfredson 1981*) ойлгоно. Гэмт хэрэг ба түүний хохирлыг тайлбарлах гол түлхүүр хувьсагч нь тэгэхээр хүмүүсийг гэмт хэрэг гаргах орчинд тогтмол аваачсанаар заримдаа гэмт хэрэг хийх боломжтой болгодог нийгмийн амьдралын цар хүрээ юм (*Garland 1999*). Эдийн засгийн онолын нэр томъёогоор гэмт хэрэг нь гэмт үйлдэл хийх завшааны үр дүн буюу нийлүүлэлтийн тал гэж үзэж болох боловч энэ нь гэмт хэрэг хийх хүсэл буюу эрэлтийн талыг тайлбарлаж чаддаггүй.

Гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг тайлбарлахдаа эдгээр аргачлал нь гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг эрүүгийн талаас ойлгоход нь цаг хугацаа, орон зайг чухал хүчин зүйл гэж хослуулан авч үзэхийг оролддог. Гэмт хэргийн нөхцөл байдлын тал, ялангуяа орон зайд анхаараад үзвэл гэмт хэрэг нь бидний нийгмийн байгууллын салшгүй зүйл болж (*Garland 1999*) харагдана. Коэн, Фелсон (*2003*) нар хууль бус үйлдэл нь бусад үйлдэл дээр суурилдаг учир үйлдлийн орон зай, цаг хугацааны бүтэц нь хууль бус үйлдлийн байршил, төрөл, тоо хэмжээг тогтооход чухал үүрэг гүйцэтгэх учиртай гэсэн. Энэ нь хүмүүс хүрээлэн буй орчин дотроо хоорондоо хэрхэн харилцдаг ба гэмт хэргийн тохиолдлыг дээр дурдсан гурван суурь бүрэлдэхүүн хэсгийн харилцан үйлчлэлээр хэрхэн бууруулж болох вэ гэдгийг харуулах нэг төрлийн экологийн аргачлал юм. Энэхүү ‘гэмт хэргийн шинж чанар’ ба бүрэлдэхүүн хэсгүүдийн хослол нь голчлон гэмт хэргийн халуун цэгт цагдаагийн идэвхтэй тактик явуулах болон хамтын нэгдлийн орчныг гэмт хэргийг бууруулах чиглэлд хувиргахад (*Sherman 2004*) хэрэглэгдэнэ. Халуун цэгийг цагдах талаарх судалгаа улс төрийн их дэмжлэг,

ялангуяа АНУ-д дэмжлэг (*Crow and Bull 1975; Pierce et al. 1986; Sherman et al. 1989; Weisburd et al. 1992; Sherman and Weisburd 1995; Taylor 1997; Sherman et al. 1997; Brantingham 1999; Braga et al. 1999; Roncek 2000; Eck 2002; Ratcliff e 2004; Weisburd et al. 2006; Braga and Bond 2008*) авчээ. Гэсэн хэдий ч цагаан захтануудын гэмт хэрэгт бус гудамжин дахь гэмт хэрэгт ихэвчлэн анхаарчээ. Рационал сонголтын онолтой адилаар энэ онол ч бас авлигын үйлдэлд бус хүрээлэн буй орчин дахь гудамжны гэмт хэргийг авч үзэхдээ голчлон хүчирхийлэл, эсхүл хүчирхийллийн заналд голчлон анхаарсан байна.

Чадамжтай асран хамгаалагч нь сэдэлжсэн гэмт хэрэгтэн хажууд нь байсан ч гэсэн гэмт хэргээс болиулах, эсхүл урьдчилан сэргийлэх бололцоотой. Гэхдээ чадамжтай асран хамгаалагч гэдэг нь янз бүрээр тайлбарлагдахаар өргөжиж болох ойлголт юм. Цагдаагийн албан хаагч болон бусад төрлийн хууль сахиулагч зэрэг албан ёсны асран хамгаалагч нь улс орон, хуулийн тогтолцооноос хамааран гэмт хэрэг ба хохирлоос хамгаалах албан ёсны бэлэг тэмдэг болдог. Хууль хэрэгжүүлэгч нь бүх хүнийг бус зөвхөн зарим хүмүүсийг гэмт хэрэг хийхээс түдгэлзүүлдэг бөгөөд хэрэв ил харагдах замаар гэмт хэргээс амжилттай урьдчилан сэргийлж чадна гэвэл тэр нь урьдчилан сэргийлэх бус зөвхөн хойшлуулж л буй хэрэг юм. Хууль сахиулагч байх нь гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлж болох ч энэ нь бодит баримт бус таамаглал юм. Илүү албан бус агуулгаар чадамжтай асран хамгаалагч гэдэгт хамтын нэгдэл доторх тодорхой газрын оршин суугч иргэд ч багтаж болно. Коэн, Фелсон (*1979*) нар иргэд цагдаагаас илүүгээр нийгэмд асран хамгаалах байр суурь үзүүлдэг яагаад гэвэл тухайн байршилд буй иргэдээс цөөн цагдаагийн албан хаагч эргүүлд гардаг гэжээ. Гэхдээ хөршийнхөн нь өөрийн илүүдэл хүчээ ойр орчмоо цагдахад ашиглавал асуудал болох (*Johnston 1996*) магадлалтай. Зөвхөн хүмүүс асран хамгаалах үүргийг

гүйцэтгэдэггүй. Өөрөөр хэлбэл гэмт хэргээс сэргийлэхэд бас камер болон хулгайн дохиоллын технологийг ч ашигладаг.

Энэ онолоор ихэнхдээ ‘амьдралын хэв маяг’-ийн буюу бид юу хийдэг, хаана амьдардаг, хэнтэй харьцдаг гэдэг талаар авч үзэж байна. Ялангуяа хохирлын бүрэлдэхүүн хэсгийн талаар хэв маяг гэж авч үздэг. Энэ аргачлалын онцлог шинж нь хэрэгтнийг онцлохоо больж анхаарлаа бай ба асран хамгаалагч руу чиглүүлдэгт оршдог. ‘Бай’ гэдэг нь хэрэгтний авахыг хүссэн эд хөрөнгө, эсхүл хянахыг хүсэх хүн юм. Гэмт хэргийн үйлдлийн биет шинж чанарыг тодотгодог учраас хохирогч гэхийн оронд ‘бай’ гэсэн нэр томьёо хэрэглэгдэж байна. Хохирлыг хохирогч хэрэгтэнтэй харилцах магадлал буюу *өртөлт-өөр (exposure)* хэмжиж иржээ.

Үүнийг Хинделанг нар (*Hindelang et al. 1978:250*) дараах байдлаар тайлбарлажээ: ‘Хэрэгтэн ба хохирогч нар цаг хугацаа ба орон зайгаар огтлолцож ... тэдний хооронд зөрчил, маргаан үүссэн байх ёстой бөгөөд хэрэгтэн тэр үед хохирогчийг тохиромжтой объект гэсэн төсөөлөл авсан ... хэрэгтэн хүссэн зүйлдээ хүрэхийн тулд айлгах эсхүл хүч хэрэглэх (эсхүл нууц арга) хүсэлтэй ба боломжтой байх ёстой ... хэрэгтэн хүссэн зүйлдээ хүрэхийн тулд хүч хэрэглэх эсхүл айлгахад (эсхүл нууц арга) өөрийгөө давуу байдалтай нөхцөл байдалд байна гэж үзэх ёстой ... эдгээр нөхцөл байдал үүсэх магадлал нь нийгмийн гишүүдийн амьдралын нөхцөл байдлаас хамаарна.’

Түүнчлэн Готтфредсоны (*Gottfredson 1981*) эшлэснээр Коэн, Фелсон (*1979*) нар нийгмийн бүтэц ба үүргийн хүлээлтээр тодорхойлогддог хэвшсэн зан үйлд үндэслэн магадлалт өртөлтийг таамаглаж болно гэж үзжээ. Тогтмол, эсхүл өөрчлөгдөн буй нийгмийн бүтцийн үйлдэл нь хохирогч гарах хувийн ялгааг үүсгэж болох нэг механизмыг нөхцөл байдлын энэ талаар тайлбарлаж болно. Давтан хохироох явдал нь гэмт хэргийн түвшинд (*Lauritsen and Laub 2007*) дорвитой

хувь нэмэр оруулдаг гэдэг энэ үзлийг дэмжсэн хэд хэдэн бүтээл (*Kennedy and Forde 1990; Coston and Ross 1998; Tewksbury and Mustaine 2000; Mustaine and Tewksbury 2002; Schreck and Fisher 2004; Nofziger and Kurtz 2005*) байдаг. Гэхдээ яагаад хэрэгтнүүд нэг хохирогчийг дахин дахин 'бай'-гаа болгодог вэ гэдэг талаар илүү их судлах хэрэгтэй (*Farrell 1995*) байна. Энэ тайлбар нь тухайлан хохирогч, эсхүл хэрэгтнийг буруутгахгүй. Харин бусдыг хохирооход хувь нэмэр оруулдаг нөхцөл байдлыг харж байна. Тохиромжтой бай нь хэрэгтэнтэй тогтмол харилцах, мөн асран хамгаалагч байхгүй байх нөхцөл байдалд давтан хохирох магадлал өснө. Фелсон (*1987:912*) 'дотны жолоодогч' (*intimate handler*) байхгүй байх нь мөлжлөгийн нөхцөлд хэрхэн хүргэдгийг онцлон, өөрийн санааг боловсруулж, үүнийгээ нийгмийн хяналттай холбон (*VII бүлгийг үз*) үзжээ. Зарим хэрэгтэнд нийгмийн ямар ч холбоос байхгүй бөгөөд тийм учраас албан бус нийгмийн хяналтгүй байдаг боловч бидний олонх нь нийгмийн холбоостой байж 'жолоог барьж', албан ёсны хяналт тавих 'дотны жолоодогч' (*энэ утгаар аав эсхүл ээж*)-той байдаг. Энэ албан бус хяналтыг тойрч болох (*холбоосын талаарх ойлголтыг VII бүлэгт авч үзсэн*) боловч гадаад хяналт нь (*цагдаа, зохицуулах байгууллагууд*) авлигаас сэргийлэх чадвар хязгаарлагдмал байдаг. Энэ аргачлалаар гаргаж тавьсан ойлголт, утга санаа нь гэмт хэрэг хийх бололцоог багасгаж, нийгмийн хяналтын арга хэмжээг хүчирхэгжүүлж, гэмт хэргийг бууруулахад анхаардаг бусад олон онолын аргачлалтай холбогддог. Эдгээр онол нь Ньюманы (*Newman 1972*) хамгаалж чадах орон зайн ойлголтыг хэрэглэн байг чангатгах, орон зайд нэвтрэхэд хяналт тавих, ажиглалтын төхөөрөмж суурилуулах зэрэг гадаад орчны техникийг идэвхтэй хэрэглэн хэрэгтнүүдийг хэрэг хийх сэдлээс түдгэлзүүлэх, гэмт хэргийн бололцоог бууруулж болохыг онцолж үздэг боловч ихэвчлэн харагдах гэмт хэргийг голлон авч үзжээ.

Хэвшмэл үйлдлийн онолын хязгаарлагдмал тал

Хэвшмэл үйлдэл нь гэмт хэргийн сэдлийг (*сэдэлжсэн гэмт хэрэгтэн хэрэгтэй гэдэг ч*) тайлбарладаггүй. Мөн эдгээр хувьсагчдын хослолыг бий болгох нийгмийн орчин нөхцөлийг тайлбарладаггүй. Энэ аргачлалд олон асуудал байдаг боловч шууд илэрхий нэг асуудал нь хэрэглэгдэж буй тодорхойлолт, нэр томьёо нь нэгэн жигд бус явдал юм. ‘Болзошгүй’ хэрэгтэн, ‘эмзэг’ бай, ‘чадамжтай асран хамгаалагч’ гэдэг нь чухам юу вэ гэдэг нь тодорхойгүй байна. Түүнээс гадна амрахаар ‘гадагш гарах’ гэж юу гэсэн үг вэ гэдэг талаар илэрхий тодорхойлолт байхгүй. Энэ нь спорт тоглоом тоглох, юм уух, бааранд эсхүл гэртээ үдэшлэг хийх байж болно. Энэ аргачлалын хувьд хэв маяг нь гол зүйл болох боловч ‘амьдралын хэв маяг’-ийг төлөөлөх олон хэмжээс нь бодитой, эсхүл шууд биш хэмжээс байна. Энэ нь зарим төрлийн урьдчилан сэргийлэх ажил амжилттай болсон, эсхүл яагаад зарим асран хамгаалагч бусдаас чадварлаг байгаа гэдгийг хэлэх боломжгүй болгоно. Мөн уг онол нь яагаад зарим зан үйл нь хүмүүсийг илүү хохирох магадлалтай болгодгийг дэлгэрэнгүй тайлбарлая гэдэггүй (*Walklate 1998*) байна.

Энэ аргачлалыг дэмжсэн судалгаа нь амьдралын хэв маяг ба өртөх гэсэн чухал онолын ойлголтын аль алины хувьд түүхий хэмжүүрт найдахаас аргагүйд хүрдэг (*Gottfredson 1981*) байна. Хувь хүний түвшинд нөхцөл байдлын хувьсагчид нь нас, хүйс, угсаа, орлого зэрэг хүн ам зүйн шинж чанараар илэрхийлэгддэг гэж үздэг. Мөн гэмт хэрэг гарах арга замын талаар шөнө, эсхүл баарны дэргэд зэргээр энгийн таамаг дэвшүүлэх хандлагатай байна. Нөхцөл байдлын судалгаа нь цөөн онцгой тохиолдлыг эс тооцвол төлөөлөх өгөгдлийг авч үздэг боловч хохирогчдын талаарх судалгаанаас авч болох нөхцөл байдлын өгөгдөл нь өртөх явдлыг үнэлэхэд хангалтгүй байна. Гэхдээ хэвшмэл үйлдэл нь хохиролтой холбогддог учраас хэвшлийг судлахын

11 Авлигыг тайлбарлах нь: 'Бизнесийн' хэвшсэн үйл ажиллагаа юу?

тулд хохирогч ба хэрэгтний хооронд үйл явдал болохын хэрээр гарах нөхцөл байдлын орооцолдсон, яалт ч үгүй нарийн төвөгтэй цуврал аман болон биет үйл хөдлөл ба эсрэг үйл хөдлөлийг дэлгэрэнгүй, системтэйгээр тэмдэглэх шаардлагатай болно.

Түүнчлэн энэ онолын аргачлал нь гэмт хэргийг манай нийгмийн зохион байгуулалтын дотор шингэсэн шинж чанар гэж үздэг бөгөөд хэрэгтнүүд нь бусад хүмүүсээс ялгаагүй. Гэмт хэрэг нь хүний салшгүй зүйл учир 'ердийн хүмүүс' ердийн л гэмт хэрэг хийдэг. Тэгэхээр гэмт хэрэг үйлдэх сэдэл нь хүн амд ижил тархсан гэж үзнэ. Мэдээж гэмт хэргийн шинж чанарын талаар онолын бүтээлүүд байдаг боловч гэмт хэрэг үйлдэх сэдлийн талаар дурдаагүй (*VII бүлгийг үз*) байдаг. Хяналтын онолын бүлэгт хамаарах онолын аргачлалууд нь зөрчлийн/гэмт хэргийн сэдлийг асуудалгүй гэж үздэг ба гэмт хэргийн логик үндэслэлийг гарган тавихыг оролдохын оронд тэд хүмүүс яагаад гэмт хэрэг хийдэггүй вэ гэдэг логик үндэслэлийг гаргахыг (*Paternoster and Bachman 2001*) оролджээ.

Түүнээс гадна ямар хүмүүс хохирогч, хэрэгтэн болох вэ, эсхүл ямар хүмүүс чадамжтай асран хамгаалагч болох вэ гэдгийг тайлбарлах онолын үндэслэл багатай юм. Энэ аргачлалд илэрхий байдаг зүйл нь сэдэлжсэн хэрэгтний нийлүүлэлт үргэлж байж байдаг бөгөөд хүчтэй, эсхүл сул хяналт мөн дарамтын (*V бүлгийг үз*) аль аль нь сэдлийг үүсгэдэг гэсэн таамаг юм. Коэн, Фелсон (*1979*) нар сэдлийг орхиод, харин бүтцийн зохион байгуулалтыг тогтсон зүйл гэж (*Garland 1999*) үзжээ. Түлхүүр хувьсагчийг орхисон онол нь гэмт хэрэг, эсхүл хохирлыг тайлбарлах бүхнийг хамарсан онол болж чадахгүй. Лафрий (*LaFree 2007*) тэмдэглэхдээ болзошгүй хэрэгтний харж буй өнцөг ба сэдлийн талаар авч үзэхгүй бол нөхцөл байдал нь гэмт зан үйлтэй илэрхий хамаарал байхгүй болно гэжээ. Үндсэндээ соёл ба нийгмийн бүтэц нь зөвхөн агуулгаар ялгаатай бөгөөд гэмт хэрэгт нөлөөлөх хүчээр ялгаагүй тогтмол зүйл гэж үздэг

учраас тайлбарлах зүйл байхгүй бол онол байх боломж ч үгүй, бас шаардлага ч үгүй болно. Хэрэгтнүүд нь бусад хүмүүсээс ялгаатай бус үед бүх хүнийг ижилхэн нийгэмшсэн гэж хэлж (*Garland 1999*) болно. Гэхдээ төгс нийгэмшил нь боломжгүй юм. Учир нь бид түүний эсрэг дархлаатай байдаг учир ямар ч нийгэм төгс нийгэмших нөхцөлийг нийлүүлж чадахгүй. Тиймээс бүх хүн ямар нэг хэлбэрээр нийгмийн зохион байгуулалтгүйдэлд өртдөг байна.

Ашгийн төлөө: Авлига, бизнес, санхүүгийн гэмт хэрэг

Садерланд (*1949*) болон түүний дараах эрдэмтэд (*Simon 1995; Simon and Hagan 1999*) зарим салбар хууль бус практикийг хэвшил болгосон байдаг талаар тэмдэглэсэн байдаг бөгөөд ийм салбар нь санхүүгийн салбар болж таарч байна. Дэлхий даяарх бизнесийн байгууллагуудын үйлдэж буй авлигын олон жишээ байдаг бөгөөд тэр болгоны цаана сэдэлжсэн хэрэгтэн, хохирогч, гэмт хэргээс сэргийлэх талыг хариуцсан ч үр дүнгүй зохицуулах байгууллага байж байдаг. Энэ онолын аргачлалд санал болгож чадах хамгийн тохиромжтой жишээ нь авлигаас сэргийлэхийн тулд юу хэрэгтэй вэ гэдэг жишээ юм. VII бүлэгт дурдсанаар хүчээр зохицуулах болон хүнд шийтгэл оноох нь авлигын түвшнийг бууруулахад хэрэгтэй. Ардчилсан улсад шийтгэл нь янз бүр байж болох ч нийтлэг зүйл нь хувь хүнийг бус байгууллагыг шийтгэх байдаг ба ихэвчлэн санхүүгийн салбарын авлигын үйлдэлд тохирох ял бус санхүүгийн шийтгэл оноож байна.

Харамсалтай нь санхүүгийн салбарт авлига хэвшмэл зүйл болсон харагдаж байна. Ихэвчлэн луйварчин хүмүүсийн хэрэг гэж танилцуулагддаг ч ‘орчин үеийн’ санхүүгийн дэлхий нийтийн жишээнд түшиглэн дуулиант хэргүүдийн давтамж, хэвшлийг энэ хэсэгт авч үзэх болно. Хувь хүний гэмт

11 Авлигыг тайлбарлах нь: 'Бизнесийн' хэвшсэн үйл ажиллагаа юу?

хэргийн хандлагыг тодорхойлохыг оролдохын оронд практик хэмжүүртэй байх шаардлагатай. Урьдчилан сэргийлэх бүх л стратеги хязгаарлагдмал боловч энд нэг чухал зүйл байгаа. Тэр нь юу вэ гэвэл гэмт хэрэг үйлдэх боломжийг хэцүү болгох явдал бөгөөд энэ нь эдийн засгийн загвар ба хүмүүс яагаад авлигажсан байдаг талаарх үзэл бодолтой зарим талаар (*II бүлгийг үз*) төстэй. Баригдсан хэрэгтнийг яах вэ гэдэг талаар хэвшмэл үйлдлийн талаарх онолд бага зүйл яригддаг. Гэхдээ уг онол баруун реализмд харьяалагдах учраас хувь хүмүүс сонголт хийдэг бөгөөд урьдчилан сэргийлэх арга хэмжээ бүтэлгүйтвэл шийтгэл нь цээрлүүлэх хүч болно гэдгийг хүлээн зөвшөөрдөг байна. Энд буй асуудал бол авлигын гэмт хэрэг нь ихэвчлэн нууц байдаг учир энэ салбар дахь стратеги ба зохицуулалт нь хязгаарлагдмал байдаг явдал юм. Анхдагч ба хоёрдогч хэлбэрээр аль алинаар нь цээрлүүлэхийн хувьд шийтгэл нь магадгүй бидэнд буй хамгийн сайн стратеги болно. Анхдагч цээрлүүлэлт буюу хэрэгтнийг урт хугацаагаар хорих нь ирээдүйд гэмт хэргийн үйлдэл гаргахаас цээрлүүлэх шийтгэл болно. Хоёрдогч цээрлүүлэлт гэдэг нь шийтгэлээс айх айдас нь бусдыг гэмт хэрэг хийхээс цээрлүүлэх буюу татгалзуулах явдал юм. Асуудал цээрлүүлж чадах эсэх тухайд бус шийтгэлийг хэрэгжүүлэх улс төрийн хүсэл байх эсэхэд байдаг. Япон улсад 'элит'-үүдийг хэрхэн авч үздэг нь энд тохирсон жишээ (*Suda 2011*) болно.

Дараах жишээ энэ санааг тодорхой харуулна. Санхүүгийн салбарт хэрэглэгддэг нэр томьёог одоо магадгүй санхүүгийн хямралын улмаас олон нийт мэддэг болсон байх. 'Гэвч барьцаалагдсан өрийн облигац' (*collateralized debt obligations*) гэх зэрэг нэр томьёоны ач холбогдол тодорхойгүй байна. Зарим нэр томьёог тайлбарлая.

2015 оны 2 дугаар сард Standard & Poog компани 1.375 тэрбум долларыг иргэний хэргийн тохиролцоогоор Шүүх яам, АНУ-ын 19 муж, Колумбия дүүрэгт (*Warren 2016*) төлжээ.

Энэ тохиролцоо нь хувийн байрны зээлээр баталгаажсан үнэт цаас ба барьцаалагдсан өрийн облигацын жинхэнэ зээлийн эрсдэлийг буруу мэдээлэхэд оролцсоныхоо хариуд хийгдсэн байна. Барьцаалагдсан өрийн облигац нь байрны зээл, бонд, зээл нь барьцаа болдог нийлүүлсэн хөрөнгийн иж бүрдэл юм. Тэдгээрийг хэсэг хэсгээр нь боосон байдаг ба эрсдэл нь ялгаатай байдаг. Хамгийн өндөр зээлийн үнэлгээтэй бүтээгдэхүүн нь бага өгөөж өгдөг боловч харьцангуй аюулгүй байдаг, учир нь дампуурлын үед барьцааг дуудахад давуу эрхтэй байна. Харин хамгийн бага зээлийн үнэлгээтэй бүтээгдэхүүн нь өндөр өгөөж өгдөг боловч дампуурах магадлал илүү өндөр байдаг. Эдгээр барьцаалагдсан өрийн облигац нь 2008 оны санхүүгийн хямралын гол шалтгаан байсан юм. Гэхдээ энэ тохиролцоо нь Шүүх яам ба мужууд анх нэхэмжилсэн торгуулийн хэмжээний зургааны нэгээс ч бага байсан ажээ. Түүнчлэн Standard & Poor компани хариуцлагаа хүлээн зөвшөөрч, буруугаа шүүхийн өмнө хүлээхээс татгалзсан байтал Шүүх яам ганц ч хүнийг яллаж чадаагүй байна. Гэмт хэрэг нь хүмүүсийн орон зай, цаг хугацаан дахь уулзалтуудын системтэй үр дүн байдаг. Энэ нь энэхүү хэрэг, эсхүл цуврал хэргийн оролцогч болсон хэн бүхэн түүнд оролцох сонголт хийсэн, эсхүл түүнийг зөвшөөрсөн, эсхүл тэр талаар бүгд мэдэж байсан гэсэн үг биш. Өөрөөр хэлбэл зөвшилцөлгүй ойртолт, зохион байгуулалтгүй, тэгш бус сонголтын бүтээгдэхүүн байдаг. Энэ нь олон хүн хохирч байгаагаар ч мэдээгүй байдаг авлигын хувьд зөв тодорхойлолт болно.

Хэрэв бид хохирсноо мэдэж байгаа бөгөөд бидэнд авлигын үйлдлийн талаар баримт байвал түүнийг үйлдсэн хувь хүмүүс ба байгууллага нь шийтгэгдэх ёстой гэсэн хүлээлттэй байна. Санхүүгийн салбар дахь хүмүүс авлигын хэвшсэн үйлдэл гэж харагдахаар үйлдлийнхээ төлөө шийтгэгдсэн ч шийтгэлийн төрөл нь магадгүй урам хугалахаар байна. ‘Картел’ гэж олонд танигдсан (*Citigroup, JPMorgan Chase & Co, Barclays, UBS*

11 Авлигыг тайлбарлах нь: 'Бизнесийн' хэвшсэн үйл ажиллагаа юу?

AG), Шотландын эзэн хааны банкууд 2015 оны 5 сарын байдлаар нийтдээ 5.6 тэрбум долларыг Шүүх яаманд тохиролцооны хэлбэрээр төлсөн (**Warren 2016**) байна. Эдгээр банкууд валютын ханшийг таваас дээш жил удирдаж, санхүүгийн багцад хөрөнгө оруулсан хувь хүмүүс ба байгууллагуудыг золиослон тэрбум, тэрбум долларын хөрөнгөтэй болжээ. Түүнчлэн Үнэт цаас, валютын комисс банк бүрийг гэмт хэрэг үйлдсэнийх нь дараа ч арилжаагаа үргэлжлүүлэхийг зөвшөөрчээ. Эрх болон давуу эрхээсээ сайн дураар татгалзах, эсхүл буулт хийх эрхээс татгалзах бичиг (**waiver**) гаргасныг нь үндэслэн банкуудад буруугаар ашиглаж байсан бизнесийн үйл ажиллагааг нь үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн аж. Хэрэгтнийг санхүүгийн болоод үнэт цаасны бизнесийн салбарт ажиллахыг хязгаарласан дүрэм журамд хамрагдахгүй байхын тулд банкуудад энэхүү татгалзах бичиг хэрэгтэй байв. Эдгээр бичиг нь бас тэднийг буруугаа хүлээсний дараа яригдах барьцааны үр дагавраас зугтах боломжтой болгожээ. Гэхдээ UBS зээлийн хүүг удирдахтай холбоотой шилжүүлгийн залилангийн тухайд тэд тусдаа буруугаа хүлээсэн юм. Эдгээр татгалзах бичиг нь банк буруугаа хүлээсэн гэсэн сүр дуулианыг дагуулах бөгөөд эцэстээ тэдэнд **'практик асуудал дагуулахгүй бэлэг тэмдгийн чанартай ичгүүр'** төрүүлэх учир холбогдолтой (**Warren 2016**) байв.

Түүнээс гадна Deutsche Bank-ны бүрэн эзэмшилд байдаг DB Group Service Limited компани 2015 оны 4 дүгээр сард Шүүх яаманд 775 сая долларыг тохиролцооны зарчмаар төлжээ. Энэ тохиролцоо нь уг банк Лондонгийн банк хоорондын санал болгох хүү буюу ЛИБОР хүүг будилуулсан асуудлаар ялласны хариуд хийгдсэн төлбөр аж. ЛИБОР нь дэлхийн тэргүүлэх банкууд бие биедээ богино хугацааны зээл олгохдоо ашигладаг жишиг хүү юм. Эдгээр зээл нь АНУ-ын доллар, евро, стерлинг, Японы иэн, Швейцарийн франк гэсэн таван төрлийн валютаар хийгддэг. Зээлийн хугацаа янз бүр байдаг бөгөөд нэг шөнө, нэг долоо хоног, нэг, хоёр, гурав, зургаа болон 12 сар гэх мэт.

Хүүг өдөр бүр тогтоодог бөгөөд нийт 35 янзаар боддог зээл юм. Зарим төрлийн байрны зээл, оюутны зээл, автомашины зээл зэргийг оролцуулан 10 их наяд долларын зээлд жишиг болгон ашиглагддаг энэ хүү нь бидний зээлийн төлбөрт чухал нөлөөтэй. DB Group Service Limited компани гүйлгээний залилан хийсэн буруутай үйлдлээ хүлээсэн. Гэвч хэргийг ‘шилжүүлгийн залилан, шударга бус өрсөлдөөний хэрэг хэмээн шийдвэрлэх’ ялыг хойшлуулахаар эх компани болох Deutsche Bank нь Шүүх яамтай тохиролцоо²⁸ хийсэн нь энэ юм. Deutsche Bank нь ЛИБОР-ын хэрэгт ‘тусгайлан идэвхтэйгээр оролцсон’ ба ‘АНУ-ын болон Английн хууль хяналтын байгууллагатай бүрэн хамтарч ажиллаагүй гэж шүүмжлүүлсэн’-ийх нь төлөө ганцааранг нь онцгойлон үзсэн аж.

Мөрдлөгөөр 39 ажилтан нь хууль бус үйлдэлтэй нь тогтоогдсон (*Warren 2016:5*) байна. Гэтэл Шүүх яам хэнийг ч яллаагүй бөгөөд оноосон санхүүгийн шийтгэл нь Deutsche Bank-ны 2015 оны эхний улирлын ашгийг ч хотойлгохооргүй байв. Энэ тохиролцооноос хэдэн долоо хоногийн дараа Үнэт цаас, валютын хороо үнэндээ бол зөвхөн хууль биелүүлдэг банк л эдлэх ёстой зохицуулалтын давуу талыг Deutsche Bank-нд үргэлжлүүлэн эдлэх зөвшөөрлийг өгчээ. Энэ жишээн дээр зохицуулах байгууллагууд авлигын гэмт хэргээс сэргийлж чадаагүй ба илрэхэд нь ирээдүйн үйлдлээс хангалттай цээрлүүлж чадаагүй байна. Энэ жишээ нь санхүүгийн салбарт ийм төрлийн авлига хэвшил болсныг харуулах бөгөөд дэлхийн хэмжээгээр сэдэлжсэн хэрэгтэн, бэлэн хохирогч, ба авлигын үйлдлийг хянах, эсхүл түдгэлзүүлж чадаагүй, чадваргүй асран хамгаалагч байгааг харуулж байна. 2015 оны 5 дугаар сард Deutsche Bank AG компани 2008-2009 онд 1.5 тэрбум долларын алдагдлаа

28 Deferred prosecution agreement буюу яллагдагч тодорхой шаардлагыг биелүүлбэл прокуророос ял наймаалцахгүй байхыг хүлээн зөвшөөрөх тохиролцоо. АНУ, Канад улсад хэрэгждэг бөгөөд компанийн үйлдсэн залилан зэрэгт торгууль төлөх, компанидаа шинэчлэл хийх, мөрдлөгт бүрэн дэмжлэг үзүүлэхээр яллагдагч тохирвол хийгддэг байна. (Орч.)

11 Авлигыг тайлбарлах нь: 'Бизнесийн' хэвшсэн үйл ажиллагаа юу?

нуусан ялаа тохиролцоход баримжаагаар 55 сая долларыг Үнэт цаас, валютын комисст төлжээ. Үнэт цаас, валютын комисс Deutsche Bank-ны тайлан нь уг банканд тулгараад байсан эрсдэлийг зөв тусгаагүй байсан гэжээ. Энэ нь Deutsche Bank-ны 2015 онд хийсэн хоёр дахь том тохиролцоо байсан боловч компани буруугаа огтхон ч хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд ямар ч хувь хүнд хариуцлага тооцоогүй байна.

2015 оны 8 дугаар сард Citigroup-тэй хуйвалдсан хоёр байгууллага 2008 оны санхүүгийн хямралын өмнө хөрөнгө оруулагчдыг залилсан сэжгийг шийдвэрлэх зорилгоор ойролцоогоор 180 сая долларыг Үнэт цаас, валютын комисст төлжээ. Энэ хоёр байгууллага 2002-2008 оны хооронд эрсдэлтэй, өндөр хөшүүрэгдсэн бондод (*leveraged bonds*) аюулгүй бөгөөд бага эрсдэлтэй гэсэн хуурамч баталгаа гарган өгч, хөрөнгө оруулагчдад санал болгон зарсан хэрэгт (*Warren 2016*) сэжиглэгджээ. Хөшүүрэгдсэн бонд гэдэг нь аль хэдийн нэлээд хэмжээний өртэй байгаа байгууллага, эсхүл хувь хүнд өгсөн зээл юм. Энэ бонд нь янз бүрийн хэлбэртэй байж болох ч, муу зээлтэй байгууллага, эсхүл хувь хүн нь зээл авахдаа өндөр хүү төлдөг гэдгийг онцлох хэрэгтэй. Зээлийн хүүг хуурамчаар удирдсан энэ жишээнд авлигын төлөвлөгөөтэй, тооцоолсон, рационал үйлдэл оршин байгааг харуулж байна. Эдгээр авлига нь хөрөнгө оруулагчдад 2 тэрбум долларын зардал үүсгэсэн ба энэ нь тохиролцооны дүнгээс арав дахин илүү байлаа. Тохиролцоонд буруугаа хүлээхийг шаардаагүй ба Үнэт цаас, валютын хороо буруутай хүмүүсийг илрүүлж, олонд дэлгэхээс татгалзсан бөгөөд цаашид шүүхэд шилжүүлэх ямар ч төлөвлөгөөгүй байна. Санхүүгийн салбарт гэмт хэрэг нь хэвшмэл үйлдэл болох хандлагатай байгаа ч түүнд оноох шийтгэл нь хэвээр байх хандлагатай байна.

Гэтэл хөрөнгө оруулагчид хоёрдогч зах зээл нь алга болоход зарагдахаа байдаг хортой хөрөнгийн (*toxic asset*) асуудалтай учрахаас аргагүй болж байна. Энгийн бөгөөд шууд хэлэхэд

хосууд байшин худалдаж аваад санхүүгийн байгууллагад (А банк) зээлтэй болно. А банк тэдний зээлийг бусдад (Б банк) зарна. Б банк нь ингээд байрны зээл эзэмших бөгөөд зээл төлөгдөх үед хүүгийн төлбөр авах болно. Хэрэв байрны үнэ өсөж, зээл төлөгдвөл энэ нь үнэ цэнэтэй хөрөнгө болно. Гэхдээ хэрэв хосууд байрны зээл дээр дампуурал зарлавал байрны зээлийг эзэмшиж буй байгууллага төлбөр авахгүй. Энэ тохиолдолд байр банкны эзэмшилд шилжиж, банк түүнийг борлуулна. Энэ үед хэрэв байрны үнэ зээл авах үеийн түвшнээс буурвал хортой өр болох ба тэд хохирол хүлээнэ. Хэрэв энэ хөрөнгийн бодит үнэ цэнийг мэдэж байвал ямар ч байгууллага ийм бүтээгдэхүүнийг авахыг хүсэхгүй. Гэхдээ харамсалтай нь ийм бүтээгдэхүүний бодит үнэ цэнэ нь нуугдсан байх нь хэт элбэг байна.

Хүмүүсээс мэдээллээ нуух нь санхүүгийн салбарт нийтлэг практик болсон шиг байна. Barclays Bank ба Credit Suisse компаниуд саяхан ‘хар усан сан’-гийн (*dark pool*) талаарх хэргээр Үнэт цаас, валютын комисстой нийт 154.3 сая долларын тохиролцоо хийсэн (*Moyer 2016*) юм. ‘Хар усан сан’ гэдэг нь арилжаа дуусахаас өмнө бусад худалдаачдад мэдэгдэхгүйгээр хувиараа хувьцаа зарах, худалдан авах сонирхолтой хэрэглэгчдэд зориулсан зүйл юм. Энэ нь хэдэн жилийн өмнө үүссэн боловч технологийн дэвшлийн улмаас худалдаачид явагдаж буй арилжаанд хариу үйлдэл үзүүлж чадахаар болж ирсэн учир тэд аль болох далд байх хүсэлтэй болж иржээ. Эдгээр хар усан сангууд, тэдгээр дотор хийгдэх худалдаа нь хар усан сангаас гадуур үндэс суурьтай байдаг асуудал оршдог бөгөөд зарим нь арилжаа хийгдэхээс өмнө арилжаа болох гэж буй талаар мэдчихсэн байдаг аж.

Санхүүгийн салбарын авлига нь банкуудад төвлөрч байгаа харагддаг ч Moody’s болон Standard & Poog зэрэг зээлийн үнэлгээний байгууллагууд санхүүгийн хямрал болоход үүрэг гүйцэтгэсэн юм. Үнэт цаас, валютын комисс АНУ-д одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа зээлийн үнэлгээний арван

11 Авлигыг тайлбарлах нь: 'Бизнесийн' хэвшсэн үйл ажиллагаа юу?

байгууллагад шалгалт хийжээ. Хамгийн сүүлийн шалгалтын тайлангаас үзвэл санхүүгийн хямралаас хойш юм өөрчлөгдсөн гэвэл маш бага өөрчлөгдсөн байна. Тэдний ихэнх нь увайгүй үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээгээгүй учир үүнд гайхаад байх зүйлгүй юм. Энэ нь 2016 оны байдлаар гэхэд үргэлжилсээр байсан, хүлээн зөвшөөрч болохгүй практикийг авлига бус алдаа хэмээн танилцуулсан хэд хэдэн жишээнээс харагдана. Нэг үнэлгээний байгууллага үнэлгээ тооцох аргачлалдаа алдаа олсон боловч түүний дараа гаргах үнэлгээний тайландаа алдааны талаар болон түүний далд үр дагаврын талаар дурдаагүй байна. Өөр нэг үнэлгээний байгууллага өөрийн дотоод үнэлгээтэй зөрчилдсөн мэдэгдэл хийсэн ба хамгийн том үнэлгээний байгууллагын дүрэм журам нь 'хориотой, шударга бус, хүч хэрэглэсэн, буруу хэрэглэгдсэн практик'-аас сэргийлж чадаагүй (*Morgenson 2016:17*) байна.

Энэ аргачлалд онолын болон практик хүндрэл байдаг ч ядаж л 'юу ч нэмэргүй' гэх санаанаас дээр байна. Судалгааны бүтээлүүдэд авсан жишээ нь хулгайлах, хорлон сүйтгэх зэрэг ердийн, харагдах хэрэгт төвлөрөх хандлагатай байдаг. Бүхнийг анагаагч эм буюу эрүүгийн шүүн таслах тогтолцооны философичийн чулууг²⁹ хайхын оронд ялангуяа орон нутгийн түвшинд авлигыг бага багаар бууруулах боломжийг хүлээн авах нь магадгүй ухаалаг хэрэг болно. Хэрэгтнүүд нь бүр шийдчихсэн байдаг учраас бууруулах боломжгүй олон гэмт хэрэг байдаг ч хуулийг сул, үр дүнгүй хэрэгжүүлж байгаад гол асуудал байна. Энэ аргачлал нь бид гэмт хэргийн тогтсон түвшинг ардчилсан улсад хүмүүс магадгүй 'амьдралын хэв маяг' гэсэн бүдэг бадаг ойлголтоо хамгаалахын тулд хийсэн, зардал-үр өгөөжийн шинжилгээний үр дүн гэж хүлээн авах ёстой болов уу гэж үзэж байна. Бид бүгд нэг улсад амьдарч

29 Грекийн домгоос гаралтай металлыг алт, мөнгө болгон хувиргах чадалтай алхимийн чулуу. Бодит амьдрал дээр байдаггүй мөрөөдлийн, бүтэшгүй зүйл гэдэг утгаар хэрэглэжээ. (Орч.)

байгаа боловч хүмүүс нийгмийн гарал, оршин суугаа газар, эрүүл мэнд, нөөцөд хандах боломж зэргээс хамаараад маш өөр өөр амьдрал туулж өнгөрүүлж байдаг учир энэхүү ‘амьдралын хэв маяг’ гэдэг нь ч тун бүдэг бадаг ойлголт юм.

Энэ онол нь амбицгүй, болгоомжтой гэж харагдах боловч бага багаар авч үзэх аргачлалыг санал болгож, баялаг, анги, боловсролын тэгш бус байдлыг бууруулах нь гэмт хэрэгт нөлөө үзүүлнэ гэдгийг шүүмжилдэг. Хүмүүсийн нүдэнд илүү ил байдаг гудамжны гэмт хэрэг, ялангуяа залуу хэрэгтнүүдийн үйлдсэн хэрэг нь эрүүгийн шүүн таслах тогтолцоогоор орохгүй бол илүү сайн шийдвэрлэгдэж магадгүй. Гэвч уг тогтолцоо нь нийгмийн хэсэг, бүлэгт угаасаа ялгавартай, шийтгэх хандлагатайгаар (*Muncie 1999; McAra and McVie 2007; Case 2007; Kemshall 2008; Brooks et al. 2012*) үйлчилдэг. Эрүүгийн шүүн таслах тогтолцоо нь өөрт байгаа бүхий л арга хэмжээний цогцыг ашиглан санхүүгийн салбарт хэвшил болсон гэмт хэргээс сэргийлэх хэрэгтэй.

Авлигын үйлдлийг хийх бололцоог бууруулах нь сайнаар бодвол хэсэгчилсэн амжилтад хүргэнэ: Гэхдээ энэ үзэл нь хүний зан үйлийг хэт хялбаршуулж, механикжуулсан байдлаар хардаг хэмээн тооцогддог. Харин муугаар бодвол хүний шинж чанарыг доромжилсон хэрэг (*Radzinowicz and King 1977*) болно. Дээр дурдсан авлигын гэмт хэргийн үйлдлүүд нь гэмт зан үйл нь рационал байдал давамгайлсан үйлдэл гэх үзэлд бүхэлдээ таарна. Хэрэв энэ үзлийг хүлээн зөвшөөрвөл зөвхөн хуулийг бодитой хэрэгжүүлэх практик арга хэмжээ л байж болох сонголт болно. Одоогийн ойлголтоор бол ял тохиролцох, гэм буруугаа хүлээхгүй байх, авлигын үйлдлийг үргэлжлүүлэх эрх чөлөөг хязгаарлах нь практик бус, эсхүл зүгээр л санхүүгийн салбарт боломжгүй байна.

Дүгнэлт

Энэ бүлэгт санхүүгийн салбарт хэвшмэл авлига хэрхэн оршин байгаа талаар онцолж үзэв. Хэдийгээр анхдагч зорилго нь харагдах гэмт хэргийг тайлбарлах байсан боловч энэ аргачлал нь гэмт хэргээс сэргийлэх чадварлаг, зохицуулсан, үр дүнтэй байгууллагын ач холбогдлыг ойлгоход тустай байна. Энэ онолын аргачлалд хязгаарлагдмал талууд байдаг боловч алдаа гарган авлигын үйлдэл гаргахаас бусад тохиолдолд эдгээр давтагдсан үйлдэл нь рационал бөгөөд хэвшмэл үйлдэл байдаг. ЛИБОР хүү ба валютын ханшийг удирдах, мөн эрсдэлтэй хөрөнгө оруулалтыг эрүүл бизнес гэж зарах нь ялангуяа зээлийн хүүг өдрөөр тогтоож байх үед хэвшмэл үйлдэл байв. АНУ дахь Додд-Франкын хууль (2010) зэрэг хуулийг батлуулахгүй байхаар лоббидох, гацаах, эсхүл өргөн барьсны дараа татан авахуулах явдал гарч байгаа нь санхүүгийн гэмт хэргээс сэргийлэх явдлыг бүр ч дордуулж байна. Эдгээр хууль нь санхүүгийн салбарт хөрөнгө оруулсан бүх хүнийг болон зээл, байрны зээлтэй бүх хүнийг хамгаалахын тулд байж байх ёстой хуулиуд юм.

Авлигаас олж буй ашгийн багахан хувьтай тэнцэх торгуулийг шийтгэлийн хэлбэр болгон хэрэглэж байгаа учир хуулийн хэрэгжилт нь үр дүнгүй харагдаж байна. Давтагдах үйлдлээс сэргийлэх, авлигыг зогсооход торгууль нь хангалттай шийтгэл болж чадахгүй байна. Гэхдээ ач холбогдолтой байж болох нэг аргачлал нь байгууллагын гадаад орчин, нийгэм, засаглалыг хөгжүүлэх юм. Morningstar нь сан, гүйцэтгэл, хүчин зүйлд үнэлгээ хийдэг байгууллага бөгөөд хөрөнгө оруулалтын стратеги ба үнэ зэргийг үнэлдэг ажээ. Morningstar компанид мэдээлэл нь байдаг дор хаяж 200,000 санд гадаад орчин, нийгэм, засаглалын оноо өгөх санаачилгыг тэд (Mooney 2016) гаргажээ. Эдгээр сангууд болон тэдэнд хөрөнгө оруулагчид нь ийм ёс зүйн асуудлыг бодолцож үзнэ хэмээн таамаглаж байгаа хэрэг. Хэрэв гадаад орчин нь байгууллагад чухал юм бол энэ

Авлигын криминологи

нь байгууллагад зарим талаар нөлөөтэй байх боломжтой боловч санхүүгийн салбар нь хэрхэн олохоос үл хамааран ашигт анхаардаг бөгөөд өөрийгөө хадгалж үлдэхэд анхаардаг болох нь олон зүйлээс харагдсаар байна.

Одоогоор рационал бөгөөд авлигажсан байдлаар үйлдэл хийхийг ойлгож болохоор харагдаж байна. Өөрөөр хэлбэл авлигын үйлдлээр ашиг олно, санхүүгийн шийтгэл нь үр дүнгүй, хэрэв баригдаад яллагдсан ч энэ шийтгэлийг төлөх зардал нь олсон ашгаас бага байна. Санхүүгийн салбарт олны итгэх итгэлийг алдсан хэрэг явдал олон давтагдаж, эдгээр үйлдлээс шалтгаалан нэр хүнд нь их унасан ч хувь хүн ба байгууллага ‘хэрэглэгчид’-ийн золиосоор ашгийг хураан авсаар байгаа ба тэд гэмт хэрэг үйлдсэн ч бизнесээ үргэлжлүүлэхийг зөвшөөрсөөр байна.

Ашигласан материал

- Braga, A. A., & Bond, B. J. (2008). Policing crime and disorder hot spots: A randomized controlled trial. *Criminology*, 46 (3), 577–607.
- Braga, A. A., Weisburd, D. L., Waring, E. J., Mazerolle, L. G., Spelman, W., & Gajewski, F., 1999. Problem-oriented policing in violent crime places: A randomized controlled experiment. *Criminology*, 37 (3), pp. 541–580.
- Brantingham, P. I., & Brantingham, P. J. (1999). The eoretical Model of Crime Hot Spot Generation. *Studies on Crime and Crime Prevention*, 8(1):7-26.
- Brooks, G., Chen, F. L., Lewis, C., & Ellis, T., (2012). Young people as social capital: Policing and preventing crime among young people ‘at risk’ in Taiwan and England. *Crime Prevention & Community Safety*, 14(1), 16-32.

11 Авлигыг тайлбарлах нь: 'Бизнесийн' хэвшсэн үйл ажиллагаа юу?

- Case, S., (2007). Questioning the Evidence of risk that underpins evidence-led youth justice interventions. *Youth Justice*, 7 (2), 91-105.
- Clarke, R. (1980). Situational crime prevention. *British Journal of Criminology*, 20 (2), 136–147.
- Cohen, L. E., & Felson, M. (1979). Social Change and Crime Rate Trends: A Routine Activity Approach. *American Sociological Review*, Volume Number: 44 (4), 588-608.
- Cohen, L. E., & Felson, M. (2003). Routine activity theory. In F. T. Cullen & R. Agnew (Eds.), *Criminological theory: Past to present: Essential readings*. Los Angeles: Roxbury Publishing.
- Cornish, D., & Clarke, R. (1986). *The reasoning criminal: Rational choice perspective on offending*. New York: Springer.
- Coston, C. T. M., & Ross, L. E. (1998). Criminal victimization of prostitutes: Empirical support for the lifestyle exposure model. *Journal of Crime and Justice*, 21 (1), 53–70.
- Crow, W. J., & Bull, J. L. (1975). *Robbery deterrence: An applied behavioral science demonstration – Final report*. La Jolla, CA: Western Behavior Sciences Institute.
- Dugan, L., LaFree, G., & Piquero, A. (2005). Testing a rational choice model of airline hijackings. *Criminology*, 43 (4), 1031–1066.
- Eck, J. E. (2002). Preventing crime at places. In L. W. Sherman, D. Farrington, B. Welsh, & D. L. MacKenzie (Eds.), *Evidence-based crime prevention*. New York: Routledge.
- Farrell, G. (1995). *Preventing repeat victimization: Crime and justice*. Chicago: University of Chicago Press.
- Felson, M. (1987). Routine activities and crime prevention in the developing metropolis. *Criminology*, 25 (4), 911–931.

- Garland, D. (1999). The commonplace and the catastrophic: Interpretations of crime in late modernity. *Theoretical Criminology*, 3 (3), 353–364.
- Gottfredson, M. R. (1981). On the etiology of criminal victimization. *Journal of Criminal Law and Criminology*, 72 (2), 714–726.
- Hawley, A. (1950). *Human ecology: A theory of community structure*. New York: Ronald Press.
- Hindelang, M., Gottfredson, M., & Garafolo, J. (1978). *Victims of Personal Crime: An Empirical Foundation for a Theory of Personal Victimization*. Cambridge, MA: Ballinger.
- Johnston, L. (1996). What is vigilantism? *British Journal of Criminology*, 36 (2), 220-236.
- Kemshall, H. (2008). Risks, rights and justice: Understanding and responding to youth risk. *Youth Justice*, 8 (1), 21-37.
- Kennedy, L. W., & Forde, D. R. (1990). Risky lifestyles and dangerous results: Routine activities and exposure to crime. *Sociology and Social Research*, 74 (4), 208–210.
- Lauritsen, J. L., & Laub, J. H. (2007). Understanding the link between victimization and off ending: New reflections on an old idea, in M. Hough & M. Maxfield (eds) *From Surveying Crime in the 21st Century*, pp 55-75, Monsey, NY: Criminal Justice Press.
- LaFree, G. (2007). Expanding criminology's domain: The American Society of Criminology 2006 presidential address. *Criminology*, 45 (1), 1.
- McAra, L., & McVie, S. (2007). Youth justice? The impact of system contact on patterns of desistance from off ending. *European journal of criminology*, 4 (3), 315-345.

11 Авлигыг тайлбарлах нь: 'Бизнесийн' хэвшсэн үйл ажиллагаа юу?

- Mooney, A. (2016, January 18). Ethical rating could cost funds billions. *Financial Times*, p. 2.
- Morgenson, G. (2016, January 11). Years after crisis, rating agencies still miss the mark. *International New York Times*, p. 17.
- Moyer, L. (2016, February 3). Regulators keep focus on 'dark pool' trading'. *International New York Times*. p. 16.
- Muncie, J., 1999. Institutionalized intolerance: youth justice and the 1998 Crime and Disorder Act. *Critical Social Policy*, 19(2), pp. 147-175.
- Mustaine, E. E., & Tewksbury, R. (2002). Workplace theft: An analysis of student employee offenders and job attributes. *American Journal of Criminal Justice*, 27 (1), 111–127.
- Newman, O. (1972). *Defensible space*. New York: Macmillan.
- Nofziger, S., & Kurtz, D. (2005). Violent lives: A lifestyle model linking exposure to violence to juvenile violent off ending. *Journal of Research in Crime and Delinquency*, 42 (1), 3–26.
- Paternoster, R., & Bachman, R. (2001). *Explaining criminals and crime: Essays in contemporary criminological theory*, in R. Paternoster & R. Bachman (eds) *Explaining Criminals and Crime: Essays in Contemporary Criminological Theory*. Los Angeles: Roxbury Publishing Company.
- Pierce, G. L., Spaar, S., & Briggs, L. R. (1986). *The character of police work: Strategic and tactical implications*. Boston: Center for Applied Social Research, Northeastern University.
- Radzinowicz, L., & King, J. F (1977). *The growth of crime: The international experience*. New York: Basic Books.
- Ratcliff e, J. H. (2004). The hotspot matrix: A framework for the spatio-temporal targeting of crime reduction. *Police practice and research*, 5 (1), 5-23.

- Roncek, D. (2000). Schools and crime. In V. Goldsmith, P. G. McGuire, J. H. Mollenkopf, & T. A. Ross (Eds.), *Analyzing crime patterns: Frontiers of practice*. Thousand Oaks, CA: Sage.
- Schreck, C. J., & Fisher, B. S. (2004). Specifying the influence of family and peers on violent victimization extending routine activities and lifestyles theories. *Journal of Interpersonal Violence, 19* (9), 1021–1041.
- Sherman, L. W. (2004). Research and policing: The infrastructure and political economy of federal funding. *The Annals of the American Academy of Political and Social Science, 593* (1), 156–178.
- Sherman, L. W., & Weisburd, D. (1995). General deterrent effects of police patrol in crime ‘hot spots’: A randomized, controlled trial. *Justice quarterly, 12* (4), 625–648.
- Sherman, L. W., Gartin, P. R., & Buerger, M. E., (1989). Hot spots of predatory crime: Routine activities and the criminology of place. *Criminology, 27*(1), 27-56.
- Sherman, L., Gottfredson, D., MacKenzie, D., Eck, J., Reuter, P., & Shawn, B. (1997) *Preventing Crime: What Works, What Doesn't, What's Promising*. Washington, DC: U.S. Department of Justice, Office of Justice Programs.
- Simon, D. R. (1995). *Social problems and the sociological imagination*. New York: McGraw-Hill.
- Simon, D. R., & Hagan, F. (1999). *White collar deviance*. Needham Heights, MA: Allyn and Bacon.
- Suda, K. (2011). Creative accounting and accounting scandals in Japan. In M. Jones (Ed.), *Creative accounting, fraud and international accounting scandals*. Chichester: Wiley.

11 Авлигыг тайлбарлах нь: 'Бизнесийн' хэвшсэн үйл ажиллагаа юу?

- Sutherland, E. H. (1949). *White collar crime*. New York: Dryden Press.
- Taylor, D. I. (1997). American environmentalism: The role of race, class and gender in shaping activism, 1820–1995. *Race, Gender and Class*, 5 (1), 16 – 62.
- Tewksbury, R., & Mustaine, E. E., 2000. Routine activities and vandalism: A theoretical and empirical study. *Journal of Crime and Justice*, 23(1), 81–110.
- Walklate, S. (1998). *Understanding criminology*. Buckingham: Open University Press.
- Warren, E. (2016). *Rigged Justice 2016: How weak enforcement lets offenders of easy*. Office of United States Senate, Office of Elizabeth Warren, Washington, D C.
- Weisburd, D., Maher, L., Sherman, L., Buerger, M., Cohn, E., & Petrisino, A. (1992). Contrasting crime general and crime specific theory: The case of hot spots of crime. *Advances in Criminological Theory*, 4 (1), 45–69.
- Weisburd, D., Wyckoff, L. A., Ready, J., Eck, J. E., Hinkle, J. C., & Gajewski, F. (2006). Does crime just move around the corner? A controlled study of spatial displacement and diffusion of crime control benefits. *Criminology*, 44 (3), 549–592.
- Wilson, J. Q., & Herrnstein, R. (1985). *Crime and human nature*. New York: Simon and Shuster.

XII

Эргэцүүлэл ба дүгнэлт

Төгсгөлийн эргэцүүлэл

Энэ номын мөн чанар бол социологи, криминологийн онолын аргачлалуудыг авлигын асуудал дээр хэрэглэх, мөн социологи, криминологийн мэдлэгтэй хүмүүс болон авлигын талаарх мэдлэгтэй (*гэвч аль алиных нь талаар мэдлэгтэй хүмүүс ховор*) бүх хүмүүст хэрэгтэй бичвэр бэлтгэх явдал юм гэдгийг I бүлэгт тодорхой дурдсан. Авлигыг хувь хүн, үндэстэн дамнасан корпорац, улсууд дангаар болон хамтран үйлддэг. Тиймээс энэ номд дурдсан асуудал, хэлэлцүүлэг, жишээ нь авлигын шинжилгээ, шүүмжлэлийн чанарыг сайжруулж, авлигаас цээрлүүлж чадахгүй байгаа хязгаарлагдмал шийтгэлийн асуудлыг шийдэхэд нэмэр болно гэдэгт итгэж байна.

Гэхдээ аливаа стратегийг урагшлуулахын тулд асуудлын цар хэмжээний талаар зарим ойлголттой байх хэрэгтэй. Авлигыг тодорхойлох, хэмжих, улмаар үнэлэхэд хэцүү болохыг номд үзүүлсэн. Гэхдээ авлигаас ямар нэг хэмжээгээр сэргийлнэ гэвэл зайлшгүй тэдгээр асуудлуудаар хэлэлцүүлэг хийх хэрэгтэй болно. Авлигатай тэмцэх стратегийн түлхүүр бүрэлдэхүүн хэсгүүд, авлигаас сэргийлэх, бууруулах хэрэгцээний талаар

авч үзсэн, тайлбарласан олон тооны ном, өгүүлэл байдаг (*Klitgaard 1988; Rose-Ackerman 1999; Kaufmann et al. 1999; Abed and Davoodi 2000; Amundsen 2000; Collier 2000; Carr 2006; McCusker 2006; Transparency International 2012; Brooks et al. 2013*) ба эдгээрийг энэ номд эшлэн орууллаа. Гэхдээ эдгээр бүтээлүүд дэх стратегийн түлхүүр бүрэлдэхүүн хэсгийн жагсаалт нь өсөн нэмэгдэж буй бүтээлүүдэд үндэслэсэн байгаа ч гүйцэд жагсаалт биш юм. Эдгээр стратеги өдийг хүртэл амжилтгүй хэрэгжиж буйд асуудал нь байгаа бөгөөд амжилт нь тухайн үеийн удирдлага, байгууллагын улс төрийн хүсэл эрмэлзэл болон олон улсын дэмжлэг олж авахын тулд авлигатай тэмцэх стратегийг түр зуур батлах нь ашигтай эсэхээс хамааран алаг цоог, тохиолдлын шинж чанартай (*Heywood 2015; Hough 2015*) байна. Дэлхий нийтээр тархсан байгаа авлигыг бууруулах олон улсын хөдөлгөх хүч нь ихэвчлэн хоосон үг болон хувийн ашиг сонирхолд суурилсан зүйл болж байдаг.

Энэ номд өдийг хүртэл үр дүнгүй байгаа авлигатай тэмцэх стратегийн талаар давтан авч үзэхийн оронд авлигын талаарх онолын хэлэлцүүлэгт анхаарлаа. III бүлгээс XI бүлэг хүртэл тодорхой онолын аргачлалыг тайлбарлаж, түүний ашиг тус, хязгаарлагдмал талуудыг авч үзэв. Хувь хүмүүс авлигын үйлдэл хийдэг боловч олонх нь ‘бизнес хийх’ хүрээнд үйлдэж байдаг. Бизнес нь угаасаа л гэмт хэргийг үүсгэгч болж харагддаг, мөн байгууллагын соёлын зарим хэсэг нь гэмт хэрэг болон авлигыг боломжтой болгож өгдөг, харин нөгөө зарим хэсэг нь түүнд саад болж байдаг гэж харагддаг. Авлига нь юуг хийж болох, юу болохгүй талаарх тодорхой мэдээлэл байгаа эсэхээс хамаарч үүсдэг бөгөөд хамтран ажиллагсдын хандлага, хамгийн дээд түвшний удирдлагын үзүүлсэн үлгэр дууриал, дотоод практик зэрэг хүчин зүйлээс хамаараад зогсохгүй авлигын үйлдэлд оноох хязгаарлагдмал шийтгэлээс хамаарна.

Бизнесийн гол зорилгоо хөөхийн тулд индивидуализм буюу хувь хүнд шүтэх үзэл, өрсөлдөөний ололт, ашиг, үр дүн,

прагматизм зэрэг эдийн засгийн хөдөлгүүртэй хэт олон тооны үнэт зүйлстэй холбогддог болохыг Ашфорт, Ананд (*Ashforth and Anand 2003*) нар үзүүлжээ. Энэ номд дурдсан авлигын олон үйлдэл нь бүтцийн асуудалтай байдаг. Өөрөөр хэлбэл тэдгээр нь дэлхийг хамарсан асуудал болон авлигад хувь нэмэр оруулдаг тогтолцооны нэг хэсэг болсон байдаг. Тиймээс авлигад цөөн хэдэн хүнийг буруутгах бус тогтолцооны энэ асуудалд анхаарах хэрэгтэй. Түүнчлэн худалдааны байгууллагууд олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг болсон учраас хууль хүчний байгууллагууд болон хувийн үндэстэн дамнасан байгууллагуудын авлигыг 'цагдах' тусгай байгууллага байгуулах хэрэгтэй. Энэ номд дурдсанаар үүнийг хийхэд хэцүү. Авлигаас сэргийлэх нь бүх хүний үүрэг бөгөөд зарим салбарын авлигатай тэмцэх нэгж нь магтуштай зүйлсийг хийхээр оролдож байгаа ч төрийн ба хувийн салбарын түлхүүр хүмүүсийн ухамсар нь өөрчлөлт авчрахад гол нөлөөг үзүүлнэ. Энэ бол авлигатай тэмцэх болон хууль сахиулах байгууллагуудыг муу байна хэмээн дүгнэж буй хэрэг биш бөгөөд тэдгээрийн практикт нөлөөлж чадах хязгаарлагдмал талыг ойлгож буй хэрэг (*Hough 2015*) юм. Хүчтэй дотоод ашиг сонирхол нь болзошгүй өөрчлөлтийг эсэргүүцэж, тэдний эзэмшиж буй эрх мэдэл, захиргааны байр суурийг булааж магадгүй (*Brooks et al. 2013*) юм.

Авлигаас сэргийлэхийг оролддог аливаа байгууллага, эсхүл тусгай стратеги боловсруулж байгаа байгууллагыг сайшаах хэрэгтэй. Гэхдээ ажилтнууд нь авлига гэж юу вэ, эсхүл авлига авахад нөлөөлөх ямар хүчин зүйл үүсэн гарч болзошгүй вэ гэдэг талаар тодорхой ойлголт, зааварчилгаагүй байвал авлигатай тэмцэх, ёс зүйн хорооны соёлыг бий болгох явдал нь хязгаарлагдмал үнэ цэнэтэй болно. Эрсдэл, ёс зүйтэй зан үйлийн талаарх бичмэл зааварчилгаанууд, батлагдсан ёс зүйн дүрэм, хариу үйлдэл үзүүлэх төлөвлөгөө, авлигатай тэмцэх бодлого нь дангаараа бол хангалтгүй. Хэрэв эдгээр бичиг баримт нь ёс зүйн дүрмийг үл тоодог, зөрчдөг, эсхүл тойрон

гардаг хүмүүст боловсрол олгож, эсхүл хариуцлага тооцож чадахгүй бол хүмүүсийн хандлага өөрчлөгдөхгүй. Стратегид чиглэл, манлайлал, ёс зүйн дүрэм хэрэгтэй. Стратеги нь ямар нэг байдлаар амжилттай байна гэвэл хэрэгжүүлэх хэрэгтэй. Олон улсын хууль, конвенц нь олон улсын бодлогын мэдэгдэл хийх, хэмжих боломжгүй зорилт дэвшүүлэхээс илүү өөр ямар нэг хүчтэй байна гэвэл байгууллага ба төрийн албаны төлөөллийг хариуцлагад татах хэрэгтэй.

Чиний алдсаныг би хожно: Авлигыг өөгшүүлэх нь

Бизнест өрсөлдөөний зардал нь заримдаа илэрхий байдаг боловч заримдаа далд байдаг. Байгууллагын амжилтыг хэр том байгууллага вэ гэдгээр хэмждэг бөгөөд хэрвээ байгууллагаа томруулахын тулд хүний, санхүүгийн, гадаад орчны эрсдэлтэй зүйлд зардал гаргаж байсан бол тэр нь олон жилийн дараа л ил болдог. Байгууллагын зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх хамгийн хурдан арга зам нь бусадтай нэгдэх ба бусдыг нэгтгэн авах байдаг. Энэ бол капитализмд байдаг л зүйл боловч нөөцийг олж авах, хүн ам, үйлчилгээ, зах зээлийн хандалтыг хянах нь бас улс төрийн тогтолцооны нэг хэсэг байдаг. Энэ номд өмнө нь тэмдэглэсэнээр капитализм, коммунизм, хэмжээгүй эрхт хаант засгийн ялгаа нь авлигаас өөрөөс нь сэргийлэх бус авлигыг буруугаар ашиглах болон авлигын хяналтгүй үйлдлээс сэргийлэх, эсхүл бууруулахын тулд эрх мэдлээ ашиглах болон тэнцвэрт байдлыг тогтоох чадварт байдаг.

Гэхдээ дэлхий нийтийн бизнесийн ертөнцөд хэрхэн бизнес хийх вэ гэдэг асуудал нь соёлын мөргөлдөөн болох төлөвтэй байна. Худалдаа нь олон улсынх болсон ба авлигажсан хувь хүмүүс, байгууллага, улс оронтой ‘хамтран ажиллах’ нь капитализмын салшгүй нэг хэсэг болсон учраас барууны ардчилсан тогтолцоонууд анхааралтай байх хэрэгтэй. Энэ нь

өмнө нь дурдсан авлига гэх цогц ойлголтын аливаа үйлдлийг зөвтгөсөн хэрэг бус хувь хүн, байгууллага, улс орны өмнөх сонголт хязгаарлагдмал гэдгийг хүлээн зөвшөөрч буй хэрэг юм. Бусад бүх хүмүүс үйлдэж байхад авлигажсан хүн, эсхүл байгууллагатай бизнес хийхээс татгалзах ёстой гэх нь хөнгөн хуумгай хэрэг болно. Энэ хандлага нь авлигыг зогсоохгүй харин хувь хүн, байгууллага, улс хооронд улам бат суулгаж өгнө. Түүнчлэн бизнесийг хэрхэн хийх вэ гэдэг талаарх барууны үзлийг хэрэгжүүлэх оролдлого нь авлигаас сэргийлж чадахгүй. Харин ч ‘худалдааны колоничлол’-ын хэлбэртэй төстэй болж эхэлж байна. Ингэснээр хувь хүн, байгууллага, улстай хамтран ажиллаж, энэ харилцаанд авлига нь бизнесийн хувьд ‘арааг элсээр бөглөдөг’ зүйл хэмээн итгүүлэхийг оролдох сонголт л үлдэж байна. Энэ нь дэлхий нийтийн түвшинд боломжтой боловч орон нутгийн ба улс орны авлигыг ‘*тухайн байршил*’ дээр нь шийдвэрлэх ёстой байдаг. Энэ аргачлалын амжилт нь улс төрийн хүсэл эрмэлзэл ба авлигыг шийдвэрлэхэд зарцуулахад бэлэн байгаа нөөцөөс хамаарна.

Онолын аргачлал нь авлигыг ойлгох, урьдчилан сэргийлэхийг оролдох нэг арга юм. Авлига ба криминологийн аль аль судалгааны бүтээл дэх аргачлалууд нь мэдээж хязгаарлагдмал талтай боловч ялгаатай аргачлалыг хэрэглэснээр авлигын цар хүрээ, нөлөөний талаар илүү онолын ойлголт авах боломжтой байдаг.

Авлига нь уян хатан ‘мангас’ бөгөөд түүнээс сэргийлэх, эсхүл түүнийг бууруулах оролдлого нь бас тийм байх ёстой. Нэг размер бүгдэд таарна гэсэн аргачлал амжилтгүй болсон юм. Энэ нь авлигыг мөрдөх явцыг бүрэн үгүйсгэж буй хэрэг бус ямар хэрэгцээ байна вэ, бүс нутгийн аргачлалуудтай хэрхэн хослуульж болох вэ гэдгийг эргэцүүлнэ гэсэн үг юм. Практикийн болон онолын бүх аргачлал нь бодитой байх ёстой. Зохиогч ‘баруун реализм’-д байдаг хязгаарлагдмал талуудын улмаас уг онолыг дэмжиж буй хэрэг биш. Гэхдээ хувь хүн, байгууллага, улсаас

Авлигын криминологи

үл хамааран авлига нь үргэлж л зарим хүнд ашигтай байдаг учир авлигыг, ялангуяа авлигын гэмт хэргийг бууруулах нь л байж болох хамгийн сайн хувилбар гэж үздэг. Эцэст нь хэлэхэд энэ номд үзүүлснээр шийтгэл нь үйлдлийг түдгэлзүүлэх зарим нэг хүчтэй байхгүй бол ‘чиний алдсаныг би хожно’ гэсэн үзэл буюу авлигажсан хувь хүн, байгууллага, улсад хандах өнөөгийн аргачлал нь зүгээр л тэдгээр үйлдлийн үр дагавар нь байнга биш ч ихэвчлэн бага байна гэдгийг дахин баталгаажуулах болно. Хуулийг зөрчихийг дэмжсэн өгүүлэмж нь зөрчихийг дэмжихгүй өгүүлэмжээс хэтрэх үед хүн гэмт хэрэгтэн болдог гэж Садерланд (1939) олон жилийн өмнө бичсэн байдаг. Хууль зөрчихийг дэмжсэн өгүүлэмжийг зохицуулах байгууллага үр дүнтэй ажиллах болон хатуу шийтгэл оноох явдлаар үгүйсгэж болно. Гэхдээ энэ номд үзүүлснээр зохицуулах байгууллагууд ба шийтгэл нь ихэвчлэн үр дүнгүй байна. Авлигын хэрэгт оноох шийтгэл ба түүний цээрлүүлэх чадварын талаар цааш судлах шаардлагатай байна. Криминологи ба түүний судалгааны аргачлалууд, туршилтын судалгаа мөн гэмт хэргийн талаарх хэлэлцүүлэгүүд нь өнөөгийн ба ирээдүйн авлигын боломжийг бууруулахад хувь нэмэр оруулах болно.

Ашигласан материал

- Abed, G. T., & Davoodi, H. R. (2000). Corruption, Structural Reforms, and Economic Performance in the Transition Economies (No.132). Washington, D.C: International Monetary Fund.
- Amundsen, I. (2000). Corruption: Definition and Concepts. Michelsen Institute (CMI), Bergen (Norway).
- Ashforth, B. E., & Anand, V. (2003). The normalization of corruption in organizations. *Research in Organizational Behavior*, 25, 1–52.

- Brooks, G., Walsh, D., Lewis, C., & Kim, H. (2013). *The prevention of corruption: Investigation, enforcement and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Carr, I.M., 2006. The United Nations Convention on Corruption: Making a real difference to the quality of life of millions?. *Manchester Journal of International Economic Law*, 3 (3), 33–44.
- Collier, P. (2000). *How to reduce corruption*. *African Development Review*, 12 (2), 191–205.
- Heywood, P. M. (2015). *Routledge handbook of political corruption*. Abingdon: Routledge.
- Hough, D. (2015). *Corruption, anti-corruption and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Kaufmann, D., Kraay, A., & Mastruzzi, M. (1999). *Governance matters* (World Bank Policy Research Working Paper 2196). Washington, DC: World Bank.
- Klitgaard, R. (1988). *Controlling corruption*. Berkeley: University of California.
- McCusker, R. (2006). *Review of anti-corruption strategies*. Canberra: Australian Institute of Criminology.
- Rose-Ackerman, S. (1999). Political corruption and democracy. *Connecticut Journal of International law*, 14(2), 363–378.
- Sutherland, E. H. (1939). *Principles of criminology* (3rd ed.). Philadelphia, PA: Lippincott.
- Transparency International (2012). *Corruption Perception Index 2012*. London: Transparency International.

Дэлгэрүүлж унших бүтээлүүд

- Barnett, H. C. (1993). Crimes against the environment: Superfund enforcement at last. *Annals of the American Academy of Political and Social Science*, 525 (1), 119–133.
- Barnett, H. C. (1994). *Toxic debts and the superfund dilemma*. Chapel Hill: University of North Carolina Press.
- Braga, A., Weisburd, D. L., Waring, E. J., Mazerolle, L. G., Spelman, W., & Gajewski, F. (1999). Problem-orientated policing in violent crime places: A randomized controlled experiment. *Criminology*, 37 (3), 541–580.
- Braithwaite, J. (1989). *Crime, shame and reintegration*. Cambridge: Cambridge University Press.
- Brantingham, P. L., & Brantingham, P. J. (1999). A theoretical model of crime hot spot generation. *Studies on Crime & Crime Prevention*, 8 (1), 7–26.
- Bray, C. (2015, December 1). Bank to pay fine in bribery case. *International New York Times*, p. 18.
- Brooks, G., Button, M., & Gee, J. (2012). The scale of healthcare fraud: A global evaluation. *Security Journal*, 25 (2), 76–87.
- Bunt, H. G. van de., & Huisman, W. (2007). Organizational crime in the Netherlands. *Crime and Justice: A Review of Research*, 35, 217–260.
- Burke, R. H. (2005). *An introduction to criminological theory*. Portland, OR: Willan Publishing.
- Cressey, D. (1973). *Other people's money*. Montclair, NJ: Patterson Smith.
- Glenny, M. (2008). *McMafia: Crime without frontiers*. London: The Bodley Head.

- Gundlach, M., Douglas, S., & Martinko, M. (2003). The decision to blow the whistle: A social information processing framework. *Academy of Management Review*, 27 (1), 107–123.
- Jessop, B. (2004). Hollowing out the nation-state and multilevel governance. In P. Kennett (Ed.), *A handbook of comparative social policy*. Cheltenham: Edward Elgar.
- Karanikolos, M. (2013). Financial crisis, austerity, and health in Europe. *The Lancet*, 381, 1323–1331.
- Kaufmann, D., & Kraay, A. (2002). Growth without governance. *Economia*, 3, 169–215.
- Klitgaard, R. (1988). *Controlling corruption*. Berkeley: University of California.
- Lambsdorff, J. G. (2003). How corruption affects productivity. *Kyklos*, 56 (4), 457–474.
- Lauritsen, J. L., & Quinet, K. F. D. (1995). Repeat victimization among adolescents and young adults. *Journal of Quantitative Criminology*, 11 (2), 143–166.
- Lee, J.-Y., Heilmann, S. G., & Near, J. P. (2004). Blowing the whistle on sexual harassment: Test of a model of predictors and outcomes. *Human Relations*, 57 (3), 297–322.
- Lindesmith, A., & Gagnon, J. (1964). Anomie and drug addiction. In M. Clinard (Ed.), *Anomie and Deviant Behaviour*. New York: Free Press.
- Mauro, P. (1995). Corruption and Growth. *Quarterly Journal of Economics*, 90, 681–712.
- Miceli, M. P., & Near, J. P. (2002). What makes whistleblowers effective? Three field studies. *Human Relations*, 55, 455–479.

- National Business Ethics Survey. (2005). *How employees views ethics in their organizations 1994–2005*. Washington, DC: Ethics Resource Centre.
- Olken, B., & Barron, P. (2009). The simple economics of extortion: Evidence from trucking in Aceh. *Journal of Political Economy*, 117 (3), 417–452.
- Paternoster, R. (2001). The structure and relevance of theory in criminology. In R. Paternoster & R. Bachman (Eds.), *Explaining criminals and crime: Essays in contemporary criminological theory*. Los Angeles: Roxbury Publishing Company.
- Platt, A. M. (1969). *The child savers: The invention of delinquency*. Chicago: University of Chicago Press.
- Punch, M. (2000a). Suite violence: Why managers murder and corporations kill. *Crime, Law and Social Change*, 33 (3), 243–280.
- Punch, M. (2000b). Police corruption and its prevention. *European Journal on Criminal Policy and Research*, 8 (3), 301–324.
- Rama, D., Milano, B. J., Salas, S., & Liu, C. H. (2009). CSR implementation: Developing the capacity for collective action. *Journal of Business Ethics*, 85 (2), 463–477.
- Ridgeway, J., & St. Clair, J. (1998). *A pocket guide to enviromental bad guys*. New York: Thunders Mouth.
- Rose-Ackerman, R. (1978). *Corruption: A study in political economy*. New York: Academic Press.
- Sampson, R. J. (1986). Effects of socio-economic context on official reactions to juvenile delinquency. *American Sociological Review*, 51, 876–885.
- Schwendinger, H., & Schwendinger, J. (1975). Defenders of order or guardians of human rights? In I. Taylor, P. Walton, & J. Young

- (Eds.), *Critical criminology*. London: Routledge.
- Scull, A. (1984). *Decarceration: Community treatment and the deviant: A radical view*. New Brunswick, NJ: Rutgers University Press.
- Sherman, L. W., Gottfredson, D., MacKenzie, D., Eck, J., Reuter, P., & Bushway, S. (1998). *Preventing crime: What works, what doesn't, what's promising*. Washington, DC: National Institute of Justice.
- Simon, D. R. (1999). *Elite deviance* (6th ed.). Needham Heights, MA: Allyn and Bacon.
- Singer, P. W., & Bason, L. (2004). *The private military industry and Iraq: What have we learned and where to next?* Geneva: Geneva Centre for the Democratic Control of Armed Forces.
- Spitzer, S. (1976). Toward a Marxian theory of deviance. *Social Problems*, 22, 638–652.
- Taylor, L. (1971). *Deviance and society*. London: Michael Joseph.
- UN. (2003). *Convention against corruption*. Washington, DC: UN.
- Wei, S.-J. (2000). Local corruption and global capital flows. *Brookings Papers on Economic Activity*, 2, 303–346.
- Wells, C. (1993). *Corporations and criminal responsibility*. Oxford: Clarendon Press.
- Wood, B., & Peleman, J. (1999). *The arms fixers: Controlling the brokers and shipping agents*. (PRIO Report 3/99). Oslo, Norway: Peace Research Institute.
- World Health Organisation. (2008). *Air quality and health: Fact sheet*. World Health Organisation. Geneva, Switzerland.
- Young, J. (1999). *The exclusive society*. London: Sage.

Индекс

А

AG 208, 307, 308
Авлигын төсөөллийн индекс
30, 66, 67, 68, 75, 76
автомашин 15, 107, 111, 115,
121, 205
Америк мөрөөдөл 131, 132
Америк 131, 132, 133, 134,
137, 144
АНУ 8, 12, 13, 45, 71, 83,
112, 116, 131, 132, 133,
138, 140, 146, 161, 190,
199, 207, 208, 209, 221,
225, 229, 230, 249, 253,
272, 275, 279, 280, 283,
286, 288, 289, 299, 305,
307, 308, 310, 313, 332
АНУ-ын Байгаль орчныг
хамгаалах газар 280
арааг тослох 52
Арааг элсээр бөглөх 52, 87

Б

байгаль орчин 164, 239, 277,
279, 282, 283, 289
байгаль орчны 44, 117, 164,
197, 249, 279, 280, 281,
283, 285, 286, 288, 289,
290,

байгаль орчны ялгаварлан
гадуурхалт 285
баруун реализм 271, 325
Barclays 208, 306, 310
баялгийн хараал 285
Bechtel 117
Бизнесийн орчин, компанийн
гүйцэтгэлийн судалгаа
67, 69, 77
БНСУ vii, ix
Blackwater 117

В

Волксваген 104, 106, 114

Г

Газрын тос 28, 258, 281, 283,
284
гулсах 53, 161, 162, 165, 166,
181, 250
гэмт хэрэгт өдөөсөн 112

Д

Далай ба Цаг Агаарын
Үндэсний Газар 282
дарамт 15, 37, 53, 112, 120,
132, 135, 139, 141, 143,
144, 145, 146, 147, 149,
150, 151, 153, 191, 192,
225

Deutsche Bank 12, 307, 308,
309

DynCorp 117

Дунд Стаффордшайрын
Эмнэлэг 150

дүрэм зөрчих, зөрчлийн
үйлдэл 3, 139, 161,
165, 166, 172, 174, 187,
189, 190, 191

Дэлхийн авлигын хэмжүүр
50, 78, 89

Дэлхийн Банк 17, 28, 34, 69,
84, 169, 259, 261, 262,
264, 265, 266

Дэлхийн засаглалын
индикатор (WGI) 67

Дэлхийн шударга байдлын
индекс 78, 79

Е

Европын Холбоо 114, 115,
169

Ерөнхий дарамтын онол
(GST) 135

Ё

ёс зүйн дүрэм 179

Ёс зүйн мэдээ алдалт 108

Ж

Женерал Моторс (GM) 112

JPMorgan Chase 204, 205,
208, 306, 335

З

засаглал 71, 72, 73, 75, 87,
88, 89, 152, 233, 255,
261, 265

захиргааны үр ашиггүй
байдал 85

Зохион байгуулалттай гэмт
хэрэг 39, 40, 41, 54, 68,
120, 221, 224, 226, 229,
232, 233, 235, 240, 282

зохицуулах байгууллага 105,
106, 108, 206, 304, 326

Зөвлөлт Холбоот Улс 119
зөрчилдөөн 53, 108, 109, 120,
144, 217, 218, 220, 221,
223, 224, 227, 240, 241,
283

И

Ивээн тэтгэх 140, 171, 284,
290

институтчилэгдэх
институцийн үл нийцлийн
онол (IAT) 133

Ирак 116, 117

Их Британи 11, 199, 230, 253

Ичээх 251

Авлигын криминологи

К

капиталист 16, 17, 52, 54,
105, 144, 210, 225, 228,
231, 233, 283

капитализм 15, 33, 34, 105,
117, 218, 219, 227, 228,
231, 232, 234, 235, 255,
324

Кнапшын Комисс 36

коммунизм 34, 52, 232, 324
коммунист 105, 221, 222, 226
компанийн гэмт хэрэг 39, 46,
54, 108

Л

ЛИБОР 12, 106, 307, 308, 313
лоббидох 12, 33, 35, 40, 105,
106, 112, 313

М

Макперсоны Илтгэл 44
Мексик 12, 31, 120, 258, 284
Менежмент ба Төсвийн
Алба (ОМВ) 147
мөнгө саах 33, 34, 262
Мөнгө угаах 6, 41
Мэргэжлийн гэмт хэрэг 39,
44

Н

Нео-либерал 72, 169, 232,
236

нийгмийн зохион

байгуулалтгүйдэл 118,
119, 187, 190, 304

нийгмийн хяналт 50, 145,
149, 161, 187, 190, 191,
193, 195, 200, 210, 219,
273, 281, 301

нийгэмд нөхцөлдүүлэх 16

НҮБ-ын Хөгжлийн
Хөтөлбөр 74

Нэгдмэл шалгуур үзүүлэлт
75

Нэр шошго зүүх 17, 53, 72,
110, 217, 219, 221, 222,
230, 234, 247, 248, 251,
252, 253, 254, 255, 256,
257, 259, 260, 262, 265

О

Олон зориулалтат, дахин
ашиглах хөлөг 146,
147, 149

Олон Улсын Бизнес (BI) 70

Олон улсын Гэмт хэргийн
Хохирогчийн Судалгаа
(ICVS) 84

Олон улсын хөлбөмбөгийн
холбоо 179

Олон Улсын эрсдэлийн
Зааварчилгаа
(ICRG) 70, 77

Олон улсын эрчим хүчний
байгууллага 288

ОУВС 17, 28, 34, 169, 259,
260, 261, 262, 263, 264,
266, 289

ОХУ 16, 70, 176

Р

радикал криминологи 229,
230, 231

рационал сонголт 2, 17, 53,
143, 193, 194, 195, 197,
272, 274, 275, 276, 277,
280, 281, 288, 289, 290

рационал эдийн засаг 32

С

Саармагжуулах арга
хэрэгсэл 16, 36, 53,
102, 161, 162, 165, 169,
170, 171, 172, 181

Сансрын тандан судалгаа 15,
145

Сарбанес-Окслэйн хууль 29

Супер сангийн хууль 286

Социологи vi, х, 1, 2, 3, 4, 5,
9, 13, 14, 15, 16, 27, 32,
39, 42, 44, 50, 53, 54,
110, 139, 171, 193, 222,
227, 230, 296, 321

CACI International 117

Citigroup 208, 306, 309

Credit Suisse 310

Т

тавааржилт 151, 235

Тагнуулын төв газар 221

төр хувийн ашиг сонирхолд
автагдах, төрийг эзлэн
түрэмгийлэх 49, 108

төрийн гэмт хэрэг 39, 47, 48,
49, 54, 224, 237, 239

Төрийн Зардлыг Мөрдөх
Судалгаа (PETS) 81, 82

төрийн компанийн гэмт
хэрэг 39, 54

Транспэрэнси Интернэшнл
(TI) 13, 30, 50, 66, 67,
68, 78, 79, 80

түдгэлзүүлэх 301, 326

Titan 117

У

Улс төрийн шинжлэх ухаан
2, 32, 33

Ү

үйлдэхүй 47, 50, 238, 239

Үйлчилгээ Хүргэгчдийн
Тоон Судалгаа (QSDS)
82

Үндэсний агаарын тээвэр,
сансрын нислэгийн
алба (NASA) 146

Үндэсний Эрүүл мэндийн
Алба 150, 151, 180

Авлигын криминологи

- үндэстэн дамнасан 10, 37,
165, 169, 203, 205, 207,
208, 232, 321, 323
- Үнэт цаас, валютын комисс
(SEC) 205, 208, 307,
309, 310
- Х**
- Халлибуртон 117
- Хар усан сан 310
- хахууль 6, 12, 28, 34, 50, 68,
69, 70, 82, 85, 86, 88,
105, 107, 137, 139, 168,
169, 170, 171, 201, 202,
283
- Хилсбороү 17, 254, 255, 256,
257, 265
- Холбооны Мөрдөх Товчоо
221
- Хортой өр 310
- хохирол 46, 47, 50, 54, 115,
121, 145, 164, 169, 201,
202, 232, 235, 248, 280,
283, 284, 310
- хөшүүрэг 309
- хувийн цэргийн гэрээлэгч
(PMC) 15, 31, 108, 111,
115, 116, 117, 118, 119,
120, 121
- хуйвалдах 5, 40, 4
- хуулийн 3, 12, 13, 16, 28, 36,
37, 40, 42, 43, 44, 45,
52, 54, 55, 70, 71, 74,
75, 87, 89, 101, 102,
105, 106, 109, 116, 121,
137, 140, 152, 174, 177,
205, 206, 207, 210, 220,
222, 223, 224, 225, 226,
228, 229, 233, 235, 254,
255, 257, 282, 283, 299,
313
- Хуулийн засаглал 36, 75, 87,
152, 233
- Хууль бус 2, 3, 35, 37, 41, 46,
51, 52, 54, 68, 73, 79,
83, 87, 88, 102, 107,
116, 118, 120, 131, 135,
138, 140, 141, 142, 153,
163, 164, 170, 171, 173,
175, 192, 221, 223, 225,
235, 236, 241, 247, 249,
282, 283, 296, 298, 304,
308
- хууль тогтоомж 10, 29, 30,
100, 112, 194, 195, 199,
209
- Хууль хэрэгжүүлэх 140, 207,
208, 235, 287, 288
- хүлээн зөвшөөрөгдөх байдал
200, 221
- Хүний эрх 46, 47, 49, 117,
239, 261
- хэвшмэл үйлдэл 296, 298,
302, 309, 313
- хэлбэрийн харилцаа
- Хэм хэмжээ үл нийцсэн

Хэм хэмжээнээс гажих 3, 28,
193, 194, 195, 196, 197,
231, 238, 250

хяналтын дутагдал 196, 197
хяналтын илүүдэл 196, 197
хяналтын онол 161, 187, 188,
189, 190, 197, 199, 303

Ц

Цагаан захтны гэмт хэрэг 4,
5, 6, 15, 42, 43, 53, 54,
101, 105, 106, 108, 134,
137, 144, 152, 174, 191,
221, 229, 253, 275, 276

цогц авлига

Ч

чадамжтай асран хамгаалагч
200, 297, 299, 302, 303

Ш

шижилтийн

Шотландын эзэн хааны банк
208, 307

шударга байдлын менежмент
177, 178

Шүүгэл үлээгч 178, 180, 205

Шүүх яам 112, 205, 207, 208,
209, 305, 306, 307, 308

Э

Эдийн засагчдын
мэдээллийн нэгж 70,
80

Эдийн засгийн хамтын
ажиллагаа, хөгжлийн
байгууллага 169, 261,
264, 289

эзэн-ажилтан

Эмийн бүтээгдэхүүн 45, 202,
205, 206, 207

Эрүүл мэндийн салбарыг
шалгах Комисс 150,
152

эрх мэдэл 2, 4, 14, 17, 31, 35,
42, 43, 48, 51, 52, 73,
105, 107, 111, 113, 144,
145, 146, 153, 165, 175,
176, 181, 191, 196, 198,
200, 217, 219, 221, 222,
223, 224, 225, 226, 227,
228, 230, 231, 233, 234,
241, 247, 249, 254, 255,
256, 257, 259, 260, 265,
266, 279, 323

Эс үйлдэхүй 47, 50, 238, 239

Ю

UBS 208, 306, 307

Я

Ялгаатай нөхөрлөл 4, 15, 47,
53, 99, 100, 101, 102,

Авлигын криминологи

109, 112, 115, 118, 119,
120, 121, 140, 153, 174,
194, 220, 273

Япон 43, 305, 307

Яриа хэлэлцээ 17, 265, 271